

СОРОГДОГДИН ЖАРГАДСАЙХАН

ЧИНГИС ХААНЫ  
НУУЦ ТҮҮХ

РОМАН

II



Чингис хааны нууц түүх - II  
Зохиолч: С.Жаргалсайхан, Л.Удвал  
Редактор: Г.Отгончимэг  
Эрхлэн гаргасан: "Болор-Судар" хэвлэлийн газар

ISBN: 99929-40-01-8

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

[www.bookstore.mn](http://www.bookstore.mn)

## Өмнөх үг

### ТЭНГЭРИЙН ЗАРЛИГ

Хүн төрөлхтөний түүх нууцаас нууц руу өртөөлөн яваа мэт санагдана. Тиймээс шинэ түүх гэж үгүй, бас хуучин түүх гэж үгүй бүгд түүхийн түүх ажээ. Түүхэн үйл явдал, түүхт хүмүүсийг шинээр нээн харахад уран зохиол хэмээх шидэт ертөнц ер бусын долгиныг үүсгэнэ. Чухамхүү зохиолчийн гэгээн оюун, онгод авьяас, сэтгэлийн халил, уран тавил тэргүүтэн цаг цагийн нууцыг тайлах оньсогот ертөнц бөгөөд тийнхүү түүхэн уран зохиол амилан цэцэглэдэг юм. Ийн үзэхүйд манай уран зохиолын түүхэн баатруудын дүр өвөр хоорондоо үл ялгарам дэндүү адилхан байгааг баримтын баринтагт баригдан сэтгэлгээний загварчлал, арга барил, онол суртахууны нэгэн хэвд орсноор тайлбарлаж болох боловч үнэндээ шинэчлэгдээгүйн үнэн дүр зураг энэ юм.

Монголын уран зохиолын хөгжлийн ийм үед тэсрэлт болон гарч ирсэн сор бүтээл бол “Чингис хааны нууц түүх” роман билээ. Энэхүү романы гайхамшигт хувь зохиол нь дэлхийн хүн-Чингис хааны дүрийг бүтээсэн өнөөг хүртлэх бүхий л ололтыг шингээх, омойтсоныг залруулах, орхигдсоныг нэмэх, олдошгүйг нөхөх түүхэн шаардлагыг уран бүтээлийнхээ гол зорилго болгон бүтээн туурвисанд оршино.

Тиймээс Чингис хааныг хүнийх нь хувьд хувьчлан амилуулж, тэрхүү хувь чанар нь түүхэн үйл явдлын дунд хэрхэн алдаж эндэж, унаж босч, төлөвшиж хөгжиж байгааг уран сайхны өргөн дэлгэц дээр үзүүлжээ. Үнэхээр Тэмүжин, Чингис хаан болж, Чингис хаан дэлхийн түүхэнд зуу зуун жил амьдаас амьд оршин байгаа нь Тэнгэрийн зарлиг буйзаа. Өнөөг хүртлэх, цаашид ч үл давтагдах дэлхийн хамгийн том эзэнт гүрэн Их Монгол улсыг байгуулж, даяарчлалын даяарчлалыг үндэслэж байсан Чингис хааныг 840 жил гарны дараа буюу хүн төрөлхөтний түүхийн XXI зууны эхэнд сая хүмүүн талаас нь гүн нээж, түүний гүн ухаан, гэгээрэл, ухаарлыг анх удаа өвөрмөц, хурц тод, зөн билгийн үүднээс гайхамшигтайгаар дүрсэлсэн нь өөр хэн ч биш “Чингис хааны нууц түүх” роман билээ.

Энэ роман ордны түүх биш, алдарт “Монголын нууц товчоо”-ны хуулбар бүр ч биш бөгөөд харин ч тэнд дүрслэгдээгүй, он цагийн хувьд гээгдсэн, үзэл бодлын хувьд гадуурхагдсан, оньсого мэт үлдсэн бүхнийг нөхөн шагласан нь соргог, сонгодог хувилбарыг бүтээх нэгэн учрыг бүрдүүлжээ. Тиймээс зохиогчид уран зохиолын дүрээр дамжуулан түүхэн эрхи мэт бүтээсэн энэхүү шинэ санал нь бидний дадаж заншсан сэтгэлгээ, хэвшиж тогтсон Чингис хааны хуучин дүрийг эвдэж түүнийг шинэ сэтгэлгээ, шинэ аргачлал, шинэ үнэлэмжийн үүднээс шинээр харах шинэ боломжийг олгож байна. Энэ роман бол олон талаараа монголын уран зохиолд “Цоо шинэ” гэж болох бүтээл юм.

Ургах наран залаатай цэнхэр дэлхийн талыг улаан залаатай монгол хүн нэгтгэн засаглаж, ертөнцөд өнөөг хүртэл зүүдэлж буй нэгэн дээвэрт багтах ер бусын их гүрнийг эзэн богд Чингис хаан байгуулсан нь Мөнх Тэнгэрийн эрхшээл, Эх газрын ивээл байв. Чингис хаан шөнийн од шиг түгээмэл нэгэн байсангүй, өдрийн од мэт ховор тавилантан, хүмүүн биеээс хэтийдсэн хувилгаантан байв. Чухамхүү Мөнх Тэнгэрийн зараалаар төрсөн Чингис хаан Онон мөрний хөвөөнөөс орчлон дэлхийн хаан эзэн болтлоо хувь хүний хувьд хэрхэн зовж

зүдэрч, бэрхшээл саадыг туулж ухаажин хатуужиж ноорхой дээлтээс номын ухаантан, мохошгүй тэмцлээс монголын хаантан, дэлхийн хүн болтлоо дэвжсэн адал явдал, атаа хорсол, алаан талаан, аугаа сэтгэлгээг дүрсэлсэн нь Чингис хааны урд хожид байгаагүй нууц, шинэ ертөнцийг тайлан үзүүлэв.

Сэтгэл зүй, сэрэл ухаарал, сэхээрэл мэдрэмжээрээ “Чингис хааны нууц түүх” роман монголын утга зохиолын ертөнцөд дүр бүтээх тэр дундаа түүхэн дүр бүтээх арга хэлбэрт шинэ хувьсгал хийснээ зарлан тунхаглав. Сэтгэл зүйн энэхүү роман эрдэнийн есөн бүлэгтэй бөгөөд түүнийг “Бөртэ”, ”Жамуха”, “Тэв Тэнгэр”, ”Өүлэн”, ”Хасар”, ”Хулан”, ”Зүчи”, ”Боорчи”, ”Тэмүжин” хэмээн нэрийдсэн нь гүнзгий учиртай. Энэ түүхт хүмүүсийн зан чанар, бүтээл үйл, үзэл бодол нь нэгэн голын цуггалан мэт нэгдэн нийлж түүнээс Эзэн богд Чингис хаан урган төлжсөнийг цогцлоон дүрсэлсэнд “Чингис хааны нууц түүх” романы гол ололт оршино. Үүнээс өмнө Чингис хаанаас эдгээр түүхт хүмүүс төрөн гарсныг дүрсэлж байсан бол энд тэдгээр хүмүүсийн нөлөө, үнэнч сэтгэл, атаа хорсол, амьдрал тэмлийн дундаас Чингис хаан бойжин их хааны зэрэгт хүрч буйг үзүүлсэн нь шинэ үзэгдэл болсон юм. Дүр бүхэн нь өөр өөрийнхөөрөө амьдарч, хэний ч нөлөөнд үл автан, бас монголын их эзэнт гүрний хөдөлгөгч хүчин, аз жаргал, атаа хорслын эзэн болж байгаа нь нэн сонин.

Роман бүхэлдээ хүмүүн хоорондын сэтгэлийн тулаан, зөрчил тэмцэл бөгөөд түүхэн үйл явдлын шинэ тайлал, сонирхолтой хувилбар, шийдэл, уран санаа, дүрслэлээр дүүрэн, гүнзгий агуулгатай юм. Түүхийг хэн нэгэн бичдэг, тэр нь ямар ч сонгодог бичлэгтэй байлаа ч үнэндээ тухайн үйл явдалд хандсан нэгэн хувилбар байдаг бөгөөд харин түүхэн утга зохиол нь уран сэтгэмж, бодит баримтын хоршил, найрал хөгжим юм. ”Чингис хааны нууц түүх” романы уран сайхны нээлтийг ухаарахдаа дүрээр дамжсан түүхийн шинэ өгүүлэмж, түүх өгүүлсэн уран дүрийн өвөрмөц шийдлийн зохист харьцааг монголчуудын өвөрмөц зан заншил, сэтгэл зүй, байгалаа шүтэх үзэл, тэнгэр газар хүний гурамсан холбоо, бөө мөргөлийн шүтлэгтэй холбож тайлах хэрэгтэй болж байна.

Чингис хааныг бурханчлан шүтэж зөвхөн ид шидтэн мэтээр сэтгэх, эсвэл түүний түүхэнд гүйцэтгэсэн үүргийг үгүйсгэн харлуулах хоёр туйлшралын аль алиныг огоорч гагцхүү Тэмүжин хэмээх хувь хүн тухайн цаг үеийг хэрхэн мэдэрч үнэлж, түүхийн шинэ нөхцлийг хэрхэн хөтлөн удирдаж, жаргал зовлон хосолсон хүний амьдралыг дагаж, сөрж туулахдаа ялан дийлэхийн үлгэрийг хэрхэн үзүүлснийг энэхүү роман уран дүрээр, яруу үгийн гайхамшгаар итгэл үнэмшилтэйгээр үзүүлж бүр жирийн уншигчдад түүхийн туйлын үнэн мэт сэтгэгдэл төрүүлэх болов.

Энэ бол уран зохиолын ид шид юм. ”Чингис хааны нууц түүх” роман монголын уран зохиолд шинэчлэл, өөрчлөлтийн их харанга дэлдэж, уран бүтээлчдийн зүүд нойрыг сэрээж, уншигч олонд урам зориг авчирлаа. Хэн нэг нь эл романыг хуучинсаг сэтгэлгээгээр харж хараан зүхэж, нөгөө нэг нь гайхан эргэлзэж, шинэ монголчууд амтархан уншиж, түүхчид маргалдаж байна. Бөртэ хатны хатуу сэтгэл, Жамухын тангаргын андлал, Тэв Тэнгэрийн амин нууц, Өүлэн эх, Мэнлиг хоёрын холбоо, Хасарын гэнэтийн үхэл, Хулан хатны эцсийн хүсэл, Зүчийн мэргэд цусны өширхөл, Боорчийн үнэнч сэтгэлийн нүгэл, Тэмүжиний холын далд санаа зэргийг гагцхүү энэ роман дэлгэн үзүүлж чадсан юм. Үүгээрээ “Монголын нууц товчоо” хэмээх алдарт бүтээлтэй эрхгүй харьцуулан үзмээр тулхтай бүтээл болж чаджээ. ”Чингис

хааны нууц түүх” роман Чингис хааны сэдэвт уран бүтээлийн оргил нь болоод зогсохгүй монголын төдийгүй дэлхийн утга зохиолд сэтгэл зүй-түүхийн бүтээлийн сэрэл мэдрэхүй, онол суртахуун, үзэл баримтлал, гүн ухааны шинэ үзэгдэл болж буйг манай эрдэмтэд, утга зохиол судлаачид үнэлэн дүгнэх, үгээ хэлэх цаг болжээ.

Шинэчлэл хийсэн бүтээл бүхэн их хэлэлцүүлэг, их маргааныг эхлүүлдэг нь жам бөгөөд түүний сонгодог нэгэн хувилбар-“Чингис хааны нууц түүх” романыг зохиогчид нь нэмж засварлан хоёр жилийн хугацаанд дөрөвдэхь удаагаа хэвлүүлэн уншигч танд өргөн барьж байна. Шинэ хэвлэлтэд оруулсан засвар, нэмэлт нь энэ романы агуулга болоод зохиомжийг улам ч төгс болгожээ. Та Чингис хааны тухай төдийгүй бас монголчууд бидний тухай өгүүлсэн гайхамшигт түүхийг сөхөж байна.

Таалалд тань орших болтугай.

Утга зохиол судлаач, доктор

Ү.Хүрэлбаатар

# ЗУРГААДУГААР БҮЛЭГ

## ХУЛАН

### *АМЬ ДҮЙСЭН ДУРЛАЛ*

Тэмүжин дөчин хоёр нас хүрч, 1204 оны намар болж байлаа. Найман аймгийн Таян ханыг мөхөөж найман иргэдийг бүгдийг хураан авч дуусгав. Найман аймгийг дарсны хойно нэгэн шинэ, сонирхолтой ажил өрнөсөн нь найманаас олзлогдсон Таян ханы ордны түшмэл Тататунга гэгч Тэмүжиний зарлиг ёсоор уйгар үсгээр монгол хэлийг галиглан бичиж үүнийг сурахаар олон залуус шамдан сонирхох болсныг угийн сониуч Хасар манлайлж байв. Тэмүжин харин бичиг сурах гэж хичээсэнгүй. Түүний сэтгэлийг найманы Таян ханы дэргэд очоод байснаа баригдалгүй цааш зугатаж одсон мэргэдийн үлдэгдэл Тогтообэх болон түүний хөвүүдийг дарах хүсэл эзэмджээ. Тэмүжин найманыг эзлэн авснаар олон цэрэгтэй болж Боорчи, Зэлмэ, Хасар, Сүбээдэй нарын удирдсан гол цэрэг нь нэгэнт байлдаж сурчээ.

Одоо түүнд Тогтообэхийг хүлээх биш дайран сөнөөх цаг ирж, хүч хуримтлагдсаныг ойлгов. Харин Тогтообэхээс салсан мэргэдийн үлдэгдэл Туул Орхоны завсарт одоо болтол суусаар байсныг эхлээд хураан авах хэрэгтэй байлаа. Ингээд зуны эхэн сараас эхлэн сэм бэлдсэний дүнд мэргэдийн үлдэгдэл орогносоор байгаа Саарь хээрийн талыг зорин хөдлөхөд бэлэн болжээ. Гэвч үүний өмнө олзлогдон ирсэн мэргэд иргэдийн зарим нь зугатаан очиж Тэмүжиний довглох чимээг хүргэж амжжээ. Тэмүжиний довглох мэдээ мэргэдийн удирдагчдын дотор хагарал үүсгэж хар толгой, хамаг хөрөнгөө бодсон Увас мэргэдийн толгойлогч Дайр-Үсэн Тэмүжинд бууж өгөхөөр шийджээ. Ойр зуурын хамаг монгол аймгуудыг сөнөөн дарж хүчирхэгжсэн Тэмүжинг эсэргүүцэн тэмцэх хүч Мэргэд аймагт нэгэнт үгүй болсон нь сохор дүлий хүнд ч ойлгомжтой бөгөөд энэ байдал мэргэд хүн бүрийг амиа бодоход хүргэжээ. Дайр-Үсэн ухаантай сүрхийдээ ингэж шийдсэнгүй. Энэ бүгд түүний охин Хуланы санаа сэдэл байлаа. Тогтообэхээр толгойлуулсан хэсэг мэргэд олон жилийн өмнө Бөртийг булаан авснаас үүдсэн өс хонзонг Тэмүжин өнөө болтол мартсангүй. Харин салхинд үлээгдсэн талын түймэр шиг хүчирхэгжсэн Тэмүжинтэй Мэргэд аймаг ганцаар илэрхий дайсагнахаас тойрч байсан ч түүний эсрэг тэмцэл, хуйвалдаанд ямагт оролцож байжээ. Гэвч Тэмүжинг эсэргүүцэгчдийн тархай бутархай хүчийг нэгтгэн гол тулгуур нь болж байсан Найман аймаг санаандгүй хурднаар дарагдан сөнөсөн нь монголын тал нутагт Мэргэд аймгийн эцсийн өдөр ирснийг зарласан хэрэг болов. Мэргэдүүд нэг бол Тэмүжинд дагаж орох, эсвэл эсэргүүцэн тэмцээд эцсээ үзэх ёстой цаг иржээ. Тэд Тэмүжинг шууд довлон дарах зориг хүч нэгэнт үгүй тул дэмий л эргэлзэн хүлээсээр хэсэг хугацаа өнгөрч одоо Тэмүжин довлон ирэх нь тодорхой болов. Тэмүжин мэргэдийг дарахыг туйлаас хүсч байв. Учир нь мэргэд бол түүний хувийн өстэй дайсан билээ.

Дайр-Үсэний охин Хулан хэдий арван наймтай ч эцгийн гэрт эрх танхи өссөн дураар омголон зантай, хол ойрыг ухан бодох чадалтай, сэргэлэн овтой бүсгүй юм. Тиймдээ ч Мэргэд аймгийг нөмрөн ирэх аюулыг мэдэрч бас эцэг өвгөдийн муйхар эсэргүүцлийн уршгаар алагдан үгүй болохыг хүсэхгүй байлаа. Хамгийн гол нь тэр үл таних Тэмүжин гэгчтэй хамт тал нутагт цоо шинэ амьдрал, цоо шинэ цаг үе ирж байгааг Хулан ухаантай залуу хүний ёсоор ойлгож мэдэрсэн явдал юм. Мэргэдүүд Тэмүжинтэй сөрөн байлдах бэлтгэлээ базааж, шивээ

халх байгуулсаар байхад Хулан эцэг Дайр-Үсэндээ нэгэн зүйлийг гуйж, сүүлдээ шаардах болов.

Дайр-Үсэн эхний үед Хуланы үгийг эм хүний хөөрүү сэтгэлийн хоосон үг гэж үл тоосон ч дөхөн ирж буй аюул занал өөрийн эрхгүй түүнийг элдвийг эргэцүүлэн бодоход хүргэжээ. Мэргэд хүн бүр үхэх сэхэхээ үзэх цаг болж эр бүр нум сум, илд хутгаа бэлдэн бужигнах үед Дайр-Үсэн есөн өнгийн бодолд ээрэгдэн мухар нүхэнд орсон зурам шиг болжээ. Арван найман настай охин Хуланы хэлсэн үг дэндүү осолтой, даанч хатуу шаардлага байв. Эцгийгээ Боржигон аймагт бууж өгч, бууж өгөөд зогсохгүй өөрийгөө Тэмүжинд бэлэглэхийг Хулан тулгажээ. Хуланы энэ шаардлагыг шүүрэн авч биелүүлэхэд дэндүү амь дүйсэн, осолтой хэрэг байв. Хэрэв Дайр-Үсэнг юу хийх гэж буйг сэжиглэж мэдвэл нэг аймгийнхан нь түүнийг урвагчид тооцон шууд алах биз. Гэнэн охины хөөрүү үгэнд автан гэндвэл хар толгойгоо алдаад зогсохгүй, хожим хойно үр удмаараа урвагчид тооцогдон жигшигдэх билээ. Мэргэд аймгийн мөхөл ирсэн гэдгийг Дайр-Үсэн хэрхэвч зөвшөөрөхгүй юм. Бас төрөлх аймгаас урваж Тэмүжинг дагах нь амиа аврах эцсийн арга гэж тэр үзэхгүй байлаа. Тийм учраас Хуланы шаардлагыг хүлээн авахгүй цааргалсаар ажээ. Гэтэл Тэмүжиний их цэрэг нөмрөн ирж явааг хоёр өдрийн газраас үзэж давхин ирсэн харуулын үгийг сонсоод байдал нэгэнт тодорхой болмогц Дайр-Үсэн эргэлзэж тээнэгэлзэхийг больж бууж өгөхөд сэмхэнээр бэлтгэж эхлэв. Үхлийн өмнө хар толгойгоо аврах эцсийн замыг тэр сонгов. Ингэхдээ бусад албат иргэдээс хав нууж, Тэмүжиний цэргийг хүлээжээ. Тэмүжинг угтан хөдлөх нь өөрийнхний гарт үхэхэд хүргэх, бас дайран ирэх дайсанд санаандгүйгээр алуулах аюул байх тул албат иргэддээ ч сэжиглэгдсэнгүй, дотор нууцаа хадгалан суужээ. Мэргэдийн хүрээ аймшигт сандралд авгаж эх толгой, зохион байгуулалтаа алдан ундуй сундуй зугатаж эхлэв.

Дайр-Үсэн түгшүүр дүүрэн суухад харин Хулан Тэмүжиний цэргийг мөч тоолон баярлан хүлээнэ. Бүсгүйн хүсэл биелэхэд ойртжээ. Түүний санаснаар болно гэдэгт Хулан итгэлтэй байжээ. Учир нь Мэргэдийн их бөө Бүтэнбэх “Чи Тэмүжиний хатан болох аваас жаргалын туйлд хүрнэ” гэж хувь заяаг нь мэргэлээд хэлсэн билээ. Бөртийг буцаан булааж авснаас даруй хоёр жилийн хойно төрсөн ч өдий арван найм хүртлээ Хулан Тэмүжиний тухай үлгэр домог шиг яриа олныг сонсож, тэр баатар эрийн хий дүрд дурласан байв. Хулан ямар ч үнээр хамаагүй Тэмүжиний хатан болохоор шийджээ. Сониуч эмс болоод настай цэрэг эрс, хөгшдийн амнаас сонссон болгоныг сэтгэлдээ хадгалсаар Хулан, Тэмүжиний хий дүрийг зүрхэндээ баттай босгон шингээж зүүдэндээ үзээд таньдаг болжээ.

Олны ярихаар Тэмүжин харгис догшин, аймшигтай үлгэрийн мангас мэт амьтан ажээ. Хатан Бөртэг буцааж аваад өс санан, мэргэд аймгийн олон хүнийг цавчин алсан аймшигт түүхийг одоо болтол ахмад хүмүүс ярисаар байх билээ. Хавь ойрын аймаг, овгийг нэгтгэн авч, царай гоо эмс хатдыг булаан эзэмддэг Тэмүжиний тухай яриаг сонсох нь Хуланд юугаар ч сольшгүй, урд өмнө амсаж үзээгүй жаргал болдог байв.

Тэмүжин, Хуланы сэтгэлд эр бяртан, эзлэн сөнөөгч, эмс охидыг эдлэн жаргаагч, домгийн хүчит баатар болон сэтгэгдэж барааг нь харж, биеийг нь мэдрэх хүсэл оргилоход бүх булчин шөрмөс нь зангиран чивчирч, давсаг, нууц эрхтэн нь чим чим шархиран өвдөж туйлын амттай мэдрэмж төрдөг юм. Хуланы өдрийн бодол шөнийн зүүд нь Тэмүжин байв.

Тэмүжиний тухай үнэн худал нь үл мэдэгдэх чимээ сураг үл тасарна. Татаар аймгийг сөнөөж

олон сайхан охид эмсийг эзэмдэн авсан гэж ярина. Бас Найман аймгийг дарж олон бүх хатад эмсийг олзолжээ. “Тэр Тэмүжин гэгч баатар эр гэрийн дотор гурван их хатантай мөрт хүрээн дотроо хоёр гурван зуун татвар эмс байлгадаг, ханаж цадашгүй хуял тачаалтай, нэг өдөр арван эм эдлэвч ханаж ядардаггүй гэнэ” гэж эмс хүүхнүүд сэм шивэр авир ярихыг сонсох бүр тэсэн тэвчиж болмооргүй дур хүсэл нь оргилдог билээ. Хулан ийм зовлонг дурлалынхаа хүчээр Тэмүжинд бууж өгөхийг эцгээсээ хатуу шаардсан билээ. Эхээс өнчирч хоцорсон Хулан охиндоо Дайр-Үсэн туйлын хайртай ч өөрийн амь нас хар толгойдоо түүнээс илүү хайртай учир Тэмүжинд бууж өгөхөөр шийдсэнийг Хулан гадарлахгүй өнгөрчээ.

Хуланд санаархсан, тэчъяадсан эрс олон байв. Бүр харуй бүрийгээр хүчээр эзэмдэх гэсэн нэг их санаат эрийг жижиг хутгаар улаан суга руу нь дүрж биеэ аварсан явдал ч бий юм. Хулан өөрийн зоримог хурц зангийн ачаар олон эрийн чивэлт хүслээс аврагджээ. Хэрэв эцэг нь түүний хүслийг эс дагавал Тэмүжинг довлон ирэхэд шууд өөрөө очно гэж тэр шийдсэн байв. Энэ их осолтой хэрэг юм. Гоо үзэмжит бүсгүй ганцаар дэл сул явах нь Тэмүжинд очихын өмнө өөр эрийн хүчинд авган эм биеэ эдлүүлэн булаагдах аюултай тул эцгийн өндөр нэрийн хамгаалал дор очих замыг сонгосон нь зөв байв. Гэтэл ашгүй Тэмүжин Мэргэд аймгийг хүчээр дагуулан авах нь тодорхой болж Хуланы сэтгэлийг гийгүүлжээ. Мэргэдүүд бүгд айсуу сүйрэл мөхлийг мэдээд уйлж унжиж тарж зугатаж байхад ганц Хулан л дуулах нь холгүй баяр хөөр дүүрэн байв.

Хулан Тэмүжинтэй учрахын тулд бүх Мэргэд аймгийг сөнөөхөд ч бэлэн юм. Угаас одоо нэгэнт хүчин мөхөсдөн үед Тэмүжинтэй тэмцсэнээс буун өгч дагаар орох нь зөв гэж Хулан бодно. Гэтэл мэргэдийн толгойлогчид ахмадууд болоод эцэг нь ингэхийг хүсэхгүй байгааг тэр үл ойлгожээ. Огт утгагүй зүйлийн төлөө хайран амиа үрж хамгаа алдах гээд байгаа нь харамсалтай. Гэвч үнэндээ хэн үхэх, үлдэх нь Хуланд огт хамаагүй бөгөөд хүслээ биелүүлж, хүчирхэг Тэмүжиний хатан л болох ёстой гэж бодно. Тэр онгон биеэ ганц Тэмүжинд өгнө гэж шийдсэн билээ. Хуланг удуйд мэргэдийн нэг эр зуун агтаар худалдан авах гэж эцэгтэй нь тохирсон боловч ашгүй Тэмүжин довлон ирэх сураг гарснаар тэдний энэ бодлыг тасалдуулжээ. Хулан үүнийг Тэнгэрийн аврал гэж ойлгоод Тэмүжин ганц өөрийг нь авах гэж Мэргэд аймгийг дайлах гэсэн мэт сэтгэн Тэнгэрт мөргөж, хурдан ирүүлэхийг хүсэх болжээ.

Удалгүй Хуланы бүтэн зунжин хүлээсэн өдөр болж намрын сарын дундуур Тэмүжиний цэрэг довлон ирж мэргэдүүд ихэд эсэргүүцэж төдсөнгүй ундуй сундуй зугатаав. Дайр-Үсэн аймгийнхнаасаа улайм цайм хоцорч үл чадах тул хамт зугатааж хэд хоногийн дараа Саарь хээрийн талд Тэмүжиний цэрэгт гүйцэгдэн, Тогтообэх толгойлогч нь Худу, Чулуун хөвүүдийнхээ хамт эмс, охидоо ч орхин зайлж бусад нь бүгдээр олзлогджээ. Хулан дайсны цэрэг довлон ирсэн өдрөөс хойш хэд хоногийн турш Тэмүжинг олж харах гээд чадсангүй. Хэрэв Тэмүжинг үзэгдвэл даруй гүйж очиход бэлэн байв. Гэтэл дайсны зэрлэг цэрэг довлон ирсэн ийм үед Хулан мэтийн үзэмж цэвэр охид ил задгай явах нь ерөөс үхсэнтэй адил тул Дайр-Үсэн охиноо тас нуужээ. Тэмүжин хан хүн тул жирийн цэргүүдтэй хутгалдан байлддаггүйг Хулан мэдээгүй билээ. Толгойд нөмөрсөн алчуур дороос хаа холд бие хаа өндөр сүрлэг эр харагдвал энэ Тэмүжин биз гэж бодох авч бас л биш байх ажээ. Хулан дотроо Тэмүжинг даруй зургаан тохой нуруутай, зурмал хар хөмсөгтэй, том хар нүдтэй, тогтуун сайхан харцтай эр байна гэж бодох билээ. Харин Дайр-Үсэн хашир хүн тул арга эвийг олж байгаад түүнийг албатуудынх нь хамт олзлон авсан Тэмүжиний цэргийн ноён Наяа гэгчтэй



уулзаж амжжээ.

-Би Хулан нэрт охиноо Чингис хаанд үзүүлэх хүсэлтэй гэтэл Тэмүжиний нэр алдрыг сонссон Наяа

-Чи тэгвэл манайд түр хүлээ.Ганцаар явбал зам зуур цэрэг,ардууд охиныг чинь хүчирхийлж мэднэ. Би Чингис хаанд цуг очъё гэхэд Хулан тэр биеерхүү сайхан эрээс бишүүрхэн айж бас дотроо энэ ноён садарлах гэвэл яана гэж түгшсэн ч тэдэнд үүнээс өөр зам үгүй тул үгийг нь дагажээ. Удалгүй энэ Наяа ноёны ивээлд орсон нь завшаантай хэрэг болохыг тэд үзэв. Тэмүжиний цэргүүд мэргэдийн зүс гоо эмс охид бүгдийг тал тал тийш хуваан аваад үгүй болжээ. Арай дор шигийг нь айж ичих юмгүйгээр хүчирхэн эдэлж, мал хөрөнгийг үлдээлгүй талж авав. Харин энэ Наяа ноён Хуланд хэдий харц унагавч ер шалиглах санаа өвөрлөсөнгүй, төлөв нуруутай эр байсанд Хулан талархалтай болжээ. Гурван өдрийн хойно Наяа ноён, Хуланг Тэмүжинд үзүүлэхээр эцгийнх нь хамт дагуулан явлаа. Хуланы сэтгэлийн догдлол хязгааргүй болжээ. Бэлдэж зэхсэн хувцсаа өмсөж энгэсэг тавихаа ч мартсангүй.

Зам зуур дагалдан явсан Боржигон аймгийн цэргүүд бүгдээр Тэмүжинг “Чингис хаан” гэж хэлэлцэх нь Хуланд дотно сайхан байлаа.

Өндөр өвст Саарь хээрийн талын хойморт гадна нь их хар сүлд мандуулсан хөнгөн асрыг тойроод хэдэн давхар цэрэг бүслэн хамгаалсан нь үзсэн хүний зүрхийг үхүүлж эрхгүй айж сүрдэм ажээ. Хулан сүрдэж бишрэх хийгээд хүсэн хүлээх сэтгэлд автахдаа ихээр догдлон чичрэв. Бүх юм зүүд мэт ажээ. Одоо тэр зүүдний хүслэн болсон баатар эр Тэмүжинтэй учрах цаг иржээ. Өргөөний гадна зогсох уул хад шиг олон эрсийн чухам аль нь Тэмүжин бол гэж харц хяламхийж явжээ. Мэргэд цусны үзэсгэлэнт бүсгүйг харсан эрсийн шохоорхон шунасан нүд духан дээрээ гарахыг үзээд Дайр-Үсэн охиноороо бахархан урам зориг оржээ. Хулан сэтгэлийн хүслэн болсон Тэмүжинг таних гэж баатар эрсийг толгой дараалан ширтэв. Бүгд л Хулангийн өөдөөс дуулганыхаа дороос урхинаар ширтэх ажээ. Өргөөнөөс нэг хүн гарч ирээд Наяа тэднийг

-Ор гэсэн тул Тэмүжин дотор байгаа нь ил болов. Одоо хэдхэн алхаад Тэмүжинтэй нүүр учирна. Бүхнийг дийлэгч хүчит баатар Тэмүжинд таалагдах гэж олон жил хүссэн тэр мөч Хуланд ирлээ. Хулан,Наяа болоод эцгийгээ даган өргөөнд орлоо. Асрын дотор харанхуйвтар тул нүд дастлаа Хулан хэн нь хэнийг ялгаж эс чадав. Гэрийн хоёр талаар бас л сайхан эрс дүүрэн суужээ. Харин Наяа ноён ёслохыг бас эцэг нь сөхрөхийг үзвэл өргөөний хоймор цагаан эсгийгээр бүтээсэн суудал дээр нэг хүн суух нь Тэмүжин бололтой гэж таав. Дуулга духдуулсан тул түүний царай нь үл үзэгдэнэ.

Наяа ноён Хуланг эцгийн нь хамт дагуулан ирсэн хэргийн учрыг тод хэлэв. Хэн ч тодорхой дуугарсангүй ч “Чингис хаан танд Хулан нэрт охиноо үзүүлэхээр ирлээ” гэхийг сонсоод асарт битүү дуу нүргэжээ. Хулан үүнийг сайшаасан шоолсон алин болохыг мэдсэнгүй. Тэмүжин дуугарахгүй удсанд Хулан түгшүүрт автав. Тэр Тэмүжинд таалагдсангүй бололтой гэж айжээ.

-Чи Хулан гэв үү. Наашаа энэ гэрэлд гарч зогс гэж хэн нэг хүн сөөнгө дуугаар хэлж бас нэг нь нурууруу нь түлхэв. Хүмүүс инээлдэж Хулан тэр дороо асрын өрхөөр туссан нарны гэрэлд түлхэгдэн гарчгялбан зогсов. Хоймор сэнтийд суугч хүн дуулгаа авч дэргэдэх хүндээ өгч

босоод түүнд ойртон ирэв. Тэр хүний царайг нарны гэрэлд сая л нэг тод хараад энэ лав Тэмүжин биш биз гэж Хулан түргэн зуур бодов. Намхан нуруутай, даахирч ширэлдсэн үстэй, бууралтсан өтгөн сахалтай тэр хүн дэргэд ирээд ширтэх нь даанч аймаар, бүр дух хацрыг нь өрөмдөх шиг болжээ. Тэр хүнээс морины хөлс, галын утаа үнэртэж байв. Өнөө хүн гэнэт хуурай ширүүн гараар эрүүг нь татан нүд рүү нь харав. Харц тулах тэр агшинд гэнэт “Тэмүжин” гэсэн хачин сэрэл мэдрэмж бүх биеэр нь гүйгээд өөрийн эрхгүй

-Чингис хаан гэж шивнээд сөхрөн суужээ. Юу чухам ингэснийг Хулан хожим болтол ойлгоогүй билээ. Тэмүжиний догшин харцнаас цацрах этгээд шар гэрэл нүдээр нь дамжин зүрхэнд нь нэвтрэн орж бүх биеийг нь халуу оргиулжээ. Ингэж нүднээсээ хурц шар гэрэл цацруулдаг хүнийг Хулан өмнө нь үзсэнгүй. Тэмүжиний тухай бүх дурсамж, бодол мөрөөдөл, дүрслэлийг энэ хачин хүн хормын дотор арчин хаяж, гал мэт халуун урсгал бүх биеийг нь эзэмдэн авахыг Хулан дуулгавартайгаар дагав. Түүний өмнө Чингис хаан зогсож байсан нь энэ юм. Эрүүнээс нь барьсан газар халуун оргино. Чингис хаан гэнэт өөрөөс нь холдон явахад Хулан харц өргөв. Бахдаж, шүлэнгэтсэн олон эрийн харц Хуланы бие дээр нь асгарч байв. Чингис хаан ганц алхаад баганын дор зогссон Наяагийн өмнө очжээ. Түүний сөөнгө дуу заналтай, араатны авиртай сонсдов. Хөдлөх бүрд нь хөө хуяг сэлэм нь харшина.

-Наяа. Чи хаан эзэндээ бэлэглэсэн энэ эмийг яах гэж гурав хоног гэртээ агуулан саатуулав. Чи миний итгэлийг эвдэж сэтгэлийг гутаав. Чи лав энэ эмтэй шалигласан биз. Би одоо үүгээр яана. Чамайг хаан эзнийхээ эмд халдсан гэж цавчин ална. Энэ эмийг ч мөн адил алагтүн гэж Чингис хаан хилэгнэн хашгирахад асарт байгсад бүгд хэлмэгдэн чичрэхийг Хулан үзэж чухам араатан мэт ямар аймшигт хүнтэй учирснаа мэдрэв. Гэм зэмгүй Наяа ноён сайн сэтгэлийнхээ төлөө амиа алдах боллоо. Хуланг гурав хоног гэртээ агуулснаа орж ирүүт нэгэнт хэлсэн тул Наяа ноён үхлээс зайлахгүй нь тодорхой болохоор хөөрхий тэр хэрхэн хариу хэлж биеэ өмөөрөх учраа олсонгүй. Түүнийг дагаж Хулан ч үхэх болов. Хулан ингэхийг яав ч зөвшөөрөхгүй тул ухасхийн урагш алхаж ер эрээлж айлгүйгээр Чингис хааны өмнө очив. Бүгд гайхсандаа алмайрчээ. Харин Хуланд айж ичих учир шалтгаан өчүүхэн ч байсангүй. Дайр-Үсэн амьсгаа хураах шахжээ.

-Чингис хаан. Та сонс. Энэ Наяа ноён надад шалиглах санаа ер агуулсангүй. Харин Наяа ноён асрамжлаагүй бол юу болохыг хэн мэдлээ. Хаан та үл итгэвэл бие мах бодийг минь шалган сорьж үзэгтүн. Бие минь онгон биш байвал би үхье гэж Хулан эрс чанга хэлжээ. Тэмүжин ийм зориг төгөлдөр эмийг өмнө нь үзээгүй тул гайхан хойш алхам ухраад Хуланг толгойноос хөл хүртэл дахин сайтар ажиглав. Хулан Тэмүжинээс өндөр нуруутай ажээ. Тэмүжин чимээгүй инээмсэглэв. Олон бүгд амьсгаа аван уужрав.

Бүгд Тэмүжиний юу хэлэхийг хүлээлээ. Өд шиг хөнгөн, өрөвдөм эмзэг энэ бүсгүй ингэж өөрийн биеийг тулган тушаасан нь Тэмүжинд гайхагдсан ч бас бага бишээр бахдуулсан тул инээмсэглээд

-Чи үхэхээс айхгүй юу гэв. Тэмүжин ингэж хэлсэн нь энэ зоримог бүсгүй түүнд таашаагдсаных юм.

-Би өөрийн биеийг мэдэх тул ингэж хэлэв гэсэн Хуланы дараачийн хурц үг Тэмүжинд бүр ч таашаагджээ.

-Чи хэдэн настай вэ.

-Охин минь арван наймтай юм гэж орж ирснээс хойш үхсэн мэт хөдлөгөөнгүй сөхрөн суусаар байсан Дайр-Үсэн сая л нэг амьсгаа авч уужраад боломж гармагц үг хавчуулж амжив.

-Би Увас мэргэдийн толгойлогч. Өөрийн охиныг Чингис хаан танд сайн сэтгэлээр өргөж таны ивээлд багтая хэмээв гэж бөхийжээ.

-Охин чинь худал хэлсэн байвал Увас мэргэдийн Дайр-Үсэн чи ч бас үхэх болно гэж Тэмүжин хашгирав. Харин Наяа хэрэг учир жаахан тайвширсныг үзээд сөхөрч гараа дээш өргөн сунгаад

Хамаг олны эзэн

Хаан Чингис чамайг

Хайрлаж хүндлэхээс өөр

Хар санаа надад үгүй

Харь улсаас олзолсон

Хацар гоо хатад

Хатир сайн морьдыг

Хаан чиний юм гэж

Халдалгүй харж

Хавиралгүй сахьдаг билээ.

Үүнээс өөрийг сэтгэж

Үнэн санаа гажиж

Үйлдсэн буруу байвал

Үхэхэд би гомдолгүй гэж тангараглав. Энэ бол Наяагийн үнэн сэтгэлийн үг байсан тул Тэмүжин түүнд хүндлэл үзүүлж дээш нь суулгав. Хором агшны дотор үүссэн аюул занал Хуланы зоригт үгийн ачаар сайнаар шийдэгдэж Чингис хаан тайтгарсанд тэнд байгсад бүгд баясан хөөрөлдөв. Үүний дундаас Дайр-Үсэн илүүтэй ихээр, бүр амьдралдаа үзээгүй ихээр баярлажээ.

Тэр даруй Хуланыг гаргаж тусгай гэрт оруулан хооллож ундлав. Чухам юу гээч болох гэж буйг Хулан тод мэдэж байв. Чингис хаан түүний хэлснээр бие махбодийг нь сорьж үзэх болжээ. Эр эмийн янагийн үйлийг өөрийн биеэр үйлдэж үзээгүй боловч үзэж сонссон нь тийм ч бага

биш билээ. Хулан зорьсон санааныхаа талд нь хүрчээ. Тэр ямартай ч Тэмүжиний гэрт ирж их зоригийн хүчээр энгэр зөрүүлэх цаг болов. Тэмүжинд таалагдаж бие сэтгэлийг нь эзэмдэж чадах аваас түүний мөрөөдөл бүрэн биелэх юм. Тэмүжин түүний бодсон шиг өндөр нуруутай, өнгөлөг жавхаатай эр биш байсан нь бага зэрэг гомдолтой ч түүний хүсэж хүлээсэн ганц хүн нь мөн гэдэгт тэр огтхон ч эргэлзсэнгүй. Балчир бага охин нь ямар ихийг зориглон шийдсэнийг Дайр-Үсэн үзэж, гайхаж бишрээд барсангүй.

Тэр зоригт охиныхоо ачаар энэ удаа Тэмүжиний цэргүүдэд алуулсангүйгээр барахгүй, амины албат иргэд, мал хөрөнгө нь үрэгдсэн ч ихэнх нь түүний мэдэлд үлджээ. Хэрэв Чингис хаан Хулан охиныг таалж соёрхвол Дайр-Үсэн хүчирхэг Чингис хааны хадам болох аз иржээ. Дайр-Үсэн Хулан охиныхоо ухаан, зоригтойг үзэж итгэв.

Хулан яах ёстойгоо сайн мэдэж байлаа. Мэдэхээс илүү их хүсэл, тачаал оргилох ажээ. Хуланы эх түүний багад мориноос унаж осолдсоноос хойш тэр эцгийнхээ татвар эм, хэрэйд цусны бүсгүйн асрамжинд өссөн юм. Тэр асрагч эм угийн урин тачаангуйн дээр холын ухаантай бүсгүй байлаа. Асрагч эх нь Хуланд яг найз бүсгүй шиг нь байж эр эмийн янагийн үйлийн бүх учрыг багаас нь таниулж ойлгуулсан нь Хуланг ийм энгийн биш хүсэлтэй болоход нөлөөлсөн билээ. Эр хүн хүч чадалтай, эр зоригтой боловч эмс охидтой энгэр зөрүүлэх үедээ эмийн эрхэнд ордог учрыг тэр Хуланд сайтар ойлгуулсан бөгөөд нэг гэрт хонох үедээ эр эмийн янагийн үйлдлийг Хуланы дэргэд ичих эрээлэх юмгүйгээр бусадтай хийж үзүүлдэг байв. Тэр асрагч эм угаас төрөлхийн цадаж ханашгүй дур тачаалтай тул нэгэн шөнө хэдэн эртэй цэнгэн жаргаж чаддагийг Хулан үзсэн билээ. Эм хүний хамгийн хүчтэй зэвсэг бол эрийн хүслийн оргилуулагч урин тачаангуйн увидас болохыг бас яаж эрийг эзэмдэн татах аргыг асрагч эм нь өөрийн биеэр олонтоо үзүүлсэн юм.

Дайр-Үсэн эцэг нь ч тэр асрагч эмийн урин тачаангуйн увидаст бүрэн автсан хүн болохыг Хулан бас л үзжээ. Тэр асрагч эм хэрхэн янаглахыг, яаж дуугарч хөдлөхийг, эр хүний унтаж унжийсан бие махбодийг яаж сэргээн босгохыг Хулан олон удаа дээлийн зах доогуур харж сонссон нь одоо л хэрэг болох цаг нь иржээ. Хоёр жилийн өмнө асрагч эмийг агтач эртэй шалиглав хэмээн эцэг нь хилэгнэж, тулманд хийн усанд үйж алахад Хулан эхийгээ алдсан мэт өчнөөн хоног толгой өндийлгүй уйлж гашуудсан билээ. Хайртай эмээ дэмий хардаж алсандаа Дайр-Үсэн ч ихэд харамсан өөрийгөө хараажээ.

-Эрийг эзэмдэхэд ганц гоо үзэсгэлэн үл хүрэлцэнэ. Чи эрийг эзэмдэж өмнөө сөхрүүлье гэвэл аймшиггүй зоригтой, алмай ичгүүргүй байх хэрэгтэй гэж асрагч эмийн хэлдэг нь үнэн болохыг өнөөдөр Хулан Чингис хааны өргөөнд үзэж итгэжээ. Одоо түүнд айх, ичих зүйл өчүүхэн ч үгүй болжээ. Үдэш болж алс холын үймээн, хүн малын дуу дарагдсаны хойно өөрийн биеийг угааж арчилж бэлдсэн Хулан нүцгэн биен дээр нимгэн дээл хөдрөөд Тэмүжинг хүлээж байв. Өнөө шөнийг хэрхэн өнгөрүүлэхээс, Хуланы яаж эм хүн шиг аашилж аяглахаас түүний амьдрал бас амь нас хамаарах болжээ. Тэр энэ замыг нэгэнт өөрөө сонгосон тул эргэлзэж тээнэгэлзэх юмгүй харин ч баяр хөөртэй байлаа. Хулан асрагч эмийнхээ яаж хөдөлж дуугардагийг тов тодорхой сэргээн санав. Санах бүр дур тачаал нь оргилох ажээ. Бүр юу хийхээ ч бодож төлөвлөжээ. Одоо ганцхан Тэмүжиний ирэх л үлдэв.

Үүд гэнэт чив чимээгүй сөхөгдөн өдрийн уулзсан догшин шар нүдтэй хүн сүүдэр шиг гулсан орж ирэв. Байлдааны хуяг дуулгаа тайлж энгийн хөнгөн нимгэн дээл өмссөн Тэмүжин улам

ч бөгтөр давжаа жижигхэн болчихсон юм шиг үзэгдэв. Олныг бишрүүлэгч, айлган довтлогч, хамгийг дийлэгч их Чингис хаан гэхэд даан ч гологдмоор царай муутай онигор хар хүн өмнө нь зогсож байлаа. Гэвч түүний догшин шар нүднээс цацрах омог бардам шар гэрэл энэ хүн бол өөр хэн ч биш Тэмүжин гэдгийг гэрчилнэ.

Хулан босч даруухнаар мэхийн ёслов. Тэмүжин суусангүй түүнийг ширтсээр зогсоно. Хулан огцом хөдөлж нүцгэн биендээ хөдөрсөн дээлээ тайлан хаяв. Галын бүдэг гэрэлд Хуланы хатуурч сэрийсэн хөх, уян боловч шөрмөслөг гоолиг биенээ галын улбар туяа тусч өнгийн чулуун сийлбэр шиг үзэгдэв. Тэмүжин хүчээр биеэ барин хэнэггүй царайлж байхыг Хулан мэдэрлээ. Тэмүжинг шууд байлдан дагуулж эрхэндээ оруулахыг Хулан хүсч байлаа.

-Чамайг эцэг чинь надад хүчээр авчирч өгөв үү. Энэ бол тун аюултай сорьж туршсан асуулт байлаа. Юу гэж хариулахаа Хулан тэр дор нь бодож олов. Таалагдахгүй үг хэлбэл тэр маргааш өглөө алуулах юм уу, аль эсвэл одоо түүнийг хэн нэг цэрэгт хаяж өгөх байв.

-Аав минь намайг танд өгөх, бас танд дагаж ирэх дургүй байв. Харин би хаан танд ирэхийг эцгээсээ гуйж шаардсан билээ гэж Хулан үнэн үг хэлэхдээ эцгээ ер өрөвдөж хайрласангүй.

-Чи өөрөө нададирье гэсэн гэнэ ээ. Чи юу хүснэ гэж Тэмүжин зэвүүн шивнээд нэг алхам ойртов. Харин Хулан байрнаас хөдөлж ухарсангүй түүнийг эгц ширтэж байгаад сэтгэлийн дотор байдаг хамгийн их хүслээ шууд дуржигануулан өчжээ.

-Хаан та гурван их хатантай гэсэн. Би таны дөрөв дэх их хатан болохыг хүснэ. Та намайг эдэлж сорьж үзэгтүн. Эс таалагдвал өглөө намайг алж орхи. Надад таны хатан болох, эс чадвал үхэхээс өөр хүсэл үгүй гэж тод хэлжээ. Энэ омголон зоримог мэргэд бүсгүй Тэмүжинд таалагдаж байсан ч өөдөөс нь ингэж ач тач үг хаях нь хилэнг нь хөдөлгөв. Тэмүжин энэ дэндүү шулуун задгай, эрээ цээргүй гэмээр үгэнд уурссандаа Хуланг зэрлэг догшиноор угз татан тэврэн авсан нь зүгээр л шууд хүчирхийлэн эдлээ гэж бодсоных байв. Гэтэл бүгд санасны эсрэг болжээ. Бүсгүй огтхон ч эсэргүүцсэнгүй, ингэнэ гэж хүлээж байсан юм шиг гарын аяар наалдан ирээд зогссонгүй бүр Тэмүжинг ширдгэн дээр түлхэн унагаад даран авчээ. Тэмүжин ийм юм үзээгүй тул эхлээд амиа хорлуулах бий гэж сэргийлэн түлхсэн боловч хожимджээ. Хулан бүсгүйд тийм санаа үгүй нь тэр дороо ойлгогджээ. Учир нь Хуланы савхан хуруунууд аль эрт шалмаг хөдлөн нууц эрхтэнг нь илбэн таалж эхлэхэд Тэмүжин цочиж ичсэн ч эм хүн ингэж тачаадан довглох нь харин ч таатай санагдаад биеэ суллан Хуланы гарын аяыг дагахдаа

-За яах вэ. Чи их зоригтой бүсгүй юм. Маргааш хүссэнээр чинь би алж орхье гэж бодсон билээ...

Шөнө болж Саарь хээрийн хөндийд ялсан, олзлогдсон олон хүмүүс унтах нь унтаж, ууж наргих нь ууж наргиж, янаглаж амраглах нь ч янаглан амраглаж, ядарч шархадсан нь ёолж орилж байв. Энэ шөнө олон олон хүүхэд эхийн хэвлийд олдож бас олон олон хүн үхжээ. Тэмүжин мэргэдийн Дайр-Үсэнгийн охин Хулантай жарган цэнгэхийг бүгд үзэж сонсов. Тэмүжиний гэрээс холгүй байсан майхныхаа дэргэд Зүчи бодолд авган удаан зогсов. Эцгийгээ ингэж элдэв эмс охидтой самуурах бүр Зүчийн сэтгэл тэсэлгүй бэрхээр өвдөн шаналж, холд суугаа Бөртэ ижийгээ өрөвдөн хайрладаг билээ. Өнөө ч яг ингэж зогслоо. Хулан

хэмээх мэргэд эмийн тачаалт дуу ойр орчмыг сэрээж, адгуусны ч болов сэрлийг өдөөхөөр ажээ. Эцгийнхээ энэ шалиг явдлыг Зүчи ер сайшаан бодсонгүй. Тэр дундаа мэргэд эмтэй самуурах нь бүр байж болшгүй хэрэг гэж бодно. Учир нь мэргэд аймаг бол Бөртэ эхийнх нь бас Зүчийн хамгийн заналт дайсан билээ. Ингэж бодох нь эхийгээ өрөвдөхөөс болдог байв. Бөртэ эх нь Зүчийн хувьд энэ ертөнцийн хамгийн их зовж шаналсан хүн юм. Хулан нэрт их тачаалт эмээс болж эх нь дахин зовох юм шиг гунигт бодол төрөөд Зүчийг унтуулсангүй.

Харин Хуланд эдлүүлж нойргүй хоносон Тэмүжин маргааш өдөр нь аажуу өндийхдөө урьд үдшийн хатуу бодол шийдвэр нь өөрчлөгдсөнд ихэд гайхав. Тэр Хуланг алах нь бүү хэл их зориг, хэмжээгүй тачаал, янаглах эрдмийг нь үнэлж гайхан бишрэхдээ хатан буулгахаар шийдэж эл хэргийн учрыг эхлээд Өүлэн эхдээ уламжлуулахаар Боорчийг Хэрлэн мөрний тийш төв хүрээрүү илгээв. Өүлэн эхэд түрүүлж хэлүүлсний учир нь Бөртийн сэтгэлийг эмзэглэх бий гэж санаа зовсных юм. Учир нь Хулан бол Бөртийг булаан аваачиж бие сэтгэлийн зовлонд учруулсан мэргэд аймгийн хүн байсных билээ. Ийм явдлыг Бөртэ сайшаан угтахгүй нь лавтай. Харин Өүлэн эхдээ түрүүлэн учирлавал эв зүйг нь олж зөв найртайгаар шийдвэрлэх нь гарцаагүй гэж Тэмүжин итгэж байв.

Аливаа хүнд бэрх үед зөвийг хэлж эвийг олдог нь Өүлэн эх юм. Боорчийг илгээсэн цаад наад нарийн учрыг Өүлэн эх гадарлан ухаарах нь мэдээж тул Тэмүжин тайван сууж, олзлогдсон мэргэдийг хэрхэх тухай хөвүүд болоод Хасарын хамт зөвлөлдөв. Бас үдэш нь Хуланы эцэг Дайр-Үсэнг урьж дайлахаа ч мартсангүй. Тэмүжин угаас юмыг жижиг гэж орхидоггүй зантай юм. Хуланы Тэмүжинд таашаагдсан нь олзлогдсон мэргэдийн хувь заяаг нааштай эргүүлж, тэднийг хүрээ хотод нь үлдээн зүүн өрх тутамд ахлагч томилж, бүх мэргэдийг Дайр-Үсэн ахална гэж Тэмүжин зарлиг буулгав. Хуланг шударгаар асран авчирч өгөөд бас үнэн үгээ хэлсэнд Наяаг нөхөрлөж болох хүн гэж ихэд тоожээ.

### *ЦУСГҮЙ ТУЛААН*

Тэмүжиний их хүрээнээс холгүй тусдаа намаржиж байсан Өүлэн эх гэнэт дуудуулсанд Бөртэ ихэд цочин гайхжээ. Энэ үед Бөртэ хөдөө гэрт зарц шивэгчид болоод татвар, боол эмсийг цуглуулан эсгий хийх унгас саваадуулж байжээ. Энэ бол намар цагт талын нүүдэлчдийн хийдэг хамгийн чухал ажлуудын нэг бөгөөд удахгүй ирэх хахир өвлийн бэлтгэл юм. Өүлэн эхийн ийн гэнэт дуудсан нь туйлын сэжигтэй санагдсан тул Бөртэ их өргөөгөөрөө орж хувцсаа ч солилгүй дан мориор дагуул шадраа шавдуулан давхисаар Өүлэн эхийн хүрээнд очжээ. Мэргэдийг дайлахаар явсан хөвүүд нь хамгийн түрүүн бага балчир Тулуй хүү нь санаанд орж муу л юм бодогджээ. Дайны талбараас Боорчи ирж Өүлэн эхтэй уулзсаныг шивэгчдээс олж сонсоод бүрч сэтгэл зовжээ. Өргөөнд нь бараалхан ормогц сайтар ажигласан ч Өүлэн эхийн царайнаас муу сэжиг илэрсэнгүйд тайвшрав. Харин Өүлэн эх мэндийн үг солиод цай идээ тавьж зарц шивэгчид гарсаны хойно

-Чи Чингис хааны их хатан мөртөө харц зарц шиг энгийн хувцаслаж, эзэнгүй мэт явах чинь юу вэ. Чамайг ингэж явахад Есүй Есүгэн хатад яах вэ. Хаан хүнийг хатны нь явдал суудлаар хэмждэг юм гэж зэмлэх үгийг хамгийн эхлэн хэлэхийг сонсоод дэмий яарсандаа харамсавч оройтжээ. Өүлэн эх уурлаж загнавал муу юм хэлэхийн дохио билээ. Тийм ч учраас Бөртэ Өүлэн эхийн зэмлэхийг сонсоод дахин түгшүүрт автав. Өүлэн эх ямар нэгэн муу мэдээг хэлж чадахгүй нууж байх шиг санагджээ. Бөртийн мэгдэж сандрахыг үзсэн Өүлэн гэнэт түүнийг

өрөвдөж хайрлан тэвэрчээ. Энэ хачин байдал Бөртийг эхлээд гайхуулсан ч бас ихэд уярааж, Цотон эхээ нас барснаас хойш ганцаардан шаналж явсан сэтгэл нь урагдан сэмэрч тэсэлгүй нулимс асгаруулав. Эхийнхээ энгэрт толгойгоо наагаад асгартал уйлах хүсэл бүсгүй хүнд хичнээн их байдгийг Бөртэ сая л мэдэв. Эхгүй өнчинд эрхлэх, уйлах ч хүн олддоггүй ажээ. Бөртийн үнэн сэтгэлийн нулимс Өүлэнг ч уяраав. Тэмүжинийд ирж зовлон түгшүүр, баяр баясгалан аль аль нь дүүрэн амьдарсаар ирсэн ч төрүүлсэн эх Цотон нь нас нөгчсөнөөс хойш яаж ихээр ганцаардаж явснаа Бөртэ мэдсэнгүй ажээ.

-Иш чааваас даа. Охин минь. Уйл уйл. Ижлээсээ төөрч хоцорсон өнчин унага шиг, хөхнөөсөө гараагүй янзага шиг амьтан манайд ирсэндээ чи. Хайртай аав ижий, өссөн дассан нутаг усаа орхиод ядуу Тэмүжинг минь дан дээлтэй, даавуу гэртэй гэж гололгүй ирсэн охин үр минь. Би чамайг яасан ч их зовлонд унагав даа. Чи Тэмүжин хөвүүний минь төлөө бүлээн сэтгэлээ зарж бүтэн биеэ үрсэн. Ижий нь чамайг ойлгож байна. Төрсөн эцэг эх рүүгээ буцмаар үе чамд олон байсан биз. Би ч чамайг өрөвдсөндөө буцаасай гэж санасан үе олон бий. Гэвч чи яаж буцах билээ. Би чамайг яаж ч буцаах билээ. Тарж сарниж хагацаж өнчирсөн Есүхэйн удам, Боржигон аймгийн нэрийг бүтэн болгож, бүр ургуулж төлжүүлсэн нь Бөртэ чи юм шүү дээ. Чиний гавьяа зүтгэлийг хэн ч хэзээ ч үгүйсгэн буцааж үл чадна. Тиймээ, чи надаас болж мэргэдэд булаагдсан. Буцаж ирснээс чинь хойш Тэмүжин чамайг яаж хардан хажиглаж зовоосныг би л мэднэ. Өөр хэн ч мэдэхгүй. Гэвч чи надад гомдлын ганц үг ган гэж дурсаагүй ч өглөө бүр би чиний нулимс нэвчсэн харцнаас зовлонг чинь мэддэг байлаа. Даанч дэндүү тэвчээртэй хүн дээ чи. Чи бол миний дээлтэй төрсөн охин үр минь юм шүү. Есүхэйн үхлээс хойш амьдрал минь ганцхан хар бараан сүүдэр шиг байсан. Гэтэл ижийнхээ өврөөс ч гараагүй шахам нялх амьтан, өрөвлөг нь хатаагүй ангаахай шиг охин, Тэмүжин хөвүүнтэй минь хамт уяан дээр буугаад инээгээд ирэхэд чинь олон жил уйлахгүй гэж хураасан нулимс сул асгараад ухаан балартсан юм. Чиний гар тэр үед ийм ширүүн байгаагүй.

Хөөрхөн булбарай зөөлөн алга чинь духанд хүрч “Ижээ” гэж дуудахад би сэрсэн. Чи яг л ижий минь эргээд ирэх шиг үзэгдсэн шүү. Чи миний охин мэт, бас ирэхгүй одсон ижий мэт ирсэн юм даа. Есүхэйн удмыг амьд үлдээх гэж, амьдруулах гэж, өсгөж үржүүлэх гэж чи бид хоёр хамт зүтгэлээ. Би өөрийгөө зовов. Хэн нэгний төлөө амьдрал гэж хэзээ ч бодож байсангүй. Энэ бол чи бид хоёрын биелүүлэх ёстой Тэнгэрийн зарлиг биз. Чи бид хоёр одоо нэг нь хаан хүүтэй, нөгөө нь хаан эртэй боллоо.

Чи ирээдүйн монголын их хаадын эх болжээ. Тэгэхээр чи нулимсаа арчиж хааны хатан шиг байж үз. Монгол угсаатны төлөө байгуулсан гавьяагаа бодоод Бөртэ чи, бас Өүлэн би хэний ч өмнө уруу дорой явах эрхгүй болжээ.

Өүлэн энэ бүх үгсийг Бөртийг зорижуулах гэж хэлж буйг тэр ойлгов.

-Есүй хатныг ирснээс хойш чи биеэ тордож асрах чинь багасаад нэг л алмай алгуур болжээ. Шинэ хатны өмнө чи хэзээд омог төгөлдөр их хатан байх ёстой юм шүү. Чи над шиг эмгэн болсон биш, нас зүс чинь идэр сайхан хэвээр байна. Бөртэ чамайг олон бүгдээр харж биширч дагаж байна. Чи одоо Чингис хааны их хатан болжээ. Удахгүй улсын их хатан болно.

Өүлэн эх чухам юу гэж хэлэхээр дуудсаныг Бөртэ гэнэт тааварлав. Ингэмэгц зүрх нь түргэнээ цохилж гомдол нь буцлаад ирэв. Гэвч жирийн нэг гэрийн эм шиг атаархаж хорсох цаг, нас

биш гэдгийг мэдэж байв. Гэвч эм заяанд төрсөн юм болохоор хардаж харамлахын зовлонгоос ангид байсангүй.

-Ижий минь та хэлэгтүн. Би одоо аливээ зүйлээсчочиж түгшихээ больсон. Би таны хэлснээр биеэ тордохоо ч анзаарна гэж Бөртэ сэтгэл зориг шулуудан үсээ илбэж суудлаа засч хэлэв.

-Бөртэ. Тийм бол чи сонсогтун.

Өүлэн үгээ үргэлжлүүлэхийн өмнө түр азнан бодолхийлэв. Есүгэн, Есүй хатдыг авчрахад Бөртэ тийм ч дуртай байгаагүйг Өүлэн сайн мэдэх учир үгээ цэгнэх ёстой болжээ. Гэвч Чингис хааны хүслийг эсэргүүцэх юм уу эгдүүцэх нь төрийн ёсонд харш болно гэж Өүлэн бат итгэх бүлгээ. Гэвч бүсгүй хүн хэзээд л бүсгүй хүн байх ажээ.

-Чингис хаан нэг бүсгүйг хатан өргөмжлөх гэнэ. Энэ тухай намайг чамд хэл гэж элчээр зарлиг болгожээ. Тэгээд чиний зөвшөөрлийг хүсчээ. Энэ үгийг хэлэхэд надад ч хэцүү байна. Гэвч би Чингис хааны зарлигийг чамд уламжлахаас өөр яах билээ гэж Өүлэн хэлэв. Бөртийн дотор нэг юм өгсөөд иржээ. Гэвч аль болох тайван байхыг хичээв.

-Залуу сайхан бүсгүй биз. Надаас зөвшөөрөл хүсэх юув гэж Бөртэ тэсэлгүй унтууцав.

-Чи бүү уурла. Учир нь тэр бүсгүй нь мэргэд хүн юм байна. Увас мэргэдийн толгойлогч Дайр-Үсэн гэгч хүний Хулан гэдэг охин гэнэ гэсэн Өүлэний үг хэлэхэд ч сонсоход ч хэцүү байлаа. Бөртэ шүд зуун асар их тэвчээр гаргаж тэвчиж суув. Юм ч дуугарч чадсангүй.

-Тэгээд Хулан хатны өргөөг хаана барих, хэзээ угтаж авахаа их хатны хувьд чамайг хэлэгтүн гэжээ. Чингис хаан нэгэнт чамайг мэд гэсэн тул чи их хатны хувьд хариу хэлж элчийг буцаах болжээ гэж Өүлэн тушаах аргадах хослуулан хэлэв.

-Чингис хаан нэгэнт зарлиг буулгасан хойно би юу гэх вэ дээ. Ижий минь. Би өргөөг нь бэлдэж бариулья. Харин Чингис хаан хэзээ морилохоо өөрөө мэднэ биз гэж элчид хэл дээ гэж Бөртэ арайхийн хэлж чаджээ. Тэмүжинд гомдсон Бөртийн сэтгэлд хязгаар байсангүй.

-Чи өөрөө наад үгээ Боорчид хэл. Чингис хааны их хатан Бөртэ чи шүү гэж Өүлэн хэлэхэд түүний дуунд бүхнийг Бөртэ чи үүрэх тавилантай юм шүү гэсэн хатуу шаардлага тод сонсдох ажээ. Бөртэ ч хатуу заяагаа дагаж үүнээс хойш хүний урманд хөмсгөө зангидсангүй. Өүлэн эхэд хэлснээс нэг ч илүү үг Боорчид хэлсэнгүй.

Бөртийн хэлсэн үгийг Боорчи Тэмүжинд үгчлэн дамжуулав. Бөртийн хэлүүлсэн үгийг сонсоод Тэмүжин өдөржингөө хэнтэй ч уулзсангүй ганцаар бодол болон суужээ. Тэмүжинг шийдвэрээ өөрчлөх гэж байна гэж Боорчи таамагласан ч тийм юм болсонгүй. Хулангийн Тэмүжинд ирсэн учир ийм юм. Харин Бөртэ илүү дутуу өөлсөн үг хэлж, залуу Хуланг ад шоо үзэж, аашилж загнадаггүй ч мэргэд цусны тэр дундаа Дайр-Үсэнийг охиныг хатан буулгасанд их дургүй байсан билээ. Учир нь мэргэдид булаагдаад байхад Дайр-Үсэн түүнийг Чилэгэр бөхөөс худалдан авахаар ихэд сүр далайлган тулгаж шунан тачаадаж байсныг бүр Чилэгэр бөхийн эзгүйд ирж хүчирхийлэн эдлэснийг Бөртэ яахан мартаж билээ. Тэр үед Бөртэ Чилэгэр бөхөөс хүүхэд олчихсон байсан тул хүний аймагт эзэнгүй хаягдах эсвэл эр дамжин



зарагдахаас айж энэ явдлыг тас нуужээ. Үүнээс өөр зам түүнд байсангүй. Харин охиноо дагаж ирсэн Дайр-Үсэн Бөртийн нүдэнд өртөхөөс үнхэлцгээ хагартал айх тул Тэмүжиний хүрээгээр үл үзэгдэнэ. Харин Зүчи Хуланг нэг нүдээр үзэхгүй болсон нь Бөртийг багагүй зовлонд учруулсан билээ. Гэвч Бөртэ дотроо нэгийг бодсоор байлаа. Энэ бол Дайр-Үсэнгээс өшөө авах хүсэл юм. Гэтэл бүх зүйл огт санаандгүйгээр эргэв. Хуланг хатан өргөмжилснөөс хойш хэдхэн сар болоод байтал олзлогдсон, дагаж ирсэн мэргэдүүд үймрэн самуурч салж нүүсэн тул Тэмүжин дахин цэрэг хөдөлгөж тэднийг дарж толгойлогчдыг алсан ч Дайр-Үсэнг алж арай төвдсөнгүй. Нэгэнт бие сэтгэлийг бүрэн эзэмдэн хамгийн хайртай хатан нь болж чадсан Хуланг гомдоож цочоохыг тэр хүссэнгүй тул хадам эцэг Дайр-Үсэнг өршөөхөд бэлэн байжээ. Харин Дайр-Үсэнг амьд үлдээсэнд Бөртэ маш их дургүйцэн шүүмжилжээ. Тэмүжин Бөртийн сэтгэлийн цаад учрыг мэдэж байсан ч Хуланг бодоод урван тэрсэлсэн Дайр-Үсэнг өршөөхөөр шийджээ. Гэтэл Хулан үүнийг огт зөвшөөрсөнгүй, эцгийгээ бүр өшрөлт дайсан мэт үзэж “Урваж тэрсэлсэн хүнийг юунд өршөөв” гэж эрс эсэргүүцсэн нь Тэмүжинг хамгийн ихээр бахдуулжээ. Нэгэнт Хулан, эцгийгээ шударгаар цээрлүүлэхийг шаардсан тул Тэмүжин эргэлзэх юмгүй болж Дайр-Үсэнг алжээ. Ингэж Хулан санасандаа хүрч Тэмүжиний гэрт ганцаар үлдсэнээр барахгүй олны дунд зориг зүрх, шударга шулуунаараа багагүй алдаршин тэдний итгэл хүндлэлийг олжээ. Тэмүжин үүнээс болж Хуланг улам ч дотно хайрлах болжээ. Эргэж буцсан, шийдвэр сул эцгээ дахин гай болохоос Хулан сэрэмжилсэн тул түүнийг даруй алахыг шаардсан учиртай билээ.

Эцэг нь нэгэнт дагаж ирчихээд удалгүй мэргэдүүдийг босгон үймүүлсэн нь өөрийн хар толгойгоор зогсохгүй Хуланд ч аюултай хэрэг байсан тул тэр ингэж эцэгтээ хайр найргүй хандсан юм. Тэр бүү хэл үлдсэн мэргэдүүдийг нэгдэн хүчирхэгжих замыг хааж, тэднийг айл бүрт хувааж тараан өгөхийг ч Хулан санаачлав. Энэ урин тачаангуй, ялдам зөөлөн бүсгүйн хаанаас нь ийм хатуу ширүүн үг, харгис зан гардгийг Тэмүжин таасангүй. Хулан хэдий ихээр гайхуулнав Тэмүжин өдөр ирэх бүр түүнд улам ихээр татагдан дасах ажээ. Хуланы ганц хүсэл энэ юм. Харин Тэмүжинг ингэж бага хатандаа онцгой дотно байхыг бусад хатад таашаахгүй ч үг хэл хэн гаргах билээ. Харин Бөртэ Тэмүжинг Хулангийн хамт өргөөндөө урихгүйд Тэмүжин их гайхна. Уг нь тэр ийм тоглоомд их дуртайсан. Залуу үзэсгэлэнт хатнаа хэрхэн янагладгийг үзүүлэх хүсэл их байвч Бөртийн хуучин шарх сэдэрэхээс болгоомжлон Тэмүжин Бөртийн өргөөнд хонохоор очихдоо Хуланг ер дагуулдаггүй байв. Хулан бол мэргэд цусных гэдгийг Бөртэ ч, Тэмүжин ч адил нэг ч өдөр мартаагүй билээ.

Дайр-Үсэнг үхүүлж мэргэдийн хэрэг нэг тийш шийдэгдсэний дараа нэг өдөр Чингис хаан Бөртэ хатныхаа өргөөнд очжээ. Хулан хатныг ирснээс хойш тэдний хооронд үүсэж бий болсон хүйтэн хөндий байдал Дайр-Үсэнг үгүй болсноор бага боловч дулаарсан нь ил байлаа. Тэмүжинг ингэж хоногоор ирсэнд Бөртэ их догдлон залуу бүсгүй шиг улайж, уусан дарсандаа ялимгүй согтуурч тас тас хөхөрч жаргалтай суужээ. “Ашгүй Бөртийн гомдол арилжээ” гэж Тэмүжин баясан бодоод өнөө шөнө явахгүйгээр шийдэв.

Уг нь тэр Есүй хатныдаа хоноё гэж бодож байсан билээ. Есүйг амаржиж охин төрүүлснээс хойш ер очиж хоносонгүй сар шахаад байжээ. Гэвч Бөртийн ийм аз жаргалтай байхыг ойрд үзээгүй тул түүнийг орхин явж гомдоохыг хүссэнгүй. Тэр шөнө Бөртийн янаглаж тачаадах нь хязгааргүй болоод Тэмүжин ч гайхжээ. Учир нь тэд нэг гэрийн эр эм хоёр шиг бие золгуулж учралгүй даруй таван сар болсон тул Бөртийн хагсарч ганцаардсан нь их байлаа. Шөнийн

турш загас наадуулж Тэмүжин бүр ядарч хоцров. Тэгэвч “Залуу хатнаа бодов” гэж Бөртийг уурлах бий гэж болгоомжлон шүд зуун тэсэж байжээ. Үнэхээр ч дөч гарсан насны Бөртэ залуу Хулангай хэрхэн дүйцэх билээ. Харин Тэмүжин Бөртийн янаглалд ядраад дотроо Хуланг бодож хэвтэв. Хулан хатан нь гайхалтай халуун биетэй эм ажээ. Түүний хатад, эмс дотор ийм халуун биетэй хүн үгүйг Тэмүжин сая мэдээд гайхжээ. Хулангийн омголон зоримог байдал ер биенээс нь оргилох тэр халуунгай холбоотой болохыг мэджээ. Анх учрахдаа Хулангийн нүцгэн халуун биеийг хүрмэгц ихэд гайхаж цочсон билээ. Бас шатаж байгаа мэт тэр халуун биенд дасахгүй байсан боловч харин одоо Бөртийн өвөрт хэвтэхдээ Хуланг хүсч мөрөөдөж сэтгэлээ баясгаж байлаа. Хуланг бодохгүйгээр Тэмүжиний дур сэрэл огт хөдлөхгүй болжээ. Бөртийн хамт янаглаж хэвтэвч дотроо Хулангай хамт байна гэж сэтгэж өөрийгөө хуурч байв. Бөртэ дур тачаалаа гурвантаа асгаруулж байж сая л нэг Тэмүжинг орхиж амраав. Тэмүжин ер түүнээс уйдаагүй мэт тэвэрч хэвтэхэд Бөртэ хууртан наалинхайтаж

-Тэмүжин би нэг зүйл бодов. Чи юу гэж санана гэж чихэн дээр нь шивнэв. Тэмүжинд энэ хэргийг сонирхох хүсэл огт үгүй байсан тул дуугарсангүй.

-Хулан хатан залуу хүн болохоор төр ёсны аливаа хэрэгт осолдож эндэх нь элбэг. Тийм болохоор би Хуланг аливаа хэрэгт нарийн зааж сургахаар шийдлээ. Ю-Унчиг би Хулан хатны дэргэд шадарлуулъя. Та төрийн ёс хүндлэлд Хулан хатнаа байлцуулах дуртай. Чингис хааны хатан ямар байвал зохих вэ. Тийм байдлаар Ю-Унчи Хулан хатныг сургаг. Би бүх зүйлийг Ю-Унчид сайтар хавсран захиана. Ингэж хийвэл ямар санагдана гэж Бөртэ хэлжээ. Энэ үг Тэмүжинг нойрноос сэртэл баярлуулав.

-Бөртэ чи юу гэж шийднэ. Түүгээрээ хий. Би зөвшөөрөхөөр барахгүй баяртай боллоо. Чи үүнээс хойш Хуланг өөрийн охин мэт үзэгтүн. Тэгвэл миний санаа амарч жаргах болно. Чи Хуланг мэргэд хүн гэдгийг март. Мэргэд гэж өнөө үгүй болсон. Чи тайван сайхан амьдар. Чиний уужим ухаанд би их талархах ёстой юм гэж Тэмүжин үнэн сэтгэлээс хэлжээ. Бөртэ Хуланг өршөөсөнд Тэмүжин хамгаас ихээр баярлав. Мэргэд цусны хатан буулгаж Бөртийн сэтгэлийг шархлуулсандаа Тэмүжин өнөө болтол шаналсаар байжээ. Ядаж байхад Өүлэн эх нь хушуу нэмж

-Хүү минь чамд мэргэдийн энэ хүүхнээс өөр эм хүйстэн олдсонгүй юу. Нүд чинь сохорч болно. Харин сэтгэл чинь сохорч болохгүй дээ. Бөртийг чи хэнд булаалгасанаа мартав уу. Харин Бөртэ үүнийг хэзээ ч мартахгүй биз гэж зэмлэсэн нь Тэмүжинг улам ч зовоожээ. Тэглээ гэвч түүнд Хуланг буцаан алдах сэтгэл өчүүхэн ч байсангүй билээ. Бөртэ ухаан зарж одоо Хуланг мэргэд хүн гэдгийг мартахаар шийдсэнийг үзээд Тэмүжин сая нэг санаа амарчээ. Ю-Унчи гэгч тайган эрийг ордны бусад тайгануудын хамт Татаар аймгийг дарахдаа олзлон авчраад Бөртэд өгсөн бөгөөд тэд Чингис хааны их өргөөнд алба хашин суух болжээ. Ю-Унчи гэгч нь хамгийн ахмад туршлагатай бүр Зүрчидийн Алтан улсын хааны ордонд алба хашиж байсан хүн юм. Тэр Ю-Унчи одоо Бөртийн дэргэд шадарлаж Чингис хааны ордны дотоод хэргийн их даамал болсон ажээ. Тийм болохоор Ю-Унчиг Хулан хатанд шадарлуулан өгөхөөр шийдсэн нь Бөртэ Хулан хатанг өөрийн зиндаанд үзэж буйгаа илэрхийлсэн хэрэг гэж Тэмүжин ойлгоод машид баярлаж өглөө нь энэ тухай Хуланд өөрөө дуулгажээ. Хулан тэр өдөр үнэхээр баяртай байлаа. Учир нь тэр Тэмүжинээс бие шалтагтай болсноо мэдээд байлаа.

-Хулан чи өөрийгөө мэргэд хүн гэдгийг март гэсэн Чингис хааны үг Хуланг тэр тайган Ю-Унчигаас илүүгээр баярлуулжээ. Харин Хулан өөрийнхөө мэргэд удмыг бүгд мартаасай гэж шунан хүсч байсан тул Чингис хааны дээрх үгийн дараа өөрийгөө дагаж ирсэн бүх мэргэд шивэгчин, ойр дэргэд байсан албат зарц нараа бусдад тараан өгчээ. Тэр ямар нэг мэргэд удмын биш, ганцхан Чингис хааны хатан байхыг туйлаас хүсч байв. Түүний мөрөөдөмтгий, ухарч няцашгүй сэтгэлд нь дийлдэн сөнөсөн мэргэд аймгаас гаралтай байх нь тэвчишгүй доромжлолтой мэт санагдана.

Хулан Чингис хааны өвөрт түүний дур хүслийг эзэмдэн хэвтэхдээ ер ичиж айх зүйлгүйгээр энэ мэт зүйлийг хэлдэг билээ. Тэмүжин Хулан хатныхаа хөнгөн бодол, хөөрүү гэнэн үгийг сонсоод элэглэн хөхөрдөг ч дотроо Хуланы цаад санаа зорилго их бөгөөд зөв болохыг мэдэж улам ч хайрлан тоох болжээ. Хулан бол бүхнээс онцгой содон илбэ шидтэй мэт бүсгүй байв. Энэ бол ганц түүний гоо үзэмж биш юм. Ойр хавийнхны эмс хатдын дунд Хасарын Хуаржин хатан гоо үзэмжээр онцгой бөгөөтөл Хулан түүнээс ер дутахгүй харин ч давах тул Тэмүжин сэтгэл ихэд ханадаг байлаа. Бас Хуланы эм хүнд байтугай, эр хүнд ч цөөн байх эрс хатуу зориг, зорьсон санасандаа хүрэхийн тулд цуцалтгүй тэмүүлэх чанар нь Тэмүжинг бүр бишрүүлсэн юм. Хулан бол ганц түүнд зориулан Тэнгэрээс илгээсэн хүн биз гэж заримдаа бодогдоно. Харин Хулан Тэмүжинд ирээд хөл хүнд болсон ч гай болж үр зулбаснаас хойш дахин хүүхэд олохгүй болсон нь хөөр жаргал дүүрэн амьдралын ганц бараан сүүдэр, Хуланы сэтгэлийн шаналал болжээ.

Есүй, Есүгэн хатад охидтой бол Хуланд охин ч заяахгүй байгаа нь Тэнгэрийн цээрлэл шиг болж үүнд Хулан бүү хэл Тэмүжин ч шаналан зовж үрийн хүслэн болсон хөөрхий Хуланг өрөвдөх бүлгээ. Дөрвийн дөрвөн хөвүүн төрүүлж Чингис хааны алтан ураг, Их Монгол улсад дархлагдсан их хатан Бөртийн илэрхий дээгүүр дээрэнгүй харц дийлдэн дарлагдаж сураагүй Хуланг байж суухын аргагүй болгоно. Мэргэдүүд нэгэнт булаан авсан юм бол Бөртэ хэмээх энэ бүдүүн авгайг алчихгүй яав гэж заримдаа үзэн ядахдаа шаналан боддог болжээ. Их хатан Бөртэ болоод Есүй, Есүгэн хатныхаа Тэмүжинг хоноход Хулан боож үхмээр, тэр эмсийн гэрт нь дайран орж алалдан тэмцмээр Тэмүжинг түүнээс булаагч эмсийг урж тасчин хаямаар ер солиормоор болно. Тэмүжинг ингэж бусад эмтэй хуваан хэрэглэхийг, бас тэднээс дорд үзэгдэхийг Хулан арайхийн тэвчиж байв. Тэр дундаа бүдүүн Бөртийнд очиж хоноход нь бүр галзуурах дөхнө. Хорсол занал, үзэн ядалтаа дараа нь Тэмүжинд гаргаж тачъяадсан дүр үзүүлэн мөр хүзүүг нь улаан эрээн болтол хазаж маажиж орхих билээ. Нулимс урсган орилж чарлаж,хазаж маажиж байгаа түүнийг Тэмүжин дур тавьж тачаадаж байна гэж бодохоос цаашгүй. Харин Хуланы дотор өш хонзон, уур цухал дүрэлзэн шатаж байдаг билээ. Хулан үзэн ядсан, өрсөлдөн тэмцэх хүслээсээ болж заримдаа хэн нэгнийг тэр дундаа Бөртийг багалзуурдан алах бий гэж өөрөөсөө ч айх болжээ. Хуланы энэхүү сэтгэлийн хямралыг Тэмүжин сайн мэдрэх боловч бас яаж ч эс чадна. Хүүхэд гаргахаараа зүгээр болно гэж бодсоор байтал олон жил өнгөрчээ. Бас дээр нь Алтан улсыг дайлаар мордохдоо Чингис хаан Есүй хатнаа дагуулан явсан нь Хуланг ёстой галзууруулжээ. Алтан улсад дайлаар явахдаа өөрийг нь дагуулна гэж дотроо бат итгээд бүр өмсөх зүүхээ хүртэл бэлтгэн хүлээж байсан билээ. Гэвч Хуланд хувь заяагаа дуугүй дагахаас өөр арга даанч байсангүй. Учир нь тэр өөрөө л энэ амьдралыг сонгосон билээ. Тэмүжинээс дахин хүүхэд олоогүй нь түүний гологдох шалтаг болов гэж өөртөө гомдон өргөөндөө уйлж хэвтэх нь олон болжээ. Ийм үед түүний дэргэд өнөөх тайган Ю-Унчи дув дуугүй зогсож байх бөгөөд хөөж туусан ч тэр явахгүй

бүлгээ. Хулан түүнийг хавь ойрын гартаа тааралдсан болгоноор нүүлгэж байгаад тайвширдаг байв. Харин Ю-Унчи шидсэн юмсыг түүж, буцааж тавьдаг билээ. Хулангийн зовлон шаналалыг Чингис хааны Алтан улсаас ирэхдээ авчирч өгсөн их бэлэг өчүүхэн ч тайтгаруулсангүй. ”Энэ том хөхт татаар эм Есүйг юунд нь болж ингэж сар жилээр аян дайнд дагуулж явдаг юм бол. Би түүнээс юугаараа дугав” гэж хорсон бодох нь багасаж нимгэрсэнгүй. Алтан улсаас ирээд Чингис хаан Хулан хатныхаа хамт хаашаа ч явалгүй жил суусан нь ч, бас шинэ орд өргөө байгуулах газар нутаг сонгохоор үзэсгэлэнт гол усыг хэсэн явсан нь ч өчүүхэн ч тайвшруулсангүй.

Харин Хуланд тайвшрах нэгэн шалтаг бий болсон нь монголын их цэрэг баруун зүгийн Хорезм улсыг дайлахаар болж, Тэмүжин Хулан хатнаа дагуулан явахаар амалсан явдал байв. Хулан энэ үгийг сонсоод маргааш өглөө л явах гэж буй мэт хөөрөн догдолж, шөнөжин нойргүй хонохыг үзээд Тэмүжин анх удаа Хуланг асар ихээр хөөрхийлөн өрөвдөж билээ. Хэрэв Алтан улсад явсан шигээ Хуланг дахин орхин явбал тэр тэсэхгүй амиа бүрэлгэж мэдэхийг Тэмүжиний дээрх үгийг сонсоод дүрэлзсэн харцнаас нь үзэж түүнийг орхихгүйгээр шийджээ. Гэвч Хорезмд хэзээ явахаа Тэмүжин ч сайн хэлж мэдэхгүй байлаа. Хулан лав хоёр жил хүлээх байв. Гэвч ганцаардаж зовж шаналснаас хоног тоолон хүлээж суух нь Хуланд хамаагүй дээр гэж Тэмүжин боджээ. Бас энэ бол одоохондоо ганцхан Хулан чи бид хоёрын мэдэх нууц шүү гэж хэлсэн нь Хуланг баярлуулж тэр одоо хичнээн жил ч хүлээсэн чадах болжээ. Алтан улсад Есүй хатнаа авч явснаас болж Хулан эгдүүцэл гомдлын сайн муу үг олныг хэлснийг Тэмүжин мартахгүй санаж явсны учир энэ билээ. Хатад дундаас хэн нэгийг нь илэрхий дээгүүр үзэж, онцгойлохыг Тэмүжин хүсдэггүй байв. Харин Бөртэ бол хөвүүдийн эх, их хатан учир ганц Тэмүжин ч биш бүх хүн бүр улс даяараа Бөртэд онцгой хүндлэл үзүүлнэ. Ингэх ч ёстой юм. Энэ бол их улсыг байгуулахад хамгаас их зүдэрсэн нь чухам Бөртэ хатан гэж Чингис хаан үздэгийн баталгаа гэрч билээ.

Алтан улсаас олзолж, булаасан эд агуурс, алт эрдэнэ, амуу будаа, албат боол хэмжээ тоогоо алдаж, цэрэг бүрийн ар гэр баяжаад зогссонгүй, бас дахин үүнээс ч илүү их олз олох, түүний тулд дайн хийж, шинэ газар орныг эзлэн авах, булаан дээрэмдэх их хүслийг оргилуулж, олон ардын энэ их шунал хүслийг Чингис хаан нэгтгэн зангидаж нэг зүгт чиглүүлж байлаа. Их Монгол улс бүхлээрээ олзны төлөөх шуналд эргэлтгүй автаж, дийлж ялж сурсан их цэрэг нь юунаас ч айж эмээхгүй омог зоригор шатаж байв. Одоо тэд Чингис хаан юу гэж зарлиг буулгахыг хүлээн гар дохивол дайран ороход бэлэн даланд хашигдсан үерийн их ус шиг оволзож байлаа. Асар их шунал тачаал агуу их хүчийг бий болгодгийг Чингис хаан мэдэж авчээ. Хэдийгээр монголын их цэргийн дайны онгод ид орж хүч чадал нэгэнт зузаараад хэзээ хэзээнээсээ илүү хүчирхэг болоод байсан ч Чингис хаан цэргийн хүчээ яаран ашиглахыг хүлээзнэж байв. Тэрээр дайлан эзлэхээр завдаж буй улсынхаа ард олны амьдрал байдал, сэтгэл санаа хийгээд хаан эзнээ хэр итгэн хүрээлж буйг урьдчилан сонирхож цаг улирал, аж ахуйн нь талаар хэл мэдээ авах, ер Чингис хааны суу алдар, сүр хүчийг аль хэр мэдэж буйг нь тандахыг чухалчлан энгийн худалдаачдын дүрээр олон олон тагнуул туршуулаа илгээх болжээ.

Арга чаргаар буулган авч болохгүй аваас амь өрсөн тулалдах үед анд холбоотон нь хэн бэ гэдгийг сураглан мэдэж, хүч хавсарч болох холбоотныг эв найр, эд баялаг, эмс охидын нүүрээр өөртөө татахыг эрхэмлэж байлаа. Ийнхүү тагнуул туршуул урьдчилан илгээж олж

цуглуулсан мэдээ зангийг өөрийн хөвүүд, өрлөг жанжид, үнэнч баатруудтайгаа зөвлөлдөх журам тогтоожээ. Их цэргийн сүр хүч, Чингис хааны суу алдраар далайлган цус урсгалгүй буун өгч дагаар орохыг тулган шаардаж эвийн бодлого, цэргийн сүр хүчийг хослуулан эрх мэдэлдээ оруулах алтан аргамжийн арга ухааныг эхлэн хэрэглэхийг чухалчилж энэ ялдамд цэргийн довтлох, дайтах сургуулийг цаг алдалгүй бататгасаар байлаа.

Шашин шүтлэг, амьдрах арга өөр Хорезм улстай болгоомжтой харьцаж, эхлээд худалдаачны дүрээр олон зуун тагнуулчаа янз янзын замаар цувуулан илгээсээр хоёр жил болжээ. Хорезмийн хаан Мухамедад “Би чамайг хүү шигээ үзнэ” гэсэн үгтэй баахан дээрэнгүй бардам захидал илгээсэн нь тэдэнд таалагдсангүй бололтой. Гэвч элч илгээж найртай явахыг хүсэмжилсэн нь яах аргагүй Чингис хааны сайн санааны үр байсан боловч Хорезмийн хааны эхийн садангийн хүн Сыр-Дарья мөрний эргийн Ортар хотын захирагч-жанжин Хажирхан гэгч Чингис хааны илгээсэн худалдаачдыг алсан хэрэг мандав. Хорезмоос дутахгүй их газар нутгийг эзэлж өөрийн их сүр, хүч чадалдаа эрдсэн ч болгоомжлон найртай харилцахыг чармайсан дүр үзүүлж байсан Чингис хааны тэвчээр алдарч энэ хэрэг харин ч сайхан далим болов. Чингис хаан цэргээ сурган бэлтгэхээ эрчимжүүлж урьд нь дагаар орсон Тангуд улсыг Хорезмыг дайлахад зүүн гар болон цэрэг гаргахыг сануулав. Гэтэл их санасан газар есөн шөнө хоосон гэгчээр Тангудын хааны жанжин Жаха-Хамбу гэгч “Хүнээс цэрэг гуйвал дайтахын хэрэг юун” гэж их үг хэлээд цэрэг гаргасангүй нь Чингис хааны хилэнг оволзуулж золтой л Тангуд руу цэргээ гуравдахиа хөдөлгөсөнгүй.

-За яахав. Би даан ч их хэрэгт зориглосон тул энэ удаа хойш тавья. Тэнгэрт ивээгдэж их ялалт авч ирээд Буур хаан чамаас ял асууя гэж Чингис хаан арайхийн тайвшрав. Хорезм улсыг дайлах бэлтгэл бүрэн хангагдаад цэргийн агт морь, идэш хоол, зэр зэвсгийн нөөц ачсан их хөсөг баруун зүгийг чиглэн өдөр бүр хөдөлсөөр байлаа. Хорезм бол хүчирхэг том гүрэн тул Тангуд, Уйгар, тэр бүү хэл Алтан улстай зүйрлэн үзэж болохгүй юм. Их дайны бэлтгэл агт, хүнс зэвсгийн нөөц Чингис хаанд дагаж орсон Харлаг, Хар Кидан, Уйгар улсуудад ийнхүү хоёр жилийн турш алгуур бөөгнөрч дуусав. Дайтах аргаа ч боловсруулж бас Хорезмд олноор амьдран суугч нэг угсааны Түрэг овгуудын иргэд толгойлогчдыг ч ашиглаж, түшиглэж болохыг тагнан тогтоожээ.

Хулан дайнд явна, үзээгүй улс гүрэн үзнэ гэхээс нэг ч хоног тайван унтаж чадахгүй байлаа. Энэ насны нь ганц хүсэл дайн тулаан байсан юм шиг хөөрч догдлоод хоол унднаас ч гарав. Өмсөх зүүх хувцас, суух сүйх гээд түүнд зориулсан бүх зүйл бэлэн болов. Зөвхөн Хулан хатныг хамгаалан авч явах шилдэг зуун цэрэг эгнэн жагсав. Бас зам зуур хэрэглэх хоол хүнс, өргөө майхан, өмсөх зүүхийг Ю-Унчи ажлаа мэддэг тайган хүний ёсоор жин тан болгожээ. Үүнийг үзээд Хулан бахдан хөөрч төрсөн эцгээ, цус нэгт мэргэд аймгаа дэмий нэг сөнөөгөөгүйг ойлгов. Тэдний амь насны оронд энэ их хүндлэлийг түүнд үзүүлж байх шиг санагджээ. Морь унахад нь зориулж хөнгөн хөө хуяг, дуулга сэлт хийж өгсөн нь хамгийн ихэд таалагдаж, цэрэг болж сэлэм агсахад ч бэлэн байв. Сэтгэл санааны бухимдал сатаарч хүүхэд шиг хөөрч догдолсон Хулан хатнаа хараад Чингис хаан баярлаж ажээ.

Дайны бэлтгэлийн хажуугаар Чингис хааны дараа хөвгүүдээс хэн нь хаан сууринд өргөмжлөгдөхийг хатад нь тэр дундаа Бөртэ илэрхий шохоорхон асууж, Цагадайг өргөмжлөхийг шаардах болсон нь Чингис хааныг зовоож байлаа. Есүй, Есүгэн хатад хөвүүн

төрүүлээгүй тул тэдэнд энэ талд өрсөлдөх, санаа зовох зүйл байсангүй. Гэтэл Тэмүжинд ирээд арван зургаан жил болсон бага хатан Хуланд Чингис хааны дараа Зүчийг хаан ширээнд залгамжлуулах хүсэл илт байв. Чингис хаан Хуланы энэ этгээд хүслийг мэдсэн боловч цаад нарийн учрыг тааж ойлгохыг хүссэнгүй. Ерөөс Хулан бол үргэлж элдэв дээдийг сонирхож, оролцож байдаг эцэж цуцдаггүй омголон, сониуч зантай хүн тул түүний энэ шохоорхолыг сүрхий чухалчлан бодсонгүй орхив. Гэвч Хулан хатны бодсон нь Тэмүжиний санаснаас илүү хол гүнзгий явдал байлаа. Хулан анхилам үнэрт дэрээ тэврэн эзгүй ганцаар хонох бүртээ өөрийн амьдрал, ирээдүйг үргэлж бодож төлөвлөх зантай болжээ. Зорьж зүтгэж явсаар тэр суут Чингис хааны бага хатан болов. Гэтэл Тэнгэр түүнийг ивээж үр хүүхэд заяасангүй нь гуниг, түгшүүрийн үндэс үүсгэсэн билээ. Бөртэ, Есүй, Есүгэн хатад тэр бүү хэл олон татвар эмс нь Тэмүжинээс үр хүүхэд төрүүлсэн байхад харин Хулан Тэмүжинд ирээд арван зургаан жил болоход анхны үрээ золгүй тохиолдлоор зулбаснаас болж дахин хүүхэд олсонгүй ажээ. Алгаараа илбэхэд мэдрэгдэж амьсгаа нь хүртэл сонсогдом байсан үр нь гэнэт түүнээс зугатах шиг үхдэл болон зулбасныг одоо ч санахад хар дарсан аймшигт зүүд мэт санагдана. Хулан ер өвдөж хордолгүй, тэнхлүүн эрүүл саруул байсан мөрт үр нь зулбасаныг муу санаатны хорлол болов гэж өнөө ч Хулан итгэсээр билээ. Хэрэв тэр хөвүүн нь эсэн мэнд төрсөн бол Хуланы амьдрал огт өөрөөр эргэх байв. Нас залуу цус шингэн түүнийг дахиад нэг байтугай олон хүүхэд төрүүлнэ гэж бүгд тайвшруулж бас Хулан ингэж горьдсоор энэ олон жилийг баржээ.

Одоо Хулан Тэмүжинээс хүүхэд олно гэдэгтээ бараг итгэл тасарчээ. Хуланы үр төрүүлдэггүй байдал түүнийг олны өмнө тэр дундаа дөрвөн хөвүүн төрүүлсэн Бөртийн дэргэд өчүүхэн дорой нэргүй эм болгон хувиргадаг нь тэвчиж болшгүй доромжлол байлаа. Хулан үргүйдээ гутаж гуних нь хязгааргүй болжээ. Гэтэл нас залуу цус шингэн хатнаа өвгөрч жар дөхсөн эр нь эдлэн жаргаах нь өдрөөс өдөрт холдож, өврийг гийгүүлж хонож өнжлөө ч эрхэлж янаглахаас илүү, эрт унтахыг хүсэмжлэх болсон нь үнэн юм. Тэмүжиний хатан болно гэж тэмцэж ирэхдээ ийм зовлонт шаналал үзнэ чинээ Хулан санасангүй.

Тэмүжин тэд дахин үртэй болохгүй нь нэгэнт тодорхой болсныг хүлээн зөвшөөрч, хувь заяагаа дагах нь түүнд дэндүү харуусалтай тул олон шөнийн нойроо баран элдэв янзын арга замыг сүвэгчлэн ухаанаа ухаж, учрыг бодох болжээ. Чингис хаан нэгэн өдөр тэнгэрт халих нь хэнд ч ойлгомжтой, тэр муу өдрийн хойно Хулан хэн болж хоцрох билээ гэсэн ганц бодол түүнийг хамгаас илүүгээр тарчлаах болжээ. Төрүүлсэн үргүй түүнийг хэн хүн гэж тооно. Төрөлх аймаг нь устан мөхөж, дуугарах хүнгүй, дуурсах нэргүй болов. Хулан тэгвэл хаана очиж яаж амьдрана. Хулан бол үл тайвшрах догшин сэтгэлтэй тул Тэмүжинг өнөө маргаашгүй үхэхээр сэтгэж чадах ажээ. Нээрэн Чингис хаан элс мэт хийсч, мөс мэт хайлж одвол түүнд юу үлдэх билээ гэдэг бодол Хуланг өдөр шөнөгүй зовоох болжээ.

Хорезмд дайлаар мордохдоо түүнийг дагуулан явахаар Чингис хаан зарлиг болгосон нь зөвхөн сэтгэл санааг засах, зовлон шаналалыг нь мартуулах гэсэн арга төдий болохоос юуг ч өөрчилж эс чадахыг Хулан сайн ойлгож байв. Харин бодсоор байхад Хуланы ирээдүйн амьдрал Чингис хааны хойно хөвүүдээс хэн нь хаан сууринд суухаас шууд хамаарах нь хэнд ч тодорхой билээ. Ингэж бодсоны учир Чингис хаан өөрийн залгамжлагчаар хөвүүдийнхээ хэнийг сонгохыг илт сонирхох болжээ. Хөвүүдийн дотроос үзэсгэлэн төгс зүс царай, гоолиг өндөр нуруутай Зүчийг Чингис хааны залгамжлагч болоосой гэж Хулан хамгийн ихээр хүсч байлаа. Хулан өөрөөс нь хэдхэн ах энэ идэр эрд дотроо татагдан дурлаж байв. Бас Зүчийг

мэргэд цустай болохыг мэдсэнээс хойш бүр ч илүү дотно болжээ. Адилхан мэргэдийн удам болохоор Зүчи хаан болбол түүнийг лав хатнаа болгож авах биз гэж итгэнэ. Учир нь хөвүүд нь төрсөн эхээсээ бусад хатдыг эцгийгээ өөд болсны хойно өмчлөн авах эрхтэй билээ. Хэрэв Зүчи хаан сууж, Зүчийн их хатан болбол Хуланд сая нэг насаар их хаадын хатан байх хувь тохиож болох байв. Тийм бодлоор Хулан Зүчийн нүдэнд өртөж, сэтгэлд унах боломж, өөг алдахгүйг хичээнэ. Зүчид би яахин таалагдахгүй байх билээ гэж Хулан бодох ажээ. Гэтэл Зүчи Хуланг хүн байна чинээ тоож хардаггүй байв. Хулан зорилгоо хатуу ухаарах тул юу ч хийхээс үл буцна. Тэр хэрэв Зүчи хаан сууринд суухыг мэдвэл Зүчид өөрийгөө өгөхөд бэлэн байв. Зүчи ч түүнийг хүсэмжлэх болно гэж итгэнэ. Гэвч эр нөхрийнхөө хүүд улайм цайм санаархах нь аминд хүрэх аюултай тул хормой шүргэх бүү хэл, харц тулахаас ч сэргэмжлэх ёстойг Хулан бас мэдэх билээ. Гэтэл Чингис хаан өөрийн залгамжлагчаар хэнийг сонгохыг хэн ч мэдэхгүй байв. Гэтэл Хулан яаж ч элдэвлэж хичээгээд Чингис хааны залгамжлагч хэн болохыг тэр хэлүүлж чадсангүй.

-Ууган хөвүүн Зүчийг хаан ширээнд суулгах биз гэх асуух юм уу эсвэл суулга гэж тулгах нь өөрийн дотоод бодлыг илрүүлэх аюултай тул дэмий л үг өдөж сэртэндэхээс хэтрэхгүй байв. Гэвч яг энэ бодолд Чингис хаан эзлэгдсэн болохыг мэдэж чаджээ.

Хорезмтой хийх их дайнаас өмнө хөвүүдийн дундаас нэгийг сонгон өөрийн суурийг залгамжлуулахаар зарлах нь гарцаагүй хэрэг болжээ. Алтан улсад байлдахдаа Зүчи, Цагадай, Өгөдэй гурван хөвүүнээ хамт нэг замын цэрэг удирдуулан явуулсан нь хэн нь ямар чадвартай, ухаантай болохыг нэг нөхцөл байдлын дүнд үзэж мэдье гэсэн зорилготой байлаа. Хөвүүд нь бүгд л биесээс дутахгүй жанжин болж чадсан нь илт ч хэн нь олныг удирдан дагуулж чадах вэ гэдэг нь хамгаас чухал юм. Дайн хийж хот балгас эзлэх нь амар хэрэг биш ч хурсан олны сэтгэлийг залж дагуулахын дэргэд өчүүхэн хэрэг гэж Чингис хаан үзэж байв. Олны сэтгэлийг эзэмдэн дагуулах нь энэ ертөнцийн хамгийн их хүчийг олох ганц арга зам гэдгийг Чингис хаан Тэв Тэнгэрээс бөөгөөс хойш сайтар ойлгож мэдсэн билээ. Тийм учраас их хаан болох нь юуны өмнө олны сэтгэлийг дагуулахтай утга нэг тул хөвүүдээсээ хэн нь чухам ийм чадвар илүүтэйг сонгож танихыг хичээх тул цаг алгуурласаар байжээ. Түүнээс биш Бөртийн хүссэнээр бол аль эрт Цагадайг өргөмжлөх байлаа. Цагадайг эцгийгээ залгамжлан их хаан оронд суухыг үзэх нь Бөртийн ганц насны хүслэн байв. Цагадайг төрж мэдээ орсон цагаас Бөртийн сургамжлан захисан ганц зүйл нь энэ юм. Тэмүжин ч анхандаа Бөртийн үгээр болж үнэхээр Цагадай хөвүүн нь түүнийг залгамжлана гэж итгэж үүнд огтхон ч эргэлздэггүй байлаа. Гэтэл хөвүүд нь өсч томрохын хирээр түүний бодол өөрчлөгджээ. Одоо үзэхэд хаан сууринд суухад Цагадайн зан ааш туйлын тохиромжгүй нь мэдэгджээ.

-Миний хөвүүдээс хаан суудалд өргөмжлөхөд хэн нь илүү тохирох вэ.

Ийм асуултыг Чингис хаан шадрууд болон хатаддаа хоёр биеэр суух үедээ тавьж, тэдний санаа бодлыг сонсож туршиж үзжээ. Тэдний санааг нэгтгэн авч үзвэл Зүчи болоод Цагадайг нэрлэсэн нь хувь тэнцүү байлаа. Шадрууд нь ихэвчлэн Зүчийг нэрлэсэн нь тэд түүнийг мэргэд удмынх гэдгийг нэг их чухалчлан үзэлгүй зөвхөн түүний цэргийн жанжны чадвар болоод зан аашийг үнэлсэн бас ахмад хөвүүн эцгийг залгамжлах ёстой гэж үзэгсэд байв. Харин Цагадайг нэрлэсэн нь гол төлөв Чингис хааны цусан төрлийн дүү нар, түүний гэр бүлд ойрхон өсч хүмүүжсэн шадрууд, ихэвчлэн Зүчийг мэргэд цусных тул хаан ширээнд

суулгах ёсгүй гэж үзэгсэд юм. Цагадайг хаан сууринд өргөмжлөхийг хамгийн ихээр хатуу шаардаж буй хүн нь Бөртэ байв. Энэ бол Чингис хааны алтан ургийн хөвүүдийн ахмад нь Цагадай гэж төрүүлсэн эхийн хувьд үздэг болоод мэргэдээс олсон Зүчи хөвүүнийг нь алаг үзэлгүй өсгөж амжилт, ялалтын замд дагуулсанд нь Тэмүжинд талархсан сэтгэлийн нь илрэл юм. Чингис хаан Бөртийг ойлгож байлаа. Үүнээс үзэхэд Цагадайг хаан ширээнд өргөмжлөх нь гарцаагүй зөв мэт санагдана. Учир нь түүнд Зүчийг өргөмжлөх бодол огт байсангүй. Гэвч Зүчийг оргүй мэт орхиж, чихгүй мэт ярьж болохгүйг ойлгоно. Чухам мэргэд цустай төрсөн л болохоос Зүчи бусад талаар хаан сууринд суулгахад тохирно гэж үзэгсэд нилээд байгаа болохоор Зүчийг улайм цайм зайлуулах нь хөвүүдийн хооронд их эвдрэлийг үүсгэж ойрмог зуур цочмог хэрүүл үүсч, энэ хэрүүлээс үүдэн элдэв аюул илэрхий нүүрлэж мэдэх юм. Цагадайг шууд өргөмжлөх нь Зүчийг илээр гутаан доромжилсон хэрэг болно. Чингис хаан эхний үед Цагадайг өргөмжлөхөөр хатуу шийдсэн байсан боловч аажмаар энэ бодлоосоо ухарч ядаж ая эвгэй арга олж шийдэх хэрэг тулгарсан тул ингэж алгуурласан билээ. Зүчи хэрэв үгүй бол Цагадайн зам шулуун байв. Гэвч Чингис хаан Зүчийг сэтгэлээсээ зайлуулж үл чадав. Бас тэр тэнэсэн сум, хальтарсан сэлмэнд өртөх дорой эр биш болсон тул түүнийг гомдоохоос болгоомжилж байлаа. Бас Цагадайн хатуу догшин авир нь олон хүнд, тэр дундаа жирийн цэрэг болоод иргэнд төдий л таатай биш болохыг Чингис хаан сонсож, мэдсэн нь нэг мөр шийд гаргахад нөлөөлж байв. Хэрэв Зүчи байгаагүй бол Алтан улсад дайлаар мордохын өмнө Цагадайг дэвшүүлэн зарлах байлаа. Гэвч Чингис хаан Алтан улсаас эргэж ирээд Цагадайг яаран өргөмжлөөгүйдээ ихэд баярлан Тэнгэрт мөргөсөн билээ. Харин Алтан улсад явж байхдаа бодсон зүйлийнхээ гарцаагүй зөв гэдэгт эргэлзээгүй итгэхийн тулд дахиад хэдэн жил хэрэгтэй болжээ. Энэ бол Өгөдэйн тухай бодол байв. Өгөдэйг хаан сууринд өргөмжлөх тухай санаа төрөөд удсан ч Чингис хаан энэ тухайгаа Бөртэд ч, Боорчид ч хэлсэнгүй өдий хүрчээ.

Харин цэцэн цэлмэг үгтэй, аливаад гүнзгий бодол сэтгэлээр ханддаг Есүй хатан нь огт санаандгүйгээр “Өгөдэйг хаан сууринд өргөмжлөх нь зөв” гэж хэлсэн нь Чингис хааны нууц бодолд бага ч болов итгэл өгсөн хэрэг болов. Ер нь тэрээр Есүй хатныхаа үгийг сонсож цайг нь ууж суух дуртай билээ. Есүй бол Бөртэ шиг олон хөвүүдийнхээ дунд ухаан хайр нь хуваагдаагүй, Есүгэн шиг аливаад алмай зүйлэг ханддаггүй, Хулан шиг ганц өөрийн сэтгэлийг эрхэм болгодоггүй, эр эмийн ажилд шунан дурлаж элдэвлэдэггүй үргэлж учиртай бодож, утгатай үр хэлдэг тул үгийг нь эм хүнийх гэж тоолгүй өнгөрдөг ч хожим нь заавал эргэн бодож үздэг байв. Энэ маягаар түүний Өгөдэйн тухай хэлснийг дахин дахин тунгаан бодож үзжээ. Гэрт нь очоод сэтгэл санаа тайван амар хэвтэж болдог ганц хүн бол Есүй юм. Түүнээс юу ч асуудаггүй бас юу ч шаардаж нэхдэггүй нь Есүйн сурсан зан билээ. Үнэхээр Есүй түүний далд бодлыг таажээ.

-Чи яагаад Өгөдэйг дэвшүүлэхэд тохирно гэж бодов гэж асуухад яг л Чингис хааны бодож явсан үгийг Есүй хэлсэн билээ. Өгөдэйг дэвшүүлэх нь Зүчи, Цагадай хоёрт гомдолтой ч эсэргүүцэж үл чадна. Өрсөлдөгч нь ч биш болохоор Өгөдэйг дэвшүүлэхэд тэдэнд татгалзах эсэргүүцэх үндэс шалтгаан үл олдоно. Дээр нь Өгөдэй бол аливаа хэргийг эв зүйгээр учрыг нь олж шийддэг, зөөлөн алгуур зантай нь хоёр ахтайгаа эвтэй байх шалтаг болдог билээ. Өгөдэй бол хар багаас уужуу тайван сэтгэлтэй, уяруу зөөлөн ааштай хүн юм. Дайны үед баатарлаж их зүрх, хатуу зоригийг үзүүлж чадах мөрт ерийн үед энгүүн даруу байж чаддаг нь олны сэтгэлд нийцдэг нь илт. Өгөдэйд муу санах хүн ховор байв. Энэ нь хаан сууринд суухад



их л тохирно. Гэвч алс хэтийн бодлого барьж их улсыг жолоодоход түүнд ухааны бяр, хатуу итгэл дутаж мэднэ. Бас алгуур тайван зан нь хор болж ч мэднэ. Өгөдэйн хамгийн давуу чанар нь хоёр ахынхаа дэмжлэгийг нэгэн зэрэг олж чадах явдал байв. Хөвүүдийн эв нэгдлээс их улсын ирээдүй шууд шалтгаалах тул Чингис хаан Өгөдэйг сонгохоор шийдэв.

Гэвч Өгөдэйг өргөмжлөх гол шалтгаан үндэс нь энэ бас биш байв. Харин чухам яагаад Өгөдэйг хаан сууринд өргөмжлөх болсноо хожим Өгөдэйг гарцаагүй хаан сууринд суух болоход нь ганцхан түүнд өөрт нь хэлнэ гэж Чингис хаан шийдсэн байв. Учир нь одоо ийм явдлыг олонд дэлгэх нь ашиггүйгээр барахгүй хор болно гэж Чингис хаан үзэж байв. Өөрийн залгамжлагчийг тодруулах нь хойшлуулж болохгүй хэрэг болсныг Чингис хаан Хулан хатныхаа үг, шохоорхолоос нэвт мэдэрсэн билээ. Чухам Чингис хааныг хэн залгамжлах тухай улс даяар хүлээж байгаагийн тод жишээ бол Хулан юм. Хулан шиг хүн яавч зүв зүгээр энэ хэргийг сонирхоогүй нь лавтай. Гэвч түүнд Хулангийн юу бодсоныг таахаас илүү зовлонтой хэрэг тулгараад байв.

Өгөдэйг өөрийн биеэр сонгон зарлах нь Зүчи, Цагадай болоод бусад олон хүнээс тэр дундаа Бөртэ хатны зүгээс хариу тайлбар нэхэх аюул үүсгэхийг Чингис хаан ухаарав. Тэгвэл түүнд чухам яагаад Зүчи болоод Цагадайг хаан сууринд суулгаагүйгээ олонд тунхаглах хэрэг гарна. Энэ нь Зүчи Цагадай хоёрыг олны өмнө доромжлон гутаахтай утга нэг бөгөөд тэр юу ч гэж хэлсэн тэд эцгийн үгийг эсэргүүцэх нь лавтай. Ингэвэл Чингис хаан ахмад хөвүүдтэйгээ дайсан болно. Энэ нь Зүчийг үхүүлж, Цагадайг өргөмжилснөөс долоон дор хэрэг юм. Чингис хаан удаан бодсоны эцэст Өгөдэйг өргөмжлөх, ингэхдээ үүнийг хөвүүдээр өөрсдөөр нь олны өмнө хэлүүлэх замыг сонгон авлаа. Энэ бол дөчин жилийн өмнө Тоорил хан Жамуха хоёрыг мэргэд аймгийн эсрэг дайнд татан оролцуулахаас хавьгүй зовлонтой аюултай хэрэг байв. Энд хөвүүдийнхээ сэтгэл санаа, зан авирыг нэвт мэддэг нь хэрэг болов. Хүний сэтгэл хурмын дотор хувирах осолтой тул хөвүүдээр хүссэн үгээ хэлүүлж чадна гэсэн бүрэн итгэл бас байсангүй. Гэвч үүнээс илүү найдвартай, хамгийн гол нь өөрийн болоод улсын нэр сүрд хожим хойно аюул багатай зам үгүйг ойлгов.

Энэ бол Чингис хааны явуулсан олон цусгүй дайны хамгийн төвөгтэй, аюултай нь юм. Залгамжлагчаа тодруулах нь Хорезмийг дайлахаас дутахгүй осол аюултай, буруу эргэвэл хожмын уршиг ихтэй, сэтгэлийн дайн байв. Тийм болохоор бүх зүйлийг нарийн тооцож алдаагүй бэлдэх хэрэгтэй болжээ. Юуны өмнө энэ хэрэгт Бөртийг байлцуулах шаардлагагүй гэж үзэв. Мөн Есүй хатанд зарлиг болгож хэзээ юу гэж хэлэхийг даалгав. Ийм хэргийг даалгахад Есүйгээс өөр тохирох хүн байсангүй. Есүгэний үгийг ахмадууд анхаарч ойшоож үзэхгүй. Хулангаар ийм үг хэлүүлэх нь хүүхдийн тоглоом мэт санагдана. Тэгээд ч Есүй, Өгөдэйг өргөмжлөхийг дэмжиж буй. Бас энэ хэргийг Бөртэд мэдэгдэж сэжиглүүлэхгүйгээр хийх ёстой тул Боорчи Мухулай хоёртой ч зөвлөж тэдний яах ёстойг тогтов. Хөвүүдийн дунд гэнэт үүсэж мэдэх хэрүүлийн үед хэн юу гэж хэлэхийг Боорчид чухалчлан захиж хэлэх үгээ бэлдэхийг даалгажээ. Зүчи Цагадай хоёрын эсрэг хийх Чингис хааны цусгүй дайны бэлтгэл ийнхүү хангагдав. Одоо бүх зүйл ганцхан Чингис хааны хэлэх үг, гаргах аашнаас шалтгаалах байв. Урьд шөнө нь Чингис хаан тэр нэгэн цагт Тэв Тэнгэрийн зааснаар дал шатаан мэргэлж үзвэл бүх юм санаснаар бүтэх төлөг буусанд бүр сэтгэл амарч олон зүйлийг бодож үзээд Бөртэ хатныхаа гэрт хонохоор морилжээ. Тэмүжин Бөртийнд очиж хонолгүй хоёр сар болжээ. Бөртэ лав баярлана гэж бодов.

Маргааш өдөр морин цагт Чингис хааны ёслолын их өргөөнд ахмадууд болоод шадар жанжнууд цугларч Хорезмтой хийх дайны бэлтгэл болоод бусад зүйлсийг хэлэлцэж зөвлөлдөв. Энэ зөвлөгөөнд хатдаас Есүй, Хулан хатад суусан нь олныг нэг их гайхашруулсангүй. Зөвлөлгөөний эцэст хундага өргөхийн өмнө Есүй хатан Чингис хаанаас зөвшөөрөл авч олны анхаарлыг өөрт хандуулаад

Өршөөлт эзэн хаан та

Өндөр алдраа мандуулсаар

Өгсүүр давааг давж

Өргөн мөрнийг гаталж

Ужиг холыг туулан

Урт аянд морилохдоо

Улс иргэнээ захирахыг

Урьдал болгон сэтгээсэй

Төрсөн бие төлбөрөх

Түмэн амьтны хуулийг

Төгс саруул ухаандаа

Түвдэлгүй санаасай

Уул мэт бие чинь

Нурж одвол

Улс олон Монголыг чинь

Хэн захирах юм бэ

Тулгуур мэт бие чинь

Туйвж одвол

Туг их сүлдийг чинь

Хэн өргөх юм бэ

Төрсөн дөрвөн хүүгээс чинь

Төр барих нь хэн бэ

Хан хөвүүд, дүү нар

Харц олон ард

Хатад бид бүхэнд

Хариу айлдах эсэхийг

Хааны зарлиг мэдтүгэй гэж цэлмэг тунгалаг хоолойгоор цэцэн шүлэг хэлэхэд өргөөнд ялаа нисэх ч тод сонсдохоор нам гүм боллоо. Хулан юу болох гэж буйг таамаглаад тэсэлгүй өөртөө бухимдав. Иймхэн хэдэн үг олоод хэлчих ухаан олоогүйдээ уурсаж бас сүйхээтэй сэрэглэн Есүйд үхглээ атаархав. Гэвч тэр нэгэнт хожимджээ. Есүйн үгийг сонсож суухдаа Чингис хаан туйлын тааламжтайгаар толгой дохин суухыг хараад ингэж атаархсан билээ. Харин одоо Чингис хааны юу гэж хэлэх л чухал учир Хулан атаархалаа хормын дотор мартав. Чингис хаан гүнзгий бодолд авгжээ. Зэрэгцэн суусан Бөртийн дөрвөн хөвүүнийг хараад Хулан гэнэт өөрийн золгүй хүүгээ санаж гол нь харлаад явчихжээ. Тэр хүү нь мэнд төрсөн бол одоо арван тав хүрч бас эдэнтэй зэрэгцэн суугаад хаан эцгээ залгамжлана гэх байхсандаа гэж бодогдоход гэнэт дотор нь бачуурч орилж хашгирмаар болсон ч тэвчин биеэ барилаа. Хулан хатны нүднээс нулимс мэлтрэн дүүрээд урсахыг анзаарч харах хүн даанч байсангүй.

Чингис хаан хэдий санаа сэтгэл бэлэн байсан ч хэргийн учир будилаантай, уршиг дагавар их тул бас бяцхан сандарч бодолд унав. Тэр юу гэж хэлэхээ тооцон хэсэг суув. Бүгд түгшин, хөвүүд сандарч улайн сэтгэл догдлов. Чингис хааны амнаас гарах үг хүн бүгдэд хамаатай юм. Бүгдийн өөр өөрийнхөөр сэтгэж хүлээсэн мөч ирснийг ойлгов. Чингис хаан удаан дуугүй суув. Энэ нь хаан ширээ залгамжлагчийг тодруулах нь хир хэцүү хүнд, хариуцлагатай хэрэг болохыг мэдрүүлэх зорилготой ажээ. Эцгийн үгийг хүлээсэн гол өрсөлдөгчид Зүчи Цагадай хоёрын хувьд сэлэмний дор толгой тавьсан мэт болжээ. Хаан эцгийн үг тэдний ирээдүйн хувь заяаг шийднэ. Бас тэднийг хэн болохыг олонд үзүүлэх юм. Үүнээс илүү түгшүүрт, бас хүсэмжит мөч гэж хаана байна. Цагадайн сэтгэл түгшивч эцэг нь түүнийг өргөмжлөнө гэдэгт бат итгэлтэй байв. Гэтэл Чингис хааны дуугүй удах нь сэжиглэлтэй. Цагадайн сэтгэлээ барих тэвчээр барагдаж байв. Чингис хаан Цагадайн нүүрэнд харц тусгав. Цагадай эгц өөдөөс нь шаардсан, итгэсэн харцаар ширтэн байв. Харин Зүчи сэтгэлийн хөдлөлөө нууж доош ширтэнэ. Зүчид хаан эцгийгээ залгамжлах хувь дутахыг тэр мэдэж байсан хэдий ч бас горьдлого төрж догдолсоор байжээ. Гэвч хаан эцэг нь Цагадайг өргөмжлөвөл шууд дэмжинэ гэж бодож суужээ. Энэ бол Бөртэ эхийнх нь хатуу сургаал юм. Өгөдэй энэ явдал өөрт нь тийм ч их хүртээлтэй биш тул тайван сууна. Харин Тулуй бүр ч тоомжиргүй суусан ч хаан эцэг нь ах нарын нь хэнийг сонгохыг сонирхон дотроо тааж ядах ажээ. Зүчи үү Цагадай юу. Олон бүгдээр ингэж бодож байлаа. Чингис хаан одоо үгээ хэлэх цаг болсныг мэдлээ. Чингис хаан үгээ хэлэхийн өмнө яагаад ч юм Хулан хатнаа харжээ. Хулан хатан нулимстай нүдээр инээмсэглэж суухыг үзээд чухам яагаад түүний уйлсныг шууд л ойлгов. Чингис хаан ч гэсэн тэр золгүй хүүгийн тухай боджээ.

-Хатан боловч Есүйн хэлдэг зөвөөс зөв. Дүү нар, хөвүүд та нар бас Боорчи, Мухулай та нарын аль нь ч ийм үгийг надад дуртган хэлсэнгүй.

Өвгөдийн хойноос одохгүй мэт

Өөрөө ч үүнийг мартсан байж.

Үхэл надаас тойрох мэт

Үнэхээр түүнийг санаагүй явж

Их улсдаа мөнх суух шиг

Эзэн ширээнд үүрд залрах шиг

Эрчит суманд оногдохгүй мэт

Илдний үзүүрт өртөхгүй мэт санажээ гэсэн Чингис хааны үг Есүй хатны хэлснийг сайшаагаад зогсохгүй залгамжлагчаар хэнийг томилохоо хэлнэ гэсэн итгэлийг үүсгэж олон бүгдийн сэтгэлийг хөвчрүүллээ.

-Хөвүүдийн минь ахмад Зүчи юм. Чи юу гэж бодно. Чи хэл гэж Чингис хаан Зүчид хандан хэлэхдээ Цагадайг хяламхийлээ. Хөвүүд зэрэгцэн тохой зайтай сууж байв. Эцгийн энэ санаандгүй үг хором зуур Зүчийг алмайруулж чухам юу хэлэхээ шууд олсонгүй. Чингис хааны Зүчид эхлэн хандсан нь зарим хүнд тэр дундаа Цагадайд Зүчийг шууд өргөмжилсөнтэй утга нэг санагдав. Хулан эхлээд сонссондоо итгэсэнгүй. Тэр Чингис хаан Зүчийг өргөмжлөв гэж ойлгоод баярласандаа өндөсхийлөө. Гэвч тэр буруу сонсжээ. Цагадайг үсрэн босохыг хараад Хулан юу болсныг ойлгосонгүй. Цагадай үнэхээр биеэ барьж чадсангүй. Зүчийг өргөмжлөх нь Цагадайг гутаан доромжилсонтой адил юм. Цагадай хаан эцгээ залгамжлах ганц хүн гэдгийг Бөртэ эх нь шууд баталдаг билээ. Гэтэл хаан эцэг нь юу санаад ийн хэлэв. Цагадайн уур омог дүрэлзэн шатаж бараг хамраараа утаа савсуулан байж

-Зүчийг үг хэл гэх нь юув. Зүчийг юунд томилох гэж ингэж онцлов. Энэ мэргэдийн орхидост бид захирагдах гэж үү гэж хашгирахад хаан эцэг, хамаг олны өмнө ийн гутамшигтайгаар доромжлогдсон Зүчи ч үсрэн босч Цагадайг заамдан авав.

-Хаан эцэг намайг гадуурхаагүй байхад чи намайг яагаад ялгаж үзнэ. Чи надаас ямар эрдмээр илүү билээ. Чи ганц догшин омгоороо илүү биз. Харвалцаад чамд дийлдвэл би эрхийгээ огтолож хаяъя. Барилдаад унавал унасан газраасаа үл босъё. Би чамд юугаараа ч үл дийлдэнэ. Гэвч би хаан эцэг таны зарлигийг л дагана гэж хашгиран ноцолдоход Зүчийн гараас Боорчи, Цагадайн гараас Мухулай татаж салгав. Чингис хаан тэр дороо дуугарсангүй, бүр уурлаж хилэгнэсэнгүйд гайхацгаав. Чингис хаан санасандаа хүрч өөрийн хэлэх гэснийг Зүчи Цагадай хоёроор өөрсдөөр нь хэлүүлж чадсандаа сэтгэл хангалуун дотроо инээмсэглэж, гаднаа хөмсөг зангидаж суув. Харин Хулан Цагадайн үгэнд хацар руугаа алгадуулсан мэт цочиж харц буулган тонгойв. Мэргэдийн орхидос гэсэн нь бас Хуланг хэлсэн хэрэг байв. Даанч эндээс зайлан гарах шалтгаан Хуланд байсангүй.

Энэ өргөөнд юу гээч болж байгааг Хулан ойлгов. Энд мэргэд хүн хэн ч биш ажээ. Зүчи Цагадай хоёр нам гүмийн дунд хүндээр амьсгаадан суухдаа хэн хэн нь түргэдэн гэндсэнээ

ойлгов. Харин хаан эцгийнхээ тавьсан мэхэнд унасанаа мэдэхгүй байлаа. Ийм хэрүүлийн дундаас хаан эцэг нь тэдний хэнийг ч сонгохгүй нь ойлгомжтой болжээ. Хэрэв дуугүй суусан бол гэж Цагадай өөрийгөө хараавч хожимджээ. Хэдий үнэн ч гэлээ ингэж бүх улсын ихэс дээдсийн өмнө элдвээр гутаан доромжилсон Цагадайг яав ч өршөөхгүй гэж Зүчи хилэгнэн бодож суув.

Гэнэт дүрэлзсэн хэрүүлийн хойно Чингис хааны хилэгнэхээс болгоомжлон дахин үг дуугарах зоригтон одоо байхгүй болжээ. Бүгд Чингис хааны юу хэлэхийг хүлээж байлаа. Чингис хааны тушааснаар одоо Боорчийн ээлж иржээ. Түргэдэж буруудсан Зүчи Цагадай хоёрыг зэмлэн буруушааж омгийг дарах сайхан боломж олдов. Боорчи юу гэж хэлэхээ сайхан мэдэж байв. Боорчи Тэмүжиний хөвүүдийг хамт өсгөлцсөн тул Чингис хаан болоод хөвүүдийн сэтгэлийг сайтар ойлгох билээ.

Цанх нь хөдөлсөн адгуус мэт

Цагадай чи юунд яарав

Хаан эцэг чинь чамд

Хамгаас илүү итгэдэг бус уу

Алтан ургийн нэрийг сэвтүүлэх

Атгаг хорон үгийг хэлж

Адайр догшин аашлах

Амтай нь ганцхан чи бил үү

Хатуу цагийн эрхэнд

Хамаг бүхнийг туулж

Хаан суудалд суутлаа

Хайран нэрээ бодож

Хатамжин тэмцсэн эцэгтээ

Хамаг олон бидэндээ

Хайрт ах Зүчидээ

Халтай үгийг хэлэх нь юув

Өндөр тэнгэрээс заяатай

Өршөөлт эзэн Чингис хаан

Өөрийн улсаа байгуулж

Өрөөл бусдыг хураахын өмнө

Одтой тэнгэр орчиж

Олон улс байлдаж

Орондоо унтах завгүй

Олзлон булаалдаж байв.

Хөрст дэлхий хөрвөж

Хөвчин улс хямралдаж

Хөнжилдөө унтах завгүй

Хөнөөлдөн тэмцэж байв.

Эргэлзэн бодох чөлөөгүй

Элбэлдэн зүтгэж явав.

Ухран дутаах газаргүй

Урагшлан байлдаж явав.

Амар жаргах аргагүй

Алалдан тэмцэж явав.

Хаан эзэн эцгийнхээ

Хатан сайхан эхийнхээ

Халуун элгийг хөргөж

Хайрт зүрхийг гомдоож

Тос шиг санааг царцааж

Сүү шиг сэтгэлийг ээдүүлэх

Чалчаа муу үгийг

Цагадай чи хэллээ.

Бүлээн элэг нэгтэй

Бөртэ хатны хүүхдүүд биш үү

Халуун элэг нэгтэй

Хамт төрсөн үрс биш үү

Зүрхний хайрт эхийн

Зүтгэсэн ачийг мартаж

Зүйгүй үгээр гомтговол

Гэмшивч нэгэнт хожидно.

Хэвлийдээ тээсэн эхийн

Хэтэрхий ачийг мартаж

Хэдэр үгээр гомтговол

Хэзээ ч цайруулж чадахгүй

Хаан богд эцэг чинь

Хамаг улсыг байгуулахдаа

Хар толгойгоо хайрлахгүй

Халуун цусаа гамнахгүй

Гарын ханцуйг дэрлэж

Гадаад хормойгоо дэвсэж

Шүлсний хөөсөөр хооллож

Шүдний махаар хооллож

Магнайн хөлсийг дусалтал

Махарч чармайж явахад

Улны хөлсийг урстал

Улсаа хурааж явахад

Хатан эх чинь та нарыг

Хамаг аюулаас хаацайлж

Халуун бөөрөндөө дулаацуулж

Хатуу зоригоор хүмүүжүүлж

Хамт зовж явсан бус уу.

Оюун төгөлдөр эх чинь

Оёдолт дээлээ огшуулж

Онгох зүсээ харлуулж

Омог зоригоо чангалж

Хөвүүд та нарыг өсгөхийн тулд

Хүч чадлаа шавхаж

Залгих хоолны шимтэйг

Заяасан та нарт идүүлж

Уух ундны дээжийг

Урьдаар та нарт амсуулж

Өдий зэрэгт хүргэх гэж

Өлсөж ядарч явлаа.

Эгмээс чинь татаж

Эрийн зэрэгт хүргэсэн

Эрхэм ачийг санацгаа

Хүзүүнээс чинь татаж

Хүний зэрэгтэй болгосон

Хүндэт ачийг бодоцгоо



Бохирьг чинь арилгаж

Борвийг чинь тэнийлгэж

Эрийн зэрэгтэй болгож

Эмээлийн дөрөөнд хүргээд

Энхрий хөвүүд та нарын

Эрхэм сайныг үзье гэж

Эх чинь одоо бодож байна.

Эцэг чинь одоо санаж байна

Наран шиг гэгээн ухаант

Навч шиг дэлгэр сэтгэлт

Элбэрэлт хатан эхийнхээ

Элгийг бүү эмзэглүүл

Өндөр тэнгэр шиг ачтай

Өмөг нөмөр ихтэй

Өршөөлт эзэн эцгийнхээ

Өрийг бүү өвдүүл гэж Боорчи уянгатай, утга төгөлдөр уран үгийг уламжлан хэлэхэд Цагадай ичиж, Зүчи уяржээ. Боорчийн үнэн бөгөөд уран үг олонд таашаагдаж бүгд дүнгэнэн түүнийг дэмжсэн нь Зүчи Цагадай хоёрын магнайн хөлсийг урсгаж маш их айлгаж гэмшүүлжээ. Чингис хааны сэтгэл ханаж Цагадайд

-Чи Зүчийг тэгэж хэлж яаж болно. Хөвүүд та нарын ахмад нь Зүчи юм. Хожим бүү тэгэж хэл гэж зөөлөн хэлсэн нь нэг талаас Цагадайг тайвшруулсан ч нөгөөтэйгүүр Зүчийг мэргэдийн хүүхэд гэдгийг хүлээн зөвшөөрсөн хэрэг болов. Цагадай эцгийн үгийн цаад санааг ойлгож

Амаар алсныг

Ачиж болдоггүй

Үгээр үхүүлснийг

Өвчиж болдоггүй

Аавын хөвүүдийн ахмад

Зүчи бид хоёр биз.

Хаан эзэн эцэгтээ

Хавсарч хүчээ өгье.

Далдиран зайлсан этгээдийг

Тас цавчин шийтгэе

Салж хөндийрсэн хэнийг ч

Салбартал цавчиж байя

Өгөдэй дүү өршөөлтэй тул

Өндөр сэнтийд залж

Өргөн олныг захируулж

Өргөмжлөн хүндэлж болно

Хаан эцгийн дэргэд

Хамт ойр байлгаж

Бараат их малгайг

Бариулан мэдүүлж болно гэжээ. Цагадайд үүнээс өөр зам үлдсэнгүй. Ахмад хөвүүдийн хэрүүл зөрчлийн байдал хэнийг нь ч хаан сууринд өргөмжлөх аргагүйд хүргэв. Өргөөнд цугларагсад бүгд үүнийг ойлгож байлаа. Энэ бол Чингис хааны хүссэн явдал байв. Түүний бодсоноор Зүчи Цагадай хоёр өөрөө өөрсдийг тодруулж Өгөдэйг өөрсдөө цохон нэрлэв. Ингэж хамгийн төвөгтэй хэргийг Чингис хаан өөртөө ял зэм багатайгаар шийдвэрлэсэндээ баяртай байлаа. Өгөдэйг өргөмжлөхийг Зүчи дуун дээр дэмжив.

-Цагадайн хэлсэн ёсоор бид хоёр хаан эцэг танд хавсарч хүчээ өгье. Өгөдэйг өргөмжлөө гэжээ. Чингис хаан сэтгэл дүүрэн инээмсэглэж

-Хавсрах юу вэ. Эх дэлхий агуу уужим, ус мөрөн олон. Та хоёрыг харь улс эзлүүлэн тусад нь суулгая. Өөр өөрийн нутгийг өргөтгөж явагтүн. Харин Зүчи Цагадай та хоёр хэлсэн үгэндээ хүрч ардын инээдэм, амьтны тоглоом болохгүй эвгэй явагтүн. Эрт цагт Алтан, Хучир нар энэ мэт үг амлаад эцэст нь хэлсэндээ хүрэлгүй няцаж, хэнд яаж цаазлагдсаныг та хоёр үзсэн. Одоо би та хоёрт Алтан Хучир хоёрын харьяат нарыг хувааж өгнө. Тэднийг үзэж цээрлэл болон санаж явагтүн гэжээ. Хөвүүдийн хэрүүл тэмцэл харин ч аятай зүйгээр шийдэгдсэнд бүгд баяртай болжээ. Өгөдэйг түүний хөвүүд залгамжлахыг зарлиг болгож Өгөдэйн хөвүүд хаан сууринд тохирохгүй аваас алтан ургийн хөвүүд дотроос хэн тохирохыг өргөмжилөх зарлиг буулгасныг Шихихутаг хөх дэвтэрт бичиж хөвүүдэд үүрд мөрдүүлэхээр өгчээ. Энэ

явдал Чингис хааныг шаналгаж байсан олон зүйлийг байранд тавьж, осол эндэгдэлгүй шийдэв. Чингис хаан Зүчийг нэгэнт мэргэд цустайг олонд тунхаглаж, түүнээс хойш Зүчийн үр сад хаан ширээнд суух ёсгүйг хатуу ойлгуулж чадав. Мөн зөвхөн Чингис хааны төрсөн хөвүүдийн үр садыг алтан ураг гэж тооцон үе залгамжлуулах журмыг батлав. Төрсөн дүү Хасарын эрх булаалдах явдлыг энэ зарлигаар үгүй болгов. Хамгийн гол нь хаан суудлын төлөөх хөвүүдийн тэмцэл дундаас Чингис хаан олны өмнө нэр цэвэр, сүр бүтэн гарч чадав. Одоо хэн ч гэсэн Зүчийг мэргэд цусных гэдэгт эргэлзэхгүй болсон ч Зүчи хөвүүнээ ад үзсэн гэж Бөртэ түүнийг хэлэхгүй болов. Хорезмтой хийх их дайны өмнө Чингис хааны залгамжлагч тодорсон нь түүний сүр хүч амжилтыг бэхжүүлэв. Одоо тэдний өмнө эргэлзэх юм үгүй болж нэгэн чигт зорилгоор дайтах үлдэв.

Гаднаас харахад хялбархан санаснаар шийдэгдсэн энэ хэрэг араасаа ямар үр уршиг дагуулж болохыг Чингис хаан таамагласангүй нь удахгүй ил болжээ. Зөвхөн алтан ургийн хөвүүдийг хаан суудалд суулгах Чингис хааны зарлиг лавтай хоёр хүнд таалагдсангүй. Адил тэгш эрхтэй Есүхэйн хөвүүн атал Хасар болоод түүний хөвүүдийг ийн бусдын адил ялган үзсэн нь Хасарыг уурлуулж энэ байдал нь түүний үг хөдөлгөөн бүрт илрэх болсныг Чингис хаан мэдэж байв. Мөн Өгөдэйг өргөмжилсөн нь Хуланд огтхон ч таашаагдсангүйгээр барахгүй түүнийг мэргэд удмаар нь гутаан доромжилсон хэрэг гэж тэр үзжээ. Өгөдэй бол Хуланг Тэмүжинд ирснээс хойш дургүй гэдгээ шууд илэрхийлсэн цөөн хүний нэг байв.

-Энэ муу мэргэдийн зальт эм, үнэгэн шулам гэж хараадгийг шивэгчин нь олонтаа сонсож хов зөөсөн билээ. Эхийнхээ үзсэн зовлонгоос үүдэн Өгөдэй мэргэд хүнийг илт үзэн ядах болжээ. Гэтэл одоо Өгөдэй хаан суудалд суух болсон нь Хуланг мухардуулав. Хэнээр хаан сууриа залгамжлуулах гэж буйгаа нуусанд нь Хулан Тэмүжинд их гомджээ. Тэмүжин түүнд нэгэнт хайргүй болжээ гэж Хулан гомдон уйлахад Ю-Унчи өдөрт тогтмол уулгадаг үзэмний нялуун шүүсээ барисаар дэргэд нь зогсож байв. Түүнд үнэхээр дээш тэнгэр хол доош газар хатуу гэгч л болох ажээ. Үзэмний шүүсээ уучихаад Хулан гэнэт Ю-Унчийн энгэрт наалдан асгартал уйлжээ. Хулан хатны энэ ааш Ю-Унчид сонин биш тул тэр зүгээр л хүн чулуу шиг хөдөлгөөнгүй зогсож байв. Харин Хулан түүнийг тайган гэдгийг мартжээ. Хулангийн эсэргүүцэл дургүйцэл уйлах уйтгарлах төдийгөөр дууссан бол Хасарын гомдол юунд ч хүргэж болох билээ.

Алтан улсын зүүн хойт нутгийг бүрэн дагуулаад олз омог дүүрэн ирснээс хойш Хасар Тэмүжинтэй их л найртай сайхан харилцаатай байсан билээ. Хасар одоо Хянганы нурууны ард нутаглаж шинээр эзэлсэн нутгаа хамааран суугаадаа сэтгэл хангалуун байжээ. Харин Хорезм улсыг дайлахын эсрэг байснаас болж их хурилдайн үеэр Тэмүжин Хасар нарын хооронд багагүй зөрөлдөөн үүссэн ч нэгэнт олонхиор шийдсэн тул Хасар дахин эсэргүүцсэнгүй билээ. Гэтэл огт санаандгүй байтал хэрүүлийн үр дахин дэлгэрчээ. Хасар болоод түүний үр удмын Их Монгол улсын төрийг барилцах эрхийг хүчээр булаан авч бүр зарлигаар хориглосныг Хасар тэвчсэнгүй Тэмүжиний өргөөнд давхин оржээ. Тэд юу ярилцсаныг хэн ч үзэж сонссонгүй. Удалгүй Хасар торгон цэргээ дагуулан нутагтаа буцжээ. Харин үүнээс гурван сарын дараа их цэрэг Хорезмруу хөдлөхөөс хоёр сарын өмнө Хасар гэнэт нас эцэслэсэн нь Тэмүжин тэдний үүрдийн зөрчил тэмцлийг төгсгөл болгосон билээ. Хасарын нас эцэслэсэн тухай мэдээ Чингис хааны өргөөнд ирэх үед тэр Хулан хатныдаа байжээ. Чингис хаан шууд хувцаслан гарчээ. Юу ч хэлсэнгүй. Харин Хулан түүний царайг

ажгаад Чингис хаан Хасар дүүгээ үхсэнд тэгтлээ их харамсахгүй байгааг мэджээ. Хасарын үхлийг сүр дуулиан болгон их гашуудал зарлахыг Чингис хаан хориглосныг Хулан ихэд гайхаж тэсэлгүй асуужээ. Чингис хаан түүний үгэнд хариу хэлэлгүй удаан дуугүй суусанд Хулан дэмий юм асууж хилэгнүүлэв үү гэж ихэд айжээ. Гэтэл Чингис хаан огтхон ч хилэгнэсэнгүй

-Хулан чиний ингэж асуух чинь түмэн зөв. Ганц чи ч биш. Олон хүн яг чам шиг ингэж бодож асууж байна. Гэтэл би хайртай дүүгээ, хамаг ихээр зүтгэсэн ганц нөхрөө алдав. Надад хайран биш гэж чи санана уу. Одоо түүний хойноос хамгаа алдсан мэт их гашуудал үйлдэж болохгүй юм. Би одоо их дайнд мордох гэж байна. Би дайсандаа муугаа үзүүлэхийг үл хүснэ. Хасарыг үхэв гэж ихээр гашуудвал дайсан итгээд зоригжин баясаж харин манай цэргийн санаа итгэл мохох аюултай биш үү. Надад Хасараас үл дутах баатар эрс олон байна. Би юунд харамсана. Дайсан ч тэгэж санаад зориг мохоосой гэж хүснэ. Би буруу зүйл бодсон бол чи шууд хэл гэжээ. Тэмүжин энэ үгээ харамсал гашуудал дүүрэн хэлсэн нь Хуланг

-Тиймээ. Хаантаан та зөв боджээ гэж хэлэхээс өөр аргагүй болгожээ. Хасарыг нас эцэслэсний дараа хоёр хөвүүнийг нь дуудан ирүүлж их хуралдайг зарлан хийлгээд Чингис хаан яг саяын үгээ хэлэхэд тэнд байгсад бүгдээр хүлээн зөвшөөрсөн билээ. Бүх зүйл Чингис хааны зарлиг ёсоор болж Хасарыг үхсэнийг төв хүрээнд л мэдсэн төдийгөөр нам гүм болжээ. Хасар дүүгээ үхсэнд харамсан гашуудах эрхгүй байгаа Тэмүжинг Хулан ихэд өрөвдөн түүнд гомдохоо болижээ.

Энэ мэт том жижиг олон хэргүүд нэг мөр эцэслэж Чингис хааны цэргийн түрүүч Хорезмийг зорин ээлж дараалан мордож эхлэв. Хамгийн түрүүнд Зэвийн их цэрэг баруун зүг оджээ. Түүнээс сарын хойно Сүбээдэй баатар өөрийн цэргийг дагуулан Зэвийн араас тоос манаруулан мордов. Гуравдугаарт Тогочарыг илгээв. Харин гол замын цэргээ Чингис хаан өөрөө манлайлан хөдлөх сайн өдрийг товложээ. Үүний өмнө Чингис хаан Бурхан Халдун уулыг тахиж, Тэнгэрт их өргөл барьж мөргөв. Тэгэхэд Бурхан Халдуны оройд Чингис хаан ганцаар харанхуй тэнгэрийн дор сууж мөргөв. Уулын бэлд хорин түмэн цэрэг жагсаад эцэс нь үзэгдэхгүй хөвөрнө. Цэргийн манлайд хөнгөн сүйх тэргэнд Хулан баяр хөөртэйгөөр сууж байв. Их цэрэг эзэн хаанаа Тэнгэрийн үгийг сонсч ирэхийг хүлээж байв. Чингис хаан бууж ирэв. Тэнгэр түүнийг тэтгэж Хорезмийг дагуулна гэж хэлжээ.

Их цэрэг бахдал дүүрэн хөдлөв. Хорезмийн зүүн хилийн хот хүртэл их цэрэг алгуур уужим хагас жил явах зам буй ажээ. Хорин түмэн цэрэг ачаа хөсгийн хамт замд гарах нь уул нүүж, ус урсаж байх шиг Монголын тал нутаг хоосрон үлдэх шиг гунигтай, эцгээс салсан хүүхдийн уйлаан, эхээс төөрсөн унаганы янцгаан тэнгэрт хадаж байв. Бүх үлдэгсдийг, бүх дуу чимээ, хагацлыг их цэргийн тоос цас шиг даран үгүй хийх бүлгээ. Чингис хаан урьд өмнө үзээгүй харь орныг зорьж явна. Нэгдэж хүчирхэгжсэн, лалын шашинтны их улс Хорезм түүнийг эсэргүүцэл төгс хүлээж буй. Алтан улсад байсан их цэргийг татаж, тэнд гоо ван Мухулайг цөөн цэргийн хамт үлдээгээд бүх хүчээ Хорезмд хаяв. Түүний байгуулсан их улсад түүний хөвүүдэд шинэ газар орон, их олз омог, агуу алдар нэр, ялалт хэрэгтэйг Чингис хаан ойлгож байв. Тэр одоо өөрөөсөө илүү хүчтэн, алдар суутай хаан бий гэдгийг хүлээн зөвшөөрч чадахгүй болжээ. Тийм их улс их хаан байх аваас түүнийг даран мөхөөж эрхэндээ оруулахыг хүснэ. Алтан улсын их хаан буун өгч хөвүүнээ зуун нөхдийн хамт алба хаахаар ирүүлсэн нь

одоо Тулуйн дэргэд яваа нь юутай бахархалтай хэрэг билээ.

Тэр өөрийн улсад Ойн иргэд, Уйгар, Кидан, Харлагийг нэгтгэж Тангуд, Алтан улсыг дагуулав. Одоо өмнө зүгт Сүн улс, харин их цэргийн нь замд баруун талд Хорезм буй. Хорезмийн их улс, түүний их үгт хаан Мухамедийн тогтох, орших хоног хугацаа тоотой болжээ. Чингэх ёстойг сая Мөнх Тэнгэр Чингис хаанд хэлсэн билээ. “Тэмүжин чи баруун зүгт их ялалт байгуулж буруу шашинтныг дагуулна” гэж Мөнх Тэнгэр хэлэхийг Чингис хаан сонсчээ. Хорезм улсын дотоод нөхцөл байдал, цэргийн тоо байрлал, зам зуурын олон гол мөрний гарам, уул давааны гарц харгуйг сүүлийн хоёр жилийн турш уйгагүй тагнан судалсан нь Чингис хааныг ялалт байгуулах итгэлийг бататгажээ.

Хорезмын хаан Мухамед хэдий хүчирхэг цэрэг, баян улстай ч түүний улсын олон хотын захирагч нар хоорондоо эв нэгдэлгүй, дээр нь лалын шашны тэргүүн эрхийг баригч Багдадын халиф Хорезмын хаан Мухамедтай эрх мэдэл булаалдан зөрчилдөж бүр Чингис хаанд нууц элч илгээж найрамдахыг хүссэн нь Хорезмд довтлох эцсийн дохио болов. Тийм болохоор Чингис хаанд эргэлзэж тээнэгэлзэх зүйл үгүй байв.

### *ХАТАН БАЛГАСЫН УТАА*

Хорезм улсын хамгийн нэртэй зартай, баян тансаг хот Самаркандыг Чингис хааны цэрэг эзлэн авч хамаг алт эрдэнэс, өнгөтэй өөдтэйг нутаг руу ачуулж хот утаа үнсэнд умбаж хоцрохыг Хулан эхлээд сониучирхан дараа нь харамсан харсаар байлаа. Түүний нүдний өмнө өнгө өнгөөр тунарч солонго шиг алаглан байсан үзэсгэлэнт хот сарын дотор шатсан хожуул шиг болж үлдэх гаслант өдөр холгүй болжээ. Самарканд бол перс хэлээр “Үржил шимт өгөөмөр баян хот” гэсэн утгатай үг юм.

Хорезмын хотууд Чингис хааны их цэргийн өмнө дараалан нурж эцэст нь Самарканд л үлдэв. Самаркандыг Хорезмын шилдэг арван нэгэн түмэн цэрэг сахин хамгаалж байв. Самаркандыг авахын тулд Чингис хаан өөрийн бүх замын цэргийг Самаркандын ойр цуглахыг тушааж өөрөө хотын ойр Хөх сарайд хээрийн хүрээгээ байгуулж тухлан суув. Цэргээ амрааж, юуны өмнө тэдний их ялалтын хий хөөрлийг дарахыг тэр хүсчээ.

Самарканд бол хамгийн их бэхлэлттэй яг л төмрөөр цутгасан мэт бат бэх хот юм. Хорезмын эзлэгдсэн хот, нутгаас бүх залуу эрсийг дайчлан зохион байгуулсан “үхэл”-ийн гэж нэрлэх цэргийн ангиудыг довтолгооны тэргүүн эгнээнд явуулж хотын хана хэрмийг эвдүүлэхээр бэлтгэж байв. Нутгийн иргэдийг дайчлан эхний эгнээнд амьд бамбай болгон өмнөө давшуулах аргыг Чингис хаан Алтан улсыг дайлахдаа хэрэглэж гаршсан юм. Нутгийн цэргүүд хоорондоо тулж бие биенийг алахдаа зориг хүч нь хялбархан мохон дийлддэг нь өөрийн цэргийн хүчийг хэмнэхэд туйлын ашигтай билээ. Тийм учраас аливаа хотыг эзлэн авмагц залуу эрсийн эсэргүүцэнийг шууд алж, сайн дураар дагагсдыг өршөөн “үхлийн анги”-д хуваадаг байлаа. Одоо ч тэр аргаа хэрэглэн эзлэгдсэн бууж өгсөн хотуудаас үхлийн цэргүүдийг дайчлан авчирч тэднээр Самаркандыг бүслүүлжээ. Самаркандыг бүслэсэн “үхлийн цэргийн” тоо хорин түм хол давжээ. Харин Чингис хааны шилдэг цэргүүд тэдний ард байрлана. Амьд бамбай хэрэглэж, нутаг орны бүх эд баялгийг дээрэмдэн хураасан Монгол цэргийг ялна гэсэн итгэл хэнд ч төрөхгүй ажээ.

Хотыг яаж тонох, хэрхэн сүйтгэх зэрэг нь уг хотынхон яаж эсэргүүцэн тэмцэж, Монголын цэргийг сүйрүүлэн хохироосон хэмжээнээс хамаарна. Өөрийн дураар бууж өгсөн хотыг зөвхөн албан татвар төлөх хэмжээг тогтоон цэрэг дайчлах, хүнс, агт гаргуулах зэргээр шийдэж, эвдэлгүй орхидог байлаа. Харин эсэргүүцэн тэмцсэн хотыг эвдэн сүйтгэж газрын хөрстэй тэгшлэх нь ч бий. Жилийн өмнө Хорезмын хамгийн том хотуудын нэг Бухарыг яг ийм хувь тавилан дайрчээ. Чингис хааны цэрэг довтлон ирэхийн өмнө хэдэн түмэн хүн бужигнаж, баян тансгаараа зард гарч байсан Бухар хотын суурин дээр одоо үнс чандруу бужигнасан туурь үлдээд тэнд золбин муур л орилолдож байгаа. Чингис хаан өөртөө сайн дураар дагаж орсон лалын шашны тэргүүн имамуудаас нэр хүндтэй олны танил хамгийн алдартайг нь сонгон авч эзлэн авах хотод элч болгон илгээж Тэнгэрийн гэсгээл үзэхээсээ өмнө бууж өгөхийг шаарддаг байв. Тэгээд бууж өгсөн хотыг зүгээр орхиж эсэргүүцэн тэмцэснийг эвдэж сүйтгэдэг нь Хорезмын нутгаар нэг илэрхий болсонд түрэг хүмүүс олонх суудаг олон хот ийм маягаар ээлж дараалан бууж өгсөн билээ.

Хорезмын султан хаан эхнээсээ л Чингис хаантай байлдахдаа буруу арга хэрэглэсэн нь ч ялагдан сүйрэхэд дэм болжээ. Хот болгон өөрийн эзэн жанжин, тусгаар цэрэгтэй, тэд зөвхөн хар амиа бодон өөрийгөө л хамгаалахыг сэтгэх тул хэн нь ч Чингис хааны худалдаачдыг алсан Отрар хотын захирагч Хажирханы төлөө амиа үрэхийг хүссэнгүй. Султан Мухамедийн нэгдсэн цэрэг байгуулах оролдлого бүтэлгүйтэн зугатааж түүний оронд суусан Желаладдин султаны үед мөн л хот бүр зөвхөн өөрийгөө хамгаалах арга хэрэглэсэн нь Чингис хаанд нэг нэгээр аятай тайван эзлэн авах боломж олгосон бөгөөд Хорезмийн их улсыг ердөө дөрөвхөн жилийн дотор сүйрэн мөхөх үндэс болов. Самарканд хотыг хамгаалан суугч Мухамедийн шилдэг торгон цэргүүд одоо Чингис хааны өмнөх эцсийн саад болж үлдэв. Энэ цэрэг Мухамед султаны эцсийн найдвар байв. Монгол нутгаас гарснаас хойш Уйгарын Идүүд хаан, бас Харлаг улсын Арслан хааны цэрэгтэй нийлсэн Монголын их цэрэг анх Чингис хааны худалдаачин элчийг алсан Отрар хотод хүрч бүслэн хааж зогсоход Хулан хатан туйлгүй ихээр догдлон хөөрчээ. Отрар хот шиг ийм тансаг үзэмжтэй балгасыг тэр урд нь үзсэнгүй. Нүүдэлчин иргэдийн нутагт их л сайндаа хэдэн арван гэртэй их хүрээ л байхаас наранд гялбах алтан дээвэрт ордон өргөө сүндэрлэсэн чулуун хот хаана нь байх билээ. Хотыг дөрвөн зүгээс нь шивээлэн хаасан их цэргийг харахад өөрийн эрхгүй Чингис хааны агуу сүр хүчинд бахдан бишрэх сэтгэл төрөх ажээ. Харин Чингис хаан Отрар хотыг эзлэхийг хөвүүддээ даатгаад өөрөө цэргийн хамт Хорезмын нутгийн гүн рүү Сыр дарья, Аму дарья мөрний хөндийг чиглэн явжээ. Гэтэл Хулан дараагийн хотыг үзмэгц андуурснаа ойлгов. Түүний үзэж бахархсан Отрар бол өчүүхэн жижиг суурин болохыг мэджээ.

Чингис хааны цэрэг Зарну хотыг буулган авч 1220 оны гуравдугаар сард алдарт Бухар хотын дэргэд очсон нь энэ байв. Эрдмийн хот нэртэй Бухар бол үнэхээр өчүүхэн Отрар цайзтай зүйрлэх юмгүй том хот учир Хулан гайхахаас аргагүй байв. Хүний гараар ийм тансаг, агуу их хотыг бүтээн босгосон гэхэд итгэж үнэмшимгүй санагдана. Хулан хатан энэ үзэсгэлэнт хотыг өөрийн болгож энд үүрд суухыг хүсэв. Бас эвдэн шатаахгүйгээр энэ хотын гудамж зээлээр зугаацан цэнгэхийг хүсчээ. Хулан зам зуур үнс, чандруу болсон хот, тосгод олныг үзсэн тул дайн, ялалтын хий хөөрөл нь дарагдаж амьдралыг үнэн бодитоор үзэх болсон байв. Чингис хааны бэлэглэсэн Перс газрын үнэт эдлэл, алт эрдэнэсийг түүний хөсөг арайхийн дааж явжээ. Хуланд эдгээр үнэт эдлэл нэгэнт сонин санагдахгүй болжээ. Тэр одоо энэ Хорезмын үзэсгэлэнт хотыг өөрийн болгохыг хүсч байлаа. Тийм учраас Чингис хааны цэргүүд хүний

гараар цогцлон бүтээсэн гайхамшигийг эвдэн сүйтгэж байгааг дотроо эсэргүүцэх болов. Гэтэл Хулан яаж ч эсэргүүцээд энэ их эвдрэл сүйрэл үхэл цусыг зогсоож чадахгүй ажээ. Харин Чингис хаанаас гуйвал ядаж ганц хотыг ч болов бүтэн үлдээх болов уу гэж бодох болсон нь эцэстээ нэгэн шинэ хүслийг төрүүлжээ. Хулан энэ шинэ хүсэлдээ бүр шунан дурлаж ганц ч өдөр тайван сууж чадахгүй болсоор бас энэ хүслээ Чингис хаанд хэлж төвдөхгүй байсаар Самаркандын дэргэд иржээ. Үзэсгэлэнт Самаркандыг хараад одоо цаг алдан алгуурлаж болохгүйг ойлгожээ. Магадгүй Дээд Тэнгэр ганцхан энэ хүслийнх нь төлөө түүнийг Тэмүжинтэй учруулсан ч юм бил үү.

Хорезмийн зүүн нийслэл гэгдэх тансаг баян Самаркандыг эзлэн суувал Хуланы нэр алдар түгэн дуурсах юм шиг бодогдоно. Олон түмэн хүнтэй Самарканд хотыг Чингис хааны цэргүүд эвдэн сүйрүүлэхээс аварч чадвал Хуланг энэ нутгийнхан үеийн үед сайнаар дурсан санаж эцэстээ Самаркандыг “Хулан хатны балгас” гэж нэрлэвэл хичнээн бахархалтай билээ. Ийм шинэ бэрх хүсэлд автсан Хулан солиорох гэж байлаа. Тэр угаас нэг юм санавал цаана нь гарч байж санаа нь амрах зантай тул нэг мөч тайван сууж эс чаджээ. Хулан хатныхаа эл хачин жигтэй байдлыг Чингис хаан ч гадарлажээ. Хулан ингэж өөрийгөө алдаршуулан бүхнээс дээгүүр суух гэж хүсэх болсон нь бас нэг учиртай билээ. Одоогоос хоёр жилийн тэртээ Чингис хааны их цэрэг Хорезм руу хөдлөхийн өмнөх нэгэн үдэш Бөртэ хатан Хуланг өргөөндөө урьж зоог барьжээ. Ганц биед нь ингэж анхаарал хүндэтгэл тусгайлан үзүүлсэн явдал урьд нэг их олон гараагүй тул Хулан их цочирдож балмагджээ. Алс газар одох болов гэж энэ биз хэмээн бодовч нэг л сайн зүйл төсөөлөгдсөнгүй билээ. Энэ гэрт Тэмүжинд анх ирснээс хойш их хатан Бөртэ түүнд онцгой дотно хандаагүйг Хулан мэднэ. Тэр бүү хэл атаархан хорсох байдал ч илрэх шиг санагддаг байв. Ерөөс Хулан анхнаасаа л их хатан Бөртэ гэгч хөгшин авгайг дотор сэтгэлдээ ихэд үзэн яддаг байлаа. Тэр хөгшин хатан Чингис хааны дэргэд хамгийн их эрх мэдлийг эдлэх нь гачлантай.

Бас дээр нь Чингис хаан өөрийн дөрвөн хөвүүндээ амиа тавьдаг тул Бөртэ яах ч аргагүй Хуланаас дээгүүр зиндаанд байх нь гарцаагүй агаад үүнийг хүн бүгд мэдэж Бөртийг хүндэтгэх нь Хуланд огтхон ч таалагддаггүй билээ. Ядаж түүнээс үр хүүхэд гарсангүй. Хэрэв түүнд хөвүүн үр заяасан бол Хулан Чингис хааны хамгийн хүндэт хатан болж, хөвүүн нь их хааны суудлыг залгамжлах нь гарцаагүй байхсан гэж бодох бүр хувь заяандаа ихэд гутрах болжээ. Гэтэл тэр үдшийн зоог дээр Бөртэ хатны хэлсэн үг туйлын хортой гашуун байсныг Хулан хэзээ ч мартахагүй гэж өөртөө тангарагласан билээ.

Бас энэ үгийг Чингис хаан болоод дөрвөн хөвүүнийхээ нүүрэн дээр зориуд хэлснийг яана. Бөртийн энэ үгс Хуланг эхлээд цочоож, сүүлд нь гунигт авгуулж одоо улам үзэн ядахад хүргэв. Чингис хааныг дайнд мордоход нь их хатны хувиар Бөртэ ингэж эр нөхөр, хөвүүдээ дайлж үддэг ёстой ажээ. Энэ тогтсон ёсоор Бөртийн их өргөөнд Чингис хаан, Зүчи, Цагадай, Өгөдэй, Тулуй бас Хулан нар зэрэгцэн сууж байв. Тэр үдэш Бөртэ хатны хэлсэн уран найруу үг бүгдийг эзэмдэж тэр дундаа Чингис хаан бүр их бахдалтай сонсохыг үзээд дөрвөн хөвүүн төрүүлсэн Бөртэд Хулан үхтэлээ атаархсан билээ. Хуланд залуу наснаас өөр Бөртөөс дээр гарах юм үгүйгээ мэджээ. Хулан Өгөдэйтэй нас чацуу, харин Тулуйгаас хоёр эгч бүлгээ. Бөртэ хатан тэр үдэш олон хундага өргөж сайхан үг хэлсэнд бүгд сэтгэл сэргэжээ. Харин Хуланд хундага барьж түүнд зориулан үг хэлэх хүртэл тайван сайхан байв. Бөртэ ээлжит хундагаа өргөөд ийн хэлэв.

-Хулан хатан. Чингис хааны зарлигийг дагаж чи хол аянд олон жил сараар явах тул бид уулзахгүй удах биз. Тийм болохоор би цөөн хэдэн үг хэлье. Увас мэргэдийн Дайр-Үсэнгийн охин Хулан чи Чингис хаанд ирээд арван тав зургаан жил өнгөрчээ. Одоо чи увас мэргэдийн Дайр-Үсэнгийн охин Хулан биш, Чингис хааны хайртай хатан Хулан болжээ. Чи Чингис хаанд ирэхдээ арван наймтай байсан. Тэмүжин намайг очиж авахад би ч бас арван наймтай байсан. Цаг хугацаа гэгч энэ ертөнцийн бүх зүйлсийг хувирган өөрчилж чадна. Нэгэн цагт танай Мэргэд аймаг Боржигон аймаг, Чингис хаанд дайсагнаж Бөртэ намайг хүртэл булаан авч байсан нь үнэнтэй.

Гэвч муу үйл муу үйлээ л дагуулдаг аж. Одоо танай Мэргэд аймаг үйлээ даган Чингис хаанд дарагдан сүйрч нэгэнт үгүй болов. Харин Дайр-Үсэнгийн охин Хулан чи гоо сайхан төрснийхөө хүчинд амьд үлдэв. Чи өөрийгөө олон мэргэдийн дотроос хамгийн азтайд тооцох ёстой юм. Чингис хаан чамайг соёрхон таалаагүй бол чи өнөөдөр манай улсын хэний нь хөнжлийг бүлээцүүлж, хөлийг угааж явахыг хэн мэдлээ.

Бүр сураг үгүй хумхийн тоос ч болсон байж мэднэ. Ийм үг хэлэв гэж чи надад гомдож туних зүйл үгүй. Би энэ үгийг худал гэж санахгүй байна. Би хэлье гэж хэлж байна. Би бол Есүхэй эцэг сүй тавьж, Чингис хаан ёсолж авсан анхны нь хатан. Дөрвөн хөвүүн төрүүлж өгсний хувьд би ийм үг бардам хэлэх эрхтэй хүн. Би дөрвөн хүү төрүүлсний учир алтан урагт дархлагдаж Боржигон удмын хүн болсон юм. Харин чи мэргэд хүн гэдгээ хором ч бүү март. Чи гэнэ гэнэ хэн болохоо мартдаг тул би чамд үүнийг сануулж байна. Чи мэргэд хүн гэдгээ хэзээ ч мартажгүй санаж явбаас Чингис хаан чамайг соёрхон тэтгэж хавиргандаа авсны их ач, агуу сэтгэлийн үнэ цэнийг ойлгох болно.

Чингис хааны чамайг ивээлдээ багтаасан энэ их соёрхол танай мэргэд аймгийн олон олон хүн, тэр дотор төрсөн эцэг Дайр-Үсэнгийн чинь амь насны үнэтэй юм. Чи эцгийнхээ болоод энгийн мэргэд иргэдийн халуун амийг үрсний хүчээр Чингис хаанд иржээ. Тийм болохоор Хулан чи эртэй сайндаа их хатан болов гэж бүү эрд. Чингис хааны өмнө бүү осолд. Чи залуу хүн. Сэтгэлээ бөхөл. Хатан хүнд ямар журам байх ёстой гэж Чингис хаан сургасныг би чамд давтан хэлье. Чи лав сонссон биз. Гэхдээ миний амнаас сонссонгүй.

Миний хэлэхийн учир нь Чингис хаан энэ сургаалаа миний охин Алалтун бэхид хэлсэн учиртай. Чингис хаан Уйгур улсын хаан Идүүдийг эсэргүүцэлгүй дагав гэж сайшаан Алалтун бэхи охиноо өгөхдөө түүнд ингэж сургасан юм. Хатан хүнд гурван эр бий. Анхны эр нь алтан төр болно. Түүний дараах эр нь ариун нэр болно. Удаах эр нь авсан эр болно.

Алтан төрийг хатуужиж дагавал ариун нэр бэлэн болно. Ариун нэрийг бэхэлбэл авсан эр ангид үл одно гэсийм. Би Тэмүжинтэй арван настайдаа учирсан юм. Түүнээс хойш өдий болтол би Чингис хааны энэ сургаалийг дагасан билээ. Тийм болохоор Хулан чи ч энэ сургаалийг бүү март. Хатад бидэнд өөрийн гэх юм юу ч үгүй. Бүгд Чингис хааных. Ариун бие, алдар нэр, алаг үр бүгд Чингис хааных. Үүнийг үргэлж санаж яв. Миний хөвүүд чамаас ах.Тэд дөрвүүл цэрэг засаж улс эзэлсэн их жанжин болцгоожээ.Гэвч эд бүгд Чингис хааны өмч юм. Чи одоо хол газар хаан эзнээ дагахаар сонгогдов.Ачаа нь хөнгөдсөндөө чамайг дагуулсангүй. Тиймийн тул эр нөхрөө асран халамжлахаа хичээ. Хаан хүний дэргэд хатан байхын учир юу вэ. Хоолыг нь халаах, хавиргыг нь дулаацуулах төдий юу.Үгүй ээ. Ариун нэр, алдар сууг нь бөхлөх гэж хатан байдаг юм. Бас алтан ургийг нь үлдээх гэж хатан байдаг юм.



Чи залуу байна. Нэгэн өдөр хөвүүн төрүүлэх биз. Чи хөвүүн төрүүлж хөнжилдөө хуурайлж үзээгүй болохоор үр хүүхэд гэж хичнээн үнэтэйг мэдэхгүй биз. Яах вэ. Сүүлд чи өөрөө үзэж мэднэ. Хулан минь холын замд, харийн нутагт хичээ.

Бөртийн энэ үгийг Чингис хаан болоод Хулан, бас хөвүүд нь бүгдээр нам гүм сууж сонсов. Сонсоход сургамжтай мэт боловч цаад санаа нь Хуланг илт тохуурхан доромжилж, доорд үзэн дарласан үг байлаа. Гэтэл Бөртийн энэ үгсийг Чингис хаан толгой дохин туйлын сэтгэл ханамжтайгаар сайшаан сонсохыг үзсэн Хулан тэр гэрт сууж чадахгүйд хүрэв. Гэтэл Бөртэ хахсан дээр нь нудрав гэгчээр

-Хулан хатан. Та миний өргөөнд морилон саатсанд талархалаа. Би одоо эр нөхөр, хөвүүдийн хамт халуун амиар хэсэг зуур хөөрөлдье хэмээн найртай үгээр Хуланг шууд хөөн гаргав.

Арван тавны сарны сул цагаан гэрэл дор Хулан тэгэхэд гашуунаар мэгшин уйлсаар харьсан билээ. Бөртийн хэлснээр, түүний үзэж буйгаар Хулан бол Боржигон аймгийн дайсан мэргэд удмын, дээр нь өөрөө гуйж ирсэн, аймаг болон эцгийн амийг үрж золиослон байж өөрөө үлдсэн, Чингис хаанд хөвүүн төрүүлж өгөөгүй, хатан нэрнээс цаашгүй эм ажээ. Бөртэ, Хуланг яг ингэж үзэж байсан бөгөөд Чингис хааны сургаал үгээр халхавчлан бүгдийн нүдний өмнө түүнийг сэтгэлээ ханатал доромжлон гутааж авчээ. Энэ бол Бөртийн олон жил хүлээсэн ясны өш хонзон, эм хүний хор шар, мэргэдэд булаагдсаны Хуланы эцэг Дайр-Үсэнд хүчирхэгдэн доромжлогдсоны хорсолоо тайлсан хэрэг байлаа. Бас өөрийн болоод Тэмүжиний нэр сүрийг бодоод Дайр -Үсэнд хүчирхэгдэн дарлуулснаа нууж өнгөрүүлсэн их шаналалаа тайлсан хэрэг байв.

Эр нөхрийг нь булаасан мэргэд цусны үзэсгэлэнт эм Хуланг Чингис хааны өмнө, өөрийн хөвүүдийн нүдэн дээр гутаан доромжилж сэтгэлээ тайтгаруулахын тулд Бөртэ хайртай хөвүүн Зүчиэ ч бодсонгүй, түүний мэргэд цустайг ч мартав. Дайр-Үсэнг үхүүлэв гээд Бөртэ түүнийг өршөөж тайвшраагүй бөгөөд эцгээ ч үл хайрлах Хуланы цаад санааг тааж мэдээд түүнээс заавал өс авахаар шийдсэн билээ. Зүчийгээ ч бодолгүй хатуу үг хэлсэн нь эм хүн өш санавал юугаа ч хайрлахгүй болдгийн жишээ юм. Энэ хортой үгсийн дараа хэн Хуланг Бөртэтэй жишин үзэх билээ. Хуланы итгэл найдвар, аз жаргалыг Бөртэ ингэж ганц үдшийн дотор нураан сүйрүүлж чаджээ. Хулан үр төрүүлж Бөртийн зиндаанд хүрч чадаагүй заяандаа гомдон тэр шөнө анхилам үнэрт дэрээ нэвт уйлсансан. Чингис хаан тэр шөнө нь ирсэнгүй нь Хуланы гомдол шаналалыг улам гүнзгийрүүлж, хорсол хилэнг бадраажээ.

Чингис хаан тэр шөнө их хатныхаа дэргэдээс холдох сэтгэлгүй байжээ. Сүүлийн жилд тэр Бөртийн өргөөнд хоносон нь тоотой ажээ. Харин энэ үдэш их хатныхаа цэцэн үг, саруул ухаанд биширч, өсч эрийн цээнд хүрч их жанжин болсон дөрвөн хөвүүнээ үзэж хөөрөөд ингэжээ. Шөнө дарсанд халамцсан эр эм хоёр хорин настай хонгор сэтгэлтэй хос шиг жаргаж цэнгэсэн бөгөөд үүндээ ч тэд их гайхсан билээ. Хөлс хатаан хөнжил ярж хэвтэхдээ авааль эрээ Хуланд өгч явуулах нь Бөртэд жаахан харамсалтай санагджээ.

-Чингис хаан таны явах зам хол, хугацаа удаан, ядарч чилэх нь их тул залуу хатан тань уйдаж, хагсрах бий. Хаан та асрамжлахаа хичээж бүү мартагтүн. Ер нь эм хүн эр нь үргэлж л дэргэд нь эргэлдэж дэнгийн эрвээхэй шиг дэрвэлзэж байхыг хүсдэг юм. Хулан ч тэгдэг биз. Хаан та бид хоёр одоо жар хүрэх ойртов. Хорезмоос ирээд гэртээ амар сууж, их дайнд хөвүүдээ

мордуулж байгтүн гэж шивнэв. Энэ бол нэг хүнмэт болсон эхнэр хүний халуун сэтгэлийн үг тул Чингис хаан уярав.

-Тийм ээ. Бөртэ. Би хөгширч байна. Эмийг эдлэх хүсэл эр биеийн чалх чадал буурчээ. Би яг үүнд чинь сэтгэл зовно. Гэтэл Хулан ёстой гал мэт дүрэлзсэн тачаалтай юм. Гэвч би түүнийг нүдэндээ харж, дэргэдээ дагуулахыг хүснэ. Өөр шашинтай, өрнийн тэр улс намайг ямар гоо хатантайг үзэг гэж бодно.

-Хаан та зөв боджээ. Гэвч Хуланаас үзэсгэлэнт эм Хорезмд лав буй. Та тэндээс Хулангаас ч гоо хатан авагтүн.

-Одоо чи бид тэгэж хоёр биендээ зовлон чирэгдэл учруулж яана гэж Чингис хаан үнэнээс өгүүлжээ.

-Залуу хатан таална гэдэг хар биений хэрэг биш. Хаан алдрын тань хэрэг шүү гэж Бөртэ эрс шулуун хэлэв. Бөртийн энэ үг Чингис хааныг үнэхээр бишрүүлжээ.

-Бөртэ. Ингэж хэлэхийг чинь үзвэл би биш харин чи хаан суувал таарах байжээ. Би ганц биеийг амрыг бодож хэлснээс биш чам шиг ингэж хол бодсонгүй шүү. Хатан гэдэг чинь үнэхээр хаан суудлын хэрэг юм. Бөртэ. Би чам шиг хатантай тул ийм их нэр сүрийг олжээ гэж Чингис хаан хэлэв. Бөртэ Чингис хааны энэ үгэнд талархан түүнд бүх биеэр наалдав. Гэвч тэдний хуял тачаал дахин оргилсонгүйд хоёул гунигт бодолд автсан билээ. Залуу гэгээн нас, халуун тачаалт цус нэгэнт холдон одсоныг ингэж мэдрэх нь хүн бүрт л гуниг шаналал авчирдаг биз ээ.

Харин тэр шөнө Хулан нойргүй хонохдоо олон зүйлийг эргэцүүлэн бодсон боловч эцэст нь тэр нэгэнт л Чингис хааны хатан болохоор тэмцсэн тул юу ч тохиосон эрс хатуу тэмцэх ёстойг ухаарав. Нэгэн шөнийн дотор Хуланы сэтгэл бодол өөрчлөгдөөд шинэ хүн мэт болжээ. Одоо тэр хоосон мөрөөдөгч хорсон уйлагч байх нь дэндүү гэнэн бөгөөд өчүүхэн хэрэг болохыг ойлгож авчээ. Тэр хэтэрхий дорой үхээнц байгаа учраас Бөртэ түүнийг ингэж уландаа гишгэн доромжилжээ. Бөртэтэй эрх мэдэл булаалдан тэмцэх хүчтэй зэвсэг байгаа нь түүний залуу нас, гоо үзэсгэлэн болохыг тэр санав. Одоо нэгэнт жар дөхсөн тэр хөгшин хатан Бөртэ хэзээ болтол наслах билээ. Гэтэл Хулан одоо дөнгөж гуч гарч байлаа.

Залуугийн гоо үзэсгэлэн, цог заль нь хэвээр харин ч нас тогтон байргашиж бүр ч эрийн хүслийг татах болно. Бөртэ лав үхнэ. Тэр цагт Хулан хэрхэх вэ гэдгээ бодох ёстой болжээ. Чингис хаан түүнд хайртай. Тийм учраас хатдынхаа дотроос түүнийг сонгож шинэ аян дайндаа дагуулсныг ч ашиглах ёстой гэж шийдэв. Маргааш өглөө гэхэд Хулан огт өөр үзэл бодол зорилготой болж эрс хатуугаар шийдсэн байв. Ер нь Хулан хар багын зориг, цөс ихтэй бүсгүй юм. Түүнээс биш өөр хүн байсан бол Бөртэ болоод бусад хатдын нэр сүр, хор шаранд аль эрт дарагдан мартагдах байсан биз. Харин Хулан зовох бүр, хүн өөрийг нь гутаан доромжлох бүр өнгө орж, зориг чангардаг зантай билээ. Тэр ч янзаар Бөртийн хэлсэн гашуун үгийг хүлээн авч өөрийнхөөрөө эсэргүүцэн тэмцэхээр шийдэв. Ингэх гэж, Чингис хааны хайртай хатан болох гэж алдар нэрээ мандуулахыг хүсч амиа үл хайрлан зориглон тэмцэж ирсэн биш үү. Тэр яав ч Бөртээс дор суудалтай доогуур нэртэй байж болохгүй гэж шийдсэн билээ.

Хорезмд ирж хоёр жил өнгөрөхөд олон хот үгүйрч балгас болохыг үзээд Хуланы бодол сэтгэл өөрчлөгдөв. Бас өөрийн хүсэл тэмцлийн зорилгыг ч ойлгов. Энэ нь суурин амьдрагч иргэдийн олон жилийн хүч, ур чадлаар бүтээсэн их хотыг үзээд тал нутгийн тэнүүлч нүүдэлчин амьдралдаа гутан, голох сэтгэл байлаа. Тийм ч учраас Хорезмын энэ үзэсгэлэнт хотыг эзэмшиж үүрд сууж алдар сүрээ мандуулах хүсэл түүнд улам хүчтэй төрөх болжээ. Яг ийм үед Чингис хааны цэрэг Самарканд хотын дэргэд ирсэн нь энэ байв. Сыр-Даръя, Аму даръя мөрний дунд орших цаг агаар нь дулаан зөөлөн, хөрс шороо нь нэн баялаг энэ гайхамшигт хот Хуланы сэтгэлийг татжээ. Тэр Самарканд хотод үүрд суухаар шийдэв Мөхөж сүйрсэн мэргэд аймаг, Бөртэ хатны чимээгүй дарлал дор буцаж очихыг тэр хүссэнгүй. Нутгаас гарснаас хойш даруй гурван жил шахам болоход Хулан нэгэнт өөр хүн болон хувирчээ.

Монголд байхгүй баян тансаг нутаг, нүд булаам орд харш, үнэт эрдэнэс, баялаг байхыг тэр үзэж, эдлэв. Одоо түүнд үүнээс өөр юу ч үл хүсэгдэх ажээ. Тэр энд персийн хивс торгонд хөлбөрч, Бухар дарс шимж, Самаркандын амтат идээ зооглож, Багдадын алтан эдлэл зүүж байв. Монголын тал нутагт түүнийг татах зүйл өчүүхэн ч үгүй мэт. Одоо энэ газарт Чингис хааны их цэргийг эсэргүүцэн тэмцэгч хүч үгүй болж, Хулан энэ газарт хамгийн алдар цуутай хатан болов. Гэвч Хуланы сэтгэл үргэлжийн шаналал, харууслаар дүүрэн байх ажээ. Нас идэр, дур хүсэл их бүсгүйд цэрэг дайны их үйл, аян замын алжаалд туйлдан ядарсан угаас нас ахиж өвгөрсөн Чингис хааны эр хүний халамж энхрийлэл багадаж, хагсарч гундаад үүнээс үүдэн сэтгэл санаа тогтворгүй, уур уцаар ихтэй болжээ. Үүний учрыг ч Чингис хаан мэдэх бөгөөтөл үнэн сэтгэл гарган түүнийг хайрлахын оронд перс, иран, түрэг цусны залуу охидтой цэнгэн самуурахыг урьтал болгоно.

Чингис хааны энэ цэнгэлийг тэвчиж өнгөрүүлэх нь Хуланд бэрх байвч их хааны хүслийг эсэргүүцэн хорих хүн хэн билээ. Хулан нэг талаас үзвэл тансаг эдлэл, үнэт эрдэнэстэй адил хөнгөн ганган сүйхний амьд ачаа болон хувирав. Заримдаа Чингис хаан юуны учир Хуланг дагуулан гарсныг гайхна. Залуу идэр бүсгүйд эр нөхөр нь үл тоомсорлохыг үзэж мэдрэх шиг гачлан доромжлол хаа байх билээ. Гэвч Хулан тэвчин явав. Чингис хаан Хуланы шаналал зовлонг ойлгож байв. Гэвч залуу хатнаа хэн нэгэнд сэтгэл алдрах, биеэ эзэмдүүлэхээс үргэлж сэргийлж хар нүд үл хамхих итгэлт хүмүүсийг дагалдуулан харгалзуулжээ. Хулан хүн торонд хоригдсон тогос шиг суух аж. Чингис хаан Хуланг зүгээр нэг дагуулж яваагүй юм. Хорезмын их хотуудаас элч ирж дагаар орох бүрт Хулан хатнаа дэргэдээ суулган тэднийг хүлээн авч үгийг сонсох бөгөөд ганцхүү энэ үед л тэр Чингис хааны хатан мэт байна.

Чингис хаан Хуланг өмгөөлөн хамгаалах гэж, хайртай сэтгэлийн үүднээс түүнийг дэргэдээ авч Хорезмыг дайлахаар мордсон билээ. Учир нь тэр өөрийгөө Хуланд өртэй мэт боддог байв. Залуу Хулан үр зулбаж, түүнээс хойш дахин хүүхэд олохгүй болсныг Чингис хаан өөрийн буруугаас болсон гэж бодох ажээ. Тийм учраас Хулан хатныхаа нэг насны шаналалыг нимгэлэн сэтгэлийг нь тайтгаруулан баясгах гэж Хорезмд дагуулан ирсэн билээ. Олон жилийн урт аян дайнд Хулан хатан нь уйдаж, ганцаардаж байгааг ч тэр мэднэ. Тийм ч учраас Хулан хатны элдэв этгээд хүсэлд хүндэтгэл анхааралтай хандах бүлгээ. Самарканд хотыг эвдэн сүйтгэхгүйгээр эзлэн авч өөртөө бэлэглэхийг Хулан хатан Чингис хаанаас хүсчээ. Бас энэ хотод насан үүрд сууна гэхүйд Чингис хаан инээмсэглэж

-Хулан минь би чамд Самаркандыг өгье гэж дуртай зөвшөөрснөөр барахгүй Хулан хатныхаа эцэс төгсгөлгүй хүсэл сэтгэлд бахдалтай байв. Хулан ингэж хүссэн нь Чингис хааны их нэр сүр, хүч чадлын билгэдэл, биелэл мэт санагджээ. Түүнээс өөр ямар хаан хатандаа их хотыг бэлэглэсэн юм бүү мэд. Хуланы энэ хүсэл Чингис хааны сэтгэлд яв цав нийлж өөрийн хөвүүдэд Самаркандыг эвдэн сүйтгэхгүйгээр эзлэн авахыг тушаав. Гэхдээ Чингис хаан цаад зорилгоо сурсан зангаар тас нуусан билээ. Зүчи, Цагадай, Өгөдэй, Тулуй дөрвөн хөвүүний удирдсан их цэрэг Хорезмын эзлэгдсэн хотоос дайчилсан “үхлийн” цэргүүдтэй нийлээд газар хөдлөж, өвс найгах мэт олон хүн Самаркандыг эргэн тойрон бүсэлж бараг агаар салхи нэвтрэх зайгүй шивээлсэн нь хотынхны зүрхийг үхүүлэх ажээ. Гэвч Хорезмын эцсийн цайз Самаркандыг хамгаалагч арван нэгэн түмэн цэрэг хотын иргэд жанжин Албарханы удирдлагын дор нягтраад үхэлдэн тэмцэх зориг төгс байснаас гадна хот гурван давхар хэрэмтэй, эргэн тойрон усан хамгаалалттай байлаа. Хотыг эвдэхгүй эзлэн авахыг Чингис хаан зарлиг болгосон тул Монголын цэргүүд шатаагч сум хэрэглэж чадахгүй болсон нь хэрмийг давахад саад болно. Гэвч тэдэнд үүнээс өөр зам байсангүй. Чингис хаан эхлээд лалын шашны нэртэй лам Хажиб Имамыг бичиг бариулан өөрийн элч болгож Самаркандад суугч Хорезмын султан Мухамедад илгээв. Бичигт “Чингис хаан миний бие Дээд Тэнгэрийг зарлигийг сонсох гэж энэ газарт мориллов.

Найрсаг сэтгэлийн илэрхийлэл болгон миний иэлгээсэн элчийг алсны гэмийн хариуд Мухамед чамаас ял асуухаар би ирлээ. Чиний улсын ихэнх хот балгас нэгэнт минийх болов. Одоо чи Самаркандыг надад зүгээр өгөгтүн. Би чиний лалын шашинт иргэдийн амийг хөнөөхийг үл хүснэ. Миний их цэргийн өөдөөс сөрвөл сүйрэх амь, үгүйрэх хотын нүглийг чи л Тэнгэрийн өмнө хариуцна. Хэн надад бууж өгнө, би түүний үр удмыг үл хөндөнө. Хэн миний өмнөөс эсэргүүцнэ түүний үр удам үүрд сөнөх болно. Чи миний үгийг эс дагавал чамайг чиний аллах тэнгэр чинь өршөөхгүй биз” хэмээн бичиж тамга дарсан байв.

Чингис хааны бичгийн утгыг Мухамед мэдсэн дороо цочин сандарч өөрийн оронд хөвүүн Желаладдинийг хаан суулгахыг тушааж, хатад, хөвүүдээ аван газар доорхи нууц хонгилоор Самаркандаас зугатан оджээ. Хаан Мухамедаа өргөөндөө морилж буй гэж итгэж байсан цэрэг болоод иргэд үхтэлээ тэмцэхээр шийдсэн ажээ. Тэд Чингис хааны элчийн үгийг огт сонсож мэдсэнгүй. Харин Чингис хаан Самарканд хотод суух Түрэг гаралтай иргэдийн толгойлогч Имам Падешварт нууц элч илгээжээ.

“Монгол, түрэг бид нэг гарал, удамтай ах дүүс биш үү. Бид Түрэг та нарыг Тэнгэрийн ивээлд багтаахаар тэр холоос ирэв. Та нар Мухамедийн төлөө хайран амиа үрэх хэрэг юу билээ. Хэрэв та нар удам гарлаа бодож хотын үүдийг нээж өгвөл би ах дүү Түрэг та нарыг өмгөөлөн авч амь болоод эд хөрөнгийг эвдэхгүй үлдээх болно” гэсэн Чингис хааны бичгийг авсан түрэгүүд урваж Самарканд хотын гадагш гардаг найман их хаалганы нэг Намасхахыг нээж өгснөөр Чингис хааны их цэрэг хотод цутган оров. Хорезмын цэргүүд хотын дотор байлдахдаа гаргуун, Монгол цэргүүд шатаах сум хэрэглэх хориотойгоос дэндүү олноор хядагдан, эсрэг талын харвасан шатаагч тосонд монголчуудын эзэлсэн байшин шатахад тэд олноор түлэгдэн үхэж байвч ухарсангүй. Самаркандыг эвдэхгүй авах Чингис хааны эл хачин зарлигийг зөрчих эрхгүй ч өөрийн хайртай цэргүүд дэндүү олноор үхэж үрэгдэхийг үзээд Зүчи тэвчиж эс чадаад эцэст нь цэргийн амь даанч хайран тул Самаркандын дунд хэрмийг шатаахыг тушаав. Үүнээс үүдэн Чингис хааны хөвүүдийн дунд хэрүүл үүслээ. Самаркандыг

эзлэн авбал тэр хотыг Өгөдэй авах санаатай байсан бөгөөд Чингис хааны хотыг эвдэхгүй байхыг тушаасныг ингэж таамагласан тэрээр Зүчийг эсэргүүцэн хэдий цэрэг үхсэн ч хотыг шатааж болохгүй гэжээ. Цагадай гэнэт Өгөдэйг дэмжсэн нь хэрүүлийг улам дэвэргэж Зүчи

-Би тэгвэл Самаркандаас өөрт оногдохыг шатаасугай гэжээ. Гэвч Өгөдэй арга олж Чингис хаанаас асуухаар шийдэв. Хөвүүд Самаркандыг эзэлж чадахгүй маргалдан хэний үгийг дагахыг асуусанд Чингис хаан бодож төвдсөнгүй

-Өгөдэйн үгээр бологтүн гэж тушаажээ. Галт зэвсэгтэй Хорезмын цэргийн өөдөөс сэлэм барьсан монголчууд түрэн орж дэмий олноор үхэх болов. Зүчи уурлан цэргээ хойш татлаа. Хулан хатныхаа хүслийг биелүүлэх гэсэн Чингис хааны зарлиг эцэст нь олон түмэн монгол цэргийн амийг үрж, хөвүүдийг нь хагаралдуулахыг тэр тааж мэдсэнгүй. Сэм оргож одсон Мухамед хаанаа бий гэж санан тэмцсэн хорезмын торгон цэргүүдийн эсэргүүцлийг дарахын тулд эцэст нь хотыг галдан шатаахаас өөр арга үлдсэнгүй.

Монголын цэрэг Самаркандыг эзлэх гэж бүтэн дөрвөн сар болж нутгаас гарсан хоёр түмэн монгол цэрэг үхэв. Самарканд бүрэн шатжээ. Хотыг хамгаалагч цэргүүд хааны ордонтой цуг шатаж үхэхдээ хоосон ордон хамгаалан тэмцсэнээ сая мэджээ. Гэвч өөрийн уугуул нутаг, суугуул хотоо аврах гэж яаж тэмцдэгийн үлгэр жишээг Самаркандчууд үзүүлэв. Бууж өгсөн түрэгүүдээс бусад залуу эмс, уран дархчуул хоёр түмэн хүнийг ялган цэргүүддээ хуваан өгч алт эрдэнэсийг монгол руу ачуулав. Эсэргүүцэн тэмцэгчдийн үр удмаас ташуураас өндрийг нь алсан нь гурван түм шахжээ. Хайран цэргүүдийнхээ амийг дэмий золиослосондоо Чингис хаан уурсан хилэгнэж Самаркандыг газрын хөрстэй тэгшлэх зарлиг буулгасан боловч эцэст нь тэнд сайн дураар бууж өгөгсөд үлдсэнийг бодолцоод арай ингэсэнгүй. Арван түмэн өрхтэй байсан Самаркандын иргэдийн долоон түмэн өрх нь дүрвэн зугатаж үхэж үрэгдэн сүйрчээ. Самаркандыг авах гэж удаж дэндүү олон цэргийн амь үрсэн бурууг Чингис хаан хөвүүддээ тохож, тэдэнтэй уулзахгүй ихэд хилэгнэсэн нь урьд хожид үзэгдээгүй муу үр дагавар авчирч мэдэх аюул бий болгосон тул Боорчи үгээ олж ядан Чингис хааныг ятгажээ.

Чингис хааны хөвүүдийн хооронд үүсэх болоод удсан хэрүүл зөрчил нь хөвүүд хийгээд Чингис хааны дунд үүсвэл улс бутрах аюул илэрхий болох билээ. Боорчийн үгийг сонсоод Чингис хаан дуугүй сууж сууж сая хөвүүдээ өөрт нь бараалхахыг зөвшөөрөв. Гэвч Чингис хаан өөрийгөө буруу зүйл тушаасан гэж огтхон ч бодоогүй бөгөөд “Хөвүүд зүрх зориг мохож зорилго хүсэл цалгардах биш үү” гэж Боорчийн учирласнаар тэднийг өршөөжээ.

Хэдийгээр Самаркандыг эвдэн сүйтгэлгүй бүтэн авч Хулан хатандаа өгч чадаагүй ч Сыр-Дарья мөрний эргийн хавцалд хясаа авируулан барьсан Нур балгасыг буулган авч Хуланд бэлэглэв. Нур балгас бол хоёр түм илүү иргэдтэй, сэрүүн агаарт цэцэрлэгтэй, султан хааны зуны өргөө байх гоёмсог үзэсгэлэнтэй хот байлаа. Хулан хатанд үйлчлэх албат, зарц, шивэгчид мянга илүү болж хотыг бүх талаас нь байнгын цэргээр харгалзуулж, зөвхөн тусгай зөвшөөрөлтэй хүн л нэвтрэх журам тогтоов. Бас Хорезмын хотуудаас үнэт тавилга, алтан эдлэл, торго, дурдан, идээ будааг байнга нийлүүлэх болжээ.

Хулан хатны өөрийн хоттой болж энэ газар үүрд суух хүсэл нь биелэв. Энэ бол 1222 оны өвөл байсан ч Нур балгаст цэцэг дэлгэрч, шувуу жиргэж байсан билээ. Хулан хатныхаа хүслийг бага боловч биелүүлсэндээ сэтгэл ханасан Чингис хаан түүнийг балгас ордонд нь орхиод

цэргээ авч Инд мөрнийг уруудан Желаладдиныг хөөсөөр Энэтхэг газар одож эргэж ирэлгүй жил өнгөрөхөд Хулан ганцаар суусаар Нур балгасын хуучин нэр мартагдаж олон бүгдээр Хатан балгас гэх болжээ. Бүтэн хот эзэгнэн суусан нь Хуланд төдөлгүй сонин биш болоод харин ч ганцаардмал амьдралаа өөрөө хүсч олсон мэт санагдах болжээ. Жаргалыг олох гэж хүсэх мөрт зовлон нэмэгдэх нь Хуланы хувь тавилан шиг санагдах тул зарим өдөр галзуурч солиормоор. Ерөөс тэр султан хааны зуны тансаг өргөөнд ганцаар байсаар галзуурахад ойрхон болж байлаа. Чингис хаан ялалтандаа улайраад эргэж ирэхгүй удах нь бүр ч гачлантай.

Нур балгасын ордны дотоод үйлчилгээнд зөвхөн перс, иран, түрэг эмс хүүхнүүд зарагдаж харин Хулан хатны ёслол, хүндлэл, хоол унд гээд бүх л хэргийг Ю-Унчи хуучин хэвээр эрхэлсээр ажээ. Хуланы нүдэнд ойр үзэгдэх ганц эр хүйст нь тэр болно. Ю-Унчи урьд нь Зүрчидийн Алтан хааны Жүндү балгас дахь их ордонд яг ийм албыг эрхэлж байхад Алтан хаан түүнийг найрамдалтай байсан Татаар аймгийн ханд бэлэглэсэн билээ. Татаар аймаг Чингис хаанд дарагдахад их ордонд үйлчлэх ёс дэгийг сайн мэдэх гучин тооны тайган хүнийг Чингис хаан Бөртэд бэлэг болгосонд тэднийг толгойлон анх Монголын талд ирж зүтгэх болжээ. Бөртэ хатан Ю-Унчийг Хулан хатны дэргэд томилон суулгасан нь Чингис хаанд таашаагдсан тул тэрээр Хулан хатны ордон, өргөө, ёслол, хүндлэл бүхнийг эрхлэн Хорезмд иржээ. Хулан хатан эхлээд өөрийн дэргэд эр хүн зогсож үйлчлэхэд дасахгүй хэцүү байсан ч Чингис хааны үгнээс зөрж эс зүрхэлжээ. Тайган хүнд эр эм хүн ер ялгаагүй хүн л бол хүн, эзэн л бол эзэн гэж үзэх тул Хулан төдөлгүй дасч одоо Хулан юу хүснэ, Ю-Унчи бүгдийг биелүүлэх боловч бас тэр Ю-Унчийн зөвшөөрөлгүй нэг ч зүйл дураараа хийж болохгүй хатуу ёс тогтжээ. Хулан арваад жил болоход Ю-Унчи хэмээх хэдий жар шахсан ч залуу сайхан царайтай, бие хаа тэгш энэ хүнийг эр хүн гэж бодохоо больжээ.

Ю-Унчийн дэргэд нүцгэн шалдан явахыг ч юманд үл тооцно. Учир нь тайган хүнд эмийг үзээд сэртэндэх хүсэл нэгэнт үгүй болсон байх аж. Чингис хаан болоод түүний хатдын ёслол хүндлэл, дэг жаягийг Ю-Унчи анх тогтоон мөрдүүлсэн тул их тэр хүндлэлийг олжээ. Ордон өргөөний дотоод дэг ёсыг сахиулах өөрийн үүргийг Ю-Унчи хэнээр ч хэлүүлэлгүй чин шударгаар ёсчлон гүйцэтгэх нь олонд тэр дундаа Чингис хаанд ихэд таашаагдана. Харин Бөртэ хатан чухам ямар далд санаагаар Ю-Унчийг Хуланы дэргэд шадарлуулсныг Хулан бүү хэл, Чингис хаан ч сэжиглэн тааварлахгүй ажээ. Морь унаж, амь сахихч цэргээ дагуулан Сыр-Дарья, Аму-Дарья мөрний эргээр салхи татуулан давхих нь Хуланы ганц зугаацал юм. Бас хүсвэл перс бүсгүйчүүдийг авчирч өргөөндөө дуулуулж бүжиглүүлж болно. Ганцхан эрд эрхэлж, эм биеэ зугаацуулах боломж л үл олдох ажээ. Хулан энэ хэрэгт нэг их шохоорхон дурлахгүй болсонд өөрөө ч гайхан хэдий дөнгөж гуч гарч байгаа мөрт дур хүсэл ингэж үгүй болсны учрыг үл олон өвчин эмгэг тусав гэж сэжиглэн Ю-Унчид хэлжээ. Ю-Унчи түүнийг сонсоод инээмсэглэж

-Хатантан. Газар ус, хоол хүнс солигдох нь эм хүний биед их өөрчлөлт үүсгэнэ. Та эргэлзэж элдвийг бүү бодогтүн. Чингис хааныг буцаж морилон ирмэгц та өөрийн эрүүл гэдэгт итгэх болно гэжээ. Хулан дахин өөрийг хэлсэнгүй түүний үгийг дагав. Гэвч Ю-Унчийн өдөрт гурван удаа ёс шиг өгдөг үзэмний шүүсэн ундаанд биеийн хөөрөл, тачаал хүслийг дарагч эм хийдгийг тэр мэдсэнгүй. Энэ эм Хуланд үйлчилж тэр өдөр өнгөрч сар жил улирах бүр үзэхэд л үзэсгэлэнт эмээс цаашгүй хүйтэн цэвдэг болсоор байгаа билээ. Үүнийхээ цаад нууцыг

мэдсэнгүй. Ер нь Хулан Чингис хаанд өөрөө хүсч ирснээс хойш олон олон зүйлийн нууцыг мэдсэнгүй өнгөрчээ. Чингис хаанд тоогдож хатан суусан нь эм хүн бүрийн амсаж эдлэх аз жаргалаас түүнийг үүрд хагацуулсныг тэр мэдэхгүй байв.

Зөвхөн өөрийн азгүй хувь зохиолдоо гомдон шаналахаас өөр арга байсангүй. Чингис хааны хүрээнд ирж суусан эхний ганц жил л эмийн ёсоор жаргасан байжээ. Чингис хааны үрийг тээж өгүүлшгүй их жаргал баяраар бялхаж бас Чингис хаан дөч гарсан хойно нь гарах шинэ үрдээ хичнээн их баярлаж байсныг одоо санах бүр гол нь тасрах шиг өвдөнө. Гэвч тэр азгүй бяцхан амьтанд Чингис хааны ургийг залгамжлах хүн болох заяа олдсонгүй. Бие хаа нь эрүүл саруул байсаар атал цагаасаа өмнө гэнэт эвгүйрхэн үр зулбаж амьгүй хөвүүн төрүүлсэн нь Хулан Чингис хаан хоёрыг хэрхэн цочирдуулсныг үгээр илэрхийлэх аргагүй байсан билээ. Зулбасан үр нь хөвүүн байсанд Чингис хаан бүр ч их харамсан гашуудаж шөнө дөлөөр нулимс унагахыг Хулан үзээд харуусал, шаналалаа тэвчин түүнд дахин хөвүүн төрүүлж өгөхөө амласан юм. Хэрэв тэр хөвүүн хүн болсон бол Чингис хааны голын хайртай үр нь болж одоо даруй арван найман нас хүрч хаан эцгийн суудлыг гарцаагүй залгамжлах байв. Ингэж санах бүр хэнд гомдохоо олж ядахдаа бүр Тэнгэрт ч болов өсөрхөн хорсох болжээ. Хулан хатныхаа энэ гашуун зовлон шаналалыг Чингис хаан үнэн сэтгэлээс ойлгож өрөвдөнө. Гэтэл тэд яаж ч хичээгээд Хуланд дахин үр тогтсонгүй өдий хүрчээ. Лав үр зулбаснаас болсон эмгэг биз гэж Ю-Унчид хэлж элдэв газрын домч төлөгчдөд үзүүлж эм тан хүртсэн ч тусыг олоогүй юм. Ингээд ганц хувь заяандаа гомдох л үлдсэн билээ. Энэ эмгэнэлт хэргийн цаад нарийн учрыг Хулан болоод Чингис хаан бас л тааварласангүй. Залуу үзэсгэлэнт Хулан хатан өст мэргэдийн цустайгаас гадна жирэмсэлснээс нь хойш Чингис хаан ганц түүнийг энхрийлэх болсон нь Бөртийн хувьд яавч зөвшөөрөн сайшааж болохгүй хэрэг байв. Энэ үед эм хүний сэтгэлийн мухарт байнга нуугдан байсан атаа жөтөө нь түрэн, ухаан санааг нь хордуулж, хоолонд нь жүр цэцгийн ханд хольж өгснөөс Хулан үр зулбасан билээ. Ингэж Бөртэ дөрвөн хөвүүндээ аюулт өрсөлдөгч бий болох замыг хааж мэргэдэд булаагдсан, Дайр-Үсэнд хүчирхэгдэн дарлуулсны өсөө авав гэж тайвширчээ.

Бас Бөртийн заавраар Ю-Унчи Хулан хатны бүх дэр жинтүүнд хүдрийн заар шингээснээс болж Хуланд дахин үр тогтохгүй болжээ. Эр эмийн янагийн үйлийн үед эмийн бөгсөн дор ивэх жинтүүнд шингээсэн хүдрийн заар эрийн үрийн сунг хормын дотор үхүүлэх тул ийм аргыг монголчууд нууцаар хэрэглэдэг билээ. Чухам ийм зорилгоор Бөртэ Ю-Унчиг Хуланы дэргэд шадарлуулжээ. Ордны доторхи тайган хүнд их хатны үг Тэнгэрийн зарлиг байх ёстой тул Ю-Унчи их хатан Бөртийн зааврыг өнөө Хорезмд ч туйлбартай мөрдөн сахисаар ажээ. Чингис хаан цэрэг дайны хэрэгтээ дарагдаад эмс хатдын хэрүүл зөрчлийг үл анзаарахын дээр гэрийн доторхи хэрэгт ямагт Бөртийн үгийг дагах тул ер сэжиглэн ухаж бодсонгүй нь Бөртийг санаснаа гүйцэлдүүлэн Хулангаас өшөө авах сайхан нөхцлийг бүрдүүлжээ. Чингис хаан Хуланг хөвүүн төрүүлээгүйд туйлын ихээр харамссан билээ.

Бүр зарим шөнө амьгүй хөвүүнээ амь оров, анд дагуулж явав гэж зүүдэлж хонодог байв. Учир нь Тэмүжиний авааль хатдаас хөвүүн төрөхгүй болсоор уджээ. Эм бие нь эрийн үрийг тогтоохгүй болсонд Хулан эхний үед зөвхөн өөрийгөө буруутган шаналж байсан нь алгуур өөрчлөгдөж Чингис хааны нас дээр гарч тавь гарсан хойно гэнэ гэнэ эр нөхрийнхөө чадал, чалхад эргэлздэг болжээ. Энэ бодол нь удах бүр лавшран өөрийн залуу сайхан төрхийг үзэх бүр эр нь түүнийг жирэмслүүлэх чадалгүй мэт санагдан бас нэг зовлон шаналал нэмэгджээ.

Чингис хаан Инд мөрнийг уруудан дайн хийсээр одсон хоёр жилд ганцаар гиюүрэн суухдаа сүүлийн энэ бодолдоо бүр бат итгэх болжээ. Өөр эртэй хавьтаж өөрийн биеийг сорьж үзмээр хүсэл оргиловч ингэх нь амь насны аюултай тул арай ч зүрхлэхгүй байлаа. Өөр эрээс жирэмсэлж Чингис хааныг хуурах нь дэндүү ёс бус аймшигтай нүгэл болно гэж Хулан бодно. Гэвч үрийнхээ зулайг үнэрлэж эх болох хүсэл нь өдөр шөнөгүй зовоон тарчлаах ажээ.

Яг ингэж зовж тарчлан үзэмжит өргөөнд хоригдсон ялтан шиг өдөр өнгөрөөж байх тэр зун Энэтхэгийн аагим халуунаас зугатсан Монголын цэргийн түрүүч Хатан балгасын ойрд буцаж ирсэн нь Өгөдэйн цэрэг байлаа. Түүний араас монголын бүх цэрэг цувран ирж яваа ажээ. Өгөдэй Аму-Дарья мөрний эрэгт цэргээ амраахаар байрлуулаад хоёр хоносны хойно дайны олзноос олон тооны үнэт бэлгийг авч Хулан хатанд бараалхав. Чингис хааны эзгүйд Өгөдэйн ингэж бараалхсан нь Хуланд өөрийн нууц хүслийг биелүүлэх сайхан боломж ирэв гэж тэр сүүлийн хэдэн жил баярлаагүйгээ байрлаж Өгөдэйд өөрийн санаж бодсоныг ичиж эрээлэлгүй хэлэхээр шийджээ. Өгөдэй түүнд дургүй, бас дээр нь түүний үгийг сонсоод хэрхэхийг таахгүй ч Хуланд зорисон санаанаас ухрах хүсэл үгүй байв.

Удахгүй их хааны сууринд Чингис хаан эцгээ залган суух Өгөдэйтэй ингэж хоёр биеэр тухтай уулзах учрал дахин тохиохгүй гэж Хулан айжээ.

Харин Өгөдэй, хаан эцгийнхээ хатан учир ёсыг даган ирсэн төдий юм. Өгөдэйтэй ийн учруулсан нь анх Тэмүжиний асарт очсонтой утга нэгэн санагдаад Хулан эргэлтгүй зоригжжээ. Тэд Хуланы сэрүүн өргөөнд шөнө дөл болтол ярилцаж, бухар дарс шимж, үүрээр Өгөдэй буцжээ. Үүнээс сар хагасын дараа Чингис хаан Хатан балгасад буцаж ирэхэд Хулан өвчин тусаад хэвтэрт орсон байлаа. Дуу нь цааш орж, турж эцсэн хатнаа Чингис хаан бараг таньсангүй. Харцнаас нь гэрэл цацарч, омог зориг илрэн байдаг Хулан одоо өд шиг сиймийж, өрөвдмөөр яс арьс болжээ. Чингис хаан мэргэч төлөгч бөө нараа цуглуулж даруй Хулан хатнаа аврахыг тушаав. Тэд үзэж мэргэлсний эцэст нэг л зүйлийг санал нэгтгэн илтгэсэн нь Хулан хатан хүний нутаг усны сахиусны хорлол болсон байв. Тэгээд гучин охин, гучин хөвүүнээр тайлга хийхийг зөвлөжээ.

Гэвч Перс гарлын гучин охин, гучин хөвүүнийг алж тахисан ч Хулан илааршиж эдгэсэнгүй. Чингис хааныг ирснээс хойш яг ес дэх хоногийн үүрээр амьсгал хураав. Чингис хаан эхийгээ үхсэнээс ч илүү эмгэнэн гашуудаж их сахлаа ус болтол уйлахыг үзсэн хөвүүд шадруудын элэг эмтэрч гашуудал тайлах ямар зарлиг буулгахыг түгшин хүлээж байв.

-Чингис хаан. Би танд дэмий иржээ. Дайр-Үсэн эцгийгээ ч дэмий алуулжээ. Мэргэд хүний адил танай цэргийн суманд үхэх ёстой байж. Би өөрийгөө бас таныг зовоолоо. Үрийг тань төрүүлж, өвдгийг тань түшүүлж чадсангүй. Бөртэ хатны хэлснээр би мэргэд хүн тул Тэнгэр лав таалсангүй биз. Энэ насанд заяасан цор ганц эр минь Чингис хаан та байв. Би их нэрийг чинь хугалж, эрхэм биеийг чинь хуурсангүй. Ингэж үхэх нь миний муугийнх боллоо гэж шивнэсэн нь Хулан хатны сүүлчийн үг байжээ.

Хулан хатны биенээс сүнс нь зайлан дээш нисэн одохыг Чингис хаан олж харжээ. Хулан гэгч энэ урьхан зантай, турьхан биетэй ч зориг цөс, санаа зорилго их хатандаа ямар их хайртай байснаа Чингис хаан сая сүнснээс хагацсан хүйтэн цогцсыг нь тэвэрч суухдаа л ойлгов. Амьдрал гэдэг зөвхөн ганц дайн тулаан, олз ялалт биш болохыг мэдэрчээ. Түүний сэтгэлийн



талыг энэ бүсгүй эзэлж байжээ. Бие сэтгэл нь өвгөрсний дээр, одоо сэтгэл нь хоосрон эзгүйрэхийг мэдрэв. Энэ удаад өш хонзон биш гашуудал, харамсал төрж үхлийн өмнө хүчгүйдэн мөхөсдөхийн зовлонг эдлэж байлаа. Үхлийн өмнө Чингис хааны нэр сүр, хүч чадал, хөрөнгө зоорь, их цэрэг энэ бүгд хумхийн тоос замхрах лугаа адил юу ч биш болохыг үзэв.

Өүлэн эх болоод сайн нөхдийнхөө үхлийг ёстой юм шиг андуу санаж явжээ. Гэтэл тэднийг үхэл гэгч тэр аймшигт хүч яг Хуланы адил түүнээс булаан авсныг ойлгов. Бас тэр үхэл өөрт нь ч ойрхон сууж, сүүдэр нь юу юугүй толгой дээр нь тусахыг мэдүүт Чингис хаан Хатан балгасаас даруй зугатан гарч Сыр-даръя мөрний их усыг харж байж сая л ухаан оржээ. Үхэл ашгүй түүнийг хөөлгүй ард хоцорчээ. Тэв Тэнгэр одоо дэргэд байсан болоосой гэж Чингис хаан харамсан боджээ. Гэвч өнгөрч одсон цаг хугацааг хэн ч эргүүлэн авчирч чадахгүй ажээ.

Чингис хаан ямар зарлиг буулгахыг хүлээж гурав хоног. Боорчи нар зөвлөлдөөд Хулан хатны шарилыг Хэрлэний хөдөө арал, ихсийн тавьдаг их өтөгт хүргэхээр бэлдэж байжээ. Бас цэргийн тугийг буулгаж их гашуудал зарлав. Чингис хаан гурав хоног хэнтэй ч уулзалгүй өргөөндөө бүгсэний эцэст Боорчи Шихихутаг хоёрыг дуудав. Орвол Чингис хаан халамцуу, бүсгүй нөмгөн, орон дээрээ хагас хэвтэж байлаа. Чингис хаан юу гэж зарлиг буулгахыг тэд хүлцэнгүй хүлээв. Тэдний хэн нь ч зориглон дуу гарсангүй. Ямар ч үед үг хэлэх дархан эрхтэй Боорчи хүртэл зүрхлэн ам нээсэнгүй. Өргөөнд нам гүм. Чингис хааныг халамцуу байхад элдэв үг хэлэх нь ноцтой аюултайг бүгд мэдэх тул ганцхан түүний ам нээхийг тэвчээртэй хүлээн суух ёстой байлаа. Чингис хаан бодолд автсан шиг эсвэл унтаж байх шиг таг чиг. Гагцхүү нүд нь нээлттэй ганц зүг ширтэнэ.

-Хулан хатны сүнс явахгүй энд хоргодсоор байна гэсэн үг хагас өдөр шахам хүлээсний эцэст Чингис хааны амнаас унав. Тэр согтоогүй эрүүл саруул юм шиг дуугарна.

-Хаан таны үгийг бид анхааралтай сонсож байна гэж Боорчи орж ирснээ, хүлээж удсанаа сануулан аяархан дуугарав.

-Боорчи чи юу гэж Чингис хаан шивнээд огт танихгүй хүн үзсэн шиг түүнийг цоо ширтэхэд цочив.

-Боорчи чи сонсож бай. Хулан хатан бүх насаар энэ нутагт суухыг хүссэн юм. Түүнийг нь ёсоор болго. Хулан хатны дэргэд байсан бүх хүнийг энэ балгастай нь хамт үүрд түүнд үлдээгтүн. Газар дээр, тэнгэрийн дор Хулан хатны сэтгэл хорогдох юу ч бүү үлдээ. Бүгдийг галд хайлуулж,

газарт шингээгтүн. Энэ бол Чингис хааны зарлиг байв. Дахин хагас өдөр хүлээсэн ч Чингис хаан дахин үг хэлээгүй тул Боорчи Шихихутаг хоёул чимээгүй гарч хэрхэхийг зөвлөв. Тэдэнд Тэнгэрийн цаазыг зөрчих зүрх нэгэнт үгүй тул Чингис хааны зарлигийг хичээнгүйлэн ёсоор гүйцэтгэв. Хулан хатны хүслийг ёсоор болгон түүнийг Хорезмын энэ нутагт Хатан балгасын хамт үүрд үлдээж юу ч үгүй болтол галдан шатаав. Ингэхдээ Хатан балгасын бүх иргэд, мал амьтан, Хулан хатны албат шивэгчин эмс, харуул манаа нэг ч хүнийг тэр бүү хэл хичнээн уйлж гуйсан ч Ю-Унчиг ч үлдээсэнгүй. Тэр тайган эр Хорезмын энэ балгаст Хулан хатны үхлийн нууцыг хадгалан үхэх ёстой байжээ. Ю-Унчи үхсэнээр Хулан хатны үхлийн нууцыг

ганц Өгөдэй л мэдэх болжээ. Түлэгдсэн, шатсан амьтан хүний дуу бүтэн сар тэнгэрт хадаж, бүгд нурам болон дууссаны хойно үнсийг хамж салхинд хийсгэв. Уулын аманд том хар толбо үлдсэний дээр голын эргийн зүлэг зөөн суулгаж ер байгалиас ургасан мэт болгов. Одоо энд Хулан хатныг дурсуулан санагдуулах юм нэгээхэн ч үлдсэнгүй.

Чингис хаан хоёр сарын дараа Хатан балгасын оронд үлдсэн зүлэг ногоон талбайд ганцаар зогсож байв. Одоо Хулан хатан нь Тэнгэрт гарсанд тэр итгэж байв. Бас хатныхаа хүслийг биелүүлэв хэмээн тайвширч, түүний хойноос дахин гуньж гутрахгүй байхыг өөртөө хатуу тушаав. Мэргэд аймгийн Дайр-Үсэнгийн охин Хуланы амьдрал Хорезмын эзлэгдсэн нутгийн Хатан балгасын хамт угаа болон үнс болон тэнгэр газарт шингэж алга болжээ. Түүний оронд нурж шатсан Хатан балгасын ором дээр шинэ хаврын ногоо урган соёолж байхыг Чингис хаан үзэв. Энэ уулыг Хатан уул гэж нэрлэхийг Чингис хаан зарлиг болгов.

Каспийн тэнгисийн өмнө хойд тал Энэтхэгийн нутгийн морь хүрч болох бүх газрыг Чингис хааны цэргүүд эзлэн авав. Морины үс мулзлам халуун нар,уушиг шатаам бүгчим агаараас өөр монголын морьт цэргийг зогсоох хүч нэгэнт үгүй болжээ. Чингис хаан Хулан хатныхаа үхлийн гунигийг мартаж бүх цэргээ Перваны хөндийд цуглахыг зарлиг болгон элч илгээгээд Багдад руу одсон Чормогон хорчи, Энэтхэг, Багдад хоёрын дунд орших Ару-Мару-Мараары улсын Абту хотыг эзлэхээр явсан Дөрвөдийн Дөрбэй догшин, Умар зүг Каспийн тэнгисээс хойш довтолсон Сүбээдэй баатар, Энэтхэг рүү довтолсон Жалайрын Бала ноёныг эргэж ирэхийг хүлээж суув.

Хойтон жилийн өвөл Сүбээдэй, Зүчийнхээс бусад бүх цэрэг ирж нийлсэн тул нутгийн зүг хөдөлж Ирчэс мөрөнд зусаад Туулын хар шугуй дахь их ордондоо зургаан жилийн дараа ирж буужээ. Одоо Чингис хааны эзэмшил нутаг газар дундын тэнгисээс зүүн далай хүртэл үргэлжлэх болов. Туулын хойд эрэг дээр Чингис хааны их хүрээ байрлаж ялалт олзоо дааж ядсан цэргүүдийг тал нутаг даяар дуу хуур болон угтан авчээ. Хулан хатны үхлийн тухай мэдээ аль эрт энд хүрч одоо бараг мартагдах дөхсөн байв. Учир нь мэргэд аймаг сөнөж, Хуланы эцэг болоод удам угсаа нь арилсан тул түүнийг үнэн сэтгэлээс дурсан санах хүн ховор болжээ. Хуланы гунигт түүхийг Чингис хаан л мартаж чадахгүй байв. Учир нь Хулан ганцхан Чингис хааны сэтгэлд оршиж үлджээ. Хулан хатны өргөөг яг хэвээр бариастай хүлээж байсанд Чингис хаан хатныхаа өргөөнд орж удаан ганцаар суув.

Гэхдээ тэр гуниж гутарсангүй. Маргааш нь Чингис хааны зарлигаар Хулан хатны өргөөг буулгаж нүднээс далд аваачиж шатаасан билээ. Мэргэдийн зоригт бүсгүй Хуланы түүх энэ утаатай хамт замхран дуусав гэж Чингис хаан боджээ. Гэвч тэр хол эндүүрсэн байлаа.

# ДОЛООДУГААР БҮЛЭГ

## ЗҮЧИ

### *САМАРКАНДАД ДЭГДСЭН ТҮЙМЭР*

Лалын шашинтны нэгдсэн их улс Хорезмын хуучин нийслэл Ургенч бол үнэхээр алдартай хот билээ. Хорезмын их улс хүчирхэгжиж мандахын өмнө Ургенч хот Хорезм нэртэй байв. Нэгдсэн их улс нь энэ хотын нэрийг авснаас хойш Ургенч нэртэй болжээ. Ургенч нь Арал тэнгисийн өмнө талд Аму-Даръя мөрний эрэгт орших бүлгээ. Ургенчийг хосгүй үзэсгэлэнтэй ховор цэцгэсийн хот гэж олон газрын аянчин гийчид шагшин магтах ажээ. Хорезмын шинэ нийслэл Самарканд Чингис хааны цэргийн хөлд сүйрч, ойр хавийн хот балгас бүгд эзлэгдэхэд Ургенч хот эсэргүүцэл тэмцлийн ганц тулгуур болж торойн хоцров. Хорезмын энэ гайхамшигт хот түүний хавь орчмын нутгийг Чингис хаан Зүчи хөвүүндээ өгсөн байв.

Чухам ингэж шилдэг нутаг үзэсгэлэнт хотыг сонгон авч Зүчид өмчлүүлэн өгөх зарлиг буулгасан нь Чингис хаан цаанаа олон давхар ухаан бодол агуулсных юм. Эзлэн авсан газар орон өргөжин тэлж цэргийн хүч нэмэгдэхийн хэрээр хийж гүйцээх олон олон шинэ ажил зорилго нэмэгдэх ажээ. Эдгээрийн дотроос Зүчи хөвүүний тухай бодол санаа сэтгэлээс нь салахгүй болжээ. Хорезмыг эзлэх их тулааны цус, дуулиан дунд эрхгүй дарагдан намжаад байсан Зүчи Цагадай хоёрын дундах зөрчил цэрэг дайны үл ялих хэрэг дээрээс улам хурц тод илрэх болсныг Чингис хаан анзаарахгүй байхын аргагүй болжээ.

Тэдний бие биеэс илүү гарах хүсэл хэн хэндээ үл захирагдах үзэл зөрчил нь Самаркандыг эзлэн авахад бүр ч тод илэрч энгийн олон цэргийн амийг дэмий үрэхэд хүргэв. Ингэж цөөн монгол цэрэг олноор эрсдэх болсныг яавч зүгээр өнгөрөөж болохгүй байлаа. Хөвүүд нь нэг замын цэрэгт багтан нэгдсэн дайралт, тулаан хийх чадваргүй болох нь илт болжээ. Энэ бол ялалтын сүр хүчийг алдруулж, цэрэг ардын итгэлийг сулруулах аюултай тул Чингис хаан зарлиг болгон Ургенч хавийн газар нутгийг Зүчид хуваан өгсөн нь энэ билээ. Хөвүүдээ аль болох хол, тус тусад нь явуулах нь зөв гэж тэр үзэж байв.

Өгөдэйг их хааны орыг залгамжлуулахаар сонгосноос хойш Зүчи болоод Цагадайн зан үйлд нэгэн тод өөрчлөлт орж байгааг шадрууд нь илтгэх болжээ. Энэ бол тэдний эцгээсээ тусгаарлан бие даах гэсэн эрмэлзэл байлаа. Нэгэнт хаан суудал Өгөдэйнх болсон нь тэднийг ийм алхам руу түлхэж урьд нь эцгийн хавсрага болж их ялалтын бат суурь болж явсан тэд одоо их бага ч болов өөрийн эзэмшил нутаг, улсаа байгуулах нууц хүсэлд автсаныг Чингис хаан тов тод ойлгож мэджээ. Чингис хаан эцгийнхээ орыг залгамжлан Их монгол улсын хаан суух гэсэн Цагадай хөвүүнийхээ хүслийг буруутгах аргагүй юм. Гэвч Өгөдэйг хаан ор залгамжлуулахаар шийдсэнээ Тэнгэрийн зарлиг гэж Чингис хаан үзэж байсан тул Цагадайн тухай нэг их санаа зовсонгүй билээ. Тийм ч учраас Зүчи Цагадай хоёрт шинээр эзлэн авсан Хорезмын газар нутгийг хуваан эзэмшүүлэх нь зөв гэж шийдэв. Энэ нь тэдний зорилго тэмцлийг хурцлан зоригжуулах биз гэж Чингис хаан найджээ.

Чингис хаан эцгийнхээ энэ шийдвэрт Зүчи туйлын баяртай байлаа. Өөрийн тусгаар улсыг

байгуулан суух нь Зүчийн ганц далд хүсэл мөрөөдөл болоод байв. Бас сэтгэлийн гүн дэх арилшгүй гомдол, гүнзгий харууслаа тайлах ганц арга нь ч энэ юм. Өөрийн тусгаар улсыг байгуулж хэнээс ч хараат бус суухаар Зүчи хатуу шийдсэн байлаа. Тэр ингэж эргэлт буцалтгүй хатуу чангаар зориглон шийдсэн нь Өгөдэйг хаан суурь залгамжлуулахаар сонгоход болсон хэрүүлийн дараа юм. Тэр өдрийг хүртэл хэрхэн хууртаж хий хоосон зэрэглээн дунд амьдарч байснаа Зүчи тэгэхэд яс махандаа шингэж, ой тойндоо ортол мэдэрч гашуунаар харамсан уйлж билээ.

Чингис хааны өргөөнд болсон их зөвлөгөөн өндөрлөж Өгөдэйг хаан сууринд залгамжлуулан суулгахаар зарлиг буулгасан нь Зүчийн сэтгэлийн дотор бугшин хуримтлагдсан олон зөрчил гомдлыг зад татаж илд сэлэм, ирт мэсний эдгэршгүй ил шарх мэт шаналган түүний дөч шахам жилийн үйлт амьдралын бүх зорилго утгыг сарниулан хаяжээ. Чингис хааны хүрээнээс хөдөлж Сэлэнгэ мөрний баруун цутгалан Идэрийн голын хөвөөнд байх өөрийн хүрээ рүү мордохдоо хэрэг болгож Бөртэ эхтэйгээ ч уулзсангүй нь түүний сэтгэлийн зовлон хямрал хичнээн гүнзгий болсныг илтгэнэ. Тэр хэзээ ч ингэж эхдээ хайр халамжгүй хандаж байгаагүй бөгөөд чухам ингэсэн нь бүх болсон хэргийн учирт эхийгээ буруутган бодсоных байв. Их улсын бүх ихэс дээдсийн өмнө “Мэргэдийн орхидос” хэмээгдэн гутаан доромжлогдож олон бүгдээр үүнийг илт хүлээн зөвшөөрч байсан төдийгүй бүр Чингис хаан, Цагадайн гашуун үгийг сонсоод огт хилэгнэсэнгүйгээр барахгүй харин битүү дэмжиж зөөлнөөр хандан

-Үүнээс хойш Зүчийг ингэж бүү ад үз гэсэн төдий үг хэлсэн нь Зүчийн уур хилэнг хамгаас ихээр оволзуулжээ. Энэ нь Чингис хаан түүнийг өөрийн алтан ургийг дагасан золбин нохой мэт үзэж буй хэрэг гэж Зүчи гомдон гутарчээ. Маргаангүй үнэн болж батлагдсан, бүр олны өмнө ил зарлагдсан, Чингис хаан хүлээн зөвшөөрсөн мэргэд гарал нь Зүчийг, түүний үр хүүхдийг хэзээ ч алтан урагт багтаан тооцож үзэхгүй гэдгийг нь тодруулж бас Зүчийн удам хэзээ ч их хаанд өргөмжлөгдөх эрхгүйг үнэхээр тодорхой болгож өгчээ. Ийм хэрэг болохыг Зүчи бодоогүй биш бодсон юм. Тийм ч учраас хаан орыг залгамжлан суух итгэл хүсэл Зүчид угаас хүчтэй байсангүй. Цагадайтай өрсөлдөн тэмцэлдэхгүй байхыг Бөртэ эх нь хар багаас нь хатуу сурган хүмүүжүүлсэн билээ. Хайртай Бөртэ эхийнхээ сэтгэлийг бодоод тэр Цагадайг өргөмжлөхөд огт татгалзахгүй гэдгээ эхдээ амласан байв.

Цагадайг хаан сууринд өргөмжлөхгүйн тулд Зүчийн нэр нүүрийг нэг мөсөн барж, үнэн хэрэгтээ түүнийг золиослож байж Өгөдэйг өргөмжлөхөөр Чингис хаан шийдсэнд Зүчи ингэж ихээр гомдож хорссон байжээ. Зүчийг хаан сууринд өргөмжлөхгүйн тулд Цагадай өөрөө ч хаан сууринаас татгалзах болно гэдгийг Чингис хаан тооцжээ. Чухам Цагадайн амаар Өгөдэйг өргөмжлүүлэх нь Чингис хааны зорилго байсныг Зүчи ойлгов. Тэнэг Цагадай Чингис хааны хаясан өөшинд хууртан Зүчийн нэрийг сонссон даруйд оволзон уурлаад өөрийгөө ч түүнийг ч баллаж орхижээ. Чингис хаан чухам ингэхийг л хүлээж байжээ. Ийм замыг сонгон авсан нь Чингис хаан түүнийг хар ялаанаас дорд үзсэний баталгаа гэж Зүчи итгэсэн нь түүний гомдол хорслын эх болов. Энэ бүх гүнзгий гомдол хорслын дунд хамгийн анхлан төрсөн бодол нь эхийгээ үзэн ядах сэтгэл байв. Ийм гашуун доромжлол амссанд орвол ерөөс ертөнцөд хүн болж төрөөгүй нь шулуун мэт. Төрөхөд минь хаяж орхихгүй яав гэж Зүчи гутран бодож явлаа. Ийм бодолд түүртэн автсаны улмаас эхийнхээ гэрт оролгүй өөрийн хүрээг зорисон билээ. Гэвч энэ нь үйлийн үрээс зугатаах гэсэн гэнэн оролдлого

төдий болохыг зам зууртаа ойлгов. Түр зуурын хямрал сэтгэлийн хөөрөл уур бухимдал нь морины явдал дунд дарагдахад

-Одоо яах вэ гэсэн ганцхан асуулт сэтгэлд нь эргэлдэж байлаа. Түүнд одоо Чингис хааныг дагахаас өөр ямарч амьдрал зорилго байсангүй. Бас хайрлаж өсгөсөн эхийгээ яав ч гомдоон орхиж болохгүйг ухаарчээ. Чингис хааны их хүрээнээс мордсон цагаас хойш дэргэд нь сүүдэр шиг дагаж эцгийнхээ шаналант царайг цогтой хар нүдээр гярхай ажиглаж явсан арван нэгэн настай Бат хөвүүний нь шивнэн хэлсэн ганц үг түүний нүдийг нээж зүрхийг амилуулах шиг болжээ. Тэр үед Зүчийн баг цэрэг Туул голыг гаталж амарч хонохоор буугаад байжээ. Хээрийн хөнгөн асрын дор Зүчи тэрийн хэвгэж унтах ч биш, зүүдлэх ч бишийн дунд хөвөрсөн бодолд умбажээ. Шөнө дунд өнгөрч бие чилсэн тул өндийн үзвэл гадаа галын дэргэд Бат хөвүүн нь шөнийн хэвтүүл манаа шиг ганцаар торойн гүн бодолд автан суухыг харжээ. Хөвүүнийхээ энэ эмэгнэлт төрөхийг үзмэгц гэнэт гол нь харлан өрөвджээ. Нялх балчир хөвүүнийхээ сэтгэлийн доторхи хямрал эгдүүцлийг Зүчи зөнгөөрөө мэдээд уяран нулимс урсгав. Гашуудалт сэтгэлийн нь ганц гэрэл гэгээ ирээдүйн итгэл нь энэ хөвүүн мөн болохыг аянга цахилгаан гялбан нүргэх шиг хормын дотор ухааран ойлгомогц ухасхийн босч очоод Батын толгойг энгэртээ нааж ичиж зовох юмгүй мэгшин уйлжээ. Хатуу чанга зоригтой, баатар эрсийн манлай, олны үлгэр дууриал болсон эцэг нь ийн хүүхэд адил гомдон уйлахыг үзээд Бат хэргийн цаад учрыг тодорхой сайн мэдэхгүй ч хоёр нударгаа тас зангидан олон үгт Цагадай авгаа үзэн ядаж өш авах халуун хүсэлд шатаж суужээ. Зүчийн ганц тайтгарал Бат хөвүүн нь болов. Зүчийн нулимст нүд харанхуйд гал мэт шатаж

-Хөвүүн минь, Бат минь сонс. Эцэг чинь их хаан нэр зүүх хувьгүй төржээ. Харин чи бүү осолд. Эцгийн олоогүй нэрийг хөвүүн чи бүү алд. Чамайг их хаан болохгүй бол миний сүнс ч амрахгүй гэж мэд гэж занал хорсол дүүрэн шивэгнэжээ.

Энэ бол Зүчийн гэрээслэл мэт үг байсан юм. Бат ч эцгийн үгний эцсийн үнэ цэнийг үзэж сонссон хэмжээндээ сэтгэлийнхээ хирээр ойлгоно. Харин ч эцгийн итгэлийг дааж их хэргийг гүйцэлдүүлэх хатуу хүсэлд бяцхан зүрх нь хагарах шахан цохилж байв.

-Та бүү санаагаа зовоо. Би таны үгийг осолдохгүй дагана. Би их хаан болно.

Бат хөвүүний нулимс цийлэлзсэн гэрэлт хар нүд өөрийнх нь үгний баталгаа болон гялалзахыг Зүчи үзээд сэтгэл уужирчээ. Алтан улсад гарсан үймээн самууныг дарахаар явсан Сүбээдэй баатрын хамт жил болоод ирсэн Бат хэдий нялх балчирч энэ байтугайг хэлж хийх хүсэл, чадвар дүүрэн болсон билээ. Батын эцгээсээ дутахгүй эрэмгий баатар болох шинж нь хар багаас тодорсон байв. Зүчи, Бат хөвүүнээ элгэндээ тэврээд үүр цайтал суусан билээ. Харин боол Тату, эцэг хүү хоёрын тав тухыг алдагдуулахгүйн тулд холд модны дор сууж хоножээ. Эцэг хүү хоёр эзнийхээ сэтгэлийн хямралыг Тату хэнээс ч илүү ойлгодог байв.

Их зөвлөгөөн дээр хаан хөвүүдийн хооронд болсон хэрүүл шуугианы дуулиан хүрээ даяар тарснаас болоод Бөртийн сэтгэл хямарчээ. Гэтэл Зүчи хөвүүн нь түүнтэй уулзалгүй зугатах мэт одсоныг сонсоод Бөртэ үхэл үзсэн юм шиг царай зэвхийн, зүрх нь түгшин ихэд шаналж бүр хэвтэрт оржээ. Зүчийн ингэсэн нь аймшигт аюулын дохио мэт санагдана. Энэ бол Бөртийн өдий болтол туулж өнгөрүүлсэн амьдралдаа хүлээж байсан хамгийн аймшигт мөч байлаа. Нэр нүүр бүтэн аз жаргалтай амьдралд нь нуугдан байсан далд зөрчил ганц хормын

дотор ийнхүү задран гарчээ. Бөртгийн бие сэтгэлээрээ хамгаалан өсгөсөн хөвүүн нь өөрөөс нь зугатан оджээ. Бүх юм Бөртгийн санасны эсрэг болов.

Чингис хаан түүний хэлснээр өөрийн ууган хөвүүн Цагадайг биш Өгөдэйг өргөмжилсөн нь Бөртгийн шаналалыг даруй хоёр дахин нэмэгдүүлэн цочроосон нь өвчин хөдлөхийг түргэтгэв. Одоо Бөртэ хөвүүдээ хоорондоо тэрсэлдэн тэмцэлдэхээс түгшин айжээ. Эцгийн хойно хаан сууринд суух нь яах аргагүй Цагадай юм. Бөртэ үүнийг хүсч байв. Гэтэл Чингис хаан зөвшөөрсөн мэт байтлаа гэнэт өөрөөс нь далд зөвлөгөөн хийж Өгөдэйг өргөмжилсөн нь, бас тэр хурсан олны өмнө Цагадай илэрхий дээрэнгүй доромжлох үг Зүчид хэлсэн нь Бөртгийг энэ мөчид үхэхээс өөр мэхгүй мэт болгов. Зүчи бол тэртээ тэргүй хаан удмыг залгамжлах ёсгүй гэж Бөртэ үзэж байсан тул түүнд тэгтлээ санаа зовоогүй билээ. Тийм ч учраас

-Чингис хаан эцэг чинь юу гэнэ. Чи түүнийг л хийх ёстой. Чингис хаан чиний амийг соёрхон өгсөн юм. Чи хэзээ Чингис хаан үх гэнэ. Тэр үед нь өчиггүй үхэх хэрэгтэй гэж хатуу чангаар сургаж хүмүүжүүлсэн тул Зүчид эргэлтгүй итгэж байжээ. Гэтэл сүүлийн хэдэн жил хэн ч сөхөж хэлээгүй, тэр бүү хэл Цагадай өөрөө ч мартсан мэт тайвширсан тэр явдлыг ихэс дээдсийн өмнө төрийн зөвлөгөөн дээр гарган дурдаж Зүчийн мэргэд гаралтайгаар нь гутаан доромжилсон Цагадайн болчимгүй занг Бөртэ өршөөж чадахгүй байлаа. Ингэж түргэн гоомой хэлсэн үгнийхээ золиосонд тэр өөрөө ч хаан суудал залгамжлах эрхээ алджээ. Хэвтэрт байх тэр үедээ Цагадайг дуудан ирүүлж, уйлж загнав. Цагадай тэртээ тэргүй гэмшиж гутрах нь хэмжээгүй байгааг үзээд Бөртэ хөвүүнээ өрөвдөн хэлэхээр зэхсэн хатуу үгээ татжээ. Цагадайн догшин сүрлэг овор дарагдаад сүнс сүлд нь зайлсан мэт царай алджээ. Гэвч гомдолт харцны нь гүнд аймшигт хонзон нуугдахыг Бөртэ олж харав. Тээж төрүүлж тэвэрч өсгөсөн үрийнхээ сэтгэлийг эх нь биш бол өөр хэн мэдэх билээ.

Их эрх мэдэл, эзэн хааны суудал голоо тасалж төрүүлсэн хайртай хөвүүдийг нь хэрхэн дайсан болгож өөрчлөн хөнөөхийг өнөө Бөртэ өөрийн нүдээр үзэж байв. Эцгийн суурийг залган их хаан суухын тулд хичээж чармайхыг хичнээн удаа Цагадайд зөвлөж сургаж

-Зүчи ах чинь чамд хэзээ ч саад тотгор болохгүй. Чи эхдээ итгэ. Хаан эцгээ залгамжлах ганц хүн бол чи юм. Хүү минь хичээ гэж хэлснээ санахад Бөртэ одоо Цагадай хөвүүнийхээ өмнө өөрөө ялд унасан мэт санагдана. Цагадайг өргөмжлөхийг Чингис хаан зөвшөөрсөн мэт байсан тул Бөртэ бат итгэсэн билээ. Их итгэл хөсөрдөхөд түүний оронд хорсол гомдол үлддэгийг тэр голдоо ортол мэдэрч байлаа. Гэвч одоо эх хүү хоёр юуг ч өөрчлөн хувиргаж чадахгүй болжээ.

-Чи ганц хором тэвчиж Өгөдэйн нэрийг дурдахгүй өнгөрч чадсангүй юу гэж шивнэхдээ Бөртэ, Өгөдэйг адилхан л өөрийн хөвүүн мэт санахгүй байв.

-Мэдэхгүй, ижээ.. нэг л мэдэхэд ийм явдал болжээ. Би ижий таны захиж сургаснаар явж чадсангүй. Өршөө.

Цагадайн энэ үг туйлгүй их гэмшил харамсал хийгээд сэтгэлийн шаналал дүүрэн сонсогдоно.

-Нааш ир хүү минь.

Цагадайн гучин долооны жил орж байгааг хөвүүнийхээ энхрий үнэр нь арилаагүй толгойг элгэндээ тэврэхдээ Бөртэ санав.

-Хүү минь жил чинь орж байгаа. Болгоомжтой явж үз.

-За ижээ.

Цагадай бол Бөртийн дөрвөн хөвүүд дотроос эхдээ хамгийн их эрхэлж өссөн нь билээ.

-Хаан эцэгтээ бүү гомд. Улам хичээж зүтгэ. Би Зүчи ахад чинь санаа их зовно. Чи бол эцэгтэй хүн. Харин Зүчи ахад чинь надаас өөр хэн ч байхгүй юм. Чи үүнийг үргэлж санаж яв.

-За, ижээ

Догшин түрэмгий, хурц халуун зантай Цагадай хэзээ ч ийм дуулгавартай зөөлөн байсангүй. Чингис хааны гаргасан зарлигийг эргүүлэн өөрчилж чадах ганц хүн, эцсийн найдлага бол эх нь гэдгийг Цагадай мэдэх учир ийм торго мэт аашилж байжээ. Харин Бөртэ хөвүүнээ алдаандаа гэмшиж ухаарч байна гэж уярч ямар ч болов Чингис хаантай энэ тухай эвтэй цаг олж ярина гэж бодож хэвтсэн билээ. Гэвч энэ бол санаа мухардсан эм хүний дэмий бодол төдий юм. Одоо Бөртэ үггүй мордсон Зүчи хөвүүндээ илүүтэй ихээр санаа зовж байв.

Харин Бөртэ болоод бусад бүх хүнийг гайхуулсан нэг хэрэг маргааш өглөө нь болов. Гэнэт одсон Зүчи Бөртийн өргөөний гаднах уяан дээр давхин ирж буусанд бүгд цочин түгшжээ. Олны өмнө ил тодоор “Мэргэдийн орхидос” гэж доромжлогдсон Зүчи яаж ч мэднэ гэсэн түгшүүр айдас бүгдэд төрөв. Ингэх нь ч аргагүй байв. Яаж ч нууж хаасан Зүчи Цагадай нарын хэрүүлийн дуулиан аль эрт Чингис хааны хүрээнээс халин гарч сониуч хүмүүсийн хэл чихний зугаа болжээ. Хүний мууд дуртай зарим нь энэ хэрүүлийн дараа цус үхэл гарахыг зөгнөн хүлээж суусан ч байж мэднэ. Зүчи болоод Цагадайн зан ааш ингэхгүй гэхийн аргагүй. Их аадрын өмнөх шиг түгшүүрт нам гүм эргэн тойрныг эзэлж Зүчийн гэнэт эргэн ирсэн мэдээ Чингис хааны өргөөнд тэр даруй хүрчээ. Энэ үед Чингис хаан Боорчи, Мухулай, Зэлмэ, Хасар, Сүбээдэй, Зэв нарын хамт Хорезмд мордохын өмнө Алтан улсыг хэрхэх тухай зөвлөж суужээ. Хэрүүлийн дараа Чингис хаан хөвүүдээ сэлэм сугалан цусаа урсгах вий гэж үнэндээ эмээж ийм явдал хэрхэвч гаргуулж болохгүйг Боорчи Мухулай хоёрт хатуу тушаажээ. Гэтэл огт санаагүй хэрэг болж Зүчи шууд гэрийн зүг буцсан билээ. Харин Зүчи гэнэт эргэн иржээ. Замын дундаас яах гэж эргэн ирснийг, ирээд шууд эхийнхээ өргөөнд орсны учрыг тэр дор нь таахад бэрх байлаа. Тийм ч учраас Чингис хаан чухал зөвлөгөөнөө шууд таслан Боорчийг явуулж учрыг мэдэхийг даалгав. Ингэх нь зөв байв. Боорчи бол Зүчийн хэргийг төрөхөөс нь эхлээд Чингис хааны өмнө хариуцсан хүн юм. Хоёулханаа үед Зүчийн талаар үг хэлэх бүрдээ

-Боорчи. Чи миний зарлигийг зөрчиж Зүчийг амьд үлдээсэн хүн гэж заавал дурсан хэлдэг билээ. Боорчи ч үүнийг ойлгоно. Ингэж хэлэхдээ Чингис хаан зэмлэн буруушаах өнгө ер үзүүлдэггүй юм. Харин энэ удаа олны дэргэд зүгээр л

-Боорчи чи очиж үз гэжээ.

Чингис хаан Боорчи хоёрын хооронд байх Зүчийн тухай эл нууцыг Бөртэ Зүчи хоёр мөн л өөрсдийнхөөрөө ойлгох ажээ. Бөртэ ч Зүчи ч Боорчид их дотно сайхан хандана. Ухаан орсон цагаас Зүчи үргэлж л Боорчийн асрамж халамжид явжээ. Бас Боорчи бол Сүбээдэй баатрын нэгэн адил Зүчийн байлдах дайтах, цэрэг засах эрдмийн багш нь байв. Тиймээс ч Зүчи, Боорчийг Чингис хаан эцгийнхээ дараагаар үзэж хүндэтгэнэ. Үүнийг мэдэх учраас Чингис хаан Боорчийг Зүчийн болох болохгүй үг, үйлдлээс сэргийлэх гэж яаралтай явуулжээ. Боорчийг гарахад торгон цэргүүд өргөөг тойрон зогсоод хүлээж байв. Торгон цэргийн мянгатын ноён Үүлэн-Чэрби Зүчийн бараанаар сэрэмжлэн цэргээ зассан нь энэ юм. Ингэж хэт болгоомжлон сүр үзүүлэх нь гомдсон Зүчид яавч аятай санагдахгүй гэж Боорчи бодоод торгон цэргүүдийг байранд нь буцааж өдрийн хишигтэн цэргийг ердийн журмаар үлдээхийг тушаажээ. Зүчийн сэтгэлийн гомдлыг сэдрээх өчүүхэн ч сэжиг хар үүсгэж болохгүйг Боорчи ойлгоно. Зүчи юу ч боллоо гэсэн эцгийнхээ эсрэг хэрүүл зарга үүсгэх хүн биш гэдгийг Боорчи мэдэж байв. Эхийнхээ хэвтэрт орсныг үзээд Зүчи их сандрав. Ингэнэ гэж санаагүй тул хэл сураггүй явснаас нь болов гэж өөрийгөө буруутгав. Харин Бөртэ Зүчи хөвүүндээ юу гэж хэлэх үгээ олохгүй байв. Зүчи эхийгээ үзээд сэтгэл хямарч хар цагаан таг дуугүй суусаар байжээ. Харин Бөртэ дотроо онгойтол уйлж авчээ.

-Хүү минь. Чи надаас болж ийм зовлон доромжлол амсах болжээ. Болсон хэрэгт ганцхан эхийгээ л буруутгаж, гомд. Өөр хэнд ч хар буруу бүү сана. Чингис хаан эцэгтээ, Цагадай дүүдээ муу санахыг чинь би хориглож байна гэж эх нь халуун нулимсаа асгаруулан хэлэхэд эхийнхээ хатан зоригийг мэдсэн Зүчи зүйрлэшгүй ихээр уярч гэмшжээ. Эхийнхээ юунд санаа нь зовж байгааг Зүчи сайн ойлгож байв. Төрүүлсэн хөвүүд нь хэрүүл тэмцэл хийж алалдахаас л айж буй. Эхийгээ тайвшруулан амирлуулах нь чухал байсан тул хэлэх үгээ сайтар бодож олов.

-Ижий минь. Та амар бай. Би хэзээд таны хэлснийг мартажгүй санаж явах юм. Би Чингис хаан эцгийн зарлигийг ёсчлон дагах болно. Та тайван байж биеэ бод гэжээ. Бөртэ Зүчийн үгийг үнэмшиж итгээд уяран уйлжээ. Тийм ээ. Түүний Зүчи хөвүүн эхийнхээ үгнээс гажиж зөрсөн удаа үгүй билээ. Зүчи бол эхийнхээ үг, ухаанаар ярьж сэтгэж хүмүүжсэн хүн юм. Гэвч энэ удаа Зүчи хөвүүн нь нэгийг хэлж нөгөөг бодож байгааг Бөртэ даанч мэдсэнгүй. Өгөдэйг хаан сууринд залгамжлуулахаар сонгож, Зүчийг мэргэдийн цустайг олонд тунхагласан хэрүүлээс хойш өнгөрсөн хоёр хоногт дуулгавартай ухаантай Зүчи хөвүүн нь нэгэнт огт өөр хүн болон хувирсныг Бөртэ таамагласангүй. Зүчи ч дотоод санаагаа сайтар нууж хуучин хэв төрхөө үзүүлнэ. Энэ амьдрал, хөвүүдийнхээ бодол хүслийг нэгэнт таамаглан мэдэхээс өнгөрч, хөвүүд нь эхийн мэдлээс үүрд салж одсоныг Бөртэ мэдэхгүй, мэдэх ч аргагүй ажээ. Ер бүх эх хүн Бөртийн адил юм. Эх хүн бүр төрүүлсэн үрээ өвгөн болсон ч нялх гэж санасаар байдаг биз. Харин үрс нь өөр өөрийн хүсэл зоригийг даган үүрээ орхих шувуу адил тарж одох бүлгээ. Бөртэ яг л ингэж эрийн цээнд хүрч эрдэм чадал нь жагссан хөвүүдээ эгээ л эмзэг нялх шиг санасаар байв.

Хэдийгээр Зүчи Цагадай нарын хэрүүл Боорчийн хүссэнээр элдэв хэл амгүй намжих шиг болсон ч уршиг нь хуурай хөвдөнд алдсан түймэр шиг битүү дотуур уугин ассаар байгааг Чингис хаан тааварлаж байлаа. Энэ түймэр хаана хэзээ илэрч дүрэлзэн асахыг таахын аргагүй ажээ. Буцаж ирсэн даруйдаа Зүчи хөвүүн нь бараалхах зөвшөөрөл хүссэн нь Чингис хааныг ихэд түгшээв. Ер ингэж ёсорхдоггүй байсан Зүчи харц албат, харийн элч мэт



зөвшөөрөл эрсэн нь тэр өөрийгөө нэгэнт Чингис хаанд хамаагүй хүн мэт үзэж буйгаа илэрхийлж, бас ингэж үзэж байгааг эсэргүүцэж байгаа юм шиг санагдана. Зүчийн бараалхах гэснийг Боорчи түүнд уламжилжээ.

-Чамд юу гэж хэлэв хэмээн Чингис хаан Боорчийг юу гэж хариулахыг мэдсээр атал дэмий асуув. Ингэж илүү сул үг хэлсэн нь Чингис хааны ухаан мухардан сандарсныг илтгэнэ.

-Тэр хөвүүн надад юу ч тодорхойлон хэлсэнгүй гэж Боорчи өчив.

-Зүчи юу гэж сэтгэв гэсэн Чингис хааны үгийг Боорчи хариугүй орхив. Тэр үнэхээр Зүчийн юу хүссэнийг таамаглаж чадсангүй. Хариу дуугараагүйд нь Чингис хаан хилэгнэсэнгүй. Үнэхээр юу гэхийг хэн ч таасангүй. Зүчи ер нь ингэж албархаж байсан удаагүй учир энэ явдал Боорчид ч гэсэн хачирхалтай байв.

-Хаан та Зүчийг балчир хүүхэд шиг бүү бод. Бас балмад дайсан шиг ч бүү сана. Зүчи бол Бөртэ хатны амин үр нь юм. Бас хаан таны харвасан сум шиг хавтай жанжин юм. Та ингэж бодогтун. Та илүүг сэтгэж ихийг бүү таамаглан өөрийгөө бүү зовоо. Зүчи хэзээ ч хаан эцгийнхээ эсрэг хар санахгүй. Би үүнийг батлана. Бас Бөртэ эх нь ч батлах биз.

Боорчийн энэ ухаант үг бас дээр нь Бөртийг дуртган хэлсэн нь Чингис хааныг эргэлзээг арилгаж ээдсэн сэтгэлийг амирлуулав. Боорчи хэрэгтэй үгийг яг цагт нь олж хэлжээ. Хэрэв Боорчи үгүй байсан бол Чингис хаанд Зүчи өөрийг нь хорлох гэж буй мэт сэжиг төрөөд бараалхуулахгүйгээр буцаах, бүр алахад ч бэлэн байв. Гэвч Боорчийн үгийг ухаарч Зүчийг бараалхуулах зарлиг буулгав.

Зүчийг босго давмагц Боорчи урьд нь ярилцаж тохирсон мэт үг дуугүй гарч одсон нь Чингис хааныг дахиад л хар сэжигт унагаж хилэгнэхэд хүргэв. Гэвч нэгэнт нүүр тулсан тул ухрах булзах арга олсонгүй. Чингис хаан Зүчийг ад шоо үзсэн биш харин анх удаа айж сэрдсэн сэтгэлээр угтав. Хар багаас огт хувираагүй үлдсэн Зүчийн тод цэлмэг харц өнөө ч өөдөөс нь илэн далангүй итгэл төгс ширтэж байх ажээ. Олон жилийн өмнө хорин таван настай идэр Зүчи яг ингэж ширтэн суугаад Ойн иргэдийг дайлан хураах цэргийг удирдуулахыг хүссэн билээ. Тэр үед Зүчи дээрх үгийг Бөртэ эхийнхээ зааж шаардсанаар хэлсэн билээ. Зүчийн хүсэл гэхээс илүү Бөртийн энэ шаардлагыг Чингис хаан тэгэхэд эргэлзэхгүйгээр хүлээн авч Зүчид цэрэг захируулан Хөвсгөл нуур, Шишгид гол руу хөдөлгөсөн юм. Зүчи эцэг эхийн итгэл сэтгэлийг алдалгүй бахархалтай явж ойн иргэд олныг бүр Эрчис мөрөн, Байгаль нуурын орчмын газар нутгийг эзлэн авч эцгийн улсын хаяаг тэлжээ. Энэ үед Зүчийн цэрэг байлдааны эрдэм, бусдыг дагуулах чадал од мэт гялалзан тодорч олныг бишрүүлсэн билээ.

Одоо Чингис хааны өмнө хорин тавтай идэр залуу биш, дөч дөхөж, дөрвөн улсыг дайлах тулаанд оролцсон их жанжин Зүчи сууж байв. Сэлэм эргүүлж гардан туллаа ч Чингис хаанд үл дийлдэх баатар эр болжээ. Чингис хаан өөрийн хардсан муу бодолд хэтэрхий автсанаас болж эхлээд хэлэх үгээ олохгүй сандарчээ. Зүчийн сэтгэл хөдөлж байгааг бас хэлэх гээд үгээ онож бодож чадахгүй сул дэл үг ярьж суугааг Чингис хаан мэдэв. Ийм үед өөрөө түрүүлж учиртай үгийг хэлж уймарсан сэтгэлийг нь өөрийн зүгт дагуулан авах нь зөв гэж сэтгэв. Үүний тулд идээ будаа, архи айраг сөгнүүлж өөрт бодох зав олохыг хичээсэн нь оножээ. Зүчи хаан эцгийн хүндлэлд сатаарч бас баярлаж байгаа нь илт. Чингис хаанд одоо үгээ хэлэх цаг

ирэв.

-Зүчи минь. Хүү минь

Чингис хаан ингэж хэлээд хэсэг дуугүй суув. Энэ нь өөрийн хэлсэн дээрх хоёр үг Зүчид яаж нөлөөлөхийг хүлээсэн хэрэг юм. Ийн дотно, эерүү зөөлөн хэлсэн

-Хүү минь гэсэн үг Зүчийн хатан зүрхийг ингэж уяраан догдлуулна гэж Чингис хаан бүү хэл Зүчи ч өөрөө таамагласангүй. Гомдсон сэтгэлийн хэлхээс алдарч Зүчийн зүрх жаргалтай догдлон цохилж нүүр нь улайв. Өөрийнх нь бодож хэлсэн үг Зүчийн зүрхийг онож тэдний хооронд байсан эргэлзээ сэжгийг арчин хаяхыг Чингис хаан мэдэж бас энэ үгэндээ өөрөө багагүй догдлон уярахаа анзаарчээ. Үүнд Чингис хаан ихэд гайхав. Гэвч гайхаж суух цаг биш тул бодсон үгээ үргэлжлүүлэв.

-Хүү минь. Чи одоо Их Монгол улсын алдартай жанжин болжээ. Хийсэн дайн байгуулсан ялалт чинь чиний нэрээр дуурсагдан үлдэх цаг ирж. Зүчи хөвүүн чи үүнийг үргэлж санаж яв. Чиний ялалт, алдаа эндэгдэл чинь Их Монгол улсын нэр сүртэй шууд холбоотой боллоо. Цагадай ч мөн адил. Одоо ертөнц даяар Чингис хаан намайг харж сонсож байна. Харин миний хийх хэлэхийг хөвүүд та нар гүйцэлдүүлэх учир чиний нэр Чингис хаан эцгийн чинь нэртэй адил боллоо. Бас Бөртэ эхийн чинь нэртэй холбогдоно. Чиний төлөө эхийн чинь зовсон зүдэрснийг юугаар ч хэмжиж болохгүй. Тийм биз.

Зүчи дуугүй толгой дохив.

-Хүү минь. Чи бол миний хөвүүдийн ахмад нь. Чиний хийх, хөдлөх дүү нарт чинь үлгэр болох ёстой. Харьяат албат цэргүүддээ бахархал болох ёстой. Та нарын өмнө уужим их газар орон байна. Би энэ ертөнц бүхлээрээ минийх болохыг хүснэ. Чи тэгэж хүсэхгүй гэж үү. Одоо бидэнд хэн саад хийнэ. Энэ ертөнцийг өмнөө сөхрүүлэх цаг миний хайртай хөвүүд та нарын өмнө Зүчи, Цагадай, Өгөдэй, Тулуй та дөрвийн өмнө иржээ. Энэ цагийг үзэх гэж Хаан эцэг чинь, хатан эх чинь нүдээ цавчилгүй нүүрээ арчилгүй зүтгэж ирлээ. Одоо та нарт хэн саад хийж чадна. Та дөрөв адилхан Чингис хааны алтан ургийн хан хөвүүд биш үү. Холыг бодож хоёрыг сэтгэж явагтүн.

Чингис хааны энэ бахархалт үгс Зүчийг бүр босон харайтал дэврээв.

-Тийм ээ. Энэ газар орон бүгд Чингис хааных байхыг би хүснэ.

-Суу Зүчи ээ. Чи хэлэхийн өмнө үгээ сайн бодож сур. Чамайг би ер зэмлэх гэсэнгүй. Чи одоо хүүхэд биш гэж Чингис хаан зөөлөн аяар зэмлэв. Зүчи ичингүйрэн суув. Тэр одоо эцгийнхээ үгэнд илбэдүүлж юу гэж хэлэх гэснээ ч мартаж шахжээ.

-Их хаан суух нь угаас Тэнгэрийн зарлиг тул хэн ч бай түүнийг зөрчих эрхгүй болно. Чи ч Цагадай ч би ч мөн адил.

-Тийм ээ. Би мэднэ. Хаан эцэг та бүү санаагаа чилээ. Би зарлигийг ёсчлон дагана.

Энэ үгийг Зүчи үнэн санаанаас хэлжээ. Нэгэнт Зүчийн үгийг сонссон тул Чингис хаанд санаа зовох юм үгүй болов.

-Хөвүүн чи хэл. Юу хүснэ.Бүү эрээлж нэрэлх.

Зүчийн хэлсэн бүгдийг эргэлзэхгүй биелүүлнэ гэж Чингис хаан итгэлтэй боджээ. Зүчи ч хэлэхийн өмнө хэсэг зуур бодов.

-Хаан эцэг минь. Миний цэрэг эрэлхэг байлдах сургууль шилдэг. Та үүнийг Алтан улсад үзэж мэдсэн биз ээ.

Зүчи өөрийн шилдэг хоёр түмэн цэргээр бахархах ёстой юм. Түүний цэрэг Алтан улсын гучин том балгасыг дайлан эзэлснийг бүгд батлана. Гэвч Зүчи юу гэх гээд байгааг Чингис хаан таахгүй тул дуугүй суув.

-Миний цэрэг хаа ч хүрсэн үл цуцаж, ямар ч бэхлэлтийг эвдэн сөнөөх болно. Одоо би оньсон харвуул, чөдөр их буу олонтой болсон. Миний цэргүүд шатаагч тостой сум хийж сурч байна.Бас..

-Чи юу хүснэ. Шууд хэлэгтүн гэж Чингис хаан Зүчийн энэ дүйвүүлсэн олон үгэнд төвөгшөөн үгийг нь тасалж асуув. Чингис хаан одоо нэгэнт Зүчээс айж болгоомжлохоо больсон тул эзэрхүү түрэмгий зан нь дийлжээ. Зүчи хэсэг зуур бодол болов.

-Хүү минь хэл.

Гэвч гаргасан алдаагаа Чингис хаан хормын дотор засаж Зүчийг тайтгаруулан дэмжиж дууныхаа өнгийг өөрчлөн ийн хэлжээ.

-Би... Би Хорезмын нутагт их цэргийн манлай болон орохыг хүснэ. Тэр харийн улс Чингис хааны их цэргийн нэр сүрийг надаас олж хараасай гэж хүснэ. Хамгийн эхний хотыг би өөрийн цэргийн хамт эзлэн авахыг хүснэ гэж Зүчи нэг амьсгаагаар тод хэлээд нэгэнт хүслээ илтгэсэн тул санаа амран хариу хүлээв. Ингэж хэлнэ чинээ санаагүй тул Чингис хаан тэр дороо шууд дэмжин зөвшөөрөх буюу эсэргүүцэн няцаах аргагүй болжээ. Гэвч ийм чин сэтгэлийн үгийг хариугүй орхих буюу үл тоомсорлон үзэж яавч болохгүй билээ. Бас яагаад Зүчи ингэж хүсч байгааг ч ойлгов. Энэ нь олны өмнө Цагадайд доромжлогдон алдарсан нэр сүрээ Чингис хаанаас засч залруулахыг шаардаж буй хэрэг юм. Магадгүй ийм үгийг Бөртэ хэлсэн биз гэж бодов. Гэвч энэ бол Зүчийн ганц биений хүсэл байлаа. Баруун зүгт хийх их дайны манлайд явах эрхийг олж гэмээ нь Зүчийн сэтгэл амрах байв. Хэрэв Чингис хаан түүнийг хүндэтгэн тоож үздэг бол ингэх ёстой гэж тэр боджээ. Зүчи энэ бүхнийг ганц өөрийн хар толгойн төлөө биш бүр Бат хөвүүнийхээ төлөө хэлсэн билээ. Чингис хааны ууган ач хөвүүдийн дотроос Бат хөвүүнээ ялгаран товойлгохыг Зүчи туйлаас хүсчээ. Энэ бол өөрийн гашуун хувь тавилангийн эсрэг тэмцэхээр сонгож авсан эцсийн арга зам байлаа. Одоо энэ их дайнд Бат хөвүүнээ алдаршуулан тодруулах их зорилгыг тэр сонгон авчээ. Үүний тулд Зүчи юу ч хийхэд бэлэн байв.

Гэвч Чингис хаан Зүчийн энэ холын бодлыг таасангүй. Ганцхан Зүчийн шаардлага хүсэлд

оночтой хариу хэлэхийг л хүсчээ. Чингис хаан Зүчитэй зөрчилдөн муудалцах нь аюултайг ойлгож байсан тул аргагүйн эрхэнд бууж өгч аяар нь байхыг тэвчин чармайж байлаа. Харин Зүчийн хүсэлтэд ганц хормын дотор хариу хэлэх боломжгүй юм. Учир нь Хорезмын их улсыг дайлах нь ер тоглоом биш билээ. Гэвч дуугүй суух нь Зүчид эвгүй сэтгэгдэл төрүүлэх тул ам нээхээс аргагүй. Зүчийн энэ хүсэлт олон жилийн өмнө Хүйтэн уулын тулааны үед Хасар Боорчийг цаазлахыг шаардсантай утга нэг байв. Эвгүй буруу үг хэлбэл тэртээ тэргүй эргэж буцаж гомдож бухимдсан Зүчийг цааш түлхэх аюултай билээ.

-Зүчи хөвүүн минь гэж Чингис хаан өнөөх элгэмсүү зөөлөн үгээ дахин хэрэглэв.

-Би чиний чадал хүчийг бахдаж байна. Миний их цэргийн хамгийн шилдэг нь чиний засаж хүмүүжүүлсэн цэрэг мөн. Миний бүх цэрэг бүгд ийм байгаасай гэж хүснэ. Гэвч хөвүүн минь. Хорезмын улсын цэргийн чадвар, дайтах аргыг бид сайн мэдэхгүй. Тагнуул туршуулын хүний үг сонссоноос цаашгүй. Тэд суурин балгаст зууралдан байлдахдаа сүрхий гэнэ. Бид олноор зөвлөлдөж Хорезмтой хэрхэн тулах аргаа сонгоогүй байна. Би чамайг манлайд явуулахыг сайшаана. Гэвч би ихийг үзсэн Боорчи, Сүбээдэй, Зэв бас Хасар авга чинь юу гэхийг сонсьё. Таниж мэдэхгүй газар орон, уулзаж учраагүй дайсантай хар зоригоор тулна гэдэг нүцгэн биеэр галд орсонтой адил юм. Түрүүлж дайрсныг баатар зоригтон, бахтай жанжин гэж үзэхэд учир дутна. Хөвүүн чи намайг ахмадын үгийг сонстол хүлээ. Би чамайг Хорезмыг эзлэх дайнд шалгаран мандаасай гэж хүснэ. Миний хөвүүд, чиний дүү нар Зүчи чиний адил ийм хүсэлтэй гэдэгт итгэнэ.

Гэвч хөвүүн чи мэдэхгүй газар танихгүй дайсны өөдөөс түрүүлэн дайрах гэж бүү зүтгэ. Би чиний чин их хүслийг мэдсэн тул баярлаж сэтгэл бахдан ханав. Би хөвүүн чамайг хатан биеэ сүйтгэж хайран нэрээ үрэхийг үл хүснэ. Хөвүүд та нарын амь бие алдар нэрийг би өөрийн алтан биетэйгээ агуу нэртэйгээ адил үзнэ. Гэвч би ихсийн зөвлөгөөн дээр чиний цэргийг Хорезмд манлай болгон илгээхийг илтгэнэ.

Зүчид Чингис хааны үнэн үгийг дуугүй даган зөвшөөрөхөөс өөр юу ч үлдсэнгүй. Хэдий хаан эцэг нь түүний хүсэл бодлыг шууд дэмжээгүй ч энэ яриа Зүчид сайхан сэтгэгдэл үлдээв. Чингис хаан ч баясгалантай болжээ. Ер тэрээр Зүчийн ухаан зоригийг бахаддаг билээ. Бөртэ хатны мэргэд цустай энэ хөвүүн яагаад ч юм бэ хүн хүнээс илүү үнэнч сэтгэлтэй мэт санагддагийн нууцыг Чингис хаан тайлж ядна. Магадгүй үргэлжийн гадуурхагдаж, ил далд ад үзэгдэж байхдаа Чингис хааны төрсөн хөвүүнд ногдох итгэл хайрыг олж авах гэсэн их хүсэл тэмүүлэлдээ шатаж байдаг нь Тэмүжинд хязгааргүй үнэнч зүтгэх сэтгэлийг төрүүлсэн байж мэднэ. Хэрэв Зүчи, Чингис хааны төрсөн хөвүүн байсан бол ямар ч эргэлзээгүйгээр өөрийгөө залгамжлуулах байв. Эцэг эхийн илэрхий хайр ивээлд бялуурсан Цагадай дэндүү омголон хойрго хөшүүн байдаг бол Зүчи яг л чонын бэлтрэг шиг Тэмүжиний харц хөдөлгөөн үг бүрийг манаж ам нээн хэлэхээс нь өмнө ухасхийхэд бэлэн эрвэлзэж байдгийг үзэж заримдаа ихэд өрөвдөн хайрладаг байсан билээ. Бага балчир Зүчи, Тэмүжин эцгийнхээ өчүүхэн боловч талархлыг олохын тулд юугаа ч хайрлахгүй тэмцэхэд бэлэн байдаг байв. Цагадайг нялх ахуйд эрхлүүлэн тоглож байхдаа Зүчи яг хоол горьдсон нохойн гөлөг шиг толгой гилжийн гунигтайгаар атаархан ширтэн суухыг хардагсан. Залуу гэнэн цагт түүнийг ер тоодоггүй байсан хирнээ нялх балчир Зүчийн тэр гүнзгий гунигт харц одоо хэр гэнэ гэнэ сэтгэлд нь сэвхийн ороход хачин их цочин зүрх нь шимширдэг болсноо Чингис хаан ер ойлгодоггүй

байлаа. Нэг их ял зэм хийсэн мэт заримдаа санагдана. Эцгийн хайр ивээл амсаагүй өссөн өнчин ядуу амьдрал, байнгын аюул гачаалын дунд өнгөрөөсөн хүүхэд насны нь гунигт дурсамж ингэж Зүчийн гомдолт харцаар илэрдгийг тэрээр таасангүй. Чингис хаан Зүчи хоёр их адилхан амьдрал үзсэн мэт санагдана. Ингэж бодоход Зүчийг өрөвдөн хайрламаар ч, хүний сэтгэл зүрх гэдэг эзнийхээ оюун ухаанд тийм ч амар захирагддаггүй ажээ. Яаж ч ухаан зарж хичээгээд Зүчийг Цагадай, Өгөдэй, Тулуй хөвүүд шигээ хайрлаж үнсэж сураагүй билээ. Үүнийхээ төлөө хэзээ ч Бөртийн өмнө гэмшиж өршөөл хүсэж байсангүй. Чингэхийг Бөртэ ч шаардсангүй. Өөрийн гурван хөвүүн төрж, өсөж томрох тусам Бөртийн Зүчид тавих анхаарал халамж, хамгаалал сулрах мэт болжээ. Харин Зүчийг төрөхөд түүнийг ал гэж тушаасныг эх хүү хоёр хэзээ ч мэдэхгүй гэдэгт Чингис хаан бат итгэлтэй байв. Учир нь ийм хэцүү нууц хэргийг дэндүү ухаантай Боорчи хэзээ ч задалж хэлэхгүй нь мэдээж юм. Өнөөдөр Зүчийн хэлсэн үгийг сонсоод эртний энэ дурсамж сэргэжээ. Одоо санахад Боорчи түүний хэлснээр Зүчийг алж орхисон бол ядаж зүгээр л төрмөгц нь замын хажуу руу шидэж орхисон бол Чингис хаанд амьдрахад арай л хялбар, Цагадайн хувь заяа ч өөрөөр эргэх байжээ. Боорчийн энэ тэнэг шийдвэр Тэмүжиний зөөлөн зан нийлээд өнөөдөр, ер нь цаашдаа ямар учир урхаг үүсгэхийг зөвхөн таахаас цаашгүй. Юутай ч Зүчийн өнөөдөр хэлсэн үг гаргасан сэтгэлээс үзэхэд тэр лав Чингис хааныг эсэргүүцэн тэмцэх, Цагадайтай өширхөн алалдах санаагүй бололтой. Энэ нь ядаж түүнийг түр боловч тайтгаруулж байлаа. Чингис хаан хэлсэндээ хүрч Зүчийн цэргийг манлайд явуулах бодолтойгоо шадруудтайгаа зөвлөлдөх үедээ ил тод, бүр Зүчийн нүүрэн дээр хэлж Зүчи ч сэтгэл амар болжээ. Одоо хэрхэх ёстой талаар Чингис хаан биш шадар жанжид нь үгээ хэлэх үлдэв. Мэдээж тэд Чингис хааны үгийг хүлээн авсангүй. Зүчийг тэд арай түргэдэж осолдож мэднэ гэж үзжээ.

-Хорезмыг эзлэх нь хүүхдийн тоглоом биш. Эхний дайралт ямар болох нь дайны эцсийн бүрэн ялалтыг тодорхойлох тул хэн нэгэнд найр тавих нь хортой гэж Сүбээдэй хэлсэн нь олон бүгдийн талархлыг хүлээж Чингис хаан ч толгой дохив. Ингээд бүгд зөвшин туршлагатай алдарт жанжин Зэвийг магнайд илгээхээр тогтов. Ард нь Сүбээдэйг илгээхээр болсныг эцэст нь Зүчи ч хүлээн зөвшөөрөхөд хүрчээ. Зүчийн хүсэл, шаардлагад шадруудынхаа амаар аятай хариу өгч Зүчийн өмнө өргүй, нэр цэвэр үлдсэндээ Чингис хаан хангалуун инээмсэглэж сэтгэл баяртай болжээ. Гэсэн ч Зүчийн хүслийг ямар ч болов мартахгүй санаж явсаар Хорезмыг дайлсан эхний жилийн төгсгөлд хуучин нийслэл Ургенч хавийн нутгийг Зүчид өгснөө албан ёсоор зарлан энэ хэргийн учрыг тайлж Зүчийг гомдолгүй болгов хэмээн санасан нь эндүүрэл болжээ.

Зүчи Цагадай хоёр хамт нэг дор байх нь улам бүр аюултай болсоор байгааг Чингис хаан мэдэж байв. Гэвч Зүчид Ургенчийг өгсөн нь зөв эсэхэд эргэлзэх бас атаархах хүн гарахыг тэр тооцож үзсэнгүй. Ургенч хавийн нутгийг түүнд өгсөн нь Зүчийн хувьд тун санамсаргүй явдал болсон билээ. Тэр урьд нь эзэлсэн нутаг, олсон олзыг ер минийх гэж санаж байсангүй тул хүн амьтан, ер юуг ч байсан өрөвдөн хайрладаггүй байв.

Гэтэл одоо үзэсгэлэнт сайхан Ургенч хот минийх гэж бодохоор харин ч хайрлалтай санагджээ. Гэвч өөрийн болгон эзэмшихийн өмнө эхлээд Ургенчийг эзлэн авах ёстой. Үүний тулд тэр өөрийн цэргийг Ургенчийн дэргэд аваачжээ. Хорезмын их улсын сүүлчийн бэхлэлт болсон Ургенч үнэхээр үзэсгэлэнтэй хот ажээ. Самаркандаас амь зулбан гарч Чингисийн хааны цэрэгт нохой мэт хөөгдөн зугатсаар Каспийн тэнгисийн нэг жижиг арал дээр нэр

төргүй үхсэн Мухамед султаны оронд түүний хүү гавшгай зоригт эр Желаладдин өргөмжлөгдсөн нь Хорезмын бутарч тарсан цэрэг ардыг сэхээн зоригжуулж Чингис хааны цэргийг эсэргүүцэх тэмцэл урьд байсангүй тийм их хүчээр өрнөжээ. Газар бүр Монголын цэрэг ихэд хохирох болов. Цэргийн давшилт ялалт удааширч эхэлсэн нь Чингис хааныг түгшээж бас үүний хажуугаар Хорезмын ялагдашгүйн баталгаа болсон Ургенчийг Зүчи эзлэн авч чадахгүй удсан нь Чингис хааны хилэнг бадраав. Харин Зүчи өөрийн цэргийн амийг хохироохоос эмээн буулган авах арга сэдэж зүгээр л бүслэн суусаар хэдэн сар болжээ. Залуу султан Желаладдиний нэр хүнд огцом өсөж тэр одоо даруй зургаан түмэн цэрэгтэй болоод Ургенчийн зүг давшиж очих нь тодорхой болсон тул Чингис хаан зарлиг буулгаж Цагадай Өгөдэй хоёрыг цэргийн хамт Ургенч руу даруй очихыг тушаав. Бас нэгдсэн цэргийн хэргийг Өгөдэйг шууд захирахыг ч зарлиг болгов. Ингэх нь Чингис хааны зөв байсан ч өмнө нь Самаркандыг эвдэлгүй эзлэх гэж хөвүүд нь хэрэлдэж зөрчилдсөн нөхцлийг дахин бүрдүүлэв. Хорезмд хийж буй дайныхаа эцсийн ялалтыг эрхэм болгосноос биш хөвүүд нь юу хүсэж байгааг хайхран үзээгүй түүний энэ шийдвэр тийм ч зөв оночтой биш байлаа. Гэвч түүнийг хэн ч эсэргүүцсэнгүй. Ялангуяа Боорчи юм хэлсэнгүй.

Өөрийн эзэмшлийн хотод бусдын цэргийг оруулахыг Зүчи огт хүсэхгүй байв. Самаркандыг эзлэхэд хайран олон цэргийнхээ амийг дэмий үрсэндээ Зүчи одоо ч харамссаар ажээ. Цэргийн амийг хайрлах нь Зүчийн төрөлх зан хүмүүжил юм. Ургенчийн ойр байрласан Зүчийн хээрийн өргөөнд Өгөдэй ганцаар очиход Зүчи илт таагүй угтав. Хэд хоногийн өмнө Чингис хааны зарлигийг түүнд хүргэн иржээ. Өгөдэй ахынхаа уур уцаарыг ойлгож мэдэх учир тэсч өнгөрөөж дараа нь Чингис хааны зарлигийг ёс журмын дагуу дахин дуулгав. Тэдний хэн нь ч Чингис хааны зарлигийг эсэргүүцэн буцаах аргагүй билээ.

-Ургенчийг даруй эзлэн авахыг Чингис хаан надад зарлиг болгов. Иймийн тулд хэрхэн довлохыг зөвшөөр би ирлээ гэж Өгөдэй болгоомжтой хэлэв.

-Цагадай юунд ирсэнгүйв гэж Зүчи бухимдсан хэвээр асуув.

-Та бид тохирвол Цагадай ах бүгдийг зөвшөөрнө гэв.

Энэ үг Зүчийг бага боловч тайвшруулжээ. Угаас өөрт нь үргэлж хүндэтгэлтэй ханддаг Өгөдэйтэй сөргөлдөн тэмцэлдэх шалтгаан Зүчид байхгүй байв. Өгөдэй хүлээц тэвчээр ихтэй болохоор Зүчи ахтайгаа юу гэж ярихаа сайн боловсруулан бэлджээ. Үүний тулд Цагадай ахынхаа үг гэж нэгийг ч хэлж болохгүй гэж бодсон нь зөв болжээ. Цагадайд мөн л Зүчид хэлсэн шигээ

-Та бид тохирвол Зүчи ах дагана гэж хэлсэн билээ. Тэр үед Зүчитэй нүүр тулахаас бяцхан эмээж асан Цагадай дуртайяа зөвшөөрч

-За тэгвэл чи явж Зүчитэй тохирч ир. Би та нарын хэлснээр хийе гэжээ. Одоо Зүчи ч зөвшөөрөв. Өгөдэй ингэж жижигхэн заль хэрэглэж үл эвлэрэх хоёр ахынхаа Ургенч хотыг нэгдэн эзлэх замыг засч чадав. Зүчид харамсалтай ч Ургенч хотыг хоёр дүүтэйгээ хуваах хэрэг тулгарчээ. Хамтран эзлэж авсан ч Ургенч түүнийх болж үлдэх тул аль болох эвдэх сүйтгэхгүй эзлэхийг хичээсээр байлаа.

-Өгөдэй. Ургенч бол Чингис хаан эцгээс надад хувааж өгсөн хот гэдгийг бүү март. Эвдэж шатаахыг би үл хүснэ гэж хатуу хэлсэн нь Өгөдэйг баахан тулгамдуулжээ.

-Ах аа санаа бүү зов. Энэ их хотоос юу л үлдэнэ. Та түүнийг бүгдийг авагтун. Харин та бид гурав Ургенчийг хаан эцгийн заасан хугацаанд эзлэн авах ёстой.

-Хэзээ эзлэн ав гэнэ.

-Арав хоногоос бүү хэтэр гэв. Бид Желаладдинийг хүчирхэгжин нааш давшиж ирэхээс өмнө Ургенчийг ямар боловч эзлэн авах ёстой. Ургенч бууж өгөхгүй ингэж их удах нь дайсанд итгэл төрүүлэх муу нөлөөтэй гэж Чингис хаан хатуу зарлиг буулгав. Бас Желаладдиний туслахаар ирэх замыг таслах хэрэгтэй байна

Энэ үгийг Өгөдэй санаснаас хатуу чанга хэлсэн тул Зүчи бодолд оржээ. Зүчи нэгэнт гарцаагүй байдалд орж Ургенч хот сүйрэн нурах цаг болсныг ойлгон зөвшөөрөхөд хүрэв.

-Зүчи ах аа. Би маргааш өглөө танд давшин орох цагийг хэлье. Би одоо Цагадай ахтай уулзана гэж Өгөдэйг шийдэмгий тулган хэлээд босоход

-Чи өөрийн үзсэнээр хийгтүн гэж Зүчи хашгирчээ.

-Харин хотыг эзэлсний дараа бүх иргэд, эд хөрөнгө таных болно. Би танд амлаж байна гэж Өгөдэй тайтгаруулах мэт хэлээд давхин оджээ. Цагадай түүнийг бас л баргар царайлан угтав.

-Юу гэнэ. Зүчи ах чинь гэж Цагадай уцаартай бас даажигнасан мэт асуув.

-Намайг цаг товломогц нэгэн зэрэг дайран орохоор шийдэв.

-Би зөвшөөрнө гэж Цагадай ямар ч тайлбар асуулгүй ингэж хэлэв.

-Харин Ургенч хотыг эзлэн авмагц та бид хоёр цэргээ даруй татан хотоос гарвал зохино. Бид Ургенчээс юу ч авч болохгүй. Ургенч хот бол Чингис хаанаас Зүчи ахад соёрхон өгсөн бэлэг юм. Би сая Зүчи ахтай тэгэж тохирлоо. Та бид хоёр Чингис хааны зарлигийг биелүүлбэл болно биз гэж инээмсэглэхэд Цагадайн нэрэлхүү зан хөдлөөд зөвшөөрчээ. Өгөдэй ингэж өөрийн санаснаар эмээлийн хоёр бүүрэг шиг болсон ах нараа зохицуулж чадаад Ургенч хотыг довлон эзлэх бэлтгэлээ шуурхайлав. Хотыг дайран эвдэх тэргүүн эгнээнд нутгийн иргэдээс дайчилсан хоёр түмэн “үхлийн цэргийг” оруулж араас нь өөрийн цэргээ давшуулж галдагч сумаар зайгүй буудахаар Өгөдэй шийджээ. Өөрийн цэргийг золиослон түрүүлж дайрах нь Өгөдөйд хохиролтой ч Ургенчийг түргэн эзэлж өөрийн чадвар, хүчийг үзүүлэхийг гол болгожээ. Энэ бол Өгөдэйн хувьд хамгийн зөв шийдвэр байв. Чингис хаан Өгөдэйн юу чадахыг үзэх хүсэлтэй байгаа нь мэдээж билээ. Маргааш үүрээр “үхлийн” цэргүүд Ургенчийн гадаад хэрмийг дайран довтолж биесийн хүүрээр шат хийн авирч эхлэв. Тэдний толгой дээгүүр шатдаг тостой бортого зайгүй нисч Ургенч хот галд авалцан шатаж гадаад хэрэм нуран унажээ. Ингэж Ургенчийн төлөөх тулаан долоон өдөр долоон шөнө үргэлжилж гурван түм шахуу монгол цэргийн амийг золиослосны эцэст нь хотынхон бууж өгөв. Ургенчийг эзэлсэн тухай мэдээ Чингис хаанд хүрэхэд тэр Тулуй хөвүүний хамт Алтан

горхины нуруунд цэргээ амраан сэрүүцэж байлаа. Элчийн баярт мэдээг сонсоод

-Даруй эргэн ирж цэргээ амрааж нийлэгтүн гэж зарлиг буулган элч илгээжээ. Ургенч эзлэгдсэн нь Хорезмын улс бүрэн мөхсөний баталгаа болов. Одоо эзэмшил нутаггүй, иргэд хотгүй болсон Желаладдинийг хөөж устгах үлдэж, түүний хойноос Чингис хаан өөрөө морилохоор шийджээ.

### *НУУЦ ЭЛЧ*

Бүтэн долоон сар үргэлжилж Чингис хааны хилэнг бадраасан Ургенч хотын төлөөх дайн олон мянган монгол цэргийн амийг золиослосны хүчинд монголчуудын бүрэн ялалтаар төгссөн ч ардаа олон санаандгүй хэргийг үүсгэв. Эмээлийн хоёр бүүрэг шиг өөд өөдөөс үл харалцах, үл эвлэрэх хоёр ахынхаа арга эвийг олж, гайхмаар амь хайргүй ширүүн тулалдсан Ургенчийнхний эсэргүүцлийн хүчийг дарж хамгийн удаан ужигран сунжирсан тулааныг ердөө долоон өдөр долоон шөнийн дотор ялалтаар дуусгаж чадсан нь Өгөдэйн нэр сүрийг хэмжээлшгүй ихээр өргөсөн явдал болов. Энэ нь чухам Өгөдэйг шилж өөрийн хойно хаан сууринд өргөмжилсөн Чингис хааны зарлигийн зөвийг давхар баталжээ. Чухам ингэх гэж Өгөдэй ухаан заль зориг гурваа шавхсан билээ. Бүх юм санаснаар болж хамгийн анх олдсон боломжийг Өгөдэй дүүрэн ашиглаж олон хүний сэтгэлд ирээдүйн их хаан суурийг эзэлж чадав. Өөрт зарлигаар оногдсон Ургенчийг эвдэхгүй эзлэн авах гэсэндээ цаг алдан алгуурлаж байснаас болж Зүчи өөрийн нэр хүндийг баахан унагасандаа харамсаад ч барахгүй болжээ. Гэвч Зүчээс илүү харамсаж гашуудсан хүн нь Бат байлаа.

Чингис хаан Ургенчийг эзлүүлэхээр Цагадай Өгөдэй хоёрыг цэргийн хамт илгээснийг сонсмогц л Бат дуугаа хураан дүнсийснийг Зүчи харж байв. Хорезмын энэ үзэсгэлэнт хот удахгүй эцгийнх нь мэдлийнх болно гэж бодохоос Батын нойр хүрэхгүй байжээ. Өглөө бүр Ургенчийн дэргэдэх өндөрлөгт гарч хотыг ширтэн холын мөрөөдөлд автан зогсдог байлаа. Зүчи ч Бат хөвүүнийхээ сэтгэлийг ойлгон ийн зогсохыг нь хараад ихэд баясан хуучин гомдлоо мартдаг ажээ. Зүчи, Бат хөвүүндээ зүрхний угаас хайртай юм. Бусад хүүхдүүддээ гаргадаггүй өгөөмөр халуун, бүр хэтэрхий гэмээр хайр халамжийг Батад үзүүлнэ. Үүнийг нь Бөртэ хатан эх нь илэрхий дэмжин Батыг ач нарынхаа дундаас онцгой үзэн эрхлүүлсэн билээ. Учир нь Бат бол Бөртийн удмын Уги хатнаас төрсөн юм. Өгөдэй нэгэнт хаан эцгийг залгамжлах нь тодорхой болсон үед Өгөдэйг хэн залгамжлахыг бодох хэрэгтэй байлаа. Өгөдэйн Дөргөнө хатнаас төрсөн хөвүүн нь Гүюг бөгөөд Батаас хоёр ах байлаа. Чингис хааны зарлигт “Хэрэв Өгөдэйн хөвүүд өвсөнд ороовч үхэр тоож идэхгүй өөхөнд ороовч үнэг тоож шиншлэхгүй аваас миний алтан ургийн дотор сэргэлэн гавшгай хөвүүн эрхбиш олдоно. Тийм үед түүнийг олж өргөмжлөгтүн” гэжээ. Ийм учир шалтгааны үүднээс Бат хөвүүнээ Чингис хааны ач хөвүүдийн манлай нь болгохыг Зүчи хүсч байлаа.

Зүчийн алдсан нэр төр, эрх ямбыг буцаан авч бас хүсэл мөрөөдлийг гүйцэлдүүлэх ёстой хүн нь Бат хөвүүнээ гэж Зүчи өөрийн олон хөвүүдийн дотроос түүнийг сонгожээ.

Чингис хааны зарлигаар олгосон Ургенч болоод тэр хавийн нутаг хэдий шашин, хэл өөр ч яах аргагүй Зүчийн өөрийн бие даасан улсын эх үндэс ирээдүйд хөвүүн Батын суурьшин нутаглаж захиран суух их улсын үүсэл болно гэж сэтгэлийн мухарт шийдэн бодсон тул Зүчи



Ургенчийг эвдэхгүй буулган авахыг хичээсэн билээ. Ууган хөвүүн Ордыгоо Сигнах хотыг захируулан суулгаж үлдээсэн нь ч үүнтэй холбоотой байв. Арван дөрвөн нас арай хүрээгүй ч Бат эцгийнхээ алс далдын хүслийг аль эрт ойлгож гадарласан төдийгүй Ургенчид эзэн суухыг тэсч ядан хүлээж байжээ.

Чингис хааны зарлигийг хэн ч зөрчин эвдэж чадахгүй тул Зүчи, Өгөдэй дүүгийнхээ үгийг хаан эцгийн зарлиг шиг л дагаж Ургенчийг өгчээ. Ургенчийг эзлэн авахад хүч хамтрахаас өөр аргагүй болсон ч баян тансаг энэ хотоос олох олзыг хэнтэй ч хуваах хүсэл байсангүй. Харин Өгөдэй хэлсэндээ хүрч Ургенчийг буулган авмагц цэргээ татан хотоос гадагш гарчээ. Цагадай ч мөн адил цэргээ татав. Өгөдэйг хэлсэн үгэндээ хүрдэг хүн болохыг Зүчи ингэж үзжээ. Одоо хотод Батын толгойлсон Зүчийн цэрэг үлдэв. Ургенчийг алдсандаа гуниж хорссон Бат хөвүүнээ тайтгаруулахын тулд Зүчи Ургенчийг дайрах өөрийн цэргийг Батаар удирдуулсан билээ. Уг нь энэ хэргийг Зүчи өөрөө удирдах байлаа. Гэвч залуу хөвүүнээ харамлаж харамссандаа бодол цалгар болуузай гэж сэргийлэхдээ, гуниж гомдсон сэтгэлийг нь тайтгаруулах гэсэндээ их цэргээ анх удаа бие даан удирдахыг зөвшөөрчээ.

Энэ бол арван дөрвөн настай Батын хувьд амьдралдаа бие даан хамгийн том тулааныг удирдах болсон хэрэг юм. Эцгийн энэ үгийг сонсмогц Батын харуусалт харц ахиад л цог хиймориор дүүрэн гэрэлтэхийг үзээд өөрийн шийдвэрийг зөв гэдэгт эргэлзэхгүй болжээ. Зүчи анх Ойн иргэдийг дайлахаар мордох зарлигийг сонсмогц л яг Батын адил баясан бахдаж зориг хийморь нь дүрэлзсэнээ санажээ. Гэвч Бат хөвүүн нь эцэг шигээ гадуурхагдан доромжлогдохыг үзээгүй ч хожим хойно Цагадай, Өгөдэй, Тулуй нарын хөвүүдэд дарлагдахыг Зүчи тэвчихгүй байлаа. Тийм учраас л Бат хөвүүнээ арван дөрвөн настай ангир хонгор зүстэйд нь энэ бэрх том тулааныг удирдах эрх олгожээ. Анх мянган цэрэг ахлан Тайчуудтай дайтахаас эхлэн Зүчид зүтгэсэн Хунан, Мүнхээр, Хэтэ гурван ноён ил далд эсэргүүцэж элдэв тайлбар хэлсэн ч Зүчи үгнээсээ ухарсангүй. Чингис хааны зарлигаар Зүчид хуваагдан ирж шадарласан хүмүүс тул энэ гурав хэзээд үнэн үгээ ил хэлдэг билээ.

-Та гурав өөрсдийн цэргийг удирдаж Бат хөвүүний минь тушаалыг хичээн биелүүлэгтүн гэхээс өөр үг Зүчи хэлсэнгүй. Зүчийг нэг үгээ олон дахин давтдаггүй зантайг мэдэх тэд дахин дуугарсангүй тус тусын хүрээнд оджээ. Цэргийн эрдэмд нэвтэрсэн шадар жанжнуудтайгаа зөрж Бат хөвүүнээ ийм хэрэгт томилсондоо Зүчи дотроо эргэлзсээр байсан ч гаднаа эл байдлаа мэдэгдсэнгүй. Тэгээд ч одоо л Батыг биеийг даалган цэрэг захируулж их тулаанд оруулж сургахгүй бол оройтно гэж бодсоноос гадна хамгийн гол нь Батын урам хугаран Чингис хаан болоод авга ах нартаа хонзон санах бий гэж болгоомжилсон билээ. Зүчийн ингэж бодсон зөв байлаа. Бат үнэхээр дотроо уурсан хорссоор байсан ч Өгөдэй авгадаа туйлын хүндэтгэлтэй хандах тул ер муу үг хэлж муухай ааш гаргасангүй тэвчжээ.

Зүчи, Цагадай, Өгөдэй гурвын цэрэг Ургенчийг гурван талаас зэрэг довтлохоор тохирч Өгөдэй цагийг товложээ. Тохирсон ёсоор довтолгоон эхлэхэд Бат өөрийн цэргийг хөдөлгөхгүй зогссоор үлдсэн нь Зүчийг гайхшруулж тэсч чадахгүй өндөрлөгт эзэлсэн байрнаасаа бууж цэргийнхээ тэргүүнд давхин очиход хүргэжээ. Бат хөвүүнээ цалгардаж осолдов гэж эмээсэн билээ. Гэтэл Бат цэргийн магнайд эргэлзэхгүй догь зогсож “үхлийн цэргүүд” Ургенчийн зүүн хэрмийг дайрахыг хөмсөг зангидан харах ажээ. Зүчийн цэрэг энэ үед Ургенчийн баруун талд байрлаж байлаа. Эцгийгээ юуны учир сандарсныг Бат ойлгожээ. Зүчийг давхин очиход

түүний ам нээхээс урьтан

-Ургенчийг эзлэн авахыг надад даалгасан биш үү гэж хашгирчээ. Батын дуунд хоолоо булаалгасан залуу нохойн хорсол тод сонсдов.

-Тийм ээ. Би хэлснээсээ үл буцна. Ганцхан чамайг юу хийхийг дэргэдээс чинь харахыг хүснэ гэж Зүчи хөвүүнээ тайвшруулан инээв. Хөвүүн нь ингэж өөртөө итгэлтэй байхыг үзэх Зүчид туйлын таашаалтай байлаа. Арван таван настайдаа Зүчи ийм байж чадаагүй тул Бат хөвүүнээрээ бахархахаас өөр аргагүй болов. Зүчи өөрийн амьдралд үзэж эдлээгүй бүхнийг хөвүүндээ эдлүүлэх гэхээс юу ч хийхээс буцахгүй болжээ. Бат юу хийхээ сайн мэдэж байлаа. Бүрэн бүтэн хэвээр нь буулган авахыг хүсч байсан Ургенч хот одоо зүүн хойт талаасаа шатаж эхлэв. Энэ нь Өгөдэйн цэргийн харвасан шатаагч сумнаас үүдсэн байлаа. Галын дөлөнд тэнгэр улайж шөнө болсон ч тулалдсаар байжээ. Өгөдэй ямар ч үнээр хамаагүй Ургенчийг эзлэн авахаар улайран цэргийнхээ үхэл сүйрлийг үл тоон довтолно. Харин Бат “үхлийн цэргийн” араас өөрийн цөөн тооны цэрэг явуулаад харин гол цэргээ хүлээлгэн бүтэн өдөр өнгөрөөв. Өгөдэй энэ байдалд гайхан элч давхиулж Зүчийг цэргээ оруулахыг тушаажээ. Маргааш өглөө нь байдал яг хэвээр Бат гол цэргээ хөдөлгөсөнгүй тул Зүчи Хунан, Мүнхээр, Хэтэ гурвын хамт цэргээ довтлогоонд оруулахаас өөр үггүйд хүрчээ. Батын энэ хачин авир эцэст нь юунд ч хүргэж болох аюултайг бүгд мэдэж байлаа. Өгөдэйн элч дахин ирж Чингис хааны зарлигийг сануулав. Байдал улам ч хурц боллоо. Зүчи тэссэнгүй цэргээ өөрөө удирдахаар шийдэв. Гэвч Бат хөвүүнээ гомдоохыг тэр хүссэнгүй. Зүчийг хээрийн асарт очиход Бат Ургенчийн зүг ширтэн довцогийн дээр морьтой зогсож байлаа. Чингис хааны зарлигийг ингэж санаатайгаар зөрсөн явдал өмнө нь ер гарч байсангүй. Зүчийн хөвүүнээ гэсэн зөөлөн зан одоо амь насаа алдах аюултай байдлыг үүсгэжээ. Өгөдэй яавч энэ хэргийг хаацайлан өнгөрөөхгүй нь мэдээж. Бага балчир хөвүүн нь гэнэн томоогүйгээсээ болж юу ч хийж мэдэх болжээ. Эцсийн эцэст энэ хэрэг Зүчийн буруугаас болсон тул Чингис хаан түүнд хэрхэн хандахыг хэн ч үл мэднэ. Шадрууд нь яг ингэж хэлсэн билээ.

-Хөвүүн минь. Өгөдэй биднийг цэргээ оруулахыг шаардаж байна гэж Зүчи аль болох зөөлөн хэлэхийг хичээв.

-Одоохон би цэргээ оруулна. Түр хүлээж байг гэж Бат унтууцав.

-Чи юу хүлээнэ гэж Зүчи оворзож ирсэн уур хилэнгээ арайхийн барьж шивнэв.

-Тэнд хотын зүүн талд монгол цэрэг ихээр сүйрч байгааг чи харахгүй байна уу. Энд дайн болж байна. Цэргээ даруй хөдөлгө. Бидний ингэж байгааг Чингис хаан юу гэж үзэхийг мэдэж байна уу чи гэж тэсэж чадсангүй зандрав.

-Би Төмөр-Мэлигийг цэргээ зүүн тийш Өгөдэй, Цагадайн цэргийн зүг татахыг хүлээж байна. Тэгвэл миний цэрэг ямар ч гарзгүйгээр хотод орно гэж Бат хүн итгэхийн аргагүй хүүхдийн гэнэн үг хэлэхэд Зүчи гэнэт дүрсхийн уурлав. Эцэг хүү хоёрын юу хэлэлцэхийг одоо энд хэн ч сонсохгүй, амь сахигч цэргүүд хэдэн алхмын зайтай байлаа. Бат угийн гавшгай сэргэлэн хүн тул энэ удаа ч эцгийгээ ууртай догшин үг хэлж хилэгнэхээс бас урьтав.

-Та сонс гэж Батын шивнэн хэлсэн нь Зүчийг хэлний үзүүрт гарч ирсэн ширүүн үгээ буцаан

залгихад хүргэв. Бат хөвүүн нь ер дэмий сул үг ярьдаггүйг тэр мэднэ. Гэвч түрүүчийн хэлсэн үгс даанч гэнэн томоогүй санагдсан тул тэвчээгүй билээ. Бат ингэж сэрэмжлэн урьтаж дуугараагүй бол эцгийн амнаас гарах зэмлэлийн үг тэдний хооронд ямар уршиг тарихыг хэн ч таахын аргагүй юм. Цагадай болоод Өгөдэйн цэрэг Ургенчийн хэрмийг зүүн талаас давах гээд өдөр шөнө хоёр хичнээн хохирол үзээд байгаа нь бүхэнд ил энэ үед Зүчийн цэрэг хөдлөхгүй зогсохыг хэн ч байсан тайлбарлан зөвтгөж чадахгүй биз. Чингис хаан үүнийг мэдэхгүй өнгөрнө гэж бодох нь хамгийн гэнэн хэрэг юм. Одоо Зүчид ямар ял оногдох нь тодорхой. Гэнэн балчир хөвүүн нь юу сэдэж тэр эцэст нь ямар ялд унах бол гэж Зүчи эмээж байв. Батын энэ хачин тоглоомыг эцэс болгож өөрийн цэргийг зовтолгоонд оруулахаас өөр зам Зүчид үгүй байлаа. Гэвч тэр хөвүүнийхээ үгийг тэвчин хүлээв.

-Та сонс гэж Бат эцэгтээ дөхөн ирж давтан шивнэв. Бат дахин ам нээхийн өмнө Ургенчийн хэрмийн зүг удаан ширтэв. Батын идэр царай гэнэт дуулган дороос инээмсэглэж үзэгдэхэд Зүчи гайхлаа. Энэ хөвүүн ер нь ухаан санаа эрүүл биз гэсэн бодол төрөх шиг.

-Аав та харж байна уу. Тэр Төмөр-Мэлиг цэргээ зүүн хэрэм тийш татаж байна гэж Бат догдлон хашгирлаа.

-Чи юу ярина вэ.

-Та хараач дээ.

Тэдний өмнө хөндөлдөх хэрмийн дотор болж буй явдал өндөр дээрээс ил үзэгдэнэ. Нээрээ Төмөр-Мэлигийн хамгаалалтын цэргийн хэсэг нь зүүн тийш цувран явцгааж байв. Тэр даруй хагас түмэн цэрэг бий биз.

-Та хар даа. Би танд хэлсэн биш үү. Төмөр-Мэлиг цэргээ зүүн тийш татахыг хүлээе гэж.

-Чи юу гээчийг сэдэв гэж Зүчи харсандаа итгэж ядан асуужээ.

-Би Төмөр-Мэлигт таны нэрээр элч илгээж “Ургенч хот бол Чингис хааны зарлигаар Зүчи надад ногдсон газар юм. Тийм болохоор Ургенчийг би бүрэн бүтэн эзэмшиж авахыг хүсэх тул чамайг бууж өгөхийг шаардсан үгээ батлах гэж даруй хагас жил бүслэн суусан билээ. Харин чи миний үгийг үл дагаж одоо нэгэнт Чингис хааны их цэрэг довтлон ирлээ. Чиний үхлийн өдөр болжээ. Нэгэнт Ургенч хот, түүний иргэд чиний мулгуу тэнэгээс болж үгүй болох цаг ирлээ. Эвдэж сүйрсэн Ургенч нэгэнт надад хэрэггүй тул одоо хэрхэхийг миний дүү Цагадай Өгөдэй хоёр мэдэх боллоо. Чи ямар жанжин болохоо үзүүлж тэдэнтэй тулалдагтүн. Харин би цэргээ үл хөдөлгөн чамайг хэрхэн тулалдахыг харж байя. Чи миний өмнөх баруун хэрмийг сахигч цэргээ эргэлзэх юмгүй татаж Цагадай Өгөдэй нарын эсрэг байлдагтүн” гэсэн бичиг хүргүүлсэн билээ. Одоо тэр цэргээ татаж байна. Төмөр-Мэлиг надад итгэжээ. Гэгээ тасартал хүлээгээд би цэргээ хөдөлгөж Ургенчид орно.

Батын энэ үгийг зөв гэж сайшаахад бэрх ажээ. Атаат дайсныхаа үгэнд итгэн нээрээ үзтэл цэргээ татан баруун хамгаалалтаа хаяж буй Төмөр-Мэлигийг ч ойлгож ядна. Ухаан зоригоороо Хорезм улсдаа цуутай Төмөр-Мэлиг жанжин Бат хөвүүний энэ томоогүй үгэнд хууртана гэхэд яагаад ч итгэх аргагүй байлаа. Бат үүнийг дахин тайлбарлаж хэлээгүй учир

Зүчи харсандаа итгэхээс өөр аргагүй болов. Ар талаа хамгаалалтгүй шахам үлдээж Цагадай Өгөдэй хоёрын эсрэг бүх цэргээ хөдөлгөсөн Төмөр-Мэлигийн үхэл ирж буйг Зүчи ойлгож, хөвүүнээ яаж ингэж чадсанд гайхаад барсангүй. Батыг хэрхэн чадав гэж гайхахын огт хэрэггүй байсан бөгөөд Бат хөвүүн нь Чингис хааны дээд удам Добу мэргэний дүү Дува сохорын сүнс байсанд хэргийн учир байсан билээ.

Түүнээс гадна Бат элч болгон илгээсэн өөрийн боол Татугаар Төмөр-Мэлигт өөр юу гэж хэлүүлснээ эцэгтээ хэлсэнгүй. Ургенчийн цэргийн удирдагч зоригт Төмөр-Мэлиг Батын энэ нууц үг, Татугийн ховсонд автсаны учир ийн цэргээ хотын зүүн хэрэм рүү шилжүүлжээ. Эсрэг этгээдийн цэргийг ховсондоо оруулан ухааныг самууруулж дуртай зүгтээ ухрааж, буцааж болох аргыг Бат, гоо ван Мухулайн дэргэд Алтан улсад жил болохдоо сэм үзэж мэдсэн билээ. Мухулай ван өөрийн дэргэд Нанги хэмээх алдартай ховсчин байдгийг хэнд ч хэлдэггүй чандлан нууцалж байжээ. Нанги уг нь Харлууд овгийн хүн бөгөөд Мухулайд аль долоон наснаас эхлэн зүтгэсэн байжээ. Нанги Зүчийн хөвүүн Батыг дагаж ирсэн Татуг хармагц түүний далд чадлыг мэдэж Мухулай эзэндээ хэлжээ. Гэвч Бат өөрийн боолыг Мухулайд худалдсангүй.

-Энэ Тату бол Зүчи эцгийн минь зүрх юм гэсэн есөн настай Батын санаандгүй хурц үгийг сонсоод Мухулай дахин ам нээсэнгүй. Зүчи Татугийн чадлыг мэдэх учраас түүнийг хөвүүндээ өгсөн биз гэж таамагласан Мухулай өөрийн бодлоос ухарч харин ховсчин боолоо хэрхэн ашиглахыг Батад сайтар сургасан билээ. Харин Тату хэмээх тэр хэдэн настай нь үл мэдэгдэх загас мэт үл анивчих нүдтэй эрийн ховсдох эрдмийн тухай энд зөвхөн Бат л мэдэх билээ. Тату өөрийн энэ далд чадлыг огт мэддэггүй байсан бөгөөд Батыг дагаж Алтан улсад очоод л сая гадарласан ажээ. Мухулай вангийн дэргэдийн ховсчин Нанги Татуд олон зүйл зааж түүний далд чадлыг илрүүлж өгчээ. Харин үүнийг мэдсэн Бат хэзээ ч хэнд ч хэлэхгүй байх тангарагийг Татугаас авчээ. Зүчи эзэн нь хөвүүнээ төрөхөд өөрийн боол Татуг Батад өгснөөс хойш тэд нэг ч өдөр салсангүй арван таван жил дөхөж өнөөдрийг хүрчээ. Ингэж ганц эзэнд захирагдах нь ховсчдын мөрдөх хууль юм. Татугийн энэ ховсдох нууцыг Зүчи ч мэдэхгүй билээ.

Хэрэв ховсдох эрдэм нь олонд ил болбол тэр бүгдийн дайсан болж амиа алдах нь энүүхэнд тул Татугийн эрдмийг ганцхан Бат мэдэж, түүний зарлигаар л илбэ шидээ үзүүлэх ёстой ажээ. Үүнийх нь төлөө Бат, Татугийн амь насыг даана. Хөндлөнгийн хүнд Тату бол Батын шадар мэт үзэгдэнэ. Зүчийн цэрэг Ургенчийн захад ирж буухаас яг хорин найман жилийн өмнө Тэмүжингийн хүрээнд нэгэн хэрэг мандсан нь Тэмүжин дүү охин Тэмүлэнээ Ихирэс аймгийн Буту гэгчид найрамдан дагасны нь шанд эхнэр болгон өгсөн явдал байлаа. Тэмүлэн энэ үед Тэмүжиний торгон цэрэг Тату гэгч залуу эрд сэтгэлтэй болсон байв. Тату бол Хасарын их хатан Борогчины дүү тул Тэмүлэний ингэж сэтгэл алдарсныг бас буруутгах үндэсгүй ажээ. Тату ч Тэмүжиний дүү Тэмүлэн охинд дурлажээ. Гэвч тэд амраглан амьдрах хувьгүй байсан юм. Тэмүлэн Татугийн тухай хэнд ч хэлж болохгүй гэсэн Өүлэн эхийнхээ хаширлан захисныг дагалгүй, Тэмүжин ах нь эцсийн эцэст түүний хайр сэтгэлийг нь ойлгон шийдвэрээ буцаана хэмээн горьдлого тасрахгүй тул өөрийн сэтгэлийн нандин нууцаа Бөртэд дэлгэж туслахыг гуйсан билээ. Бөртэ Тэмүлэний толгойг энгэртээ нааж удаан суужээ. Гэтэл гадаа Тэмүжиний ирэх сонсодсон тул Тэмүлэн годхийн гарч гүйжээ. Тэмүжин тэдний юу ярилцсаныг шууд мэдэв.

-Бөртэ. Чи бас ээж шиг Тэмүлэнг Бутуд бүү өг гэж намайг ятгах нь уу гэвэл Бөртэ цай аягалж өгөөд дэргэд нь дөхөн сууж,

-Тэмүжин. Чи Тэмүлэний хэргийг дэмий нэг хялбар явдал гэж бүү үз. Тэмүлэн Бутуд очихгүй оргон зайлах гэнэ гэв.

-Чи инээд бүү хүрэг. Тэр яаж ингэж чадна. Харин чи цаад хүн нь хэн болохыг мэд.

-Би мэдэж байна.

-Хэн бэ.

-Үгүй ээ. Чи намайг түүний нэрийг хэлэхийн өмнө нэг зүйл амла.

-Чи хэл.

-Чи түүнийг өнөө шөнө үхүүлнэ гэвэл би хэлье.

Бөртийн энэ үг Тэмүжинг ихэд цочоов.

-Чи түүнийг өнөө шөнө үхүүлэхгүй бол тэд маргааш оргон зайлах болно. Ингэвэл чиний нэр сүрэнд хар толбо болох биш үү. Тэр хүн нь чиний амь сахигч цэрэг Тату гэнэ.

-Борогчины дүү Тату гэж үү.

Тэмүжин бодолд унав. Тэр Татуд хайртай юм. Тату бол өөрөө сайн дураар зүтгэж торгон цэрэгт шилэгдэн тэнцсэн сул ард гаралтай цөөн эрсийн нэг билээ. Торгон цэрэгт зөвхөн ноёдын хөвүүд орох бөгөөтөл Тэмүжиний тушаалаар жирийн ардын хүүхдээс хүсэлтэй, ухаалаг, гавшгайг нь сонгон авах болсон байв. Тэмүжинг хамгаалах гэж үнэн сэтгэлээр зорьж ирэгсдийг тэр онцгойлон үзнэ. Тату бол хамгийн шилдэг цэрэг байв. Гурван өдөр шөнө нойр хоолгүй явж, зогсож чадах хүн ганцхан Тату билээ. Тайчуудтай хийсэн тулаанд Тату Тэмүжиний дэргэдээс огт холдохгүй гурав хоносон бөгөөд борооноос түүнийг хамгаалан халх барьж шөнөжин зогсохдоо ганцхан удаа хөлөө сольж гишгэснээс өөр хөдлөөгүйг Тэмүжин нойтон газар дээрээс үзсэн юм.

Тату бол үнэхээр шидтэй, тэвчээртэй хүн юм. Бусад нь нойрмоглон унаж байхад Тату ганцаар нүд цавчихгүй зогсож байдаг байв. Очиж очиж хамгийн хайртай торгон цэрэг нь Тэмүлэн дүүтэй нь сэтгэлийн холбоотой болсныг мэдмэгц Тэмүжин гайхан тээнэгэлзэж эхлэв. Хэрэв Ихэрэс аймгийн Буту албатуудаа дагуулан түүнд дагаж орсныхоо шанд Тэмүлэнг гуйгаагүй бол хэдий ардын хүүхэд ч Татуд дүү Тэмүлэнгээ өгөхөд татгалзах юмгүй санагдана. Гэвч хэрэг нэгэнт иймд хүрчээ. Цэрэг хүн хэдий зориг тэвчээр ихтэй, үнэнч сэтгэлтэй ч бүхэл бүтэн аймагтай дүйцэх гэж үү. Ийн санахад Бөртийн шаардсанаар Тату даруй үхүүлэх нь зөв санагджээ. Бөртэ л ингэж сийрэг ухаантай загнаагүй бол зориг ихт Тату яаж ч мэдэх билээ. Тату нэгэнт л зориглон зүтгэвэл хэнийг ч хөнөөж мэднэ. Бүр Тэмүжинг өөрийг нь ч хорлож дөнгөх билээ. Ийн санаад Тэмүжин босон харайв.

-Чиний зөв санагдана. Би одоохон Боорчийг явуулж түүнийг сэм бариульа гээд гарах гэтэл

Бөртэ дуудаж түүнийг зогсоов.

-Тэмүжин. Чи Боорчийг бүү явуул. Борогчин хэргийн учрыг мэдвэл чамд өшрөх биш үү. Боорчи тэртээ тэргүй чамтай нэр нэг. Ийм хэрэгт Хасарыг зарвал зохино. Борогчин мэдлээ ч Хасарт өшрөхгүй биз. Тэр Татуг өчиггүй үхүүл.

Ийм холын нарийн ухаан гаргах хүн Бөртээс өөр үгүй билээ. Бөртийн хэлсэн үгний цаад гүнзгий санааг ойлгоод Тэмүжин бахдалтайгаар инээж

-Бөртэ. Би чиний хэлснээр хийе. Чи бид хоёр нэг хүн болжээ гэж шивнээд гарчээ.

Тэр шөнө хайртай Тэмүлэнгээ авч оргохоор шийдсэн Татуг Хасар очиж барьж хорьжээ. Тэмүжин түүнийг арай ч алж зүрхэлсэнгүй хайрласан билээ. Тэмүлэнг Буту Ихэрэс аймаг руугаа авч явснаас хойно Татуг авчир гэж Тэмүжин хэлжээ. Тэмүжин Татуг үгээр үхүүлж өөртөө зүтгүүлж чадна гэж боджээ. Гэтэл тэр даанч хол андуурсан байлаа. Тату харгалзагч цэргүүдээс хоёрыг нь улаан гараар хөнөөж галзуу барс шиг аашилжээ. Нэгэнт энэ хэрэг ийм дуулиантай болсон тул Татуг бусдад нь сургамж болгох үүднээс олны нүдэн дээр ил цаазлахыг Тэмүжин тушаав. Хүрээний захад цаазын тавцан засаж цэргийг жагсааж ардыг цуглуулав. Тату итгэж зүтгэсэн эзнийхээ илдэнд үхэх болов. Тэмүжиний цаазнаас одоо түүнийг хэн ч аврахгүй болсныг мэдмэгц дэмий юм хийсэндээ туйлгүй гэмшиж харуусчээ. Амьд явах гэдэг хичнээн үнэтэй, хүслэнтэй болохыг сая л ойлгов. Амьд л явбал хичнээн ч бүсгүйд дурлаж, хичнээн ч бүсгүйтэй учирч болохыг мэдэв. Хайран сайхан залуу нас амьдралаа гэнэн болчимгүй үйлдлээсээ болж алдах болжээ. Өтөл муу боол атал өндөр язгуурт бүсгүйд сэтгэл алдарсан нь түүний үхлийн үр болжээ. Үүн шиг харамсал байхгүй билээ. Гэрийн үүдээр Тэмүжиний дэргэд танил хүмүүс эгнэж тэдний дунд ээжийнхээ дэргэд зогсох зургаан настай Зүчийг олж харав. Тату амьд үлдэхсэн гэхдээ Тэмүжиний энэ хөвүүн гүйж ирээд

-Тату ахыг битгий алаач. Надад өгөөч гэж орилж уйлж тэврэн аваасай гэж шаналан бодож Зүчийг ширтэж байжээ. Учир нь олон хүүхэд дундаас Тату Зүчид ихэд дотноор хандан хайрладаг байжээ. Энэ нь Тэмүлэн Зүчийг хайрладаг байснаас болсон биз. Гэтэл түмнийг гайхуулсан хэрэг болж Зүчи гэнэт ухасхийн түүн лүү гүйж ирэх нь тэр. Бөртэ хашгирав.

-Зүчи ээ. Миний хүү. Зүчи гүйн ирж сөхрөн суусан Татугийн өмнө ирж зогсоод эргэж

-Аав аа. Та энэ хүнийг битгий алаач. Та энэ хүнийг надад өгөөч. Та тэгээч дээ. Надад энэ хүнийг өгөөч дээ гэж шингэн хоолойгоор цангинуулан хашгирч гарчээ. Бүгд цочин балмагдаж Бөртэ гүйн ирж Зүчийг гэдрэг татав. Гэвч Зүчи эхтэйгээ ноцолдож Татугийн толгойг тэврээд өнөөх үгээ хашгирсаар ажээ. Тэмүжин тэдэнд ойртож ирэв. Эргэн тойронд ганцхан Зүчийн хашгирах сонсдоно. Бөртэ ухаан алдталаа айжээ. Томоогүй хөвүүн нь юу хийх нь энэ вэ. Тэмүжинг хилэгнэнэ гэж зүрх нь түг түг цохилон хөвүүнээ хамгаалах мэт тэвэрч аргадав. Гэтэл номхон томоотой Зүчи үгэнд нь орсонгүй. Тэмүжинг ойртон очмогц Зүчи таг дуугүй болов. Гэвч эцгийн өөдөөс ширтсээр байхад Бөртэ хүүгээ хамгаалан ардаа хийжээ.

-Аав аа. Та Татуг битгий алаач гэж Зүчи нулимсаа урсган шивнэв.

-Зүчи нааш ир гэж Тэмүжин дуудав.

Тэмүжин анх удаа Зүчи хөвүүнээ бахархан ширтэж байв. Тэмүжинд Татуг алах хүсэл үнэндээ байсангүй боловч Татугийн үйлдсэн хэрэг нэгэнт түүнийг өршөөж болохгүйд хүргэсэн билээ. Гэтэл Зүчи хөвүүн нь түүний энэ далд хүслийг таасан мэт хэлсэн нь Тэмүжинд хачин дотно бүр бахдалтай санагджээ.

-Тату чи сонс. Би чамайг алах ёстой юм. Гэвч Зүчи хөвүүн минь чамайг амьд үлдээхийг хүсчээ. Чи миний хөвүүнд үүрд үнэнч зүтгэнэ гэж тангараглавал би чамайг өршөөе.

-Би тангараглаж байна гэж Тату амьд үлдсэндээ итгэж ядан Зүчийн өлмийд мөргөжээ.

-Тату чи сонс. Хөвүүн минь балчир байна. Чи одооноос эхлэн Зүчийн боол боллоо. Би чамайг Зүчи хөвүүндээ өгье. Амь чинь Зүчийн гарт гэдгийг бүү март.

Тату эхэр татан уйлж байв. Тэмүжин Зүчи хөвүүнээ тэврэн өндөрт өргөв. Олон бүгдээр түрхрэн сайшааж Зүчийн зориг ухааныг биширчээ. Энэ бол Зүчийн үеийнхэн дундаас онцгойрон ялгарахын эхлэл болжээ. Үнэхээр Татуг бүү үхээсэй гэсэн хүн олон байжээ. Зүчи яагаад ингэснээ ер ойлгоогүй бөгөөд тэр үед Тату ч Зүчийг ховдсоноо мэдээгүй билээ. Тэр мөчөөс хойш Тату хэлсэндээ хүрч Тэмүлэнг үүрд мартаж Зүчийн дэргэд сүүдэр мэт явах болжээ. Батыг төрсөн өдөр Зүчи Татуг дуудан

-Энэ өдрөөс эхлэн би чамайг Бат хөвүүндээ өгье. Чи түүний дэргэдээс алхам ч бүү холд. Дэрний нь дэргэд гэрийн нь үүдэнд хад мэт зогсож халхавч мэт яв гэж тушаажээ. Зүчийн хэлсэн үг Татугийн хувьд Тэнгэрийн зарлиг юм. Ингэж Тату Зүчийг хайрлан өсгөсөн шигээ Батыг яг төрсөн эх шиг нь маллаж өсгөжээ. Тату бол Батын хувьд эцгийн нь удаах итгэлт нөхөр нь билээ. Харин Тату өөрийн ховсдох чадварыг мэдэхгүй байсан бөгөөд Зүчийг түүнд Тэнгэр илгээсэн гэж итгэж биширч явжээ. Жамухын шадар Хантөмөрийг унтуулж Зүчи Цагадай хоёрыг оргуулан авчирсан, Наймантай хийсэн тулаанд Зүчийг гарцаагүй үхлээс аварсан гээд түүний ховсны хүчээр болсон олон хэргийг тэр таамагласангүй иржээ. Хэдий өөрийн нууц чадлыг мэдсэн ч Тату Батад үнэнч зүтгэх сэтгэлээ хувиргаагүй юм. Угаас тэр Зүчид үнэнч зүтгэх тангарагтай бас энэ тангарагаа Батад өгсөн билээ. Татугийн ховсонд хэнийг оруулж яаж ашигласан нь зөвхөн Бат тэр хоёрын л нууц болж үлджээ. Тату Батыг хэлээгүй бол хэнийг ч хэзээ ч үл ховдоно. Батын үг Татугийн хувьд Тэнгэрийн цааз юм. Бат эхний үед хүүхдийн томоогүй аашаар олон болохгүй хэргийг Татугаар хийлгэжээ. Аз болоход ховсдуулсан хүн үүнийгээ үл мэддэг нь Бат тэр хоёрт завшаан болжээ. Бас Тату хаширч ухаажсан хүн тул нялх хүүхдийн үгээр юунд бүгдийг хийх билээ. Хэн нэгэн Татугийн ховсонд орохгүй бол Бат ихэд уурладаг байлаа. Хорезмд мордохын өмнө болсон найран дээр Тату өөрийн чадлыг үзмээр санагдсанд анх удаа өөрийн хүслээр хийжээ. Чингис хаан өөрийн их хуланд айраг дүүргээд өргөө дүүрэн суусан ихэс дээдсийн дэргэд Батыг дуудан өгсөн нь чухам гайхамшигтай явдал болсон билээ. Чингис хаан хэзээ ч хэнийг ч ингэж онцгойлон үзэж байсангүй тул Бөртэ нүдэндээ итгэсэнгүй. Зүчи Бат хоёрын баяр бахдал хязгааргүй болжээ. Хайртай хоёр эзнээ ингэж баярлуулсандаа Тату их жаргалтай байлаа. Харин өөрийн энэ үйлдлээ Чингис хаан ойлгосонгүй уджээ. Юуны учир Батыг олны өмнө онцгойлох болсноо удтал боджээ. Тэгээд Зүчийн өмнө өөрийгөө буруутай гэж бодсоноос ингэв гэж ойлгожээ. Ач нар дотроосоо Батыг онцгойлон үзсэн нь харин ч аятай зүйтэй хэрэг болов гэж баяртай

байжээ. Чухам ингэж Батыг олны өмнө өргөмжилсөн нь Тэнгэрийн зарлиг биз гэж итгээд Батыг ихэд тоох болжээ. Татугийн анх удаа өөрийн хүслээр хийсэн энэ ховс хожим хойно Батын амьдралд ямраар нөлөөлөхийг таах аргагүй билээ.

Харин энэ удаа Ургенчийг хамгаалагч Хорезмын жанжин Төмөр-Мэлигрүү Татуг явуулсан нь Батын санаа бөгөөд дайсны хүрээнд илгээсний анхных болжээ. Цагадай Өгөдэй нар Чингис хааны зарлигаар цэрэглэн ирж тэднээс Ургенчийг булаан авсныг эсэргүүцэх сэтгэл Батыг ийм алхам хийхэд хүргэв. Эцэг нь Ургенчийг дайлах цэргээ засахыг түүнд зөвшөөрснийг эцэг нь түүнээс аврал эрсэн хэрэг гэж Бат үзжээ. Хайртай эцэг нь ямар гарал цустай, яаж зовж шаналж амьдарсан, эцэст нь яаж доромжлогдон гутаагдсаныг Бат шиг гүнзгий ойлгож, гуниж бухимдсан хүн үгүй байв. Хэлсэн үг хийсэн үйлийнх нь төлөө Чингис хааныг, Цагадайг ч тэр үзэн ядаж байв. Гэвч тэр юу ч хийж үл чадна. Харин одоо Ургенчийг бусдад алдахыг хүссэнгүй. Ургенчийг бусдад алдсанд орвол юу ч үлдээхгүйгээр сүйрүүлэх нь дээр гэж үзжээ. Бас Цагадай, Өгөдэйн цэрэг ч хохирохыг юманд үл тоов. Татуг Төмөр-Мэлигт илгээсэн нь Батын хийсэн хамгийн анхны осолтой шийдвэр байв. Төмөр-Мэлиг Татугийн ховсонд автахгүй бол Тату үхэх нь гарцаагүй. Байдал, үр дагавар нь аюултай хэдий ч Бат зорьж шийдсэнээсээ ухарсангүй. Бат угаас хүний санаагүйг санаж хийгээгүйг хийх дуртай хөвүүн байлаа. Энэ чанар нь ийм хэцүү осолтой хатуу шийдвэр гаргахад хүргэв. Бүх юм санаснаар болж Төмөр-Мэлиг Батын илгээсэн элчийн үг болоод захидалд итгэв. Захианд дурдсанаас гадна Тату ганц Төмөр-Мэлигт сонсдохоор хэдэн үг нэмж хэлжээ.

-Цагадай Өгөдэй нар хэдий миний дүү ч гэлээ надтай өрсөлдөн тэмцэлдэгчид юм. Иймд би өөрийн хотыг тэдэнд өгөхийг үл хүснэ. Чи ар талдаа санаа зовох юмгүй тэдний эсрэг байлдагтун. Чи тэднийг ухрааж чадвал аз чинь болог. Тэднийг ухарсаны хойно чи надад бууж өгвөл би чамд хуучин эрх ямба харьяат цэргийг чинь үлдээж дэргэдээ авъя. Эс тэгвэл чамд хэний сэлмэнд үхэх чинь хамаагүй биз. Би өөрийн үгний баталгаа болгож дотно шадраа чамд илгээв. Би хэрэв цэрэг хөдөлгөн чамайг довтолбол миний элчийг цавчин алагтун гэсэн Батын үгийг Зүчийн нэрийн өмнөөс Тату Төмөр-Мэлигт өчжээ. Эхний өдөр Зүчи нээрээ цэргээ хөдөлгөж Ургенчийг баруун талаас довглоогүй нь итгэхэд хүргэсэн ч дайсандаа итгэнэ гэдэг үхэлтэй адил гэдгийг хашир Төмөр-Мэлиг юу эс андах билээ. Төмөр-Мэлиг Зүчийн элч Тату дэргэдээсээ үл холдуулав. Зүчийн зүгээс ганц цэрэг ч болов довтлон ирвэл түүнийг алахыг тушаажээ. Зүүн талаас Цагадай Өгөдэй нарын довтлох дийлдэшгүй болоод цэргийн хагасыг хотын баруун жигүүрт барих нь байдлыг хүндрүүлж цэргийн эсэргүүцлийн хүчийг сулруулсаар байв. Гэтэл тэр Феридон-Гүр жанжнаа эсэргүүцсээр байтал баруун цэргээ татаж Өгөдэйн өөдөөс тулалдахыг тушаав. Энэ нь Төмөр-Мэлиг Татугийн ховсонд орсных байлаа.

Энэ бүх нууцыг Бат эцэгтээ дурссангүй. Үнэхээр Ургенчийн баруун хэрэм эзгүйрч цөөн цэргээс өөр хамгаалалт үлдсэнгүй. Хүч нэмэгдсэн дайсны эргүүцэлтэй тулсан Өгөдэйн цэрэг ихээр сүйрэх боллоо. Бат шөнө болохыг тэвчээртэй хүлээнэ. Зүчи ч хөвүүнийхээ энэ залыг аргыг сайшаав. Шөнө дунд өнгөрч сар жаргахад Зүчи Бат хоёрын цэрэг Ургенчийн хэрмийг төвөггүй эвдэн онгойлгоод сэм урсан орлоо. Хотын тал нь даруй эзлэгдэж харин Төмөр-Мэлигийн цэрэг шивээлсэн хотын зүүн дүүргийг Бат бүхэлд нь галдан шатаахыг тушаав. Галд хуйхлагдаж үхэхээс зугатсан олон цэрэг хэрмээс гадагш үер мэт довтолсонд Өгөдэй, Цагадайн цэрэг хориглож эс чадаад хойш ухрахад хүрэв. Гэвч Өгөдэй “үхлийн цэрэг” нэмж оруулсан тул Хорезмчууд даруй хоорондоо алалдан сүйрчээ. Энэ гал, цусны тулаан долоон



өдөр долоон шөнө үргэлжилж Ургенчийн үлдсэн цэрэг бууж өгөв. Урчууд дархчууд, эмс хүүхдээс бусдыг нь хядаж, Бат Ургенч хотын усны даланг эвдэн Аму Дарья мөрний усыг хотод оруулснаар үлдэгсэд бүгд живж үхжээ. Ургенчийг хэнд ч өгөхгүй гэсэн амандаа Бат ийн хүрэв. Төмөр-Мэлиг Зүчид хууртсандаа өөрийгөө хараасаар үхжээ. Үхэхийн өмнө Зүчийн элч Татуг шатаасныг Төмөр-Мэлигийн олзлогдсон цэргүүд хэлжээ. Хэд хоногийн турш хайлгасан боловч хөөрхий үнэнч Татугийн яс үс ч олдсонгүй нь энэ удаа түүний ховс амийг нь аварч чадсангүй үхсэн бололтой. Зүчи Бат хоёр эцгийгээ алдсан мэт өнчрөн гашууджээ. Гэвч Бат Татугийн үхсэнд итгээгүйгээр барахгүй цөхрөлгүй эрж хайсаар байжээ.

Ургенчийг авсан тулаан энэ мэт дуулиан, хэрүүл дагуулж, Монголын олон мянган цэргийн амийг авч өндөрлөв. Гэтэл Ургенчийг авсан тулаан ингээд дууссангүй. Ургенчийг авмагц цэргээ татан ирж нийлэх тухай Чингис хааны зарлигийг эхлээд Өгөдэй дараа нь Цагадай даган өмнө зүг хөдөлжээ. Харин Зүчи “Өөрийн эзэмшил нутаг орон, хот газрыг тохинуулна” гэж хэл өгөөд Ургенчээс хойд зүг Каспийн тэнгисийн зүүн биеэр хөдөлж замд таарсан жижиг хот балгасыг эзлэн явжээ. Хэдий Ургенчийг Бат эзлэн авсан ч оногдох нэр гавьяа нь Өгөдөйд очсонд Зүчи туйлын их харамсчээ. Бас Батын учир нь үл ойлгогдох хачин шийдвэрээс болж Өгөдэй Цагадай нарын зүгээс гомдол санал гарахыг ч тэр мэдэж байв. Үнэхээр Өгөдэй Цагадай хоёр уур хилэн дүүрэн буцжээ. Зүчи, балчир хөвүүн Батдаа цэргээ удирдуулж хотын гурван талаас зэрэг довтлох шийдвэрийг зөрчин алгуурласнаас болж олон цэргийн амь сүйдсэн гэж тэд үзжээ. Тэд үүнд Батыг биш Зүчийг буруутгана. Энэ бол Чингис хааны зарлигийг зөрчсөнтэй адил явдал болжээ. Хөвүүдийн хоорондох зөрчлөөс үүдэн Ургенчид юу гээч болсныг Өгөдэйг очихоос өмнө Зүчийн дэргэд байсан тагнуул нууц элч илгээн Чингис хааны сонорт хүргэсэн байлаа.

Чингис хаан хөвүүддээ тэр дундаа Зүчид ер ингэж хилэгнэж байсангүй. Нэг муу өчүүхэн өнчин балгасыг санал нэгдэн эзэлж авч чадалгүй олон цэргийн амь сүйрүүлсэнд хилэгнэж Өгөдэй Цагадай хоёрыг бараалхуулахгүй хэд хонов. Чингис хааны дэргэд байх Боорчи, Шихихутаг болоод шадар, хорчингууд ятгаж ядаад үгээ баржээ. Чингис хаан хөвүүддээ хилэгнэхээс илүү тэднийг яаж гэсгээх аргаа олохгүйдээ ингэж олон хоног хилэгнэсэн дүртэй суусан билээ. Бодож бодож хэргийн учрыг нарийвчлан сонсоод гол буруутан нь Зүчийг гэж үзээд Өгөдэй Цагадай хоёрыг өршөөжээ. Тэд ч өөрсдийгөө цагаатгахын тулд муу үг хайрласангүй. Өөрийн буруутан гэдгээ батлах гэсэн мэт Зүчи түүний зарлигийг дагаж цэрэгтэйгээ ирж нийлсэнгүй зун өнгөрч намар болжээ. Чингис хаан Зүчийг мартсан мэт болоод сэрүү ормогц цэргээ хоёр хуваан Инд мөрний баруун зүүн эргээр урагшлуулж Хорезмын үлдсэн цэрэг сүйрсэн хаан Желаладдинийг нэхэн Энэтхэг газрын гүн рүү довтолж одов. Харин Зүчи нутгийн бууж өгсөн цэргээр хүчээ сэлбэж даруй зургаан түмэн цэрэгтэй болж Каспийн тэнгисийн зүүн, зүүн өмнө талын нутгийг бүхэлд нь эзлэн авахаар довтолж эхлэв. Энэ бол түүний өөрийн дур хүслээр хийж буй дайн байлаа. Энэ бол Зүчи үндсэндээ Чингис хаанаас тусгаар явах болсноо баталсан хэрэг юм. Ингэснийхээ төлөө ямар ч гэсгээл цаазанд унахаас тэр эмээсэнгүй. Учир нь Зүчид анх удаа өөрийн эзэлж авсан нутгаа захиран өөрийн улсыг байгуулах боломж олдсон нь энэ юм. Үүний төлөө амиа үрэхэд бэлэн байв. Жил гаран болоход Зүчийн эзлэн авсан нутаг даруй хоёр дахин нэмэгдэв. Гэвч тэр үүнд сэтгэл ханасангүй. Харин ч Бат хөвүүн нь Кавказын нурууг давж Сүбээдэйн хамт баруун зүг довтолхыг хүсчээ. Харин Зүчи зэргэлдээх Хивчаг аймгийг эзлэн Уралын нуруунаас баруун тийш орших Оросын хотуудыг нэгтгэн авахаар төлөвлөж байлаа.

Каспийн тэнгисийн зүүн хэсгийн нутгийг эзлэн авч дуусгасан нь 1223 оны өвөл болжээ. Эзлэн авсан нутгийн хил хязгаарт харуул томилон суулгаж нутгийн хотуудад хууль цааз, гааль татварын журам тогтоон нэгдсэн улсын хэлбэрт оруулах ажилдаа Зүчи нутгийн иргэдээс дагаж орсон хүмүүсээс шилж сонгон хэрэглэж байлаа. Тусгаар улс болон суухыг хүсэгчид түүний дэргэд нэн олон болсон нь Зүчийн сэтгэлийг бадрааж итгэлтэй болгоно. Зүчи одоо Чингис хаанаас тусдаа суухаар эргэлт буцалтгүй шийджээ. Чухам ингэж суу хэмээн Чингис хаан түүнд нутаг хот зааж өгсөн биз хэмээн өөрийн зоргоор үйлдлийг зөвтгөн бодож бас өөрийгөө зоригжуулж байв. Чингис хааны зүгээс сайн муу хэл аль нь ч ирсэнгүй хэсэг зуур таг чиг болсон нь Зүчийг санасанаа тайван гүйцэлдүүлэх сайхан боломж олгожээ. Гэвч түүний итгэлт шадар Хунан сар бүр нууц элч зарж Зүчийн хүрээнд юу болж байгааг Чингис хаанд илтгэж байгааг тэр таамаглахгүй байв. Өөрийн үйлдлийг сэм илтгэх тагнуул дэргэдээ байгааг Зүчи гадарлаж байсан ч хамгийн итгэлт ахмад жанжин Хунанг байна гэж огтхон ч сэжиглэсэнгүй. Тэгээд Чингис хаан мэдлээ ч Зүчи айж нэрэлхэхгүй болжээ. Каспийн тэнгисийн зүүн өмнөд эргийн Авралт булангаас арван бээр зайтай үзэсгэлэнт сайхан Алагтуу уулын уужим бэлийг авируулан хараа бараа сайтай өндөр газар сонгон авч өргөөгөө босгон суув. Зүчи энд өөрийн хаан ордыг байгуулахаар нутгийн урчуудыг дайчлан авчирчээ. Шатааж сүйрүүлсэн Ургенчээс дутахгүй үзэсгэлэнтэй сайхан хот босгох хүсэлд Зүчи Бат хоюул адилхан авгжээ.

Харин Батыг Монголд илгээхээр шийдэв. Монголд үлдсэн хатад хүүхдүүд нааш ирэх хүсэлтэй чадалтай албатуудаа нүүлгэн авчрах ажлыг түүнд даалгахаар тогтов. Бас Бөртэ эхдээ хэргийн учрыг дуулгаж үгийг нь сонсохыг ч хүсэв. Бат нутагтаа очих хүсэл их байсан ч бас энд хоргодон үлдэх сэтгэл төрж байсанд нэг учир бий билээ. Каспийн тэнгисээс цааш нутаглан суух Хивчаг аймгийн хан Хотиан, Кавказын нурууг даван хөрш Асу аймагт цөмрөн орсон Сүбээдэйн цэргээс айхдаа Зүчитэй найрамдахыг хүсч үзэсгэлэнт Герта гүнжээ их бэлэг, араб үүлдрийн агт морьдын хамт элчээр хүргүүлснээс Герта гүнжийг нь Зүчи Бат хөвүүндээ өгсөн байв.

Тэр хэзээ ч ийм үнэт бэлэг авч байсангүй. Герта бол уг гарал нь хойд Оросын нэгэн аймгийн эзэн Долгорукий вангийн удам бөгөөд түүний эхийг арван зургаан настайд нь орос жанжин Местслав гэгч Хивчагуудтай найрамдахдаа бэлэг болгожээ. Герта Хивчаг аймагт төрсөн, орос түрэг цус холилдсон алтан шаргал үстэй, алаг цэнхэр нүдтэй, нуруу өндөр, хөх том, гуя зузаан чухам шим шүүс нь нэвт гэрэлтсэн бүсгүй байв. Хоёр насаар ах янаглах эрдэмд гаргууд Герта гүнж Батын бие сэтгэлийг эзэмдэн булаажээ. Ийм амраг бүсгүйгээс хагацна гэхэд Багад их л гачлантай байхыг Зүчи мэдэрчээ.

Зүчи дахиад л хөвүүнийхээ аяыг дагав. Монголын нутагт ер үзэгдээгүй өнгө төрхтэй эмээ дагуулан явахыг Зүчи зөвшөөрсөн нь залуу Багад чухам Тэнгэрийн хишиг шиг санагджээ. Хөвүүнээ баярлахыг үзээд Зүчид үнэхээр жаргалтай байлаа. Багадаа үзэж эдлээгүй аз жаргалыг нь Бат хөвүүн нь дүүрэн эдлэх ёстой гэж Зүчи дандаа хичээх бүлгээ. Батын төмөр дугуйтай сүйх болоод хамгаалах таван зуун цэрэг бэлэн болж нутгийн зүг сүр бараатай үдүүлэн хөдөллөө. Зам хол бартаатай лав хэдэн сарын явдал болох биз. Хэд хоногийн өмнө Зүчийн Бөртэ эхдээ өгөх бэлгийг ачсан хөсөг монголын зүг хөдөлсөн юм.

Бат, Монгол нутагтаа очоод юу хийх, хэнийг нүүлгэн авчрахыг зөвхөн эцэг хүү хоёр л мэдэж

байв. Ингэх нь зөв гэж тэр үзсэн билээ. Хөвүүнээ явуулж нэг чухал хэрэг бүтээгээд Зүчи өргөөндөө сая л нэг тухлан амрах шиг болжээ. Өөрийн байдал гаргасан шийдвэр цаашид хэрхэхээ тайван тунгаан бодох цаг өмнө нь ер олдоогүй мэт. Одоо Зүчи бага биш нутгийг эзлэн авчээ. Баруун зүгт Кавказын нуруу Арал тэнгисийн хойгуур давшвал шууд Киевийн Орос улсад цөмрөн орж, Газар дундын тэнгис хүрэх зам шулуун ажээ. Мөн хойт зүг Урал мөрнийг гатлан Уралын нуруунаас баруун талаар давшвал оросын олон тусгаар хотуудыг эзлэн хойт хүйтэн тэнгис ч хүрч болох зам нээлттэй. Ийм учраас Зүчи өнөөдрийн байдлаар хамгийн ашигтай нутаг орныг эзлэн авчээ. Тийм учраас хэдэн жилдээ өөрийн хүчийг бэхлэн нутгийн цэргүүдийг сургуулилж бэлдэх, өөрийн цэргийг амраах, олз омгоо хувааж тэдний урмыг сэргээх боломжтой, иргэд харьяатаа Монголоос нүүлгэн авчирч суурьшуулах гээд хийвэл зохих олон ажил овоорчээ. Гэвч Зүчи цуцаж ядарсангүй. Түүнийг өөрийн тусгаар улсыг байгуулах их хүсэл хөтөлж, тэр нойр хоолыг умартсан мэт эзэлсэн нутгаараа дөрөө мултлахгүй явж хэрэг заргыг шүүж хэрэм хотыг төвхнүүлж шинэ амьдралыг төлөвшүүлж байлаа.

Энэ зуур Монголын их цэрэг Энэтхэг рүү цөмрөөд буцаж эргээгүй байсан тул Зүчид тайван амар өөрийн улсыг бэхлэх цаг олджээ. Зүчи өөрийн шинэ хотод “Алтан ордон” гэж нэр өгсөн бөгөөд түүний улс “Алтан ордны улс” гэж дуурсагдах болно гэж шийджээ. Гэхдээ үүнийгээ хараахан зарлаагүй хүлээсээр байгаа бөгөөд ингэх нь Чингис хааны зүгээс түүний тусгаар улс байгуулахыг юу гэж үзэх нь тодорхойгүйтэй холбоотой билээ. Чингис хааны дуудсан зарлигийг хэрэгсэхгүй орхиж Ургенч хотын дэргэдээс өөрийн замыг хөөснөөс хойш Зүчи эцэгтэйгээ уулзалгүй даруй хоёр жил болж 1224 оны хавар Бат эх нутгаас инээд хөөр дүүрэн эргэн иржээ. Батаас талын сэрүүн салхи таана айраг ханхалж байв. Монголоос ирэх нүүдэл хүний тоо тодорхой болж тэдэнд суух нутаг газрыг бэлдэх ажил Батын ирсний маргаашнаас ундарч эхлэв. Гэвч эцэг хүү хоёр хамгийн гол юмаа яриагүй байв. Бөртэ эх нь юу гэж хариу хэлсэн бол гэхээс Зүчи сэтгэл түгшин асууж эс түвдэнэ. Батад ч гэсэн шууд ам нээн ярихад тийм ч хялбар бус байлаа.

Батын цуваа Чингис хааны их өргөө суурин хүрээ байрлах Туулын хөндийд очиход урьд өдөр нь Тулуйн Иранаас илгээсэн элч дөнгөж ирээд хөл хөдөлгөөн ихтэй байжээ. Нутгаас гарснаас хойш таван жил шахахад монголын тал нутаг Хэрлэн, Туул, Орхон голуудын хөндийд олон зүйл өөрчлөгджээ. Анх Хорезмд одоход оргүй хоосон байсан газарт одоо түм илүү хүн байнга суух хот Туул голын Хүн чулууны хөндийд босчээ. Айл болгоны үүдэнд хар нөмрөг битүү өмссөн зарц боол бөхөлзөж, мужаан дархчуул ажиллах нь Хорезмоос илгээсэн олзны хүмүүс ажээ. Перс газрын үнэт хивс эдлэл газраар хөглөрч морь малын тохом болжээ. Батын бэлэг монголчуудад төдий л сонин биш, тэд угаас баруун зүгийн баялагт бялуураад байжээ. Харин Батын дагуулан ирсэн хулсан шар үстэй, цэнхэр нүдтэй Герта гүнжийг барьж үзэх нь холгүй, морьтой явган хушууран дагаж, цэрэг хамгаалалтад саад учруулав. Батыг хамгийн их хүлээсэн хүн нь Бөртэ байлаа. Бат Эрчис мөрний хөвөөн дэх эцгийн хүрээнд очиж Уги хатан ижийдээ золголгүй шууд Чингис хааны өргөөнд ирсэн билээ. Уги бол Бөртэ өөрийн хүслээр Зүчи хөвүүндээ сонгон авч өгсөн Хонгирадын Элчи ноёны охин, Бөртэ хатны ойрын хамаатны удам билээ. Тийм учраас аль ч талаар бодсон эхлээд Бөртэ эмэгдээ очиж золгох нь Батын зөв байв. Ингэхийг нь Зүчи захисан юм. Чингис хааны төв хүрээ, гол улсаа сахин суух Тэмүгэ ноён Батыг хамгийн дээд хүндэлээр угтан тосч авахаар бэлдсэн ажээ. Баруун зүгт байгуулсан их ялалтын амьд гэрч болон ирж буй Бат, Чингис хаан их дайнд мордсоноос хойш дөрвөн жил

гаран хугацаанд дайны талбараас нутагтаа эргэн ирж буй хамгийн том зочин байлаа.

Тэмүгэ ноён өөрийн торгон цэргээ гурван өртөө газраас угтуулан жагсаагаад тосч байв. Яг л Зүчи өөрөө эргэн ирсэн мэт төв нутаг даяар угтан авсан нь Батыг туйлын ихээр догдлуулжээ. Өнгөрсөн дөрвөн жил гарны хугацаанд Бат танигдахын аргагүй өөрчлөгдөөд зогссонгүй дэргэдээ харь цусны хатан дагуулсан залуу гацуур шиг гоолиг сайхан эр болсон нь түмний нүд булааж байв. Харин Батыг дагалдсан их хүндлэл, талын нүүдэлчин монголчуудын сонин ахуй төрх Герта гүнжийг гайхашруулан баярлуулжээ. Хатуу тавилангийн эрхээр түүнд заяагдсан эр нөхөр нь анхлан санасанчлан талын зэрлэг догшин удмын балчир хөвүүн биш харин их хааны ач хүү гэдгийг сая л нэг нүдээр үзэж мэдээд Герта дахин өөрийн амьдралдаа харамсан гунихгүй гэж эрс шийджээ. Тэмүгэ ноены хийсэн их найрын дараа л Батад эмэг эхтэйгээ тухтай ярих цаг олджээ. Батын үг бүр Бөртэд сонин, бас аймшигтай сонсоно. Хөвүүд нь эцгийнхээ хамт их ялалтыг олжээ.

Харин эхлээд Зүчи хөвүүнээ Чингис хааны зарлиг зөрчин хойш үлдэж тусдаа суугааг нь зөвтгөж чадсангүй. Бас Чингис хаан ингэлээ гэж Зүчид хилэгнэн бухимдаагүйд ихэд сэжиглэн гайхжээ. Ийм хэргийг Чингис хаан зүгээр өнгөрөөнө гэхэд даанч санаанд багтамгүй ажээ. Тэмүжин чухам юу сэдсэнийг хэн ч таахын аргагүй билээ. Зүчи хөвүүн нь үзэж хараагүй хүний нутагт Каспий хэмээх их тэнгисийн хөвөөнд үүрд суухаар хатуу шийдсэнийг Бөртэ Батын үгнээс олж мэджээ. Зүчи энэ үгийг хэлүүлэхдээ эхээсээ зөвшөөрөл, тусламж эрсэнгүй, зүгээр л хүндэтгэх сэтгэлийн үүднээс эртлэн дуулгаж байгааг ч ойлгов. Бөртэ юу гэхээ мэдэхгүй байв. Ер нь юу ч гэх билээ. Одоо Зүчид юу хийе гэнэ түүний дурын хэрэг болжээ. Зүчийн бие даан улс засах эрхтэйн баталгаа болсон Бат хөвүүн өмнө нь сууж байхыг Бөртэ харж байв. Ийм хөвүүний төлөө далайг ч болов гаталж уулыг ч болов нүхлэх багадна. Зүчи хөвүүнээ өөрийн улсыг байгуулж Чингис хаан эцгийн адил нэр алдраа дуурсгаасай гэж Бөртэ хүсчээ. Зүчийн үгийн учрыг, түүний алс цаад бодлыг мэдмэгц Бөртэ анх удаа Зүчи хөвүүндээ сэтгэл зовинохгүй болов. Зүчи хөвүүн нь өөрийн их цэрэгтэй иргэн улстай өмгөөлж хамгаалах зориг хүч төгс хөвүүдтэй болжээ. Зүчийн хөвүүдийн сор болсон Батыг хараад Бөртэ бахархаж ханахгүй байлаа. Чингис хаан Зүчийг зэмлэж буруутгахгүй чимээгүй байгаа нь лав түүнийг тусгаар улсаа байгуулахыг битүүдээ дэмжсэн хэрэг гэж эцэст нь Бөртэ итгэв. Тэмүжин хэрвээ дэргэд байсан бол Бөртэд хэлж ярих юм хичнээн их байна гэх вэ. Гэвч одоо түүнд өөртөө бас Зүчид итгэх л үлджээ. Бодоод бодоод Чингис хаан Зүчийг буруутгах үндэсгүйд итгэн сэтгэлээ амраав.

-Хөвүүн минь юу хийнэ. Өөрөө мэдэг. Чингис хаан эцэг нь ч сайшаан дэмжих биз гэж Бөртэ баясгалантай хэлжээ. Учир нь Өгөдэйг хаан сууринд залгалжлан суулгахаар сонгосноос хойш Бөртийн сэтгэлийн дотор хуримтлагдан зовоож байсан түгшүүрт бодлууд Батыг үзмэгц замхарч хавар цагийн шинэ соёолох ногоо шиг идэр залуу, ид хавтай ач хөвүүдээ өсч томорсныг үзэхэд Чингис хаан болоод Зүчи, Цагадай, Өгөдэй, Тулуй хөвүүдийнх нь залгамж халаа нэгэнт хүчээ авч, урьдын зовлон түгшүүр ул болон элэгдсэнийг мэджээ. Одоо Бөртэд ер санаа зовох юм үгүй мэт санагдана. Зовлонт амьдралын эцэст хөвүүд нь тус тусын их улсыг байгуулан суухыг үзэх хувьтайдаа баясна. Ийм их хувь заяа эх хүн бүрт олдохгүй биз. Бөртэ энэ жил жаран нэгэн нас хүрч байлаа. Гэвч их хааны эзгүйд даруй таван жил шахам хааны ордны доторхи эрхийг барьж Тэмүжиний отгон дүү Тэмүгэгийн хамт ер ажрах сандрах зүйлгүй төв улсаа захиран суусаар байжээ. Бөртийг ард үлдсэнд Чингис хаан ч санаа сэтгэл

тайван байх билээ. Хулан хатныг Хорезмын нутагт тансаг ордонд суух болсныг мэдэж байсан ч түүний тухай ёсыг бодон асууснаас хэтэрсэнгүй. Бас Ургенчийг эзлэн авахаас болоод хөвүүдийнхээ дунд үүссэн хэрүүлийг гадарлаж байсан ч ухаж сонирхсонгүй. Учир нь Чингис хаан “Хээрийн үйлийг хээр шийтгэ.Гэрийн үйлийг гэрт шийтгэ” гэж сургасан тул энэ хэргийг нэгэнт болоод өнгөрсөн явдал гэж үзжээ. Харин Зүчийг өршөөсөн Чингис хаанд ихэд талархжээ. Зүчи хөвүүнээ тусгаар улс байгуулан суухыг дэмжиж өдөөснөөр юунд хүргэж болохоо Бөртэ тэр үед ухаарсангүй. Харин Батын өгсөн болоод Зүчи хөвүүний нь илгээсэн бэлэг дотроос Хивчаг аймгийн бие өндөр, бөгс том арван залуу охин хамгийн ихээр баярлуулжээ. Учир нь Бөртэ эм бие нь хөгширч дур тачаал буурсан ч бусдыг тэр дундаа залуу эмс охидыг өөрийн нүдний өмнө эрчүүлд эдлүүлэн харж дураа тайлах донд авгах болжээ. Тийм учраас өөрийн ордны дэргэд залуу шивэгчдийг олноор байлгаж шөнөд нь дотоод өргөөндөө авчран, шилсэн идэр эрчүүлд өгч эдлүүлэн цэнгэдэг байв. Хэрэв дургүйцсэн юм уу, энэ явдлыг ил тод илчлэхийг оролдогсдыг зүгээр л алуулж орхидог тул эмс, залуус Бөртийн үг харцаар байх бүлгээ. Эзэлсэн дайлсан улсуудаас үс зүс өөр, харь цусны бүсгүйчүүдийг авчруулан хэрхэн янаглахыг харж дарс шимж суух нь Бөртийн хамгийн дуртай цэнгэл юм. Чингис хаан ч Бөртэ хатныхаа энэ цэнгэлийг сайшаан хөхүүлэх тул түүнд харийн нутгаас эмс охид илгээхээ мартдаггүй байв.

Бөртэ эмэгтэйгээ уулзсаны маргааш нь Бат өөрийн хүрээнд буцжээ. Зүчи эзэн нь хол газар харийн нутгийг эзлэн сууж албат иргэдээ нүүн ирэхийг тушаасныг нүүдлийн ая даахгүй хөгшдөөс бусад нь талархан угтаж их нүүдэлд бэлдэж хөлтэй нь хөлхөж хөлгүй нь мөлхөж эхэлжээ. Идэр, Дэлгэрмөрөн, Эг, Шишгэд голын сав нутгаар суурьших Зүчийн унаган албатын чадалтай хөлтэй нь Каспийн тэнгисийн зүг нүүхэд бэлэн болжээ. Нүүдлийн түрүүч хөдлөхөөс өмнө Бат буцахаар бэлтгэв. Буцахын өмнө эмэг эхтэйгээ заавал уулзах ёстой тул Бөртийн өргөөнд очжээ. Бат Монголд ирээд сар болох хугацаанд Бөртийн сэтгэлд нэн их өөрчлөлт оржээ. Зүчийн иргэд алс хол Хивчаг аймаг, Каспийн тэнгис хэмээх их усны зүг нүүх чимээ төв монголын нутгаар нэг тархаж хамаг улсын чихийг дэлдийлгэж нүдийг бүлтийлгэжээ.Албат иргэдээ нүүлгэн аваачих тухай Бат уулзахдаа дурдсангүйд Бөртэ нэг их юм бодсонгүй. Зүчи хөвүүн нь санасандаа хүрч өөрийн тусгаар улсыг байгуулан суухаар сэтгэл зориг шулуудсанд Бөртэ туйлын баяртай болжээ. Харин энэ баярын сэтгэлийг цочирдуулсан нэг явдал болов. Чингис хааны эзгүйд ахуй амьдралын олон хэргийг Бөртэ, улсын их хатны хувьд шийдвэрлэж зовсон гачигдсан иргэд албат бараалхан тус аврал эрэх нь элбэг билээ. Энэ бол Бөртийн толгой даан шийддэг олон хэрэгт хамаарах тул аль олон жилийн өмнө Есүхэйн гэрт ирснээс хойш хийж дадсан ажил байв.Их хатан Бөртэд бараалхана гэдэг хэр баргийн хүнд тийм ч амар тохиох хувь биш юм. Ордны даамлууд олон түшмэл чербийн давааг давж онцгой хүндэтгэх шалтгаантай цөөн иргэд л Бөртэ хатны их өргөөний босгыг алхах бүлгээ. Бас Тэмүгэ ноён ихэнх хэргийг хамаарах тул түүнд хандагсад бүр ч олон ажээ. Ийм нэг хуваарьт өдөр Бөртэд Бичэлдэй гэгч залуу цэрэг бараалхах болжээ. Өргөөний их даамал илтгэснээс үзвэл энэ Бичэлдэй нь Бөртэ хатанд бараалхахаар олон хоног хүсэмжилсэн, ордны гадуур харуулын цэрэг ажээ.

Газар дээр цор ганцаар өнчин бас Бөртэ хатанд хувийн зүгээс өргөх айлтгал хүсэлт бий гэснийг сонсоод Бөртэ бараалхуулахыг зөвшөөрчээ. Алс газар их дайнд одож олз олж баяжих, гавьяа байгуулж мөнхрөхийг хүсэгчид ордны хамгаалалт, эх нутгаа сахин үлдсэн цэрэг эрсийн дотор олон байдаг бөгөөд тийм л оргилуун сэтгэлтний нэг биз гэж Бөртэ тааварлаж

боджээ. Орж ирэхийг үзвэл өндөр нуруутай мөр тэгш чухам л торгон цэрэгт таарсан залуу байв. Хүүхэд нялх төрхөө алдаагүй царай нь нүдэнд дулаан яагаад ч юм бэ нэг л танил төрхтэй тул хэний хүү байх вэ гэж бодсон билээ. Залуу цэрэг дор сөхрөн мөргөж

-Намайг Бичэлдэй гэдэг. Би ордны гадна харуулын албаны цэрэг юм. Их хатан танд аминчлан хэлэх үг байна гэж өргөөнд байх их даамал шивэгчин бүсгүйн зүг хяламхийсэн нь хэлэх үгээ хэнд ч сонсохгүй гэснийх юм. Бөртэ эргэлзэв. Зүс үзээгүй огт танихгүй энэ залуу яахыг хэн мэдлээ.

-Чи санаа бүү зов. Хэлэх үгээ хэл. Энэ улсаас бүү нэрэлх. Эд албаа гүйцэлдүүлж байна гэж Бөртэ хэлэв.

-Миний энэ үгийг их хатан танаас өөр хүн сонсох ёсгүй юм аа. Та болгоо гэж Бичэлдэй туйлбартай шаардав. Бөртийн сониуч зан гэнэт хөдлөв. Бөртийн зангахад их даамал хэдий дургүй ч шивэгчинг дагуулан гарчээ. Бичэлдэй үүд рүү чагнаж хүний хөлийн чимээ алдрахыг сонсож мэдээд Бөртэд дөхөхөөр урагшлав.

-Хүлээ. Чи наанаасаа хэлэхээ хэл гэж Бөртэ сэрэмжлэв.

-За

Залуу Бичэлдэй Бөртийн үгийг дагав.

-Би чамайг сонсож байна. Юу болов. Хэлэгтүн.

-Их хатантан. Би бол мэргэд хүн юм.

Энэ үгэнд Бөртэ гэнэт сэрхийн цочлоо. Чухам яагаад ингэтлээ цочиж сэтгэл түгшүүрлэснээ тэр даруйдаа ойлгосонгүй ч дуугарсангүй.

-Би Мэргэд аймгийн хүн. Би мэргэдийн Чилэгэр бөх гэгчийн ач хөвүүн юм.

Ийм үг сонсоод Бөртэ суудлаасаа өндөсхийлээ. Ийм байх ёсгүй. Мэргэдийн эрчүүд тэр дундаа Чилэгэр бөхийн удам бүгд сүйрсэн байхад энэ залуу юун дэмий үг хэлэв. Бөртэ уурлах, учирлахын алиныг ч олж чадсангүй.

-Чи юу ... ярина. Чамайг Чилэгэр бөхийн ач гэж хэн итгэнэ. Ийм дэмий үг бүү чалч гэж Бөртэ үнэн санаанаасаа хилэгнэн хашгирав. Гэсэн ч үгээ дуусгалгүй дуугаа намсгав. Тэр дэндүү түргэдэж байгаагаа ойлгожээ.

-Та намайг яаж таних билээ. Их хатан таныг Мэргэд аймгаас буцаан авахад эцэг минь төрөөгүй байжээ. Миний эмэг эх бол Чилэгэр бөхийн гэрт зарцлагдаж байсан шивэгчин Шихүр юм.

Залуу хөвүүний амнаас гарсан энэ нэр Бөртэд танил байсан нь Бичэлдэйн үгийг анхааран сонсоход хүргэв. Тийм ээ. Өрөвч сайхан сэтгэлтэй шивэгчин Шихүрийг Бөртэ мартахын аргагүй билээ. Шихүр бол Бөртийг мэргэдийн Чилэгэр бөхийн гэрт булаагдан очиход эмэгтэй

хүний өрөвч сэтгэлээр угтан асарч тойлж, уйлахад нь өрөвдөн хамт нулимс унагасан зөөлөн сэтгэлт бүсгүй юм.

-Эмэг эх Шихүр эзэн Чилэгэр бөхөөс хүүхэд олсон нь миний эцэг Бүргий байжээ. Харин эцэг минь намайг зургаан настай байхад Алтан улсад алагдсан. Эмэг эхийг хэрэйдийн Жаха-хамбу эзэн олзолж авсан тул эцэг минь тэнд төрж түүний боол болсон. Би ч мөн тэнд төрж сүүлд Жаха-Хамбу эзнээ Чингис хаанд дагаж ороход хамт ирсэн билээ. Намайг одоо хэрэйд хүн гэж олноор тооцож буй. Харин намайг яс угсаагаа бүү мартаарай гэж эмэг эх минь сургасан юм.

Энэ танихгүй залуугийн үгэнд итгэхгүй байх аргагүй мэт Бөртэд санагдаад тэр бодолд унав. Тоорил хан, Жамуха нарын тусламжтайгаар Тэмүжин Бөртийг мэргэдээс буцаан авснаас хойш Шихүрийн хэрхсэн, амьд үхсэн болохыг Бөртэ өдий болтол мэдээгүй явжээ. Бөртэд тийм боломж олдоогүй билээ. Харин Шихүр амьд үлдсэн, тэр бүү хэл ач хөвүүн нь энэ Бичэлдэй гэдгийг мэдмэгц сэтгэл хөдлөн догдолжээ. Бичэлдэйн хэлсэнд Бөртэ яг л гэнэн балчир охин шиг итгэж орхив.

-Чи юу гэнэ ээ. Бүхнийг надад сайтар ярьж өг гэж Бөртэ залуу хөвүүнд тал өгөн дээш нь дэргэдээ суулгав.

Хэрэйдийн цэрэг довлон ирэхэд Чилэгэр бөхөд хаягдсан өрх гэр цөөн албат зарц нь хэрэйдийн Жаха-Хамбын олз болжээ. Чилэгэр бөхийн нялх хөвүүд, авааль эмсийг хүйс тэмтэрч харин зарц шивэгчид нь Жаха-Хамбын гэрт хүргэгджээ. Жаха-Хамбуд олзлогдсоноос хойш зургаан сарын хойно Шихүр бүсгүй хөвүүн төрүүлсэн нь үнэхээр Чилэгэр бөхийн үр мөн байв. Чилэгэр бөх гэрийн дотор ёсолж авсан хоёр эмтэй, дээр нь булаагдсан Бөртийг авчирсан ч зүс цэвэр шивэгчин Шихүрийг хүчирхийлэн эдэлж байсныг батлан Бичэлдэйн эцэг Бүргий төржээ.

Жаха-Хамбу өөрийн цэргийн зуутын ноён Хэрсэнд Шихүрийг шагнаан өгчээ. Хэрсэнгийн ивээлд орсон Шихүр азгүй төрсөн эмийн ёсоор үйлээ дагав. Хэрсэн догшин сүртэй ч зөөлөн сэтгэлтэйн дээр залуу, царай зүс цэвэр Шихүрийг таалжээ. Бүргий хөвүүнд нь Хэрсэн ер хатуу сэтгэл гаргасангүй харгалзан өсгөв. Шихүр, Бүргий хөвүүнээ мэргэдийн Чилэгэр бөхийн үр гэдгийг тас нуув. Эс нуувал нялх үрд нь үхэл ирнэ гэдгийг сайн мэднэ. Ерөөс Бүргий хөвүүн нь мэргэд удамтайгаа ч мартаасай гэж хүсжээ. Харин Бүргий хөвүүн нь Хэрсэнгийн ачаар мэргэд гэж ад үзэгдэлгүй өсч удалгүй Тоорил хан дарагдахад тэд бүгдээр Жаха-Хамбу эзнийхээ хамт Чингис хаанд дагаж иржээ. Энэ үеэс Шихүр холоос ч болов Бөртийн барааг харах болов. Бас Чилэгэр бөхийн үр Зүчи гарамгай баатар эр болсныг ч үзэв. Шихүр хэдийгээр харц шивэгчин заяатай, Хэрсэнгийн татвар эм болсон ч гэлээ тийм ч амар хялбар, алмай наазгай хүн биш байжээ.

Тэр аливаад ухаан сэргэг хандаж үүсч бий болсон нөхцөлд түргэн дасаж зохицдог бүсгүй юм. Тийм ч учраас өөрийн эзэн Чилэгэр бөхтэй хормой хотоор холбогдож, түүнийг Тэмүжинд алуулсны хойно олзлон авсан Хэрэйдийн Жаха Хамбу ноёны албат Хэрсэнгийн сэтгэлийг татан итгэлийг авч татвар эмийн эрхийг олоод Хэрсэнгийн хүү охин хоёрыг төрүүлж өрх гэр, өмч малтай ч болжээ. Шихүр хүүхдүүд дундаасаа Чилэгэр бөхийн үр Бүргий хөвүүнээ амиа тавин хайрлаж түүнийг мэргэд гэж ад үзэгдэх вий гэж алалдахаас бусдыг үзсэн нь яг л Бөртэ Зүчи хөвүүнээ хайрлахтай эгээ адил байв. Ингэж бие биенээ мэдэхгүй хоёр хөвүүн, үйлт

Чилэгэр бөхийн хоёр үр Чингис хааны улсад өсч, үржин өнөө хүрчээ. Зүчийн алдар нэр түгэх бүр Шихүр Бүргий хөвүүнийхээ төлөө санаа зовон түгших, атаархах нь нэмэгддэг байжээ. Учир нь Бүргий хэдий зоригтой сайн эр болсон ч асарсан эцэг Хэрсэнгийн дор зуутын захирагчаас үл хэтэрнэ. Гэтэл Бүргийтэй яг адил Чилэгэр бөхийн үр Зүчи их Чингис хааны ахмад хөвүүн гэгдэж, алдар нь цууриатсан их жанжин байх нь дэндүү шударга биш санагддаг байв. Гэтэл өчүүхэн муу эм Шихүр юу хийж чадах билээ. Их хатан Бөртэд ойртож бараалхана гэдэг Шихүрт наранд хүрч, саранд сарвайхтай адил. Бас Хэрсэнгийн нутаг Туул, Орхоны билчэрт тул гэрийн эм Шихүрт дэндүү алс байжээ. Тэмүжинг их хаанд өргөмжлөх өргөн ёслолын үеэр Бөртэ хатныг тэртээ алсаас ганц удаа барааг нь олж харсан билээ. Бөртэ хатан түүнд яавч муугаар хандахгүй гэж тэр бодно. Гэвч Шихүрийг Чилэгэр бөхийн үрийг төрүүлснийг Бөртэ хатан мэдвэл хэрхэн хүлээн авах нь сэжигтэй тул эргэлзэж байжээ. Осолдвол Бүргий хөвүүн нь амьгүй ч болж мэднэ. Бүргийг Чилэгэр бөхийн үр гэдгийг мэдвэл Бөртэ яаж ч мэдэх билээ. Энэ бодлоос болж Шихүр яахаа ч мэдэхгүй болоод ойд төөрсөн мэт явтал гай ирж Бүргий хөвүүн нь Алтан улсад яваад амиа алдав. Бүргийн хөвүүн Бичэлдэйг Шихүр өсгөж хүн болгосон билээ. Тэгээд хэдэн сарын өмнө үхэхдээ Бичэлдэй ачдаа энэ бүх явдлыг ярьж Бөртэ хатанд очиж мөргөхийг гэрээслэжээ. Энэ ёсоор Бичэлдэй өнөөдөр Бөртэд бараалхжээ. Шихүр үхвэл Бичэлдэй ертөнц дээр орь ганцаар үлдэх юм. Гэтэл түүний цус нэгтэй авга нь ганц Зүчи тул үхсэн ч, сэхсэн ч түүнийг дагахыг эмэг эх нь шаарджээ. Үнэнээ хэлж очвол Бөртэ эрхбиш эм хүн учир ач хөвүүнийг нь хайрлах биз гэж бодсондоо Шихүр ингэжээ. Эцгээс өнчирч бас түшиг тулгуур эмэг эх нь үхсэнд үнсэнд хаягдсан шалз шиг болсон Бичэлдэйд эмэг эхийн үнэмшилгүй боловч үгийг дагахаас өөр арга үлдсэнгүй. Өмнөө суугаа, Батын үеийн идэр хөвүүн Бичэлдэйн үгийг төгс итгэхэд бэрх ч бас худал гэж няцаах хүсэл Бөртэд хүчтэй төрөхгүй байлаа. Бичэлдэйн урт ярианы дараа Бөртэ дуугүй хэсэг суув.

-Шихүр надад өөр юу хэлэв.

-Бөртэ хатан надад лав сайнаар хандаж, дурсан санах биз. Би Бөртэ хатныг мэргэдэд булаагдаж ирэхэд эхний хэдэн шөнө дандаа цуг хонодог байлаа. Бөртэ хатан ганцхан миний дэргэд л нулимсаа урсган уйлдаг, өөр хүний дэргэд уйлдаггүй хатуу зоригтой хүн байсан юм. Би Бөртэ хатны нулимсыг үзээд тэсэлгүй уйлдагсан. Хүн ирэх чимээнээр бид хоёр нулимсаа арчиж нүүрээ яаран цэвэрлэдэгсэн. Ингэж байхдаа бас болоогүй бие биеээ шоолон инээж чаддаг байлаа. Мөн ч залуу гэнэн тэнэг байжээ. Энэ явдлыг ганцхан Бөртэ хатан бид хоёр л мэдэх юм. Хэрэв Бөртэ хатан чиний үгэнд үл итгэн эргэлзвэл чи энэ үгийг хэлээрэй гэсэн дээ гэж Бичэлдэй гүн санаа алджээ. Ийм үг сонсмогц Бөртэ, Бичэлдэйн ярьсанд эргэлзэхгүй итгэв. Энэ явдлыг ганцхан Шихүр л мэдэх билээ. Одоо ч тэр цаг нүдэнд харагдах шиг болж зүрх нь догдлон чичирлээ. Шихүрийг гэнэт өрөвдөн харамсаж нулимс нь цийлэлзэн нүд дүүрэв.

-Шихүр эртхэн надад ирэхгүй яав. Би түүнийг асарч хамгаалах байв. Би Шихүрт өртэй хоцорчээ гэж Бөртэ гуниглан хэлжээ.

-Эмэг эх өөрийгөө үхнэ гэж бодоогүй биз. Эмнэг гүү саах гээд өшиглүүлж үхсэн. Харин үхэхийн өмнө надад энэ бүгдийг ярьсан юм.

-Би одоо чамд яаж туслана. Би сайн эмэг эхийн чинь ачийг санаж чамд туслая гэж Бөртэ эргэлзэх юмгүй хэллээ. Бөртэ энэ өнчин хөвүүнд туслая үнэн санаанаас хүсэв. Чилэгэр



бөхийн үр болж төрсөн нь юуны буруу билээ.

-Хүү минь. Чи юу хүснэ. Надад хэл.

-Бөртэ хатан ижээ гэж Бичэлдэй итгэлтэйгээр хэлэв. Энэ үг

Бөртийг догдлуулав.

-Бичэлдэй бүү эрээл. Чи одоо намайг эмэг эх Шихүрийгээ гэж бод.

-Би эмэг эхийнхээ хүссэнээр Зүчи авгын дэргэд шадарлан зүтгэж нэг удам угсаагаа батлан явахыг хүснэ. Би өвсөн дунд хаяж орхисон өнчин тэвнэ шиг мартагдаж үрэгдэхийг үл хүснэ.

Бичэлдэйг ингэж хэлнэ чинээ даанч санаагүйдээ Бөртэ өөрийгөө ихэд голов. Хүний хүсэлд хязгаар гэж үгүй болохыг, хүсч мөрөөдөхөд айж ичих зүйл өчүүхэн ч үгүй болохыг Бөртэ үзэв. Идэр Бичэлдэйн энэ хүслийг буруушаан шүүмжлээгүй ч шууд дэмжин ам алдаж чадсангүй.

-Чи энэ үгээ, өөрийн мэргэд гарлаа надаас өөр хэнд ч бүү хэлэгтүн. Би чамайг сүүлд дуудаж уулзана гэхээс өөр үг дахин хэлж төвдсөнгүй гаргав. Зүчи хөвүүний нь цус нэгт төрөл гэнэт гарч ирсэн нь Бөртийг эхлээд өрөвдөх сэтгэлд авгуулж эцэст нь айлгах юм гэж санасангүй. Цусан төрөл гарч ирснээс илүү тэр Бичэлдэй өөрийгөө Зүчи болоод Батын адил үзэж, зэрэгцэн суух хүслээр дүүрэн байгаа нь бөөн эргэлзээ, бараан бодолд оруулжээ. Чухам юунд түгшиж, сэтгэл зовсноо сайн ойлгож мэдсэнгүй. Амьдралдаа үзсэн гунигт түүхийг сөхөж, нууц шархыг дахин сэдрээсэн энэ явдалд Бөртэ ингэж цочирдон шанална гэж бодсонгүй. Төрсөн эхийндээ очоод ирсэн Бат, Бөртэ эмгийнхээ царайг үзмэгц дуу алдав.

-Та өвчин тусаа юу гэж Бат түгшив.

Бичэлдэйн тухай Бөртэ хэнд ярих билээ. Ганц өөрийн сэтгэлдээ хураан хуримтлуулсан бодол эргэлзээ нь туйлдуулж Батыг үзмэгц тэнцвэр алдав.

-Хөвүүн минь. Чи сонс.

Бөртийн дуу хүн танихын аргагүй өөр сонсогджээ.

Бат эмэг эхийнхээ эл хачин байдалд сандарч цочив. Бөртэ эмэг нь хэзээ ч ийм ядруу дорой байсныг тэр үзсэнгүй.

-Та юу болов. Хэлээч

Хар багаас өлгөйдөж өвөртөлж өсгөсөн тул Бөртэ Бат хоёр бүхнээс илүү дотно, өөриймсөг харьцаатай юм. Бөртэ бол Батын хувьд хамгийн хайртай, эрхэлж өссөн хүн нь билээ. Хайртай эмэг эх нь ийн гуниг зовлонд учирсныг үзээд Бат үнэн сэтгэлээс сандарч айжээ.

-Хөвүүн минь. Бүү санаа зов. Надад ямар нэг зовлон учирсангүй. Харин чамайг буцахыг бодохоор чамтай бас эцэгтэй чинь дахин уулзахгүй мэт санагдаад...

-Бөртэ ижээ. Та юун ойрхон юм бодно. Би таныг өөрийн улсад аваачна. Бүр Каспийн тэнгисийн зөөлөн салхинд суулгаж тэнгисийн усанд хөвүүлнэ. Та ер тийм их ус үзээгүй биз. Аав ч удахгүй бас ирнэ. Та ийм ялигүй олиггүй бодолд бүү авт гэж Бат энгүүн хөхүүнээр инээжээ. Нээрээ Зүчи хөвүүнтэйгээ дахин уулзахгүй гэж муу ёрлоод гэж Бөртэ өөрийгөө зэмлэв. Уйтгарлаж, түгшсэнээ нуух гэсэндээ, бас өөрийнхөө энэ уруу дорой байгааг зөвтгөх гэсэндээ хэлсэн энэ үг нь дэмий хэрэг болжээ. Чингис хаан Хорезмыг дагуулж дуусаад эргэн ирэхэд лав Зүчи ирнэ. Харин Батад Бичэлдэйн тухай хэлэх үү, үгүй юу гэдгийгээ л шийдэж ядан бодсоор байжээ. Эцэст нь хэлэхээр шийдэв. Энэ бол явж явж Бөртийн мэдэж шийдэх ч хэрэг биш, Зүчийн л мэдэх хэрэг юм. Тэгээд энэ тухай хэлүүлэх итгэлтэй сайн элч Батаас өөр хэн байх билээ. Гадна хөндлөнгийн хүнд яаж Бичэлдэйн тухай хэлж болно. Батад учрыг сайтар хэлэх нь зөв байлаа. Бат идээ будаагаар дайлуулж эцгийн орноос хүндлүүлж суух зуур Бөртэ хэлэх үгээ сайтар тунгаан бодож авчээ. Бат сая ирэхдээ Гертаг Уги хатан эхийнхээ дэргэд үлдээжээ. Олон хоногийн явдлын аяыг тэр бүсгүй яахан тэсэж чадах билээ.

-Бат минь. Хүү чи сонс. Чи бол Зүчи эцгийнхээ хамгийн хайртай хөвүүн. Чингис хааны онцлон тоодог ач хүү шүү.

Эмэг эхийн энэ тойруу холын үг нэг чухал зүйл ярихыг ойлгуулав. Тийм болохоор эмэг эхийнхээ дараагийн үгийг Бат анхааран хүлээв.

-Би чамд нэгэн зүйл хэлье. Чи сайн тогтоож ав. Бас гадагш бүү задруул. Нэг ч үг гээлгүйгээр эцэгтээ хэлээрэй.

Бичэлдэйн тухай яриаг Бат таг дуугүй сууж сонсов. Эцэг нь, түүнээс үүдээд Бат өөрөө ямар гарал, цустайгаа тэр сайн мэднэ. Хэн ч түүнийг мэргэд гэж дурдаж, ад шоо үздэггүй ч эцэг Зүчи болоод Бат өөрөө Их Монгол улсын их хаанд өргөмжлөгдөх эрхгүй болсноо ч мэднэ. Тийм болохоор энэ тухай яриа Батыг нэг их цочоосонгүй. Харин цус нэгтэй үеэл ах гарч ирсэнд баярлах, бухимдахын аль нь болохыг мэдээгүй ч сэтгэлийн дотор үл мэдэгдэх утас доргиж, зүрх нь түргэнээ түг түг цохилохыг мэдрэв. Үеэл ахтай гэдгээ мэдэх нь тун чиг сонсголонтой бөгөөд ямар хүн байгаа бол гэсэн сониуч бодол хүчтэй төржээ. Цусан төрлийн хөвүүн бийг сонсоод Бат Бөртийн бодсон шиг цочирдож гайхаагүй нь Бөртийг харин тайвшруулжээ. Өөрийн цусан гарлыг Бат, Зүчи эцгийнхээ адил эмзэг гүнзгий авч үздэггүй болохыг энэ явдал гэрчилжээ. Ер нь цаашдаа Зүчийн энэ гарал Батын үр хүүхдийн үед бүр ч мартагдах мэт санагдсан нь Бөртэ Бичэлдэйг хэрхэхээ шийдэхэд туслав.

-Бат. Би чамд тэр Бичэлдэйг өгч явуулья. Чи эцэгтээ аваачиж өг. Хэрхэхийг Зүчи шийдэг гэв.

-Харин та юу гэж бодно. Бичэлдэйг яах нь зөв бол гэж угийн сэргэлэн Бат асуув. Бөртийн үг Зүчи эцэгт нь лав хүчтэй нөлөөлнө гэдгийг Бат мэдэх тул ингэж асуужээ. Түүнийг буцаж очоод Бичэлдэйн тухай хэлэхэд хамгийн түрүүнд

-Бөртэ ижий юу гэв гэж эцэг нь асуух нь гарцаагүй билээ.

-Чиний хаан өвөг, Билгүтэй авга хоёр чинь эх өөртэй эцэг нэгтэй ах дүүс юм. Билгүтэй авга чинь Чингис хаанд яаж зүтгэснийг та нар лав мэдэх биз. Яг үүний адил энэ Бичэлдэй бол чиний эцэг нэгтэй эх өөртэй ах чинь болно. Бичэлдэй чамд яг Билгүтэй, Чингис хаанд

зүтгэсэн шиг зүтгээсэй гэж би хүсч байна. Бичэлдэй цус нэгтэй учир чамд хэн хүнээс илүү үнэнч зүтгэх биз. Би түүнд ингэж хэлнэ. Тэр чамд яг л Тату шиг зүтгэг. Эмэг эхийн энэ үг Батад туйлын дотно, итгэлтэй санагдав. Тату Ургенчид үрэгдсэнийг Бат хэлээгүй юм. Үнэнч боол Тату үхсэн мэт яс үс ч олдохгүй болсонд Бат одоо ч харамссаар бас түүнийг үхэлд илгээв гэж өөрийгөө буруутгасаар байсан тул Бичэлдэйг үнэнч зүтгүүлэх гэсэн эмэг эхийн ухааныг шууд дэмжин зөвшөөрөв. Үнэнч нөхөр дэргэд байх хичнээн хэрэгтэйг Бат сайн мэдэх билээ. Сайн нөхөр, үнэнч боол Татугаа алдаж өнчирсөн Батад Бичэлдэйг өөрийн нөхөр болгох хүсэл оргилжээ. Үзэж танихгүй ч энэ Бичэлдэй Тату шиг үнэнч зүтгээсэй гэж Бат хүсэв. Тийм учраас

-Би Бичэлдэйтэй хэзээ уулзана. Ямар хүн болохыг би үзмээр байна гэж Бат яаран догдлов.

-Би түүнийг дуудуулсан.Одоо ирнэ.

Нэгэнт л цус нэгтэйн учир Бат Бичэлдэй хоёр харваас л адил төстэй үзэгдэх нь тэднийг тун ч их догдлуулжээ. Харин Бичэлдэй биеэ барьж чадаад эгц ширтэн зогсох нь Батад ч, Бөртэд ч таалагджээ. Бичэлдэй Батаас хоёр насаар ах ажээ.

### *ОРОСЫН ХУВЬ ТАВИЛАН*

Бат Монголоос “Алтан ордонд” эргэн ирснийхээ маргааш нь Бичэлдэйн тухай эцэгтээ хэлжээ. Хатад хөвүүд албат иргэд нь Монголоос ирэхийг сонсоод Зүчи бэрх ихээр хөөрөн догдолсон байв. Эцгийн сэтгэлийн догдлолыг дарагдахыг Бат хүлээж нэг хоножээ. Бат Каспийн тэнгисийн зөөлөн долгиохыг харж суугаад эцэгтээ Бөртэ ижийнхээ хэлснийг бүгдийг нэг ч үг гэж орхигдуулалгүй хэлэв. Бас зам зуур Бичэлдэй түүнд их л дотно сайхан санагдаж, эцэг нь татгалзахгүй бол өөрийн дэргэд авч шадар нөхрийн адил үзэж явахаа ч хэлжээ. Зүчи таг дуугүй суусаар байлаа. Бичэлдэйн тухай сонсоод эцэг нь хөөрөн догдолно гэж Бат залуу хүний гэгээн дэврүүн сэтгэлээр бодож итгэсэн тул эцэг нь ингэж хүрэл царайлан суухыг үзээд гайхжээ. Бичэлдэйн гэнэт гарч ирсэн нь Зүчийн дотор ямар гэгч догшин шуурга үүсгэснийг Бат олж харж чадахгүй байв.

-Бат чи юунд нь итгэтлээ баясан инээд алдана. Чи энэ Бичэлдэй гэгчийг хэн гэж санав гэж Зүчи үгээ зөөж, ял асуух мэт тод заналтай дуугаар гэнэт зандрав. Эцгийнхээ хилэн бадарсан шалтгааныг Бат ойлгосонгүй тул

-Аав аа, энэ Бичэлдэй миний үеэл ах биш гэж үү гэж хөөрч догдолсон хэвээр хэлээд эцгийгээ босон харайхад амаа хамхиж амжсангүй таг болов. Зүчийн нүд аяганаас бүлт үсрэх нь үү гэмээр дүрлийж хөвүүнээ хурга шүүрэх бүргэдийн адил заамдан аваад сэгсчив. Эцгээ ингэж уурлахыг бас түүнд ингэж гар хүрэхийг анх удаа үзсэн Бат айж бас гайхжээ.

-Чамайг ингэж ярихыг би хориглоно. Юун мэргэд. Тэр мэргэд чинь сүйрч сөнөсөн. Одоо энэ ертөнцөд ганцхан их улс байгаа. Энэ бол Их Монгол улс. Чи тэр мэргэдийг март. Тэр Бичэлдэй билүү хэн гэнэ түүнийг март. Чи бол Чингис хааны ач хөвүүн гэж хашгирч хөвүүнээ тэнгисийн эргийн зөөлөн дулаан элсэн дээр савж унатал алгадаад мордон давхиж оджээ. Эцгийнхээ хилэгнэсэн учрыг Бат сая л ойлгов.

Эцэг нь өөрийгөө Чингис хааны хөвүүн байлгахыг хүссээр ажээ. Бас Батыг Чингис хааны ач хүү гэж батлахын төлөө үүнийг хэлжээ. Бат ингэж эцгийнхээ чанад алсын зорилгыг сая л нэг гүйцэд ойлгож туйлын халуунаар уяран уйлав. Эцэг нь ганцхан Батыг Чингис хааны ач хүү гэдгийг нотлохын төлөө өрөө өвтгөн өөрийгөө золиослож яваа болохыг сая л ойлгов. Тийм ээ, Зүчи яг ингэж бодсон юм. Ургенчийн төлөөх тулаанд цэргээ түүнд өгсний цаад учрыг ч олов. Бат элсэн дээрээс босохдоо огт өөр хүн болжээ. Түүний зорилго дэндүү тод ойлгомжтой ажээ. Чингис хаан бол ертөнцийн эзэн юм. Гэтэл Чингис хаан, эцгийг нь өөрийн ууган хөвүүн гэж үзэж хаан ороо залгамжлуулсангүй. Тэгвэл энэ алдсан суудлыг Бат л олж авах ёстой биш үү. Үүний тулд Бат мэргэд удмынхаа тухай санах ч хэрэггүй юм. Ганц Бат ч биш бүгд мартаж ёстой. Бүр мартуулах ёстойг Бат тодорхой ойлгов. Эцгийн хилэн бадарсаны учир энэ байжээ.

Бат өөрийгөө ихэд голж, бас эцэгтээ талархав. Гэвч Бат өөр олон зүйлийн учрыг олж хужрыг тунгааж чадахгүй байлаа. Өөрийн мэргэд цустайд Бат эцгийнхээ адил харамсан гашуудаж гутардаггүй юм. Яагаад гэвэл ийм цустай төрснөөсөө болж алдсан юм Батад үгүй, ядаж өсөхөд нь хэн ч түүнийг дарлаж гадуурхаж зовоосонгүй билээ. Гэвч эцгийгээ Чингис хааны ард хаан орыг залгамжлах ёстой хүн гэж үздэг ч нэгэнт эцэг нь мэргэд цустай тул Чингис хаан Өгөдэйг өөрийн залгамжлагчаар сонгосныг зөв гэж Бат ухааран боддог болжээ.

Харин Батад Чингис хааныг залгамжлан суухаас илүүтэй өөрийн улсыг үүсэн байгуулах нь бахархалтай, ганц мөрөөдөл болсон үйл хэрэг нь юм. Бат хэзээ нэгэн цагт их цэргээ удирдан довтолж Герта бүсгүйн ярьдаг Орос угсаатны олон хотуудыг эзлэн авч Динээпэр, Урал, Ижил гурван мөрнөөс цааш бүр баруун зүгт байх Их далайд хүрэхийг хүсч байв. Тийм учраас Каспийн тэнгисийн эргийн энэ нутгийг эзлэн хүчирхэгжин суух эцгийн бодлыг туйлаас дэмжинэ. Энэ нутаг бол Урал, Ижил, Динээпэр мөрний сав газрыг довтлоход хамгийн ашигтай байрлал юм. Ийм нутгийг олж суусан эцгийн алс ухааныг биширнэ.

Энэ нутаг Батыг тогтоон барих эцсийн газар биш гэдгийг ч ойлгоно. Бат Герта бүсгүйн адил өсгөлүүн биетэй, өндөр хамартай, өтгөн шаргал үстэй бүсгүйчүүл суудаг баруун, хойт зүгт сэтгэл татагдаж байлаа. Бат урьд үзээгүй шинэ нутгийг эзлэн авч их улсаа байгуулан алдар нэрээ Чингис хаан мэт дуурсгахыг хүсч байв. Тагнуул туршуулын хүмүүсийн хэлэхээс үзвэл Орос угсаатны хотууд яг энэ Хорезмтой адил вангууд нь хоорондоо эв нэгдэлгүй, үргэлж самууран тэмцэлддэг, нэг хаанд захирагдах явдалгүй нь Батад ихийг бодогдуулдаг болжээ. Чингис хаан өвөг нь тал хангай нутгийн олон аймаг улсыг нэгтгэн Их Монгол улсаа байгуулсан шиг тэр Каспийн тэнгисээс хойш, зүүн хойт зүгийн орос угсаатны олон хот улсыг нэгтгэн өөрийн их улсыг байгуулах хүсэлд автжээ. Ийм хүслээ биелүүлэхсэн гэхэд цаг хугацаа дэндүү удаан өнгөрч тэсч ядахдаа эцэг нь ч саадтай санагдан элдвийг бодсон удаатай. Бат үнэхээр яарч байлаа. Энэ ертөнцийг нэгтгэн жолоодох нь Чингис хаан болоод түүний хөвүүд ач нарт Тэнгэрээс буулгасан зарлиг гэдгийг хамгийн гүнзгий ухамсарласан хүн бол Бат юм. Тийм ч учраас Каспийн тэнгисийн орчим нутгийг эзлэн суурьших гэсэн Зүчи эцгийнхээ хүслийг тэр чамлаж голж байсан ч тэвчин дуугүй явжээ.

Харин цус нэгт үеэл Бичэлдэйн гарч ирсэн нь Батыг эцгийгээ ихээр хүндлэхэд хүргэв. Тийм учраас өнөөдөр түүний төлөө амиа өргөх ганц хүн нь эцгийгээ гэдгийг ч гүнзгий ойлгов. Ийн бодоод тэр даруй мордон эцгийн “Алтан ордон” руу давхижээ. Ийн бахархалтай давхиж

явахдаа хожим хойно орос болоод бусад угсаатныг нэгтгэн их улсаа байгуулж, түүнийгээ сайн эцгийнхээ дурсгал болгон “Алтан ордны улс” гэж нэрлэе гэж Бат боджээ.

Сайн эцгийнхээ ачийг хариулж, алдар нэрийг нь их хаан мэт үүрд дуурсгахын тулд орос угсаатныг нэгтгэн их улс байгуулахаар тэр ингэж бат тогтов. Уралын нуруунаас баруун тийш үргэлжилсэн зөөлөн хөрст нам дор газраар тархан суусан орос угсаатны хожмын хувь тавиланг Бат ингэж шийджээ. Ижил, Урал, Динээпэр, Дон, Двина гэх олон мөрний орос угсаатнуудын хожмын үр сад, нэгдсэн хүчирхэг Орос улсыг байгуулж үлдээснийх нь төлөө Батад үүрд баярлан талархах ёстой учир ингэж эхлэжээ. Харин Зүчийн хүсэл нь энд Каспийн тэнгисийн хойт эрэг дээр өөрийн “Алтан ордон” хэмээх хот босгох явдал байлаа.

Батын их хүслийн дэргэд эцгийн хүссэн нь өчүүхэн ажээ. Гэвч Бат Зүчи эцгээ бахархан хайрлаж байв. Бөртэ ижийн нь илгээсэн бэлэг Зүчийн сэтгэлийг үнэхээр догдлуулсан билээ. Тэнд ер байхгүй юм алга. Дуртай ааруул, сэнгэнэсэн айраг, баавгайн доньт,бугын зуулт юу эс байхгүй гэх билээ. Харин Зүчийн сэвлэгийг алтан хуудсанд боож илгээснийг үзээд бүр ч уярав. Зүчийг таван нас хүрэхэд найр хийж сэвлэгийг нь үргээснийг саналаа. Энэ бол Ононы эрэгт болсон явдал юм. Бас энэ найранд Жүрхэн аймгийн ихэс уригдаж шөнө нь бөөн хэрүүл зодоон болсныг ч санав. Бөртэ эхийнх нь сүүний үнэр сэнгэнэх сэвлэгээ үнэрлэн сууж байхад нь Бат орж иржээ.

Эцгийн хилэн дарагдаж нэгэнт тайвширчээ. Өргөөнд тал нутгийн агь ганга,айраг цагааны үнэр ханх тавьж байв.

-Би таван настай байжээ гэж Зүчи инээмсэглэв. Эцэг нь тайвширч инээмсэглэж суухыг ашиглан Бат өөрийн алдааг засч авахыг хичээв.

-Аав аа. Та намайг өршөө. Би Бичэлдэйн талаар дэмий үг хэлжээ. Би их бодлоо. Таны хэлснийг зөв гэж итгэв. Би Чингис хааны ач хүү юм. Би үүнийг батална. Та бүү эргэлз гэж сөхрөв. Зүчи,Бат хөвүүнийхээ ухаантай үгийг ихэд ойшоон сэтгэл тэнэгэр сонсов. Эцэг хүү хоёр бие биеийн хүслийг ойлгож байлаа. Ийм сайн хөвүүн төрүүлж өгсөн байтал би Уги хатнаа дэмий зовоожээ гэж ч харамсан бодов. Зүчийг арван зургаа хүрэхэд Бөртэ эх нь өөрийн төрөлх Хонгирад аймгаас Угийг хатан болгон авч өгсөн билээ. Анх үзээд л тарган цулцгар Уги Зүчид таашаагдсангүй. Харин хөвүүнээ айл болгож бие даалгах гэсэн эхийнхээ хүслийг дагахаас өөр зам Зүчид үгүй билээ. Угид огтхон ч сэтгэлгүйн дээр хүүхэд төрүүлэхгүй удсан нь Зүчийг ингэж хүйтэн хөндий ханэдахад хүргэжээ. Харин Зүчийг хорин зургаатай байхад Уги ашгүй хөвүүн төрүүлсэнд Бөртэ Угигаас бараг л булаан авсан юм. Батыг хайрлах халамжлах хүн нь ганц Бөртэ болоод Уги эх нь гэдэг нь бараг мартагдах шахаж Бат эхийгээ төдийлөн ойшоож үзэлгүй өссөн билээ.

Бат хөвүүн нь Зүчийг сүрхий дууриасан, эгц өндөр нуруутай, сэргэлэн гавшгай эр болон өссөн нь үзтэл Чингис хааны ач нарын сор нь болжээ. Харин Угийн хойно Зүчи, Найманы Буйраг ханы удмын эм авч бас Алтан улсын хааны Агч гүнжийг Чингис хаан түүнд өгчээ. Харин энд Каспийн тэнгисийн зүүн эргийн Алтан ордонд түүний дэргэд түрэг угсааны бага хатан Тод-Ханум байв. Тод- Ханум бол дөрвөн жилийн өмнө Чингис хааны цэрэгт буун өгсөн Хорезмын зүүн хилийн хот Хожент балгасын захирагч Махтур-ужийн охин юм. Махтур-уж түрэг угсаатан тул Чингис хааны илгээсэн элчийн үгэнд орж хотоо эсэргүүцэлгүйгээр өгч

бага охин арван таван настай Тод-Ханумаа Чингис хааны ууган хөвүүн Зүчид бэлэглэн ураг барилджээ.

Одоо Тод-Ханум бие тулгар тул өдрийг асрагч нарын халамжинд өнгөрөөж байв. Махгур-уж хорезмын эзлэгдсэн нутгаас дайчлагдсан цэргийг захирах болжээ. Харин Зүчийн бусад хатад үр хүүхэд нь Монголоос нүүж одоо нэгэнт Или, Чүй мөрнийг гаталж зам зуур монголын их цэргийн өмнө буун өгч дагаар орсон Хар Кидан улсын хуучин нийслэл Хос балгаст амсхийж байлаа. Тэд энд иртэл дахиад даруй гурван сарын явдал бий. Зүчи одоо тэдэнд биш Бөртэ эхийнхээ илгээсэн Бичэлдэйг хэрхэх билээ гэж ухаанаа уудалж хол ойрыг бодож суув. Бичэлдэйг илгээж бүх учрыг Батаас нуулгүйгээр өчсөн эхийнхээ энэ хачин авирт эхлээд гайхсан билээ. Гайхаад ч зогссонгүй хамгийн эмзэг нууцыг Бат хөвүүнд нь тоочсонд хилэн бадарсан юм.

Зүчи Бөртэ эхдээ гаргасан уураа Бат хөвүүндээ гаргасан байжээ. Хайртай хөвүүндээ гар хүрч орхин давхиж одсондоо сүүлд нь ихэд харамссан ч сая Бат ирж өршөөл эрсэнд тайтгараад дахиад хөвүүнээ гомдоохгүй гэж дотроо тангараглаж суув. Эх нь Бичэлдэйг илгээхдээ Батаар хэлүүлсэн үгийг дахин санав. Чингис хааны эцэг нэгтэй эх өөртэй дүү Билгүтэйн тухай дурдсан нь Бичэлдэйг Батад өгөхийг шаардсан хэрэг юм. Бат ч Бичэлдэйг дэргэдээ авахаас татгалзахгүй гэжээ. Чилэгэр бөхийн бас нэг удам гарч ирснийг илгээсэн нь эх нь Зүчийн мэргэд удмыг нэгэнт хүлээн зөвшөөрч байгаа бас ивээлдээ авахыг даалгасантай адил байв. Эх нь хөгширч залуу зандан үеийн тэвчээр зориг үгүй болсныг Зүчи ойлгов. Хэдэн жилийн өмнө хэн нэгэн би мэргэдийн Чилэгэр бөхийн хөвүүн, түүний үр гэвэл чухам тэр хүнийг эх нь улаан гараар тасчин хаях байсан биз. Харин одоо тэгсэнгүй. Эхийнхээ энэ үйлдлийн цаад санааг ойлгох гэж Зүчи ихэд хичээв. Чингис хаан эцгээсээ тусдаа суухад Зүчид чин үнэнч хүн хэрэгтэй гэдгийг эх нь хэлжээ.

Цусан гарал нэгтэй Бичэлдэйг үнэнч зүтгүүлэхэд дөхөм гэсэн үг юм. Бас Чилэгэр бөхийн үр удам үржиж, амьдраасай гэж хүссэн мэт. Үгүй бол Зүчийн адил алдаршиж мөнхрөөсэй гэсэн мэт. Бичэлдэйг илгээсэн нь Зүчийг нэгэнт бүхэнд ил болсон өөрийн мэргэд цуснаас бүү ичиж эмээ гэсэн захиас ч юм шиг ойлгогдохоор ажээ. Бодож үзээд Бичэлдэйг илгээсэн нь түүнийг Чингис хаанаас нэгэнт хараат биш, тусгаар явахыг шууд сайшаасан явдал гэж Зүчи ойлгожээ. Бөртэ эхийнхээ чин үнэн санааг Зүчи зөв мэджээ.

Бөртэ хэдий Батад хэлээгүй ч дотроо яг ингэж бодсон билээ. Зүчи хөвүүн нь нэгэнт өөрийн тусгаар улсыг байгуулах цаг болсон гэж үзсэн учраас Билгүтэйн тухай дурдан Бичэлдэйг үнэнч зүтгүүл гэж хэлжээ. Зүчи нэгэнт Чингис хааны төрсөн үр биш учраас одоо Чингис хаанаас тусгаарлахад саад болох зүйлгүй болжээ. Бөртэ эх нь түүнийг олон жил өмгөөлж хамгаалж ирсэн бөгөөд одоо цаашид хэрхэхийг өөрөө мэд гэж Бичэлдэйг өөрийн биеийн амьд гэрээс мэт үзэж илгээжээ. Зүчи эхтэйгээ уулзалгүй даруй таван жил дөхжээ. Энэ нь Монголын их цэрэг Хорезм улстай дайтахаар гарснаас хойш юм. Батын үгээр бол эх нь их л өтөлж бие нь ч бас сайнгүй бололтой. Болдогсон бол Зүчи эх нутаг руугаа өнөө ч хамаагүй давхин очмоор ажээ. Гэвч эзлэн суусан нутгийн бүх хот дайны хөлд эвдрэн нурсан, аж ахуй, ардын амьдрал, мөргөлийн үйлийг сэргээн хуучин хэвэнд нь оруулах гээд дор дороос ундрах их ажлаа хаяж яахан одох билээ. Бас зарим нэг хот балгаст түүний цэргийг эсэргүүцэн тэмцэж бослого самуун гарах нь элбэг тул хар нүд хамхиж болохгүй байлаа.

Нутгийн иргэдээс дайчилсан цэрэг үнэнч сэтгэлгүй, нутгийн ардын эсрэг хөдөлгөхөд хуурамч хуумгай хандаж, хуйвалдан үгсэх аюултай нь цөөн Монгол цэргийн хүчийг тарамдуулна. Яг ийм явдал эзлэн авсан Тээрэмт балгаст болж, тэнд байсан монгол цэргийн жанжинг дайчилсан цэргүүд самууран алсан хэрэг мандсан нь Зүчийг түгшүүлсэн билээ. Хэрэв Зүчи мөч алдан алмайрвал Хорезмын иргэд түүнийг эсэргүүцэн босоход бэлэн байгаа нь яг л шатдаг тостой торхон дээр суусан мэт болгоно.

Нутгийн иргэд бүгдээр Зүчийг булаан эзлэгч гэж үзэх ажээ. Харин Зүчи тэгж бодсонгүй тул татвараа бууруулах, лал болоод загалмайн шүтлэгтнүүдийн мөргөл хийхийг чөлөөтэй болгох зэрэг аль болох нутгийн ард иргэдэд таалагдах арга сэдэж байв. Ямартай ч эзлэн суусан нутгийн хэмжээнд хилийн харуул байгуулж, хотуудад тус тусын хотоос олны хүндлэл хүлээсэн ахмадуудаас шилж захирагч томилсон нь хамгийн зөв алхам болжээ. Зүчийн тусгаар улс байгуулах хэрэг бага боловч ахиж урагшилсаар, нутгийн иргэд Зүчийг өөрийн хаан гэж үзэх нь олширсоор байжээ. Энэ бол 1224 оны өвлийн эхэн сар юм. Харин Зүчи Бичэлдэйг харахыг ч хүссэнгүй. Учир нь Зүчи өөрийн удмыг дахин санах, тэр тухай хэн нэгэн мэдэхийг огт хүссэнгүй. Батыг дуудаж түүнд хатуу тушаав.

-Бат. Чи Бичэлдэйг өөрийн гараар хэнд ч мэдэгдэлгүй үхүүл.

Зүчийн энэ хатуу үгийг сонсоод Бат дуугүй суусаар байлаа. Нүдэнд дулаахан тэр залуу Батад таалагдах тул эцгийн энэ тушаалыг биелүүлэхэд хэцүү байв. Гэвч эцгийн тушаалыг зөрчих эрх үгүй.

-Бат чи юунд эсэргүүцэх мэт дуугүй сууна гэж Зүчи зандрав.

-Би эсэргүүцэх бодол огт үгүй. Харин яаж алья гэж бодож байна.

-Чамд яаж ч хайран санагдсан чи түүнийг алагтүн. Энэ бол ганцхан Бат чиний төлөө юм. Хожим хойно миний үхсэний дараа чамд гэнэтийн дайсан дэргэдээс гарахыг би үл хүснэ. Зүчийн энэ үгийг зөвшөөрөхгүй байхын аргагүй юм. Эцэг нь үнэхээр түүний төлөө л үүнийг хэлж,хийж буй бүлгээ.

-За би тэр Бичэлдэйн толгойг танд авчирч үзүүлье.

Бат яг л ингэж боджээ. Бодсоноо үнэнээр хэлэв.

-Би тэр Чилэгэр бөхийн үрийн толгойг үзэхийг хүсэхгүй. Чи түүнийг алж чоно, нохой ухаж гаргаж чадахааргүй гүнд бул. Эсвэл хүүрийг нь шатаа гэж Зүчи бухимдан хашгирав.

-За... Би таны хэлснээр хийе.

Эцгийн уур хилэнгээс дайжин түргэн зайлахаас өөр арга Батад байсангүй.

-Байз.Чи хүлээ гэж Зүчи Батыг гарахын даваан дээр хашгирчээ.

Зүчи хүүгийнхээ дэргэд үсрэн ирж түүнийг багалзуурдан алах нь уу гэмээр нүүр тулан амьсгаадан зогсов.

-Байз. Би тэр Бичэлдэйг өөрийн гараар хөнөөе. Чи үүнийг бүү хий. Тэнгэрчамд хилэгнэж мэднэ. Харин би юунаас айна. Чи яв.

Бат дув дуугүй гарч явлаа. Зүчи үнэхээр Батад муу юм болохоос эмээжээ. Уур хилэн, үзэн ядахын галд шатсандаа хөвүүндээ гай чирэх шахсанаа тэр амжиж ухаарчээ. Үнэхээр Бат Бичэлдэйг алсан бол Батад гарцаагүй муу юм тохиох байжээ. Эцсийн мөчид Зүчи үүнийг ухаарч хөвүүнээ хайрласан сэтгэл нь түүнийг аварч тус болов. Бөртэ эхийнхээ үг, гэрээсийг зөрчин тэр шөнө Зүчи, Бичэлдэйг цавчин алаад уулын жалганд булж орхив. Бичэлдэйг алсан ч Зүчийн сэтгэл тайвширсангүй уур цухлаар дүүрсээр ажээ.

Эцэст нь үдэш өргөн найр, бүжиг цэнгээн үүсгэв. Турк, перс эмсийн нүцгэн бүжиглэхийг дув дуугүй гөлрөн ширтэж суух эцгээ хараад Бат голоо тасартал өрөвдөн хайрлаж байлаа. Ширүүн огцом зантай ч гайхалтай тэвчээртэй эцэг нь түүнд ямар их хайр, халуун итгэлээ зориулж байдгийг тэр үзэв. Ямар ч гэмгүй Бичэлдэйг алсандаа эцэг нь харамсан гашуудаж байгааг ганцхан хөвүүн Бат нь мэдэж байв. Магадгүй эцэг нь Бичэлдэйг алахыг огтхон ч хүсээгүй байж магад. Ганцхан түүний ирээдүйн сайн сайхны төлөө өөрийн сэтгэлийг золиослов гэж Бат өрөвдөн бодож суув. Эцгийн сэтгэлийн нууц шаналал хямрал Батыг ч эзэмдэв. Торгон цэргийн харуул гүйн ирж Чингис хааны элч ирснийг илтгэх хүртэл Зүчи ингэж түүдгийн гал ширтэн суусаар байлаа. Тэр юунд ингэж харамсаж, хайртай хүнээ үхүүлсэн мэт гунигт авган суугаагаа өөрөө ч ойлгосонгүй. Сэлэмний хурц ирэн дор гулзасхийн мэдрэгдсэн идэр залуу Бичэлдэйн зөөлөн цогцос одоо болтол атгасан гарын хуруунд мэдрэгдээд болсонгүй. Тэр хөвүүн дөнгөж арван наймтай байжээ. Юунд тэр амьтныг хөнөөв гэж өнгөрсөн хойно гаслан бодсоор суув.

-Чингис хааны элч гэж өргөөний даамал хүндэтгэлтэйгээр зарлахад л сая Зүчи толгой өргөн харлаа. Түүнээс таван алхмын цаана их түүдгийн гэрэлд нэгэн үлэмж биетэй эр зогсоно.

-Зүчи таны амрыг айлтгая. Би Их Чингис хааны зарлигийг танд хүргэж ирлээ.

Ингэж хэлээд элч үгнийхээ баталгаа болгон Чингис хааны тамгатай тохой урт цул алтан гэрэгээ галын гэрэлд дээш өргөв.

-Есөнтэй гээд Зүчи өндийв. Энэ бол Чингис хааны их шадар Урианхайн Зэлмийн хөвүүн Есөнтэй байв. Есөнтэй ирсэн нь Зүчийн хувьд баяртай хэрэг болжээ. Зүчи Есөнтэйгөөс дөрөв ах ч тэд чухам нүд нээхээс цуг өссөн билээ. Тэмүжиний хүрээнд Зүчийн хамгийн дотно үерхэн нөхөрлөсөн анд нь Есөнтэй байлаа. Тэд Зүчийг арван зургаа хүрч цэрэг ахлан мордох хүртэл хамт байжээ.

Есөнтэй нас бие гүйцмэгц Чингис хааны торгон цэрэгт орж, 1206 онд шадар торгон цэргийн мянганы ноёноор томилогдон Алтан улс болоод Харлагийг дарахад оролцсон баатар эр билээ. Зүчийн амьдралын бэрх нууцыг хар нялхаас Зэлмэ эцгийнхээ амнаас сонсож мэдсэн нь түүнийг Зүчид ингэж дотно нөхөрсөгөөр хандах болгожээ. Багадаа тэр Зүчийг гадуурхагдаж зовохыг нь үзэж ямагт түүнд туслахыг хичээсээр ирсэн юм. Эцэг Зэлмэ нь ингэхийг Есөнтэйд сургасан билээ.

Ер нь Тэмүжинээс бусад бүх хүмүүс бүр Хасар хүртэл Зүчид үргэлж найртай сайхан



сэтгэлээр хандаж үргэлж тусалж дэмжихийг хүсдэг байсан нь Бөргийн ухаан, тэвчээрийг хүндэтгэж байдгийн илрэл байв. Зовсон ядарсанд туслах нь ерөөсөө монгол хүний төрөлх шинж биз ээ. Харин Хорезмд ирснээс хойш тэд уулзалгүй гурван жил гаран болжээ. Тэдэнд ярих юм даанч их байлаа. Бүжиг найраа орхин Зүчийн өргөөнд орцгоожээ. Чингис хааны элчийг идээ будаа дэлгэн дайлах нь зүйн хэрэг юм. Ургенчийн дэргэд байхад Чингис хаан элч илгээж Ургенчийг авмагц цэргээ татан ирж нийлэхийг зарлиг болгосон ч Зүчи эзэлсэн нутгаа тохинуулах их ажил байсан тул яваагүй билээ. Түүнээс хойш Чингис хаан цэргээ авч Инд мөрнийг уруудан дайлаар яваад хоёр жил шахам болж сая л Перваны хөндийд эргэн ирснийг Есөнтэй Зүчид мэдэгдэв. Одоо Перваны хөндийд Монголын их цэрэг цуглаж байгаа ажээ. Цэргээ авч ирж нийлэгтүн гэсэн цөөн үгтэй зарлигт их хааны тамга дарсан байв.

-Надаас өөр хэн очоогүй байна.

-Сүбээдэй Зэв хоёр нааш эргээгүй бололтой. Бас Багдадын Халифт явсан Чормогон хорч, Энэтхэг рүү давшсан Бала ноён ирээгүй байна. Бүгдэд элч илгээсэн.

-Их цэргийг нэг дор цуглуулж яана. Эсвэл өөр зүг их дайнд

мордох болов уу.

-Миний сонссоноор их цэрэг Монгол нутагтаа буцна гэнэ.

-Хэзээ гэж Зүчи айсан мэт сэртэсхийв.

-Чи юунд цочив. Чи буцах хүсэлгүй байна уу гэж Есөнтэйг асуухад Зүчи тэр дороо хариу хэлж төвдсөнгүй. Чингис хаан Монголдоо буцах зарлиг буулгавал хэрхэх билээ гэж боджээ.

-Би ч бушуухан л нутагтаа буцах минь. Энэ элсэн дунд уушиг минь шатаж дуусав. Булгийн цэнгэг ус залгилж модны сүүдэрт нам унтахсан гэж хүснэ гэж Есөнтэй Зүчийн бодолд саад хийхгүй гэсэн мэт шивнэв. Зүчи түүний энэ үгийг сонсохгүй мэт сууна.

-Чи юу бодов оо.

-Би яг чамтай адил хүснэ.

Энэ бол Зүчийн ам дагуулсан үг байв. Уг нь тэр би энэ нутагтаа суухыг хүснэ гэж шууд хэлмээр байвч арай л зүрхэлсэнгүй. Учир нь тэр Есөнтөйд итгэж өгөхгүй байв. Есөнтэй бол Чингис хааны хамгийн үнэнч нөхөр Зэлмийн хөвүүн, дээр нь Чингис хааны амь сахигч торгон цэргийн мянганы ноён хүн тул илүү ихийг чалчихыг хүссэнгүй. Гэвч Есөнтэй бол нулимсыг нь арчиж, нууц гомдлыг нь хуваалцсан багын анд нь байв. Ийм хоёр салаа бодлын дунд Зүчи тэлээ хурга шиг тэлэгджээ. Есөнтэйг ирнэ гэж санаагүй ч гэнэ гэнэ түүнийг дэргэдээ байсан болоосой гэж Зүчи хүсдэг байлаа. Ингэх учир бий юм. Өөрийг улсыг байгуулахын хамгийн гол үндэс нь хүчирхэг цэрэг билээ. Нутгийн иргэдээс дайчилсан цэргийг яг өөрийн монгол цэрэгтэй адил дайн байлдаанд сургахгүйгээр юу ч хийж үл чадна. Энэ хэргийг хэрэгжүүлэхэд чухам Есөнтэй шиг авьяастай цэргийн эрдэмд суралцсан итгэлтэй анд хэрэг болно. Есөнтэйг дэргэдээ авч цэргийн хэргийг захируулан хөвүүн Батдаа

хавсруулах хүсэл Зүчийн сэтгэлд төрсөөр удсан юм. Гэтэл дээд Тэнгэр түүнийг мэдсэн мэт Есөнтэй хүрч ирэв.

-Есөнтэй. Чи өөрөө нааш ирнэ гэв үү.

Есөнтэй Зүчийн үгийн утгыг шууд ойлгов.

-Зүчи. Би уг нь ирэхийг хүсэв. Гэвч миний мянгат одоо Чингис хааны бие, өргөөг хамгаалдаг болсон тул би байлдах ч эрхгүй уйтгарлах болсон. Харин сая Чингис хаан юу бодсоныг бүү мэд. Гэнэт намайг чамд илгээх зарлиг буулгажээ. Бодвол хаантан чи бид хоёрыг уулзахсан гэснийг мэдсэн биз ээ гэж Есөнтэй инээн хэлэв.

Үнэндээ Чингис хаан Перваны хөндийд ирмэгц Зүчид элч илгээхээр шийдсэн юм. Харин хэнийг илгээхээ олон өдөр боджээ. Зүчи зарлигийг дагаж Ургенчээс цэргээ авч ирээгүйг Чингис хаан өнгөн дээрээ үл тоомсорлох мэт байсан ч энэ хэргийг нэг ч мөч мартаагүйг билээ. Эзэлсэн нутгаа төвхнүүлэх гэсэн Зүчийн үгийг тэр бас ойлгож хүндэтгэжээ. Энэ нь шинэ нутаг орныг эзлэхээс ч дутахгүй төвөгтэйг тэр мэднэ. Гэвч ингэж Зүчийн хийснийг зөвшөөрсөн мэт боловч зарлигийг зөрчин том толгой гаргаж ирээгүйд нь эгдүүцэн хилэгнэсээр байжээ. Чингис хааны энэ битүү бухимдлыг Боорчи бас Цагадай, Өгөдэй, Тулуй нараас өөр хэн ч мэдсэнгүй.

-За яах вэ. Зүчи хүссэн зүгтээ яваг. Гэвч нэг өдөр буруу замаар будаа тээвэл буцахдаа шороо тээнэ гэдэг болох бий гэж заналтай шивэгнэснийг тэр дөрөв сонссон билээ. Гэвч хэн нь ч Зүчийг хамгаалах юм уу буруушаах үг дуугарсангүй. Учир нь тэр өдөр Чингис хаан туйлын хилэнтэй байжээ.

-Чингис хаантны бие лагшин тунгалаг сайн буйзаа гэж Зүчи асуув. Ингэж ёсыг бодон асуухдаа Зүчи цаанаа юу бодож байгааг Есөнтэй гадарласан тул түүний хүсч байсан хариуг хэлэв.

-Чингис хаан ойрд их хилэнтэй байгаа. Хулан хатны үхлээс хойш бие сэтгэл нь баахан хямарч буй бололтой. Нэг л тайван биш болсон. Хол газар энэ хар халуунд эцэж ядраа ч биз дээ.

-Хулан хатныг тэнгэрт хальсанд намайг очсонгүй гэж Чингис хаан лав их хилэгнэсэн байх даа гэж Зүчи хэлэхэд Есөнтэй

-Чи энэ удаа заавал очихгүй бол болохгүй биз гэж анхааруулав. Энэ нь Есөнтэй өөрийн мэдэхийн хирээр ирэх аюулыг урьдчилан сануулах гэсэн сайхан сэтгэлийн үг байв. Зарлигийг даган очоогүйд Чингис хаан түүнд хилэгнэсээр байгаа нь нэгэнт тодорхой болжээ. Зүчи уг нь бүх зүйл мартагдан өнгөрсөн гэж бодож, ингэж итгэхийг оролдсоор байсан билээ. Гэтэл хэрэг түүний бодсон шиг тийм ч амар хялбар биш бололтой. Бас үүнээс илүү ихийг Есөнтэйгөөс асууж болохгүй гэж шийдэв.

-За чи өнөөдөр тухалж алжаалаа тайлж үз. Би чамайг чилээхээ больё гэж Зүчи хэлэхэд

-Чиний хэлснээр больё. Харин чи яаж миний алжаалыг тайлна гэв. Энэ юу гэсэн үг болохыг

Зүчи ойлгов.

-Би Зүчи чиний энэ газарт шигдэн суусны учрыг олох гэж хүснэ. Лав бүсгүйчүүд нь амттай биз.

-Чи хэл. Ямар бүсгүйг чи хүснэ.

-Орос гэж Есөнтэй эргэлзэж бодсонгүй өчив.

-Чи орос эм элбэг гэж санав уу. Гэхдээ өгвөл ганцаасаа гэдэг бил үү. Би багын ганц нөхөр чамд өөрийн орос эмийг бэлэглэе. Чи буцахдаа авч яваарай. Нутагтаа аваачиж гайхуул гэж Зүчи баясгалантай хөхрөв. Тэр үнэхээр татвар орос эмээ Есөнтөйд бэлэглэхээр шийдсэн билээ. Есөнтэйг орос эм эдлэн, тачаал сэрэлд нь автсан тэр шөнө Зүчи унтаж чадсангүй. Шөнө дунд өнгөрснөөс хойш Батыг дуудан сэрээв. Бат ч даруй иржээ.

-Чингис хааны элч маргааш буцах тул би чамтай зөвлөх хэрэг гарлаа.

Эцэг нь ингэж шөнө дөлөөр чухал хэрэг зөвлөхөөр дуудсан нь Батад бахтай сайхан санагджээ. Шадруудаасаа хэнийг нь ч дуудсангүй.

-Бат. Хүү минь. Чи анхааралтай сонс. Сонссоноо цааш нь хэнд ч бүү мэдэгд. Энэ хэргийг зөвхөн чи бид хоёр л мэдэх ёстой юм.

-За. Аав аа.

-Чингис хаан Есөнтэйг элч болгон илгээжээ гэж Чингис хааны цөөн үгтэй захидлыг өгөв. Бат гүйлгэн уншаад,

-Цэргээ авч ир гэнээ гэж гайхсандаа нүд нь томров.

-Тийм ээ. Намайг цэргээ авч ир гэжээ. Бас Киевийн зүг явсан Сүбээдэй, Багдадаас Чормогон, Энэтхэгээс Балаг ч дууджээ.

-Юу болов.

-Их цэргээ авч Монгол нутагтаа буцах гэнэ.

-Тийм үү. Тэгвэл бид наашаа дэмий нүүдэл хийжээ. Одоо буцна.

-Чи хүлээ. Тэд ирдгээрээ ирэг. Би Монголд буцахгүйгээр шийдлээ. Энд сууж, өөрийн улсыг байгуулна. Би өдий болтлоо Чингис хаан эцэгт зүтгэж, их улсыг байгуулахад хүчээ өглөө. Одоо үлдсэн насаа өөрийн улсыг байгуулахад зориулна. Намайг Зүчи хаан гэж өргөмжлөөсэй гэж би хүснэ. Хөвүүн чи юу гэж бодож байна гэж Зүчи яарч юманд хөөгдсөн мэт амьсгаадан асуув. Түүний сэтгэл хөвчрөн донсолжээ.

-Би таны төлөө уулыг давж усыг гатална. Би тантай хамт Уралын нуруунаас цааш, Кавказын нуруунаас хойшхи нутгийг хураан авахыг хүснэ. Би Гертагийн уугуул нутагт очихыг хүснэ гэж

Бат сэтгэл хөдлөн итгэл төгс хэлэв. Герта гүнж бол эхийн талын удмыг хөөвөл Эрээн мөрний Прусс үндэстэн ажээ. Гертагийн хэлснээр тэр холын нутаг цаг агаар зөөлөн, бас Балтын тэнгис хэмээх их ус байдаг гэхийг Бат мэдсэн тул ийн хэлжээ.

-Хөвүүн чиний үгийг сонсоод би сэтгэл ханалаа.

-Харин Чингис хааны зарлигт юу гэж хэлнэ. Яагаад очихгүй гэж хэлэх вэ гэж Бат сэрэмжлэн асуув. Хамгийн зовлонтой нь энэ хэрэг юм. Нутаг буцахгүй шалтгаанаа зөв ойлгуулж хэлэхгүй бол Чингис хааны уур хилэнг бадрааж бүх хэрэг нурж үхэлд ч хүрч мэдэх билээ. Эцэг хүү хоёр үүнийг ойлгож байлаа. Тусгаар улс байгуулах тухай шууд дурдаж болохгүй. Чингис хаан үүнийг талархан дэмжихгүй гэж сэжиглэж байлаа. Бас зарлигийг зөрчин очихгүй гэхэд түүнээс ч илүү аюултай. Зүчи яах учраа олохгүй учир Батыг дуудсан билээ. Маргааш Есөнтэйг буцахад заавал нэг учир хэлж захидал илгээх хэрэгтэй болжээ.

Тусгаар улс байгуулах хүсэл хичнээн амттай ч үүнийг биелүүлэхэд хичнээн хэцүү болохыг тэд ойлож байлаа. Цэрэг хөдөлгөж харийн улс аймгийг эзлэн авах хялбар ажээ. Харин Чингис хааны их нэр сүр, хүчнээс ангижирч сална гэдэг бүтэшгүй бэрх болох нь тов тодорхой болжээ. Монголоос их нүүдэл нэгэнт хөдөлсөнийг Чингис хаан сонсож мэдэхгүй байх гэж үгүй. Зүчийн өмнө хоёр зам үлдэв. Нэг бол Чингис хааны зарлигийг үггүй дагаж амьдрах, үгүй бол тусгаар улсаа байгуулахын төлөө эцсээ хүртэл зүтгэх хоёрын аль нэгийг сонгох болжээ.

Зүчи их сонголтын өмнө иржээ. Энэ мөчийг үзтэл тэр дөчин хоёр жилийн зовлонтой, бахархалтай амьдрал туулжээ. Дэргэд нь Зүчийн ирээдүйн гэрэл гэгээ болсон Бат хөвүүн нь түүний шийдвэрийг хүлээн идэр залуу насны халуун хүсэл гэрэлтүүлэн зогсоно. Чингис хаан Бөртэ эхийн хэлснээр Зүчид амь амьдралыг соёрхон өгсөн ч хаан алдрыг булаан авсан билээ. Зүчид энэ их алдрыг өөрийн хүчээр булаан авах ганц зам үлдээжээ. Одоо Зүчи яг энэ хүсэл болсон замынхаа эхэнд хэн ч булаан авч үл чадах ганц залгамжлагч, өмөг түшиг болсон Бат хөвүүнийхээ хамт зогсож байв. Түүний одоо гаргах шийдвэр, сонгох замаар Бат хөвүүн нь явах болно.

-Бат хөвүүн минь, чи юу хүснэ.

Эцгийн энэ гэнэтийн ба учир нь тодорхойгүй асуулт Батыг цочирдуулав. Батад хүсэл олон бий. Гэвч бодсоны эцэст эцэг нь түүнээс ямар хариу хүлээж байгааг ойлгов.

-Би орос аймгуудыг нэгтгэн өөрийн улсыг байгуулж их хаан суухыг хүснэ гэж эргэлзээгүй тод хэлэв. Батын үг Зүчийн хүссэн хариу мөн байлаа. Зүчи таатайгаар инээж хөвүүнээ тэврэв. Зүчи юу хийх, юу хэлэхээ сайн мэдэж авчээ.

Өглөө болмогц Зүчи Чингис хааны элч Есөнтэйг хүлээж суув. Чингис хааны шадар Есөнтэйн эцэг Зэлмэ саа өвчинд нэрвэгдээд одоо цэрэг дайнаас алс хол өөрийн хуваарьт нутаг баруун Хянганы нурууны Айраг гэгч жижиг нуурын хөвөөнд өмхий шавраар биеэ эмчилж суугаа билээ. Эцэг Зэлмийн зүтгэл, гавьяаг өвлөж авсан Есөнтэй бол Чингис хааны итгэлтэй хүмүүсийн нэг яах аргагүй мөн бөгөөд нэр нөлөө нь ч цэргийн дотор багагүй юм. Зэлмийн ийн нутаг буцсанаас хойш Чингис хаан болоод Боорчи бусад ахмад хүмүүс Есөнтэйг Зэлмийн

ороор үзэж түүнд ихэд анхаарал хүндэтгэлтэй хандах болсноор хуучин багын анд Есөнтэйн сэтгэлд ямар өөрчлөлт орсныг Зүчи анзаарч мэдсэнгүй. Бодож бодож Есөнтэйд итгэх хэрэгтэй гэж шийдэв. Тусгаар улс байгуулахад Есөнтэйн хүч чухал юм. Ер нь ганц Есөнтэй ч биш одоо Чингис хааны дэргэд алба хашиж буй хэд хэдэн хүнийг өөртөө урвуулан дагуулах хэрэгтэй байв. Энэ хэргийг гүйцэлдүүлж чадах ганц хүн нь анд Есөнтэйг гэж Зүчи үзжээ.

Есөнтэй Чингис хаанд зүтгээд мянганы ноёноос их дээш дэвших боломж бага учраас Зүчийн дэргэд ирж түүний улсын цэргийн бүх хэргийг эрхлэхийг яавч хүснэ гэж тооцов. Энэ нь Бат хөвүүний нь дараах эрхтэн болно гэсэн үг юм. Бас Есөнтэйгөөр уламжлуулан талийгч Хуйлдарын хөвүүн Оготур, Боорчийн дүү Үүлэн Чербиг өөрийн дэргэд авчирч чадвал нэн сайн гэж бодов. Бас Сүбээдэй баатрын тусыг олох нь ч чухал байв. Сүбээдэй бол үл таних баруун зүгийн улс аймагт хамгийн хол довтлон одсон, тэр газрыг хамгийн сайн мэдэх хүн юм. Зүчи цэргээ засч бэхлээд Орос угсаатнуудын нутгийн урд хязгаарыг сахин суугч Асу аймгийг довтлон эзлэхээр төлөвлөж байжээ. Асу аймаг бол суурин амьдрагч иргэд бөгөөд Уралын нурууны баруун талд Урал мөрний дунд биеэр нутаглан суудаг юм. Асу аймгийг эзлэн авбал Хивчаг болоод Орос угсаатны олон аймгуудтай шууд хил залгана. Асу аймгийн хүчийг авч цэргээ сэлбэвэл Орос аймгуудтай дайтах хүчин бүрдэх билээ.

Есөнтэйг орж ирэхээс өмнө Зүчи Сүбээдэй баатарт өөрийн элч болгон Төрөлчи хүргэнээ илгээе гэж шийджээ. Чингис хаан нутаг буцлаа ч Сүбээдэй эзэлсэн нутгаа сахин тохинуулж үлдэнэ гэж Зүчи итгэж байв. Нэг улс орныг эзлэн авмагц талж дээрэмдээд буцдаг Чингис хааны энэ нүүдэлчний дайтах аргыг Зүчи таашаахгүй болсоор уджээ. Ингэж дургүйцэх нь ганц Зүчи биш юм. Залуу идэр жанжид цөм л эзлэн авсан нутгийг захиран суухыг хүсч байв. Чингис хааны цэрэг хүчирхэгжин нэр сүр дэлгэрэх хэрээр түүний ихийг бүтээгч, зоригт баатруудад шинэ шинэ газар нутаг нэхэгдэх ажээ. Энэ бол нүүдэлчин аймгийн удирдагчаасаа салан тусгаарлахыг ямагт эрмэлзэж байх язгуур шинж юм. Энэ салан тусгаарлах үзэл Зүчид бусдаас илүү хүчтэй болжээ.

Учир нь тэр Чингис хаантай цусаар холбогдоогүй, Чингис хаан болоод Зүчи хоёрын холбоо, Цагадай, Өгөдэй, Тулуй хөвүүдийг нь бодвол ёс төдий сул байлаа. Бөртэ хатны бие сэтгэл, ухаан зоригийн хүчээр тогтож байсан Чингис хаан Зүчи хоёрын эцэг хүүгийн хуурмаг, үзэмжийн төдий холбоо тасрах цаг ирэв. Одоо эх нь нэгэнт өөрийн үгийг хэлж Чилэгэр бөхийн удам цус нэгтэй Бичэлдэйг илгээсэн нь Зүчийг ийм алхам хийхэд зоригжуулав. Чингис хаанаас тусгаарлан салахад эх нь яавч эсэргүүцэн зэмлэхгүй ажээ. Гэвч шалтгаан төвөг их байв. Чингис хаан хилэгнэвэл тэдний хооронд дайн самуун дэгдэхийг ч Зүчи мэдэж үүнээс хамгийн их айн болгоомжлов. Чингэвэл Зүчи ч, Бат ч үхэх юм. Ийм учраас Зүчи хүссэн хэргээ гүйцээхийн тулд заль хэрэглэн цаг хожих нь зөв гэж үзжээ. Яаж ч бодсон Чингис хаан энэ нутагт удаан сууж тэсэхгүй нь тодорхой тул үүнээс сайн арга олохгүй биз. Чингис хаан Монгол нутагтаа буцвал Зүчид хэн ч саад хийж чадахгүй билээ. Ингэж бодоод тайвширч үүрээр дугхийгээд сэрэхдээ үзсэн зүүднээсээ их л сэжиглэжээ. Зүүдэнд өнөө Бичэлдэй хөвүүн орж, толгойгүй бие “Миний толгойг өгөөч” гэж хашгиран хөөж, харин Бичэлдэйн толгойг Бат хөвүүн нь Чингис хаанд өргөн барьж байна гэж зүүдэлжээ. Энэ бол яах аргагүй муу ёр юм. Тэр хөвүүнийг дэмий алав гэж их харамссаар байсан ч одоо нэгэнт оройтжээ.

Зүчи сэлэм далайн Бичэлдэйн хүзүүнд буулгахын өмнө яг ингэж эргэлзэн бодсон ч далайсан гараа татаагүй билээ. Харин сэлмийн ирэнд Бичэлдэйн хүзүүний яс үйрэн хугарахыг сонсож үхлийн аймшигт цохилтыг гар биеэрээ мэдрэхдээ давхийн үс нь арзайж “Дэмий юм хийв” гэж хожимдон боджээ. Тэр нялх хөвүүнийг юунд алав. Ядаж өөр хүнээр ч алуулахад яав гэж шаналан боддог байлаа. Зүчи хүн алчихаад ингэж харамсан шаналсан удаагүй билээ. Энэ бол үнэхээр муу ёр байсан бөгөөд Зүчи Бичэлдэйг алснаар өөрийн үхлийг даллан дуудсанаа мэдсэнгүй. Есөнтэйг орж ирэхэд Зүчи бодолд дарагдан сууж байв. Гэвч тэр хоёр үг сольж амжсангүй. Учир нь Бат эцгийнхээ өргөөнд зөвшөөрөлгүйгээр үсрэн орж иржээ.

-Аав аа. Тату. Тату эргээд иржээ. Амьд. Амьд эргээд ирж гэж Бат инээн хашгирч байв. Хэн ч хариу хэлсэнгүй. Зүчи ухасхийн гарчээ. Есөнтэй ч гайхан гарав. Юу болоод байгааг тэр ойлгохоо больжээ. Харин бөөн баяр болсон тэднийг харж зогсохдоо нааш гарахад нь Боорчийн хэлснийг боджээ. ”Чи Зүчээс юу ч битгий асууж шалгаагаарай. Тэгвэл цаадах чинь чамд юу ч хэлэхгүй шүү. Тэвчээртэй хүлээ. Өөрөө хэлэхийг нь хүлээгээрэй” гэж Боорчи Есөнтэйг мордохын өмнө өргөөндөө дуудан захижээ. Боорчийн Зүчид хэрхэн сайнаар ханддагийг Есөнтэй мэдэх билээ. Харин Чингис хаан яах гэж түүнийг Зүчийн хүрээнд илгээснийг Есөнтэй гадарлаж, бас ингэж их итгэл өгсөнд нь бахархаад барахгүй байсан билээ.

Одоо очоод түүний хэлэх үгнээс Зүчийн амь нас хамаарах болсныг Есөнтэй сайн ойлгож байв. Бас үүнийг мэдэж байсан учраас Боорчи Есөнтөйд дээрх үгийг хэлжээ. Чухам юуны учир хэлснийг Есөнтэй ухаж ойлгосонгүй. Их Чингис хааны итгэл, зарлигийг биелүүлэхээс өөр эрхэм хүсэл түүнд байхгүй билээ. Энэ бол түүнд эцгээс нь өвлөгдсөн бат хүмүүжил байв. Зэлмийн хөвүүн Есөнтэйгээс илүү үнэнч хүн олоход үнэхээр хэцүү биз ээ. Боорчи Есөнтэйг үнэнчээс гадна их шударга хүн гэж тоодог бүлгээ. Харин Татугийн ингэж гэнэт амьд мэнд эргэн ирснийг Зүчи Тэнгэрийн зарлигаар болов гэж итгэжээ.

Татуг буцаан илгээсэн нь Тэнгэр Зүчийн хүслийг сайшаан дэмжсэний дохио байв. Тийм учраас Зүчи Есөнтөйд эргэлзээгүй итгэж түүнд өөрийн нууц бодлоо шууд хэлжээ. Есөнтэй нэг ч үг дуугаралгүй сууж Зүчийн үгийг сонсжээ.

# НАЙМДУГААР БҮЛЭГ

## БООРЧИ

### *АЛЛАХЫН ЗАРЛИГ МЭТ*

Перваны уужим хөндийд Чингис хааны их цэрэг тал талаас цугларч хуарагнасаар намаржиж, өвөлжөөд хаврын сартай золгов. Ялалт олз хоёртоо бялуурсан цэргүүд их тулааны таван жилд хурсан ядрал зүдрэлээ тайлж хэдэн сар нам жим байцгаах зуураа ханатлаа унтаж бас нутгийн эмстэй ханатлаа зугаацаж авчээ. Тэр жилийн хавар нь эрт дулаарч бүр аагим халуун шатаж эхлэв. Инд мөрнөөс дөрвөн өртөө газар суваг татан Чингис хааны хээрийн их өргөөний үүдээр урсгаад салхин дээр нь том шүршүүр зоож оньсот хүрдээр ус хөөрөгдөн нарийн ширхэгтэй зөөлөн бороог өдөрт дөрвөн удаа хиймлээр оруулах нь яг л нартай бороо намирах мэт бүлгээ.

Каспийн тэнгисийн баруун биеэр хойш довтлон Кавказын их нурууг давж Грузин, Хивчаг, Асу, Орос аймгуудыг дайлаад эгэж ирэхгүй болсон Зэв Сүбээдэй хоёрыг хүлээн их цэрэг ингэж амарч хагас жил суув. Энэ завсар бас ч зүгээр суусангүй Хорезмын эзлэгдсэн хотуудын бүтэн үлдсэнд нь захирагч томилж нутгийн иргэдээс авах татварын хэмжээг тогтоон улсын хууль журмыг мөрдүүлснээр Чингис хааны их гүрний нэг хэсэг болон тогтох амьдрал эхэлжээ. Юуны өмнө нутгийн имам нарыг сүмд нь ирүүлж шашин мөргөлийг сэргээсэн нь Чингис хааны нэр сүрийг олны дунд сайнаар дуурсгав.

Эхлээд зугатааж одсон Хорезмын султан Желаладдинийг нэхэх нэрээр эхлэсэн довтолгоон Кавказын нурууг давмагц аль эрт наашаа дүрвэн ирж хоргодсон хэрэйд, мэргэд аймгийн үлдэгдлийг олж устгах нэртэй болон хувирч монголчуудын өөрсдийн довтолгоог зөвтгөх үндэс болж байв. Зэв Сүбээдэй хоёр нэгэнт эхэлсэн дайнаа дүүрэн ялалтаар дуусгахын тул морины жолоог эс татан яг л галзуу ноход шиг үсчин Оросын олон тусгаар аймгуудын зүрх болсон Динээпэр мөрний хөвөөндөх Киев хотын зүг урагшилж байв.

Харин Ургенч хот хавийн нутгийг эзлэн суух эрхийг Чингис хааны зарлигаар хүртсэн Зүчи өөрийн эзэмшлийг төвхнүүлээд эргэж ирэхгүй, уулзахгүй байсаар жил гаран болсон нь Чингис хааны уур цухлыг барж эхлэв. Энэ нутгийн халуун бүгчим агаар, олон жилийн аян дайны алжаалд Чингис хааны бие эрхгүй ядарч нүд аних бүр сэрүүн салхит Хэрлэний хөндий, сэтгэлд дотно Бурхан Халдун уул зүүдлэгдээд бушуухан нутгийн зүг буцахыг хүсч байв. Хулан хатны гэнэтийн үхэл Чингис хааныг ингэж ганцаардлын туйлд хүргэнэ чинээ санасангүй. Гашуудал харуусал өдөр ирэх бүр мартагдан нимгэрдэг атал тэгсэнгүй. Харин ч бүр тодорч Хуланы сүнс Чингис хааны өргөөнөөс гарахгүй болжээ.

Их монгол улстай зэрэгцэн оршиж байсан Аллах тэнгэрийн шүтлэгт Хорезмын хаант улсыг мөхөөн дарсан нь Чингис хааны нэр сүрийг тэнгэрт өргөж Каспийн тэнгисээс цааших улс аймгуудад аюул аймшгийг төрүүлэх болсон нь өдөр алгасахгүй ирэх элч нарын үг мэдээнээс илт байлаа. Гэвч энэ бүхэнд, дайны олз, ялалтад Чингис хааны сэтгэл огт хөөрсөнгүй. Дайн тулаангүй хэдэн сарын тайван амьдрал түүнд өнгөрсөн амьдрал болоод ирээдүйгээ цэгнэн бодох боломж олгожээ. Унасан нутаг угаасан уснаасаа хэдэн мянган бээрийн алс энэ харийн

нутагт хэсэг зуур суухдаа яавч энд суурьшиж амьдарч чадахгүйгээ тэрээр ойлгожээ. Цэргийн доторхи жанжин захирагчдын зарим нь Инд мөрнийг уруудан хүрч үзээгүй Энэтхэг нутгийг эзлэн авч тэгээд хойш эргэн Алтан улсын өмнөд хөрш Сүн улсын урдаас нь дайран эзлэх эцэс төгсгөлгүй аян дайн хийхийг хүсч байгааг ч итгэлт хүмүүсээсээ сонсов.

Гэтэл Чингис хаан нутагтаа очиж суухыг юунд ингэтлээ хүсч байгаагаа өөрөө ч ойлгохгүй байлаа. Эцэж ядарч, өвгөрч хөгширснийх үү. Аль эсвэл ялалт байгуулах их хүсэл нь унтрав уу гэдгийн аль нь болохыг тэр эс мэдэв. Түүнд учрыг хэлж ухааруулах хүн одоо энд хэн билээ. Хар нялхаас цуг зүтгэсэн шадар Зэлмэ нь саа өвчинд дайрагдан эдгэрч сайжрахгүй болсон тул Отрарын дэргэдээс нутгийн зүг хөнгөн сүйх тэрэгний ачаа болж одов. Одоо дэргэд нь Боорчи л ганцаар торойж үлдэв. Зэв Сүбээдэй хоёр хөгширсөн ч тэд эргэж харах сөхөөгүй загалмайн шашинтнуудтай дайтсаар явна. Харин түмэн торгон цэргээ удирдаж дэргэдээс нь нэг ч мөч үл холдох Боорчи л түүнийг сахиж, хэлбэл сонсож хэрэлдвэл зөвлөж яваа билээ. Боорчийн үрчлээт нүүр, бөгтийсөн нуруу хийгээд амсхийх ч завгүй бэрх жилүүдэд бавайтлаа ургасан бөөн сахал нь бууралтсаныг үзэх бүр хичнээн жил амьдарч өнгөрөөснөө Чингис хаан ойлгож өөрийгөө толинд харах мэт болдог байв. Цаг хугацаа гэдэг даанч хайр найргүй дэндүү харгис хатуу бөгөөд хэн ч байсан, юуг ч болов элээн эмтэлж дуусгадаг, эцэст нь үгүй хийн хумхийн тоос болгодгийг ойлгож мэдрэх бүр эцэсгүй ядрал, хэмжээлшгүй ганцаардалд автах ажээ.

Нэг л сэрэхэд Боорчи ч, Зэв ч, Сүбээдэй ч үгүй болно гэж санахад даанч итгэмгүй, бүр байж болшгүй мэт санагдана. Гэтэл энэ итгэлт нөхөд нь чухам яах гэж ийнхүү энэ биеэ идэр насаа гамгүй үрж гэмгүй зарж түүнд зүтгэнэ вэ. Ихэр мэт явж ижил бяруу шиг ноололдож өссөн, илүү бодолгүй идэвхийлэн зүтгэсэн тэднийг үхнэ гэхэд дэндүү хайран. Гэвч хорвоогийн жамыг яалтай билээ. Дэргэд нь дэнлүү шиг асч явсан Хулан хатан нь өвчнөөр үхэв. Хэн Хуланг үхнэ гэж саналаа. Одоо мөрт инээгээд ороод ирэх юм шиг санагдах нь хачин. Чингис хааныг ийм гунигтай эзэнгүй бодолд авган шаналж хэдэн сарыг ёстой нэг уймарч өнгөрөөснийг хэн ч сэжиглэсэнгүй. Зэв Сүбээдэй хоёрын ирэхийг хүлээлгүйгээр явж болохгүй гэж Чингис хаан шийдсэн билээ. Учир нь урьд хожид зөвхөн дуулж сонссоноос цаашгүй шинэ газар орны тухай мэдэх хүсэл нь хязгааргүй байлаа. Харин Зүчид илгээсэн элч Зэлмийн хөвүүн Есөнтэй буцан ирж, Зүчийн хариу захидлыг гардуулсан хойно Чингис хаан гэнэт сэргэн хуучны омголон догшин, сүр хүч дүүрэн төрхөндөө буцаж оров. Боорчийг дуудан ирүүлж Зүчийн захидлыг Шихихутагаар дуудуулан сонсгожээ.

“Чингис хаан эцэг таны заасан нутгийг үүрд сахиж, захисан сургаалийг баримтлан эцгийн их улсын баруун хаяаг баталж, наран шингэх зүгт өргөтгөж, олны дунд нэр алдалгүй, овстоотны өмнө хүч алдалгүй явах нь миний ариун үүрэг тул би Хивчаг аймгийн нутгийг эзлэн авч Хаан эцгийн заасан Хорезмын нутагтай нийлүүлэн сууя. Энэ зүгт их цэрэг хөдлөх аваас хаан эцэгт хавсарч хавийн улсыг нийлүүлье. Энэхэн зуур босож хаан эцэг таны зарлигаар эргэн хөдөлье гэвч элэг бөөр өвчтэй тул эрхгүй эмнэн сувилууштай” гэж бичсэн тэр захидлаа дагалдуулан Зүчи зуун залуу эм, зуун залуу хөвүүнийг бас алтаар цутгасан азарганы хамт илгээсэн байв.

-Тэр хөвүүн нутаг буцахгүйгээр шийджээ гэж Чингис хаан огт хилэгнэсэн зүйлгүй энгийн шивнэв. Гэвч сэтгэлийн гүнд уур бухимдал биш харин яагаад ч юм бэ гомдол гуниг төрөхийг тэр мэдэрчээ. Гэвч захианаас гадна Есөнтэйн амаар өчсөнийг тэдэнд хэлсэнгүй. Хэргийн



учир ээдрээтэйн дээр Чингис хаан түүнд хандаж огт үг хэлээгүй тул Шихихутаг даруй гарч явав. Боорчи үлдээд дуугүй сууж байв. Боорчи ингэж дуугүй суусан ч Зүчид ямар нэг муу юм тохиохыг мэдэрч түгшжээ. Чингис хаан өнгөн дээрээ тайван дөлгөөн төрх үзүүлэвч дотроо бухимдуу байгаа нь мэдэгдэнэ.

-Боорчи чи юу гэж бодно. Энэ Зүчи чиний хүмүүжүүлсэн хүн биз гэж Чингис хаан хэлэхэд Боорчи инээж

-Чингис хаан та ер нь юм мартдаггүй хүн юм даа. Зүчийг энэ дайтай яваа нь ер Сүбээдэй баатарын гавьяа гэж үзэх нь үнэнд илүү нийцнэ гэв.

-Чи шууд хэл. Зүчийн үгийг юу гэж санана. Бүү үгээ булзааруул.

-Зүчи нэгийг санаад ийм үгийг илгээсэн биз. Түүнд Хивчаг нутгийг эзлүүлэн суулгагтун. Угаас хаан таны хувааж өгсөн нутгийг сахин суух гэдэг нь Зүчийн зөв биз.

-Боорчи чи үнэхээр ингэж бодно уу гэж Чингис хаан занасан мэт шивнэв.

-Миний зарлигийг даган энд ирж болоогүйг нь чи юу гэж тайлбарлах вэ. Даруй гурван удаа боллоо. Үүнийг Боорчи чи энгийн явдал гэж санаж байна уу.

-Түүний захидалд бие чилүүр байна гэж дурдсаныг та сая сонсов биш үү.

-Тийм ээ. Зүчийн бие чилүүр гэжээ.

Тэр үдэш Чингис хаан Зүчийн тухай дахин яриагүй билээ. Гэвч маргааш нь шөнө дунд гэнэт Боорчийг дуудав. Боорчи тэгэхэд өөрийн цацарт Чормогон хорчийн Багдадаас ирэхдээ бэлэглэсэн бүсгүйтэй амраглаж байсан тул их л төвөгшөөн бухимджээ. Чормогон хорчи Багдадын халифыг дагаар оруулж даахгүй их олзтой ирэхдээ Чингис хаанд гучин эм авчирч бэлэглэснээс нэгийг Боорчид өгсөн билээ. Тэр эм угийн их янаг, дуу ихтэй бөгөөд Боорчи өмнө нь ийм тачаалтай эм үзээгүй тул сүүлийн хэдэн сар түүнээс салахгүй байжээ. Боорчийг ирэхэд Чингис хаан сарны гэрэлд гадаа алтан цацрын дор сууж байв. Үзвэл тэр ер архи дарс уусан шинжгүй байлаа. Сүүлийн жилд ингэж шөнө дунд дуудсан нь үгүй тул Боорчийн гайхах алмайрах их болжээ. Дэргэд нь суусан хойно

-Миний нойр хүрэхгүй тул чамайг дуудуулав. Чи энд хүний нутгийн ч гэлээ сэрүүн тэнгэрийн дор надтай хамт суу гэж Чингис хаан хэлжээ. ”Нойр хүрэхгүйн учир намайг дуудах нь юув” гэж Боорчи бодсон ч зүгээр нэг дуудахгүйг мэдэх тул юу хэлэхийг хүлээн сурсан янзаар дуугүйхэн сууж байлаа. Чингис хаан түүнийг удаан хүлээлгэсэнгүй.

-Боорчи. Чи энэ нутгийн хамгийн өндөр оргилыг юу гэнэ мэдэх үү.

-Өмнө зүгт харагддаг тэр өндөр уулыг нутгийнхан Барыгжан уул гэдэг юм. Эндээс лав нэг өдөрчийн газарт буй. Хаан та үүнийг асуух гэж намайг шөнө дөлөөр дуудаагүй биз.

-Тийм ээ. Би чамд зарлиг буулгая. Би тэр уулын оргилд гарч Тэнгэрийн үгийг сонсохоор шийдлээ.

Чингис хааны энэ үгийг сонсоод Боорчийн сэтгэл хачин ихээр уяран догдолжээ.

-Тэр уул дундаасаа дээш цул элгэн хад. Өндрөөшөө лав гурван мянган сайн алд бий байх. Харахад манай Отгонтэнгэр уулнаас арай л намхан болов уу.

-Тэгвэл чи маргаашнаас тэр оргилд гарах оньсон шат хийлгэ. Харин үүнийг хэнд ч бүү мэдүүл.

-За ёсоор болгоё гэж Боорчи ямар ч эргэлзээгүй хэлэв. Үүн шиг бахархалтай зарлиг сонсож байгаагүй мэт санагджээ. Боорчи ч Тэнгэрийн үгийг сонсохыг хүсч байжээ. Чингис хаан ингэж Тэнгэрийн үгийг сонсохоор шийдсэн нь яав ч их цэрэг нутаг буцахын дохио гэж Боорчи таамагласан нь түүнийг ингэж баярлуулсан билээ.

-Тэгвэл чи явж үз. Тэр өндөр хамарт, дуу ихт эмдээ оч гэж Чингис хаан жуумалзав. Боорчи гэдрэг буцав. Ийм баясгалантай зарлиг сонссон нь түүнийг юун эмс хүүхэн бодохтой манатай болгов.

Боорчид зарлигийг хэрхэн гүйцэлдүүлэх билээ гэж эргэлзэх буцах сэтгэл огтхон ч төрөөгүй бөгөөд маргааш нь нутгийн уран дархчуул хоёр зуун хүн дайчлан цуглуулж тэдний дундаас хамгийн алдартай Иш-Химама гэгчийг сонгон гурван мянган алд өндөр Барыгжан уулын ноён оргилд хүн гаргах оньсон шат хийхийг тушаажээ. Боорчи ийн тушаахдаа адуунаасаа морь барьж эмээллэхээс илүүтэйгээр үзсэнгүй нь цугласан уран дархчуулыг ихэд гайхшруулжээ. Гэвч тэдэнд энэ хачирхалтай зарлигийг эсэргүүцэх буюу буцааж хойшлуулах эрх байсангүй. Оргилд урсан гарах шатны оньс, хүрдийг Самарканд хотын цуутай их сүмийг барьсан Иш-Химама гэгч тэр алдартай уран дархан эр удирдан зохиож дууссаны дараа даруй мянга илүү залуусыг Барыгжан уулын хормойд шат бариулахаар илгээжээ. Хол газраас зөөлөн бат бэх урт мод, олс гээд хэрэгтэй бүгдийг Боорчийн зарлигаар ачин авчирчээ. Чингис хааны эл зарлигийг гүйцэлдүүлэхдээ Боорчоос дутуугүй баярлаж хөөрсөн хүн бол лалын гүн шүтлэгт уран дархан Иш-Химама юм. Нэг насаараа лалын шашны олон сүм босгож Аллах тэнгэрийн дор мөнхөрсөнд тооцогдсон энэ хүн урд хожид сонсдоогүй гайхалтай бүтээл хийх хүсэлдээ хөтлөгдөн хязгааргүй урам зоригтойгоор ажиллаж байлаа. Хэдийгээр энэ оньсон шатыг ямар зорилготой хийлгэж буйг Иш-Химама тааварлаагүй ч Хорезмын урчуудын дотроос анх удаа дүүжин өргүүр шат зохиосондоо бахархаж хэдий буруу номтон ч гэлээ Чингис хаанд туйлгүй бишрэлтэй болж, энэ бүтээл нь түүнийг мөнхөд дуурсгана гэдэгт итгэлтэй байлаа. Энэ бүх ажлыг Боорчийн хяналтын дор түүний дүү Үүлэн чэрби өөрийн мянган торгон цэргийн хамт хамгаалж, зохицуулж байв. Харин өргүүр шатыг мянга илүү мужаан дархчуул хийж, зургаан сарын дараа бэлэн болсныг Боорчид илтгэв. Барыгжан уулын бэлийг алсуур тойруулан цэргээр хамгаалсан тул чухам юу хийж байгааг олон хүн үзэж харж чадсангүй. Уулын тэхий дунд элгэн хадан оргилын хөлд байрлуулсан том хүрдийг хоёр талаас нь тавин хүн эргүүлж оргил хүртэл барьсан хашлага дээгүүр хөнгөн сүйх тэрэг олсонд татагдан өгсөх ажээ. Боорчи, Иш-Химамын хамт хоёр удаа өгсөж өөрийн биеэр шалгав. Мөнх цаст оргил дээр гарах сонин ч шатны бат бэх түүнээс илүү сэтгэл зовоох тул энэ бүгдийг Боорчи үл анзаарав.

-Олс тасарвал яана.

-Би давхар олсоор хамгаална. Та санаа бүү зов.

Чингис хааны шадар сайд, торгон цэргийн их жанжин Боорчи өөрийн биеэр чухалчлан шалгаж буйгаас чухам яах гэж энэ шатыг хийлгэж буйг Иш-Химама гадарлаж үнэн сэтгэлээс хөөрөн бахдав. Тэр их Чингис хаанд зориулан оньсон шат урлажээ гэдгээ мэджээ. Иш-Химама бүх л сэтгэлээсээ бишрэн бахдаж өөрийгөө мөнхрөнө гэж санав. Чингис хаан ингэж сэтгээгүй бол Иш-Химама хэзээ ч Барыгжан уулын оройд гарах татуурган хүрдэт шат хийхгүй билээ. Үнэхээр агуу хүн л агуу санаа сэддэгийг Иш-Химама ойлгож, чухам Аллах тэнгэр ивээсэн мэт баясан хөөрсөн нь хэмжээгүй болжээ.

-Одоо Иш-Химама чамд хэдэн хүн үлдвэл болох вэ .

-Хүрд эргүүлэх зуун хүн л байхад болно. Харин та бусад хүмүүст лав их шан өгөх биз гэж Иш-Химама хэлжээ.

-Тийм ээ. Иш-Химама. Энд зүтгэсэн бүгд Тэнгэрийн таалснаар хувь хүртэх юм. Харин та зуун хүнээ шилж аваад бусдыг надад өгөгтүн. Би тэднийг их хүрээнд хүргэж зохих шан харамж олгоод тарааж явуулна. Боорчийн үгээр Иш-Химама хүрд эргүүлэх булчин шөрмөс сайн зуун залуу эрийг сонгож аваад бусад хүмүүсээ Боорчид тушаав.

-Та хэзээ эргэж ирэх вэ.

-Хэзээ ч ирж мэднэ. Иш-Химама чи үргэлж л бэлэн байгтүн.

-Өршөөгөөрэй. Чингис хаан өөрийн биеэр залрах буй заа гэж Иш-Химама болгоомжтой шивнэн асуув.

-Чи тэгэж санана уу.

-Тийм ээ. Би ийм их хувьтай төрсөндөө өөрөө ч итгэж чадахгүй байна. Аллах тэнгэр намайг ивээн тэтгэж байгаад харин би итгэлтэй байна гэж хөөрч догдолсон уран дархан аймшиггүйгээр хэлжээ. Харин Боорчи түүний үгэнд дахиж хариу хэлсэнгүй давхин оджээ. Иш-Химама гэгч урлаж дархлах, урьд байгаагүйг бүтээх хэнээ туссан тэр түрэг иран цусны хүн газар сөхрөн сахлаа илбэж

-Аллах тэнгэр минь намайг өршөө. Чингис хааны зарлигийг би таны зарлиг гэж биелүүллээ. Энэ их шатыг би Аллах тэнгэрийн ариун сүм гэж бодож бүтээлээ хэмээн мөргөжээ. Шат хийхэд оролцсон эрчүүдийг урьдаас бэлдсэн их нүхэнд тэр шөнө бүгдийг нь унагаад булж орхижээ. Энэ бол Боорчийн тушаал байв. Чингис хааны торгон цэргүүд нэг ч үг дуугаралгүй, чимээ ч гаргалгүй бүгдийг ёсчлон хийгээд Үүлэн чэрбийн өмнө эгнэн жагсаж байв. Харин болж өнгөрсөн бүгдийг Чингис хаанд Боорчи илтгэв.

Чингис хаан Иш-Химамаг өргөөндөө урихыг тушаасан нь Боорчид төдий л таатай санагдсангүй. Иш-Химамаг урихын өмнө Чингис хаан өөрийн биеэр нууцаар очиж татуурган оньст шатыг үзээд сэтгэл ихэд хангалуун болжээ. Иш-Химама өөрийгөө Аллах тэнгэр болоод Чингис хааны ивээлд багтсан хүн гэдэгт бат итгэж байлаа. Тиймгүйсэн бол энэ ертөнцийн талыг байлдан дагуулсан их хаан түүнийг юу гэж орд өргөөндөө урьж хүндэтгэл үзүүлэх билээ. Чингис хаанд бараалхахын өмнө Иш-Химама барьц алдан тэвдсэн ч Чингис хааны

зөөлөн эерүү ааш, үгийг сонсоод тайвширчээ.

Иш-Химама ийм тансаг зоогийг урьд өмнө үзсэнгүй. Мухамед султан ч өөрийн нүүдлийн их асрыг бариулаад ингэж хүндэлсэнгүй билээ.

-Иш-Химама чи одоо хаана сууна гэж Чингис хаан асуув.

-Би ... гээд Иш-Химама түгдрэв. Учир нь түүний төрөлх хот Тахраныг Чингис хааны цэрэг эвдэн сүйтгэсэн байв. Тийм учраас Иш-Химама энэ асуултанд тэр даруй хариу хэлж чадсангүй гацаж хоцорчээ.

-Чиний хот сүйрчээ гэж Чингис хаан инээв.

-Тийм ээ. Хаантан. Цэргүүд дэмий эсэргүүцсэн юм гэж Иш-Химама тал засав.

-Чи их уран хүн юм. Нэгэнт төрсөн хот чинь үгүй болсон болохоор чи надтай хамт манай нутагт очигтүн. Би өөрийн улсад Бухар, Самарканд шиг сайхан хот байгуулахыг хүснэ. Чи юу гэж санана.

-Хаантан минь. Би бол уран мужаан, дархан хүн тул хаана ч байсан ялгаагүй үзэсгэлэнт орд харш байгуулахыг хүснэ. Энэ бол миний амьдрал юм гэж Иш-Химама баяртай өгүүлэв.

-Тэгвэл чи өөрийн хүссэнээр бас манай монголын тал нутагт тохирсон гайхамшигт хот байгуулагтүн. Би чамд юу хэрэгтэйг бэлдэж өгнө гэж Чингис хаан баясгалантай хэлжээ. Чингис хаан үнэхээр монголынхоо тал нутагт ирсэн гийчдийн нүд булаасан тансаг хот байгуулж суурин суухыг хүсч байв.

-Чингис хаантан. Надад Багдад, Самарканд, Бухар шиг их хотыг удирдан байгуулсан гавьяа зүтгэл үгүй. Гэвч би хичээе. Та надад газар газраас мэдлэгтэй сайн урчуудыг олж өгөх биз. Би хот босгож чадвал Чингис хаан танд ивээгдсэний ачийг хариулах юм гэж дор мэхийн ёслов. Урлаж бүтэхээс өөр хүсэлгүй энэ хүн Чингис хаанд таалагджээ. Иш-Химамыг үдэхдээ Чингис хаан түүнд Энэтхэг газрын торгон дээл, их алт өгсөнд Иш-Химамын хөл газар хүрэхгүй болжээ. Харин Иш-Химамтай цуг ажилласан урчуудыг Боорчи өөрөөс нь үг зарлиг асуулгүй дур мэдэн бүгдийг нь алсанд Чингис хаан хилэгнэн хоёр өдөр уулзсангүй. Хэдэн муу боолын төлөө ингэж сүйд болсонд Боорчи ч дотроо дургүй хүрч Чингис хааны хилэнг нэг их ойшоож харамссангүй, түүний дараагийн зарлигийг тэвчээртэй хүлээж байв. Харин Сүбээдэй Зэв нарын элч ирж тэд Динээпэр гэх их мөрөнг гатлан Киевийн их вантай тулалдахаар зэхэж буйгаа хэлүүлжээ. Элчийг гэдрэг буцааж

-Өөрсдийн хүссэнээр явагтүн гэж хэлүүлсний дараа л Чингис хаан тайтгарч

-Боорчи. Бид хол явж хот балгас эвдэж үзлээ. Одоо яг тийм хотыг тал нутагтаа босгоё гэж санахгүй болохоор чи аргагүй морин унаатан, модон ташууртан төдий юм даа гэж зөөлөн зэмлэжээ.

-Хаан таны зарлигийн нууцыг чандлан хадгалахын үүднээс ингэж хийсэн билээ гэж Боорчийг

биеэ өмөөрсөнд Чингис хаан хариу хэлсэнгүй өнгөрч Боорчийн сэтгэл ханажээ.

Удалгүй намрын дунд сарын битүүн болж, саргүй нүхэн хар шөнө эхлэхэд Чингис хаан Барыгжан уулын оройд гарахаар шийдэв. Тэр энэ өдрийг мэргэ төлөг үзэж өөрөө тогтоов. Ер нь Чингис хаан аливаа үйлийн эхлэх өдрөө зөв сонгохыг ихэд чухалд үздэг, ихэвчлан өөрөө мэргэлэн тогтоодог тул бүгд түүнийг дагаж сурчээ. Аливаа цэрэг дайны болоод бусад чухал хэргийг эхлэх өдрийг тогтоохдоо Чингис хаан ер алдаж байсангүй. Энэ удаад ч намрын сүүл сарын битүүний өдрийг сонгон авчээ. Шөнө саргүй тул морины чих ч үл харагдана. Харин энэ шөнө Чингис хааны их өргөөнөөс Барыгжан уулын бэл хүртэл Боорчи өөрийн түмэн торгон цэргээ арван алдын зайтай морьтой нь цувуулан зогсоож тус бүрт бамбар бариулсан нь гурван өртөө илүү газарт гэрэлт зам үүсгэжээ. Морьтой торгон цэргүүдийн барьсан бамбарын гэрэлд Чингис хаан Боорчи хоёр нумтай хөнгөн сүйхээр давхиж явлаа. Барыгжан уулын бэл хүртэлх явах замыг чулууг түүлгэж хонхор хотгорыг шороо асган тэгшилж зассан билээ. Боорчи аливаа зүйлийг ганц Чингис хааны таалалд нийцүүлж сурсан зангаар юуг ч үл орхигдуулан ширхэгчлэн нямбай бэлддэг ёсоороо энэ бүхнийг олон боолын хүчээр хэдхэн өдрийн дотор амжуулж бэлджээ. Дөрвөн морь хөллөсөн хөнгөн сүйх торолгүй, донслолгүй довголгосоор төдөлгүй Барыгжан уулын бэлийг өгсөж элгэн хадан оргилын хөлдэх хүрдэт оньсны дэргэд очиход тэднийг Үүлэн чэрби болоод Иш-Химама нар хүлээж байв. Оргилд гараад буцах болмогц дугтарч дохио өгөх нарийн олсыг Иш-Химама Чингис хаанд үзүүлж, учрыг тайлбарлаад дээш өгсөхөд зориулан угсарсан жижиг сүйхний үүдийг онгойлгов. Тэр сүйхээр Чингис хаан олсоор татагдан өгсөх ажээ. Сүйхний дөрвөн буланд дөрвөн их бамбар зоосон нь хавь орчныг гэрэлтүүлнэ. Боорчийн сэтгэл гэнэт түгшүүртэй болов. Таньж мэдэхгүй хүний нутагт энэ гүн шөнийн харанхуйд чухам яах гэж ингэж байгаа учрыг олсонгүй. Гэвч Чингис хааныг хориглох эрх түүнд байсангүй. Ганцхан олс нь тасрах вий, эсвэл оньс нь гацаж эвдрэх вий гэж түгшин байх зуур Чингис хаан ер сэтгэл төвдсөн шинжгүй сүйхэнд орж үүдийг хаагаад

-За явцгаая гэж хашгирчээ.Цуг яв гэж хэлээгүй тул Боорчи дэмий л сүйхний үүд сайн хаагдсан эсэхийг шалгаж үзэхээс хэтэрсэнгүй. Бурхан халдуныг тахиж оргилд нь гарахад хэн ч Чингис хааныг дагалддаггүй тэр ёсыг Боорчи дагав. Чингис хаан ч онцгойлж элдэв үг хэлсэнгүй. Иш-Химама хашгирахад хоёр том хүрд тавь тавин хүний хүчээр чахран эргэхүй сүйх дээшлэн өгссөөр харанхуйд үзэгдэхгүй болж, сүүлдээ дөрвөн их бамбар нь од адил гэрэлт цэг болон хувирав. Ямар нэг зүйл болохгүй бол дохио өгч татах ёстой олс хэвээр унжиж, хүрд эргэсээр. Боорчи тэнгэр өөд ширтэж эцэст нь аль нь бамбарын гэрэл, аль нь од болохыг ялгаж танихгүй болмогц гэнэт сэтгэл нь хүйт оргин түгшүүр улам хүчтэй болж байв.

Тэр ингэж их айж байсангүй шиг санагдана. Юу гэж Чингис хааныг ганцаар явуулав гэж одоо өөрийгөө харааж зогсов. Тэр ерөөс тайвширч чадахгүй байв. Ертөнцөд ганцаар хоцрох мэт ийм аймшгийг Боорчи хамгийн анх хэзээ амссанаа саналаа. Тэр шөнө яг ийм нүх мэт харанхуй байсан билээ. Жамухыг Гүр хаанд өргөмжилж найманы Буйруг хаан, тайчуудын Аучу баатар нар цэрэг цуглуулан ахуйд Тэмүжин, Тоорил хантай хавсран тэдэнтэй Хүйтэн ууланд байлдсан тэр шөнө яг ийм нүх мэт харанхуй байжээ. Өдөржингөө зууралдан тулалдаж харанхуй болсон хойно цэргээ хойш татан өглөөг хүлээхээр хуарандаа цугларвал Тэмүжин Зэлмэ хоёр үгүй болжээ. Бүрий болохын алдад Тэмүжинг шархдан унахыг үзсэн цэргийн

хэлэхийг сонсоод Боорчи чухам юу хийх яах учраа олохгүй анх удаа зүрх чичрэн яг өнөөдрийнх шиг балмагдсан билээ. Тэмүжин Зэлмийн хамт алга болсонд тэднийг амьд үлдсэн гэж итгэхээс илүү нэг дор л алагдсан байх гэсэн аймшигт бодол хамгийн түрүүнд хүн бүхний толгойд оржээ. Хасар болоод бусад нөхдийн сүр сүлд Тэмүжинтэй хамт алга болсон мэт царай алдан гуньж гутарсныг харахад Боорчид бүр ч хэцүү байв. Үнэхээр тэдний хэн нь ч Тэмүжинг үхнэ гэж санаагүй явсан нь ингэж цочирдоход хүргэв. Тэмүжин тэдэнд хичнээн үнэтэй хүн болохыг Боорчи ганц мөчийн дотор мэдэрчээ. Хасарын нүднээс нулимс ус адил урсана. Боорчи арай ч уйлсангүй.

Тэмүжин алга болсныг, эсвэл үхсэнийг тэр даруй Тоорил хан болоод өөрийн цэргүүдэд дуулгахгүй байх нь зөв гэсэн ганц бодол төржээ. Тэмүжин үхсэн бол яах вэ гэсэн аймшигт бодол тархин дотор нь эргэлдэж бас яахаа ч үл мэднэ. Ганц хормын дотор хүн хичнээн олон зүйл бодож амждагийг тэр үзжээ. Эцсийн эцэст Хасараас өөр дотночлон зөвлөх хүн ч үгүй байв. Болсон хэрэг явдалд Боорчи ганц өөрийгөө буруутгаж байлаа. Учир нь Тэмүжиний амь насыг хамгаалах ёстой хүн нь Боорчи юм.

Гэтэл Хүйтэн уулын тулаанд Жамухын дагуул монгол аймгийн Аучу баатарт жадлагдан мориноос унасан ч Боорчи арай л амиа алдсангүй үлджээ. Түүнийг ингэж явгарч сандраад дайснуудад бүчүүлэн алалдаж байх зуур Тэмүжин нүднээс далд орж хаана байгааг мэдэхийн аргагүй болжээ. Толгой руугаа илдээр дэлдүүлж ухаан алдан унахдаа Боорчи өөрийгөө үхэв гэж санасан билээ. Гэтэл дуулганыхаа ачаар тэр үхсэнгүй амьд үлджээ. Харин унасан хойно нь жадалж орхиогүй нь гайхалтай. Дуулгын дороос асгарсан цусанд нүүр ам нь будагдаад хүн таних нь бүү хэл, харахын эрхгүй болсон нь түүнийг аварчээ. Ингэж Боорчи амьд үлдсэн ч Тэмүжин Зэлмэ хоёр алга болсон нь Боорчид үхсэнээс долоон дор юм болов.

Боорчид тулалдааны газарруугаа буцахаас өөр зам үлдсэнгүй. Үүр цайхаас өмнө Тэмүжинг амьд, үхсэн аль нь ч болов олох ёстойгоо Боорчи мэдэж байв. Хөл болж олуулаа орилж хашгирч дайсанд сэжиг авахуулахаас сэргийлэн Боорчи Хасар хоёр итгэлт цөөн нөхдийн хамт явжээ. Хүйтэн уулын хэдэн гуу жалга, хүний өөрийн цэргийн хүүр дүүрсэн газраар нүдгүй шөнө тэмтчиж, хүйтэн, бүлээн хүүрийн цустай нүүр амыг тэмтрэн тэмтрэн эржээ. Боорчи тэд хашгирч дуудаж болохгүй байв. Тэмүжин шөнийн харанхуйд яг шар шувуу шиг харах тул амьд сэргэг байвал эрхбиш тэднийг харна гэдэг л ганц горьдлого байлаа. Хүүрийн дээгүүр биенээс салсан сүнснүүд эргэлдэж, дутуу үхсэн биенээс салж чадаагүй сүнс чарлалдан байхыг Боорчи үзэж сонсохгүй нь харин азтай хэрэг болжээ. Түүнд тийм чадвар байхгүй нь энэ удаа Боорчид тус болов. Эс тэгвэл эргэлдэж, орилолдон чарлах хэдэн мянган сүнсийг үзсэн хэн болов ч солиорч эрүүл ухаанаа алдах байлаа. Боорчийн халуун нулимс цусанд хутгалдсан нүүр рүү нь урссаар байвч

-Тэмүжин, Тэмүжин гэж шивнэн гарт дайралдсан хүүрийг эргүүлэн нүүр амыг нь тэмтрэнэ. Хүүрийн хүйтэн нүүрэнд хүрэх бүр хуйх нь ханзран, үс нь босох шиг болно. Харанхуйд юу ч үл үзэгдэх тул зөвхөн хуруу гарынхаа мэдрэмжинд найдах бүлгээ. Барьж үзээд Тэмүжинг мянган хүний дундаас ч танина гэж өөртөө итгэнэ. Чухам яаж танихаа тэр ойлгосонгүй ч борооны ус, шавар шалбааг дотор мөлхөн ундуй сундуй унасан хүүрнүүдийг тэмтчин урагшилж байв. Гэнэт дулаан бүлээн нүүр гарт тааралдсанд цочин давхийлээ.

-Тэмүжин гэж баярлан шивэгнээд өндийлгөв. Гэвч тэр Тэмүжин биш байлаа. Тэр цэрэг

харанхуйд юуг ч юм бувгнах нь дэргэдээ хүн ирснийг лав мэдсэн бололтой.

-Чи хэн бэ гэж Боорчи нүүрэнд нь тулан шивэгнэв. Аманд нь чихээ наан чагнаж байж сая нэг юу гэж бувгнахыг нь олж сонсов.Тэр цэрэг

-Чи намайг үхүүл гэж сонсдох төдий шивэгнэх ажээ.

Боорчи түүний хэрхэн шархадсаныг мэдэх санаатай гар сунган тэмтрээд цочин ухрав. Тэр цэргийн гэдэс хүү татагдаж дотор эрхтнүүд нь газраар нэг хаягджээ. Өмхий үнэртэж байсныг Боорчи сая л мэдэв. Тэгмэгц хутгаа сугалан түүний хоолойг тэмтэрч байгаад тас хэрчиж буян болоод цааш мөлхөв.

Хэрэв Тэмүжин амьд байдаг л юм бол хэзээ ч дэргэдээс нь холдохгүй гэж тангараглан Тэнгэрийг дуудан Тэмүжинг амьд үлдээхийг гуйж явлаа. Боорчи ийнхүү Тэнгэрээс аврал эрэн дуудсан нь анхных байлаа. Тэнгэр түүнд туслана гэж итгээгүй ч ийм үед өөр хэнээс аврал тусламж эрэхээ тэр даанч мэдсэнгүй. Боорчи мөлхсөөр эцэст нь Онон мөрний хүйтэн усанд тулжээ. Голын тэртээ эндээс холгүй Тайчуудын цэргийн хүрээ байгаа билээ. Боорчи Ононы хүйтэн усанд хувцастайгаа булхан ус залгилав. Дотор нь халуун оргин шатах нь арай дээрдэж ухаан санаа нь сэргэх шинжтэй болов. Уснаас цус амтагдах нь Онон цусаар урсаж байх шиг ажээ. Голын хүйтэн усанд цохигдон жаахан ухаан ороод цаана нааныг сэхээрэн бодох сөхөөтэй болсон Боорчийн сэтгэлийн цочрол хөөрөл нь дарагдаж юу хийж байгаагаа эргэцүүлж бодов. Энэ гил хар шөнө тэр Тэмүжинд ямар ч тус хүргэж чадахгүйгээр зогсохгүй ингэж нүд сохор, сэтгэл балайгаар иш мухаргүй зориглох нь өөрийн амийг ч алдах бас бусад нөхдийг ч үхэлд хүргэх аюултайг ойлгов. Хүний өөрийн цэргийн хүүр тэмтрэн тарж одсон нөхөд нь одоо хаана явааг бүү мэд. Тэднийг үхэхгүй, дайсанд олзлогдохгүй гэх газаргүй.Тэмүжиний үгүй болсны дээр цэргийн сүр сүлд нь болсон нөхдөө нэмж алдах, бүх юм муугаар эргэсэн тохиолдолд Тэмүжинг залгамжлах ёстой Хасарыг ч хамгаалалтгүй орхисон нь түмэн алдаа болсныг ч тэр сая л ойлгов. Ийн санамагц Боорчи уснаас даруй гарсан ч хаашаа явах учраа олсонгүй. Гэнэт түүний дэргэд шахам чоно улихад Боорчи айсан цочсондоо хөдөлж чадсангүй хөшжээ. Чоно дахин улсангүй. Гэтэл тэнгэрийн зүүн хойт хаяанд гэрэл тусч удалгүй нэгэн хачин цэнхэр гэрэлт бөмбөлөг түүнийг чиглэн хурднаа ойртон ирэхийг үзээд гайхан зогсов. Боорчи ийм хачин сонин юм урьд нь огт үзсэнгүй тул гайхах, айхын алин болохоо мэдэхгүй мэлэрлээ. Гэрэлт бөмбөлөг түүний толгой дээр ирэхэд Боорчи айж ус руу зугатан оров. Гэтэл бөмбөлөг хөдөлсөнгүй, бүр түүнийг даажигнан харж байх шиг зогсжээ. Боорчи айхаа больж гэрэлт бөмбөлөгийг сайн ажиглав. Түүний хурц гэрлийн өөдөөс харах нь сохрохтой адил тул тэссэнгүй. Бөмбөлөг баруун тийш зайлан явснаа түүнийг хүлээх мэт зогсов. Дахиад л өнөөх үл үзэгдэх чоно дэргэд нь улих сонсдов. Харин энэ удаа Боорчи айсангүй чонын улихыг ойлгох шиг болжээ. Боорчи өөрийн мэдэлгүй түүнд хөтлөгдөн хойноос нь дагав. Бөмбөлөг түүнийг дагахад цааш улам хурдлана. Боорчи бүхнийг мартаад хойноос нь гүйж эхлэв. Хүүрэнд бүдэрч унасан ч бөмбөлгөөс хоцрохгүй гүйсээр байв. Бөмбөлгийн гэрэлд өмнөх зам нь гэрэлтэнэ. Бөмбөлөг зогсоход Боорчи гүйсээр дор нь очиж зогсов. Гэтэл өнөөх бөмбөлөг гэнэт гарч ирсэн шигээ гэнэтхэн алга болов. Эргэн тойрон тас харанхуй боллоо. Бүр алсад чоно нэгэнтээ улиад чимээ тасрав. Боорчид үүр цайхыг хүлээхээс өөр арга үлдсэнгүй. Тэмүжиний хүүрийг л эрж олох үлдэв гэж тэр гашуудан бодсоор бүр нулимс урсган суув. Боорчи өөрийгөө зөвтгөж цагаатгах арга олсонгүй. Үүр цайж холын

уулсын орой, орчмын газрын бараа тодров. Тэр Ононы бургастай өндөр эргийн дээр сууж байв. Гэрэл түүнийг энэ хүртэл хөтлөн авчраад алга болжээ. Гэгээ орж даруй нөхдөө олж цэрэгтэйгээ нийлэхгүй бол аюул тулгарах тул буцах, үүний өмнө хаашаа явах, хаана байгаага мэдэхийн тулд өндөрлөг газар гарч бараа харах нь зөв гэж боджээ. Гэтэл тэр нэг ч алхаж амжсангүй зогссон газраа нам хэвтэв. Учир нь нүдний үзүүрт бургас хөдөлж хэн нэгэн явахыг олж харжээ. Боорчид хутганаас өөр зэвсэг үгүй байв. Үнэхээр бургасны завсраар хүн явах нь үзэгдэнэ. Тэр ганцаар бололтойг мэдээд өндийж,

-Хөөе. Чи юун хүн бэ гэж аяар хашгирав.

-Боорчи чи юу гэх нь Зэлмийн дуу ажээ. Боорчи ч босч гүйв. Бургаснаас дотуур өмдтэй Зэлмэ гарч угтав.

-Тэмүжин яав.

Зэлмэ дуугүй гэдрэг явж бургасан халхыг сөхвөл Тэмүжин тунасан цусны дэргэд гулдайн хэвтэх ажээ.

-Үхчихэв үү.

-Унтаж байна. Хамаг цусаа юүлсэн болохоор толгойгоо өргөх тэнхэлгүй болжээ. Би Тэмүжиний цусны талыг уусан биз гэж Зэлмэ тайван инээмсэглэн хэлсэн нь Боорчийг тайтгаруулж тэр дороо сөхрөн суугаад Тэнгэрт мөргөв.

-Чи яаж байна аа.

-Би Тэнгэрт мөргөж байна. Шөнө намайг та хоёрыг эрэн хүүрэн дунд тэнэж явахад Тэнгэр намайг дагуулан энд авчирчээ гэж Боорчи хэлэв. Тэр гэрэл бол үнэхээр Тэв Тэнгэрийн дуудахад ирээгүй Хүйтэн уулын савдаг байсан билээ. Хүйтэн уулын савдаг Тэв Тэнгэрийн хүсэлтийг сонсож мэдээгүй тул хоцорч түүний хүч Тэмүжиний хүзүүн дэх Тэнгэрийн сахиусанд шингээгүй ажээ.Тийм учраас Тэмүжин энд Хүйтэн ууланд шархаджээ.Гэвч үхээгүй нь Хүйтэн уулын савдаг тусласных юм. Зэлмэ Боорчи хоёр Тэмүжинг авч тэндээс зайлав. Шөнө салсан нөхөд нь ч удалгүй иржээ. Хэрэв Боорчи ирээгүй бол Тайчууд гэгээ ормогц нойтон шавар дээр Зэлмийн шөнө үлдээсэн мөрөөр мөшгин тэднийг олж, Тэмүжин гарцаагүй үхэх байсан юм. Шөнө Зэлмэ тайчуудын хүрээ рүү нүцгэнээр сэм очиж хөхүүртэй тараг хулгайлан авчирч цус их алдсанаас болж ам нь анган ёолж бачимдах Тэмүжинд уулгасан билээ. Энэ бол хоёул амь алдаж болох аюултай хэрэг байв.Гэвч үүнээс өөр арга Зэлмэд байсангүй. Үнэхээр өглөө нь голын нойтон шавар дээр Зэлмийн тохой урт нүцгэн тавхайн мөр эзнээ хаанаас ирж, хаана очсоныг илтгэн дурайж байхыг тайчууд үзээд давхилдан ирвэл нуугдсан газар нь тунасан цуснаас өөр юм үлдсэнгүй ажээ.

Боорчи хэдийгээр өнөөх цэнхэр гэрэлт бөмбөлгийн учрыг олоогүй ч түүнийг Тэмүжинд туслахаар ирүүлсэн Тэнгэрийн дохио гэдгийг гадарлажээ. Тэр Тэв Тэнгэр шиг чонын хэлийг ойлгодог байсан бол учрыг тайлж цөхөх юмгүй байсан биз. Шөнийн гэрэлт бөмбөлгийг ганц Боорчи харсан биш байжээ.Тэр бөмбөлөг тайчуудын цэргүүдэд үзэгдсэнд тэд сэжиглэн зэвүүцэж, цэргийн төлөгч нь мэргэлж үзсэнд дайсанд дийлдэхийн ёр байсан тул маргааш нь



тайчуудын ихэнх нь зугатан тарж одсон билээ.

Өөрийнх асарт аваачиж, тойгны халуун шөл уулгасны хойно жаахан тэнхэрч өндийсөн Тэмүжин хэдийгээр гүрээний судсаа хага харвуулж цус ихээр алдан тамирдсан ч хэдэн үг хэлэв. Санаа зовж шаналсан нөхдийн нь царай гийж сэргэв. Цацарт шархтай Тэмүжиний дэргэд Хасар, Боорчи, Зэлмэ гурав л байлаа. Учир нь Тэмүжиний шархадсаныг олноос нуух ёстой тул ингэж хөл хорьжээ. Тэмүжинг ухаан орж сэргэмэгц л түүний шархадсаны буруутан Боорчийг гэсгээхийг Хасар шууд шаардав. Өөрийн хийхийг умартсан бурууг ганц Боорчи хүлээх ёстой гэж Хасар үзжээ. Тайчуудын Аучу баатар өөрийн шилдэг цэргүүдийн хамт тэдний эсэргүүцлийг няцааж бүслэн авах аюул илэрхий тулгарсан үед Боорчи Тэмүжиний дэргэд байсан цэргүүдийг удирдан халз тулаанд орсон билээ. Ингэж түргэн шуурхай эсрэг довтолоогүй бол Тэмүжиний гол цэрэг Хүйтэн уулын хавцалд хашигдан сөнөх аюул илэрхий байсан ч Боорчи Хасарын зэмлэлийг эсэргүүцэлгүй дуугүй сонсож өөрийгөө зөвтгөх нэг ч үг унагасангүй. Боорчи ер тийм зантай билээ. Хасарын үгийг няцаан хэрүүл уруул үүсгэхийг тэр хүссэнгүй. Тэр Тэмүжиний үгийг дагахаар шийджээ. Боорчийн ийн дуугүй зогсохыг буруугаа хүлээж байна гэж Хасар ойлгов. Нэгэнт Боорчийн буруу илэрхий, түүнээс болж Тэмүжин хамгаалалтгүй болж амь эрсдэх дөхсөн нь тодорхой тул Боорчийг үхүүлэх ёстой гэж Хасар шууд тулгав. Боорчийг ирснээс хойш гэрийн доторхи байр суурь, эрх мэдэл нь илт хумигдаж, Тэмүжин энэ залууд бүгдээс илүү нүүр өгөх болсонд Хасар угаас дургүй байжээ. Тэмүжиний дараагаар өөрөөс нь илүү хүндлэл хүлээсэн Боорчийг одоо л дарж авах ёстой гэж Хасарын дотор бодогджээ. Зэлмэ бол угаас тэдний боол тул ямар ч үед Хасарт хүндэтгэл үзүүлнэ. Харин Боорчи бол тийм биш. Хасарыг өөрөөсөө дорд үзэх мэт санагдах болоод уджээ.

-Хэн хэлсэн үгэндээ эзэн болж үл чадна, тэр хүнийг бусдад дохио санамж болгон үхүүлэх ёстой. Би ч байсан тэгэх болно гэж Хасар шаардав. Тэмүжин бодолд унав. Бусад нь түүний үгийг хүлээн таг дуугүй сууцгаана. Түүний шархадсан нь Тэмүжиний нөхдийн байлдах дайтах арга чадвар, цэргийн сахилга үнэндээ дутуу байгааг илрүүлжээ. Гэвч Боорчийг буруутгах сэтгэл Тэмүжинд огтхон ч төрсөнгүй. Бас Хасарын шаардсан нь ч зөв гэж бодно. Боорчи бол Тэмүжинд Тэнгэрээс илгээсэн хамгийн анхны ганц үнэнч нөхөр нь юм. Тэнгэр түүнийг Боорчитой учруулахын тулд Жүрхэн аймгийнхнаар найман шарга агтыг нь хулгайлуулсан гэдгийг Тэмүжин ойлгосон билээ. Гэтэл Хасарын хэлсэн ёсоор Боорчийг шийтгэх нь цэргийн сахилга журмыг бататгах сайн арга, сургамж болох байв. Бас үнэнч нөхөр гэж тал тохой татаж хэнийг ч дээгүүр үзэхгүй чин шударга шинжийг үзүүлэх тул цэрэг ардын дунд Тэмүжиний нэр нүүрийг ч өсгөх юм. Боорчийг үхүүлэх амархан. Бас тэгэх шалтаг бэлхэнээ байв. Боорчи ч үхэхийг үл тооно. Айх ч үгүй биз. Харин Боорчи Хасар хоёрын хэнийг сонгох вэ гэдгээ шийдэх цаг Тэмүжинд одоо иржээ. Хэрэв Хасарын үгийг дагаж Боорчиос хагацвал хэн түүний орыг нөхөх билээ. Хасар уу. Эсвэл Боорчийг өршөөж Хасарын үгийг няцаавал Хасарын сэтгэлийн гүний эгдүүцэл нэмэгдэж гэрийн дотор дайсан бий болох аюултай. Хуяг дуулга өмсөлгүй цалгар зан гаргаснаас үүдэж дайсны суманд өртөн шархадсан нь ах дүүгийн холбоо, Өүлэн эхийн нэр сүрийн дор дарагдан явсан далд зөрчил тэмцлийг илрүүлэн гаргаж буйг Тэмүжин харав. Хэрэв тэр үхсэн бол Хасар нэгэнт өөрийн эрхийн дагуу Тэмүжинг залгамжлах нь гарцаагүй байсан биз. Өөрөө үхэж, хэн нэгэн түүний байр суурийг эзэлнэ гэж Тэмүжин бодохыг ч хүсэхгүй байлаа. Гэнэт төрсөн энэ бодол нь түүнийг ингэж бухимдуулна чинээ санасангүй. Энэ бухимдал эцэст нь Тэмүжиний шийдвэрийн үндэс

болсон юм. Хасарын хэлсэн шиг Тэмүжиний үхлийг хүсэх шалтаг Боорчид үгүй. Харин Боорчийг үхүүлэх нь Тэмүжинг хамгаалалтгүй болгох гэсэн Хасарын далд санаа шиг санагджээ. Тэмүжин үхвэл чухам хэнд ямар ашигтай нь даанч тод ойлгомжтой байлаа.

-Боорчи гэж Тэмүжин арай ядан шивнэв. Бүгд анхааран чагнажээ.

-Боорчи гэж Тэмүжин дахин арай тод хэлээд хагас өндийв.

-Тэмүжин чи олон долоон юм хэлж бүү зовоо. Би өөрийн гэмийг үхэж цагаатгая гэж Боорчи эргэлзэхгүйгээр хэлэв. Хасар бардам инээмсэглэхийг Тэмүжин олж үзэв.

-Боорчи, Хасар, Зэлмэ та гурав сонс. Энэ Боорчи бол Тэнгэрээс заагдаж түмнээс түрүүлж дэргэд ирсэн ганц нөхөр минь юм. Ийм тулаанд үхэхгүй бие, үрэгдэхгүй амь гэж үгүй. Би өөрийн сэрэмжгүй алмайдаа дайсны суманд өртөв. Би Зэлмийн хэлснээр толгойн дуулгаа өмссөн бол юунд ийм хэрэг болох вэ. Би Хасар дүүгийн үгийг ойлгон сайшааж байна. Хэн ч байсан гэмээ шударгаар хүлээх ёстой юм. Бид Хасарын саяын хэлсэн журмаар цаашид өөрсдийгөө болоод цэргүүдээ хүмүүжүүлбэл зохино. Тийм ээ, Боорчи буруутай. Гэвч тэр торгон цэргээ авч Аучу баатрыг эсэргүүцэн тулаагүй бол бид бүгд үхэж болох байв. Үүний төлөө Боорчийг бас сайшаавал зохино. Хасар өчигдөр Жамухын гол цэргийг хориглон зогсоох гэж яаж баатарласныг би үзсэн. Чиний хүч, зориг дайсны зүрхийг үхүүлэв. Чамгүй бол би юу хийж чадах билээ. Хасар бол халуун амь, хатан биеэ надад зориулах ёстой дүү минь юм. Чиний байлдах дайтах арга, үл шантрах зориг, цавчих харвах эрдмийг хэн ч үл гүйцнэ. Гэмтэн хүнд гэмийг оноох ухааныг чинь би биширлээ. Чи үүнээс хойш энэ үгээ үргэлж санаж бас үргэлж дэргэд минь байж сануулж явагтүн. Өнөөдөр бид нар үхэх биш, үрэгдэхгүйн төлөө санаж сэдэх ёстой. Өнөөдрийн өчүүхэн гэмээр, өнгөрсний өш хорслоор өнө ирээдүйн их хэргээ умартахгүй байвал зохино. Үүнийг санагтүн. Би Боорчи чиний хүчээр амь аврагдав гэж санана. Хэрэв чи нүдгүй хар шөнө Зэлмэ бид хоёрыг бэдэрч олоогүй бол бид тэнд тайчуудад баригдан алагдах байлаа. Харин чи Тэнгэрийн зааснаар уйгагүй явж олжээ. Би чиний энэ сэргэг байдал, сэтгэлийн үнэнчийг чинь мартахагүй. Би чиний ачийг яаж хариулах билээ гэж Тэмүжин хамаг тэнхээгээ шавхан хэлээд толгойгоо даахгүй унажээ. Тэмүжиний энэ үг Хасарт таашаагдаж, Боорчийг уярааж, Хасар болоод Боорчийн хооронд, бас Тэмүжин болоод Хасарын дунд үүссэн зөрчлийг түр намдаан тайвшруулав. Тэмүжин ончтой, ухаалаг үг олж хэлж чаджээ. Зэлмэ харин гайхсан дүр эсгэж

-Тэмүжин эзэн та юу ярина. Нөжирсөн цусыг чинь шөнөжин шимж, амь хайргүй явсан миний гавьяаг яана хэмээн баяртайгаар хөхөрч хар саналгүй үнэн бодлоо хэлэв.

-Зэлмэ би чиний тусыг багад үл үзнэ. Хожим хойно есөн удаа ял хэлтрүүлье гэхэд бүгд инээлдэв.

-Би тэгвэл мөнхөрсөн мэт болжээ. Харин та Боорчийг лавтай надаас илүү үзжээ гэхэд Тэмүжин ер тоглосон янзгүй

-Би биш Тэнгэр ингэж үзжээ хэмээн шивнэхэд хэн ч хариу хэлсэнгүй.

-Боорчи Зэлмэ та нар сонс. Миний шархадсаныг бусдаас нууцалсан чинь сайн хэрэг. Цаашид

ч бүү мэдэгд. Харин намайг харвасан цэргийг амьд үхсэн алин боловч надад авчирч үзүүлэгтүн гэж Тэмүжин тушаажээ. Тайчуудын хуарагнасан цэрэг тэр шөнө ачаа хөсөг, явдлын ая даахгүй эмс хөгшдөө хаяж зугатан одсон нь Тэнгэрийн аврал байсан боловч Тэмүжиний шархадсан нь олон зүйлийг ойлгуулж, бас олон зүйлийг өөрчлөхийг шаардав. Юуны түрүүн Тэмүжиний амь нас аймаг, цэргийн бүх амьтай тэнцэхийг ухаарцгаав. Бас Тэмүжин шархдах буюу үхэхэд хүрвэл цаашид хэрхэх ёстойг хэн ч мэдэхгүй байгаа нь ийм үед дайсны идэш болоход хялбар болохыг илрүүлэв. Бас Тэмүжиний шадар хишигтэн цэргийн байлдааны үеийн сахилга, журмыг бэхлэх хатуу цааз тогтоох, тэднийг сурган хүмүүжүүлэх нь чухал болжээ гэдгийг харуулав. Эцэст нь Тэмүжинг байлдаанд хутгалдан орохыг нэг мөсөн зогсоох хэрэгтэйг ойлгуулав. Дүү нар болоод нөхдөөс хэн нь ч цэрэг байлдааны хэргийг нэгтгэн удирдах бэлтгэлгүй байгаа нь Тэмүжинг ихэд айлгажээ. Тэднийг бие даан дайтахад сургах, бас дайсныг дарах арга мэх, цэргийн боловсрол, чадлыг сайжруулах нь тулгарсан зорилго болсон байв. Гэртээ сууж, малаа адуулж, эзнээ дуудсан үед мордож ирдэг иргэн цэргийг, байнгын хатуу сургуультай, дайтах байлдахаас өөр зорилгогүй байнгын цэргээр солихыг хойшлуулж болохгүй хэрэг гэж тэд шийдсэн нь Тэмүжиний шархадсаны олз байв.

Ингэж Тэмүжин нар байнгын цэрэгтэй болох ажлыг шуурхайлсан бөгөөд энэхүү цэргийн цөм нь Тэмүжиний хишигтэн хэмээх торгон цэрэг болж байлаа. Зуут мянганы ноёдын хөвгүүд болон шилдэг гавшгай, амь хайргүй үнэнч тэмцэх дур хүсэлтэй эрсийг сонгон хишигтэн цэргийг байгуулах зарлиг гаргав. Ийнхүү Чингис хааны их аян дайны гол бэрхийг үүрч гадны улсын хүчирхэг цэргийг бут цохисон монголын морьт цэргийн мянгагууд үүсч эхлэв. Алдаа болгоноос суралцах ёстойг Тэмүжин энд анх удаа нөхөддөө чухалчлан хэлсэн нь тэр өөрөө ч сайтар ухаарч ойлгосны гэрч юм.

Урьд тайчуудад олзлогдох үед нь аварч тусалсан зарц Сорхоншар, Чулуун Чимбай хоёр хөвүүнийхээ хамт энэ тулааны дараа дагаж ирсэн нь Тэмүжиний сэтгэлийг туйлын ихээр догдлуулжээ. Сорхоншар бол хэдий боол ч гэлээ Тэмүжинд хамгаас түрүүн их тусыг хүргэж амийг нь аварсан ачтан билээ. Сорхоншар түүнийг хоёр удаа нуун өнгөрөөж авраагүй бол Тэмүжин тайчуудын Таргудайд алуулж өт хорхойны хоол болох байв. Түүний ачийг хариулах нь Тэмүжиний өдрийн бодол шөнийн зүүд байлаа. Эцэг ах нараасаа тусдаа сууж байсан Сорхоншарын охин Хадааныг нь Мухулай олж ирсэн нь бүр ч баясгалантай хэрэг болов. Арван хэдэн настай алмай багадаа тайчуудын хүрээнээс амь дүйн оргож ирэхэд нь сэтгэл гарган асарсан Хадааныг Тэмүжин огтхон ч мартаагүйгээр барахгүй, зүрхний цаана энхрийлэн хүсэмжилж явснаа мэджээ. Цус алдаж сул дорой байсан хэдий ч Тэмүжин Хадаантай амраглан цэнгэхийг хойш тавьсангүй. Хадаан хэдий царай зүс гоо үзэсгэлэн ихгүй ч ид насны шим шүүс бүрдсэн танхил борхон бүсгүй болон хувирчээ. Хадаан Тэмүжинд хайртай хэвээр ажээ. Тэмүжинд охин биеэ найр тавин өгч эр эмийн үйлийг анхлан амсуулж эдлүүлсэн хүн бол Хадаан байв. Хадааны анхны эр нь Тэмүжин бүлгээ. Тийм болохоор Тэмүжин энэ олон жилийн дотор түүнийг огт мартаагүй бөгөөд бүр сэтгэлийн гүнд хүсэмжлэн явснаа мэджээ. Хадаан эрд гарч айлын эм болжээ. Гэтэл эр нь өнгөрсөн тулаанд Тэмүжиний цэрэгт алуулжээ. Гэсэн ч Хадаан уй гашуугаа мартаж Тэмүжиний тэврэхэд эсэргүүцсэнгүйгээр барахгүй охин цагийн хонгор зангаараа тачьяадан шунаж биеэ сул тавин өгчээ. Хадаан бол гайхалтай дуулгавартай бүсгүй билээ. Гэвч боолын охинтой шадарлах нь Тэмүжинд зохисгүй байсан тул сэтгэлийн хүслээ чандлан барих ёстой болжээ. Тэмүжин

хүслээ тэвчиж Хадааныг гэрт нь буцаав. Хөөрхий тэр бүсгүй, харцын заяандаа гомдон уйлж явлаа. Тэмүжиний шаналал ч хязгааргүй байв. Тэдэнд хамт амьдрах заяа байсангүй. Гэвч Хадаан бүх насаараа Тэмүжиний татвар эм шиг явахыг хүсээгүй бөгөөд түүнд энэ амьдралаа аз жаргал дүүрэн болгох нэгэн нууц хүсэл зорилго байжээ. Бөртийн хардлага сэжгээс эмээлгүйгээр Хадаан Тэмүжинтэй учрах боломж бүрийг алддаггүй байлаа. Асар их эрх мэдэлтэй бас далд хорон зантай Бөртэтэй эвдрэлцэж, эр булаалдан өрсөлдөх нь боолын охин Хадаанд үхэлтэй адил байсан ч Хадаан өөрийн санаанаас буцсангүй. Их зориг хүслийн нь шагнал болж дөч хүрсэн насандаа Хадаан Тэмүжинээс бие шалтагтай болжээ. Түүний ганц насны хүсэл тэр байсан болохоор бие шалтагтай болсноо мэдмэгц баярлаж хөөрсөндөө учраа олохгүй байлаа. Олдсон үрээ хөвүүн гэдгийг Хадаан зөнгөөрөө мэджээ. Гэвч түүний энэ их баяр хөөр ямар аюул дагуулахыг Хадаан сайн мэдэж байсан билээ. Бөртийн туршуул эмс эргэлдэж Хадааны хөдлөх гишгэхийг тандаж байдгийг тэр гадарлана. Тэмүжиний хавьтаж ойртсон эмсийг хардаж цагдаж чимээгүйхэн хорлож алдаг нь Бөртийн ганц дуртай ажил болоод удсаныг Хадаан өөрийн нүдээр үзэж мэдсэн тул сэрэмжтэй болжээ. Хэрэв түүнийг Тэмүжинээс бие давхар болсныг Бөртэ мэдвэл золгүй эх үр хоёрт үхлийн аюул тулгарах нь гарцаагүй байлаа. Сорхоншар Тэмүжинд дагаж ирснээс хойш Бөртэ Хадааныг ихэд халамжлан хүрээнийхээ дотор өөрийн ойр суулгах болсон нь сайн санааных биш Тэмүжиний анхны амраг бүсгүйг хараандаа байлгаж хэзээ жирэмслэхийг нь хүлээсэн хэрэг байлаа. Тэмүжиний эмс хүүхнүүдтэй орооцолдохыг хорьж цагдах эрхгүй тул харин хавьтсан эмсээс хөвүүн төрүүлэхгүй байлгах нь Бөртийн хийж чадах зүйл байв. Бөртэ өөрийн хөвүүдэд өрсөлдөгч бий болохыг хэзээ ч зөвшөөрөхгүй билээ. Өөрт нь болоод хэвлий дэх үрд нь нүүрлээд байсан аюулаас аварч туслах хүн Хадаанд хэрэгтэй байлаа. Чингис хаанд итгэл олж шадарласан эцэг, ах нартаа Хадаан итгэсэнгүй. Тэд тэртэй тэргүй Бөртийн зарлигаас зөрөх эрхгүй тул түүнийг охиноо, дүүгээ гэж хайрлахгүйгээр алж орхих биз гэж Хадаан боджээ. Бас Тэмүжинд ч итгэхгүй байлаа. Тийм учраас хүсч олсон үрээ зүгээр үхүүлэхийг Хадаан хүссэнгүй. Удах тутам аюултай тул түүнд нэг өдөр ч хүлээх цаг байсангүй. Бие давхар болсныг Бөртэ мэдвэл үхэлтэй адил хэрэг болох байв.

Хадаан гэнэт алга болсныг Бөртэ яаж ч оролдож хичээгээд олж мэдэж чадсангүй. Бүх үнэн зовлонгоо тоочин нулимс асгаруулсан Хадааныг үзээд Боорчи удаан татгалзаж чадсангүй. Хадааны дуулгавартай үнэнч зан эртнээс Боорчид таашаагдаж байсан нь түүнийг ийм алхам хийхэд хүргэжээ. Бас Хадаан Бөртэ хоёрын хооронд үүсч бий болох зөрчил тэмцэл эцэстээ юунд хүргэж болохыг урьдчилан таамаглаж сэргийлсэн хэрэг байв. Боорчийн хувьд юуны түрүүнд Тэмүжиний амар тайван амьдрал хэрэгтэй байсан билээ. Хадааныг ирснээс хойш Бөртийн зан ааш хэрхэн хувирч байгааг Боорчи анзаарахгүй байхын аргагүй байв. Тэмүжинг хамгаалж тайчуудын Таргудайн гараас аварч тусалсан Хадаан гэгч гэмгүй бүсгүйг Бөртийн гарт дэмий үрэгдээсэй гэж Боорчи хүссэнгүй. Хамгийн гол нь Тэмүжин Хадаанд хайртайг Боорчи үзэж мэдсэн явдал байв. Боорчи Хадааныг Алтайн нурууны өвөрт байх өөрийн хамаатны итгэлтэй айлын хаяанд суулгасан бөгөөд Хадаанаас хөвүүн төрснийг тас нуухаар шийджээ. Харин Хадаан хөвүүн төрүүлснээ Тэмүжинд дуулгахыг чин сэтгэлээс хүссэн ч Боорчи түүний хүссэнээр хийгээгүй бөгөөд хөвүүндээ хэлэхийг ч хориглосон билээ. Ингэх нь хэн хэндээ аюул осол багатай байлаа. Хадаан гэгч тэр даруу төлөв номхон зантэй бүсгүй Тэмүжиний хөвүүнийг төрүүлсэндээ аз жаргалтай харамсах юмгүй үхжээ. Харин Хадааны хөвүүн Гэрэгийг арван нас хүрмэгц Боорчи өөрийн дэргэдээс салгаагүй билээ. Гэрэгийг бүгдээр Боорчийн найманы буурин дээрээс олж авсан хүүхэд гэж итгэх бүлгээ.

Тайчууд болоод Жамухын цэргийн орхиж одсон иргэдийг хураан авчирсны дараа олзлогдсон буюу дагаж ирсэн цэргүүдийн дотор Тэмүжинг харваж шархдуулсан хүн байх нь магад тул Тэмүжин тэдний дундуур явж зарим хүнийг бүр тулж очин харж явжээ. Энд дагаж ирсэн цэргийн нэг болох тайчуудын Зургаадай гэгч эр Тэмүжинг харвасан атлаа айлгүй үлдсэн байжээ. Зургаадай угийн зоригтой дайнч эр учир Жамуха шиг шөнө дөлөөр зугатаахыг бодсонгүй. Зугатаасан дорвол дайсандаа алагдахыг тэр дээр гэж үзсэн бөгөөд Тэмүжиний хэрхэхийг хүлээн суужээ. Мөн Тэмүжинг шархдуулснаа ч олж үзэв. Уг нь Тэмүжинг алав гэж санасан билээ. Гэвч Тэмүжин эрүүл саруул явахыг үзээд ончгүй муу харвасандаа ихэд харамсаж суув.

-Хүйтэн уулын тулаанд миний байлдааны ам цагаан хул морины хүзүүг хэн харваж шархдуулав гэж Тэмүжин Зургаадайн өмнө ирээд ойрын хүн л сонсохоор шивнэх шахам асуув. Боорчи, Хасар, Зэлмэ нар түүнийг залгуулан “Миний байлдааны ам цагаан морины хүзүүг хэн харваж шархдуулав” гэж дуу дуугаа аван бархиралджээ. Нам гүм боллоо. Дахин хашгирахад нь Тэмүжин чухам юун тухай асууж буйг мэдсэн Зургаадай алгуур босон түүнд дөхөн очив. Зургаадай, Тэмүжинээс даруй сайн тохой өндөр сүрлэг сайхан эр байв.

-Чи юу гэв хэмээн Тэмүжин эгц ширтэн асуув.

-Би Тайчуудын Зургаадай гэгч билээ.

Морины хүзүүг би харважээ.

Алья гэвэл ал

Алганы төдий газрыг

Алаг болгож өмхийрүүлэх

Алд бие байна.

Аварья гэж санаад

Амий минь соёрх

Халд гэсэн газарт чинь

Харайж очоод би

Хар усыг цалгитал

Хад чулууг хэмхэртэл

Харь дайсныг довтолж

Хаан чамд туслая.

Цээлийг усыг цалгитал

Цэгээн чулууг хагартал

Чин зоригийг гаргаж

Чингис чамд туслая

Хүр гэсэн газарт чинь

Хүрч очоод би

Хүр чулууг хэмхэлье.

Хүний зүрхийг шанталъя гэж шүлэглэн хэлэв.

-Чи яах гэж морийг минь харвав гэж Тэмүжин түүнд бүр нүүр тулж очоод асуув.

-Би алья гэж харвасан билээ.

Зургаадайн энэ чин үнэнч аймшиггүй сэтгэл, цэцэн цэлмэг үг Тэмүжинд таашаагджээ.

-Дайсны хүн дайсагнаж хорлох санаагаа нуух бөгөөтөл харин чи хорлосноо нуухгүй үнэн очив. Чи шударга, зоригтой хүн юм. Ийм хүнтэй нөхөрлөж болно. Чи миний байлдааны ам цагаан хул морины хүзүүг зэвээр харвасан тул чиний Зургаадай нэрийг халж Зэв гэж нэрлэе. Чи үгэндээ хүрч дэргэд минь жагсаж зэв мэт хамгаалж яв гэж чамайг өршөөе гэжээ. Учрыг мэдэхгүй хүн морь шархдуулснаар ойлгов. Харин цөөн хүн Зэвийг ямар учиртай ингэж хэлснийг ойлгож байв. Ийнхүү Зэв амь өрсөн байж Тэмүжиний дэргэд ирсний учир энэ юм. Тэмүжиний энэ гэнэтийн шийдвэр түүний нөхдөд таашаагдсангүй. Хасар эсэргүүцсэнээ илэрхийлж дуугүй эргэн явжээ.

Харин Зэлмэ дуугүй зогсож байв. Өөрийг нь алах гэсэн өстнийг Тэмүжин ийнхүү энэрэн өршөөснийг Боорчи удтал зөвшөөрөн хүлээж чадахгүй Зэвийн хөдлөх, алхахыг хянамгай ширтэж цагдан хянах болжээ.

Тэр өчүүхэн төдий сэжиг гарвал Зэвийг дор нь алахад бэлэн байв. Шархадсаныхаа дараа өөрийн амь нас, төр улсын бат бэхийг сахигч шадар торгон цэргийг Боорчиор удирдуулахаар Тэмүжин тогтов. Түүнээс хойш Боорчи Тэмүжиний дэргэдээс холдсонгүй билээ. Боорчи Тэмүжиний торгон цэргийг удирдах болсон нь түүний нэр нөлөөг нөхдийн дотор илт өргөж Хасарын зэвүүг ихэд хөдөлгөв. Торгон цэрэг бол байнгын цэргийн гол цөм, амин сүнс нь тул Боорчи ингэж Тэмүжиний удаах эрх мэдэлтэн болсон юм. Уг нь Тэмүжиний удаах эрх дархтан нь Хасар байх ёстой боловч Тэмүжин ингэж шийдсэнгүй. Харин Зэв үнэнч зүтгэх нэгэн үзүүрт зорилгоос өөр далд санаа агуулаагүй ч Боорчи итгэж үнэмшихгүй байдгийг Зэв ч, Тэмүжин ч мэдэх болжээ. Бас дарагдсан дайсны цэргээс урван дагаж ирсэн хүн ганц Зэв биш юм. Буун өгч үнэнч зүтгэх тангараг өргөгсөд бүгдээр тийм итгэлтэй үнэнч гэдэгт Боорчи үргэлж эргэлзэнэ. Харыг үзэж хазайж, шарыг үзэж шарвах сэтгэл нэгэнт гаргасан тэд Тэмүжинг хөл алдвал араас нь хутга шаахад хэзээд бэлэн байна гэж Боорчи итгэх тул харуул

хамгаалалтыг улам чангаруулан бэхлэв. Удалгүй Тэмүжиний хамгаалалт хамгийн журамтай бат бэх болжээ. Их хаанд өргөмжлөгдсөнөөс хойш Чингис хааны шадар торгон цэргийн тоо түм болж, байнгын цэргийн тоо арван түмд хүрчээ. Боорчи яваандаа Зэвд итгэх болж Зэв ч Чингис хааны унтлагын болоод ёслолын өргөөнд зөвшөөрөлгүй орох болжээ. Зэв ямар гавшгай баатар болохоо Алтан улсыг дайлахад бахархалтайгаар үзүүлсэн билээ. Зэв ингэж Боорчийн итгэлтэй нөхөр нь болжээ.

Боорчийг одоо энд Барыгжан уулын бэлд Чингис хааныг хүлээн түгшиж элдвийн бодолд дарагдан зогсох тэр мөчид Зэв Сүбээдэй хоёр түүнээс мянган бээрийн цаана Динээпэр мөрнийг сэм гатлахаар гэтүүлж явлаа. Харин тэнд Динээпэр мөрний өргөн хөндийд сартай нам гүм бөгөөд холд Киев хотын их сүмийн хонх дуугарах нь сонсдож энэ дуунаар сэрсэн олон хэрээ шаагилдан эргэлдэж байсан билээ. Монгол цэргийн магнайд Сүбээдэй Зэв хожуул таг дуугүй явж байжээ.

### *ХОРЕЗМЫН ДҮЛИЙ ТЭНГЭР*

Хорезмын их улсыг эзэлж Мухамед хаан болон түүнийг залгамжилсан хаан Желаладдинийг мөхөөж Хорезмтой хил залгаа Багдад, Энэтхэг зэрэг олон улс, хотыг эзэмшилдээ хураан авсан их ялалтын бахархлыг Хулан хатны гэнэтийн үхэл үргээн зайлуулснаар Чингис хаан тайвширч эс чадаад Тэнгэрт мөргөхөөр шийдсэн нь Боорчийг ингэж ганцаар үлдэхийн аймшигт дахин унагасан ажээ. Хүрдэнд ороогдон эргэх олсоор татагдсан сүйх дээш өгсөх бүр улам сэргүүн болж салхины хүч нэмэгдэнэ. Хөлийн доор, толгой дээр ч ёроолгүй харанхуй нөмөрч энэ ертөнцөд гав ганцаар үлдсэн нь Чингис хаанд аймшигтай санагджээ.

Иш-Химама гэгч энэ уран дархан буруу тооцсон эсвэл шатны хөндөл, олс гээд аль нэг нь эвдэрч тасарвал Чингис хаан ёроол дээвэргүй харанхуйн дунд ширхэг элс мэт хийсэн мянган алдын дор харанхуйлан байх цавчим байц руу няц унаж үхэх байв. Уулын оройд дөхөхөд салхины хүч нэмэгдэн сүйх салж унах вий гэмээр салганан үлээгдэхэд дэмий юм хийв гэж харамсах, айх сэтгэл оволзсон боловч Чингис хаанд ухрах буцах хүсэл эс төржээ. Хүсвэл гарт хөврөх олсыг л дугтрахад болно. Түүнийг буцааж буулгана гэдэгт итгэлтэй байв. Боорчийг хуурч болох авч Чингис хаан өөрийгөө хуурахыг үл хүсчээ. Тэр одоо өөрийн хүслийн эрхэнд тэнгэр салхи хоёртой ганцаар хоцорчээ. Сүйх ямар ч болов бэхэлгээнээс мултран хийсэн уналгүй Барыгжан уулын оройд зассан тавцанд хүрч зогслоо. Иш-Химама бүгдийг зөв тооцжээ. Чингис хаан тавцанд гарлаа. Тэр одоо гурван мянган алдын өндөрт тэнгэрт зогсож байв.

Яг энэ мөчид салхи зогсож сэрүү татсан агаар сэнгэнэсэн нь яг л Бурхан халдун уулын оройд зогсох мэт сэтгэгдэнэ. Чингис хаан хүссэнээ биелүүлж хүний нутгийн тэнгэрт гарав. Чингис хаан Барыгжан уулаас дөрвөн зүг найман зовхист өөрийн эзэмшсэн нутгийг бүхэлд нь харж болохоор байв. Дорноос ойртож буй нарны гэгээг ч олж харав. Холд Каспийн болоод Газар дундын тэнгисийн ус цэнхэртэж байв. Чингис хаан харанхуйд нэвт харах чадалтай тул бүхнийг алган дээрх шиг үзнэ. Яг одоо Барыгжан уулын ойр орчим харанхуй, түүнээс холдох тутам гэгээтэй үзэгдэх ажээ. Чингис хаан бүсээ тайлж, хүзүүндээ тохоод сөхрөн сууж хоёр гараа дээш сунган .

-Дээр хөхрөгч эцэг Тэнгэр минь гэж шивнэв. Энэ бол Тэнгэрийг сэрээн дуудаж буй хэрэг юм.

Алсын үүлс хурдан хурдан эргэлдэн хуйларч Барыгжан уулын зүг, Чингис хааны зүг бөөгнөрөн дөхөхийг тэр үзлээ. Битүү нүргэх дуу сонсдож салхи яг морин хуурын аялгуу шиг, хэн нэгэн амьсгаа шахан хөөмийлөх шиг эгшиглэн үлээв. Энэ бол Тэнгэр түүний үгийг сонсож байгааг илтгэнэ. Хорезмын тэнгэр хилэгнэн түүний үгийг сонсохгүй биз гэж Чингис хаан эмээж байсан билээ. Гэтэл энэ ертөнцөд тэнгэр ганц байдгийг тэр ингэж мэдэв. Тэнгэр гэдэг ертөнцийг тольдогч цорын ганц мэлмий болохыг Чингис хаан энд анх удаа бүрэн ойлгожээ. Тийм учраас хаана ч байсан тэнгэр нэг болох ажээ. Ганц өөрөө мэдэх тийм нууцаа Тэнгэртэй хуваалцах гэж хүссэн цаг мөч нь иржээ.

Перваны хөндийд суусаар байсан нь зөвхөн Зүчи, Сүбээдэй, Зэв нарын ирэхийг хүлээсэн төдий биш байлаа. Хулан хатны гэнэтийн үхэлд цочирдсон сэтгэлээ тайвшруулах гэсэн хэрэг төдий ч бас биш юм. Барыгжан уулын оройд ингэж амь дүйн гарсан нь бас өөр учиртай байсан билээ. Гэнэт ард нь чимээ гарч хэн нэг хүний

-Тэмүжин чи юу гэж дуудах шиг сонсдоход Чингис хаан айсан цочсондоо зүрх нь салганаж тэр даруй босож эргэн харж чадсангүй хөшжээ. Зөвхөн “Аллах тэнгэр гэж дэмий дуудаж залбирч мөргөдөггүй ажээ” гэж бодож амжив. Түүний ард Аллах тэнгэр иржээ гэдэгт Чингис хаан бат итгэж байв. Хорезмын тэнгэрт Аллахаас өөр хэн байх билээ.

Барыгжан уулын бэлд түгшүүртэйгээр хүлээн зогсох Боорчи болоод цэргүүдийн дээрээс зөөлөн шиврээ бороо харанхуйд намиран орж эхлэв. Боорчиос алхам ч үл холдох Гэрэг халх авчран барьсанд Боорчи хэрэгссэнгүй. Боорчи энэ бороонд зүрхэндээ хүртэл нэвг норохыг хүсч байв. Учир нь энэ бороо Чингис хааны үгийг Тэнгэр сонссоны гэрч Монгол нутгийнх нь бороо гэж Боорчи бат итгэж байлаа. Бурхан халдун уулыг тахиж, Чингис хаан Тэнгэрт мөргөхөд яг ийм бороо ордгийг Боорчи мэдэх билээ. Чингис хаан Барыгжан уулнаас өгссөн шигээ чив чимээгүй бууж ирэв. Доошлон ирэх сүйхийн бамбарын гэрэлд Чингис хаан үзэгдсэнд Боорчи сая л нэг санаа амарчээ. Бууж ирсний хойно түүний хөмсөг зангидсан догшин сүрлэг царайг хараад Боорчийн тайвширсан сэтгэлд дахин түгшүүр дүүрчээ.

Барыгжан ууланд гарч Тэнгэрт мөргөхөд ер элдэв явдал тохиолдсонгүй ч Чингис хаан зам зуур нэг ч үг дуугаралгүй явсаар өргөөндөө морилж хэнтэй ч уулзахгүй өдөржин болоод үдэш нь Боорчийг дууджээ. Гэнэтийн ажил ундрааж ертөнцөд урьд хожид байгаагүй оньсон шат бүтээлгэн уулын оройд гарсныхаа дараа Чингис хаан ийм хачин зан ааштай болсон нь Боорчийн гайхлыг төрүүлсээр байв.

Барыгжан уулнаас эсэн мэнд бууж ирсэн нь Боорчийг тайтгаруулж элдвийг шүүмжлэн бодохтой болгожээ. Бурхан халдун уулын оройд гарч Тэнгэрт мөргөөд бууж ирэх болгондоо Тэмүжин сэтгэл санаа нь сэргэж Тэнгэрийн юу гэж зарлиг болгосныг нөхөддөө хөөр бахдал, урам зориг дүүрэн илтгэдэг байв. Харин Барыгжан хэмээх энэ гурван мянган алд хадан ууланд гарч ирээд ганц ч үг хэлэлгүй өргөөндөө шургасанд Боорчи ихэд алмайран бас түгшүүрлэн гайхсан билээ.

Чингис хаан гэнэт дуугаа хураах буюу ихээр инээвэл ер сайн юм болж байсан удаагүй юм. Тэмүжиний эл хачин занг Боорчи болон бусад нөхөд нь эхлээд анзаарч мэддэггүй байсан билээ. Тэмүжин хүний үгийг сонсоод юу хэлснийг мартсан мэт хөндлөн ширтэн таг чиг суувал дараа нь заавал эсэргүүцэн эгдүүцсэн үг дуугарна. Эсвэл хүний үгийг сонсоод



Тэмүжин гэнэт ихээр инээвэл даруй бушуухан холдон явах буюу болж өгвөл өөр юм ярьж сатааруулах хэрэгтэй. Гэвч ингэсэн ч оройтож дэмий үгнийхээ шанг дориун хүртдэг билээ. Чингис хаан хүний үгийг сонсоод гэнэт ил шууд уурлан хилэгнэх нь ховор. Харин ч ингэж хилэгнэн аашилвал өршөөсөнтэй адил үзвэл зохих ажээ. Удаан дуугүй суух юм уу хөхөрч байхдаа Чингис хаан заавал нэг хорлонтой, муухай харгис шийдвэр бодож олох шиг Боорчид санагддаг билээ. Тийм ч учраас Барыгжан уулнаас бууж ирээд өдөржин таг чиг суусанд их л болгоомжлон сэжиглэн хүлээсэн нь энэ юм. Тэмүжинтэй учирсан анхны өдрөөс эхлэн Боорчи түүний үг, тушаалыг дуугүй даган биелүүлж ирсэн нь Боорчийн хүлцэнгүй доройнх биш, харин Тэмүжиний хийсэн хэрэг, хэлсэн үг бүхэн зөв зүйтэй санагддагийнх байлаа.

Анх адууны билчээрт арван гурван настай Боорчи Тэмүжинтэй тохиолдлоор учирч нөхөрлөжээ. Эцгээс үлдсэн ганц өмч болох найман шарга агтаа хулгайд алдаад мөрөөр нь мөшгиж явсан Тэмүжин сураг асуухаар хүрч ирэхэд эцгийн мал сүргийг адуулж өглөөнөөс үдэш хүртэл нэг л хэвийн амьдрал ажилдаа уйдсан Наху баяны ганц хүү Боорчи гүү сааж суусан билээ. Наху баян бол адуу мал арвинтай, ам хэл хурцтай, сэргэлэн овжин ухаантай хүн тул дайсан нөхөр хоёрт тал алддаггүй, зовлон гачаал үзэхгүй амьдарч сурсан нэгэн бөгөөд Боорчи хөвүүнээ ч өөрийн адил засч хүмүүжүүлж иржээ. Хөвүүн Боорчийн сэтгэлд ямар бодол байсныг Наху баян олж мэдсэнгүй. Боорчи эцгийн хөрөнгийг өвлөн авч тайчуудын Торгон баяны охин сүй тавьсан Гүмүдагаа нас бие гүйцмэгц эхнэр болгон авч суух ёстой байлаа. Гэтэл Боорчи нэгэнт арван зургаан нас хүрсэн байтал Гүмүда дөнгөж найман настай байжээ. Гүмүда охиныг төрсөн даруй Наху баян яаран очиж сүй тавихад Торгон баян баярлан угтсан нь тэдний холыг бодсон дотор бодол нь нэгдсэнийх байжээ.

Хүүхдүүдээ гэрлүүлэх нь хөрөнгөө нэгтгэн хүчээ зузаатгах, тэгснээр овог аймгийн дотор нэр нөлөөгөө өргөтгөх гэсэн алсын зорилгоос үндэстэй байв. Нүүдэлчин овгийн амьдралд хамгийн аюултай дайсан нь хөрш нь байдаг жамтай. Хөрштэйгөө худ ураг болох нь дэргэдээ дайсангүй амар амьдрах хамгийн найдвартай арга юм. Энэ л жамын үүднээс Наху баян ганц хөвүүнийхээ ирээдүйн амьдралыг ингэж шийдсэн нь хэдий зөв ч гэлээ идэр залуу Боорчид таалагдсангүй билээ. Гэвч Боорчид өөр амьдрал, өрсөлдөх тодорхой зорилго тэр үед бас үгүй байлаа. Харин Тэмүжиний давхин ирсэн нь халуун зуны бүгчим өдөр хүслэнт салхи сэрүү татан үлээх шиг сэтгэл сэргээн үзэж эдлээгүй их баяр төрүүлснийг одоо ч Боорчи үл мартана. Бас гүү сааж гэрийн эм шиг суусандаа ихэд ичсэнээ ч үл мартана. Магадгүй энэ ичсэн сэтгэл нь Тэмүжинд туслах, туслахаас илүү эр хүн гэж харагдах гэсэн хүслийг нь оргилуулсан биз. Боорчи эцгийн зөвшөөрөх эсэхийг ч хайхралгүй, морио сэлгэн Тэмүжиний хамт үг сураггүй одсон нь амьдралдаа бие даан гаргасан хамгийн анхны эрс зоримог, бас осолтой шийдвэр байсан юм. Тэмүжинг дагасан нь түүнийг үхэлд ч хүргэж болох байв. Хэрэв эцэг нь мэдсэн бол яавч түүнийг ингэж явуулахгүй байсан билээ. Энэ санамсаргүй зоримог шийдвэр Боорчийн ирэх амьдралыг эцэст нь хүртэл өөрчилсөн юм. Санамсаргүй тохиолдол мэт санагдавч Тэмүжиний гэнэт ирсэн нь ер тохиолдол биш Тэнгэрээс таалан соёрхсон явдал гэдэгт Боорчи эргэлзэхгүй итгэх болжээ.

Тэмүжинд Боорчоос өөр үнэнч анд үгүй, Боорчид Тэмүжинд зүтгэхээс өөр эрхэм зорилго үгүй байлаа. Энэ бол Тэнгэрийн хүсэл юм. Ингэж нөхөрлөснөөс хойш өдгөө хүртэл дөч гаран жил хамт зүтгэхдээ юу эсийг үзэж, юу эсийг хийв дээ. Гэвч би юуны учир Тэмүжинд амиа үл хайрлан зүтгэв гэж эргэлзэн бодсон удаа нэгээхэн ч үгүй юм. Нөхөрлөө хэмээн

Билгүтэйг зарж ирүүлсэнд мөн л урьдын адил эцэгтээ хэлэлгүй Тэмүжиний хүрээнд ирснээс хойш тэд хагацсангүй одоо энэ Барыгжан уулын бэлд хамт хүрчээ. Олон жилийн уртад баяр гуниг, үхэл хагацал хосолсон дайн тулаан мэт амьдралыг өнгөрөөхдөө Тэмүжиний ингэж гансарч царай алдахыг Боорчи ер үзсэнгүй. Лалын шашинтны нэгдсэн улсыг уландаа дэвсэж, өөрийн их улсын хязгаарыг Газрын дундах тэнгис хэмээх их усанд хүртэл тэлсэнд сэтгэл ханаагүй гэхэд хэцүү. Цовоо зантай, адайр ааштай Хулан хатнаа үхсэнд ингэтлээ гуниглана гэхэд итгэмгүй. Харин Барыгжан уулнаас бууж ирмэгц өргөөндөө морилтлоо нэг ч үг унагасангүй нь яавч сайны ёр биш билээ.

Боорчийг өргөөнд ороход их дэнгийн гэрэл мэлтийж Чингис хаан түүний орж ирэхийг хүлээн сууж байлаа.

-Би хаан таны дуудсан ёсоор ирлээ.

Боорчи бүх зүйлийг ёсчлон гүйцэтгэж мэхийн хүндэтгээд зүүн талд гарч суув. Ширээнд тансаг зоог өрсөн нь удаан сууж ярилцахын шинж ажээ. Чингис хаан бодолд авгаж үрчлээт царайд нь зохиогүй мэт харагдах хачин тод хар хөмсөг нь зангирна. Чингис хааны үс, сахал бууралтаж харин хөмсөг нь тод хараараа үлджээ. Чингис хаан үг дуугүй ширээн дэх зоог руу дохив. Боорчи ч элдвийг асууж үг өдсөнгүй. Идээ будаанд хүрсэн болж, дарс аажуухан шимж суув. Тэртээ тэргүй Чингис хааны үгийг хүлээх хэрэгтэй тул яарах сандрах зүйл байсангүй.

-Боорчи чи Отрар хотыг эзлэснийг санаж байна уу гэж Чингис хаан зөөлхөн дуугарав.

-Санаж байна.

-Хамгийн сүүлд хотын сүмд хэдэн зуун хүн орчихоод бууж өгөлгүй бүр тэндээ шатаж үхсэнийг санаж байна уу

-Саналгүй яах вэ. Тэнд хүүхэд, эмэгтэй хүн ч хүртэл байсан шүү.

Тэр сүмийг яаж шатаж, нурж унан унатал дотроос нь Аллах тэнгэртээ залбирах хүмүүсийн хашгираан сонсогдоор байсныг санахад галд түлэгдэж үхэгсдийн уйлаан чарлаан одоо ч чихэнд нь сонсогдох шиг болж Боорчи мөрөө хавчив. Хотоос бүтэн үлдсэн тэр лалын шашны сүм энэ нутгийнханд авралын од юм шиг санагдсан биз. Сүмд шургагсад бууж өгсөнгүй тул сүмийг галдан шатаасан билээ. Гал дүрэлзмэгц бүгд гүйлдэн гарч ирнэ гэж монголчууд бахдан хүлээж байв. Гэтэл хэн ч гарч ирсэнгүй. Бүгд Аллах тэнгэртээ залбирсаар шатаж үхэхийг үзжээ. Дөрвөн жил гаруйн өмнө болсон хэрэг явдлыг яах гэж Чингис хаан энэ үдэш цохон асуусны учрыг Боорчи олсонгүй. Бас Чингис хаан чухам юу гэж хариулахыг шаардаж байгааг ухаарсангүй.

-Хаан та юуны учир үүнийг надаас асууна вэ. Үхсэн болгоны учрыг олох гэвэл нас минь хүрэхгүй биз гэж Боорчи хариултаас тойрон гарах арга хайж хэлэв. Боорчийн эл үгэнд Чингис хаан сахал дотроо жуумалзан инээх нь Боорчийн залигч яг таасан хэрэг юм. Бусдыг шоолж дооглосон үедээ Тэмүжин ингэж сахал дороо сэмхэн жуумалзан инээмсэглэдэг билээ.

-Боорчи. Чи юунд ингэж үнэн үг хэлэхээс зайлна вэ. За яах вэ. Би чамд учрыг хэлье. Тэд

Чингис хаан намайг Аллах тэнгэрээсээ дорд үзсэн тул амиа хайрласангүй сүмдээ шатаж үхжээ.

Чингис хааны энэ үг санаанд оромгүй байсанд Боорчи сандрав.

-Хэрэв тэд намайг үхлээс дээрд үзсэн бол бүгд амиа аврахаар гарч гүйлдэх байлаа. Чингис хаан надад бууж өгөх нь Аллах тэнгэртэй цуг үхсэнээс дор хэрэг гэж тэд үзжээ.

-Би хаан таны үгийг сайтар ухахгүй байна гэж Боорчи шууд үнэнээ хэлэв.

-Энэ бол суманд оногдож, сэлмэнд цавчигдан үхэхээс огт өөр хэрэг юм. Би үүнийг ойлгосонгүй явжээ.

Ингэж хэлээд Чингис хаан гүнзгий санаа алдав. Боорчи түүний ингэж дор орж дорой суухыг үзсэнгүй тул ихэд гайхжээ. Чингис хааны сэтгэлийн гүнд чухам юу өөрчлөгдсөнийг тэр мэдсэнгүй.

-Энэ ертөнцийн бүх хүмүүс намайг аврагч Тэнгэрээ гэж үзэхийг би хүснэ. Чингэхгүй аваас ертөнцийн талыг эзэлж их хаан суухын хэрэг юун. Боорчи чи миний үгийг ухаж ойлгох гэж санаа сэтгэлээ бүү зовоо. Би чамд хэлэхгүй бол өөр хэнд хэлэх билээ. Тэр Аллах гэгч нь Тэнгэр биш аж. Хэрэв Аллах тэнгэр байсан бол сая надтай ярих байв. Гэвч тэр миний үгэнд хариу эс дуугарав. Энэ Хорезмын тэнгэр дүлий аж. Гэтэл тэр Аллах, хүмүүний үгийг сонсохгүй мөрт тэд яах гэж түүний төлөө үхэв. Би үүнийг эс ойлгоно гэж Чингис хаан сахлаа илбэн ганцаар ярив.

Ертөнц ганц тэнгэртэй гэж итгэж явсан атал Хорезмын тэнгэр Чингис хааны үгийг сонсоогүй нь түүнийг ингэж гүн бодолд унагасан болохыг Боорчи сая хальт мөлт гадарлаж эхлэв. Бас Хулан хатан газар орны лус савдгийн хорлол болж үхсэнийг ч бодов.

-Чингис хаан та хэрхэх гэж бодно вэ. Бид баруун зүгт зорьсон хэргээ гүйцээж Газрын дундах тэнгис хүртэлх нутгийг, лалын шашинтны их улсыг хураан авлаа. Одоо хэрэг нэгэнт иймдээ хүрсэн тул халуун бүгчим энэ газарт хүн, морио зовоон сул хэвтэхийн хэрэг юун. Их цэрэг нутгаа санаж чилж гүйцлээ. Тэд бүгдээр их ялалтын баяр хөөрөө ар гэр, амраг садантайгаа хуваалцахыг хүсч байна. Чингис хаан та зарлигаа буулга. Нутагтаа очиж Хэрлэн, Туулынхаа хөвөөнд сэрүүн салхинд цэнгэж суугтүн. Ингэхийг бид бүгд хүснэ.

Боорчийн энэ үгийг хэлсэний хойно өргөөнд нэг хэсэг нам гүм болов. Боорчи сүүлийн хэдэн сар сул дэмий суухдаа хэлье гэж бодсоноо сая хэлж санаа нь амрав. Бас Чингис хаан Тэнгэрээс чухам ийм үг сонссон байх ёстой гэж итгэж байв. Боорчи Алтайн нурууны ардах өөрийнхөө өргөө гэртээ очихыг туйлгүй ихээр хүсч байлаа. Шөнө бүр хөөрхий Гүмүда нь зүүдлэгдэж, хуучин шарх сэдрэн өвдөх шиг сэтгэл шаналан өссөн нутаг нь хүсэгдэх билээ. Энэ бол түүний өвгөрч, ядарсных байв. Далайсан сэлмээ буулгалгүй шахам явсан таван жил өнгөрч Сыр-Даръя, Аму-Даръя, Инд, Ефрат, Тигр таван их мөрний нутаг, иргэд ардыг эзлэн авчээ. Одоо Сүбээдэй Зэв хоёр шилдэг цэргээ манлайлан баруун, умар зүг үзээгүй нутгийн гүн рүү зөөлөн модонд цүүц шаах адил ярган давшсаар ажээ. Тэд эргэж буцахаас нэгэнт өнгөрчээ. Цусны үнэр авсан өлсгөлөн чоно шиг улайран довтолж байгааг Боорчи мэдэж байв.

Сүбээдэйн оронд Боорчи байсан ч чингэх байсан биз ээ. Цус, ялалтын амтанд согтуурсан нохдыг гэдрэг огцом татвал эргэж эзнээ ноцох ч аюултай. Яг ийм явдал Алтан улсыг дайлахад болсныг Боорчи санаж байлаа. Алтан хаан их бэлэг сэлт илгээн Чингис хаанд дагаж орохыг гуйсанд зөвшөөрч цэргээ татах зарлиг буулгасан нь Хятадын олон хотыг эзлэн авч ялалт олзонд шунасан цэргийн дотор эгдүүцэл зэвүүцэл төрүүлснийг тэр яахин мартана. Бүр баруун замын цэргийн жанжид Чингис хааны зарлигийг зөрчин Шар мөрний хойд нутгийг түйвээн явсан хэрэг гарсан юм. Тэднийг Чингис хаан олны өмнө зэмлэн буруушаагаад ял хэлтрүүлсэн ч сүүлд нь хүн явуулж толгойлогчдыг нь хөнөөсөн билээ. Чингис хааны энэ үйлдлийг Боорчи илт таашаасангүй. Учир нь Алтан хааны хуурмаг заль, бэлэг, зүс гоо гүнжид хууртагдсан Чингис хааныг дотроо буруутгасан билээ. Гэтэл жилийн хойно Алтан хаан дахин самуун дэгдээж Сүн улсад илгээсэн монголын элчийг замаас нь барьж хороосон хэрэг дэгдэж Монголын их цэрэг дахин Цагаан хэрмийг давсан билээ. Алтан хааны заль мэхэнд авталгүй эхний цохилтоор л түүнийг мөхөөх байсан гэдэг нь бүхэнд ил болсон ч Чингис хаан дахин цэрэглэн хөдөлж довглох зуураа бас л Алтан хааны үгэнд авгаж, хөвүүнээ зуун нөхдийн хамт илгээж найрамдахыг гуйсанд зөвшөөрч дахин цэргээ татав. Чингис хаан өөрийн алдааг ингэж дахин давтав. Үүнээс үүдэн багагүй хэрүүл, самуун дэгдэж олны аминд хүрсэн юм. Монголын цэргийн удирдагчдын дотор Алтан улсыг нэг мөсөн мөхөөхийг хүсэгчид давамгайлж байсан ч эрхгүй Чингис хааны зарлигийг дагасан билээ. Алтан улсыг дахин дахин өршөөж цэрэг моридоо зовоосон Чингис хааны эл хөнгөн хуумгай мэт санагдах шийдвэрийн цаад санаа зорилгыг Боорчи ойлгоогүйгээр барахгүй дотроо буруутган бодсоор яваа билээ. Алтан улс өнөөг хүртэл хэвээр оршсоор, дагасан нэртэй боловч дотоодын самуун дэгдсээр байгаа, тэнд Мухулай цөөн цэргийн хамт эсэргүүцэн дарах гэж хүрч ядаж, хөдөлж цөхөж байв. Хорезмын улсыг эзлэн авмагц даруй буцахгүй бол Алтан улсын зүгээс ар хударгаар төв Монгол руу довлохгүй гэх баталгаа үгүй. Бас дээр нь Тангуд улс дайсан болсныг мартаж аргагүй юм. Эртний хэлхээ холбоотой Алтан улс Тангуд хоёр эвсэн ар хударгаар довтолбол юу болох нь ойлгомжтой. Монголын цэргийн гол хүч энд байгаа тул Тэмүгэ ноёны цөөн цэрэг их эсэргүүцлийг үзүүлж үл чадах тул хялбархан автах байв. Энэ нь ар гэр, алтан нутгаа эзгүй сул орхисонтой үлгэр нэг юм. Үүнд Боорчи маш их санаа зовж байсан тул энэ үдэш ам нээвэл уушиг нээ гэгчээр нэг мөсөн сайн хэлж авчээ.

-Боорчи чи намайг хэн гэж санаж гэж Чингис хаан зэмлэсэн өнгөтэй хариу асуусан ч хилэгнэх цухалдах шинж үзүүлсэнгүй. Тэмүжин нөхөрлөсөн цагаасаа хойш хоёулханаа байхдаа Боорчид хатуу үг хэлж хилэгнэж үзээгүй билээ. Харин олны дунд хамаг уур хилэн, омог, муу үгээ Боорчид хандан гаргах нь элбэг. Энэ нь тэдний хооронд тогтсон нэг ёсны итгэл бусад нөхдөө айлгах, сургамжлах, хууль цаазыг бэхлэх нэг сайн арга болжээ. Хамгийн дотно нөхөр Боорчидоо ингэж хатуурхан хилэгнэх нь бусдыг шууд загнаж, донгодсоноос илүү ихээр айлган хүмүүжүүлдэг байлаа. Тэмүжин ганцхан Боорчид л үнэн сэтгэлээс итгэдэг байв. Тэр Боорчиос өөр хэнийг ч ингэж сэтгэлийн мухарт хоргүй сэтгэлээр итгэн зөвшөөрч үл чадна. Энэ их итгэл Тэмүжинээс биш Боорчийн хиргүй тунгалаг сэтгэлээс үүсэн гарсныг харин Тэмүжин ойлгодоггүй байлаа. Ингэж бодохын учир нь Боорчийг түүнд туслуулахаар Тэнгэрээс илгээсэн гэж итгэдэг болсонтой нь холбоотой юм. Тийм ч учраас Боорчийг үнэнч зүтгэх тангарагтай хүн гэж тооцно. Чингис хаан Боорчийн саяын хэлсэн үгийг бодохгүй биш бодсоор байсан тул шинэ ховор санаа гэж гайхсангүй. Тэр угаас Монголдоо буцахыг хүсч байсан билээ. Перваны хөндийд суусаар даруй жил шахаж эзэлсэн булаасан хот, иргэдийг хууль журмаар зохицуулан төвхнүүлэх ажил ид зүгшрэн ундарч байв. Одоо Сүбээдэй Зүчи

хоёрын цэрэг эргэж ирвэл нутгийн зүг хөдлөхөд бэлэн болжээ.

Зүчийн бие чилээрхэж их хөл хорьж хөдөлж чадахгүй суугаагаа Есөнтэйгөөр бичиг илгээн хэлүүлснийг Чингис хаан үнэмшихэд бэлэн байсан ч Есөнтэй Зүчийн хэлснийг бүгдийг Чингис хаанд илтгэсэн нь чухам аянга ниргэх шиг цочирдуулжээ. Харин Есөнтэйг Зүчийн нууц бодлыг хэнд ч хэлэхгүй байхыг зарлиг болгожээ. Зүчи үнэхээр толгой мэдэн тусгаар улс байгуулахаар зориглоно гэхэд Чингис хаан эхлээд итгэхийг хүсэхгүй байжээ. Гэтэл Эрчис мөрний сав газраар нутаглаж байсан Зүчийн албат иргэд их хүрээ эмс хүүхэд нь наашаа нүүж ирснийг Тэмүгэ элч илгээн мэдэгдсэн нь аргагүй Есөнтэйн хэлсэнд итгэхэд хүргэжээ. Зүчи юу сэдэж байгааг Чингис хаан гадарлаж эхэлсэн нь даруй нутгийн зүг хөдлөхөд саад болжээ. Үнэндээ Сүбээдэй ямар төөрөх биш түүнийг орхин буцах ёстой юм. Зүчийн дэргэд байх Чингис хааны тагнуул хэл ирүүлснээр Зүчи үнэхээр хэвтэрт орж, өргөөнөөсөө ч цухуйхгүй болсныг баталсан ч Чингис хаан итгэсэнгүй. Хүний хүү хүрэн бөөртэй гэдэг болов гэж тэсч чадахгүй бухимдсаар болдог бол өөрөө Зүчийн тэнд цэрэглэн очмоор санагдах болсон ч тэвчжээ. Зүчийг зүгээр орхин нутаг буцах аргагүй болсон нь тодорхой байлаа. Зүчийн тухай бодсоноо тэр хэнд ч хэлсэнгүй, бас хэнээс ч асуусангүй. Зүчи ингэж гэнэт өөрийг нь хаяхаар шийдсэнийг мэдмэгц Чингис хаанд урьд өмнө үзээгүй хачин мэдрэмж төржээ. Энэ бол гомдол харуусал байв. Түүний зарлигийг хүндэтгэн Зүчи цэргээ авч ирэх ёстой юм. Зүчи ирье гэвэл хүүрээ ч болов ачаад ирэх ёстой гэж Чингис хаан бодсон нь түүнийг ингэж хилэгнүүлж бас гомдоход хүргэв. Барыгжан ууланд гарч мөргөсөн ч түүнд цэцэн ухаан авчирсангүй. Энэ нь Бөртийг буцаан авсан шөнө Мэргэдийн нутагт болсонтой адил хэрэг болжээ. Тэр шөнө Тэнгэр түүнд хариу хэлсэнгүйн адил энэ удаа бас л таг чиг өнгөрөв. Бодож үзвэл Зүчийн тухай Тэнгэр юу ч гэж хэлэхгүй өнгөрдөг ажээ. Энэ нь Чингис хааныг өөрөө шийд гэсэн үг юм. Зүчийг төрмөгц алах тухай анх Тэмүжиний өгсөн зарлигийг Боорчи биелүүлээгүй нь өнөөгийн хэргийн үндэс болжээ. Тийм ч учраас Боорчийг дуудсан билээ.

Харин Чингис хаан юу гэж зарлиг буулгахаар дуудсаныг Боорчи таагаагүй ч яг одоо Зүчийн тухай, түүний хүнд өвчинд нэрвэгдсэн тухай бодож суужээ. Яагаад ч юм бэ энэ үдэш тэдний хооронд чухам Зүчийн тухай яриа болно гэж битүүдээ таамаглаж суулаа. Бүх байдлыг эрэгцүүлэн бодож үзвэл Зүчиэс өөр ингэж Чингис хааныг бодолд унагах зүйл үгүй байв. Энэ олон жилийн гүн нөхөрлөлийн дунд Чингис хааныг Боорчитой бусдаас илүү холбон гагнасан хүн нь Зүчи болохыг тэд урьд нь ер бодож үздэггүй байжээ. Зүчи гэгч энэ хөвүүн Бөртэд олдсон нь, бас Зүчийг төрмөгц алахыг Боорчид тушаасан нь бүгд л тохиолдол мэт бодогдоно. Гэвч энэ бол тохиолдол биш үйлийн үр байсныг тэд бас л тунгаасангүй. Тэмүжин болоод Боорчийн хүн чанар, бие биендээ итгэх их итгэлийг шалгах гэж Тэнгэрээс Зүчийг илгээжээ. Хэрэв Боорчи Зүчийг гарсан дор нь Тэмүжиний хэлснээр алж орхисон бол тэдний амьдрал, тэмцэл цаашид хэрхэн өрнөх байсныг одоо хэлэхэд бэрх юм. Үйлийн үрийг угаас өөр бусад үйл явдал тохиолдлоор орлуулан нөхөх аргагүй байдаг билээ. Одоогоос яг дөчин хоёр жилийн өмнө мэргэдийн дарагдаж сүйрсэн хүрээний дэргэдээс Боорчи тулгар биетэй Бөртийг дагуулан мордсоноо санах. Тэр өдрийн явдлыг Боорчи хэзээ ч мартаж чаддаггүй юм. Мартахын аргагүй үйл явдал учраас тэр биз. Мэргэдийн ам цагаан морь гөрөөсөн хэлбэрт адуу тул эцэж цуцахыг мэдэхгүй довтолгоно. Мэргэдийн хүрээнээс гарснаас хойш морины ам таталгүй довтолгосон гуравдахь өдөр Зүчи төржээ.

-Боорчи. Зогсооч. Үхлээ гэж Бөртэ өрөвдөлтэйгээр бархирсаар авч зогссонгүй. Гэвч Бөртэ мориноос унасан тул яах ч аргагүй болжээ. Бөртэ ухаангүй мэт унажээ. Дагалдан явсан хэдэн цэрэг гүйцэн ирэв. Мориноос унахад нь Бөртийг үхэв гэж сандарсан учир ийн зогсчээ. Бөртэ үхсэнгүй, харин ч хормойн доогуур урсах цус, усан дунд сарвалзан чарлах хүүхдээ үзээд цочин алмайрсныг харав. Морины давхиан дунд эмээл дээр төрсөн хөөрхий үрээ үхлээс хамгаалах ганц арга нь мориноосоо унах байжээ. Бөртэд өөрийгөө бодох зав байсангүй. Зөвхөн төрсөн үрээ л бэртээж гэмтээхгүйг хичээсэн билээ. Мориноос унасан ч хүүхэд нь амьд үлджээ. Ийм үед яах ёстойг Боорчи мэдсэнгүй. Бөртэ хэдийгээр огт дуугараагүй ч “Хүүхдийг минь авраач” гэж гашуун нулимс гаслант харц нь гуйж байхад Боорчи чухам л Тэнгэрт хөтлөгдөх шиг нэг л мэдэхэд улаан нялцгай амьтныг гартаа шүүрэн авчээ. Хүйг нь тас хазаад улаан нялзрай тэр амьтныг арвалзуулан алган дээрээ өргөв. Одоо түүнийг хажуу тийш шидэх л үлдэв. Халуун нойтон биетэй өмөлзөн бархирах тэр хүүхэд хөвүүн байсан нь хамгийн түрүүнд нүдэнд туссан ганц ойлгогдох тэмдэг байв. Энэ явдал хормын төдий болсон ч Бөртэд хичнээн удах шиг болжээ. Боорчи хүүхдийг нь одоохон няц шидэх юм шиг санагдсан боловч юу ч дуугарч чадсангүй. Харин Боорчи харж харж улаан нүцгэн тэр амьтныг энгэрээ яран өвөртөө хийхэд нь Бөртэ сая санаа амран эхэр татан уйлсан билээ. Зүчийн улаан нялзрай бие, эмзэг бяцхан гар хөл Боорчийн цээжинд хэрхэн анх хүрсэн нь одоо болтол мэдрэгдэх шиг болдог юм. Тэндээ буудаллан гал түлж, Бөртийг амрааж бас шинэ төрсөн хөвүүнийг амлуулж хоножээ. Мэргэдийн Чилэгэр бөхийг хичнээн ч үзэн ядсан эх хүний ёсоор Бөртэ шинэ үрээ үзмэгц ухаангүй хайртай болов. Хөвүүн эхийнхээ уургийг ховдоглон хөхөж Бөртэ хайрлан инээмсэглэн ширтэж хэвтэхийг үзээд Боорчи “Энэ хөвүүн хэрэв хүн болбол түүнийг өөрийн хүүхэд шиг хамгаалж явъя” гэж өөртөө тангарагласан билээ. Боорчи энэ тангарагаа өнөө хүртэл эвдсэнгүй. Харин хамгийн гайхалтай нь Тэмүжин эргэн ирээд Бөртийн хөвүүн төрүүлснийг, бас Боорчи түүнийг алсангүйд ер уурлаж хилэгнэлгүй таг дуугүй өнгөрчээ. Зүчи ингэж хүн болсон билээ. Зүчид үхэл үнэхээр ойрхон байв. Нялх балчир Зүчийг Тэмүжин юу юугүй алчих юм шиг Боорчид санагдсан үе олон. Гэвч

муу юм болсонгүй. Магадгүй Тэмүжин Боорчийн сэтгэлийг бодсон ч байж мэднэ. Ер нь Тэмүжин өөрөө л нээж хэлэхгүй бол түүний юу бодож санаж байгааг таахын аргагүй билээ.

Харин Зүчийн хэрхэн төрснийг Бөртэ хөвүүндээ хэлсэн байжээ. Үүнээс хойш Боорчи, Зүчийг өөрийн хөвүүн шиг үзэх болсон бас нэг шалтгаан нь түүний ёсолж авсан болоод татвар эмсээс өдий болтол хөвүүн төрөөгүй явдал юм. Зүчийг алж орхисон бол Боорчи лав хөвүүнтэй болох байсан биз гэж бодсон удаа ч олон. Гэвч Зүчийг амьд үлдээсэндээ Боорчи өдий олон жил болоход нэг ч удаа харамссангүй билээ. Зүчи ч ингэж бодох шалтаг гаргасангүй. Дуулгавартай, тэвчээртэй, ухаантай Зүчи Тэмүжиний бүх дарамт, доромжлолыг тэсэн гарч өөрийгөө хүлээн зөвшөөрүүлж чадсан жанжин болсон юм. Зүчээр бахархахгүй байхын аргагүй. Зүчийг хэн нэгэн, тэр дундаа Чингис хаан сайнаар дурсах юмуу магтан сайшаах бүр өөрийн хүмүүжүүлсэн жанжин гэж Боорчи дотроо ихэд хөөрөн омогшдог билээ. Чингис хаан Зүчийн тухай хэргийг заавал Боорчитой хэлэлцэж, ер нь Боорчийг Зүчийн эцэг нь юм шиг ханддаг нь түүнийг амьд үлдээсэн явдлыг зөвтгөж сайшаасан хэрэг мэт бодогдоно. Зүчи Чингис хаанд зүтгэж ихийг бүтээсний дотор ууган хөвүүний хувьд журамтай, шударга, зоригтой байж бусад хөвүүдэд сайн үлгэр үзүүлснийг Чингис хаан хамгаас онцгойлон үнэлдэг байв. Үнэхээр Цагадай, Өгөдэй, Тулуй гурав Зүчийн үлгэр дууриал дор өсч хүмүүжсэн юм. Чингис хаан өөрийн сэтгэлийн гүн дэх зөрчлөө нуун Зүчийг магтах өргөмжлөхдөө харамгүй байж чадсанд нь Боорчи их талархалтай байв. Харин Зүчи Ургенчийн дэргэдээс хөдөлж цэргээ хураан эргэж ирээгүй нь бүгдийг, тэр дундаа Боорчийг хүртэл гайхшруулжээ.

Дуулгавартай, Чингис хааны үг, зарлигт бусдаас илүү үнэнч, хүндэтгэлтэй ханддаг Зүчи ингэв гэхэд итгэмгүй. Чингис хаанаас зааж өгсөн нутгийг тохинуулах нь чухал ч Чингис хааны зарлигийг даган ирэх нь ер юунд саад болохгүй явдал байв. Ирээгүйн учрыг Боорчи өөр зүйлтэй тэр дундаа Цагадайтай зөрөлдсөнөөс болов гэж боджээ. Ургенчийг авахад Зүчи илт дургүйцэн цэргээ оруулахгүй алгуурласнаас Өгөдэй Цагадай нарын цэрэг ихээр үхсэнийг сонсоод ингэж үзэх болжээ. Ерөөс Ургенчийг авах гэж Цагадай Өгөдэй хоёрыг илгээсэн нь буруу байлаа. Тэднийг биш ядаж Шихихутаг юмуу, эсвэл Дөрбэй Догшин ч юм уу, Зүчитэй хэл амаа ололцох тийм хүнийг илгээх байсан нь одоо бодоход зөв байжээ. Хөвүүдийн хоорондох зөрчлөөс болж Зүчи эргэж ирэхгүй шалтаглах болов гэж Боорчи таана. Тэдний хооронд юу гээч болсныг Өгөдэй Боорчид ер хэлэхгүй тойруулан өнгөрөөнө. Бас Чингис хаан ч гэсэн Боорчиос нуух мэт санагддаг байжээ. Хөвүүдийнхээ хэн нэгнийг илт дэмжих, нөгөөг буруутгах нь зохихгүй гэж Чингис хаан үзсэнээс ингэж тэвчин дуугүй өнгөрснийг Боорчи мэднэ. Тэгээд ч Чингис хаан зөв шийджээ гэж бодсон билээ. Ургенчийг эзлэн авах гэж юу болсныг байцаан асуусан бол Цагадай Өгөдэй нар их олон гомдол санал хэлэхэд бэлэн байлаа. Хэрэг явдал ингэж эргэвэл Чингис хаан хөвүүдийнхээ хэн нэгийг дэмжих ёстой болох тул дуугүй өнгөрөөснөөрөө тэр хэцүү асуултаас тойрон гарч чаджээ. Бас үнэхээр эзлэн авсан хуваарьт нутгаа тохинуулах нь ч зөв гэж үзсэн биз. Ингэх нь ер буруу зүйл биш учраас Ургенчээс буцаж ирээгүй Зүчийг тайван орхиж Инд мөрнийг уруудан хөдөлсөн билээ. Гэтэл тэндээс эргэн ирж бүх цэргээ цуглахыг тушаан дуудсан зарлигийг Есөнтэйгөөр илгээсэн ч Зүчи аргалан ирсэнгүй. Хорезмын улсыг мөхөөсөн их аян дайны эцэст энэ хэргийг өчүүхэн гэж үзэж болохгүй болжээ. Чингис хаан Зүчид хилэгнэх гомдох хоёрын аль нь болохоо ойлгохгүй мухарджээ.

Боорчи өөрийн бодолд автан Чингис хааны өргөөнд байгааг мартсан мэт суув. Чингис хаан толгой өргөн Боорчийг харав.

-Боорчи.

Чингис хаан зөөлөн дуугаар ийн хэлээд сахлаа илбэнэ.

-Боорчи. Чи бидний залуу зандан цаг дуусаж байна даа гэж гунигтай хэлэв.

-Би чамайг олон бэрх зовлонд унагасан биз. Би одоо чамайг нэгэн хэрэгт заръя. Энэ хэрэгт би бодож бодож чамайг илгээхээр шийдлээ гэж Чингис хаан хэлээд дуугүй болов.

-Ямар гэж тодруулан асуух нь илүүц бөгөөд хаашдаа л Чингис хааны хүсэл зарлигийг буцааж үл чадах тул Боорчи дуугүй хүлээв. Ингэж бодол болж хоёулхнаа суувал эцэст нь заавал нэг сонссон хүн цочмоор, айж зугатмаар, аргадаж гуймаар хэрэг гүйцэлдүүлэхийг тушаах тул юу болохыг бараг таах шиг болоод Боорчийн зүрх түгшин хавиргаа дэлсэж эхлэв. Тэр ямар ч зарлиг сонсоод ингэж түгшиж сандарч яваагүй билээ. Чингис хаан ер нь хэний ч санаагүй аймшигт цээрлэлийг олж сонгохдоо даанч гаргууд хүн юм.

Хорезмд морилохын урьд өвөл өргөөндөө дуудаж оройжин архи дарсаар дайлж элдвийг энгүүн зүгээр хүүрнэж суугаад хэлсэн үгийг нь одоо тод саналаа. Энэ бол Хасарын тухай байв. Чингис хааны хэлэх үг, буулгах зарлиг хэцүү хүнд байх тутам түүнийгээ сайтар ойлгуулах гэж урдаас нь тайлбарлан эсэргүүцэх бүх шалтгаан нөхцлийг арилгахын тулд удаан тайван ухуулан ярьдаг юм. Зарлигийг биелүүлэх тэр хүнээ зоригжуулах, бас Чингис хаан өөрийгөө энэ хэрэгт буруугүй гэдгийг нотлох гэж ингэх бүлгээ. Хэрэв сонсогч хүн түүний зарлигийг биелүүлэхгүй татгалзвал Чингис хааны бүх нууцыг мэдсэний хувьд үхэх л үлддэг байв. Иймээс хүн үхэхийг яахин хүсэх билээ. Ингэж Чингис хаан өөрийн хэргийг бүтээнэ.

Энэ нь түүний шалгарсан арга юм. Хорезмд дайтах их цэрэг хөдлөхөөс яг хоёр сарын өмнө Боорчийг дуудсан нь тэр байв. Тэр үдэш Чингис хаан туйлын сайхан ааштай угтжээ. Өдөр нь Зүчи хөвүүнтэйгээ уулзаж түүний үг хүслийг сонссон нь Чингис хааныг баясгажээ. Их цэргийг манлайлан Хорезмд орох хүслээ Зүчийн хэлсэн нь Чингис хаанд үнэхээр тааламжтай байв. Тийм учраас үүнийг Боорчид дуулгах ёстой гэж үзжээ.

-Боорчи. Чиний хүмүүжүүлсэн Зүчийг би өнөөдөр бахдаж байна. Чи түүнийг амьд үлдээсэн нь сайн хэрэг болжээ. Чи лав далдыг харж, алсыг мэддэг шидтэй биз гэж Чингис хаан хөхөрч угтсан билээ. Зүчийг ийн магтсан нь Цагадайн хатуу үгний дараа хөвүүдийн хооронд бий болсон далд зөрчлийг түр боловч тайтгаруулжээ гэдгийг Боорчи ойлгов. Боорчи ч энэ үгийг сонсоод их л баясав. Ингэх нь аргагүй юм. Учир нь Зүчийг хэрхэн хүмүүжүүлснийг Чингис хаан сайшаах нь ер бага хэрэг биш байв.

-Суу. Хоёул өнөөдөр сайхан цэнгэе. Сүүлийн үеэс чи бид хоёр ер ингэж суусангүй гэж Чингис хаан сэтгэл тэнэгэр байв. Тэд чамгүй олон хундага тогтоож, мах зооглов. Гэвч Чингис хаан дэмий нэг ингэж архи дарс болдоггүйг мэдэх тул Боорчи аль болох бага ууж согтохгүйг хичээжээ.



-Хасарын ааш авир тэвчишгүй боллоо.

Чингис хаан Боорчийн өөдөөс харж сууснаа гэнэт ийм үг амнаас унагав. Үдшийн турш хүлээсэн зовлонт, бас түгшүүрт мөч эхэлжээ. Юу хэлэх гэж Чингис хаан түүнийг дуудсаныг сая л ойлгов. Боорчи Чингис хааны дараачийн үгийг дуугүй хүлээв.

-Хасар миний төлөө амиа өргөх ёстойгоос бус, миний өмнөөс үг хэлж, үйл дэглэх ёсгүй хүн. Гэтэл тэр ямагт түрүүлж дуугарч, түрэмгий загнасаар өдий хүрлээ. Чи эс мэдэв гэж үү. Би Өүлэн эхийн сэтгэлийг бодож өрх гэр, өнөр бүлээ гутаахгүй гэж өдий хүртэл тэвчив.

Тэмүжин, Хасар хоёрын дундах зөрчил дэндүү гүнзгий, төвөгтэйг хамгийн сайн мэдэх хүн бол Боорчи юм. Чингис хааны сэтгэлийн дотрох уур бухимдал гэнэт дэлбэрч амьсгаа нь давхцаад ухасхийн өндийж ширээ тулан босов. Боорчи сандран түүнийг тайвшруулж

-Хаантан та бүү ингэж бухимд гэж дэмий л үглэв. Боорчийн энэ хариугүй дорой байдалд Чингис хаан улам хилэгнэв.

-Хасар бүр галзуурч. Хорезмд их цэрэг хөдөлгөхийг шүүмжилж, намайг дор үзэн үүд хаяж одов. Чи түүнийг далд оруул. Тайчуудтай байлдах үед намайг шархдахад Хасар чамайг буруутгаж “Үхүүл” гэж шаардсаныг чи мартаагүй биз. Би тэгэхэд чамайг Хасарын сэлэмнээс аварсан. Харин одоо чамд би Хасараас өшөөгөө авах боломж олгоё. Би Хасарын надад хийсэн гавьяаг хүндэтгэн нэргүй үхлээр биш миний итгэлт нөхөр Боорчийн гараар үхүүлнэ. Хасарыг чамаас өөр хэн үхүүлэх билээ. Одоо Хасарыг чи үхүүл. Хүн нэгэнт хүслээ гүйцээж үгээ хэлсэн бол үхэхэд юунд дургүйцэх билээ. Тэнгэр нэгэнт ингэж таалсан тул хэн түүнийг зөрчинө хэмээжээ.

Чингис хааны даанч дэндүү заналтай хэлсэн дээрхи үгсийн цаана түүний үзэж сонсоогүй ноцтой явдал нуугдаж байгааг Боорчи мэдэрлээ. Чингис хаан уураа гарган тайвширч гэдрэг суув. Боорчи Алтайн өвөрт өвөлжөөд их чуулганд дуудагдан Чингис хааны хүрээнд ирсээр удаагүй тул түүнийг эзгүй хооронд чухам юу болсныг тааварлахгүй байлаа. Өгөдэйг хаан сууринд залгамжлуулан суулгахыг зарлиг болгосон явдал Хасарт таалагдсангүйгээр барахгүй гомдол бухимдлыг нь оргилуулсан билээ. Сонссон үзсэн бүгдээр Чингис хааны залгамжлагчийн тухай шуугиж, энэ явдлын цаана хоцорсон Хасар болоод түүний хөвүүдийн хувь тавилан, ирээдүйг төдийлөн анхаарахгүй байгаа нь Хасарын бухимдлыг оргилуулжээ. Өгөдэйг хаан сууринд өргөмжилсөн явдлаар далимдуулан Чингис хаан өөрөөсөө хойш зөвхөн алтан ургийн хөвүүдээс хаан сууринд суухаар зарлиг буулгасан нь Хасар болоод бусад дүү нараа, тэдний үр садыг зүгээр л өөрсдийн хавсрага, сул иргэн мэт үзэхээр шийдсэн хэрэг юм. Үүнийг Хасар хэзээ ч зөвшөөрөхгүй билээ. Түүнийг, хөвүүдийг нь энгийн нэг иргэний адил үзэх нь боолчилж дарласантай агаар нэг санагдаад тэссэнгүй.

Өүлэн эхийн үхлийн дараа Хасарын сэтгэл санаанд гарсан өөрчлөлтийг Чингис хаан цагт нь таан мэдэж түүнд Алтан улсын зүүн хойт нутгийг эзлэн авах хэргийг найр тавин өгснөөр тэдний хооронд оч өгвөл дүрэлзэн асахад бэлэн байсан их түймрийг түр боловч намжаасан билээ. Зүүн хойт Хятадыг хялбар дагуулж олон хот балгасыг эзлэн авсан ч Чингис хаан өөрт нь тэр нутгаас ганц хот ч болов өмч болгон хуваан өгсөнгүйг Хасар бас тэвчин өнгөрчээ. Удалгүй Хорезмд довглох шийдвэр гарсныг Хасар эсэргүүцсэн нь тэдний зөрчлийг дахин

дэвэргэв. Таньж мэдэхгүй Хорезмд цэрэг хөдөлгөснөөс цаг алдалгүй Алтан улс, түүний хөрш Сүн улсыг эхлэн эзлэх нь зөв гэж Хасар хатуу зүтгэж байв. Дахин дахин найрамдаж, найрамдах бүр итгэл алдан урвах Алтан улсыг өдөр хүлээлгүй даран сөнөөхийг Хасар шаргуу шаардсаар байлаа. Ийм бодолтой байсан нь ганц Хасар ч биш юм. Алтан улсыг нэг мөсөн дарж аюулгүй болгох нь хүчирхэг, үл мэдэх Хорезмтой хийх дайны өмнө зайлшгүй хэрэг гэж Хубилай нарын хэсэг жанжин бас Хасарыг дэмжсэн нь Чингис хааны хилэнг бадраажээ.

Гэвч тэдний эсрэг илэрхий эсэргүүцэн хэрүүл тэмцэл хийхийг хүссэнгүй. Алтан улсыг дайлах нь зөв ч байж мэдэх юм. Гэвч Алтан улсыг Хасарын хэлээд байгаа шиг тийм хурдан түргэн эзлэн авах нь юу л бол. Харин түүний оронд Алтан улс хүчээ хуримтлуулан довтолж чадахгүй болсон энэ цагийг ашиглан Хорезмыг дагуулж элчээ алуулсны өшөөг авах нь илүү чухал, алс хол шинэ газарт хөлөө тавьж, нутгаа өргөтгөх илүү боломж олно гэж Чингис хаан үзэж байлаа. Үүнээсээ ч ухрахыг үл хүсчээ.

Боорчийг өвөл Алтайгаас ирэхийн өмнө Хасар Чингис хаанд бараалхахдаа юу хэлж ярьсныг тэр бүрэн хэлсэнгүй. Ер нь энэ яриаг хэзээ ч, хэнд ч хэлэхгүй биз. Харин Боорчи сая хэлсэн үгэнд нь цочирдож бодолд ээрэгдэн суухыг хараад тэр явдлыг санажээ. Хасарыг туйлбартай буруутгах шалтгаангүйгээр алах нь Боорчид хэцүү байгааг Чингис хаан мэдэж байв.

-Боорчи. Чи самуун бодолд автан бүү эргэлз. Хэрэв би их цэргээ Хорезм руу хөдөлгөвөл Хасар өөрийн хүчээр Алтан улсыг довтолон эзлэж авна гэнэ. Чи үүнийг юу гэж санана. Хасар тэгэж чадах уу.

Энэ бол тэгэж бараалхахдаа Хасарын хэлсэн олон үгний нэг нь юм. Ийм үг сонссоны дараа Боорчи Хасарыг өмгөөлж чадахгүйг Чингис хаан мэдэж байлаа. Үнэхээр энэ үгийг сонсоогүй бол Боорчи Хасарыг алахгүй байх олон шалтгаан, түүний их гавьяаг дурдан хэлэхээр бэлтгэж байсан билээ. Чингис хаан Боорчийн юу бодож, юу хэлэхийг шууд хараад л гадарлана. Хэрэв Чингис хаан зарлиг буулгаагүй байхад Хасар Алтан улсыг довтолбол үүнийг чухам юу гэж нэрлэхийг Боорчи мэднэ. Энэ бол хаан төрийн эсрэг улаан цайм самуун гаргасантай адил хэрэг юм. Хасар ингэж хэлж, бас хийж чадахыг Боорчи мэдэх тул сэтгэлд нь могой шургах мэт хүйт оргиод явчихыг мэдэрчээ. Бас Чингис хаан түүнээр юу хийлгэх гэж буйг сая л жинхэнэ ёсоор ойлгов. Эхлээд тэр Чингис хааныг ятган тайтгаруулж чадна гэж бодож, бүр итгэж байсан юм. Одоо гэнэт энэ байдалдаа эргэлзэж эхлэв. Хасарыг өмөөрөх нь хаан төрийнхөө эсрэг самуун дэгдээхийг дэмжсэн хэрэг болох байв. Энэ ах дүү хоёр хэзээ л алалцах бол гэсэн хөндүүр болгоомжлол олон жилийн турш Боорчи Зэлмэ нарыг түгшүүлсээр байсан бөгөөд тэр үйл лийн цаг нь иржээ. Болох болохдоо Чингис хаан энэ хэргийг Боорчиор гүйцэлдүүлэхийг хүсчээ. Яг энэ үед тэр саа өвчин туссан Зэлмэд агаархах шиг болжээ.

Одоо түүнд ухарч буцах, булзаж бултах арга нэгэнт

байхгүй байлаа.

-Тэмүжин.

Чингис хааны алдар гуншинг умартан ингэж дуудахдаа Боорчид нэгэнт эргэлзэж тээнэгэлзэх

зүйл үгүй болсон байв.

-Тэмүжин. Хасарыг алах тийм хялбар биш. Хэрэв тэр нэгэнт Алтан улсад толгой даан довлохоор шийдсэн бол үүнээсээ ухрахгүй. Гэхдээ Хасар бол Боорчи биш. Тэр бол Чингис хаан таны төрсөн дүү, Есүхэй баатарын хөвүүн. Их Монгол улсад хамгийн их гавьяатны нэг. Нэр өндөр, нөлөө хүч их. Хөвүүд нь гавшгай. Тэмүжин чи намайг Хасарыг яаж үхүүлнэ гэж бодно. Чи хэлээч.

-Би чамд хүн яаж үхүүлэхийг заах гэж үү. Чи юу ярина.

-Гэвч Тэмүжин чи нэгийг лав бодсон биз. Би чиний хэлснээр хийе. Түүнийг ёс бусаар үхээсэй гэж чи лав хүсэхгүй биз. Бас Хасарыг зүгээр нэг хүний нүдэн дээр цаазлах юм уу, андууран харваж болохгүй санагдана. Сүүлд үүсэх будлиан самууныг яах вэ. Миний амь ер хайран биш. Харин Чингис хааны их нэр хайран болно.

Боорчийн энэ ухаантай үгийг Чингис хаан хүндэтгэн сонсжээ.

-Тийм ээ. Хасарыг үхүүлэх амар биш. Тийм болохоор л чамд хэлэв. Хасар өөрийн үхлээр л үхмээрсэн. Тэгвэл надад хоргүй юм. Үүнийг чи л хийж чадна. Харин тэр жил Зүчийг төрөхөд амьд үлдээсэн шигээ хялбар хэрэгт бүү бодоорой. Барын сүүлнээс баривал бүү тавь. Үхтэл нь атгаад бай гэдэг биз. Би чамд сануулга болгож Зүчийг хамт туслуулъя. Зүчээс бүү нуу. Энэ хэргийг Зүчи бид гурав л мэдэг. Энэ хэрэгт Зүчийг туслуулбал тэр надад улам ч итгэн дотносох биз.

Ингэж Хасарын амьдрал шийдэгдэв. Чингис хаан ингэж шийдсэнийг Боорчи зөв гэж эргэлтгүй дэмжсэн бөгөөд ерөөсөө Хасар үг хэл, үйл хөдлөлөөсөө болж өөрөө л үхэл рүүгээ очсон гэж үзжээ.

Эргүнэ мөрний эхээр байх нутагтаа буцаж харьсныхаа дараа Хасар гэнэт үхсэн нь Боорчи болоод Зүчийн хийсэн хэрэг гэдгийг тэднээс гадна ганцхан Чингис хаан мэдэж байлаа. Хорезмд их цэрэг хөдлөхөөс хоёрхон сарын өмнө энэ хэрэг болсон бөгөөд Чингис хаан улс даяар их гашуудал зарлахыг хориглож нам гүм өнгөрөөгөөд Хасарын хөвүүдийг дуудан авчирч сайн эцгийн нэрийг өргөж явахыг захиж, эцгийнхээ хүслийг та нар биелүүлэх ёстой гэж Алтан улсад явах Мухулайд тэднийг өгснөөр Чингис хаан нэг насанд заяасан хамгийн хүчтэй өрсөлдөгчөөсөө нэр бүтэн салж амарсан билээ. Харин өнөөдөр энэ Перваны хөндийд хиймэл борооны чийгтэй агаар сэнгэнэх өргөөнд Чингис хаан Зүчийн тухай олон сайхан үг хэлж магтах хиймэл хуурамч зангийн цаана чухам ямар санаа нуугдаж байгааг мэдрэх шиг болоод Боорчи өөрийн эрхгүй Хасарын үхлийг санажээ. Хэрэв Чингис хаан Зүчийг үхүүл гэвэл Боорчи хэлэх үгээ олж ядна. Чингис хааны үгний цаана яг ийм санаа цухалзсаар байсныг Боорчи мэдэж байлаа.

“Тэнгэр минь. Надад туслаач. Зүчийг бүү үхүүлээч” гэж Боорчи дотроо Тэнгэрээс гуйн залбирч суув. Боорчи олон жилийн өмнө “Тэмүжинг бүү үхүүлээч” гэж Хүйтэн уулын бэлд Тэнгэрт гуйн мөргөснөө саналаа. Тэгэхэд Тэнгэр түүний гуйлтыг сонсож гэрэлт бөмбөлөгөө илгээж Тэмүжинг аварсан билээ. Одоо яг тийм явдал болоосой гэж хүсч байв. Боорчийг ингэж хачин мэлгэр царайлан тооно өөд гөлрөн суухыг Чингис хаан үзээд маш их гайхжээ.

-Боорчи. Чи яав. Сүнс сүг үзсэн юм шиг зэвхий царайлах чинь.

Боорчи сая дотор бодлоосоо салж хаана суугаагаа ухаарчээ.

-Хаан та намайг ямар хэрэгт зарах гэж байгааг би тааж ядна. Зовлонгийн түргэн нь дээр гэдэг биз гэж Боорчи хэлсэн нь Чингис хааныг “Бүү уд. Үгээ шууд хэл” гэсэнтэй адил сонсогдов. Чингис хаан Боорчийн үгийг ойлгож инээмсэглэв.

-Боорчи. Чи миний хэлэх үгийг сонсоод лавтай баярлах биз. Би чамайг ер баярлуулж байсан удаагүй биш үү.

Чингис хааны сэтгэл дүүрэн хэлсэн энэ үг Боорчийг сэргээх биш харин ч хуучин гунигт түүхийг санагдуулсан тул тэр гүнзгий санаа алдав.

-Яав чи. Би чамд бахтай сайхан үг хэлж байхад санаа алдаж гуниглах чинь. Би буруу зөрүү үг хэлэв үү. Чи хэл гэж Чингис хаан Боорчийн урамгүй гунигтай байдлыг үзээд бухимдан шалжээ.

-Би эртний дэмий явдлыг саналаа. Хаан та “Гүмүдаг очиж авчир” гэхдээ яг ийм үг хэлсэн билээ. Тэр явдал санагдаад гэж Боорчи үнэнээ хэлэв. Өргөөнд гэнэт түгшүүртэй нам гүм боллоо. Чингис хаан Боорчийн энэ гэнэтийн үгэнд балмагдан харц буулгаж бодолд автав. Тэгээд Боорчийг аргадаж тайтгаруулах санаатай

-Боорчи. Би тэр явдлыг яаж мартана. Би л чамд тэгэж хэлээгүй бол, ядаж хэд хоногийн дараа хэлсэн бол ер ийм явдал болохгүй байв. Энэ хэрэгт чи ганцхан намайг буруутгах ёстой юм гэв. Чингис хааны энэ харамслын үг Боорчийн сэтгэлийн тэвчээрийг барагдуулжээ. Боорчийн уусан архи гэнэт дээш өгсөн ходоодноос тархинд гарч зүрх нь урагдах шиг шимшрэн шархирч, нулимс нь халуу оргиулан нүд дүүрлээ. Яаж ч хүчлээд нулимс нь түүнд дийлдсэнгүй эзэнгүй мэт урсан гарчээ.

-Чи битгий уйл.

Боорчийн том том дусал нулимсыг Чингис хаан харж чадсангүй дальдрав.

Энэ бол хамгийн аймшигт явдал байсан юм. Боорчи түүнийг санахгүй гэж, эргэж дурсахгүй юмсан гэж хичнээн жил хичээж, сэтгэлээ хүчээр барьсаар ирсэн билээ. Гэтэл одоо гэнэт биеэ барьж дийлэхээ болиод анх удаа хүүхэд адил гашуунаар мэгшин уйлав. Бүр эхэр татан уйлжээ. Чингис хаанд хэлэх үг, тайтгаруулах арга даанч олдсонгүй. Тайчуудыг дарсны хойтон зун Ононы Сэрүүн булгийн эхэнд зусч байх үед, нэг өдөр Тэмүжин яг өнөөдрийнх шиг үгийг Боорчид хэлсэн билээ. Боорчи тэгэхэд хорин дөрвөн настай байв.

-Боорчи. Чи миний хэлэх үгийг сонсоод лавтай баярлах биз. Би чамайг ер баярлуулж байсан удаагүй биш үү гэж Тэмүжинг инээмсэглэн хэлэхэд Боорчи чухам юу гэхийг таасангүй.

-Чиний сүй тавьсан Гүмүда одоо арван зургаан нас хүрчээ. Чи Гүмүдагаа авчирч бага эхнэрээ болгох цаг чинь болсон биш үү. Эсвэл чи мартав уу.

Энэ үгэнд Боорчи үнэхээр их баярласан билээ. Танхил бага насанд Наху баян эцгийнхээ сүй тавьсан Гүмүдаг яахан мартаж билээ. Тэмүжиний аймагт ирж арваад жил болоход Боорчи нэгэнт Бөртийн садангийн Оюутцэцэн бүсгүйг эхнэр болгон авч охин үртэй болсон ч Гүмүдаг мартсангүй. Гүмүда нэгэнт балчир байсан, бас Тэмүжин тэд тайчуудтай дайтаж байсан зэргээс болоод Боорчи Гүмүдагийн тухай ам нээж дуугарахгүй байжээ. Учир нь Гүмүдагийн эцэг Торгон баян бол тайчуудын дунд нэртэй хүн билээ. Дайснаасаа эхнэр авахыг хэн таашаах вэ гэж Боорчи болгоомжилж байсан хэдий ч нэг ч мөч Гүмүдагаа мартсангүй явжээ. Харин Тэмүжин түүний бодсоныг нэвт харсан мэт ингэж хэлсэн нь туйлын сэтгэл догдлом баяртай хэрэг болжээ.

-Боорчи чи яв. Гүмүдагаа очиж авчир. Тэр одоо нэгэнт нас бие гүйцэж үзэсгэлэнтэй эм болоо биз. Удвал өөр хүнд өгч мэднэ. Одоо бид тайчуудын гол хүчийг нэгэнт дарсан болохоор чи очиж Гүмүдаг авчир гэж Тэмүжин хэлсэн билээ. Ингэхийг Өүлэн эх ч дэмжин сайшааж байв. Дийлдсэн тайчуудын иргэдийг хураан авсан ч Торгон баяны хүрээг тэд довтлоогүй нь сайн болжээ. Тийм болохоор Торгон баян Тэмүжинтэй эвссэн Боорчийг талархалтай угтах нь гарцаагүй гэж тэр бодсон нь ямар аймшигтай алдаа болсныг одоо ч санахад эмгэнэлтэй. Тийм ч учраас Боорчи сэтгэлийн хөвч тасран гаслан уйлсан билээ. Ялалтандаа дэндүү эрдэж итгэсэн нь Боорчийг дөнгөж таван цэргийн хамт Торгон баяны хүрээ рүү явахад хүргэв. Хэн ч түүнийг сэрэмжлүүлж сануулсангүй. Ганцхан Оюутцэцэн л эм хүнийхээ атаач зангаар өөр эхнэр буулгахаар явж буй эр нөхрөө таашаасангүй үлдсэн ч гаднаа баяр хөөртэй үджээ. Тэмүжин ч, хэн нь ч муу юм санасангүй. Боорчи, Торгон баяны хүрээнд очиж багын сүйт Гүмүдагаа үзээд хэмжээлшгүй их аз жаргалтай болжээ. Гүмүда үнэхээр арилгасан сонгино шиг хаанаас ч харсан цэвэрхэн бүсгүй болон өсчээ. Торгон баян эртний сүйгээ мартаагүй ажээ. Боорчийг бөөн баяр болон угтаж гурав хоног найр цэнгэл хийж, охиноо ёс төртэй өгөв. Гүмүдагийн гэнэн ялдам аашинд автаж гурав хонохдоо Боорчи авааль эхнэр Оюутцэцэндээ огтхон ч хайр сэтгэлгүйгээ ойлгов. Амьсгалд хиртэж, алганд бяцармаар эмзэг, энхрий Гүмүдаг үзээд хайр дурлал гэдэг ийм шаналгаатай, бас энхрий нялх байдаг гэж санасангүй явснаа л ухаарчээ. Боорчи дэндүү хайрласандаа болоод Гүмүдаг эрийн ёсоор эдэлж, охин биеийг нь эвдэж зүрхэлсэнгүй. Тэр зүгээр л галын гэрэлд Гүмүдагийн гоо царайг ширтэн нойргүй хонодог байв. Хол ойрд зард гарч эхэлсэн Тэмүжиний шадар нөхөр Боорчид Гүмүда яг л хүүхэд шиг эрхлэн дурлажээ. Торгон баян ч хүчирхэг хамгаалагчтай боллоо гэж баярлав. Гэвч Боорчи Гүмүда хоёрын дэндүү нялх эмзэг дурлал ердөө л хэдхэн хоногийн настай байв.

Боорчийг Торгон баяныд ирсэн сураг хавь орчмын тайчуудын хүрээнд тарж Тэмүжинд ялагдсандаа өс санасан Таргудай залуу эрсийг турхиран Боорчийн замыг отоож байжээ. Тэдний хувьд Боорчоос өшөө авах нь Тэмүжинээс өшөө авсантай адил хэрэг байлаа. Боорчи Гүмүдаг авч гэрийн зүг хөдөлсний маргааш тэд Таргудайн отоонд орж баригдав. Тайчууд юу хийхээ аль эрт төлөвлөсөн байлаа. Дагалдагч хэдэн цэрэг төдөлгүй алагдаж, Боорчи олон хүний эсрэг яаж ч эс чадаад эцэст нь хүчинд автан баригдав. Боорчийг шууд алчихаагүйн учир тэр дороо тодорхой болжээ. Тайчууд үг дуугарч яах вэ, ийх вэ гэж ярилцсан ч үгүй. Боорчийг харуулж байгаад хайртай Гүмүдаг нь нүцгэлэн ээлжлэн хүчирхийлж бахаа хангаад нүцгэн түүнийг өрөөсөн хөлнөөс нь модны мөчрөөс дүүжилж орхив. Хээрийн тансаг цэцэг шиг ариухан Гүмүдагийн царай хормын дотор өнгө алдан гэрэл бөхөхийг харахад нүд хальтирна. Гүмүда бараг амь тавьсан байв. Боорчийг модтой хүлж Гүмүдагийн толгойн дор хаяжээ. Тэд явахдаа Боорчи Гүмүда хоёрын гүрээний судсыг тас хэрчихээ мартсангүй. Тайчууд нэг ч үг

дуугаралгүй явж одоход Боорчи Гүмүда хоёрын цус нийлэн урссаар хоцров. Хайртай, дэндүү хайртай Гүмүда нь харсаар байтал бүх цусаа дусал дуслаар юүлж удаан тарчлан шаналж үхжээ. Гүмүдагийн цус Боорчийн толгойруу асгарсаар гэрэлт хар нүд нь унтарч, цусандаа норсон гэзэг нь нүүрийг нь сэрвэгнүүлсээр байлаа. Боорчи ч бас үхэж байв.

Харин түүнийг мод налууулж суулгаад хүлсэн нь аврал болж арай ч цусаа юүлж дуусаагүй байхад эрлийн хүн таарч Гүмүдаг таньснаар Торгон баяныд хэл өгч, Боорчи аврагдсан ч ийм аймшигт үхлийг үзсэн Торгон баян тэссэнгүй зүрх нь хагарч үхээд, эхнэр нь солиорсон билээ. Гүмүдагийн энэ аймшигт үхлийг Боорчи ганцхан Тэмүжинд хэлсэн бөгөөд Тэмүжин Боорчиос дутуугүй цочиж Гүмүдагийн үхэлд өөрийгөө буруутгах болжээ. Гүмүдагийн үхэл Боорчид гүнзгий цохилт болж нэг хэсэг тэр ухаан солиотой мэт болоод шөнө хар дарж зүүдлэх нь олширч, бүр сүүлдээ хажуугаар хэвтэх эхнэрээ багалзуурдан алах шахсанаас хойш тэд гэр тусгаарлажээ. Гүмүдагийн үхсэн нь Боорчийн сэтгэлд байсан эмэгтэй хүнийг хайрлаж энхрийлэх дадал, хүслийг нэгмөсөн үгүй хийсэн билээ. Тэр цагаас хойш Боорчи эм хүнд хөндий хүйтэн хандах болжээ. Энэ нь түүнийг гэр бүлийн амьдралаас холдуулж гэртээ орж эхнэртэйгээ нэг хөнжилд хэвтэх нь жинхэнэ тамлал болон хувирав. Гүмүдаг авахаар яах гэж очив гэж бодох бүр үхэхдээ аврал эрэн ширтсээр байсан хөөрхөн нүд нь, ангалзсаар байсан уруул нь үзэгдээд шөнө орилон босч ирдэг байлаа.

Ингэж Боорчи гэр орны амьдралаас үүрд зугатаах болж бүх цагаа цэрэг дайны хэрэгт зориулах болжээ. Тэр аль болохоор Гүмүдагийн үхлийг санахгүйг хичээдэг билээ. Тэмүжин ч Боорчийг аль болох дэмжих, санаа сэтгэлийг нь тайван байлгахыг хичээнэ. Харин өнөөдөр санамсаргүй хэлсэн үг тэдний сэтгэлийн шархыг ийн сэдрээжээ. Боорчи гэнэт уйлахаа больж аягатай архи авч гуд залгилаад ер юу ч болоогүй юм шиг

-Тэмүжин чи юу хийхээ даруй хэл. Шөнө дууслаа. Маргааш би эртхэн мордсугай гэхдээ Боорчи Зүчийн тухай бодож байв.

-За яамай чи ашгүй тайвшрав уу. Одоо би чамд дахиж Гүмүдаг сануулахгүй.

-Чи юу хүссэнээ хэл. Юу ч байсан би биелүүлнэ гэхдээ Боорчийн дотор хэнээс ч юм бэ өшөө авах гашуун хүсэл оргилсоор байгааг мэдлээ.

-Би чамайг ... Сүбээдэйн тийш илгээе.

-Юу гэнэ ээ гэж Боорчи үнэнээсээ гайхан дуу алдлаа.

-Чи шинэ нутаг билчээр, хот балгас үзэж хийморио сэргээж уйтгараа үргээж үз. Сүбээдэй Зэв хоёр чи бид хоёрын нэгийг очихоос нааш ирэхгүй бололтой. Чи очиж тэр айхтар зуудаг нохдыг оросын боривноос салгаж авчир. Тэгээд тэднийг ирмэгц харьцгаая.

-Хаантан та. Чин үнэн хэлнэ үү гэж Боорчи сая л хаана байгаагаа ухаарах шиг хэлэв.

-Тийм ээ. Би үнэн хэлж байна. Чи торгон цэргээсээ өөрийн хүссэнээр авч одогтүн. Харин Сүбээдэй Зэв хоёртой нийлээд бүр цаашаа явчихав. Тэднийг дагуулж авчир. Ирсэн хойно нь би тэр айхтар зуудаг нохдыг сайн залхаая гэж Чингис хаан хөхрөв.

-Зүчийг ал гэж хэлээгүйд нь Боорчи сэтгэл цэлмэн баярлаж Гүмүдагийн үхлийн тухай гунигт бодлоос бага боловч салав. Тэгээд Тэнгэр Зүчийг харжээ гэж талархан бодов.

Орос гэж ямаршуухан улс байдгийг үзэх хүсэл Боорчид нэн их байсан билээ. Боорчи дотроо Сүбээдэй Зэв хоёрт атаархаж байсан тул Чингис хааны энэ зарлигт их баярлажээ. Бас дээр нь Чингис хаан Зүчи хөвүүнээ хөнөөх сэтгэл үгүй байгааг мэдэж авав. Би дэмий харджээ гэж Боорчи бодсон юм. Тэр шөнө,Боорчи догдлон хөөрч, маргааш эцгийгээ дагаж аянд мордох гэж байгаа балчир банди шиг нойргүй хонов. Асарт нь өнөө өндөр хамарт, их дуут харь цусны бүсгүй нүцгэн тэлчилж хэвтэнэ. Боорчи түүнийг ч тоосонгүй хөлбөрсөөр байлаа.

Энэ шөнө Боорчи сэтгэл хөдлөн баярлаад зогссонгүй тун ч ихийг тунгаан боджээ. Сонссон баярт мэдээгээ хуваалцах дотно хүнгүй яваагаа өнөө шөнө л голдоо ортол мэдэрчээ. Боорчи энэ газар дээр цор ганцаар хоцорчээ. Гүмүдагаас хойш тэр дахин ямар ч эмийг тийм гүнзгий дотноор хайрласангүй. Хайрлая гээд ч түүний сэтгэл нэгэнт хоосорсон байжээ. Гэтэл дасаж сурсан амьдралаа өөрчлөх хүсэл яагаад,хаанаас ингэж оргилоод байгааг Боорчи ойлгосонгүй үүр цайлгажээ.

Арван гурван настайдаа анх Тэмүжинг даган явсан шигээ эрс шийдвэрийн өмнө тулж ирснээ Боорчи гэнэт ойлгов. Тэр жирийн хүн шиг хайрлаж дурлаж, үр хүүхдээ өсгөж, дэргэдээ дагуулан явахыг хүсч байжээ. Харин одоо хүссэнээ биелүүлэх тийм цаг хугацаа үлдсэнгүй. Боорчи Тэмүжинд атаархах шиг болов. Гэвч энэ бодлоосоо айжээ.

Гэтэл Тэнгэр түүнд хилэгнэж хөвүүн заяасангүй нь гачлантай. Энэ бол түүний гуниг харууслын үндэс байлаа. Боорчи нэгэн зүйлийг санамагц цочин өндийжээ. Бүр бодох бүр зүрх нь догдлон чичирч байжээ. Энэ бол олон жил өөрөөсөө ч нууж явсан бодол юм. Одоо түүнд эргэж буцах, эргэлзэн тээнэгэлзэх цаг нэгэнт үгүй болсныг сайтар мэдэж байв. Тийм учраас алгуурлаж хойшлуулахыг хүссэнгүй босож зэргэлдээ асарт унтаж байсан Гэрэгийг дуудан босгов. Бас өнөөх Багдадын эмийг ч эмсийн гэрлүү хөөж явуулав. Үүр цайж тэнгэрийн баруун хаяа цайрчээ. Гэрэг хэзээ ч сэргэг байдаг зангаараа нүдээ гялалзуулан орж ирэв. Одоо Гэрэг хорь хүрч, галзуу барын аманд гараа хийхээс буцахгүй ааг омог дүүрэн насан дээрээ яваа билээ. Чингис хааны их торгон цэргийн хамгийн шилдэг зуутыг захирч Боорчийн дэргэдээс алхам ч холдохгүй явсаар уджээ. Харин ингэж үүр цүүрээр дуудсанд Гэрэг огт гайхсангүй.

Ижийгээ нас барахад Гэрэг есөн настай байсан бөгөөд хойтон жил нь Боорчи түүнийг дэргэдээ авчирч шадар цэргээрээ маллуулжээ. Эцэг нь хэн болохыг Гэрэг эхээсээ асуусан ч үгүй, бас эх нь хэрэг болгож хэлсэнгүй үхжээ. Тийм учраас Гэрэг эх эцгийн элбэрэл хайраас хол хөндий яг л эзнийхээ турхирахыг хүлээгч зуудаг нохой шиг болон хүмүүжжээ. Гэрэгт Боорчи эзний нь үг зарлигаас эрхэм гэгээн зүйл энэ газар дээр үгүй юм. Боорчи эзнийхээ зарлигийг биелүүлэх нь түүний ганц хүсэл жаргал билээ. Одоо ч тийм л сэтгэлээр юу хэлэхийг нь хүлээн сууж байв. Боорчи Тэмүжиний энэ нууц хүүг удаан ажиглав. Гэрэг эхийгээ илүү дуурайжээ. Харин доош тонгойн суугааг нь хальт харвал Тэмүжиний залуугийн төрх танигдах ажээ. Гэрэг бол хувь заяагүй хөвүүн гэж Боорчи түүнийг үргэлжид өрөвдөн боддог билээ. Хэрэв Гэрэгийг Тэмүжиний хөвүүн гэдгийг Бөртэ мэдсэн бол тэр аль эрт алагдах байсан гэдэгт Боорчи одоо ч эргэлзэхгүй итгэсэн хэвээр байв. Тийм учраас Боорчи Гэрэгийн хэн болохыг тас нуусан бөгөөд одоо ч илчлэхийг хүссэнгүй. Боорчи Тэмүжиний

хөвүүн Гэрэгийг үүрд булаан авахаар шийджээ. Боорчи аз жаргалтай амьдрахыг хүсч байв.

-Гэрэг хөвүүн минь сонс.

Энэ хэдэн үгийг хоолой давуулан хэлэх гэж Боорчи цай чанахын дайтай хугацаанд амьсгал түгжин суув. Ийм үг хэлж үзээгүйн дээр бас түүний үгийг Гэрэг хэрхэн хүлээн авах нь эргэлзээтэй байсан нь түүнийг ингэж шаналгажээ. Харин одоо нэгэнт хэлж чадаад санаа амарчээ. Гэрэг зарлиг сонсдог ёсоороо тонгойн суусаар байгаа нь Боорчид түүний царай зүс хэрхэн хувирахыг харах боломж олгосонгүй. Боорчи л өөрөө догдлон чичирсээр байжээ. Гэрэг эзнийхээ дараагийн үгийг хүлээн суусан хэвээр ажээ.

-Гэрэг чи үүнээс хойш бүү ингэж тонгойн суу.

Боорчи үгээ үргэлжлүүлж чадалгүй тасалжээ. Учир нь Гэрэг толгой өргөн түүнийг эгц ширтжээ. Гэрэгийн харцанд гайхсан шинж илэрнэ. Боорчи түүний энэ харцнаас цочиж бүр түгшин нүд буруулжээ. Учир нь түүний өөдөөс хорин настай Тэмүжин ширтэж байх шиг үзэгджээ. Гэвч Боорчид санаснаасаа ухрах хүсэл төрсөнгүй. Тэгээд Гэрэгийг эгц ширтэж байгаад

-Хөвүүн минь. Чи миний хэлэхийг сонс. Чи бол миний төрсөн хөвүүн юм. Эх чинь чамд лав энэ тухай хэлээгүй биз. Одоо чи нэгэнт нас бие жагсаж, ухаан чинь тэгширчээ. Энэ өдрөөс хойш чи Чингис хааны шадар сайд Боорчийн хөвүүн мэт явагтүн. Би хөгширч байна. Харин Гэрэг чи Зэлмийн хөвүүн Есөнтэйн адил эцгийгээ залгамжлах болно. Би чиний тухай Чингис хаанд айлтгаж чамайг өөрийн дор мянганы ноёноор өргөмжилнө. Чи миний үхсэний дараа Алтайн түмнээ захирч эцгийгээ залгамжлан сууж үр хүүхэд чинь ч энэ мэтээр явах болно. Боорчи миний үр удам үеийн үед тасрахгүй мөнх үргэлжлэх болно гэж шөнөжин бодсон үгээ хэлж санаа амраад толгой өргөвөл Гэрэгийн нулимс мэлтэрсэн нүдийг олж харжээ. Боорчийн зүрхний угт нэг утас тонхийн дуугарч тасрах шиг болоод нулимс нь сул асгараад өөрөө ч мэдэлгүй гараа сунгаж

-Хөвүүн минь. Нааш ир гэж шивнэжээ. Гэрэг хүүхэд адил мөлхөн ирээд Боорчийн өвдгийг тэврээд гашуунаар бархиран уйлж

-Аав минь. Та юуны учир намайг ингэж удаан залхаасан юм бэ гэж шивнэсээр байжээ. Хатуу бэрх хүмүүжилтэй Гэрэгийг ингэж уйлна чинээ санаагүй учир Боорчи туйлын ихээр сандарч бүр яах ч учраа ололгүй таг суужээ. Гэвч тэд хурдан тайвширчээ. Гэрэгийн энэ нулимс, итгэл Боорчийг нэг мөсөн эзэмдэж, одоо тэр Гэрэгийг өөрийн төрсөн хөвүүн гэдэгт бат итгэлтэй болжээ. Боорчи аз жаргалтай байлаа. Хөвүүн үртэй байх гэдэг хичнээн их хувь зохиол болохыг Боорчи ингэж нэг үзэж мэдэрчээ. Одоо түүний өнгөрүүлсэн болоод үлдсэн амьдралын нь зорилго утга, нартай өдөр мэт тод томруун болов.

Гэрэгийн аз жаргалд хэмжээ байсангүй. Анх арван настайд нь дагуулан явсан Боорчи эзэн нь эцэг нь байгаасай гэсэн далд хүсэл сэтгэлийг нь нэвт эзэмдсээр ирснийг Гэрэг өөрөө ч мэдэхгүй явсан нь Боорчийн үгийг сонсоод тэгэж бахардан баярлахад хүргэжээ. Хатуу харгис, хайр энэрэлгүй сэтгэл, хүмүүжил нь нэгэн мөчийн дотор зөөлрөн өөрчлөгдөж тэр өөр хүн болон хувирч байх нь Гэрэгт тод мэдрэгдсэн билээ. Хүний үрийг чонын үүрэнд аваачиж



хаялаа ч түүний сэтгэлээс эх эцгээ хайрлаж хүсэх дадал нь хэзээ ч үл арилахын адил хар нялхаас дэг чанга цэргийн амьдралд нухлагдсан ч эх эцгээ хүсэмжлэх, эрхэлж үнсүүлэх хүүхэд зан нь Гэрэгээс огтхон ч хаягдсангүй харин ч сэтгэлийн гүнд улам хүчтэй болсоор ирснийг өөрөө ч мэдсэнгүй билээ. Харин Боорчи хэргийн учрыг удаашруулж өөрийгөө зовоохыг хүссэнгүй тул Гэрэгийн тухай Чингис хаанд тэр өдрөө мэдүүлжээ. Хэдийгээр энэ олон жил өөрийн төрсөн үрийг хэл чимээгүй дарагдуулан явсны учрыг Боорчи итгэж үнэмшихээр тайлбарлаагүй ч Чингис хаан мөн л Боорчийн адил догдлон хөөрчээ. Чингис хаан Боорчийг аз жаргалтай байгаасай гэж үнэн сэтгэлээс хүсэх учир даруй Гэрэгийг дуудан ирүүлжээ. Гэрэг хэзээ ч Чингис хаанд ингэж биеэр бараалхаж байсангүй тул ихэд балмагджээ. Харин Чингис хаан Гэрэгийг үзмэгцээ түүнийг Боорчийн үр гэдэгт эргэлзэхгүй итгэжээ. Танил дотно төрхтэй нүдэнд дулаахан царайтай тэр залуу түүний үнэнч нөхөр Боорчийн хөвүүн байхаас өөр арга байсангүй. Гэрэгийг үзээд Чингис хааны баяр бахдал улам нэмэгджээ. Боорчи ч Чингис хааныг итгүүлж чадсандаа тайвшран баярлажээ.

-Чиний эцэг Боорчи бол дээд Тэнгэрээс надад хувааж өгсөн миний ганц үнэнч нөхөр минь юм. Би Боорчи болон бусад нөхдийн хүчээр энэ их улсыг байгууллаа. Харин чи Боорчи эцгээ залгамжлан миний төлөө зүтгэгтүн. Би чамайг их торгон цэргийн мянганы ноёноор өргөмлөж сайн эцгийнхээ хувь хишгийг үеийн үед үрийг үрд эзэмшиж явах зарлиг буулгая гэж Чингис хаан бахархалтай хэлжээ.

Чингис хааны энэ зарлигийг Шихихутаг тэр өдөрт нь олонд тунхагласан бөгөөд энэ өдрөөс эхлэн Боорчи болоод Гэрэгийн шинэ аз жаргалтай амьдрал эхлэсэн билээ. Юм ингэж санаанд оромгүйгээр хурдан тэгэхдээ ийм сайн сайхнаар хувирч өөрчлөгдөнө чинээ Боорчи санасангүй. Бас Гэрэгийн олон олон асуултанд хариу өгч өөрийн үзээгүй амьдралыг зохион ярих хэрэг хамгийн түрүүнд Боорчид тулгарчээ. Эхтэй нь хэрхэн учирсан бас яагаад түүнийг орхин явсан юуны учир өөрийн хөвүүн гэдгээ нуусан гээд бүх зүйлийн учрыг Гэрэгт тайлбарлах хэрэгтэй болжээ. Гэрэг бүхнийг мэдэж, өөрийн ээдрээтэй хувь тавилангийн үнэн учрыг тодруулж ойлгохыг хүсэх нь зүйн хэрэг болжээ. Энэ бол дайсантай нүүр тулан байлдахаас хэдэн хувь хэцүү хэрэг тул Боорчи Гэрэгийн шаардлагад алгуур тайван хандаж бас түүний баярласан дэврүүн сэтгэлийг гомдоохгүйг хичээж байлаа. Харин Сүбээдэйн араас явахдаа Гэрэгийн мянгатыг дагуулан явахыг Чингис хаан зарлиг болгосон нь эцэг хүү хоёрыг жаахан сагааруулж, Боорчид аврал болж Гэрэгийн амьдралыг үнэмшилтэй тайлбарлах аргаа бодож сэтгэх хугацаа олджээ. Явах газар хол, хэдийгээр эзлэгдэн бууж өгсөн ч эсэргүүцлийн самуун газар сайгүй дэгдсээр тул тэр Гэрэгийн шилдэг торгон цэргийг дагуулах нь гарцаагүй зөв байжээ.

Боорчийг Сүбээдэйн тийш Орос газарт илгээх зарлиг буулгаснаасаа хойш Чингис хаан бас л нойргүй хонох болжээ. Боорчийг мордох хүртэл түүнд бодож шийдэх юм их байлаа. Боорчийг явчихвал Хорезмын энэ бүгчим харанхуй тэнгэр дор гав ганцаар хаягдах мэт сэтгэгдээд тэр өөрийгөө ер ойлгохгүй болжээ. Боорчи гэнэт өөрийн хөвүүнийг зарласан нь ингэж шаналах үндэс болсон гэдэгт итгэхийг хүссэнгүй. Боорчийг түүнтэй булаацалдах хүн гэнэт гарч ирсэнд Чингис хаан ихэд цочирдсон билээ. Үүнээс өмнө Боорчийг ер хүн биш юм шиг, үр хүүхэд, ар гэргүй мэт сэтгэж, зарж сурсан сэтгэлд нь одоо тэр өөрийн хөвүүнийг хайрлана, хөвүүнийхээ төлөө санаа зовон зүтгэнэ гэж бодохоор Боорчи дахин түүнд эргэж ирэхгүй одох мэт хачин бодол төрөх болжээ. Бас энэ олон жилийн хугацаанд Боорчи ингэж таг дуугүй

явсан мөртөө гэнэт Сүбээдэйн зүг одохын өмнө өөрийн хөвүүн гэж нэг цэргийг зарласан нь цаанаа сэжигтэй санагдаад болсонгүй. Гэвч одоо түүнд энэ тухай хэлж зөвлөх хүн даанч байсангүй. Шихихутагийн хэлснээр Гэрэгийг Найманы нутгаас Боорчи өөрөө олсон нь үнэн ажээ. Харин түүний төрсөн үр гэдгийг хэн ч баталсангүй гэж Шихихутаг хэлжээ. Боорчийг явуулах болсон нь гарцаагүй хэрэг болохоор яах ч арга байсангүй. Боорчийг явмагц хэн ч түүнийг хамгаалахгүй юм шиг хар төрсөн нь улам гүнзгийрчээ.

Бас Боорчи, Зүчийн адил хэзээ ч эргэж ирэхгүйгээр түүнийг хаян одох мэт санагдаад уур хилэн нь гэнэ гэнэ оволзоно. Чингис хаан өөрийн сэтгэл санаанд гарсан гүн өөрчлөлтийг анзаарч мэдэхгүй байжээ. Чингис хаан агуу их нэр сүрийнхээ буулган дор ядарч, хязгааргүй их ганцаардалд автсанаа даанч ойлгосонгүй. Ойлгох ч аргагүй болжээ.

### *ИЙСҮС ХРИСТИЙН ЭЛЧ*

Сүбээдэйн илгээсэн элчийн зааснаар Перваны хөндийгөөс хойш Каспийн тэнгисийн баруун талаар өгсөн Боорчийн явах зам тодорхой болжээ. Дайн хийж ойр зуурын хотуудыг эзлэн тулалдаж явахад туулсан замын урт, эзэлсэн газрын уудмыг тэр бүрий анзаардаггүй ажээ. Харин одоо явах болтол Хорезм гэгч хичнээн том улсыг эзлэн буулгаж авснаа Чингис хаан ч, Боорчи ч ойлгох шиг болжээ.

Чингис хааны цэрэг нутгаас гарсаар 1223 оны эцэс гэхэд зүүн хойт талаараа Сыр дарья мөрөн, зүүн өмнөд талаараа Инд мөрөн, хойт талаараа Арал болоод Каспийн тэнгис, баруун хойт талаараа Азарбайжан, баруун талаараа Багдадын халифат улс, өмнөд талаар Энэтхэгийн далайд хүрсэн уудам их нутгийг эзлэн авсан байлаа. Монгол болоод Хорезмын хооронд орших Хар кидан, Уйгар, Харлаг улсууд нэгэнт Чингис хаанд дагаар орсон тул одоо Их монгол улсын нутаг дэвсгэр Хятадын зүүн далайгаас Газар дундын тэнгис хүрч, Шар мөрнөөс хойш Сибирийн их хөвч хүртэл тэлжээ.

Харин одоо Зүчийн цэрэг Каспийн тэнгисийн зүүн талаар Сүбээдэйн цэрэг баруун талаар нь хойш давшиж Урал, Динээпэр, Ижил мөрний хоорондох үржил шимт уужим их талд амьдран суугч Асу, Сасу, Болгар, Орос, Мэжигэд, Мажар, Хивчаг, Ханлин, Кивамен зэрэг аймаг улсуудыг эзлэн авахаар урагшилж байв. Шуурга мэт давшиж яваа Сүбээдэйн цэргийг гүйцэхийн тулд Боорчид даруй хэд дахин түргэн явах хэрэг тулгарчээ. Үүний тулд зам зуур тохиох эзлэгдсэн хотуудад хамгаалан сууж үлдсэн монгол цэргийн ноёдод урьдчилан элч илгээж бэлтгүүлэв. Хот болгонд Боорчийн цэрэгт шаардлагатай агт сайн морь,хоол хүнс бусад зүйлийг бэлэн болгох зарлиг хүргүүлжээ.

Ийм бэлтгэл хангагдах хүртэл Боорчид хийж гүйцэтгэх ажил олон үлдээд байлаа. Тэр юуны өмнө Чингис хааны нэгэн гайхалтай зарлигийг гүйцэлдүүлэх хэрэгтэй болжээ. Барыгжан уулын нэрийг өөрчлөн түүнийг Тэнгэр уул хэмээн нэрлэж, оргилд нь хүн гарахыг цаазалсан зарлиг Чингис хаан буулгасныг даруй олон түмэнд зарлан тунхаглаад байлаа. Харин Боорчид нууцаар зарлиг болгосон ёсоор мөнөөх Иш-Химамын урласан оньсон шатыг шатаах болжээ. Уг нь Боорчи энэ шатыг үгүй болгохыг хүсээгүй билээ. Учир нь энэ шат бол Иш-Химам гэгч үнэн сэтгэлт уран дарханы бүтээсэн гайхамшигтай хараад ханамгүй бүтээл юм. Чингис хаан гэнэт ийм хачирхалтай зарлиг буулгасныг Боорчи гайхан эгдүүцсэн ч түүнээ ил гарган мэдэгдсэнгүй. Иш-Химам Чингис хааны зарлигаар Монголын тал нутагт их хот барихаар

явах болоод хот барих ажлын дадлагатай урчуудыг цуглуулан бэлтгэж байгаа билээ. Нэгэнт Чингис хаан зарлиг болгосон тул Иш-Химамыг дуудан авчирч энэ тухай хэлэхээс өөр арга Боорчид байсангүй. Хэл чимээгүй шатааж болох байсан ч Боорчи яагаад ч юм тэгэж чадсангүй. Харин Чингис хааны эл зарлигийг сонсоод номхон дөлгөөн зантай тэр уран дарханы хэрхэн цочирдон хэлмэгдэхийг Боорчи гадарлаж байлаа. Иш-Химам бол үнэнч шударга зантайн дээр Чингис хаанд тоогдсондоо хөл нь газар хүрэхгүй хөөрч байсан тул Боорчийн дээрх үг газар цөмөрч галав юүлсэнтэй адил сонсогджээ. Тэнгэр уулын оройг хүртэл босгосон тэр оньсон шат бол Иш-Химам энэ яваа насандаа дахиад хэзээ ч барьж босгож чадахгүй, бас түүний бодсоноор өөр хэн ч бүтээж чадахгүй тийм мөнхийн бүтээл юм. Чингис хаан зарлиг буулгаж, Хорезмын бүх урчуудыг нэгэн дор цуглуулж Иш-Химамд тушаагаагүй бол өөр хэн ч ийм шатыг урлана гэж сэтгэхгүй байсан гэж бодох учир хичнээн түмэн гэмгүй хүмүүсийн алж, төрөлх улсыг нь үнсэн товрог болгон түйвээн сөнөөсөн Чингис хааныг сэтгэлдээ өршөөн хэлтрүүлээд зогсохгүй бүр шүтэн бишрэх болсон билээ. Хэзээ ч, хэн ч сэтгэж урлаагүй ийм аварга шат хийх санааг өдөөж барьж босгох хөрөнгө хүчийг хайргүй зориулсан Чингис хаан бол Иш-Химамын хувьд Аллах тэнгэрээс дутахгүй агуу их хүчтэн, ариун дээд явдалтан болжээ. Хэрэв Чингис хаан байгаагүй бол ийм аварга том, энэ ертөнцийн хамгийн өндөр шатыг хэн ч хэзээ ч дархлахгүй байсан билээ. Гэтэл одоо өөрийнх нь оюун ухаан ур чадлаар бүтээгдсэн энэ гайхамшигийг шатаах гэдэг юу гэсэн үг болохыг Иш-Химам ойлгож мэдэрмэгц Боорчийн өлмийд ухаангүй мэт унажээ. Өөрөө зарлиг буулгаж бүтээлгэчихээд дараа нь түүнээ устгах зарлиг буулгасан Чингис хааны ухааныг Иш-Химам ойлгож чадсангүй. Иш-Химам бүү хэл дэргэд нь шадарлаж бүх насаараа зүтгэсэн Боорчи ч ойлгохгүй байгаагаа чин үнэнээр өчжээ. Чингис хааны энэ зарлигийг зөв гэж бодохгүй байгаагаа Боорчи Иш-Химамаас нуусангүй. Уран дархан хүнийг монголчууд угаас хүндлэн үздэг тул эзлэн авсан улс орноос ийм хүмүүсийг юуны түрүүнд олзлон авч ашигладаг тэр л ёсоор Боорчи, Иш-Химамд хүндэтгэлтэй хандаж байлаа. Бас Иш-Химамын хагас жил хүрэхгүйн дотор удирдан барьж босгосон тэр өндөр шат бол үзсэн хүн гайхаж, үзээгүй хүн сонсовч итгэмгүй гайхамшиг болохыг Боорчи эрхгүй хүлээн зөвшөөрч бас тэр шатаар гарч Тэнгэр уулын оройд гарснаа хувь зохиол гэж бодох билээ.

-Би өөрийн биеэр Чингис хаанд бараалхаж учирлан гуйя гэж Иш-Химам гуйжээ. Харин Боорчи энэ талаар Чингис хаанд дахин илтгэх санаагүй байсан болохоор зөвшөөрсөнгүй.

-Иш-Химам чи нулимс урсган бүү бухимд. Чингис хаан чамд монголын тал нутагт их хот цогцлоон босгох зарлиг буулгасан биш үү. Чи ийм өчүүхэн зүйлд харамсах явдалгүй. Чи Чингис хааны зарлигаар энэ байтугай гайхамшигийг бүтээх болно. Чингис хаан нэгэнт л ингэж шийдсэн бол илүү үг зарж түүнийг бүү хилэгнүүл. Чиний хар толгойд хор болж мэднэ. Би чамд сайн санах тул үүнийг хэлж байна гэж Боорчийн ухуулсныг Иш-Химам аргагүй зөвшөөрчээ. Үнэхээр Чингис хаан ингэж шийдсэн бол хэн ч өөрчилж чалахгүй биз ээ. Гэвч Аллах тэнгэртээ хандан гуйж аврал хүсэхээр Иш-Химам шийджээ. Бүтээсэн шатнаас хагацах хүсэл түүнд байсангүй.

-Шатыг хэзээ шатаах вэ гэж Иш-Химам арга барагдан асуув.

-Иш-Химам. Чи тэр шатыг шатаж үнс болохыг үзэх гэж юунд хүснэ. Чи даруй монголын зүг мордогтүн. Би чамайг явмагц шатыг шатаая гэж Боорчи түүнийг өрөвдөн хэлжээ.

-Боорч сайд аа. Би танаас нэг зүйл гуйя. Та зөвшөөрөөч.

Иш-Химамыг яльгай зүйл гуйхгүй гэж Боорчи санасан тул толгой дохив.

-Хэлэгтүн

-Боорчи сайдаа. Би өөрийн хийсэн шатаар дахин нэг өгсөж Тэнгэр уулын оройд гарвал болох болов уу.

Боорчи үүнийг сонсоод тэр дороо зөвшөөрч чадсангүй. Учир нь Чингис хаан морилж Тэнгэртэй ярьсаны дараа тэр уулын оройд дахин хүн гарахыг цаазалсан тул Иш-Химамын хүсэлтийг зөвшөөрч болохгүй байлаа.

-Боорчи сайд аа. Та намайг гарав гэж Чингис хаанд айлтгахын хэрэггүй биз. Одоо тэр шатыг нэгэнт шатаах тул дахин хэнд ч хэрэггүй болжээ. Харин би өөрийнхөө шатаар дахин нэг өгсөхийг хүснэ. Хожим хойно энэ гайхамшигт шатаар Иш-Химам гэгч дархан хамгийн сүүлчийн удаа гарчээ гэж хүмүүс дурсан ярьж байгаасай гэж хүсч байна гэж Иш-Химам, Боорчийг эргэлзэж байгааг мэдээд хэлжээ. Иш-Химамын энэ хүсэлд хортой зүйл үгүй тул Боорчи зөвшөөрөв.

-Чи тэгвэл хэзээ гарна гэвэл

-Та хэзээ шатыг шатаана. Тэр өдөр л гаръя гэж Иш-Химам

эргэлзсэнгүй хэлэв.

-За тэгвэл би хэлье.

-Би Боорчи сайд танд гүнээ талархаж байна гэж Иш-Химам сахлаа дахин дахин илбэн бөхөлзөх нь ихэд баярласныг илтгэнэ. Боорчи ч энэ гэмгүй, зүтгэлтэй уран дарханыг баярлуулсандаа сэтгэл хангалуун байлаа.

Иш-Химамыг гарч одсоны дараа Чингис хааны элч ирэв. Чингис хаан түүнийг өргөөндөө дууджээ. Яаран очвол их өргөөний гадна тойрогт огт үзээгүй хийцийн төмөр дугуйт сүйх, өндөр хөлтэй урт хүзүүтэй олон сайхан агт, хар хувцас нөмгөн өмссөн загалмайтны шашны лам, хэд гурван хүн ирсэн харагджээ. Их өргөөнд орвол Чингис хаанаас гадна бичгийн түшмэл Елюй-Чуцай, Шихихутагийн хамт сууж байлаа. Гаднаас зочин ирсний учир түүнийг дуудуулсныг Боорчи таамаглажээ.

-Энэ элээ шиг нэвсгэр амьтад чинь юун улс хаанаас гараад ирэв гэж Боорчи эрээлэх юмгүй шууд асуув. Түүний энэ задгай үгэнд Чингис хаан инээмсэглэж нөгөө хоёр нь дуугарсангүй.

-Рим хэмээх улсын их ламтны элч надад бараалхах гэж ирээд хэрхэхийг зөвлөх гэж Боорчи чамайг дуудсан юм гэж Чингис хаан хэлэв.

-Их сайхан агттай юм. Тэр Рим гэдэг улс чинь эндээс хир хол юм бэ дээ гэсэн Боорчийн үгэнд “Очоод эзлээд авчихвал яасан юм бэ” гэсэн омогтой санаа тод илрэнэ.

-Рим хэмээгч улс нь эндээс баруун зүгт байх Газар дундын тэнгисийн хойг дээр оршигч улс юм. Мянган жилийн өмнө Римчүүд энэ газрыг бүхэлд нь эзлэсэн хүчирхэг гүрэн байсан гэнэ. Харин монголчуудын өвөг дээдэс Хүннү гүрний хаад довтлон ирж тэр Римийн их улсыг мөхөөжээ. Одоо энэ Рим загалмайн шашныг шүтэн суугч жижиг улс болсон гэнэ. Харин тэр шовх оройтой сүмд мөргөгч загалмайн шашин бол хуучин Римийн их гүрний эзэлж байсан бүх нутаг оронд шүтдэг шашин болжээ. Загалмайн шашны лам нар цэрэг цуухгүй ч их эрх мэдэлтэй, олон улсын жолоог өөрийн шашны нөлөөнд барьдаг гэжээ. Тийм болохоор энэ хар хувцаст лам нарыг төрийн элч гэж үзэх нь зүйтэй гэж Елюй-Чуцай үгээ зөөн хэлэв. Елюй-Чуцай гэгч энэ эр Алтан улсыг анхлан дайлахад Чингис хаанд сайн дураар дагаж ирсэн ордны түшмэл бичгийн хүн тул уншсан сонссон арвин бас аливааг давхар хорон санаагүй байгаагаар нь үнэлж цэгнэн шударгаар хэлэх тул ихэд үнэлэгдэн Чингис хааны ордны доторхи бичиг хэргийн их түшмэлд өргөмжлөгджээ.

Энэ удаад ч Елюй-Чуцайн үгийг бүгд анхааралтай сонсож Шихихутаг тэмдэглэн авчээ. Монголчуудын дээд өвөг Хүннү нарын их байлдан дагуулалт одоо нэгэнт домог болон хоцроод хүчирхэг Хүннү гүрнээс тоос ч үлдээгүй байхад түүнд дарагдан мөхсөн гэх Римчүүд өнөөг хүртэл оршин байсаар зогсохгүй, тэр хүннүчүүдийн үр удам болох их Чингис хаанд элч илгээсэн болохыг мэдэхэд хэнд ч сонин санагдах ажээ. Чингис хаан хэний ч байсан аливаа элчид их л хүндэтгэлтэй ханддаг бөгөөд одоо ч энэ байдлаараа сонсож мэдэхээс цаашгүй Рим гэгч улсын ламын элчийг төрийн элчийн ёсоор бараалхуулах зарлиг буулгав. Харин ингэхдээ Боорчийг байлцуулсан нь нэг талаас түүнд хүндэтгэл үзүүлсэн нөгөө талаас одоо Сүбээдэйн араас явах замд нь хэрэг болно гэж бодсоных байв. Чингис хаан ингэж өөрт нь ялимгүй ч болов хүндлэл үзүүлэх бүрт Боорчи баярлан бахаддаг байв. Чингис хаан ч Боорчийн сэтгэлийг ойлгоно. Ер нь Чингис хааныг Боорчи шиг, Боорчийг Чингис хаан шиг ойлгодог мэддэг хүн үгүй юм. Илүү дутуу олон үг ярьж ам уралдахгүй ч аливааг зөвлөхөд Боорчи дуугүй ч гэсэн сууж байвал гаргасан шийдвэр нь үнэн баттай болох шиг Чингис хаанд санагддаг билээ. Боорчи таг дуугүй суух нь зөвшөөрсний тэмдэг тул Боорчийг ингэж дуугүй сонсон суухад Чингис хаан туйлын дуртай байлаа. Харин Боорчи, Гэрэг хэмээх хөвүүнтэй болсноосоо хойш олон үгтэй, жаахан давилуун түрэмгий зантай болсныг хэн ч анзаарсангүй ажээ. Өөрийн зан аашинд гарсан энэ өөрчлөлтийг Боорчи ч мэдсэнгүй.

Эртний хүчирхэг түүхтэй Рим гэгч улсын элч ирсэн нь Чингис хааны сүр хүч Адриатын тэнгис хүртлэх үлдсэн бүх аймаг улсыг донслоон айлгасны тэмдэг байв. Дорно зүгээс гэнэт хуй салхи шиг довтлон ирээд лалын шашинтны нэгдсэн улс Хорезмыг дөрөвхөн жилийн дотор мөхөөн эзлэн авсан талын нүүдэлчин аймгийн тухай мэдээ салхи мэт тарж тэдний догшин түрэмгий авир, дайнч шийдэмгий төрхийг Хорезмоос зугатан очсон хүн бүхэн батлан ярьсаар Монголчуудын тухай одоо балчир хүүхэд ч сонсоод айхаар болжээ. Хэрмийн доторхи халуун ханзтай шавар чулуун оромжинд нүүхгүй сууж, гарахгүй амьдрагч суурин соёлтой иргэдэд морь унаж мод тохож газраас ургах мэт гэнэт тал талаас орилолдон гарч ирэх тэр аймшигт монголчууд яг л зэрлэг догшин амьтад, өлсгөлөн араатан мэт сэтгэгдэх ажээ. Ийм байдлыг баруун зүг цөмрөн довтолж байгаа Сүбээдэйн ялгуусан баатар цэрэг бүрэн харуулж байлаа.

Римийн их ламтны элч өрөөсөн хөмсөгтэй, этгээд царайтай Авраам Даяан гэгч ихийг үзэж дол цохисон, дал хол гарсан ч хөнгөн шаламгай еврэй гарлын энэ эр эхлээд Азарбайжаны Лилпур балгасыг эзлээд байсан Сүбээдэйтэй уулзсан ажээ. Алтан улстай хийсэн анхны дайнд

зүүн хөлийн өсгийгөө тас цавчуулж доголлон болсон Сүбээдэй төмөр хөө хуягаа хангинуулан хазганан алхах нь газар доргиж байх мэт бөгөөд элч нар ихэд сүрдсэн ч харин үзсэн зовсон нь их Даяан огт ажиггүй зогсжээ. Үнэхээр Авраам Даяан лам үхэж хүртэл үзсэн билээ. Тиймээс Чингис хааны догшин төрхт жанжин Сүбээдэйн өнгөн гаднах байдлаас айж сүрдсэнгүй, дагуул шавь нараа зоригжуулж зогсжээ. Харин ч энэ Сүбээдэй олон жилийн өмнө Тангудын Ашиг балгасын ойр анх учирсан монголоос тийм ч догшин сүрлэг үзэгдсэнгүй билээ. Сүбээдэй баруун зүгийн олон хот балгасыг эзлэж энэ нутгийн хүн зоны аяг жаягийг мэдэх болсон тул Даяаны үгийг анхааран сонсоод тэр дор нь хариу өгчээ. Харин тэгэхдээ Чингис хаанд бараалхахын өмнө түүний шадар жанжин Боорчид бараалхахыг зөвлөжээ.

-Манай Рим улсын их ламтан монголчууд та нартай дайсагнах хүсэлгүй гэж элчийн хэлснийг сонсоод Сүбээдэй

-Энэ Рим улс хүртэл хэдий хир зайтай бол гэж уйгар хэлмэрчээс асуужээ.

-Одоо та бидний байгаа Лилпур балгасаас даруй мянга шахам бээрийн зайтай болов уу гэжээ.

-Тэгвэл миний цэрэг саадгүй явбал хоёр сарын дараа танай хотод хүрэх юм байна. Миний цэргийг очиход хаалгаа дэлгэн найртайгаар угтагтун. Тэр үед би эдний нөхөр, дайсан алин болохыг хэлье гэж Сүбээдэй ихээр инээжээ. Харин уйгар хэлмэрч Сүбээдэйн энэ үгийг яг ёсоор нь орчуулж чадсангүй билээ. Гэвч төмөр хувцаст, өрөөсөн нүдэт энэ доголлон монгол жанжин чухам юун тухай, юу гэж хэлснийг түүний дууны өнгө, нүдний харц, инээднээс нь Даяан төвөггүй ойлгосон ч огт ойлгоогүй, мэдээгүй царай гарган өнгөрөөжээ. Римийн их ламтны тагнуул, элч болж дорно зүгийн бараг бүх улсад зорчсон Даяан энэ байтугай их үгтэй хаан эзэнтэй уулзаж байсан тул Сүбээдэйн давилуун үгэнд гайхсангүй. Олсон өчүүхэн ялалтаа үүрдийнх мэт санах нь жирийн цэргийн удирдагчдын өвчин байдгийг тэр сайн мэдэх билээ. Сүбээдэй бол Даяаны нүүр тулан уулзсан хоёрдох монгол хүн юм. Учир нь Шар мөрнөөс хойш амьдран суугч нүүдэлчин аймгуудын нутгаар тэр очиж байсангүй. Очих хэрэг ч гарсангүй. Очсон элч нарын үгнээс сонсвол тийш зүглэх нь ер үхсэнтэй адил гэлцжээ. Тэр нүүдэлчдийг Даяан хээр билчих зэрлэг гөрөөсний адил үл тоомсорлон үздэг байжээ. Гэтэл өнөөх зэрлэг араатан мэт нүүдэлчдийг Тэмүжин гэгч нэгэн баатар эр нэгтгэн хурааж улс байгуулаад хэдхэн жилийн дотор ойрын хөрш, хүчирхэг Зүрчид, Тангуд, Уйгар, Харлаг, Кидан улсуудыг эзлэн дагуулсан сураг холын Римийн улсад дуулдсаар удаж, энэ нь тэдний сэтгэлд гайт Хүннүгийн сүнс сүүдрийг дахин амилуулжээ. Тэмүжиний толгойлсон монголчууд ингээд зогссонгүй бүр Каспийн тэнгис хүртэл довтлон ирээд лалын шашинтны Хорезм улсыг сөнөөсөн нь загалмайн шашинтнуудын хувьд хэдий сайшаалтай ч зуны тэнгэрээс цас унасантай адил цочмог санаандгүй явдал болжээ. Тийм учраас хүчирхэг дайсны өмнө хүлцэнгүй зогсох нь Даяаны цорын ганц зөв зам байв. Үүнээс гадна их ламтны өгсөн нууц даалгаврын чухлыг бодсон ч Монголчуудын гашуун үг, давилуун занг тэвчин өнгөрөөх ёстой байлаа. Тийм ч учраас Сүбээдэйн бардам их үгийг өчүүхэн жанжны хөөрүү омголон зангийн илрэл төдий хэрэг гэж үзжээ.

Даяан бол Римийн их ламтны шадруудаас дорно зүгийн шар арьстнуудыг хамгийн сайн мэдэх цөөн хүний нэг билээ. Тийм учраас хэний ч үл мэдэх Чингис хаантай уулзаж ирээдүйд тохиолдож мэдэх довтолгооноос улс болоод шашин соёлоо хамгаалан сэргийлэх арга замыг

хайх үүрэг түүнд тохоогджээ. Сүбээдэйн эзлэн аваад байсан Лилпур балгасаас Гүржийн Тифлис хотыг дайран Кавказын нурууг давж Афганы Перваны хөндийд суугаа Чингис хааны хээрийн өргөөнд ирэх хүртэл Сүбээдэйн шийтгэн олгосон алтан пайзыг үзүүлснээр Римийн ламтны элч нарт өчүүхэн ч саад учирсангүй тул Даяан нүүдэлчин монголчуудын энэ ухаанд багагүй биширчээ. Олон улс дамжсан холын аян замд дайран өнгөрөх боомт, хотуудын харуул хамгаалалтыг ингэж энгийн бөгөөд шуурхай зохион байгуулсныг тэр хаана ч үзсэнгүй тул ихэд гайхан бахаджээ. Сүбээдэйн өгсөн, дээр нь Чингис хааны зарлиг тамгыг сийлсэн тохой хирийн алтан пайзыг үзүүлмэгц тэдний явах замын бүх саад шалгалт хормын дотор үгүй болж байлаа. Бас өртөө улааг гавшгай зохион байгуулж тэдэнд бараг хоол идэх цаг гарахгүй шахам түргэнээр унааг нь юулж байсан нь харин ч төвөгтэй мэт санагджээ. Үнэхээр Монгол цэргийн түргэн гавшгай зохион байгуулалт, сахилга баттай байдал нь түүнийг ихэд бишрүүлжээ. Талын энэ нүүдэлчдийг тийм дорд үзэж болохгүй бололтойг Даяан ойлгож байлаа. Зам зуур Хорезмын хотуудын амьдрал сэргэж дайны түймэр утаа униар дарагдаж эхлэсэн нь илт байв. Тэр бүү хэл Чингис хаан урьдын хаадаас бага татвар тогтоож, хэн ч болов дуртай шашинаа шүтэхийг зөвшөөрсөнд хүмүүс харин ч талархалтай байгаа нь ажиглагджээ. Лалын шашинтны улсад загалмайн шашныг дэлгэрүүлэхийг зөвшөөрсөн нь Даяаныг юу юунаас илүүтэй гайхашруулжээ. Даяан Чингис хааны хээрийн хүрээнд хүрмэгц алтан пайзаа харуулын ахлагч Есөнтэй гэгчид үзүүлж Чингис хаанд бараалхах хүслээ илтгэжээ. Дахиад л өнөөх шидэт пайзныхаа хүчээр хүрээний дотогш саадгүй нэвтэрчээ. Тэднийг тусгай гэрт оруулж Елюй-Чуцай гэгч түшмэл ирж тэдний ирсэн хэргийн учрыг байцаан асуужээ. Харин Сүбээдэйн хэлснээр Боорчитой уулзаагүй нь өөрийн их ламтны нэр сүрийг өргөх гэсэн Даяаны их санаа байв. Тэр өөрийн их ламтныг Чингис хаанаас дээгүүрт бодсоор байлаа. Ер нь тэр дотроо Чингис хаан гэгч болон эдгээр монголчуудыг дорд үзсээр байсан бөгөөд ганцхан тэдний дэндүү зэрлэг догшин авиртайг сонссон тул дэмий ихэмсэглэн хайран амиа золиослохоос болгоомжлон тэвчиж явжээ. Түүнээс биш дорно зүгийн Алтан улс, Сүн улсын их хаадтай уулзаж хэрэг хэлцэж явсан түүнд энэ зэргийн нүүдэлчин омгийнхонд дорд үзэгдэн бөхөлзөх нь тэвчиж болшгүй хэрэг юм. Гэвч элч хүн очсон улсын ёсыг дагах нь хууль тул яалтай билээ.

Даяан уйгар хэлмэрчээ дагуулан Чингис хаанд бараалхахаар очив. Явах замд хиймэл бороо шир шир дусалж байсан нь дахиад л алмайруулав. Тэр амьдралдаа хиймэл бороо оруулахыг анх үзжээ. Гэвч ингэж бороо оруулж болохыг түүний үл тоомсорлогч нүүдэлчин Шихихутаг санаачилсныг харин мэдсэнгүй. Арван таван газрын хэл мэддэг, Хималайн их нурууны хойт урд талд оршигч бүх улс орныг нүхлэсэн Даяан нүүдэлчин аймгуудын их хаан Тэмүжиний алтан цацарт хөл тавих нь энэ ажээ. Тэр ороод нүд дастлаа юу ч дуугарсангүй. Бас хэтэрхий дор мэхийсэнгүй. Сурсан зангаар хормын дотор цацрын дотрох байдлыг гүйлгэн харж амжив. Чингис хаан цацрын хойморт Хорезмын султан Мухамедийн их алтан сэнтийд заларчээ. Хаана ч байхгүй уран хийцтэй энэ цул алтан сэнтийг Даяан таньж байв. Мухамед султан Самарканд дахь өргөөндөө энэ сэнтийдээ залраад түүнтэй ярилцаж байжээ. Тэр үед Даяан Египетийн баян худалдаачны дүрээр Хорезмд тагнуул хийж явсан билээ. Чингис хаан түүнд ер онцгой сэтгэгдэл төрүүлсэнгүй. Ядарч аяншсан царайтай буурал сахалтай тэр хүн нүүдэлчдийн догшин хаан гэхээсээ илүү Тангудын жирийн худалдаачны төрхтэй үзэгджээ. Даяан бусад хүний адил Чингис хааны тухай сураг ховоор санаандаа бий болгосон хий дүрд итгэж явснаа ойлгов. Чингис хааны баруун талд урт хар сахалтай өнөөх Елюй-Чуцай харин зүүн талд нь нэгэн үл танигч хүн суусныг Сүбээдэйн ярисан Боорчи гэгч биз гэж таажээ.

Үнэхээр Елюй-Чуцайн танилцуулснаар Боорчи сайд ажээ. Боорчийн дор бийр янтай зэхэн суусан идэрхэн эр нь Шихихутаг гэх ажээ. Елюй-Чуцай түүний тухай хаандаа танилцуулав бололтой хэдэн үг хэлээд Даяанд дохио өгөв. Чингис хааны ордны ёс дэглэм аливаа соёлтой улс гүрнийхээс хоцорч дор орох шинжгүйг тэр мэдээд өөрөө ч ёс алдахгүйг хичээжээ. Тийм ч учраас өөрийн ирсэн хэргийн учрыг уйгар хэлмэрчээрээ дамжуулан уламжилсанд Елюй-Чуцай алга дэлгэн өөрөөс арай дор суухыг урьжээ. Тансаг зандан ширээ зөөлөн олбогт сандал нь үзтэл дорно зүгийн гайхамшигт хийцтэй бөгөөд Зүрчидийн алтан улсын хааны ордны тавилгатай адил санагджээ. Елюй-Чуцай нэг зүйл хэлснийг хэлмэрчээс сонсвол ирсэн хэргийн учрыг Чингис хаанд айлтга гэсэн ажээ. Елюй-Чуцайн дууны өнгө хэдий зөөлөн намдуу ч өмнө уулзсан доголлон Сүбээдэйн дуутай адил түрэмгий шаардсан аястай байхыг Даяан мэдэрч өөрийн эрхгүй босож мэхийв. Ингэх нь хэдий доромжлолтой ч төрийн ёсыг дагах нь түүний үүрэг билээ.

-Манай Римийн эзэнт гүрэн бол энэ газрын хамгийн эртний агуу их түүхтэй улс юм. Мянга гаран жилийн тэртээ манай Рим энэ газрыг бүхэлд нь эзэлсэн их гүрэн байжээ. Тэр цагт танай монголчуудын дээд өвөг Хүннү гүрний хаан Атилла цэрэглэн нүүж ирээд манай Римийн эзэнт гүрнийг мөхөөв гэж түүх шаштирт тэмдэглэжээ. Гэвч Римийн их улс Атилла хааны хүчинд дарагдан сөнөсөнгүй. Өөрсдийн дотроо эв эвдрэлцэн эрх булаалдсанаас болж дарагджээ. Хэдий тийм ч тэр цагийн Хүннү гүрнээс зөвхөн нэр л үлдэв. Харин манай улс өнөөг хүртэл тогтносоор биднийг аврагч Ийсус Христийн ариун сургаал энэ гэзрын бүх улсыг нэгтгэн ивээн тэтгэсээр иржээ. Бид хэл угсаа ямар ч байсан Ертөнцийн эзний гэгээн сургаал, хэмжээлшгүй авралын дор амьдран суух ёстой юм. Манай их ламтан та нарыг ч мөн адил ертөнцийн эзний авралд багтаасай гэж хүсэх тул намайг элч болгон илгээлээ. Танай тал нутгийн Хэрэйд аймаг Ийсусын ариун сургаалийг дагаж Ертөнцийн эзний ивээлд багтаж байсныг би та бүхэнд сануулж байна гэж Даяан давилуун хэлээд хэлмэрчээ харжээ. Энэ бол түүний хэлэх үгийн оршил байв. Хэлмэрч түүний сая хэлснийг дамжуулсны хойно цацарт хэсэг зуур нам гүм болов. Анх удаа Чингис хааны үгийг сонсож ухааныг мэдэх цаг ирлээ. Нүүдэлчдийн хаан Тэмүжин гэгч энэ хүн чухам ямаршуухан ухаан санаатай эр бол гэхээс Даяан тэсч ядав. Хүний эхлэн хэлсэн хэдэн үгнээс ухаан санааных нь хэр хэмжээг мэдэж таньж чаддагтаа тэрээр туйлын ихээр бахархан бардамнадаг бөгөөд ингэж шинжихдээ хэзээ ч алдаж байсангүй гэж өөрийгөө дөвийлгөдөг билээ. Тийм учраас энэ бүдүүлэг зэрлэг нүүдэлчдийн хааныг ямар хүн болохыг мэдэх гэж яарчээ. Гэтэл бүх юм түүний санаснаар болсонгүй. Түүний үгийг хэлмэрчийн дамжуулсны хойно Чингис хааны зүүн талд суугч гэнэт дуугарсан нь арслан архирах мэт сонсогдсонд сая л түүнийг сайтар анхааран харжээ. Энэ бол Боорчи байв. Даяаны нүдэнд энэ нимгэн дээлтэй, үрчлээт царайтай эрийн зүүн чихний омогноос доогуур зурайх гүнзгий улаан сорви хамгийн түрүүнд тусжээ. Даяан түүнийг танив. Даяан бол үзсэн харснаа хэзээ ч андуурч мартдаггүй гаргууд ойтой хүн билээ. Тэр андуурсангүй. Одоо тэр хүний нүд хөмсөг нь ч сэтгэлд тодрон буув. Чингис хааны шадар сайд Боорчи гэгч энэ эр олон жилийн өмнө Тангуд улсын Ашиг балгасын ойр анх учирсан тэр хүн мөн мэт гэнэт санагдахад айх гайхах зэрэгцжээ. Гэвч одоо эртний тэр дурсамжид автан суух хором даанч байсангүй. Уйгар хэлмэрч Боорчийн хэлснийг орчуулжээ.

-Чиний тэр Ертөнцийн эзэн гэгч чинь хэн бэ. Танай улсын хаан юм уу. Тэр юун их нэртэй юм бэ.



Улаан сорвитын архирах мэт дуугарсан нь ингэж асуусан хэрэг байжээ. ”Би зүүдэлж байгаа биш биз” гэж Даяан бодож байсан ч Боорчийн асуулт дэндүү гэнэтийн, бас дэндүү болхи шулуун байсан нь түүнийг сандаргав. Энэ бол зэрлэг нүүдэлчин л асууж болох үг байлаа. ”Та нар Ертөнцийн эзнийг мэдэхгүй хаана явсан улс вэ” гэж сөргүүлэн асуумаар байсан ч тэвчив. Ийм бүдүүлэг, ийм ичгүүр сонжуургүй, аймшиггүй асуулт Даяан өмнө нь сонсож байсангүй. Бас талын зэрлэг нүүдэлчидтэй буруу ярьж эхлэснээ ч ойлгов. Монголчууд, хятадуудтай адил мэдэмхий нэрэлхүү биш болохыг ухаарав. Тэгээд Боорчид Ертөнцийн эзэн гэж хэн болохыг ойлгуулах гэж бодолхийлэв. Даяан хэзээ ч ийм гэнэтийн хэцүү асуултад хариулж байсангүй мэт санагджээ. Ер нь Ертөнцийн эзэн гэж хэн бэ гэж тэр өөрөөсөө ч асууж байсангүй.

-Ертөнцийн эзэн Ийсус Христос бол гэж Даяан сүмд цугласан сүсэгтнүүдийн өмнө хэлдэг үгээ хэлэх гэтэл Боорчи түүний үгийг таслан дахин архирав. Уйгар хэлмэрч даруй орчуулжээ.

-Чи Ертөнцийн эзэн гэж юун дэмий үг байн байн чалчина вэ. Энэ ертөнцөд ганцхан эзэн байх ёстой юм. Одоо чи Ертөнцийн эзэн их Чингис хааны өмнө зогсож байна. Хэрвээ чи их Чингис хаанаас өөр Ертөнцийн эзэн гэж өөрийгөө тооцогч байгааг мэдэх аваас түүнийгээ бидэнд зааж өгөгтүн. Бид даруй очиж эрэгчин эмэгчинээ үзэлцье. Чиний тэр эзэн лав үүнийг хүсэж чамайг явуулсан биз. Харин элчээ илгээж найрамдья гэснийг үзэхэд ялимгүй амьтан боллоотой. Гэвч сайхан сэтгэлээр элч илгээсэн аваас бид ад үзэх явдалгүй. Харин танай улс хүртэл эндээс хэдий хол байна.

Боорчи яг өнөө доголлон Сүбээдэйн адил үг хэлснийг Даяан сонсоод энэ хол газар бие, морио зовоон дэмий иржээ гэж ойлгов. Монголчууд үгсэн нэгдсэн мэт нэг зүйлийг хатуу шаардсан нь бүх газрыг нэгтгэн захирах явдал эдний ганц бодлого болохыг гэрчилнэ. Доголон Сүбээдэй өөрийн зоргоор дэмий чалчаагүйг мэдээд эдгээр нүүдэлчид ийм холын хатуу зорилготойд ихэд гайхжээ. Талын зэрлэг монголчуудыг шашин сурталдаа дагуулан авах гэсэн их ламтаны зарлиг хад мөргөн бутрах тэнгисийн ус адил бутран сарнихыг тэр өөрөө үзэв. Эдэнтэй илүү үг ярьж сөргөлдөх нь харин ч тэдэнд Римийг довлох санааг төрүүлэх аюултай болохыг Даяан ойлгов. Боорчийн ил шулуун үгэнд эсэргүүцэх буюу тайлбарлах хариу өгөх ямарч боломж түүнд үлдсэнгүй. Одоо түүнд зөвхөн элчийн нэрэн дор өөрийгөө хамгаалан авч гарахын тулд инээж бөхөлзөхөөс өөр зам үгүй болжээ.

Харин энэ бэрх байдлаас түүнийг Чингис хаан өөрөө аварсан нь гайхалтай хэрэг боллоо. Боорчи гэгч энэ мунхаг амьтан зөвхөн өөрийнхөө бодсоныг хэлсэн ажээ. Даяан дахин амьсгаа аван тайтгарав. Шашин нэгтнээ нүүдэлчдийн довтолгооноос авран сэргийлэх ариун үүргээ биелүүлэхийн төлөө бүхнийг тэвчих ёстойг нь Чингис хаан түүнд сануулах шиг санагджээ.

-Танай их ламтан чухам юуг хүснэ вэ гэж Чингис хаан зөөлхөн асуув. Чингис хааныг ийм аядуу нам дуутай гэж Даяан огт санаагүй тул түүний асуусныг эхлээд ойлгохгүй хэсэг тулгамдсан ч “Чингис хаан нь арай илүү ухаантай юм” гэж ихэмсэглэн боджээ. Гэвч энэ асуулт зөөлөн хэдий ч Боорчийнхтой адил хэцүү тулгасан асуулт байв.

-Хэл яриа, зүс царай ялгаагүй энэ газрын дээр амьдрагч хүмүүн бүр ертөнцийн эзний ивээл дор дайн самуунгүй амьдран суухыг манай их ламтан хүсдэг юм гэж Даяан тайван, сандарч тэвдсэн зүйлгүй сууж хариулав. Монголчуудаас хэн нь ч тэр дороо хариу хэлсэнгүй. Энэ нүүдэлчдийг одоо л нэг өөрийн үгэнд барьж авлаа хэмээн тэр баярласан билээ.

Монголчуудын чимээгүй болсон нь Чингис хааныхаа үг хэлэхийг хүлээсэн хэрэг байв. Тэд хэдий зэрлэг нүүдэлчид ч гэлээ ордны дэг ёсонд амархан, хурдан дассан нь илт байв. Энэ байдлыг үзээд Даяан өөрийн эрхгүй хүндэтгэх сэтгэгдэл төрж байжээ.

-Танай их ламтан ухаантай, сайхан сэтгэлтэй хүн бололтой. Түүний хүсэл надад таашаагдаж байна. Би дайн самууныг үл хүсэх учир энэ Хорезмд ирлээ. Хорезмын хаан Мухамед миний илгээсэн жирийн худалдаачдыг алсан тул би өөрийн эрхгүй их цэргээ хөдөлгөн ирж ял асуухаас өөр аргагүй болов. Миний сайхан сэтгэлд хэн ч бай, энэ Мухамед шиг бас түүнийг залгамжлан суусан Желаладдин шиг хандана, тэр үхдэл болж улсаа хураалгах болно. Миний улс баян, цэргийн хүч дийлдэшгүй. Надад бусдын газар нутаг, эд баялаг хэрэггүй. Би ганцхан энэ газар дээр дайн самуунгүй энх амгалан байхыг хүсч биеэ зовоож цэргээ хохироож явна. Хорезмын хаан Мухамед Аллах тэнгэрээ дуудсаар миний цэргийн өмнө мөхөж сүйрлээ. Аллах тэнгэр нь түүнд тусалсангүй. Та нар ч хар буруу санавал мөн үүний адил болох нь гарцаагүй. Миний их цэрэг довтлон орвол танай тэр ертөнцийн эзэн Иус чинь та нарыг авран хамгаална гэж чи санана уу. Чин үнэнээр нь хэлэгтүн гэж Чингис хаан асуухдаа ивээнгүйгээр инээмсэглэж байсан нь Даяаныг хариу олохгүй гэдгийг лавтай мэдэж байх шиг санагджээ. Чингис хаан өнөөдөр угаас туйлын баяр хөөртэй байжээ. Учир нь тэр Боорчийг Сүбээдэйн хойноос илгээхдээ хэлэх үгээ урд шөнө нь бодож олсон байжээ.

Харин Даяан Чингис хааны хэцүү бэрх асуултад хариулахын өмнө оюун ухаанаа хөвчлөн байж сайтар бодов. Түүнийг монголчууд шавдуулсангүйгээр барахгүй Елюй-Чуцай идээ зоогт урьсан нь түүнд бодох боломж олгосон ордны түшмэлийн нарийн арга болохыг мэдээд түүнд гүн талархлтай болжээ. Энэ монголчууд санаснаас тийм ч амар хоол биш болохыг Даяан перс газрын идээ будаа зооглож суухдаа бодож байв. Гэвч Елюй-Чуцай хоолой засаж түүнээс хааныхаа үгний хариуг нэхэв. Өөрийгөө ертөнцийн эзэнтэй эн тэнцүүд үзэх нүүдэлчдийн их эзэн Чингис хаантай үг хэлээ ололцох нь туйлын хэцүү, бүр боломжгүй хэрэг юм гэдгийг тэр одоо мэдэрч байлаа

-Манай их ламтаны хүсэл бол ертөнцийн эзний зарлиг юм. Ертөнцийн эзэн бидэнд амьдрах арга зааж өгсөн шигээ бас энх амар амьдрах аргыг зааж өгчээ.

Хэлмэрчийн дамжуулсныг сонсоод Боорчийн гар хөдөлж Даяаны үгийг тасалдуулсан нь тэр үг хэлэх зөвшөөрөл хаанаасаа хүссэн хэрэг юм. Харин Чингис хаан Боорчийн хэлэхийг сонсохыг хүсчээ.

-Ламын элч чи. Чингис хааны үгийг дутуу ойлгов уу. Эсвэл чи албаар зөрүүдлэн зүтгэнэ үү. Үгүй бол уйгар хэлмэрч чи буруу зөрүү үг хэлж элчийг төөрөгдүүлнэ үү. Наад элч чинь яагаад ингэж Ертөнцийн эзэн гэж байн байн давган чалчина вэ. Энэ Хорезмынхон өөрсдийн Аллах тэнгэрийг мөн л ертөнцийн эзэн гэж залбирч мөргөж гуйсаар бидэнд дарагдсан. Биширч шүтсэн иргэд албатаа хамгаалж эс чадвал хэн түүнийг Ертөнцийн эзэн гэж үзэх вэ. Хэрвээ наад ламын чинь хэлээд байгаа шиг Христос бил үү тэр эзэн нь тийм сүрхий хүчирхэг юм бол бидэнд түүнийгээ үзүүлэг. Бидэнтэй ирж хүчээ үзэг гэсэн биш үү. Үгүй бол түүнийг Ертөнцийн эзэн гэж бүү дуудагтүн. Манай Хэрэйд аймгийн Тоорил хан христийг шүтэж модон загалмай гэрийнхээ үүдэнд өлгөөд юу хожив. Газар дээр булш бунхан ч үгүй үхсэн. Тэгэхээр хар хувцаст чи Ертөнцийн эзэн гэж гарт үл баригдаж, нүдэнд үл үзэгдэх дэмий юм ярьж цагийг бүү бар. Харин танай улс манай Чингис хааныг дагаж ивээлд нь

багтвал бид танай улсыг хамгаалан авч жаргаан сууя. Би удахгүй Чингис хааны зарлигаар баруун зүг одно. Тэгэхдээ Сүбээдэй баатрын тэндээс цэрэг илгээн танай их ламтан чин үнэнээсээ найрамдъя гэсэн эсэхийг шалган үзье. Чи манай цэргийг газарчлан дагуулж яв гэж Боорчи сүртэй хэлсэнд уйгар хэлмэрч сүрдэн хормой чичрүүлж зогсжээ. Боорчийн энэ үг Елюй-Чуцайг баахан гайхашруулж харин Чингис хаанд таашаагдахыг Даяан анзаарчээ.

-Элч чи үнэхээр эв найрыг хүсч ирсэн бол өөрөө манай цэрэгт хотынхоо хэрмийн их хаалгыг дэлгэж өгөгтүн гэж Чингис хаан Боорчийн үгний дараа хэлжээ. Ийм гэнэн бөгөөд тэнэг, бас гэнэтийн шаардлагыг элч болж зарагдан элдэв хүмүүстэй нүүр тулж явахдаа тэр огт үзсэнгүй билээ. Энэ Чингис хаан өөрийгөө Ертөнцийн эзэн гэж үнэхээр итгэснээс зайлахгүй ажээ. Хаана байгаа Рим, хэзээ хүрэх монголын цэрэг билээ. Гэвч Чингис хааны үгэнд хариу хэлэхгүй байх эрх түүнд даанч байсангүй. Болдогсон бол тэр энэ ихэмсэг тэнэг нүүдэлчдийн цацрыг орхин одмоор санагдана.

-Манай улсын хил хүртэл хол зайтай. Тэгээд зам зуурын улс аймгийн эсэргүүцэл их тул Чингис хаан таны энэ зарлигийг түргэн зуур биелүүлэхэд хэцүү байх болов уу. Харин би даруй гэдрэг буцаж Чингис хаан таны энэ үгийг их ламтандаа уламжлан хариуг илгээе. Таны их цэрэг бидэнтэй найрамдахаар очих аваас бид лавтай хотынхоо хаалгыг дэлгэн угтах болно гэж Даяаны хэлснийг Чингис хаан сонсоод

-Элч чи бүү санаа зов. Бидэнд хол газар гэж үгүй. Гагцхүү элч чи миний цэргийг нутагтаа дагуулан очихоос айж буйг би харж байна. Энэ нь ч зөв биз. Их ламтандаа үнэнч зүтгэх сэтгэлийг чинь би үнэлж байна. Хожим нэг өдөр монгол цэрэг танай хотын дэргэд хүрээд танай их ламтаны үнэн үгийг сонсохоор асуух болно. Тэр цагт өнөөдрийн хэлсэн үгээ бүү мартаарай гэж их ламтандаа хэлэгтүн. Чиний үгийг их ламтаны үг гэж би ойлгов. Дараа уулзахад өнөөдрийн үгээ мартсан байвал харин ял асуух болно гэдгийг бас сануулагтүн

Энэ үгээр уулзалт гэнэт өндөрлөж Даяан Чингис хаанд бэлгээ гардуулах л үлдэв. Бэлгийг Чингис хаан өөрийн биеэр хүлээн аваагүй нь түүний улсыг, их ламтныг монголчууд хэрхэн үзэж байгаагийн илрэл байв. Сая бараалхаад хэлсэн түүний үг Чингис хаанд онцгой сэтгэгдэл төрүүлж чадаагүйг Даяан ойлгов. Их ламтаны бэлгийг Шихихутаг, Гэрэг гэгч залуу ноёны хамт хүлээн авчээ.

Аллах тэнгэр, Ийсус тэнгэр хоёрыг үл тоомсорлогч, өөрсдийгөө тэднээс дээгүүрт үзэгч Чингис хаан гэгчид бараалхаж, үгийг нь сонссон Даяан гайхах эгдүүцэх зэрэгцсээр байв. Хорвоогийн хэрэг явдал юутай хурднаа хувиран өөрчлөгдөнө вэ. Тангудын Ашиг балгасын ойр Прескучи нэрт хэрмэл худалдаачны дүрээр тагнуул хийж яваад хээрийн дээрэмчдэд баригдан хамаг бараагаа дээрэмдүүлсэн нь санагдав. Тэгэхэд Даяан үхэлтэй нүүр тулгарч Ийсус тэнгэрийн авралаар амьд үлдэв гэж итгэсээр өнөөг хүрсэн билээ. Гэтэл үхлээ хүлээн элсэнд булаатай хэвтэж байхад нь давхин ирээд элснээс сугалан авч аварсан улаан сорвит монгол эрийг чухам Ийсус тэнгэрийн элч гэж итгэн түүнд бишрэн өдөр алгасахгүй залбиран мөргөж ирсэн билээ. Амийг нь аварсных төлөө тэр Исус тэнгэрийн элчид сайн сайхныг хүссэн нь тоогүй байв. Гэтэл түүнийг аврагч Исус тэнгэрийн элч өнөөдөр Чингис хааны дэргэд шадарлан суухыг үзжээ. Бүр тэр Ийсус тэнгэрийн элчийг Чингис хааны их шадар сайд Боорчи гэдэг ажээ. Чингис хаантай хийсэн хүнд хүчир уулзалтынхаа сэтгэгдлээс Даяан алгуур салж тэр өнгөрсөн явдлыг сая л нэг санахтайгаа болов.

Энэ явдал одоогоос хориод жилийн өмнө 1205 оны хавар болсон ажээ. Найман улсыг мөхөөж иргэдийг нь хураан авсан Тэмүжин их цэргийн хамт Алтайн нурууны өвөрт өвөлжөөд хаваржиж байв. Хаврын урь орж эхэлсэн нэгэн өдөр Тэмүжин, Хасар, Боорчи, Зэлмэ нарын дунд нэгэн нууц яриа болсон нь Тангуд улсад цэргээ оруулж байдлыг туршин тагнах тухай байв. Тал нутгийн монгол аймгууд Тэмүжиний дор нэгдэж цэргийн хүч их болоод байсан нь дараагийн олз омгийг хаанаас эрэх вэ гэсэн далд хүслийг бүгдийн сэтгэлд сэм ургуулжээ. Цэргийн хүчээр булаан авахын амтанд тэд нэг мөсөн шунан дурлаад байсан нь яг л цусны амт мэдэрсэн араатны хүслийг ундрааж байлаа. Ийм үед цэргийн чадварыг шалган турших бас сургах нь зайлшгүй болжээ. Амьд хурга авчран бэлтрэгээ сургадаг чонын аргыг хэрэглэхээр Тэмүжин шийджээ. Одоо тал нутгийг хүрээлэн суугч суурин иргэдийн хот балгасыг эзлэн авах нь зайлшгүй байлаа. Гэвч тал газарт морин дээр сэлэм жад, нум сумаар дайтаж сурсан монгол цэрэгт шавар хэрмийг дайран эзлэх туршлага арга байсангүй. Сургаж заах чадвартан ч үгүй байв. Бас тэднийг яаж хамгаалж бэхлэн суудгийг ч үзсэн мэдсэн хүн ховор байлаа. Яг ийм зорилгыг хэрэгжүүлж, хурга шиг ноолж болох улс бол Тангуд гэж Тэмүжин нар үзжээ. Тангуд улсад хүрэхэд энэ Алтайн нуруунаас хамгийн дөт байлаа. Гэвч Тангудад их хүчээр шалтгаангүй довтлох нь бас галаар тоглох шиг аюултай хэрэг юм.

Тангудтай их дайн үүсгэвэл Алтан улс хүч хавсрах тул Тангудыг их хүчээр дайлах гэсэн зарим нөхдийн үг, хүслийг няцаахаас өөр аргагүй болжээ. Гэвч хэн хэнээ гомдоохгүй арга олсон нь хамгийн шилдэг мянган цэргийг шилэн авч Тангудын хойт талын хот балгасыг сэм довтлон туршихаар шийдсэн явдал байв. Энэ цэргийг Боорчи удирджээ. Хэрэйдийн Тоорил ханы хөвүүн Сэнгүм, Тангудын Ашиг балгасын хавиар тэнүүчлэн явааг эрж олох зорилготой гэж зар тараагаад Боорчийн цэргийг Тангудын хилийг давуулсан билээ. Энэ бол хуурамч зорилгоор халхавчлан харь улсад хийсэн Тэмүжиний анхны дайн байлаа. Яг ингэж явахдаа Сэнгүм нарт талагдсан хэдэн худалдаачидтай таарсан нь Даяан, түүний дагуулууд байжээ. Нүүр толгойг нь цухуйлган элсэнд булж орхих нь дээрэмчдийн хамгийн шилдэг хорон аллага билээ. Халуун наранд хатаж үхэх нь хамгийн бэрх тамлал юм. Харин аз болоход Боорчийг очиход Даяаны нүдийг шувуу арай ухчихаагүй байжээ. Цуг явсан хоёрын нь нүдийг аль эрт шувуу амьдаар нь орилуулан ухаж идэхийг Даяан үзжээ. Одоо түүний ээлж иржээ. Хар шувуу толгой дээр нь ирж суухад Даяан эцсийн хүчээ шавхан Ийсус тэнгэрээ дуудаж аврал энэрэл гуйжээ. Хар шувууны эвэр хошуу зүүн хөмсөгийг нь ханз татан авахад Даяан бараг ухаан алджээ. Ийсус тэнгэр түүний дууг сонссонгүй ажээ. Ийсус тэнгэрт итгэж явсан нь талаар болохыг гашуудан мэдрэх даанч гашуун байсансан. Гэвч цөхөрсөнгүй дуудсаар байв. Дараа нь юу болсныг Даяан яг л зүүдэлж байх шиг үзжээ. Хүзүү хоолойдоо аймшигт улаан сорвитой Ийсус тэнгэрийн элч хүрч ирээд түүнийг элснээс сугалан аварч амьдралыг эргүүлэн өгөөд хэрэг болгож нэрийг нь ч асуулгүй, ирсэн шигээ гэнэт алга болоход Даяан уйлан мөргөсөөр хоцорчээ. Ингэж Ийсус Христос түүний үнэнч зүтгэснийг нь үнэлэн аварч өршөөв гэж Даяан эргэлтгүй итгэсэн билээ. Хоёр нөхөр нь шувуунд нүдээ ухуулж азтай Даяан зүүн хөмсөггүй хоцорчээ. Харин сохорч үлдсэн хоёр нөхрөө Ашиг балгасын дэргэд эзгүй газар өөрөө хутгалан хороосон билээ. Үүнийг хэн ч үл мэднэ. Сохорсон тэднийг маллаж явах арга түүнд байсангүй. Тэднийг төөрч эсвэл ангаж тарчилж үхэх аюулаас гэтэлгэсэн гэж одоо ч өөрийгөө цагаатган бодсоор ажээ. Харин өнөөг хүртэл Ийсус тэнгэрийн элч гэж санаж явсан тэр улаан сорвит хүнтэй одоо уулзах, аварч өршөөсөнд нь талархах эсэхээ шийдэж чадахгүй эргэлзсээр байв. Улаан сорвитой тэр эрийг Ийсусын элч гэж итгэж явсан тул Боорчийг Чингис хааны их шадар сайд байсанд ихэд балмагджээ. Учир нь өнгөрсөн тэр явдал Авраам Даяаны сэтгэлд

дэндүү гүнзгий ул мөр үлдээсэн байв. Тэр үед Даяанд үхэхэд ердөө хэдхэн хором үлдсэн байсан билээ. Харсаар байтал хэдэн хар шувуу нисэн ирж хоёр нөхрийн нь толгой дээр суугаад нүдийг нь ухаж эхлэхэд тэдний аймшигтайгаар хашгирах одоо ч чихэнд нь сонсогдох ажээ. Тэд зүгээр л албат зарц, Ийбус тэнгэрт гүнзгий сүсэг бишрэлгүй хүмүүс байсан нь хар шувуунд нүдээ ухуулан тамлуулахад хүргэсэн хэмээн одоо ч тэр итгэх бүлгээ. Харин Даяан Ертөнцийн эзэн, аврагч тэнгэр Ийбус Христосыг зай завгүй дуудан мөргөж залбирал уншлагаа таслаагүй нь түүнийг амьдаараа нүдээ ухуулахаас аварчээ.

-Аврагч тэнгэр Ийбус минь. Үнэнч шавь намайг үхлээс авраач гэж гуйсаар байсанд нөхдийнх нь дөрвөн халуун нүдийг ухаж идээд нисэн ирж толгой дээр нь суумагц хөмсөгийг нь зулгаан идэж эхлэсэн шувууд гэнэт нисэн одоод бүрэлзсэн нүдэнд нь Тэнгэрээс морьтон баатар бууж ирэх нь үзэгджээ. Энэ бол Ийбус тэнгэрийн илгээсэн аврагч элч байв. Даяаны зүрхний цохилт удаашраад тэр үхэж байсан билээ. Харин энэ бүх явдал хойт насанд нь болж байна гэж боджээ. Ухаан балартсан түүнийг элснээс сугалан гаргахыг, булгийн цэнгэг ус цээжийг нь онгойлгон цутган орохыг мэдэж сэхээ оржээ. Өмнө нь аврагч Ийбус тэнгэрийн элч сууж байв. Зүүн чихний омогноос доош гүнзгий улаан сорвитой бас их зөөлхөн дулаан харцтай тэр хүн чухам амилсан Ийбус Христос шиг үзэгджээ. Даяаны цус, нулимс холилдон урсаж, Тэнгэрийн элчийн этэн хоншоорт гутлын өлмийгөөс адис авснаа л санадаг билээ. Ибус Христос амьд хүний эгэл дүрээр оршдог, зовж шаналсан шавь нараа үргэлж авран хамгаалж байдгийг Даяан ингэж өөрийн биеэр үзжээ. Түүнийг аварсан тэр Тэнгэрийн элч бол Ийбусын арван гурван шавийн нэг зоригт Шолом мөн болохыг сүүлд Римд ирсэн хойноо эртний судар үзэж байгаад Даяан гэнэт олж мэджээ. Зоригт Шолом яг тэр Тэнгэрийн элч шиг зүүн чихнийхээ омогноос доош гүнзгий улаан сорвитой байлаа. Аврагч Ийбусын элч Шолом өөрийн биеэр морилон ирж Тангудын цөлд учирсан гарцаагүй үхлээс аварсан тухай Даяаны бичсэн ном Ийбус Христосыг шүтэгчдийн дунд алдаршин тархаж аврагч Ийбусын тухай жинхэнэ үнэн магтаал болон дуурсагдсанаар барахгүй Даяан ч ертөнцийн эзний жинхэнэ үнэнч шавийн ёсоор нэрд гарч төдөлгүй Римийн их ламтанд шадарлан хамгийн алдартай номлогчийн хувиар шилэгдэн харийн оронд элчээр томилогдох болсон билээ. Тэр цагаас хойш Даяан Римийн хамгийн алдартай хүний нэг болсон юм. Аврагч Ийбус тэнгэр өөрийн үнэнч шавь зоригт Шоломыг илгээн түүнийг хамгаалан авснаар Даяан өөрийгөө Ертөнцийн эзний ивээлд багтан нэрд гаран тодорсон гэж чин үнэнээр итгэн биширч иржээ. Гэтэл өнөөдөр түүний чин үнэн бишрэлд хэзээч үл мартагдахаар гүн шингэсэн аврагч Ийбусын элч зоригт Шолом, Чингис хааны дэргэд шадарлан суухыг үзээд учраа олохоо болив. Үнэхээр сэтгэл санаагаа барьж, удирдан жолоодож сурсан хүний ёсоор элчийн журмыг бат сахин үг хэлэлцэж чаджээ. Есөнтэйн тушаалаар олгосон сэрүүн гэрт орж ганцаар үлдмэгцээ Даяан хөлгүй мэт сөхрөн унажээ. Түүний гайхашрал эргэлзээнд хязгаар байсангүй. Тээшээ ухаж, хэзээ ч орхилгүй нандигнан авч явдаг өөрийн дурсамж номлолоо гарган үзэв. Эхний нүүрэнд өөрийн гараар зурсан Ертөнцийн эзэн Ийбус тэнгэрийн элчийн зураг байдгийг айсан мэт нээжээ. Зургийг үзмэгц тэр гашуунаар эхэр татан хашгираад ухаан алдан унав. Тэр яах аргагүй Чингис хааны шадар сайд Боорчийн хөргийг зурсан байжээ. Түр зуур ухаан балартаад сэргэхдээ Авраам Даяан хэмжээлшгүй их айдаст автсан байв.

Чингис хааны болоод түүний шадар сайд Боорчийн хэтэрхий түрэмгий давилуун зан гэнэт аврагч Ийсустай холбоотой мэт санагдаад тэр ийнхүү үлэмж ихээр айн балмагджээ. Талын нүүдэлчдийн их хаан Тэмүжиний дэргэд аврагч Ийбусын элч зоригт Шолом өөрийн биеэр

заларч суугааг үзээд Даяаны ухаан ингэж самуурах нь аргагүй билээ. Тохиолдол биш үү гэж өөрийн самуурсан ухааныг цэгцлэхийг хүчлэн оролдсоор байвч хэт их итгэл бишрэл нь аврагч Ийсусын эсрэг сэтгэж чадахгүйд хүргэжээ. Залбирч мөргөсний нь бас итгэж биширсний нь хариуд элчээ илгээн үхлээс аварсан, өнөөг хүртэл амьдралыг нь хөтлөн зааж ухааруулан гэгээрүүлж байгаа аврагч Ийсуст итгэхгүй байхын арга даанч байсангүй. Итгэхгүй байна гэдэг өөрийн үзсэн амьдрал, итгэл үнэмшилээс урвана гэсэн үг байлаа.

Эцсийн эцэст Даяан өөрийн итгэл бишрэлд хөтлөгджээ. Энэ бол түүний төрсөн өдрийн төөрөг тавилан байжээ. Хээр талын зэрлэг бүдүүлэг нүүдэлчин аймгууд гэнэт хүчирхэгжин энэ хүртэл довлон ирж лалын шашинтны их улс Хорезмыг сөнөөн дарсан нь Ертөнцийн эзний хүсэл зарлигаар хийгдэж байгаа хэрэг гэж бодохоос өөр аргагүй мэт санагджээ. Тэгээд ч энэ зэрлэг бүдүүлэг нүүдэлчид аврагч Ийсусын ивээл дэмжлэгийг олохгүйгээр яахин ингэж баян хүчирхэг Хорезмыг сөнөөж чадах билээ. Харин ч Ертөнцийн эзэн өөрийн үнэнч шавь нараа хамгаалан энэ нүүдэлчдийн гараар буруу номтон лалын шашинтнуудыг даруулсан нь нэгэнт тодорхой санагджээ. Тийм ч учраас Чингис хааны дэргэд өөрийн үнэнч шавь зоригт Шоломыг илгээн суулгажээ хэмээн Даяан хэргийн цаад учрыг тайлан ойлгомогцоо чухам яагаад Чингис хаан Ертөнцийн эзний өмнөөс ярьж байсныг мэджээ. Чингис хаан энэ газар дэлхийн өөр өөр шашин сурталтай улс орнуудыг илбэн тохинуулж, эзлэн дагуулж байгаа нь Ертөнцийн эзэн Ийсус Христосын зарлиг болохыг ойлгов. Энэ тухай Ийсусын ариун сударт тов тодорхой өгүүлсэн байдгийг Даяан гэнэт ухаарчээ.

Бүхнийг аврагч Тэнгэр Ертөнцийн эзэн тэрбээр талын нүүдэлчдийн эзэн Тэмүжинг буруу номтнуудыг даруулахаар газарт илгээжээ. Ертөнцийн эзний их хүч ивээлийг олсон Чингис хааны өмнө лалын шашинтны улс Хорезм, Багдад, дараа нь Каспийн болоод Газар дундын тэнгисийн хойгуур орших улс аймгууд ээлж дараалан дарагдан мөхөх тавиланг Даяан одоо тод харж байлаа. Харин тэр өөрийгөө энэ ертөнцийн хамгийн азтай хүнд тооцов. Ертөнцийн эзэн үнэхээр түүнийг онцлон үзэж ивээлдээ багтаасанд дахин итгэв. Тэр Ертөнцийн эзний элчтэй хоёр дахиа уулзав. Ийм хүн загалмай шүтлэгтний дотор түүнээс өөр байхгүй гэдэгт тэр итгэлтэй байлаа.

Энэ бол түүнийг Римийн их ламтаны залгамжлагч байх ёстойг батлах мэт санагдах ажээ. Маргааш өглөө нь Авраам Даяан унтаад сэрэхдээ төрөл арилжсан байв. Тэр энэ мөчөөс эхлэн Ертөнцийн эзний элч Чингис хааны гэгээн үйлсэд мөнхөд зүтгэхээр шийдэв. Чингис хааны цэргийг Римд очиход найр тавин хэрмийн хаалгаа дэлгэн угтана гэж амлаад морджээ. Аврагч Ийсусын элч Боорчи түүнийг танисангүйд, бас үдэж өгсөнгүйд Даяан огтхон ч гомдсонгүйгээр барахгүй ингэх нь зүй ёсны хэрэг гэж боджээ. Энэ мөчид Ертөнцийн эзний элчтэй дахин учраад буцаж яваа Авраам Даяан шиг аз жаргалтай, зорилго итгэл төгс хүн газар дээр байхгүй байсан бизээ. Рим хүртэл нойр хоолгүй довтолгосон нь их ламтандаа Ертөнцийн эзний элчийн зарлигийг даруй хүргэхийн тулд юм. Ертөнцийн эзний элчтэй уулзаж Чингис хааны үнэн зорилгыг ухаарсан нь түүнийг дахин алдаршихын эхлэл болно гэж бодохоос даанч бахархалтай сайхан байжээ. Тэр одоо зуу биш, бүр хоёр зуу наслахыг хүсч байв.

Авраам Даяан хэмээх жүүд гаралтай, загалмайн шашны тэрхүү номлогчийг явсны маргааш шөнө лалын шашин, Аллах тэнгэрийг шүтэгч түрэг иран гаралтай уран дархан Иш-Химама

Боорчийн хамт Тэнгэр уулын зүг явж байлаа. Иш-Химамын сэтгэлд гүн өөрчлөлт гарсныг хэрэв өдөр байсан бол Боорчи анзаарч харах байлаа. Гэвч түнэр харанхуй шөнө бүх үнэн зүйлсийг халхлан нууж байжээ. Харин Боорчи маргааш нь Сүбээдэйн зүг морин цагт хөдлөхөөр бэлэн болжээ. Иш-Химамын бүтээсэн шатыг шатаамагц Боорчи Чингис хаанд бараалхан түүний сүүлчийн зарлиг захиасыг сонсох ажээ. Боорчийн сэтгэл тэнүүн өөдрөг байв. Түүнд гуних гутрах үндэс өчүүхэн ч байсангүй. Тэр маргааш шинэ газар орныг туулан явах гэж байхад баясан бахдахаас өөр яах билээ. Гэрэг хөвүүн нь гол цэргээ ачаа хөсгөө удирдан өглөө эрт замд гарсан байлаа. Гэрэг хөвүүнийхээ баяртай царайг хараад Боорчи амьдралдаа анх удаа эцэг хүний ёсоор жаргалтай болсон билээ. Энэ бол түүний хувьд урд өмнө эдлэж үзээгүй жаргал байлаа.

Шатыг шатаахад бэлтгэх зарлиг хүлээсэн Үүлэн черби аль эрт шатыг газрын тосоор нэвчүүлж бэлджээ. Одоо ганцхан гал хүргэх л үлдээд, Боорчи сайдыг хүлээж байв. Энэ өчүүхэн хэргийг заавал Боорчи өөрийн биеэр хүрэлцэн ирж харахын учрыг Үүлэн черби ойлгосонгүй билээ. Зам зуур Иш-Химам юу ч дуугарсангүйд Боорчи түүний сэтгэлийг ойлгох тул түүнийг зовоож дуугарсангүй явсаар шатны дэргэд иржээ. Үүлэн черби тэднийг угтан авахад яг шөнө дунд болж нүдгүй хар шөнө нөмөрчээ.”Энэ шатны дэргэд ирэхэд заавал саргүй шөнө таарах юм даа” гэж Боорчи боджээ. Шатны сүйхэнд суухын өмнө Иш-Химам нэг зүйл хэлэх гээд байгааг мэдсэн Боорчи баахан гайхаж Үүлэн чербиг холдохыг тушаав.

-Иш-Химам чи бүү ай. Би чамайг ер шатаачихгүй. Чи харин даруй эргэж ир. Чамайг бууж ирмэгц шатаамц гэж Боорчи түүнийг тайвшруулав. Яагаад ч юм бэ Боорчи өөрийгөө Иш-Химамын өмнө буруутай мэт санах болсон тул ингэж зөөлөн дуугарчээ. Бамбарын гэрэлд Иш-Химамын нүд гялалзаж амьсгаа нь давхацсан мэт ам нь ангалзаж байх нь үзэгджээ. Төлөв даруу энэ уран дарханыг ингэж үхэл үзсэн мэт догдлон чичирч байхыг Боорчи өмнө нь үзсэнгүй болохоор ихэд гайхжээ

-Боорчи сайдаа. Би танд гомдох санах зүйлгүй. Гэвч би дахин эргэж ирэхгүй. Би өөрийн бүтээсэн энэ шаттай хамт үүрд шатахыг хүснэ. Өөрийн бүтээсэн энэ шатыг үнс болон шатахыг би яавч өөрийн нүдээр харж чадахгүй. Үүний оронд үхсэн минь дээр юм. Үүний төлөө Аллах тэнгэр танай Чингис хааныг өршөөхгүй. Чингис хаан үйлдсэн нүглийнхээ хорыг өөрөө амсах болно. Би түүнийг Аллах тэнгэрт айлтгаж гэсгээн цээрлүүлэхийг хүсэхээр явлаа. Аллах тэнгэрээс илүү хүчтэн энэ газарт байхгүй гэдгийг би Чингис хаанд үзүүлнэ. Та миний энэ үгийг Чингис хаандаа айлтгагтун. Миний хэлэх үг дууслаа гээд Иш-химам толгой дээрээ хувинтай тос асгаад шатанд суужээ.

-Боорчи сайдаа. Хүрдийг эргүүл гэж цэргүүддээ тушаагтун гэж Иш-Химам хашгирчээ. Цэргүүд бэлэн байлаа. Боорчи энэ гэнэн тэнэг дарханы хөөрүү үгийг огт тоосонгүй хойш ухарч цэргүүдэд дохио өгөв. Хүрд чахран эргэж Иш-Химам харагдахгүй болов. Гэнэт Боорчийн эгдүү хөдөлж Үүлэн чербийн барьж байсан бамбарыг аваад шатанд хүргэв. Тосонд нэвчсэн шат дүрэлзэн асч гал дээш өгсөн төдөлгүй галд автсан Иш-Химам аймшигтайгаар хашгирах сонсогджээ. Гэвч Иш-Химам унаж ирсэнгүй.

-Иш-Химам. Чи эндүүрч. Чи тэр Аллах тэнгэртэйгээ хэзээ ч уулзаж чадахгүй гэж Боорчи хорсон шивнэжээ. Шат дөлөнд автан яг галт могой шиг үзэгдэнэ. Шат шөнөжингөө шатаж харин өглөө гэхэд уулын бэлд овоолсон үнс болон хоцорчээ. Харин уулын орой хүртэл элгэн

хадан дээр шатсан ормоор хар мөр үлдсэнийг хэзээ хойно болтол нутгийн иргэд Химамын зам гэж нэрлэсээр байхыг хэн ч таасангүй. Ингэж Иш-Химама гэгч уран дархан Аллах тэнгэртэй уулзаж Чингис хаантай заргалдсан эсэхийг хэн ч мэдэхгүй хоцорчээ.

Тэр шөнө Чингис хаан ордноосоо холдон явж шат хэрхэн шатахыг ойроос харсаар нойргүй хоножээ. Одоо бүх зүйл түүний хүссэнээр болж Тэнгэр уулын оройд хүний хөл нэгэнт хүрэхгүй болжээ. Өүлэн эх нь дэргэд байсан бол түүний хийснийг хараад лавтай сайшаан магтах байсан даа гэж яагаад ч юм бэ бодож байв. Учир нь Өүлэн эх нь түүнийг Тэнгэрээс харж байсан билээ. Харин Боорчи үүр цайсан хойно иржээ.

-Хаантан. Би морин цагт мордоно гэхээс өөр үг хэлсэнгүй. Боорчийн сэтгэл тавгүй болжээ. Гэмгүй дарханыг дэмий шатааж алсандаа тэр харамсаж байлаа. Гэвч үүнийгээ Чингис хаанд цухуйлгасангүй. Бас Иш-Химамын хэлсэн үгийг ч тас нуун өнгөрөөхөөр шийджээ. Элдэв тэнэг амьтдын үгийг сонсож Чингис хааныг чилээхийг хүссэнгүй. Бас тэр Аллах тэнгэрээс ч айсангүй.

-Сүбээдэй чамайг ирнэ гээд нүдээ хөхөртөл харуулдан суугаа биз. Боорчи чи замдаа бүү саат. Би чамайг мордмогц их цэргээ хөдөлгөн нутгийн зүг явна. Та нар Эрчис мөрний хөндийд биднийг гүйцэж очигтүн. Бид тэнд хүрээд та нарыг хүлээн өвөлжинө. Тэгээд хойтон зун гэхэд Монгол нутагтаа хүрнэ гэж Чингис хаан газрын зураг харж суугаад хэлжээ. Тэр үед Чингис хаан Боорчи хоёр задгай алтан асрын дор цайлж суужээ,

-За би хаан таны хэлснээр явья.Сүбээдэй Зэв нар ч ингэнэ биз.

-Би чамайг өөрийн биеэр үдэж өгнө. Хоюул өртөө газар хамт явья. Чи түүнээс цааш шувуу мэт нисэгтүн.

-Хаантан та ингэж биеэ чилээх хэрэг юу байх билээ.

-Боорчи чи хүлээ. Би морин дээр гарч хийморио сэргээх нь муу явдал биш шүү. Би морь унасангүй бараг сар боллоо гэхэд Боорчи дахин эсэргүүцсэнгүй. Чингис хаан зөвхөн морь унахын тулд түүнийг ингэж үдэж өгөх гээгүйг гадарласан ч Тэмүжинээр үдүүлэх нь туйлын бахархалтай хэрэг тул дуртай байжээ. Өртөө газар тааваар явахдаа Чингис хаан Боорчи хоёр чухам юу ярилцсаныг хээрийн салхинаас өөр хэн ч сонссонгүй. Чингис хааны хүсэл энэ байсан билээ.

Түүний хэлснийг ганц Боорчи л мэдэх ёстой гэж тэр олон хоногийн өмнө шийдсэн тул ингэж хэрэг болгон Боорчийг үджээ. Боорчийн цэрэг тоос манаруулан далд ортол Чингис хаан мориноос буулгүй харж зогсов. Одоо түүний сэтгэл тайвшран амрав. Дээд Тэнгэрээс түүнд хуваагдаж ирсэн ганц нөхөр Боорчи нь түүний хамгийн хэцүү зарлигийг биелүүлэхээр давхин одохыг тэр харж байлаа. Тэдний дээр Хорезмын халуун тэнгэр манарч монгол морьдын хөлөөр боссон тоос шавар хотын дээгүүр суунаглана. Боорчийн баг цэрэг морины амыг сул тавин давхиж явлаа. Дөчин хэдэн жилийн өмнө Боорчи, бие тулгар Бөртийг дагуулаад яг ингэж эргэж харалгүй давхиж явсан билээ.

Яг тэр үеийнхтэй адил одоо түүнд Чингис хааны хэцүү зарлигийг биелүүлэх л үлджээ.



Чингис хааны одоогийн зарлиг яг тэр эрт цагийнхтай адил Зүчийн тухай байлаа. Чингис хаан Боорчийг өөрийн биеэр үдэж өгсний нууц энэ билээ.

Боорчид одоо ухрах буцах зам үлдсэнгүй. Тийм боломжийг Чингис хаан түүнд үлдээсэнгүй. ”Есүхэйн Тэмүжин чи айхтар чоно юмдаа” гэж Боорчи морины давхил дунд инээмсэглэн бодож явжээ.

# ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

## ТЭМҮЖИН

### *ИХ УЛСЫН ДАЛД ЗОВЛОН*

Хорезм улсыг дайлан мөхөөсөн Чингис хааны их цэрэг арван хоёр цуваанд хуваагдан гурван тус газраар хоорондоо өртөө зай барин Монгол нутгаа зорин хөдөлжээ. Эзлэгдсэн хот, дагаар орсон улсуудад Их Монгол улсын хууль цаазыг сахиулах үүрэгтэй үлдэж буй цөөн цэргээс бусад нь ийнхүү Хэрлэн мөрний хөндийгөөс хөдөлснөөс хойш таван жил хагасын дараа эх нутгаа зорьжээ. Чингис хаан болоод түүний ойр шадрууд чухам аль цуваанд хаана явааг цөөхөн хүн мэдэх бөгөөд цэргийн цуваа буцах энэ нүсэр хэргийг ерөнхийд нь Өгөдэй удирдаж байв. Харин отгон хөвүүн Тулуйг хоёр сарын өмнө төв улс руу түрүүлэн илгээж их цэргийг угтан авах бүх бэлтгэлийг базаах зарлиг буулгажээ.

Тийм учраас их ялалт байгуулаад алс холоос буцан ирэх цэргүүдийг угтан авахад Монгол нутаг даяар баяр хөөр, бас уй гашуу дүүрэн бэлдэж байлаа. Хорезмын нутагт хийсэн аян дайны энэ жилүүдэд анх Монголоос гарсан цэргүүдийн тал илүү хувь нь хүний газарт ясаа тавьжээ. Сэрүүн агаарт тал нутагтаа очих энэ аяны хол зам анх харийн нутгийг эзлэн авахаар явж байснаас огт өөрөөс гадна хязгааргүй ихээр аяншиж ядарсан цэргүүдэд хэзээ ч барагдахгүй мэт урт удаан санагдана. Учир нь амьд үлдсэн азтай эдгээр цэргүүд нутгаа санан яарч догдлох нь хэмжээлшгүй болсон тул туулж өнгөрсөн уул ус хэвээр атал газар дэлхий сунаж буцах зам урт болсон мэт эцэс төгсгөлгүй униартах ажээ. Тэд нутаг ус, амраг садан, үр хүүхдээ зүүдлэн морин дээрээ зүүрмэглэж урт өдөр, ужиг холыг барж туулж явлаа. Их цэрэг хөдөлсөн өдрөөс хойш Чингис хаан хэнтэй ч юу ч ярьсангүй, сүйхнээсээ ч цухуйсангүй.

Түүний сүйхийг Үүлэн чербийн мянгат дөрвөн талаас нь хамгаалж явах бөгөөд Хорезмыг захиран үлдэх монгол цэргийн ноёд Отрар хотын дэргэд их цэргийг үдэх ёслол хийхээр цуглараад байгааг түүнд айлтгахад л Чингис хаан эрхгүй сүйхнээсээ бууж мориндоо морджээ. Зүчийн эзэмшилд байгаа нутгаас бусад эзлэн авсан бүхий л газрыг Чингис хаан Цагадайд өгсөн тул тэр одоо энд лалын шашинтны улсыг захиран үлдэхээр болжээ. Тийм учраас Цагадай Отрар хотын дэргэд өөрийн гурван түмэн монгол цэргээ жагсааж Чингис хааныг үдэн гаргахаар зогсож байлаа. Чингис хааныг дагуулуудын хамт давхин хүрч ирэхүй олон түмэн цэрэг уухайлан угтсанд нь энд цуглаад байсан хар, цагаан нөмрөгтэй лалын шашинтан хүмүүс ихэд цочин голдоо ортол айн сүрджээ. Салахын өмнө Чингис хаан, Цагадай хөвүүнийхээ хамт дуугүй удаан зогсов. Ингэж дуугүй зогсохыг үзэхэд эцэг хүү хоёр дахин уулзахгүй гэж бодсон мэт санагдах тул шадрууд нь ч зүрхлэн үг дуугарсангүй ажээ. Эзлэн авсан нутаг орныг захиран үлдэх нь ч, нутаг буцаж байгаа нь ч бүгд л сэтгэл санаа гүнзгий хямарч догдолсон нь илт бөгөөд хэлж ярихаа олж цөхөж байжээ. Олон жил аялан дайтаж сурсан монгол цэргүүд энэ их амгалан алгуур, бүр уйтгартай наазгай байдалд түргэн зуур дасан зохицож чадахгүй байлаа.

Харин Чингис хааны дуугүй зогссон нь Зүчээс болжээ. Монгол газрын зүг салж явахын өмнө ингэж дуугүй гунигт автан зогссон нь гаднаас харахад Цагадайтай хагацаж чадахгүй байгаа мэт боловч чухамдаа өнөөдрийг хүртэл Зүчийг ирнэ гэж хүлээсэн сэтгэлийн үр байв. Харин

Зүчи хэзээ ч эцэгтэйгээ уулзахгүй гэж шийджээ. Чингис хаан болоод монгол цэргийг эх нутгийн зүг үдэн гаргах ёслолд Зүчи өөрийн орноос хөвүүн Батыг, шадар Хунангийн хамт илгээснийг үзээд л энэ хүлээлтийн эцэс болов гэдгийг Чингис хаан ойлгов. Үүнээс болоод Чингис хаан урьд өмнө үзээгүй их гунигт автсан ч энэ байдлаа хүнд мэдэгдэхийг хүссэнгүй. Бас Сүбээдэйн зүг одсон Боорчи энд, түүний дэргэд байсангүй нь улам ч ганцаардуулж байлаа. Сүүлийн үес хэрэг явдал нэг л Чингис хааны санаснаар болохгүй байгаа нь түүнийг гуниглуулахаас илүүтэй түгшээх болжээ.

Үдэн гаргах ёслол удаан үргэлжилсэнгүй. Одоо монгол цэргүүд нутагтаа хүрэхэд морьдоо амраахаас өөр зогсох шалтаг үгүй болжээ. Тэдний дайлан эзлэх энэ удаагийн дайн нэгэнт дууссан учир эдүгээ зөвхөн гэр орондоо очоод амар амгалан амьдрах цаг ирсэн мэт санагдах боловч жилийн дараа юу болохыг урьдчилан тааж мэдэхийн аргагүй байлаа.

Хорезмыг эзлэн дагуулсан их цэрэг Монгол нутагтаа эргэн ирсний баяр хөөрийн дуулиан хараахан намжаагүй байтал Чингис хаан Тангуд улсыг дайлах зарлиг буулгаж цэрэг засах ажил дахин ундарчээ. Угаасаа Тангуд улсыг дайлах нь гарцаагүй байсан бөгөөд зургаан жилийн өмнө Чингис хаан Хорезмыг дайлахаар хөдлөхдөө Тангудын Буур хаанд элч илгээн цэрэг гаргахыг шаардахад тэрээр их үг хэлж хүлээн аваагүй нь Тангуд улсын мөхлийн шалтгаан болжээ. Тангуд улсыг дайлан мөхөөх нь гарцаагүй зөв хэмээн Чингис хааны шадрууд Их хуралдайн үеэр нэгэн дуугаар сайшаажээ. Учир нь Монголын их цэрэг Хорезмд байх хойгуур Тангуд улс өмнө нь дагаж орсон тангаргаа эвдэн Алтан улстай эвсэж Мухулайн эсрэг цэрэг хөдөлгөсөн нь бүр ч том шалтаг болов. Тангуд улсын мөхлийн цаг ийнхүү иржээ. Тангуд улсыг мөхөөх нь өмнө, дорно зүгт орших Зүрчид болоод Сүн улсад ч мөхлийн дохио өгсөн хэрэг байв. Чингис хааны ялан дийлэгч цэргийн өмнөөс ихээр эсэргүүцэн тэмцэх хүчтэй тийм улс гүрэн нэгэнт үгүй болсон мэт олон хүнд санагдах болжээ. Тийм учраас хүч чадал ихгүй Тангудыг биш, эртний өст Алтан улсыг эхлэн дайлахыг хүсэгчид олон байлаа.

Харин Тангуд улсыг яаран довтлох гарцаагүй өөр ямар шалтгаан Чингис хаанд байсныг тэр тодорхой тайлбарлан хэлсэнгүй тул хэн ч гадарласангүй. Тэгээд ч урьд өмнийн Тэмүжиний бүх ааш авир танихын аргагүй өөрчлөгдөөд залуу идэр үедээ эвийг хичээн бүхнийг сайтар ухуулан сэнхрүүлэхийг чармайдаг асан зангаас нь юу ч үлдээгүйг анзаарч мэдэх хүн энэ олон жилийн хугацаанд цөөхөн үлджээ. Тэр бүү хэл урьдын Тэмүжин эдүгээ өөрийгөө ч танихгүй, ойлгохгүй байх үе их болсон байлаа. Учир нь Чингис хааны их сүр хүч, эрх мэдлийн өмнө бүх хүн сөгдөн биширч Тэмүжин өөрөө ч үг дуугүй захирагдах болсон байлаа. Түүний үг сургаалийг Мөнх Тэнгэрийн зарлиг хэмээн олон бүгдээр үг дуугүй даган мөрдөх болжээ. Чухамдаа энэ л урьдын Тэмүжиний хувьд бий болсон өөрчлөлт, түүний сэтгэлийн жаргал зовлонгийн үндэс болж байв. Олон жилийн их тэмцлийн ялалт, ялагдлын дундаас олж хуримтлуулсан суу алдар, эрх мэдэл нь өсөхийн хэрээр сурсан дассанаараа чөлөөтэй амьдрах, бодох сэтгэх нь хумигдсаар ирснийг Чингис хаан гадарлаж байв.

Сэтгэлийн гүн дэх нууц шаналал, жирийн хүмүүний адил хүсэл мөрөөдөл нь хэвээр атал түүнийгээ өөрөөсөө ч болов нууж амьдрах нь түүний зовлон болон хувирчээ. Чингис хааныг олон бүгдээр шүтэн нэр сүр нь Тэнгэрийн адил өндөр болсон ч дайн самуунгүй тайван амьдрал эхэлмэгц л үй олон зовлон бэрхшээл урган гарахыг тэрээр үзэж эхлэв. Ингэж Чингис хаан болоод Тэмүжин гэгч хоёр хүн нэгэн биенд багтан өөр хоорондоо нэг эвлэж, нэг

зөрчилдөн амьдрах болжээ. Харин Чингис хааны нэгэн биенд ямархан зовлон шаналал байхыг жирийн хүн таахын аргагүй ажээ.

Угаас тэд Чингис хааныг энэ ертөнцийн хамгийн аз жаргалтай, эрх мэдэл, сүр хүч төгс хүн хэмээн тооцож байсан бизээ. Харин Чингис хаан болоод Тэмүжинд эргэцүүлэн бодох хийгээд эргэлзэж тээнэгэлзэлгүй эрс шийдэх зүйл мундахгүй байлаа.

Тангуд улсад их цэрэг оруулж эзлэн дагуулахад Чингис хаан өөрийн биеэр морилон төвөг чирэгдэл болох онцгой шалтгаан байсангүй бөгөөд ялангуяа Өгөдэй нас өндөр болсон эцгийгээ гэртээ амар тайван суухыг зөөлнөөр шаардаж Тангудыг дайлах хэргийг өөрөө удирдахыг хүсч байгаа нь илт байлаа. Ингэлээ гэж Өгөдэйг буруутган зэмлэх аргагүй бөгөөд ганцхан хөвүүдийн нь сэтгэл санаа ийм түргэнээр хувиран өөрчлөгдөж байгаа нь ойлгоход бэрх санагджээ. Харин Чингис хаан огт өөр бодолтой байлаа. Зургаан жил үргэлжилсэн баруун зүгийн аян дайнаас төрсөн нутагтаа эсэн мэнд, ялалтын сүр хүч дүүрэн эргэн ирэхэд хичнээн сайхан ч амар тайван суусан эхний сардаа л монголын амьдрал танигдахгүй өөрчлөгдсөнийг Чингис хаан мэдэрсэн билээ. Зөвхөн амьдрал өөрчлөгдөж баян чинээлэг болоод ч зогссонгүй. Эргэн тойрны бүх хүмүүс, Чингис хаан өөрөө ч өөрчлөгджээ. Улс гүрэн нь хаяа тэлж, сүр хүч нэмэгдэх тутам албат иргэдийн хүсэл зориг ч өөр болжээ.

Баруун зүүн зүгт газрын хязгаар болон оршигч хоёр их далайн хооронд хил хязгаар нь үргэлжилсэн энэ их улсыг нэгтгэн жолоодох гэдэг цэрэг засаж хот балгас эзлэхтэй зүйрлэшгүй бэрх болохыг сая нутагтаа ирсэн хойноо л сайтар ойлгож мэдэрчээ. Бас ямар их нутаг орныг нэгтгэн захирах болсноо ч ухаарав. Гэвч улс орон, үндэстэн ястан бүрээс шилэн авчирсан эрдэм төгс, үнэнч сэтгэлтэй шадар сайдууд нь энэ бүгдийг түүний хэлснээр гүйцэлдүүлэн их улсын амьдрал төлөвшин тогтнож нэгэн хууль цаазын буулган дор амьдарч сурч байгаа нь бахархалтай хэрэг байлаа. Харин Чингис хааны сэтгэл санаанд гарсан өөрчлөлтийг л хэн ч залж жолоодож, зааж зөвлөхгүй болжээ.

Мэдээ орсон цагаас эхлэн Чингис хааны амьдралд сэтгэл түгшээсэн хэцүү бэрх хэрэг доор доороос ундран гарсаар байсан ч тэдгээрийн дотроос Зүчи хөвүүний нь үхэл юутай ч зүйрлэшгүй эмгэнэлтэй гашуун байв. Хорезмоос хөдөлж хэдэн сар яваад дөнгөж Эрчис мөрний хөндийд ирж буугаад байтал Зүчийн үхлийн тухай мэдээ ирсэн нь Чингис хааныг тэгэж цочоон эмзэглүүлнэ гэж тэр даанч санасангүй билээ. Учир нь Чингис хаан чухам Зүчийг үхүүлэх л гэж Боорчийг сонгон илгээсэн юм. Гэтэл хүссэн юм хүзүүгээр татна гэдэг болоход бүх зүрх сэтгэл нь ингэж шаналан эмзэглэнэ гэж мэдсэнгүй. Зүчи өвчнөөр үхсэн нь Мөнх Тэнгэр түүний санааг гэнэт тааж мэдээд түүнд тусалсан хэрэг мэт санагдсан ч тэр хөвүүн үхсэн нь Чингис хааны сэтгэлд хязгааргүй их эмгэнэлээс гадна айдас, түгшүүр авчирчээ.

Зүчийн “Алтан ордон” хэмээх шинээр цогцлоосон хүрээнд Боорчийг очсоны дараахан энэ хэрэг болсныг илтгэсэн захидлыг Боорчийн өргөмөл хөвүүн Гэрэг Чингис хаанд гардуулжээ. Сүбээдэйн хүрээнд очиж уулзаад ирэх замдаа Каспийн тэнгисийн зүүн өмнөд талд байсан Зүчийн “Алтан ордон”-д Боорчи очжээ. Харин хэвтрийн хүнд өвчинд нэрвэгдсэн Зүчи, Чингис хааны их шадар сайд Боорчийг өөрийн биеэр босон хүндлэн угтаж чадсангүй ажээ. Их шадар сайд Боорчи гэнэт ирсэн нь Чингис хаан өөрийн биеэр морилсонтой нэгэн адил хэрэг байлаа.

Зүчитэй нүүр тулан уулзсангүйгээ Гэрэг Чингис хаанд өчжээ. Боорчийн захидал тун товчхон байв. “Зүчи хаан хүнд өвчний улмаас таалал төгсөж суурь нь эзгүйрэв. Чингис хаан таны олгосон их эрхийн дагуу Зүчи хааны хөвүүн Батыг эцгийнх нь суудалд түр өргөмжилж энд их гашуудал зарлав. Цаашид хэрхэхийг Чингис хаан та болгоох буй заа. Чингис хаан таны ууган хөвүүн Зүчи миний гар дээр амьсгал хураав” гэсэн байв. Энэ захидлыг уншмагц Чингис хааны дотор одоо Бөртөд юу гэх билээ гэсэн айдас хамгаас түрүүлэн төрсөн билээ.

Хүнд өвчинд нэрвэгдсэн гэдгээ илэрхийлж бичиг захидал илгээсээр байсан ч Чингис хаан Зүчид итгээгүй юм. Бас Зэлмийн хөвүүн Есөнтэйн хэлсэн үг Зүчийн цаад зорилгыг тодруулсан тул Есөнтэйд итгэхгүй байхын аргагүй байжээ. Есөнтэйг өөрийн дэргэд ирүүлж цэргийнхээ хэргийг эрхлүүлэхийг Зүчи хүсээд зогссонгүй түүгээр дамжуулан Үүлэн черби болон бусад шилдэг залуу жанжинуудыг өөрийн талд урвуулан оруулахыг шууд санаархан зориглож байгааг Есөнтэй, Чингис хаанд нуулгүй илтгэсэн билээ. Бас Сүбээдэй баатарыг өөрийн дэргэд шадарлуулан суулгахыг хүсч буйгаа Зүчи, Есөнтэйд хэлсэн байжээ. Зүчийн гаргасан энэ ухаан бол гайхалтай мэргэн шийдвэр байлаа. Хэрэв Зүчи ингэж өөрийн дэргэд хамгийн итгэлтэй, сэтгэл нэгтэй шадар нөхдөө цуглуулан эрдэм чадлыг нь хэрэглэж чадвал хэр баргийн хүнд дийлдэхгүй ухаан, хүчийг өөртөө хуримтлуулах нь гарцаагүй байв. Чухам Зүчи л ийм ухаан гаргаж чадахыг Чингис хаан сайн мэдэж байлаа.

Өвчинд нэрвэгдсэн мэт дүр үзүүлэн олныг мэхлээд Чингис хааны дэргэд байсан өөрийн санаа сэтгэл нэгтнүүдээ цуглуулж, дээрээс нь амьдралын ухаан, цэргийн эрдмийн хүүдий болсон Сүбээдэй зэрэг хөгшчүүлээр хавсруулан сэм аргаар, ар худрагаар нь өөрийн тусгаар улсаа байгуулах гэсэн Зүчийн зорилгыг Чингис хаан таамаглан ойлгоод Хорезмоос буцахаар шийдээд байснаа өөрийн эрхгүй хойшлуулсан билээ. Зүчийн энэ санаа бол Чингис хааны зовж байгуулсан их улсыг бутарган мөхөөх алсын аюул агуулж байгааг тааж мэдэхэд амар хялбар биш ч басхүү ивээн дэмжих аргагүй хэрэг байлаа. Гэтэл сэтгэлийн дотор Зүчийг буруутгаж үл чаджээ. Энэ нь нэг талаас Чингис хаан өөрийгөө Бөртэ болоод Зүчийн өмнө буруутай гэж бодсоор явсны илрэл байв. Хэрэв Зүчийн оронд өөрөө байсан бол огт эргэлзэхгүйгээр яг ийм алхам хийх байсан биз хэмээн Чингис хаан бодсон билээ. Энэ нь Зүчийн ухаан зоригийг хүндэтгэн биширдгийн илрэл юм. Зүчи бол Бөртийн хамгийн хайртай үр нь учир Чингис хаан эцсийн шийдвэр гаргаж чадахгүй удтал эргэлзжээ.

Зүчийн өөрийн биеэр зүтгэж байгуулсан гавьяаг санаж байсан нь саад болж байв. Хажуугаар нь Есөнтэйн үгэнд хатуу итгэх аргагүй мэт санагджээ. Бас энэ хэргийг олонд задалж хэн нэгэнтэй зөвлөж ярихаас эмээсэн билээ. Ингэх нь Чингис хааны болоод алтан ургийн нэр хүндэд туйлын хортой явдал болох нь гарцаагүй. Ганц тодорхой зүйл нь Зүчи түүний үг зарлигийг үл ойшоож өөрөө бүх хэргээ толгой даан шийдэх хүсэлтэй байгаа явдал байлаа. Чингээгүй бол Зүчи бүр Ургенчийн дэргэдээс цэргээ татан Цагадай Өгөдэй хоёрын хамт эргэж ирэх байв. Энэ үед түүний бие эв эрүүл, сав саруул байсан юм.

Зүчийн дэргэд байсаар буй Хунангийн нууцаар мэдээлж буйгаар сүүлийн нэг жилийн хугацаанд Зүчи гэнэт хэвтэрт ороод ан ав, цэрэг цуух гэж гарахгүй болсон тул Бат хөвүүн нь бүх хэргийг эцгийн заавраар ягштал удирдаж байгааг Чингис хаан мэдэж байлаа. Есөнтэйг өөрийн өсөх цагийн үнэнч нөхөр гэж үзээд Зүчи чин санаагаа хэлсэн бизээ. Харин Есөнтэй Зүчид биш Чингис хаанд үнэнч зүтгэхээр шийдэж Зүчийн чин зорилго хүслийг илчилсэн нь

түүнд үхлийн аюул учруулсан хэрэг болжээ. Зэлмэ эцгийнхээ үг сургаал, Чингис хааны алдар хүндийн нөлөөн дор хүмүүжсэн Есөнтэйг Зүчийн нууцыг хэлэв гэж буруутгах аргагүй юм. Харин ч төрийн эсрэг ийм ноцтой хэргийг нуух нь бүр ч байж болохгүй явдал гэж Чингис хаан үзсэн тул Есөнтэйг ихэд сайшаан үзэх болжээ. Чингис хааны үзэл бодлогыг хар нялхаасаа үзэж дагасан Есөнтэй, Зүчийг хар толгойдоо халтай хэрэг үүсгэснийг сонсмогц ойлгосон ч огтхон ч эсэргүүцэн шүүмжлэлгүйгээр түүний алсын бодол үнэн үгийг сонсчээ. Зүчи Есөнтөйд итгэжээ. Итгэхээс өөр арга ч байсангүй. Энэ л түүний алдаа байсан бөгөөд бусад бүх зүйлийг тэр зөв хийсэн байв.

Өөрийн хөвүүд нь, тэр дундаа Зүчи тусгаар улсаа байгуулахаар ингэж зориглон шийдсэн нь Чингис хааны хувьд хэзээ ч зөвшөөрч болохгүй бөгөөд чадахгүй тийм хэрэг билээ. Үүний өмнө Хасар яг ийм санаа гаргасан юм. Алтан улсын зүүн хойд нутгийг эзлэн сууж улмаар өөрийн тусгаар улсаа байгуулах хүслээ Хасар шууд тулгаж Чингис хааныг үл зөвшөөрсөн ч энэ хүслээ өөрийн хүчээр гүйцэлдүүлэхээр хатуу шийдсэнээ илэрхийлэхэд л байгуулсан их улсыг нь булаан авах, таслан хуваах үзэлтэн хаа нэгтэй ч бус, бүр дэргэд нь байж болохыг Чингис хаан анх үзэж итгэсэн билээ. Энэ бол яавч зөвшөөрч болохгүй, дэлгэрч хүчээ авбал түүний их улсыг мөхөөх аюул учруулах илэрхий хорон муу санаа тул Чингис хаан огтхон ч эргэлзэхгүйгээр Хасарыг үхүүлэхээр шийдсэн юм.

Үүнээс өөрөөр Хасарыг зогсоох, буцаах арга байсангүй. Хасар нэгэнт ингэж хатуу шийдсэн тул ухуулж яриад нэмэргүй, бас үхүүлэхгүй бол Хорезм улсад явсан хойгуур зөвхөн Алтан улс ч төдийгүй, хамгаалалтгүй шахам үлдэх Монголын төв улс ч Хасарын мэдлийнх болох аюул илэрхий мэт байв. Хасар ч яг ингэж хийнэ гэдэгт Чингис хаан итгэж, айж байв. Харин Хасар өөртөө хэт итгэж Чингис хаан түүний энэ зоримог бодол, хүсэлд яаж ч хандсан өөрийгөө зөвтгөж, хамгаалж чадна гэж боджээ. Бас Хорезмтай хийх их дайныг эхлэхийн өмнө ах нь түүнтэй илэрхий эвдрэлцэн муудалцахыг хүсэхгүй гэж тооцсон байлаа.

Хасарын зорилго тодорхой байв. Чингис хааны их цэрэг баруун зүг хөдөлмөгц Алтан улсад довлон орж Шар мөрнөөс зүүн хойших бүх нутгийг нэгтгэж, захиран суухыг тэр хүсжээ. Ингэх нь Есүхэй эцэг, Өүлэн эхийнхээ хүслийг биелүүлсэн хэрэг болно гэж Хасар үзэж байв. Хар багаас хүсэж шунаж тэмүүлсэн Хасарын ганц мөрөөдөл нь Алтан улсыг мөхөөж эцэг өвгөдийн өшөөг авах хэрэг байв. Энэ хүслийг нь Чингис хаан булаан авч өрсөн хэрэгжүүлэхийг хараад тэр яахин зүгээр сууж байж болох билээ. Хасарын энэ хүслийг биелүүлэхэд одоо хэн ч саад болж чадахгүй мэт байв. Чингис хаанд тэртэй тэргүй газар нутаг элбэг, баруун зүгийн олон улсыг дагуулан авахад л хангалттай гэж Хасар боджээ. Хасар өөрийн олсон хураасан харьяат албат, итгэлт нөхдийн хүчийг дайчилбал даруй зургаан түмэн шилдэг цэрэг гаргаж чадах байв.

Чингис хаанд өөрийн энэ санааг шууд тодорхой хэлэхэд тэрээр огт үг дуугарч чадахгүй суухыг үзээд Хасар дахин эргэлзэхгүй болжээ. Чингис хаан өөрийн хөвүүд, тэдний үр садыг л алтан ураг гэж үзэж Их Монгол улсын эрхийг бариулахаар зарлиг буулгасан нь Хасар Тэмүжин хоёрын хооронд байсан ах дүүгийн харилцаа, эрт багын аман тангаргийн эцсийн нарийн сэжмийг таслан хаясан бөгөөд энэ нь Хасарыг ингэж эрс шийдвэр гаргахад хүргэсэн билээ. Үүнээс өмнө Хасар аливаад хүлээцтэй тэвчээртэй байж түүний гавьяа зүтгэлийг Чингис хаан хэзээ нэгэн цагт шударгаар үнэлнэ гэж гэнэн зангаар итгэж явснаа

ойлгов. Бас байгуулсан улсын тал нь Хасар дүүгийнх юм гэж нэгэн цагт Өүлэн эхдээ хэлсэн түүний үгийг санаж байжээ. Гэтэл өөрийн Их Монгол улсыг алтан ургийн хөвүүддээ өвлүүлж Өгөдэйг хаан сууринд залгамжлуулан суулгах зарлиг буулгасан нь Чингис хаан түүнийг хууран мэхэлж байсныг нэгэнт гэрчилсэн билээ. Иймээс Хасар зориг гарган өөрийн хүчээр тэмцэж хөвүүддээ газар нутаг олж өвлүүлэхээс өөр зам үлдсэнгүй, үүнээс өөр зорилго ч байсангүй. Хөвүүд нь тэр нутаг усандаа түүнийг үүрд залгамжлан суугаасай гэж Хасар хүсч байв. Чухам ингээсэй гэж хүсэж Өүлэн эх нь Буянтай өвгөний домгийг ярьсан гэж Хасар итгэжээ.

Гэвч Хасарын хүсэл биелэх хувь байсангүй. Эргүнэ мөрний хөндий дахь өөрийн өргөөндөө зүв зүгээр унтаад л маргааш өглөө нь сэрээгүй билээ. Түүнтэй хамт тусгаар улс байгуулах хүсэл мөрөөдөл нь ч хамт үгүй болов. Наж могойн хор шингээсэн төө хэрийн хулсан зүүг Хасарын зүрхэнд зоож орхисныг хэн ч мэдсэнгүй өнгөрчээ. Учир нь Хасарын хавирганы завсраар шаасан зүүг сугалан авсан ором хэнд ч ажиглагдсангүй. Бүр хамгийн хянамгай сэргэлэн Борогчин хатан ч үзэж мэдсэнгүй өнгөрчээ. Хасарын гэнэт үхсэн учрыг мэрэглүүлж үзвэл Тэнгэрийн хорлол болжээ гэсэн нь хэл ам, сэжиг хардлага гарах үүдийг нэгэнт хаасан билээ.

Гэтэл Хасартай хамт төгсгөл болов гэж санаж явсан туурга тусгаар улс байгуулах хүсэл зорилго Зүчид халдварлаж бүр илэрхий болсон нь Чингис хаанд удаан бодох, уучилж өршөөх боломж олгосонгүй. Зүчийг өршөөж хэлтрүүлэх шалтгаан бодоод бодоод үгүй байв. Зүчи ямар ч их гавьяатан чадвартан, бүр Бөртийн хамгийн хайртай үр нь байлаа ч тэр нэгэнт Чингис хааны дайсан болжээ. Их улсыг байгуулахдаа ч яг хэн нэгэнд хувааж өгөх зорилго бодлого Чингис хаанд байгаагүй бөгөөд ерөөс энэ газрыг бүгдийг нэгтгэн суух нь тийм төвөгтэй хэрэг биш болох нь Хорезмыг эзлэн авснаар нотлогдоод байв. Бүгдийг нэг гарын дор ийнхүү нэгтгэн амирлуулж газар дээр зөвхөн ганц Их Монгол улсыг байгуулах нь Чингис хааны эцсийн зорилго тул Зүчийн энэ дураар сэтгэсэн хулгай хэргийг өршөөж болохгүйд хүргэв. Гэвч Зүчийн ард Бөртэ байх тул Чингис хаан нэг хэсэгтээ эргэлзэн тээнэгэлзэж, бас Зүчийг ухаарч өөрийн санаанаас ухрах биз гэж хүлээсэн нь түүний ийнхүү Перваны хөндийд бараг бүтэн жил шахам суух үндэс болжээ.

Гэтэл Зүчи, Эрчис мөрний хөндий болоод Эг, Идэр, Дэлгэрмөрөн, Шишгэд голоор нутаглаж байсан өөрийн албат иргэд, хатад, хүүхдүүдээ Каспийн тэнгис рүү, өөрийн ордон, шинэ эзэмшил нутагтаа нүүлгэж авчирснаар Чингис хааны эргэлзээ, итгэлийг нэг мөсөн үгүй болгожээ. Ийм учраас л тэр Боорчийг Сүбээдэй рүү илгээхээр шийдсэн билээ. Сүбээдэйн зүг илгээсэн нь Боорчийг тайвшруулах, Зүчийн хэргийг олноос нуух гэж Чингис хааны олон сарын турш бодож олсон далд санаа юм. Бас Зүчид их л сайнаар ханддаг Боорчи үг зарлигийг нь гэнэт эсэргүүцэж мэднэ гэж сэрэмжилсэн учир түүнийг Сүбээдэйтэй уулзуулахаар тийш илгээсэн мэт сэтгэгдэл төрөхөөр бүгдийг зохицуулж гол санаагаа нууцалж байлаа. Харин эцсийн үгээ Боорчийг үдэж өгөх замдаа хэлнэ гэж бодсон нь хамгийн зөв байв. Хэлэх үгээ ч бодож олжээ. Боорчи Чингис хааны үгийг сонсон дув дуугүй явж байв Тэдний үгийг одоо хэн ч сонсохгүй ажээ. Гэрэгийн торгон цэрэг дөрвөн талд нь ойр саахалтын зайтай хамгаалан бүсэлж явав.

-Боорчи.Чи бид өсөх цагаас өглөх нас хүртлээ тусгаарыг нэгтгэж,туургатныг хурааж Их

Монгол улсыг байгуулсан нь юуны төлөө билээ гэж Чингис хаан асуух шиг хэлээд төдөлгүй үүндээ өөрөө хариулжээ. Чингис хааны энэ үгийг сонсмогц түүнийг ингэж өөрийн биеэр үдэж яваагийн учрыг Боорчи сая л гадарлаж эхлэх шиг болжээ.

-Би энэ их газрыг өөрийн нэрийн дор нэгтгэн ард иргэдийг хэл язгуур ялгалгүй амар жимэр айван тайван амьдруулахыг хүснэ. Тэр уран дархан Иш-Химам, өнөө Римийн ламын элч Даяан ер нь хэн ч бай бүгдээр Чингис хаан намайг Ертөнцийн эзэн гэж дуудан хүндэтгэж, надад итгэх болжээ. Угаас дайн самуунгүй амар тайван нэгдэн амьдрах нь энэ газрын бүх хүний хүсэл юм. Энэ хүслийг Чингис хаан намайг биелүүл гэсэн нь Мөнх Тэнгэрийн зарлиг тул хэн ч байсан тэр дундаа Чингис хаан би ч зөрчих есгүй юм. Мөнх Тэнгэрийн зарлигийг биелүүлэн дагах нь миний амьдралын зорилго болно. Миний их зорилгыг эсэргүүцсэн бүгд үхсэн биш үү. Хасар ч хүртэл ингэхийг оролдоход үхэв. Харин одоо гээд Чингис хаан үгээ тасалсан нь Боорчийг хэрхэх нь вэ хэмээн ажигласных юм. Боорчи морины чихийг ширтэн дуугүй явж байв. Боорчийн энэ байдалд ямар нэг сэжигтэй зүйл үгүй тул Чингис хаан үгээ үргэлжлүүлэв. Ерөөс Чингис хааны энэ үгийг эсэргүүцэхийн аргагүй байсан билээ.

-Харин одоо Зүчи миний их улсаас хулгайлан авч тусгаар явахыг хүсчээ гэж Чингис хаан хүндээр шивнээд морины амыг татан зогсов. Чингис хааныг морины амыг татах төдийд торгон цэргүүд ч яг зогсчээ.

Боорчи толгой өргөн Чингис хааны өөдөөс гайхан ширтсэн ч үг дуугарсангүй.

Түүнийг юуны учир Сүбээдэйн зүг илгээж буйг ч ойлгов. Гэвч тэр даруй хэлэх үг олдсонгүй ажээ. Чингис хаан өөрийн зорилго санааг тов тодорхой хэлсний учир ийнхүү мухарджээ. Боорчийн юуны учир дуугүй байгааг Чингис хаан шууд ойлгон өөрийн нь сонгосон арга зөв байсанд итгэсэн тул одоо түүнд сэжиглэж эргэлзэх явдал үгүй болжээ.

-Миний Их Монгол улсыг хэн нэгэн самууруулж сарниулахыг үл тэвчинэ. Ингэхийг хүссэн хэнийг ч болов Тэнгэр өршөөхгүйг чи мэднэ. Тиймээ. Чи Зүчийг ихэд хайрлах тул миний өөдөөс үг тайлбар хэлж эсэргүүцэх санаа бий биз. Гэвч бид байгуулсан төр, улс гүрнээ үр хүүхдээсээ илүү хайрлах ёстой юм. Зүчи нэгэнт зориг шийдээд чиний дүү Үүлэн черби, Зэлмийн хөвүүн Есөнтэй бас Сүбээдэйг өөрийн дэргэд шадарлуулан зүтгүүлэхийг хүсэж шаардан, элч зарж үг дайжээ. Бас өөрийн итгэл өгч шадарлуулах хүсэлтэй хүмүүсийн дотор Боорчи чиний нэрийг ч дурджээ. Би чиний сэтгэлийг зовоохгүйн тулд үүнийг чамд хэлсэнгүй удлаа. Хэрэв Зүчийн тусгаар улс байгуулахыг зөвшөөрвөл Цагадай, Өгөдэй, Тулуй хөвүүдэд муу үлгэр болж чи бидний зовж цуглуулсан, зүдэрч байгуулсан улс хана туургаар салж, хаяа хатавчаар задрах биш үү. Бид чухам ингэхийн тулд дөрвөн мөчөө сарвайж цуцтал, дөрөөн сэнжээ сунаж сэтэртэл халуунд шатаж хүйтэнд хөлдтөлөө зүтгэв үү.

Чингис хааны энэ үгэнд хорсол занал гэхээсээ илүү гомдол цөхрөл сонсогдох шиг болсонд Боорчи их цочжээ.

-Эсвэл Боорчи чи хэлээч.Би буруу ярьж зөрүү сэтгэнэ үү.

Сүүлийн хагас жил Чингис хааны сүр сүлд доройтон бодолд дарагдан суух болсны учрыг Боорчи сая л ойлгов. Тэгээд ч юуны тулд Тэнгэрт мөргөснийг ойлгов. Бас Тэнгэр юу гэж



зарлиг буулгасныг ойлгов. Харин Зүчи өөрийн итгэх хүмүүсийн дотор түүний нэрийг дурдсаныг сонсоод Боорчи туйлын ихээр цочин эмзэглэжээ. Чингис хаан энэ үгийг хэлэхдээ дотроо чухам юу бодсоныг Боорчи ч гадарлаж байв. Харин Боорчийн нэрийг дурдсан гэж Чингис хаан худал хэлснийг тэр мэдэх аргагүй байлаа.

-Хаантан минь. Та бүү эргэлз. Тэнгэр юу гэж зарлиг болгов түүгээр би хийе гэж Боорчи эрс хэлэв. Үүнээс өөр хэлэх үг түүнд байсангүй бас элдвийг тунгаах цаг ч үлдсэнгүй ажээ. Тэд нэгэн хэсэг дуугүй зэрэгцэн явцгаажээ. Хэлэх гэсэн үгээ хоолой давуулахад хэцүү байгаа биз гэж Боорчи боджээ.

-Тэр нэг цагт би Зүчийг төрмөгц үхүүл гэж зарлиг буулгасныг чи лав санаж буй. Энэ зарлигаа би чамд дахин нэг сануулъя. Зүчийг хэрхэхээ чи шийд. Үхүүлэх ёстой гэж үзвэл үхүүл. Үнэн зөв сэтгэжээ гэж өршөөвөл өршөө. Боорчи чи яаж шийднэ. Би чинийхээр больё. Зүчийн хүрээнд очиж газар дээр нь уулзаж учрыг нь ологтун. Бас надад Зүчийг үхүүлэхийг улайран хүсэх явдалгүй. Ганцхан Зүчи чиний үгийг сонсоод ухаарч ойлгож мэднэ. Бас Есөнтэй болоод Хунангийн үг баттай биш байж болно. Тиймийн учир би чамайг Сүбээдэйн дараа Зүчийн дэргэд очуулахаар илгээж байна. Хэрэв Зүчи үнэхээр надаас салахаар шийдсэн бол өршөөлгүй үхүүлэхтүн. Ухаарч ойлгох юм уу миний сонссон, бодсон ташаа байсан бол сайтар ухуулж сургаад орхигтүн. Тэгээд цаашид хэрхэхийг чамайг ирэхээр хэлцэж байгаад шийдье. Хэрэв болдогсон бол түүнийг дагуулан ирэхийг хичээ. Би Зүчийн улаан нүүрийг харж, үнэн үгийг сонсохыг хүснэ. Гэсгээлээ ч гэм нүглийг нь өөрөө хэлж ял асууна. Дүү нарт нь сургамж болно. Бас Бөргийн өмнө хар буруу санаагүй шударга явдал болно. Одоо Боорчид бүх зүйл тодорхой болов. Чингис хаан юуны учир хэрэг болгон Есөнтэйг сонгож Зүчийн тийш илгээснийг ойлгов. Худал байсан ч, үнэн байсан ч Зүчид ямар аюул тулгарч байгаа нь одоо нүдний өмнө хад чулуу мэт хөндөлдөх торгон цэргүүд шиг тодорхой харагдаж байв. Бас Чингис хааны юу хүсэж байгаа нь тов тод болжээ. Энэ бол хэрэг явдал ноцтойгоор эргэвэл Зүчийг алах, үгүй бол ямар нэгэн аргаар баривчлан авчрахыг Чингис хаан хүсч байлаа. Үүнийг ч Боорчи дээрхи үгнээс ойлгов.

-За би Хаантны хэлснээр хийе. Хэлбэл үг, гишгэвэл газар гэдэг биз. Та бүү эргэлз. Би Чингис хаан таны өмнө Зүчийг өөрийн биеэр дагуулан авчирья гэхээс өөр үг Боорчи хэлсэнгүй. Тэр дуугүй явахыг яарч байв. Үнэхээр Зүчи буруу санаж зөрүү сэтгэсэн мэт санагдаад бас Зүчийг төрөхөд нь амьд үлдээснээс энэ хамаг хэрэг булхай үүсэв гэж өөрийгөө буруутгаж бодсоноос Боорчи, Чингис хааны дэргэдээс холдон зугтахыг хүсчээ.

Чингис хааны гомдсон бас харамсаж зэмлэсэн харцыг тэсвэрлэхэд түүнд үнэхээр хэцүү байсан билээ. Дөчин хэдэн жилийн хойно болох хэрэг явдлыг тааж мэдэхийн аргагүй бөгөөтөл яг ийм хэрэг явдал болохыг урьдчилан тааж мэдээд түүнд Зүчийг төрмөгц алахыг тушаасан мэт санагдахад Боорчи зугатмаар болжээ. Харин Чингис хаан хэлэх үгээ дуусаагүй нь илт байсан тул тэр даруй давхин одож эс зүрхэлжээ.

-Боорчи чи миний хүссэнийг зөв ухаарч ойлгожээ. Чиний үгийг сонсоод миний сэтгэл амарлаа. Чи юу ч болсон өөрийн санаснаар хийгээд Эрчис мөрний хөвөөнд намайг даруй гүйцэж оч. Одоо хөдөл гэсэн Чингис хааны үгэнд дөнгөж ёслох төдий болоод морио давиржээ. Харин одоо бүх хэрэг нэгэнт дуусаж Зүчи өөрийн үйлийг даган өвчнөөр үхжээ. Гэвч Зүчи өвчнөөр үхэв гээд Чингис хааны сэтгэл цэлмэн амарсангүй харин улам ч түгшүүр

гуниг дүүрэн болжээ. Зүчийн өвчнөөр үхсэнийг Боорчи эргэн ирээд батлаад зогссонгүй Чингис хаан өөрийн итгэлтэй хүнийг худалдаачны дүрээр нууцаар илгээж нягтлуулсан нь давхар батлажээ. Зүчийг өвчнөөр үхэв гэдэгт итгэсэн нь Есөнтөйд эргэлзэхэд хүргэв. Гэтэл Зүчийн дээрх үг, санааг зохион хэлэх учир Есөнтөйд яагаад ч байхгүй гэж бодогдоно. Харин Зүчи нэгэнт бие өвчтэй байсан тул өөрийн зорилгыг хэрэгжүүлэх гэж ингэж яарчээ гэж бодоод Чингис хаан бага боловч тайвширчээ.

Зүчийг үхүүлбэл улсын доторхи самуун бодол арилах мэт санасан нь түмэн эндүүрэл байсан нь ойлгогдож эхлэв. Хасарыг үхүүлээд мөн л ингэж хэрэг явдал дууссан мэт бодсон билээ. Гэтэл Хасарын хөвүүд Хянганы нуруугаар нутаглаж засаг захиргаагүй мэт явааг Хорезмоос эргэж ирээд л сонсож мэджээ. Хасарын хөвүүд эцгийнхээ язгуур санааг мэдэхгүй гэж байхгүй нь ойлгомжтой билээ. Тэд нэгэн өдөр Хасараас дутахгүй дайсан, их санаатан болж мэдэхийг таах аргагүй байв. Амьдрал өөрчлөгдөж цоо шинэ хүмүүс төрж өсөн бойжиж, тэдэнтэй цуг хүсэл зорилго нь хамт өөрчлөгдөж шинэчлэгддэгийг Чингис хаан ухаарч ойлгосонгүй явжээ. Тийм учраас Зүчийн үхсэний дараа зөв шийдвэр гаргах нь зайлшгүй болжээ. Хэрэв үнэхээр Зүчи тусгаар улс байгуулахаар шийдсэн бол Батыг түүний оронд суулгах учир үгүй юм. Гэвч Чингис хаан үүнээс өөр зөв мэргэн шийд олсонгүй. Хэдийгээр Батыг түр өргөмжилсөн нь одоохондоо аюулгүй ч Чингис хааны эцсийн хатуу зарлиг бас биш байлаа. Үүнийг хэн хүнгүй тэр дундаа идэр залуу Бат ч сайн мэдэж байлаа. Үүсч бий болсон шинэ нөхцөл байдлыг сайтар ойлгохыг Чингис хаан хичээж бас өөрийн гаргасан алдааг олж засахыг чухалчилж байв. Ямартай ч Зүчийн хэргийг нам гүм дарагдуулах нь зөв гэж шийдэв. Есөнтөйг дуудан ирүүлж Зүчийн санаж бодож явсныг таг нуухыг зарлиг болгож, ургийн боол Зэлмийн хөвүүн тул уучлан амьд үлдээж буйгаа хэлжээ. Энэ үед Есөнтөй эргэлзэж айлгүйгээр Зүчийн амнаас сонссон үгээ баталж үүрд нууцлан чандлаж явахаа тангараглажээ. Есөнтөйн шулуун шударга зан төрх, төр улсын хэргийг хувийн явдлаас ямагт дээгүүрт үздэг хүмүүжил нь Чингис хаанд угаас ихэд таашаагддаг тул Есөнтөйг алах санаа байсангүй харин ч түүнийг үнэнч зүтгүүлэхийн тулд дээрх үгийг хэлжээ.

Зүчийн дараа Батыг өргөмжлөсөн нь Боорчийн зөв байсан бөгөөд харин ч Батын дэргэд Сүбээдэйг суулгахаар зарлиг болгов. Энэ бол бүх хэрэг явж явж Зүчийн хүслээр болсон мэт боловч ингэх нь гарцаагүй зөв шийдвэр байлаа. Бат бол Зүчийн үргэлжлэл тул тэр хөвүүний дэргэд хашир чоно Сүбээдэйг суулгах нь бүх зүйлээс сэргэмжлэн засч болох ганц арга мэт санагджээ. Бат нас балчир, дөнгөж арван долоотой тул Сүбээдэй түүнийг сайхан хүмүүжүүлэн сургаж түүнд үнэнч зүтгүүлж чадна гэж Чингис хаан итгэж байв. Бас Сүбээдэйг Батын дэргэд суулгасны зорилго ч тэр байв. Ингэвэл Батын зүгээс гарч болох тусгаар улс байгуулах хүсэл санааг цаг тухайд нь таслан зогсоож болно гэж Чингис хаан найджээ. Харин Зүчийн хүсэл зориг Бат хөвүүнд нь хэрхэн гүнзгий шингэснийг бас ч хэлж мэдэхийн аргагүй. Гэвч одоохондоо арван долоотой Бат, Сүбээдэйгээс зөрж юу ч санаан зоргоор хийж чадахгүй байгаа нь Чингис хааныг тайвшруулжээ.

Ерөөс Зүчийг анхаарлаасаа холдуулж зоргоор нь орхисноос ийм явдал болов гэж Чингис хаан өөрийгөө буруутгаж байлаа. Тийм ч учраас Чингис хааныг хамгийн их зовоож байсан зүйл нь Зүчийн үхлийг Бөртэ хэрхэн хүлээж авах бол гэдэг явдал байлаа. Яагаад ч юм бэ түүнийг, Зүчи хөвүүнээ үхүүлсэн мэт буруутгах вий гэсэн бодол Чингис хаанд төрж зовоосоор байжээ. Бөртийн нүүрийг харахад туйлын хэцүү санагдан халширч Эрчис мөрнөөс Туулын хөвөөн дөх

их хүрээг хүртэл явдал нь удаширч саатсаар байв. Харин Зүчийн үхлийн тухай мэдээ аль эрт Бөртэд хүрч улс даяар их гашуудал зарлаад байсан билээ. Чингис хаан Бөртийн сэтгэлийн шархыг бүдгэрч илааршихыг хүлээж зам зуур алгуурлан явсаар Хорезмоос хөдөлснөөс хойш жил гарны дараа сая нэг юм Туулын хөндийд ойртон иржээ. Туул, Улиастай, Сэлбэ гурван голын дундах их өргөөнөөс даруй өртөө илүү газар цагаан эсгийгээр зам засан хоёр талаар нь албат иргэд, цэргүүдээс өгсүүлээд Чингис хаанд дагаж орсон хорин том улс, аймгийн хаад, хан хөвүүд хатдын хамт эгнэн жагсаж угтахад бэлджээ.

Энэ бол Бөртэ, Тулуй хоёрын санаа байв. Үүний тулд эзлэгдэж дагаар орсон бүх улс аймгийг захиран суугчдыг бүгдийг сарын өмнө Туулын хөндийд шинээр байгуулсан их хүрээнд дуудан ирүүлжээ. Ганцхан дагаар орсон үгээ буцсан Тангудын Буур хаан ирсэнгүй ажээ. Чингис хааны их ялалтын сүр хүчинд үүл хүртэл үлээгдэн хөдөлж, үндэс хүртэл сугаран гарч байв. Энэ газар ийм сүрлэг ёслолыг лавтай үзээгүй бизээ. Туулын хөндийд газар газрын олон шашны мөргөлч сүсэгтнүүд цугларч, бүх үндэстэн хэлтэн нэг дор амьдрахаар ирсэн мэт байлаа. Бөртэ яг л хуучин ёсоор их хатныхаа буйраар бүгдийг манлайлан Чингис хааныг их өргөөнөөс хол саахалт зайтай угтав. Бөртэ хөгширч, бүдүүрч таргалаад танигдахгүй шахам болжээ. Юуны учир ингэж өтөлснийг Чингис хаан ойлгосонгүй. Есүй, Есүгэн хоёр ч өтөлжээ. Охид нь өсөж гээг нь газар шүргэсэн бүсгүйчүүд болсон нь бахдалтай байв. Найр цэнгэл бүжиг наадам эхэлж Туулын хөндийд зассан их талбайд дайнд гавьяа алдраа мандуулсан шилдэг жанжин, цэргүүдээсээ түмэн хүнийг шилэн авчирч шагнан урамшуулж бүтэн арав хоног найрлажээ.

Ёслол өндөрлөсөн ч Бөртэ, Зүчи хөвүүнийхээ тухай нэг ч үг цухуйлгасангүй олон хоног. Чингис хаан ч хэлэх үгээ олохгүй байжээ. Харин найр цэнгэл өндөрлөж наадмын талбайн өвс сэргэн ялалтын сүр дуулиан баяр хөөр нам гүм болсон хойно нэгэн үдэш Бөртэ

-Тэмүжин. Би Зүчи хөвүүнийхээ булш бунханд очиж сүү өргөө дөө. Хөвүүний минь сүнс ээждээ хоргодоод байгаа бололтой. Тэр амьтныг үхсэн хойно нь дахин зовоогоод яах вэ дээ. Ер нь хөгшин би өвөртлөж өсгөсөн Бат хөвүүнийхээ дэргэд очиж суувал яана. Бат хөвүүн минь ингэхийг хүссэн юм гэж хэлжээ. Тэмүжин Бөртэ хоёрын янаглан цэнгэх нь ядаргаа уйтгар төрүүлэхээс өөр юмгүй болж хувирсныг тэд зургаан жил хагацаад учрахдаа мэдсэн тул гэрийн унь ширтэн зэрэгцэн хэвгэж байжээ. Бөртийн энэ үгийн цаана олон ноцтой далд санаа агуулагдаж байгааг Чингис хаан мэдэрсэн ч буруушаан эсэргүүцэх сэтгэл төрсөнгүй харин ч зөв зүйтэй үг хэлэв гэж урамшуулжээ. Тэгээд

-Бөртэ. Би Зүчи хөвүүндээ ер муу санасангүй шүү. Гайт өвчин тусаагүй бол бид хамт ирэх байв. Чиний очих чинь зөв. Хөвүүнийхээ бунханыг хүссэнээрээ хийхгүйн. Би чамайг Боорчийн өргөмөл хөвүүн Гэрэгийг торгон цэргийн нь хамт дагуулан илгээе. Тэр хөвүүн одоо миний амь сахигч, хамгийн шилдэг торгон цэргийн мянганы ноён болсон гэж бахтай хэлжээ. Тэмүжиний үг Бөртийг ч баярлуулав. Бас Боорчи өргөмөл хөвүүнтэй болсонд ихэд догдолжээ.

-Боорчи их жаргалтай байгаа байхдаа гэж Бөртэ үнэн сэтгэлээс хэлэв.

-Тиймээ. Боорчи хөвүүнтэй болоод их баяр болсон шүү гэж Чингис хаан инээж аз жаргалтай болжээ. Зүчийн үхсэнд Бөртэ, Чингис хааныг буруутгасангүй харин ч Зүчи хөвүүн нь өвчнөөр

үхжээ гэсэн мэдээ ирэхэд Бөртэ дотроо баярласан билээ. Зүчи хөвүүн нь лав харамсах юмгүй үхжээ. Бат хөвүүнд нь байгуулсан улс нь үлдэв. Харин одоо Бөртэ үлдсэн насаа Батын дэргэд очиж түүнийг хамгаалан сууж өнгөрөөхөөр хатуу шийдээд байжээ. Энэ хүслийг нь Чингис хаан огт эсэргүүцэхгүй дэмжсэн нь бөөн баяр болов. Батын дэргэд байх нь Цагадайн ойр очих тул Бөртэд давхар давхар хэрэгтэй байлаа. Уг нь Зүчийн эзэмшил нутгийг хураан авч Цагадайд юм уу, Өгөдэйд өгөх бодол Чингис хаанд эхэн үед гэнэ гэнэ төрсөөр байсан боловч Бөртийн сэтгэлийг бодоод ингэж хийж чадахгүй байжээ. Бас Өгөдэй Цагадай хоёрын хэн нэгэнд өгөх нь хөвүүдийг хагаралдуулж болох тул бас болгоомжилжээ. Гэвч бодсоны эцэст Зүчийн эзэмшлийг Батад өгөхөөр эргэлтгүй шийдсэн юм. Харин Батын дэргэд суух Бөртийн санааг дэмжиж болохгүйг бодсоны эцэст ойлгов. Бөртийн энэ үгийн цаана ямар санаа нуугдаж байгааг Чингис хаан мэдэж байсан тул сэжиглэн эргэлзэв. Бөртэ, Батын дэргэд очиж суувал Зүчийн улс Их Монгол улсаас тусгаар болсон мэт харагдах болно гэж тэр хамгийн түрүүнд бодов. Ингэх нь Бөртэ, Зүчи хөвүүнийхээ тусгаар улс байгуулан суух хүслийг дэмжиж байсан, одоо ч дэмжсээр байгааг илтгэх мэт санагдах болов. Бас Бөртө Зүчийн удамд очиж суух нь Зүчийн үхэлд Чингис хааныг буруутгаж байгаа мэт сэжиг төрүүлж мэдэх байв. Бөртийг Зүчи хөвүүнийхээ бунханыг өөрийн хүслээр байгуулахыг хориглох аргагүй ч түүнийг Батын дэргэд суулгах нь ирээдүйд Их Монгол улс хоёр хуваагдах аюулд хүргэж болзошгүй нь тодорхой байв. Тийм учраас Бөртийг төв улсдаа их өргөөнд нь үүрд үлдээх аргыг сүвэгчлэх ёстой болжээ. Батын дэргэд суух гэсэн Бөртийн хүсэл зориг их байсан нь хэргийг улам төвөгтэй болгожээ. Бөртийг хэн ч хорьж дийлэхгүй болоод тэр Каспийн тэнгисийн зүг явахад бэлдэж эхлэв. Чингис хаан бодолд унав. Чингис хааны сэтгэлийн түгшүүрт бодлыг хамгийн түрүүнд таасан хүн нь Есүй байв.

-Их хатан Бөртэ Тэнгэрт одсон хөвүүнийхээ гэрт очиж суух нь гаднаас харвал Чингис хаан Бөртэ хатан хоёрын хооронд гарсан далд их зөрчлийг илтгэх бөгөөд бүр гүнзгий ургуулж бодвол Чингис хааныг Зүчийн үхэлд буруутган тэд хагаралдан салсан мэт бодогдохоор ажээ. Бөртэ хатан ингэж их өргөөнөөс явах нь ер зохисгүй хэрэг билээ. Гэтэл бас Бөртэ хатныг илэрхий буруушаан зэмлэх, хориглон саатуулах аргагүй болжээ. Энэ бол Есүй хатны чин сэтгэлийн үг байв.

-Хаан танд хоёр их хатан тань байна. Юунд санаа зовно. Та дахин бага хатан буулгасан ч болно. Ер нь та эр биеийн чалх буураагүй дээр дахин хатан буулгавал зохино. Хүсвэл би танд Алтан улсаас сурвалжит гүнж буулган авч ирүүлье гэж Бөртэ хэлсэн нь бүх үгний хариу болж Чингис хааныг мухардуулжээ. Харин Бөртийг төв улс, их өргөөнд үүрд үлдээх хамгийн сайн аргыг Чингис хаан бодож олж чадав. Ингэхэд нь Есүйн хэлсэн ухаант үг хэрэг болсон билээ. "Бөртэ хатныг энд үүрд үлдээх ганц юм нь эрх мэдэл биз" гэж Есүй туйлын энгийн үнэн үг хэлжээ. Бөртийг төв улс, их хүрээнд үүрд үлдээх ганц арга нь түүнд "Төрийн их хатан" цол өргөмжлөн, эм хүн эдлэж байгаагүй их эрх ямбыг олгох явдал байлаа. Энэ бол Бөртэд хатан хааны эрх, цол хэргэм олгосон хэрэг юм. Их Монгол улсаа бүтэн бүрэн байлгахын тулд Чингис хаанд үүнээс өөр сайн арга олдсонгүй.

Харин гайхалтай нь Чингис хааны энэ зарлигийг Бөртэ туйлын талархалтайгаар догдлон хүлээн авав. Ер нь энэ их цол хэргэм Бөртийн зовж зүдсэн амьдрал, бүтээж хийсэн гавьяанд яг дүйцсэн хэрэг байсан нь Чингис хааны энэ зарлигийг олон бүгдээр нэгэн дуугаар талархан угтсанаар батлагдав. Чингис хааны энэ зарлиг яг нүдээ олсон зөв хэрэг байв. Нэг талаас

дөрвөн хөвүүн төрүүлж, өсгөн хүмүүжүүлж төр улсдаа зүтгүүлсэн түүний их гавьяанд энэ цол яг таарч хурсан олныг тэр дундаа Бөртийг баярлуулав. Дайн тулаан хийж эзгүй байсан олон жилүүдэд Бөртэ нутгийн үлдсэн олон түмний дунд ямархан их нэр хүндтэй болж төв улсаа түвшин амар байлгахын төлөө хичнээн ихийг хийснийг давхар батлан харуулжээ. Бас Төрийн их хатны ёсоор төв улсдаа залран суухаас өөр арга Бөртэд үлдсэнгүй. Ингэснээр улсын дотор хагарал үүсэхээс сэргийлж Бат болоод Зүчийн улсыг Бөртээс салган авч чадав. Бат эмэг эхдээ туйлын халуун дотно сэтгэлээр ханддаг нь хэн хүнд илэрхий бөгөөд хэрэв аливаад ухаан сийрэг, олон давхар санаа бодолтой, нэр хүнд нөлөө ихтэй Бөртэ хатан Батын дэргэд суувал хэрэг учир хаашаа ч эргэж мэднэ гэж Чингис хаан хамгийн ихээр болгоомжилж байв.

Бөртэ хатантайгаа дайсагналцахаас тойрон гарахыг тэр чармайж байлаа. Бөртэ нэг эвдрэлцэн муудалцвал хамгийн аюултай дийлдэшгүй дайсан болно гэдгийг тэр сайн мэдэх билээ. Ингэж бодоход хүргэсэн олон тохиол бий юм. Жамуха, Тэв Тэнгэр бөө, Хасар гээд Тэмүжиний зам зуур учирсан дайснуудыг зайлуулахад чин үнэнээр сэргэмжлэн хэлж тэднийг дарах уран аргыг эрэлхийлэн тусалсан хүн бол Бөртэ юм. Тэмүжин дайсныхаа өмнө хүчин мөхөсдөн шахагдах яг ийм үед Бөртийн гэмгүй тайван зан төрхийн цаана нуугдан байдаг гүнзгий ухаан, хэзээ ч дийлдэхийг үл хүсэх хатуу зориг тэвчээр хурц илрэн гардаг байв.

Бөртэ насан туршдаа Тэмүжиний дайснуудтай өөрийн сурсан аргаар ил далд тэмцэж, түүнд тусалсаар ирсэн нь угтаа Их Монгол улсын төлөө зүтгэсэн хэрэг гэдгийг мэдэх тул Чингис хаан Бөртийг ихэд хүндэтгэн үзэх бөлгөө. Хамгийн эцсийн мөчид сэтгэлийнхээ мухрын нууцыг итгэн хэлэхэд эргэлзэхгүйгээр юу хий гэснийг хийх хүн бол Бөртэ гэдгийг Чингис хаан сайн мэднэ. Ийм ч учраас хамгийн хүчирхэг нөхрөө өрсөлдөгч бүр муугаар эргэвэл дайснаа болгон хувиргахыг Чингис хаан хүссэнгүй. Бөртийн хүслийг үг дуугүй биелүүлэн түүнд бууж өгөх замаар илэрхий сөргөлдөөнөөс тойрон гарах замыг сонгон авсан нь зөв болжээ. Бөртэд “Төрийн их хатан” цол өргөмжлөх зарлиг буулгаж түмэн олонд тунхагласны дараахан түүнийг Каспийн тэнгисийн зүг их хүрээ даяар үдэн гаргаж өгөв. Их торгон цэргийг бүрнээр жагсааж ёсолсон нь ер урьд өмнө болж байгаагүй явдал байлаа. Зам зуурын улс хотуудад түүнийг Чингис хааны адил угтан авч, үдэж гаргах зарлигийг урьдчилан хүргэж бэлдэн хариуцах ноёдыг томилон илгээжээ. Харин Бөртэ хатан Батын дэргэд сараас илүү суух эрхгүй болжээ. Учир нь намрын эхэн сарын арван тавны сайн өдөр улс даяар их ёслол үйлдэж Бөртийг Их Монгол улсын Төрийн их хатнаар өргөмжлөн залахаар товлож Их хуралдайг зарласан зарлигийг Чингис хаан буулгажээ. Бөртэ ингэж төрийн их нудрагын дороос хэзээ ч гарахгүйгээр баригдав. Бөртэ сэтгэл тэнүүн замд гарчээ. Түүнийг Боорчийн өргөмөл хөвүүн Гэрэг өөрийн мянгатын хамт хамгаалан дагалджээ. Чингис хаан Зүчийн үхлээс болоод Бөртийн санаа сэтгэлд гарсан хувирлыг аятай сайнаар зохицуулж чадсандаа баяртай байлаа.

Бөртийг явахаас хэд хоногийн өмнө Боорчи, Алтайн өвөрт байх өөрийн хүрээнээс Чингис хааны төв хүрээнд эргэн иржээ. Чингис хаан түүнээс Зүчийн үхлийн тухай тодруулан асууж зүрхэлсэнгүй байсаар өдий хүрчээ. Хүнд өвчинд нэрвэгдсэн Зүчи хөвүүнээ хэтэрхий ихээр хардан Боорчид олон үг хэлсэндээ Чингис хаан ихэд харамсан гэмшсээр байсан тул ингэжээ. Харин одоо тэрээр энэ явдлыг ор тас мартахыг хүсэж байв. Боорчийг ирмэгц шадруудаа

цуглуулан цэргийн зөвлөгөөн хийж Чингис хааны хүссэнээр Тангудыг хэрхэх тухай удтал зөвлөлджээ. Боорчи хэдийгээр Тангуд руу цэрэг оруулахыг азнах хүсэлтэй байсан ч Чингис хаан өөрийн бодлоос ухарсангүй. Ингэх шалтгаан Чингис хаанд байсан билээ. Хорезмоос буцаж ирээд бүх цэргийг орон гэрт нь тарааж, бүр торгон цэргийн ихэнх нь гэр гэртээ түр хугацаагаар оджээ. Ингэхээс өөр арга байсангүй. Бүтэн зургаа, долоон жил дайтаж ядарсан цэргүүдэд амрах, ар гэр, эмс хүүхэдтэйгээ хүн шиг амьдрах хүсэл дүүрэн байв. Их Монгол улс даяар амар тайван цаг эхэлж, хагацал харамслын нулимс хатжээ.

Дайны олз омог гэр бүхэнд дүүрэн байсан нь тэдний амьдралыг улам ч амар амгалан, аз жаргалтай болгох ажээ. Хорезмд хийсэн дайнаас амьд үлдэгсэдээр зогсохгүй, азгүй үрэгдэгсэдийн ар гэр бүхэн хөлжиж баяжжээ. Монголчуудын олсон, ялсан бүгдийг Чингис хааны гавьяа гэж улс даяар тооцож байв. Харин энэ назгай тайван амьдралд Чингис хаан огтхон ч дасаж өгсөнгүй. Сүр хүч, ялагдашгүй баатарлагийн баталгаа болсон их цэрэг тарсан нь Чингис хаанд олон зүйл бодогдуулах болов. Гадаад харийн улсаас заналхийлэх аюул үгүй мэт боловч аймаг улсын хан эзэд, өөр өөрийн цэргийг захиран тусдаа суух нь Чингис хаанд огтхон ч таалагдсангүй. Чингис хааны сэтгэл шинэ аян дайн, их олзыг нэхэн шаардаж, энэ хүсэл нь бүр цусанд нь шингэжээ. Хүчирхэг их цэргээ дахин цуглуулан тэднийгээ манлайлан, дайлж ялж, аялан явах хүслээ барьж тэсэхгүй болжээ.

Цэрэг ноёдыг ингэж дэл сул амрааж, эрх дураар байлгах нь тэдний тусгаар орших, салж сарних хүслийг оргилуулан дэврээж болохыг Чингис хаан ойлгов. Цэрэг, ноёдыг өөрийн дор салшгүй бат бэхээр барьж байх ганц арга нь дайн хийх, өөр газар орныг эзлэн авах явдал болохыг тэр ойлгожээ. Одоо хүчирхэг байж, их сүр хүчээ цуурайтуулахын эцсийн зорилго нь ард иргэдийн энх амар амьдрал биш, шинэ газар нутгийг эзлэн авах дайн болжээ. Дайн хийж олз олох нь цэрэг бүрийн, түүний ар гэр, эмс хүүхдийн хүслэн болохыг, бас энэ аргаар олон түмнийг дагуулан уриалж болохыг мэдэж авсан нь Чингис хааныг тайван амар суулгасангүй. Үүний тулд тэр их цэргээ дахин цуглуулж Тангудыг дайлахаар шийдэв. Чингис хаан өөрийн цэрэг жанжинуудаа элдвийг бодон самуурахаас сэргийлэх үүднээс цаг алдалгүй цэргээ засан Тангудыг дайлах зарлиг буулгасан нь энэ байв. Алтан улс болоод өмнөд Сүн улсыг Хорезм, Персийн нутагтай холбодог худалдааны гол зам одоо хир Тангуд улсаар дайрч, тэд эрхэндээ байлгасаар байгаа нь Тангудыг довтлох гол зорилго байв. Энэ худалдааны их замыг эрхэндээ байлгахгүйгээр Алтан улстай дайтаж болохгүй гэдгийг Чингис хаан ойлгожээ.

Монголын их цэргийг байлдаанд бэлэн болгоход хагас жил л хангалттай байжээ. Баруун зүгт Каспийн тэнгисээс өмнө зүгт байгаа Цагадай, Ил мөрөн, Тарвагатайн нуруугаар нутаглан суугаа Өгөдэйг ч өөрсдөө цэргээ удирдан ирэхийг тушаав. Харин Батыг Хивчагаас дуудсангүй азнажээ. Учир нь цэрэг эзгүй, Батыг нялх гэж үзээд Орос Хивчаг аймгууд далимдуулан довтолж мэднэ гэж хаширлажээ.

Ингээд 1226 оны намрын сүүлчээр Монголын цэрэг гурван замаар хөдөлж Тангудыг зэрэг дайран ороход бэлэн болжээ. Ингэж Тангуд улсын мөхлийн үе иржээ. Гэвч Тангудад довтлох нь Чингис хаанд баяр жаргал авчрахгүй гэдгийг тэр өөрөө мэдэхгүй байв. Өгөдэй Тангудыг дайлах хэргийг удирдахыг хүсч байсан ч Чингис хаан өөрөө морилохоор шийдэв. Үнэт эдлэл, алт эрдэнэсээр чимэглэгдсэн өргөөндөө сууж төрийн хэрэг хэлэлцэх нь чухал ч их цэргийн тоосонд морьдын туурайн битүү нүргээн сонсож явахаас илүү жаргалыг Чингис хаан

үзсэнгүй. Жамуха, Тоорил нарын нийлсэн дөрвөн түмэн цэргийн тоос, чимээн дунд анх эдэлсэн хачин түгшүүртэй атлаа амттай аз жаргалыг дахин эдлэхийг Чингис хаан тэсэлгүй хүсэж байлаа. Энэ аз жаргал нь анх эм хүнтэй хавьтаж дур ханаж үзсэн шиг тийм үгээр илэрхийлэн хэлж болдоггүй зөвхөн биеэр эдлэж мэдэрч болдог тийм мэдрэмж ханамж билээ. Одоо тэгэж жаргаж үзэхийг тэр туйлаас ихээр тачьяадан хүсч байв.

### *ГАЛЗУУРСАН ХУЛАН*

Чингис хааны их цэрэг Тангуд улсын Яргай балгасыг бүслэн суусаар даруй сар болжээ. Чингис хааны бие чилээрхсэн нь ингэж хөдлөхгүй суухын шалтаг болсонгүй ч олон хүний дотор ингэж бодох үндэс бий болгожээ. Монголын цэрэг нутгаасаа хөдөлснөөс хагас жилийн дараа хавар, өвлийн заагаар Тангудын баруун, зүүн болоод хойт хилийн хот балгасыг эзлэн аваад одоо энэ Яргай балгасыг довтолгон оролгүй бүслэн суусан нь энэ байв. Яргай балгас бол өрнө, дорныг холбосон худалдааны их замын гол боомт тул Буур хааны нэг өргөө энд байх ажээ. Хамгаалалт бэхлэлт сайтай хана хэрэм өндөртэй энэ балгаст Буур хаан хамгийн шилдэг цэргүүдээ цуглуулаад байжээ. Чингис хаан Тангудын их үгт Буур хааныг цэргийн хүчээр даран сөнөөхийг хүсээгүй нь Яргай балгасын дэргэд удаан суухад хүргэжээ.

Дэмий өчүүхэн Буур хаанд их хүчийг үзүүлэх нь хайран цэргийн амийг үрэхээс цаашгүй хэрэг гэж тэр боджээ.

Тиймээс Буур хааныг өөрөө дагаж ирэхийг шаардан Зэлмийн хөвүүн Есөнтэйг элч болгон илгээгээд хариу хүлээн тэвчээртэй суув. Буур хаан, Чингис хааны элч Есөнтэйн үгийг сонсож илгээсэн захидлыг уншуулж сонсоод өөрийгөө өмөөрсөн үг хэлж буцаасан байв. Буур хааны цэргийн жанжин Аша-Хамба гэгч хаанаа төлөөлөн их үг хэлж “Байлдахгүй юм бол юу гэж энд ирэв” хэмээн хэлүүлсэнийг сонсоод тэвчих хүн олон гарсангүй бүгд тэр муу ялаахай Буур хааныг даруй довтолгон сөнөөхийг шаарджээ. Ингэх нь ч аргагүй болжээ. Баруун зүгт ялгуусан их ялалт байгуулсан Чингис хааны их цэргийн хүчийг мэдэхгүй тэр бардам үгт Аша-Хамбын хэлсэн бодлогогүй хорон үг Тангуд улсын мөхлийг үүдийг нээв.

Гэтэл хэрэг иймдээ тулаад байхад Чингис хаан Яргай балгасыг дайран сөнөөх зарлиг буулгалгүй өдөр хоног өнгөрсөөр сар болжээ. Цаг агаар дулаарч халуун хуурай салхи өдөр алгасахгүй шуурч хүн малыг туйлдуулсан хаврын өдрүүд өнгөрч байлаа. Яргай балгасаас өртөө хүрэхгүй газарт намхан шавар уулын энгэрт Чингис хааны хээрийн хүрээ байрлажээ. Монголын баруун замын цэргийг Өгөдэй удирдан Тангудын нутгийн баруун хойт талын хотуудыг ээлж дараалан эзлэн авч байлаа.

Харин Цагадайн цэрэг баруун талаас довтолж Өгөдэйн цэрэгтэй нийлэх дөхөж байв. Ингэж Тангудын хойт, баруун тал бүхэлдээ монголчуудын гарт оржээ. Гэтэл Тангудын Буур хаан нэгэнт сайн дураар дагаар орохгүй нь тодорхой болоод байхад Чингис хааны ингэж алгуурлах нь хэн хүний тэр дундаа Боорчийн сэтгэлийг зовоож эхлэв. Чухам яагаад цэргээ хөдөлгөхгүй байгааг Боорчи таамаглан мэдэхийг оролдовч Чингис хаанаас тоймтой шалтаг олж сонсонгүй. Гэвч ямарч шалтгаангүйгээр Чингис хаан дэмий суухгүйг Боорчи мэдэж байв. Харин сүүлийн хэд хоног Чингис хааны бие чилээрхэж шөнөдөө ихэд халуурсныг маш чандлан нууцалж байв. Үүнээс болоод Боорчийн сэтгэл маш түгшүүртэй байх болжээ. Чингис хааныг хэзээ ч өвдөж зовохгүй мэт санаж явснаа тэр сая л мэджээ. Чингис хааны

биеийг монгол,кидан оточ эмчлэн сувилж байв.

Аз болоход Чингис хаан түргэн тэнхэрч урьдын эрүүл төрхөндөө оржээ. Энэ бол үнэхээр баярт хэрэг байлаа. Уг нь Чингис хаан Тангудыг дайлахад заавал биеэр морилохын хэрэг байгаагүй ч бас түүнийг хэн ч хориглож дийлсэнгүй билээ. Хэн ч энэ явдлыг буруу зөв гэж шүүмжилсэнгүй ч зам зуур Арбух нэртэй өргөн зоонд хулан авлаж яваад Чингис хаан мориноос унасан нь Боорчийн сэтгэлийн шаналан болжээ. Тэр үед юу ч болсонгүй өнгөрчээ. Хувцас шороо болохын төдий өнгөртөл түүнээс хэдэн сарын дараа Чингис хааны тэнхээ гэнэт ингэж чилээрхсэн нь яав ч зүгээр өнгөрөөж болохгүй хэрэг мэт Боорчид санагдах болжээ. Гэвч хэргийн учрыг хөндөн энэ талаар Чингис хаантай ярихаас цааргалсаар байлаа. Өвчин бол Чингис хааны хамгийн сонсох дургүй яриа юм. Тэгээд өөрийнх нь тухай бол бүр ч сонсохгүй билээ. Чингис хаан өөрийгөө өвчинд нэрвэгдэхгүй мэт санадаг нь ингэхэд хүргэх ажээ. Тэр хар багаас өвчин зовлон ярих нь муу ёр гэж үздэг байлаа. Ингэж үзэхийг тэр Тэв Тэнгэрээс сурчээ. Тийм учраас Чингис хааны ингэж шийдвэргүй удаан суух нь бие нь чилээрхснээс болов гэж Боорчи итгэжээ. Харин Чингис хаанд Яргай балгасын дэргэд цэргээ барьж хүлээн суух учир шалтгаан байв. Үүнийгээ хэнд ч хэлэх аргагүй ажээ. Хамгийн түрүүн Тангудын их үгт Буур хааныг шавар оромжноосоо өөрөө мөлхөн гарч ирээд өлмийдөө сөгдөхийг тэр үзэхийг, бүр олон түмэнд үзүүлэхийг хүсч байв. Одоо Монголын их цэргийн өмнө Тангуд байтугай улс хүчин мөхөсдөн мөхөх нь хэнд ч илхэн тул хий дөвчигнөн хайран цэргийн амийг үрэх цаг нэгэнт биш болжээ. Чингис хаан хамгийн амттайгаар хорслоо тайлж байж санаа нь амрахаар билээ. Тийм болохоор Цагадай, Өгөдэйн цэргүүд Тангудын бусад хотуудыг эзлэж авахыг хүлээж байв. Ингэхийг хүртэл шавар нүхний мухарт шахагдсан энэ Буур хаан ялаа шиг тэрүүхэндээ дүнгэнэж байг гэж хэлжээ. Чингис хааныг ийн хэлснээс хойш Монголчууд Тангудын Буур хааныг зүгээр л Ялаахай гэж нэрлэх болов. Гэтэл энэ хэрэг ийм ч хялбар биш болохыг Чингис хаан мэдэхгүй байлаа. Мэдсэн ч аль болохоор мэдээгүй дүр эсгэн өөрийгөө тайвшруулж байв. Чингис хааны энэ далд түгшүүрт байдлыг хамгаас түрүүлэн сэжиглэн тааварласан хүн нь Есүй хатан билээ. Татаарын Их Чэрэнгийн охин,Есүгэн хатны эгч тэрбээр Тэмүжинд ирснээс хойш өөрийн ухаалаг ялдам ааш, уран цэцэн үгээрээ олны сэтгэлийг эзэмдсэн бүсгүй юм. Чингис хаан аливаа холын аянд Есүй хатнаа дагуулах дуртай бас түүний үгийг сонсохдоо дуртай билээ.

Гэтэл Чингис хааны сэтгэлийн далд түгшүүрийн цаад нарийн учрыг хэн ч үнэн зөвөөр таамаглах аргагүй байв. Үүнийг зөвхөн Тэнгэр, Чингис хаан хоёр л мэдэх хэрэг билээ. Тангуд улсад явалгүй Монгол нутагтаа сууж байхыг Тэнгэр зарлиг болгосон ч Чингис хаан түүнийг тоосонгүй энд ирсэн нь бүх зовлон түгшүүрийн үндэс болжээ. Энэ бол Чингис хаан Тэнгэрийн зарлигийг зөрчсөн анхны тохиолдол байв. Хорезм улсад Перваны хөндийд сууж ахуйдаа Барыгжан уулын оройд гарах үеэр энэ явдал түүнд тохиолджээ. Иш-Химамын урласан оньсон шат түүнийг өргөж ганхан чахран дэнжигнэсээр уулын оройд гаргажээ.

Ямартаа ч үхэх цагаа болоогүйг Чингис хаан мэдээд Барыгжан хэмээх чулуун уулын оройд хөл тавихдаа ихэд баярласан билээ.

Өөрийнхөө зүрхийг зүсэн зүсэн эмээж, хүний нутгийн ууланд олсоор татуулан авирах нь ямар тэнэг хэрэг болохыг тэр мэдэж байсан ч санаснаасаа ухраагүй билээ. Энэ үед тэрээр өөрийгөө солиорсон байх гэж анх удаа бодож өөрөөсөө айсан юм. Гэвч ингэж амиа үрэх



шахан хүний хөл хүрэхгүй эгц элгэн хадан уулын оройд гарах олон учир шалтгаан түүнд байв. Тэдгээрийн дотроос Хулан хатны сүнс түүнд хорогдоод явахгүй байсан нь Чингис хааныг хамгийн ихээр шаналгаж байлаа. Эхлээд холоос гунигтай харж зогсдог байснаа удалгүй гэрт ордог болж, сүүлдээ бүр орны өмнө сууж гараас барих нь үзэгдэж мэдрэгдээд нэг мөч тайван унтуулахгүй болжээ. Шөнө нойрон дунд гарыг нь зөөлөн илбэж байгаа нь мэдрэгдэхэд тэр хөдөлж чадахгүй хэвтдэг байлаа.

Хуланы зөөлөн дулаан гар бүх биеийг нь төөнөн, бүр нууц эрхтнийг нь хүртэл илбэж таалахад Чингис хаан солирсон мэт салганан чичирч хэвтдэг билээ. Хуланы сүнс түүнийг дур ханасан хойно л холдох боловч бүр явчихгүй хатавчаар инээмсэглэн ширтэх нь үзэгддэг байлаа. Ингэж Чингис хаан Хулан хатнаа хүсэлжлэн шөнө бүр нойрондоо дур тачаалаа хангах өвчинд автжээ. Энэ бүхэн Чингис хаанд Хулан хатны сүнс хорогдсоноос болж байв. Хулан хатны сүнснээс болж Чингис хаан эмс хүүхнүүдтэй орооцолдох дур хүсэлгүй болов. Энэ бол Чингис хааны амьдралд гарсан хамгийн шаналгаат өөрчлөлт байв. Хуланы сүнсийг Тэнгэрт даатган өөрөөсөө холдуулахын тулд тэр Барыгжан ууланд гарахыг хүсчээ. Бас Зүчийг хэрхэхээ шийдэж чадахгүй эргэлзсээр байснаа нэг мөр болгохын тулд Тэнгэрт дуулган хүсэл зарлигийг сонсох хэргийг хойшлуулж болохгүй байв. Үүнээс гадна Өүлэн эхийнхээ нэг хүслийг биелүүлэхэд Барыгжан уул тохирно гэж боджээ. Хэрэв байдаг бол лалын шашинтны аливаа хүслийг биелүүлэгч, тэднийг эрхэндээ оруулагч Аллах тэнгэртэй уулзах адын хүсэл ч түүнд байв. Энэ мэт шалтгаан, хүслийн үүднээс Барыгжан ууланд гарах шат хийхийг тушаасан билээ.

Биелүүлж болохгүй зүйл байдаг гэж сэтгэхээ Чингис хаан нэгэнт мартсан байлаа. Загалмай шүтдэг Тоорил хан дарагдан мөхсөн нь түүнийг аврал ивээлдээ авч асран хамгаалж байсан Ертөнцийн эзэн Есүс Христос гэгч нь ямаршуухан хүч чадалтай амьтан болохыг нэгэнт баталсан тул Чингис хаан Христосыг ойшоож үзэхгүй болжээ. Харин Аллах тэнгэр гэгчтэй нүүр тулан учрах хүсэл оргилж байв. Лалын шашинтны улс Хорезм түүнд дарагдан мөхсөн нь Аллах тэнгэрээс бас айн сэжиглэх үндэсгүй болгожээ. Аллах тэнгэр гэгчээс Чингис хаан нэгэнт айхгүй болсон нь хүний нутгийн энэ ууланд гарч Тэнгэртэй ярих хүслийг нь бадраажээ. Барыгжан уулын оройд гармагц харанхуй тэнгэрийн доор сөхрөн сууж байгаад Тэнгэрийг урин дуудах шүлгээ уншжээ.

Энэ бол Тэв Тэнгэрийн зааж өгсөн шүлэг билээ. Хулан хатныхаа сүнсийг тайвшруулан ивээлдээ авахыг, бас Зүчийг хор хөнөөлгүй салгаж өгөхийг хичээнгүйлэн гуйжээ. Тэнгэр түүнд хариу хэлсэнгүй. Чингис хаан тэнгэрийн үгийг хүлээн удаан суужээ. Гэвч хорезмын тэнгэр дүлийрсэн мэт таг дуугүй байв. Чингис хаан гомдож бас Тэнгэр ингэж таг дуугүй байхад гайхав. Бурхан халдун ууланд гарсан мэт сэтгэл хөөрөн догдолж омог зориг оргилсонгүй харин ч гуниж гутарчээ. Гэвч Өүлэн эхийнхээ захисныг биелүүлэхээ мартсангүй билээ. Зүрчидийн Алтан улсад анх дайлаар мордохын урд орой Өүлэн эхийнхээ гэрт Тэмүжин салах ёс хийхээр очжээ. Өүлэн эхийн бие чилүүр, сэтгэл санаа нь хөндүүр байсан ч түүнийгээ мэдэгдэхгүй гэж ихэд хичээж байхыг Тэмүжин мэджээ. Тэр үдэш эх нь голдоо нүхтэй хумсны толион чинээ бөндгөр улаан чулуу өгч

-Хүү минь. Энэ бол чиний төрөхдөө атгаж төрсөн Тэнгэрийн тэмдэг юм. Хожим хойно Тэнгэр чамайг таних гэсэндээ энэ тэмдгийг чамд атгуулжээ. Чиний атгаж төрсөн нөжийг ээж

нь угаасан ус, унасан газрын чинь элс шороотой хольж хатаагаад өлгийд чинь зүүж сахиус болгосон юм. Хөлд орж, хол явахад чинь учир мэдэхгүй чамайг хаячихна гэж эмээхдээ авч энгэртээ шидэн хадгалсан нь энэ. Энэ тэмдэг одоо чамд гай гавьяа алийг авчрахыг ээж нь мэдэхгүй боллоо. Хөвүүн чи нэгэнт Тэнгэрт тэтгэгдсэн их хаан болов. Энэ тэмдгийг чамаас өөр хүн олж эзэмшвэл хөвүүн чамтай өрсөлдөн тэмцэгч хүн тэнгэрийн дор төрж мэднэ гэж эх нь болгоомжилж байна. Миний санахад энэ тэмдгийг хөвүүн чи хүний нүд үл үзэх, хөл үл хүрэх газарт залах нь зөв мэт санагдана. Чи миний хэлснийг бодож үзээд зөв гэвэл эхийнхээ хэлснээр хийгтүн гэж хэлсэн байв.

Тэнгэрийн тэмдэг атгаж төрснийг эх нь эрт хэлсэн бол гэсэн харуусалт бодол тэр үед төрсөн ч Алтан улсад довглохын өмнө үүнийг хэлсэн нь Өүлэн эхийн ухаанаас гадна Тэнгэрийн зарлиг байсныг Чингис хаан ойлгоод тайвширчээ. Өүлэн эх нь тэр үед Тэмүжинтэй уулзахгүй гэдгээ мэдэж байсанд одоо ч Чингис хаан гайхсаар байдаг билээ. Мөнөөх Тэнгэрийн тэмдэг болсон улаан чулууг түмний нүднээс нуух газрыг олохгүй, бас санахгүй явсаар Хорезмд ирсэн билээ. Гэтэл гэнэт энэ газрын Барыгжан уулын оройд нуухаар Чингис хаан шийджээ. Аллах гэж байдаг бол тэр энэ Тэнгэрийн тэмдгийг танихгүй тул чухам энд нуух нь гарцаагүй зөв гэж бодсон ажээ. Ганц түүнд заяасан Тэнгэрийн тэмдгийг хэн нэгэн олж дахин эзэмших вий гэж болгоомжилсон нь Өүлэн эхийн үрээ гэсэн сэтгэл байв. Үүнийг Чингис хаан ойлгожээ. Хожим хойно түүний урагтай өрсөлдөх хүмүүн гарч ирэхийг хэзээ ч тэвчихгүй билээ. Одоо энэ Барыгжан уулын оройгоос хэн олох билээ. Өөрийнхөө атгаж төрсөн Тэнгэрийн тэмдгийг Барыгжан уулын оройд сайтар булаад санаа амарч босох гэтэл гэнэт ард нь агаар хөдлөн хүн дуудах шиг болсонд үс босож үнхэлцэг хагарах шахжээ. Чингис хаан айсан, цочсондоо тэр дороо эргэн харж чадсангүй. Яах аргагүй хэн нэгэн

-Тэмүжин. Чи юу гэж дуудах сонсдох шиг болж билээ. “Аллах тэнгэр гэж байдаг аж” гэж бодож амжжээ. Түүнд босож эргэн харахаас өөр арга үлдсэнгүй. Түүний ард хэн ч байсангүй. Ганцхан хэн нэгэн тэнгэрийн хүнээс аяархан шивнэхийг олж сонсжээ. Үүнээс өмнө Тэмүжиний тэнгэрээс олж сонсдог байсан тэр дуу биш байлаа.

Чингис хаан яг зүүдэлж байх шиг болжээ. Зүүдлээд зогсохгүй Өүлэн эх нь сэрээх гэж духан дээр нь үнсээд аяархан дуудаж байх шиг болжээ. Түүнийг гүн нойрноос арайхийн сэрмэгц Тэнгэр

-Тэмүжин. Хөвүүн чи даруй нутагтаа буц. Очоод хаашаа ч явахгүй нутагтаа суу. Хөвүүн чиний явах газар, үзэх нутгийн тоо гүйцжээ гэж тов тод хэлэх нь сонсогджээ. Дараа нь нам гүм болсон бөгөөд бороо шиврэн орохыг мэдэрчээ. Тэр нэг л мэдэхэд Боорчийн хамт сүйх дотор явж байжээ. Чингис хаан, Тэнгэрийн хүчинд авган хэсэг зуур ухаан алдсан нь тэр байв. Хачирхалтай нь өнөөх Тэнгэрийн тэмдгээ гартаа тас атгасан байжээ. Харин өргөөндөө хүрэх зам зуур нэгэн гайхалтай зүйл мэдэрчээ. Гартаа атгаж явсан өнөө Тэнгэрийн тэмдэг болох бөөрөнхий улаан чулуу гэнэт халуу оргиж байхыг анзаарчээ. Тэнгэрийн тэмдэгнээс халуун урсгал оргилон алгаар нь дамжаад бүх биед нь тархаж бүр зүрхэнд нь цутган орж байхыг мэдэрчээ. Чингис хаан хөдөлж үг дуугарч чадахгүй болов. Чулуу халсаар сүүлдээ бүр атгасан гарын нь хуруунууд нэвт гэрэлтэж үзэгдэхэд гараа хормой дороо хийн Боорчиос нуусан билээ.

Харин Тэнгэрийн тэмдэг удалгүй хуучин хэвэндээ оржээ. Гэвч биед нь шингэсэн дулаан илч

хэвээр үлджээ. Өргөөндөө ирмэгц хэнтэй ч уулзалгүйгээр болсон явдлыг тунгаан бодож өдөржин суусан билээ. Тэнгэрийн тэмдгийг буцаан авчирсныг бодвол Барыгжан ууланд хадгалахыг Тэнгэр таалсангүй бололтой. Харин бодсоор байтал “Нутагтаа буц, Дахин явалгүй суу” гэж тов тодорхой хэлсэн нь Өүлэн эх нь байсанд итгэжээ. Нэгэнт Өүлэн эхийн сүнс ирж уулзсан тул Барыгжан уулын нэрийг өөрчилж Тэнгэр уул болгоод хүн гарахыг хориглосон цааз зарлиг буулгахаар шийдэв. Тэр өдрийн үдэш гэхэд Чингис хааны сэтгэл санаа цэлмэн гийгээд урам итгэл төгс болж бас ингэсэн учрыг эхийнхээ өгсөн Тэнгэрийн тэмдэгтэй холбон ойлгож боджээ. Тэнгэрийн тэмдэгнээс урсан гарч биед нь шингэсэн тэр халуун илч бол Өүлэн эхийнх нь сэтгэлийн хайр энэрэл болохыг Чингис хаан тод мэдэрсэн билээ. Өүлэн эх нь түүнтэй уулзахын тулд, хагацахын өмнө түүний атгаж төрсөн Тэнгэрийн тэмдгийг өгчээ. Энэ бол Тэнгэрийн тэмдгээс гадна Өүлэн эхийнх нь бие сэтгэлийн тасархай байлаа. Эх нь Тэнгэрийн тэмдэгт өөрийн бүх хайр хүсэл, үлдсэн амь нас, амьдралаа шингээж өгчээ. Тийм ч учраас хаана залахыг өөрөө мэд хэмээжээ. Өүлэн эх нь өөрийн үлдсэн насыг Тэмүжин хөвүүндээ үлдээгээд амиа егүүтгэснийг, тэр амьдрал нь Тэнгэрийн тэмдгээр дамжин Чингис хааны биед шингэснийг ойлгожээ. Гэтэл Чингис хаан эхийнхээ ухааныг дутуу ухаарч өндөр уулын оройноос цааш сэтгэсэнгүйдээ ихэд харамсжээ. Бас бодсоор байсан ч эхийнхээ хэлсэн “Хүн харж хөл хүрэхгүй газар” гэсэн нь юу болохыг таасангүй. Лав өндөр уулын оргил биш болжээ. Өүлэн эхийн сүнс түүнийг Тэнгэр уулын оройд мунгинаж буйг үзээд яаран ирж түүнд тусалжээ. Өүлэн эхээс өөр хэн ингэж хол гүнзгий сэтгэхийг Чингис хаан мэдэхгүй билээ. Өүлэн эхийнхээ ухааныг одоо ч гүйцэд ухаарч чадахгүй байгаадаа Чингис хаан өөрийгөө ихэд голжээ. Өүлэн эх нь түүнийг нутагтаа ирж суухыг хүсчээ. Чингис хаан ч нутагтаа очихыг туйлаас хүсч байв. Эх нь түүний сэтгэлийг ойлгоод дууджээ. Ингэж бодоод Чингис хаан нэгэнт эргэлзэхгүй болсон билээ. Тэнгэрийн тэмдгээ Өүлэн эхийнхээ сэтгэл гэж бодож бугуйнаасаа оосорлоод үргэлж атгаж явах болжээ. Шөнө ч гараас салгахгүй болсоор тайван унтах болов. Тэр яг бага насандаа эргэн очсон мэт Өүлэн эхдээ тэврүүлэв гэж зүүдлэн нойрсдог болсон ажээ. Хулан хатны сүнс ч сураггүй болж мартагджээ.

Одоо энд Яргай балгасын дэргэд сууж ахуйдаа анх Тангуд улсад дайлаар мордох хэргийг өөрийн биеэр удирдан явахаар шийдсэнийг эсэргүүцэгчид нэг биш байсныг Чингис хаан байн байн санах болж өнөөх Тэнгэр уулын оройд сонссон Өүлэн эхийнхээ үгтэй холбоотой юм биш биз гэж сэжиглэжээ. Чингис хааныг нутагтаа суухыг Тэнгэр хэлсэн билээ. Гэхдээ нутгаасаа явбал яахыг хэлсэнгүй. Гэтэл нутаг гэсэн нь чухам ямар газар болохыг цохож хэлсэнгүй. Хорезм ч Чингис хааны нутаг. Тангудыг эзлэн авбал тэр мөн түүний нутаг болно гэж тэрээр итгэж байв. Тэнгэрийн үгийг санаж байсан ч энэ мэт тайлбар шалтгааны улмаас Тангуд улсад өөрийн биеэр морилж их үгт Буур хаанаас ял асуух ёстой гэж тэр эцэст нь эргэлтгүй шийдсэн билээ. Хорезмыг ялсан Монголын их цэрэг дахин цугларахыг үзмэгц Чингис хаан үнэхээр онгод хийморь нь сэргэж сүр хүч төгс болоод Тэнгэрийн үгийг мартжээ.

Түүнд огт өөр хүсэл зорилго байв. Тангуд улсыг дайлах нь Чингис хааны эртний их бодлогын үргэлжлэл, Монголоос дорно, өмнө зүгт их далай хүртэл оршин байгаа Алтан болоод Сүн улсыг эзлэн нэгтгэх их аян дайны бэлтгэл, эхлэл болох байлаа. Энэ их зорилго Чингис хааныг гэртээ сууж чадахгүйд хүргээд зогссонгүй Тэнгэрийн зарлигийг умартахад ч хүргэжээ. Чингис хаан өөрийн бодлого зорилгыг бүхнээс дээгүүр, бүр Тэнгэрийн зарлигаас дээгүүр тавих болсон нь Хорезмд аялсан долоон жилийн их дайнаас өмнө бий болсон сэтгэлийн их

өөрчлөлт байв. Сэтгэл санаа, үзэл бодлын гүнд суусан ийм өөрчлөлт нэг мөч, нэг сар, нэг жилийн дотор хурдан түргэнээр гэнэт бий болдоггүй тул хүн өөрөө мэдэрч чаддаггүй ажээ.

Номхон далайгаас газар дундын тэнгэс хүртэл өргөн их газарт Их Монгол улсын нутаг тэлж энэ нутагт оршин суугаа хэл, соёл өөр ард олон, үндэстэн ястан бүгдээр Чингис хааны тогтоосон хууль цаазын дор нэгдэн амьдрах болсон нь түүнийг ингэж хувирган өөрчилж байгааг Чингис хаан мэдсэнгүй.

Дөрвөн их усны хооронд орших энэ хавтгай газар хэдий уудам ч удахгүй бүгдээрээ түүний хүчний дор нэгдэн нэг улс болно гэдэгт бат итгээд одоо энэ их зорилгоо биелүүлэх гэж яарч догдолж байлаа. Ингэж бүх дэлхийг нэгтгэх нь эрт дээр үеэс уламжлагдан ирсэн Алангуа эхийн домогт чухам Тэмүжин түүний тухай өгүүлснийг батлаад зогсохгүй хожим хойно Тэмүжин гэж Хамгийг эзлэсэн хаан байжээ гэж дуурсагдахын бат үндэс болох учир Чингис хаан ингэж улайрчээ. Түүнд одоо айж ичих хүртэл нэгэнт үгүй болжээ. Гэвч Тангуд улсад өөрийн биеэр морилох нь юунд хүргэж болохыг тэр даанч таамагласангүй билээ. Үнэхээр тэр нэгэнт Тэв Тэнгэр бөөгийн адил билгийн нүд, ид шид үгүй тул бүхнийг урьдчилан тааж чадахгүй нь гачлантай. Тангуд улсад морилохыг Бөртэ эрс эсэргүүцсэн билээ.

Тангуд улсыг дайлах хэргийг Бөртэ, нэгэнт хаан суурийг залгамжлахаар тохоогдсон Өгөдэйд даалгах хүсэлтэй, энэ нь Өгөдэйд сайхан сургууль хүмүүжил олгож олны дундаас товойлгон нэр сүрээ бэхжүүлэхэд тустай гэж үзэж байв. Бөртийн санасан үнэхээр зөв мэргэн ухаан байлаа.

-Тангудын Буур хаан, Чингис хаан миний элчид их үгээр хариу хэлж цэрэг гаргаагүй учир би өөрийн биеэр түүнээс ял асууна гэж Чингис хаан санаанаасаа ухарсангүй. Их үгт Буур хааныг өмнөө сөхрүүлж амыг нь асууж бах таваа хангахыг Чингис хаан туйлаас хүсч байв. Ийм боломжийг өөр хүнд олгож, алдар нэрээ хэнтэй ч хуваалцахыг тэр хүссэнгүй. Олон жилд олсон ялалт амжилт нь Чингис хааныг дотроос нь идэж бардамнаж, бах таваа хангах бүгдийг ялж дийлэх муу хүсэлд идэгдээд байгаагаа тэр мэдсэн ч ойлгож ухаарахыг хүссэнгүй. Тангудыг эзлэх тийм хялбар биш ч бас бүх цэргээ Чингис хаан өөрөө удирдан явах илэрхий шалтгаан байсангүй. Алтан улсад арван хэдэн жил байлдаж туршлагажсан Мухулайд цэрэг нэмж илгээхэд л болох байв. Гэвч Тангуд улсад их хүчээр довтлон орвол тэднийг богино хугацаанд эсэргүүцэлгүйгээр буулган авах, ингэснээр хил залгаа Алтан улс, Сүн улсад нөлөөлж тэдний эсэргүүцэл зоригийг мохооно гэж Чингис хаан үзжээ. Ингэх нь алс хэтдээ Алтан болоод Сүн улсыг эзлэн авах зорилгод нь нийцсэн тул ийм тайлбарын дараа Чингис хааны үгийг эсэргүүцэх хүн Их хуралдайн үеэр гарсангүй. Харин Боорчи дув дуугүй байсан нь дотроо Чингис хааны үгийг сайшаасан хэрэг байв. Ингээд Монголын их цэрэг Тангудад довтлох нь гарцаагүй болсон билээ. Цагадай өөрийн улсаас цэргээ хөдөлгөн Тангуд улсын баруун талаас Өгөдэй өөрийн цэрэгтэй хойт талаас, харин Чингис хаан өөрийн цэргээр зүүн хойт талаас нь довтлохоор их хурилдай шийдвэрлэсэн ч үүний өмнө Чингис хаан сурсан ёсоор Тангудын Буур хаанд элч илгээн дагаж орохыг тулган шаардсанд Тангудын хаан, жанжин Аша-Хамбынхаа үгэнд автан нөмрөн ирэх үхлийг тоолгүй

Алт эрдэнэс хэрэгтэй бол Аржуд ирэгтүн

Тэмээ мал хэрэгтэй бол Алашад ирэгтүн

Тэнд байлдъя гэж хариу өгүүлсэн нь Монголын цэргийн хөдлөх дохио болов. Тангудад явахдаа Чингис хаан Есүй хатнаа асралтай гэж дагуулж явсан нь ганц Бөртийн зөвлөснөөр ч болсонгүй цаанаа нууц зорилго агуулж байв. Гэвч энэ нууцыг Чингис хаан ганцаар мэдэх билээ. Монголын цэрэг намар орой хөдөлж урд зүг алгуур урагшлах зуур ан авлаж, хүнс хоолоо базааж явжээ. Энэ бардам итгэлтэй хөдөлж цөхсөн их аяны цаана гэнэтийн ямар аюул нуугдаж байгааг Чингис хаан гадарласангүй. Их цэргээ дахин цуглуулж өөрийн болоод хөвүүдийнхээ гарт атгуулсандаа тэр хөөрөн бахдаж байлаа. Их цэргээ дахин цуглармагц Чингис хаан урьдын адил итгэл төгс, омог заль дүүрэн болохоо мэдэрч одоо их цэргээ дахин тарааж болохгүй гэж тэр шийджээ. Нарны дор эзлэн нэгтгэсэн их улсыг нь тогтоон барьж торгоон зогссоох хүч бол ганцхан хүчирхэг цэрэг байв. Их цэргийг тэжээхийн тулд их хоол хүнс, хөрөнгө зоорь шаардагдана. Үүнийг бусдаас булаан авахаас өөр арга Чингис хаанд байсангүй. Цэргийн нэр сүр, алдар хүнд эрдэм чадлыг бат байлгах нь түүний их улсын оршин тогтнох баталгаа учир цэргийг асрахад юуг ч хайрлаж болохгүйг Өгөдэйд хатуу сургах ёстой болжээ. Чингис хааны олсон амжилт ялалтын үндэс нь үнэнч нөхөд, цэргүүд байлаа. Үүнээс хойш мөн л ийм байх болно гэдэгт Чингис хаан итгэлтэй байв.

Харин Чингис хаан түүний үгэнд оролгүй Тангудад явах болсонд Бөртэ ихэд гомджээ. Ер нь Хорезмоос эргэн ирэхдээ Тэмүжин хачин их өөрчлөгдөж өвгөрч хөгширсөн байлаа. Тэмүжиний бодол болсон үрчлээт царай, буурал үсийг харах бүр Бөртэ түүнийг өрөвдөх болжээ. Залуу цагийн омог, сүр төгөлдөр төрхөөс юу ч үлдсэнгүй. Түүний хамаг сүр жавхаа, хийморийг Хорезмын халуун тэнгэр, Хулан хатан хоёр авч одсон мэт үзэгдэнэ. Тэр мэргэдийн гайт эмийг дагуулснаас ийм болов гэж Бөртэ дотроо бодох ажээ. Үнэхээр Хорезмоос ирснээс хойш Чингис хаан Хулан хатнаа ихэд үгүйлэн дурсах болсон нь илт ажиглагджээ. Хэдий Хулангийн өргөө түүний эд юмсыг шатаасан ч Хуланг мартаж янзгүй байв. Ингэх болсны цаад нарийн учрыг Бөртэ таамагласангүй. Сүүлийн үед Хулан хатныхаа сүнсийг Чингис хаан хачин ихээр үгүйлэн шөнө нойргүй хонох болжээ. Хэдий өвгөрч эр биеийн чалх харьж яваа ч Чингис хаан хатдынхаа хүсэл тачаалыг хангасаар ажээ. Хэдий бүх юм хуучнаараа эрхлэн янаглах нь янзандаа ч Хулан хатны нь сүнс шөнөөр ирж хүслийг нь хангадаг байсан шиг тийм таашаалыг амсахгүй болжээ. Гэвч Хулан хатны сүнс эргэн ирэхгүй бөгөөд хатныхаа сүнсийг өөрөө хөөж явуулсандаа одоо харамсаад ч барахгүй болжээ.

Чингис хаан Тангудад морилохын өмнө ирж хоносон шөнөө Хуланг зүүдэлж хар даран хашгирсныг Бөртэ өглөө нь түүнд хэлэлгүй өнгөрчээ. Харин энэ зүүдний учрыг төв хүрээнд байх бөөгөөр мэргэлүүлж үзвэл Чингис хааны сэтгэл Хулан хатандаа тэмүүлсээр буйг хэлж тэр даруйд түүдэг асаан сэтгэлийг тайтгаруулах арга засал хийжээ. Бөртэд үүнээс өөрийг хийх чадал байсангүй. Чингис хаан мордохын өмнө Төв улсаа Бөртэ хатан, отгон хөвүүн Тулуйн хамт захиран суухыг зарлиг буулгаж бас түмэн цэрэг үлдээв. Энэ нь түүнийг төрийн Их хатны ёсоор хүндлэн үзсэн хэрэг юм. Хэдий Зүчи хөвүүн нь үхсэн ч Бөртэ Батын дэргэд очиж үзээд сэтгэл нэгэнт тайвшран Чингис хаанд талархан мөргөсөн билээ. Тэр амалснаа биелүүлж Зүчи хөвүүнд нь муу юм хийсэнгүй, Зүчи өөрийн үхлээр үхжээ. Үүнийх нь төлөө Бөртэ Тэмүжинг эгнэгт уучилж түүнд ганцхан сайныг хүсэх нэгэн үзүүрт сэтгэлийг өвөрлөн Төв улсаа захиран суух болов. Бас Зүчийн хөвүүн Бат эцгийнхээ орыг залгамжлав. Отгон хөвүүн Тулуй нь Төв улс, эцгийн голомтыг сахин сууж байна. Цагадай хөвүүн нь алс хол их улсын баруун хилийг захирах болов. Эм хүнд үүнээс илүү хүсэх юм гэж юу билээ. Бөртэ сая л нэг өөрийгөө аз жаргалтай хүн гэж тооцох болжээ.

Ганцхан сэжиглэлтэй зүйл илэрсэн нь Боорчийн өргөмөл хүү Гэрэг болжээ. Каспийн тэнгис хүрэх аяны их замд хамгаалан явсан тэр гавшгай гялалзсан залууг харсан цагаас эхлэн хэнтэй ч юм бэ адилхан санагдаад болсонгүй билээ. Эхийнх нь нэрийг асуухад тэр Хадаан гэсэн нь Бөртийн эргэлзээг нэгэнт тайлжээ. Хадаан нэрт бүсгүй хаана хичнээн байж таарахыг мэдэх аргагүй юм. Гэрэгийн эх нь үхэж тэр ах дүү ч үгүй өнчин хоцорчээ. Хадааны гэнэт сураггүй алга болсны учрыг Бөртэ ингэж хэдэн жилийн дараа олох шиг болжээ. Хэдий итгэл муутай ч байж болмоор санагдаад Гэрэгийг ихэд ажиглах болжээ. Бөртийн ажигласнаар тэр хөвүүн Тэмүжинтэй тун ч төстэй нь илт байжээ. Төрөөгүй байхад нь тэр бүү хэл эхийн хэвлийд оллоогүй байхад нь алах гэж өширхөн хөөцөлдөж байсан хөвүүн одоо нэгэнт хорь хүрээд Чингис хааны их шадар Боорчийн нэрэн дор явааг үзээд Бөртэ эхлээд итгэж чадаагүй билээ. Олон хоногийн хол замд бодсоор явсны эцэст Бөртэ энэ хэргийг үнэн гэж итгэхээр шийдэв. Гэвч эрхгүй ирсэн амьдралын жамыг эсэргүүцэн тэмцэхийг хүссэнгүй. Бөртийн сэтгэл санаа ихэд өөрчлөгджээ. Гэсэн ч тэр өөрийгөө буруутгасангүй. Харин тэднийг уучлан өршөөхөөр шийджээ. Ингэж бодвол Гэрэгийг Хадааны хөвүүн гэдэгт итгэхэд амар санагджээ. Эцэг Сорхоншар, Чулуун Чимбай хоёр ах нь Хадааныг үхсэн гэж тооцоод дотроо Бөртийг хардсаар явааг тэр мэддэг байв. Сорхоншар үхтэл үр харам гэгчээр Хадаан охиноо санан голоо эмтэлж, сэтгэлийн мухарт Бөртийг алуулав гэж итгэж хорсовч яаж ч чадахгүй явсаар хэдэн жилийн өмнө үхжээ. Харин Бөртэ, Сорхоншарыг Хадаан охиноо нууж харагдахгүй газар аваачсан гэж хардаад ийш тийш эрэл сурал тавиад сүүлдээ цөхөрчээ.

Гэрэгийг Бөртэд бараалхуулж хол замд хамгаалан явна гэж үг сургаал хэлэх болоход тэр залуугийн хачин танил төрх нүдэнд нь шууд унасан билээ. Энэ яг өнөө Бичэлдэйг үзсэнтэй адил хэрэг болжээ. Эхлээд Бөртийн өмнө Гэрэгийг хэрхэх вэ гэсэн асуулт тулгарав. Гэрэгийг өөрийн хөвүүн гэдгийг Тэмүжин мэдэхгүй байгаад Бөртэ эргэлзэж эхлэв. Өөрийн төрсөн үрийг нүдний нь өмнө зогсож байхад танихгүй баймгүй мэт санагдаад болсонгүй. Гэвч танилаа гээд Гэрэг түүний хөвүүдэд өрсөлдөгч болж чадахгүй нь нэгэнт тодорхой тул тэр гэмгүй хөвүүнд хор хийхгүй байхаар Бөртэ эцэст нь шийджээ. Учир нь өөрийн төрсөн хүүгүй Боорчи, Гэрэгийг олсондоо ямар их аз жаргалтай байгааг ойлгоод “Энэ лав Тэнгэрийн хүсэл биз” гэж бодон бүх илүү санаагаа мартжээ. Түүний сайхан санан илгээсэн Чилэгэр бөхийн ач хөвүүн Бичэлдэйг Зүчи алж орхисныг очсон хойноо Батаас сонсоод Бөртэ ихэд харамссан нь Гэрэгийг зүгээр орхиход хүргэв. Цагийн эрхээр нас ахиад Бөртэ уян зөөлөн болжээ. Тийм учраас Гэрэгийг Тэнгэрт даатгав. Өөрт нь учирсан аюул холдсоныг мэдээгүй Гэрэг Чингис хааныг хамгаалах мянган цэргийнхээ өмнө баяртайгаар оджээ. “Хөвүүн чи өөрийнхөөрөө амьдар даа. Хадаан эх чинь чамайг хараад баясаж яваг” гэж Бөртэ Чингис хааныг үдэхдээ дотроо хэлжээ. Ингэж Гэрэгийн амьдрал шийдэгдэв. Харин Гэрэг өөрийгөө Боорчийн хөвүүн гэдэгт эргэлзэлгүй итгэсэн бөгөөд одоо түүн шиг аз жаргалтай хүн Чингис хааны арван найман түмэн цэргийн дотор байсангүй билээ. Чингис хааны торгон цэргийг хуучин хэвээр Боорчи удирдаж харин Чингис хааны гэр тэргийн зүүн талд Зэлмийн хөвүүн Есөнтэйн мянгат, баруун талд Боорчийн хөвүүн Гэрэгийн мянгат хамгаалан явж байхыг Чингис хаан зарлиг болгожээ.

Гэрэгийн мянгат Чингис хааны амь биеийг хамгаалан явах үүрэгтэй тул ямарч үед хааны дэргэдээс үл холдоно. Өнөөх хулангийн аваар Гэрэг хамгийн шилдэг зуун цэргийнхээ хамт Чингис хаанаас хэдхэн алхамын зайтай хулан шахаж явжээ. Чингис хааны цэрэг Тангуд руу аялан явах зам зуурт хулан авлах цаг таарсан нь Чингис хааны болоод түүний шадар нөхөд

ерөөс монголчуудын хувьд юу авчрахыг хэн ч урьдчилан мэдэх аргагүй байв. Хэрэв Тэв Тэнгэр бөө байсан бол Чингис хааныг хулан авлахаар бүү яв гэх байсан биз ээ. Чингис хаан суугаа амьдралаа сэргээж хийморио бадраахаар зост буурал мориндоо мордон давхижээ. Талын энгээр тархсан тоо томшгүй олон хулангийн сүргийг торгон цэргүүд бүслэн шахаж Чингис хаан болоод харваач цэргүүдэд дөхүүлэн өгчээ. Ан хийх нь угаас монгол цэргийн дайтах байлдах сургуулийн нэг хэсэг тул бүгдийг яг л атаатан дайсантай тулалдаж байгаа мэт чанд бэлтгэдэг билээ. Энэ удаад ч яг тэгэж бэлджээ.

Чингис хааны дэргэд Гэрэгээс гадна нум сум баригч дөрвөн цэрэг дагалджээ. Эднээс хорь гаруй алдын цаана торгон цэргүүд гудамлан эгнэн зогссон нь хүн хашаа мэт болоод тэдний дундуур шахагдан орж ирсэн хуланг Чингис хаан хөөж морины явдал дунд харван намнах ажээ. Чингис хаанаас мултарч өнгөрсөн хулангийн сүрэг дараагийн хүн хоолойд шахагдан ороход сая цэргүүд харваж эхлэнэ. Энэ бол ангийн нэгэнт тогтсон дэг жаяг юм. Олон мянган зэрлэг адгуусны туурайн чимээ тэнгэр дуугарахын адил нүргэлээд хүн морьдын зүрхийг хөөргөнө. Зэрлэг адууны түрүүнд хонгор соёолон азарга манлайлан үхлийнхээ зүг давхиж явлаа. Сүргийн дотроос хамгийн зоригтой, хүч чадалтай нь ингэж үхлийн өөдөөс нүдээ цавчихгүй дайран ирэхийг харах үнэхээр бахтай байдаг билээ. Сүргийн манлайг харван алах нь Чингис хааны ганц хүслэн юм. Тэр өдөр яг анх удаа хулангийн сүргийг тосож зогсоо мэт догдлоод манлайлан довтлогч хулангийн азаргыг оноон харж нумаа татахад бэлдэж байв. Хүн адгуус хоёрын зай ойртож азарганы сарталзсан хамар дүрэлзсэн нүд харагдаж эхлэв. Хормын дотор Чингис хаан зөвхөн тэр дүрэлзсэн нүднээс өөр юу ч харж, юу ч сонсохгүй болжээ. Хулангийн азарга хэдхэн алхам дөхөн ирээд шаасан гадас мэт зогсоход сүрэг нь ч зог тусав. Хулангийн сүргийн хөлөөр боссон хөшиглөсөн их тоос тэр даруй нөмрөн ирээд ойр зуурын зүйл үзэгдэхгүй болсон ч Чингис хаан өнөөх дүрэлгэр нүдийг ширтсээр сумаа тавьж чадахгүй морьтойгоо эргэлдэж олон хулан түүнийг тойрон давхиж байлаа. Гэнэт Чингис хаан нумаа хаяж мориныхоо амыг гэдийтэл татан цочлоо. Түүнээс хэдхэн алхамын цаана Хулан хатан нь инээмсэглэн гараа сунгаад зогсож байв. Хулан хатны хөлийн өлмийд өнөөх догшин азарга толгойгоо тавьж сөхрөхийг үзжээ. Хулан хатан азарганы нуруун дээр гишгэж тэр нь огт хөдлөхгүй Чингис хааныг ширтэх ажээ. Гэтэл нүд ирмэж амжаагүй байтал хулангийн сүрэг дундаас тас хар зүсмийн азарга дүүлэн гарч ирээд шүднээсээ гал улалзтал янцгаан Чингис хааны зүг дайрчээ. Хар азарганы хөлд Хулан хатан нь дайрагдан унахад Чингис хаан

-Хулан гэж хашгираад ухасхийжээ. Гэтэл зост буурал морь нь огт санасанаар болсонгүй гэнэт бухан түүнийг унагахад дотор нь бачууран ухаан балартжээ. Хэн нэгний зөөлөн гар нүүр хүзүүнд нь хүрч байх шиг санагдсан билээ. Хар азарга эрчээрээ Чингис хааны хамгаалагч цэргүүдийг цавчлан дайрчээ. Хэрэв Чингис хаан мориноос унаагүй бол хар азаргын туураинд цавчигдан үхэх байжээ. Хар азарганы унгалдах дуунаар хулангийн сүрэг хашлагаа эвдэх үерийн ус адил дайрчээ. Энд ан биш адгуус хүн хоёрын аймшигт тулаан болжээ. Битүү тоосон дундаас Чингис хааны “Хулан” гэж аймшигтайгаар бахирахыг сонссон Гэрэг дагуулуудын хамт тоосон дунд хар таамгаар дайран оржээ. Тэр дороо л бүгд аймшигт авгаж ухаан алджээ. Чингис хаан хулангийн сүргийн хөлд дайрагдан үхсэн нь нэгэнт тодорхой болжээ. Галзуурсан хулангийн сүргийн дундуур орох нь үхсэнтэй яг адил хэрэг юм. Тоос алгуур намдтал бүгд дуугүй зогсоцгоов. Тэгтэл тэднээс ердөө хэдхэн алхамын цаана хулангийн сүргийн мөр гараагүй эрүүл газарт Чингис хааны хэвтэхийг харжээ. Дэргэд нь хулангийн хар азарга үхсэн хэвтэнэ. Гэрэгийн дотор аймшиг төрлөө. Тэр өөрийнхөө төлөө

айсангүй. Цалгардаж Чингис хааныг үхүүлсэн байвал юу болохыг тэр төсөөлсөн билээ. Гэрэг Чингис хааны дэргэд очиж сөхрөн суув. Чингис хаан тэр халуун өдөр ердөө л дан нимгэн торгон цамцтай явсан нь шороо болжээ. Чингис хаан үхсэнгүй ажээ. Тэрээр нүдээ алгуур нээж Гэрэгийг тогтоон харснаа таниж

-Хөвүүн. Чи намайг босго гэж шивнэжээ. Чингис хаан эв эрүүл сав саруул зөвхөн хувцас нь шороо болж бас үхсэн азарганы цусанд будагдсан төдий байжээ. Чингис хааныг ийн зүв зүгээр байхыг үзээд Гэрэг асгартал эхэр татан уйлжээ. Энэ бол эзэн хаанаа гэсэн үнэнч цэргийн чин сэтгэлийн баярын нулимс байсан тул Чингис хаан тэр залууг ихэд хайрлан өрөвдөж билээ. Тэр бүү хэл амьдралдаа өөр хэнийг ч ингэж хайрлан өрөвдөөгүй мэт тэр зуур санагдсанд их гайхжээ. Тэгээд болсон хэрэгт Гэрэгийг огтхон ч буруутгаагүйгээр барахгүй Боорчийн хөвүүний эхэр татан уйлсныг санах бүр Есүхэй эцгээ үхүүлээд бархирч хэвтсэн нь бодогдож, үзэгдээд зүрх нь шимширдэг болжээ. Гэрэгийн айсан бас баярласан харц бүр сэтгэлд нь хадагдаад ер миний хөвүүд намайг үхэхэд энэ Гэрэг шиг уйлах болов уу гэсэн хачин жигтэй бодол төржээ. Мориноос унахын хажуугаар Чингис хааныг айлган цочоосон нэг хэрэг болсныг тэр хэнд ч хэлэлгүй тас нуужээ. Учир нь тэр нууцыг ганцхан Чингис хаан өөрөө л мэдэх бөгөөд санаж мэдэх хүн одоо Боорчоос өөр үлдсэнгүй ажээ. Мориноос унасан нь ашгүй гэмгүй мэт өнгөрсөн ч Чингис хааны биеийн байдал ихэд өөрчлөгдсөн байв. Гэвч түүний сэтгэл санаа түүнээс ч хүнд, бүр эдгэшгүй цочирдон өвдсөнийг хэн ч, тэр бүү хэл Чингис хаан ч мэдсэнгүй. Монгол хүн мориноос унаад бэртэнэ үү гэхээс үхнэ гэж байхгүй гэж тэд ярилцдаг ч сүүлийн сард Чингис хааны бие чилээрхэн, зан ааш хувирсныг мориноос унасантай холбон бодох болжээ. Үүнээс өөрөөр үзэх шалтгаан байсангүй.

Харин Хулан хатны сүнс салахгүй дагасаар байсан нь хулангийн авын үеэр тохиолдох байсан гарцаагүй үхлээс аврахын тулд байжээ гэдэгт Чингис хаан баг итгээд Тэнгэрт талархан мөргөжээ. Мөнөөх аймшигт хар азарганы омруунд зоолттой байсан хутгыг хэн ч танисангүй. Тэр гоёмсог урт чичлүүр хутгыг торгон цэргүүд тэр бүү хэл Боорчи ч өмнө нь хараагүй байв. Алтан бариул, эрдэнийн чулуун чимэгтэй тэр хутга бүсгүй хүнийх л баймаар тул Боорчи эргэлзэж эргэлзэж Чингис хаанд хэлжээ. Ерөөсөө хулангийн авын үеэр Чингис хаантай тохиолдсон хэрэгт нууц зүйл олон байлаа. Чингис хаан хутгыг үзээд удаан дуугүй сууж сууж

-Тиймээ. Энэ хутгыг би санаж байна. Түүнийг надад Тэнгэр илгээжээ гэснээс өөр үг хэлээгүй билээ. Тэнгэр илгээсэн гэсэн нь хутгыг хэлэв үү хутганы эзнийг хэлэв үү гэдэг нь бас л нууц үлджээ.

### *ОЛГОЙ ХАГАРАВЧ ТОГООН ДОТОР*

Тангуд улсын Буур хаан тийм амар санаагаар бууж өгсөнгүй. Цагадай Өгөдэй хоёрын нэгдсэн цэрэг Тангудын баруун хязгаарын Сижоу балгасыг бүслээд сар илүү суув. Өндөр уулын бэлд тулган барьсан Сижоу балгасыг дайран эзлэхэд бэрх ажээ. Гэтэл Яргай боомтын дэргэд хүрээд байсан Чингис хааны бие чилээрхэж хэвтэрт орсон нь Монголын цэргийн довтолгоог сааруулжээ. Чингис хааны шадруудын санаа хоёр хуваагдаж нэг хэсэг нь Тангудыг дайлахгүй орхин буцаж хааны биеийг эдгэртэл хүлээхийг шаарджээ. Гэвч энэ хэргийг Чингис хаан огт зөвшөөрөөгүй тул тэд Цагадай Өгөдэй хоёрыг дуудуулахаар тохирч Боорчи Чингис хаанд бараалхан айлтгав. Чингис хаан өөрийн хэвтрийн дорой байдлыг Есүй хатнаас өөр хэнд ч үзүүлэхийг хүссэнгүй ажээ. Боорчийн үгийг сонсоод тэр маш ихээр хилэгнэсэн боловч Есүй



хаган

-Хаан та хөвүүдийнхээ үгийг сонсохгүй бол хэн тэдний үгийг сонсох билээ. Одоо бид Цагадай Өгөдэй хоёрын эзгүйд энд юугаа хэлэлцэх билээ гэж аргадан учирлан хэлснийг сонсоод уужирч тэдэнд өөрийн нэрээр Гэрэгийг илгээн даруй ирэх зарлиг буулгажээ. Яагаад Гэрэгийн нэрийг дурдсаныгаа тэр үедээ анзаарсангүй билээ. Зүгээр л Боорчийн хөвүүний нэр, дүр цээжинд нь хоногшоноос тэр байв. Гэтэл Сижоу балгасыг эзлэх гээд улайрч байсан Цагадай Өгөдэй хоёр Гэрэгийг буцаж ирснээс хойш дахин сар саатаад сая л нэг Чингис хааны хээрийн өргөөнд иртэл Чингис хаан хилэгнээд тэднийг бараалхуулсангүй өнжжээ. Чингис хааны бие жаал илааршин наашилсан ч босож явахаар болоогүйн дээр өвчиндөө шаналж гутраад уур уцаар ихтэй болжээ. Дуудмагц ирсэнгүй гэж хилэгнэв гэж Цагадай Өгөдэй хоёр бодож байв. Чингис хаан эцэг нь хилэгнэсэнд баахан эмээсэн тэд зүгээр зогсоод байж чадсангүй уулзаагүй удсан Есүй хатанд бараалхаж бэлэг сэлтээ өргөжээ. Энэ бол тогтсон хатуу ёс юм. Есүй хатан тэднээс сэтгэлийн айдас түгшүүрээ нууж чадсангүй уйлж бүх үнэнийг хэлжээ.

-Өнгөрсөн жил ирэх замдаа хулангийн авын үеэр осолдон мориноос унаснаас ийм хэрэг болов. Өөдгүй эм би хаан эзнээ харийн газар халамжлан явж чадсангүй. Тэр өдөр халуун байсанд хаан эзэн миний үгэнд оролгүй дан цамцтай яваад ингэж дотуураа хүнд гэмтлээ. Хөвүүд та нар намайг яаж ч зэмлэж шийтгэсэн гомдох зүйлгүй гэж эхэр татан уйлжээ. Эцгийгээ мориноос унаж бэртсэнийг тэд огт мэдээгүй байсан бөгөөд Чингис хаан энэ хэргийг тэдэнд дуулгахыг цаазалсныг ч хэлжээ. Цагадай Өгөдэй хоёрын уурлаж цочсон нь хэмжээгүй болоод ёс журмаа алдаж Боорчийн өргөөнд үсрэн оржээ. Тэдний юу болсныг Боорчи хараад мэдэв. Цагадай хамаг хэрэгт Боорчийг буруутган хилэгнэн хашгирчээ.

-Хаан эзнээ хамгаалах ёстой торгон цэргүүд энгийн хялбар ангийн үеэр ийм осол гаргасныг та юуны учир биднээс, Чингис хааны төрсөн хөвүүдээс нуув. Яагаад. Яагаад гэж Цагадай суусан ч үгүй хашгирчээ.

-Хаан эзнийхээ амь нас, алтан биеийг хамгаалж чадаагүй тэр гэмтэн этгээдийг надад тушаа. Би тэднийг хаан эзэндээ санаатай халдсан гэж үзэж төрийн цаазаар аваачна. Та юуны учир биднээс нууж тэднийг өдий болтол хаацайлан сууна вэ.

Боорчид хэлэх үг, эсэргүүцэх тайлбар олдсонгүй. Цагадайн хэлдэг түмэн зөв юм. Чингис хаан хориглоогүй бол Боорчи яг Цагадайн адил хийхсэн билээ.

-Хэрэв тэр гэмтэн этгээдийг цаазлахгүй аваас Боорчи таныг би Чингис хаанаас урвасан гэж үзнэ. Таныг ч бас төрийн цаазаар аваачвал зохино. Чингис хааны амь насыг та хариуцан суугаа биш үү. Мартсан бол би танд сануулж байна гэж Цагадай хэлээд үүд шидэн гарчээ. Харин Өгөдэй, ахыгаа хориглоогүй нь Боорчийг буруутган бодсоных юм.

-Дээшээ морил гэж Боорчийг зөөлөн хэлэхэд Өгөдэй тээнэгэлзлээ. Боорчийн гэрт үлдэх нь Цагадайн уур хилэнг улам шатаах тул тэр яг энэ мөчид Цагадайн талд оржээ. Бас Чингис хаан эцэг нь хамгийн ихээр хүндлэн тоодог шадар сайд Боорчитой учир бүрхэг хэргийн улмаас эвдрэн муудалцахыг хүссэнгүй тул

-Та өршөө. Бид ёс алдлаа. Ийм юм сонсоод цочиж балмагдсанаас болов. Би Цагадай ахын араас очье. Тэр уурандаа юу ч хийж мэднэ гээд гарчээ. Цагадайн хэлсэн үг бол олон жилийн өмнө Хүйтэн ууланд болсон тулалдаанд Тэмүжинг шархдахад Хасарын амнаас анх гарсан үг байв. Цагадай түрэмгий зоригтой, хэлснээс буцахгүй тул энэ хэрэг эцэстээ юунд хүрч төгсөхийг бодмогц Боорчи зэвхий цайн салгаллаа. Хайрлаж өсгөөд Тэмүжинээс хулгайлан авсан Гэрэг хөвүүнийг нь Цагадай цаазлахыг шаарджээ. Гэрэг бол Боорчийн хувьд Тэмүжинд үнэнч зүтгэсний нь төлөө Тэнгэрээс өгсөн хайр шагнал юм. Одоо түүнийгээ алдах болов. Чингис хааны хоёр хөвүүнтэй өрсөлдөн тэмцэх хүч мэдэл түүнд үгүй юм. Бас Цагадай... гэж бодмогц Боорчи айсандаа хашгираад үсрэн бослоо. Тэр амьдралдаа ингэж айж үзсэнгүй. Цагадай уурандаа очоод Гэрэг хөвүүнийг нь цавчин алчихсан мэт муу совин татаад хүзүүний нь улаан сорви зад үсрэн цус урсжээ. Боорчи сэлмээ сугалан авч ухасхийлээ. Түүний эцсийн тулаан ирсэн мэт санагдаад зүрх нь хагарах шахаж байв. Гэвч тэр босгоо давж чадсангүй муужран унажээ. Ядарч шархадсан зүрх нь тэссэнгүй. Түүний ухаан самууран зүүдэлж байх шиг болжээ.

...Голоос хайртай Гүмүда нь холоос ямар нэгийг хашгиран гүйсээр боловч нэг ч алхам ойртохгүй зовооно. Араас нь Цагадай сэлмээ далайн хашгиран дөхнө. Цагадайн сэлэмнээс цус дусаж байв.

-Гэрэг ээ. Хүү минь. Цагадай түүнийг минь алчихжээ. Би чамайг хамгаалж чадсангүй. Чи яасан азгүй хөвүүн байв даа. Гэрэг ээ. Хүү минь гэж дуудав.

Боорчи нүдээ нээлээ. Гэрэг түүнийг дуудаж байжээ

-Аав аа.Та яав аа гэж хөвүүн духыг нь илбэх ажээ. Боорчи ухаан оров. Өмнө нь хөвүүн нь сөхрөн суугаад доголон нулимстай нүдээр инээмсэглэн ширтэж байв.

-Аав аа. Би таныг үхчихлээ гэж санаад гээд Гэрэг эхэр татжээ. ”Чиний Гэрэг хөвүүн өнөөдөр учиргүй уйлахыг үзэж их уярлаа. Чи түүнийг их зөөлөн сайхан сэтгэлтэй хүн болгон хүмүүжүүлжээ. Би тэгэж чин сэтгэлээсээ уйлдаг хүнийг анх үзэв. Түүний нулимс нүднээсээ биш зүрхнээсээ урсаж байх шиг санагдлаа. Чи Гүмүдагаа үхүүлчихээд яг ингэж зүрхээрээ уйлж байсныг би мартаагүй байна. Тэр надад бидний залуу насыг санагдууллаа. Гэрэг хөвүүн чамайг дуурайжээ. Түүнийг лав Тэнгэрээс чамд илгээсэн хөвүүн биз” гэж тэр нэг өдөр Чингис хааны хэлснийг Боорчи санажээ. Гэрэг хөвүүн нь амьд байгаад Боорчи хязгааргүй аз жаргалтай болов. Тэр үүнээс өмнө ийм аз жаргалтай байгаагүй билээ. Харин тэр Гэрэг хөвүүндээ юу ч хэлсэнгүй. Чингис хаанд ч айлтгасангүй өнгөрчээ.

Гэвч Боорчи юу хийхээ сайтар бодон нэгэнт хатуу шийдсэн байв. Тийм учраас хөвүүнээ харж аз жаргал дүүрэн суужээ.

Тангудын ууланд борооны улирал эхэлж хэдэн өдөр бороо зүсрэв. Чингис хаанд бэлэглэхээр Цагадай Өгөдэй хоёрын авч ирсэн олон эмс охид, хөвүүд энэ бороонд сөхөрч суусаар хоног өнгөрөхөд захаасаа муужран унаж эхэлсэн ч тэд тоосонгүй. Хаан эцгийн ингэж хилэгнэсэнд Өгөдэй туйлын их хэлмэгдэж айжээ. Дээр нь Боорчийн өргөөнд болсон гэнэтийн санаандгүй явдал юугаар төгсөхийг таахын аргагүй байлаа. Цагадай өнгөрсөн хойно болсон явдалд бяцхан харамссан ч Есүй хатанд

-Би өөрийн шийдвэрээс няцаж ухрахгүй. Хэний хөвүүн хэн ч байсан хаан эзнээ хамгаалан харгалзаж чадаагүй бол гэм ялаа хүртэх ёстой гэж хэлжээ.

-Дайтаж байгаа цэргээ орхиод ирж чадаагүй ялаа бид хүлээе. Харин хаан эцгийг мориноос унагасан ялтныг шударгаар залхаагтүн гэж бас хэлэхээ мартсангүй. Учир нь Есүй хатан түүний энэ үгийг Чингис хаанд уламжлахыг тэр мэдэж байв. Тэр ёсоор ч болжээ. Гэтэл Цагадайн бодсон шиг Чингис хаан уужран тайтгарч, уучлан өршөөж бүгдийг түүний санаснаар хийсэнгүй харин ч тэднийг бараалхуулсангүй дахин нэг хонов. Цагадайн тэвчээр алдарч ёстой өлсгөлөн суман могой шиг эвхэрч, үсчиж байв. Гэвч одоо түүнд өөр хийх юм олдсонгүй. Боорчийн өргөмөл хөвүүн гэгдэх тэр Гэрэгтэй үүнээс илүү шөргөөлдвөл аюултайг Өгөдэй сануулсан тул эрхгүй үгэнд нь оржээ. Уг нь түүнийг тас цавчин алахад Цагадай бэлэн байв. Гэр тэргийнхээ тавцан дээр Цагадай баргар царайлан зогсож байтал Чингис хааны хүрээ рүү явсан Өгөдэй буцаж ирээд түүний дэргэд таг дуугүй зогсов. Энэ үед Цагадай дөчин гурав, Өгөдэй дөчин нэгэн нас хүрч байлаа. Өгөдэйн царайг хармагц л олигтой юм болсонгүйг Цагадай ойлгосон ч тэссэнгүй.

-Хаан эцэг биднийг бараалхуулах зарлиг буулгасангүй юу гэж хашгирчээ. Цагадай уурлан хилэгнэснээсээ болоод шатаж дэлбэрэх гэж байлаа.

-Цагадай ахаа. Би Есүй хатантай уулзлаа. Хаан эцэг юу ч эс хэлжээ. Биднийг түргэн гоомой хөдөлжээ гэж Есүй хатан зэмлэж байна гэж Өгөдэй гашуудалтайгаар шивнэв.

-Өгөдэй. Чиний энэ өлбөгөр үхээнц зан хэнд хэрэгтэй юм бэ. Юунд тэр эмд олон үг хэлж дэмий чалчин муугаа үзүүлэв. Чи түүнийг хаан эцэгт юу гэж нэмж зохиож бурахыг мэдэх үү. Тэр чинь нэг муу хөндлөнгийн эм биш үү. Чи бид хоёр ингэж хөндлөнгийн эмээс дорд үзэгдэж долдой шиг байхаар хаан эцгийн өргөөнд дайран орж учрыг асуун яллагдвал яллагдая гэж Цагадай тэсэлгүй бухимдав. Цагадайн энэ үг Өгөдэйд таалагдсангүй.

-Цагадай ах та тэвчиж азна. Есүй хатныг яаж тэгэж үзэж болно.

Тэгээд ч би таны хэлснээр бүхнийг хийх ёстой гэж үү. Бүү омогд. Ер нь би буруу хэрэг хийсэнгүй. Бурууг та хийв гэж эсэргүүцэн шивнэв. Тэд бие биеийг хэрсэн бух шиг харж зогсжээ.

-Өгөдэй. Чи эссэн тараг шиг бүү сага. Чи одоохондоо хаан суугаагүй байна. Хаан эцэг энх тунх байхад чи бүү хаан хүн мэт загнаж, хамаг их үгийг хэлэгтүн. Эссэн тараг сайндаа л ирмэг даван ширдгэн дээр асгарна. Чи өөрийгөө ихэд бүү бод. Хэрэв Цагадай би, чиний нэрийг дуртган хаан эцгийн өмнө, хамаг ихсийн дэргэд дэвшүүлээгүй бол хэн чамайг хаан суудалд өргөмжлэх билээ. Тийм болохоор чи миний үгийг дагах ёстой. Би чиний ах биш үү.

-Би дуртайдаа хаан больё гэсэнгүй. Хаан эцэг соёрхон зарлиг буулгаж Зүчи ах, Тулуй дүү та гурав дэмжиж баталсан биш үү. Цагадай ах та өнгөрсөн хойно зальхай үг бүү хэл. Би таны энэ үгийг сонсоогүй гэж саная. Харин таны энэ үгийг хаан эцэг сонсвол ер сайн юм болохгүй гэж Өгөдэй Цагадайн хурц түргэн занг мэдэх хүний ёсоор тайвшруулан хэлэв. Цагадай хэдийгээр Өгөдэйн энэ үгэнд ширвэгдэн цочиж айсан боловч тийм ч амар бууж өгөхийг үл хүсэв. Тэр угаас бууж өгөхийг үхэхтэй адил үзэх билээ.

-Өгөдэй. Би чамайг хаан сууна гэж хэлсэн үгээ үл буцаана. Би бөөлжисөө буцааж иддэг нохой биш. Гэвч хожмын нэг өдөр үг зөрж, үйлс хазайхгүйн тулд би хэлсэн үгээ мартъя. Чи ч дахин бүү сана гэвэл Өгөдэй

-Ахын үгэнд сэтгэл ханалаа гэж зөөлөн инээмсэглэв. Үнэхээр Өгөдэйгөөс өөр хүн байгаад Цагадайг Чингис хаанд ховловол тэр сайнаа үзэхгүй нь мэдээж билээ. Тэд дахин үг хэлэлцэж чадсангүй. Учир нь сөхрөн суусан боолуудын дунд үймээн гарч харуулууд нэг хүнийг чирэн авчирсан нь урт бавгар сахалтай, Цагадайн боол орос дархан ажээ.

Орос дархан хоёр хоног сөхрөн сууж доромжлогдсондоо ихэд хилэгнэж уурандаа үхлээс ч айхгүй болжээ. Тэр “Муусайн үхэр монголчууд намайг үтэр түргэн алагтүн. Та нарын боол байсан дорвол тааваараа үхье” гэж орос хэлээрээ хашгирч хараан зүхэж цэргүүдтэй ноцолдох бүлгээ.

-Наадах чинь юу гэж хэдгэнэ шиг дүнгэнээд байна гэж Цагадай өөрийн боолыг танимагц хашгирав. Энэ Михээ гэгч орос эр бол сэлэм урлахдаа даанч уран гартай тул Цагадай, Чингис хаанд бэлэглэхээр авчирсан нь энэ байжээ. Цагадайг үзмэгц дархан сөхөрч хашгирсаныг хэлмэрч дамжуулав.

-Цагадай эзэнтээн. Би танайд ирээд бүтэн жил хоёр гараа холцортол сэлэм хутга дархаллаа. Гэтэл би энд ус шавар дунд хоёр хоног борвио тэнийлгэсэнгүй сөхөрч суулаа. Би сөхөрч сууж ханав. Ийм залхаалтыг тэвчиж чадахгүй. Энд гэмгүй охид хөвүүд шөрмөс нь татаж үхэж байна. Намайг түргэн алахтүн. Би ясаа амраая гэсэн ажээ. Орос дарханы үгийг сонсоод Цагадай гэр тэрэгнээс доош бууж очив. Өгөдэй ч дагалджээ. Баавгай шиг хүдэр болхи биетэй орос дархан үнэхээр үхэхээр шийдсэн бололтой зориг төгс үзэгдэв.

-Дархан чиний хөл өвдөв үү гэж Цагадай юунд ч юм зугаатай болж инээмсэглэн асуув.

-Эзэнтэн. Би бол алс холын Киев хотын хүн юм. Анх намайг Сүбээдэйн цэрэг олзолж авлаа. Сүбээдэй намайг Батад өгөв. Бат намайг харин Цагадай танд өгсөн билээ. Би энд гурван өдөр дэмий суув. Сөхөрсөөр суутал хөл минь тэнийхгүй болжээ.

-Дархан чи хэд ч хоносон тэвчин суух ёстой болжээ гэж Цагадай өнөөх л ивээнгүй өнгөөр хэлэв. Цагадай ер уурлаж хилгэнэсэнгүй нь гайхалтай. Бөртэ хатан эжий нь Батынд ирснийг дуулаад Цагадай Сыр Дарья мөрний эргийн Тэрмэш балгасаасаа ухаангүй яаран давхин очиж билээ. Тэгэхэд Бат энэ дарханыг бэлэглэжээ.

-Би яах гэж ингэж дэмий сууна вэ гэж орос дархан дахин хашгирчээ.

-Дархан чи сонс. Энэ талд Перс, Тангуд газрын хамгийн шилдэг дархан урчууд, гоо эмс, гоолиг хөвүүд цугларсан юм. Тэднийг би ертөнцийн эзэн Чингис хаан эцэгтээ бэлэглэнэ. Ертөнцийн эзэн Чингис хааны боол болно гэдэг чамд олдохгүй хувь тавилан юм.

-Хэний ч боол болсон би хийдгээ л хийнэ биз. Боол хүнд юуны ялгаа. Харин миний хөл өвдөөд тэсэхгүй нь ээ.

Дарханы энэ үгийг хэлмэрчээс сонссон Өгөдэй гэнэт урагш алхан ойртоод

-Орос дархан чи хэл. Энд чам шиг хөл нь өвдсөн хүн олон байна уу гэв.

-Олон байна. Энд бүгдийн хөл өвдөн шаналж байна. Тэд бүгд над шиг ийм үг хэлж байна. Энд гэмгүй хүмүүс үхэж байна.

-Тэгвэл чи юунд ганцаар ирэв гэж Өгөдэй сэлмээ ханхийтэл сугалав. Дарханы царай барайсан ч

-Би ч үхэхээс үл айх тул ирлээ гэж шивнэжээ.

-Чи үхэхийг хүсэв үү гэж Өгөдэй дахин алхам урагш болж асуув.

-Миний хөл өвдөөд байна л даа гэж хэрэг бишдсэнийг мэдсэн дархан бувтнахад “Чангахан дуугараач” гэж хэлмэрч зандарчээ. Цагадай улам зугаатай болж сүүлийн хэдэн өдөр анх удаа хөмсөг нь тавиран инээж байв.

-Би дархан хүн ингэж дэмий сууж болохгүй. Та нарт сэлэм зэвсэг хэрэгтэй биз дээ гэж дархан эвэршсэн баравгар гараа сунган хашгирав.

-Чи Чингис хааны боол болохгүй гэнэ ээ гэж Өгөдэй заналтай хэлсэнд түүнийг ингэж аашлахыг үзээгүй Цагадай гайхсандаа бүр ангайтал инээжээ.

-Би хэний ч боол байсан адилхан. Үргэлж л сөхөрч амьдрах биш үү.

Энэ орос дархан бас цөс ихтэй эр ажээ. Тэр Өгөдэйн сүрдүүлсэнд тийм ч амар бууж өгөхгүй шинжтэй байсан нь Өгөдэйг улам ч хилэгнүүлжээ.

-Чи нэгэнт өөрөө Чингис хааны боол байх хувь зохиолоос татгалзсан тул хүслийг чинь ёсоор болгоё гэж Өгөдэй сэлмээ далайв.

-Чи намайг алж чадахгүй. Та нарт зэвсэг хийж өгдөг хүн шүү дээ би гэж дархан хашгирсан ч дальдарсангүй харин ч сөхөрч сууснаа босчээ. Эргэн тойрон нам гүм болов.

-Би чамайг алах үгүй ээ. Харин ядраад байгаа хөлийг чинь тайраад өгье. Дархан хүнд хөлний хэрэг юув гэж Өгөдэй хашгираад хэлмэрчийг дуугарахаас өмнө дарханы хөлийг өвдгөөр нь цавчин унагав.

-Ингээд чи муу өмхий орос их Чингис хааны өмнө үүрд сөхөрч явах боллоо. Аваад яв наадахаа гэвэл харуулууд дарханыг цусыг гоожуулсаар орилуулан авч оджээ. Өгөдэйн өмнө ганц Цагадай хоцров.

-Өгөдэй чи яасан хатуу сэтгэлтэй хүн бэ. Уг нь хамгийн сайн дархан юм шүү. Чиний наад сэлмийг дархалсан юм. Гэтэл чи хөлгүй болгож орхидог. Уг нь нэг мөр толгойг нь цавчсан бол сайн байлаа. Би чамайг уян зөөлөн сэтгэлтэй гэж бодсон чинь тийм биш бололтой гэж Цагадай хөхрөв.

-Бусад боолын хөл өвдөхгүй болно биз гэхдээ Өгөдэй нойтон газарт сэлэмний цусаа арчин хуйлжээ.

Энэ үед морьтой хүмүүс давхин ирж харуулыг өнгөрөн уян дээр буусан нь Боорчи ажээ. Цагадай Өгөдэй хоюул түгшин бие биеийг харав. Боорчийн ингэж гэнэт хүрч ирсэн тэдэнд ер сайхан санагдсангүй, харин ч сэжигтэй санагдсан тул тэд дуугүй ёслохоос хэтэрсэнгүй. Гэрт орохыг урьсан ч Боорчи орсонгүй, тэрэгний хөндөл сандайлан суугаад ядарсан мэт санаа алджээ.

-Хаан эцэг биднийг бараалхуулах болов уу гэж Өгөдэй дуугүй байхаас төвөгшөөсөндөө асуув.

-Би сая Чингис хаанд бараалхтал хаантан “Боорчи чи их мартамхай болжээ” гэв. Тэгээд би та хоёртой уулзахаар ирлээ гэж Боорчи шивнэв. Дуу нь сөөнгөтөж бас гуниг дүүрэн болжээ. Тэр үнэхээр гунигтай байлаа. Итгэж найдаж элдвийг бодолгүй зүтгэсэн амьдрал нь ийм төгсгөлтэй байсныг Боорчи гадарласангүй дээ их харамсжээ.

-Би их мартамхай болжээ. Өгөдэй Цагадай хоёр оо. Чингис хаан үнэн хэлжээ. Би их мартамхай болж. Мартана гэдэг ямар аймшигт өвчин бэ. Би яасан их зүйлийг мартаа вэ. Би олон олон хүнийг мартжээ. Би Онон мөрний хөвөөгөөр адуу хөөж явсан бага насаа мартжээ. Ижил бяруу шиг ноололдож явсан нөхдөө мартжээ. Амьдрал гэдэг даанч хатуу тоглоомтой ажээ. Би ч удахгүй та нарт мартагдана. Би та хоёрыг нартад мэндлээгүй байхад анх шархдаж байлаа. Би үүнийгээ мартжээ. Бас Хүйтэн уулын тулалдаанд эцгийг чинь шархадсаныг мартжээ. Тэр үед хаан эзнээ хамгаалах ёстойгоо умартсан нэг хүнийг Хасар авга чинь цаазлахыг шаардсан юм. Энэ бол Цагадай чиний хэлж шаардаж байсан шиг шударга хэрэг байв. Чингис хаан тэр үед Хасарын үгийг зөвшөөрөлгүй тэр хүнийг цэрэг цөөн гэдэг нэрээр өршөөн амьд үлдээсэн юм. Тэр өршөөгдсөн хүн бол Боорчи би байлаа. Харин өнгөрсөн

намрын хулангийн ангийн үеэр болсон хэрэг бол Хүйтэн уулынхаас ч хүнд ноцтой явдал юм. Тийм болохоор Цагадай би чиний өмнө буруутан болжээ. Дайны үед шархдах байтугай үхэх ч юу ч биш. Гэтэл энгийн нэг ангийн үед эзэн хаанаа мориноос унагаж бэртээнэ гэдэг үнэхээр өршөөж болшгүй хэрэг юм. Чингис хаан хэдий өршөөсөн ч Боорчи би Чингис хааны хөвүүдийн өмнө ялтан болжээ. Чингис хаан лав та нарын үгийг сайшаан дэмжих нь гарцаагүй. Тэгэхээр Цагадай чи намайг хороогтүн. Залууст сургамж болог. Би одоо хэдийхэн насалж юуг бүтээв гэж. Харин миний Гэрэг хөвүүнийг өршөө. Түүнд буруу бий. Би бурууг нь үүрье. Тэр нас залуу. Та хоёрын хөвүүд Есөнмөнх Гүюг хоёртой ойролцоо. Гэрэг бол Тэнгэрээс надад илгээсэн ганц хөвүүн минь юм. Түүнийг битгий алаач. Надаас хойш бүү гадуурхан ад үзээрэй. Ингэж амалвал надад үхэхэд санаа зовох зүйлгүй. Эх нь нас барсан. Ганцаар өнчин юм. Чингис хаан, Боорчи чи их мартамхай болжээ гэсэн нь Хүйтэн ууланд болсон хэргийг хэлжээ. Чингис хаан тэгэхэд намайг Хасарын цаазнаас аварсан юм. Одоо хөвүүдийнхээ цаазнаас аварч чадахгүй гэсэн үг гэж би ойлгов. Цагадай Өгөдэй хоёроо. Хаан эцгийгээ та нар л өмгөөлж хамгаалахгүй бол та нар шиг үнэн сэтгэлээр өмөөрч туслах хүн үгүй шүү. Төр улсаа төрсөн хөвүүнээсээ илүү хайрла гэж Чингис хаан эцэг чинь сургажээ. Харин би хөвүүнээ, өөрөөсөө илүү хайрлах тул Гэрэгийг өршөөж намайг үхүүлэгтүн. Түүнд энэ улсад зүтгэж бүтээх нас байгаа юм. Харин надад юу ч үлдсэнгүй.

Боорчийг үгээ дуустал тэд дуугарсангүй. Үгээ хэлж дуусаад Боорчи санаа амрав. Одоо хэргийн эзэн тул Цагадай үг хэлэх хэрэгтэй болжээ. Гэвч тэр энэ гэнэтийн явдалд гэмшиж айгаад дуугарч чадсангүй зогсов.

-Цагадай би чамд ер гомдож санасан зүйлгүй. Бас сая худал үг хэлж хуурмаг зан гаргасангүй. Би чиний дуугүй байгааг ойлгоно. Хэрвээ чи намайг тас цавчин хаяж чадахгүй байгаа чинь намайг хүндэлснийх биш харин хаан эцгээ хайрлахгүй байгаагийнх юм.

Энэ бол Цагадайн хор шарыг хөөргөх гэж Боорчийн санаатай хэлсэн туршсан аймшигтай үг байв. Бас ийм үгнийхээ төлөө Цагадайн сэлмэнд үхэж болохыг ч тэр мэдэж байв. Цагадай үнэхээр энэ үгийг сонсоод минчийн улайж амьсгаа нь түргэссэн ч арай ч сэлмээ сугалсангүй. Харин Өгөдэй

-Боорчи ахаа. Бид таныг юу гэж муугаар бодож, модоор цохих билээ. Цагадай ахыг ч тэгэж хэлж болохгүй гэж зохицуулах үг хэлэв. Энэ үг Боорчид таалагдав.

-Цагадай чи тайвшир. Намайг алах бол чи хэзээ ч амжина. Одоо явцгаая. Чингис хаан намайг та хоёрыг дагуулан ир гэж зарлиг буулгав гэсэнд тэд ойлгохгүй болж хэсэг зуур алмайрчээ.

-Та тоглож байна уу гэж Цагадай уурсан хашгирав.

-Үгүй дээ. Би Чингис хааны зарлигийг уламжилж байна.

-Тэгвэл сая та юу ярив

-Тэр чинь ч үнэн. Би харин бүр үнэн санаанаас хэлсэн шүү. Цагадай чи өөрийн бодсоноор хийгтүн гэхэд Цагадай гайхан зогссоор байжээ.

-Шалавлаж үз. Тулуй дүү чинь ирээд хүлээж байна гэхэд тэд сая л нэг үнэмших шиг болжээ.

Үнэхээр Боорчи худал хэлээгүй билээ. Чингис хаан хөвүүдээ бараалхуулахыг зарлиг болгожээ. Бас Цагадайн загнасныг сонсоод уурлаж “Боорчи.Чи их мартамхай болжээ” гэснээс өөрийг ч хэлээгүй нь үнэн юм. Ингэж хэлсэн нь хэлсэн амнаас буцаж одоо тэр мориноос унасан явдлыг сөхөхгүй гэсэн үг байжээ. Боорчи үүнийг ойлгож байсан ч боломжийг алдалгүйгээр омогтой Цагадайн ааш авирыг сайтар дарж авахыг хичээсэн нь энэ юм. Харин ч Цагадайн сөхсөн хэрэг ийм амарханаар сайнаар төгссөн нь Боорчи болоод Гэрэгт таатай хэрэг болжээ. Хэрэв Цагадай тэр чигээрээ зүтгэсэн бол Гэрэгийг алчихад бүгдээр Цагадайд зөвийг өгөн сайшаах байсан билээ. Үнэхээр энэ бол Боорчийн амьдралд тохиолдсон хамгийн аймшигт явдлуудын нэг байв. Тэр Гүмүдаг үхэхийг хараад яаж ч чадахгүй модонд хүлээтэй хэвтэж байхдаа яг өнөөдрийнх шиг гаслан орилж байсан билээ. Хэрэв Цагадайн шаардлагыг Чингис хаан хүлээн авч Гэрэгийг буруутган цаазлах аваас хөвүүнийхээ өмнөөс үхнэ гэж шийдсэн байв. Гэрэгийг Чингис хаан өршөөсөнд Боорчи талархаад ч барахгүй болжээ. Гэвч Гэрэгийг Чингис хаан өршөөсөн биш бүх учир Хулан хатны сүнстэй холбоотой байсныг хэн ч мэдсэнгүй. Учир нь өөртэйгөө хамт байсан цэргүүдийг буруутган гэсгээвэл Хулан хатны сүнс хилэгнэнэ гэдгийг Чингис хаан мэдэж байсан тул Цагадайн шаардлагыг тоомсорлосонгүй мэт өнгөрөөсөн билээ.

Хаан эцэг нь өршөөсөнд Цагадай Өгөдэй хоёр баярлаж бас түгшиж төдөлгүй тэдний бэлгийн нүсэр цуваа Чингис хааны хээрийн өргөөг чиглэн хөдлөв. Тангудын Сижоу балгасыг эзлэн авахад олзолсон бас Цагадайн Хорезмоос нааш ирэхдээ ачиж авчирсан перс гоо эмсийн тал нь шавар шалбааг дунд хэвтэж хоцорчээ. Үлдсэн тэдний амьдийг нь цэргүүд өөрсдийн майхан руу чирч аваачжээ. Уг нь Цагадай Өгөдэй хоёрт ингэж залхаагдах онцын буруу үйлдэл байсангүй билээ. Сижоу балгасыг эзлэн авах гэж сар саатсан нь Чингис хааныг хилэгнүүлсэн төдий ажээ. Гэвч Чингис хаан тайтгарахгүй байсанд Есүй хатан уйлж гуйсаар сая л нэг бараалхуулах зарлиг буулгажээ. Гэвч Чингис хааны сэтгэлд бухимдах өөр шалтгаан байсныг тэд мэдэхгүй байв. Чингис хааны бие чилээрхсэнээс болж Тангуд улсыг хэрхэх тухай зөвлөлдөхөөр хөвүүдийг дуудъя гэхэд зөвшөөрсөн нь өөр учиртай байв. Чингис хаан угаас тэднийг дуудахаар шийдээд байсан бөгөөд энэ нь Зүчийн үхэлтэй холбоотой байжээ. Хулан авлах үеэр мориноос унаснаас хойш тэр ихийг боджээ. Харин Яргай балгасын дэргэд иртэл бие нь чилээрхэн хэвтсэн яг энэ үед Зүчи хөвүүний нь үхсэн өдөр тохиох байлаа. Зүчи үхээд гурван жил өнгөрчээ. Энэ өдрөөр хөвүүдээ дэргэдээ цуглуулж хэлье гэсэн үг байжээ. Гэтэл Өгөдэй Цагадай хоёр түүний зарлигаас даруй сарын дараа Зүчийн үхлийн өдөр өнгөрсөн хойно ирсэнд Чингис хаан тэвчиж чадсангүй. Чингис хааны зан ааш өөрт нь танигдахгүйгээр өөрчлөгдөж байгааг тэр мэдэрч эхэлжээ. Энэ бол туйлын аймшигтай хэрэг байв. Хэвтрийн байдалд ганцаар үлдэх нь түүнд ер үхэлтэй адил санагдаад юуханд ч болов дүрсхийн уурлах болоод уджээ. Чингис хааны сэтгэл санаа туйлын тогтворгүй болсныг ойр орчмынхон дэргэдийн шадрууд нь ч гадарлаж Боорчиос өөр зориглон бараалхах хүнгүй болжээ. Гэвч Чингис хааны сэтгэл санааны энэ өөрчлөлтийг түр зуурын мориноос унаснаас болсон гэх төдийгөөр тэд ойлгож байв. Гэвч энэ бол тийм ч хялбар зүйл биш болохыг Чингис хаан өдөр өнгөрөх тусам тод мэдрэх болжээ. Гэвч сэтгэлийн доторхи нууц бодол, аймшиг түгшүүрээ хэнд ч мэдэгдэхийг хүссэнгүй. Ингэж дорой дорд байдалтай хэвтээдээ уурсан хилэгнэж галзуурах дөхөж байжээ. Гэтэл энэ үед нь Өгөдэй Цагадай хоёр дуудсан ёсоор ирсэнгүй нь бүр ч гал дээр тос нэмсэн хэрэг болсон билээ. Харин ашгүй Тулуй хөвүүн нь төв улсаас



амжин ирж бараалхсанаар барахгүй хэлээгүй байтал Зүчи ахынхаа үхлийн өдрийг санаж дурссан нь Чингис хааныг ихэд баясган тайтгаруулж Тулуйг бүр ихээр хайрлан тооход хүргэжээ. Чингис хаан отгон хөвүүн Тулуйгаа хамгийн ихээр хайрлан эрхлүүлж нум даахтай болсон цагаас нь дэргэдээсээ салгалгүй дагуулсан билээ.

Тулуй эцгийн үгнээс зөрдөггүй сүрхий ухаантай хөвүүн байв. Тулуй хөвүүн нь эцгийнхээ сэтгэлийн гүн дэх шаналалыг тааж тайтгаруулаагүй бол Чингис хаан цаашид хэрхэх байсныг урьдчилан тааварлах аргагүй ажээ. Тэр үдэш Тулуй эцгийнхээ дэргэд сууж, Зүчи ахынхаа тухай олон зүйлийг хүүрнэжээ. Зүчи түүнд бусдаас илүү дотноор хандаж хар нялхаас нь үүрч дүүрч өсгөснийг Тулуй яахин мартаж билээ. Тулуй Зүчи хоёр дотно, харин Цагадай Өгөдэй хоёр хоорондоо амь нэгтэй өссөнийг Чингис хаан сая л нэг ойлгож авав. Хүүхэд насны дадал хүмүүжил одоо ч хэвээр бөгөөд Тулуйн хөвүүн Мөнх Хубилай нар Зүчийн хөвүүн Баттай дотно, төрсөн ах дүүс мэт байхад, Цагадайн хөвүүн Есөнмөнх, Бүри Өгөдэйн хөвүүд Гүюг Годан нар хоорондоо илүү дотно явдаг ажээ. Түүний алтан ургийн үр удам илэрхийгээр хоёр хуваагдан эхэлж буйг Чингис хаан Тулуйн үгнээс үзэж мэдэж авчээ.

Энэ бол Чингис хааны мэдэж анзаараагүй шинэ зүйл байлаа. Үр хүүхэд нь ингэж хуваагдан алсдаа хоорондоо өрсөлдөн тэмцэлдэхийг Чингис хаан олж мэдэв. Ингэж талцан өрсөлдөх нь ганц эдний хэрэг биш юм. Түүний дээд удмаас дамжин өвлөгдөж ирсэн өвчин билээ. Өөрийн амьдарч буй энэ цагт учирсан өрсөлдөөнд Бэгтэр Хасар хоёр дүүгээ алж Тэмүжиний хаан сууж үлдсэн нь энэ зөрчлийг үгүй болгож чадсангүй харин ч өөрийн үр удамд өвлүүлэн шилжүүлснээ тэр харж байлаа. Хөвүүд нь, тэдний үр хүүхэд цаашид эвтэй найртай, өрсөлдөн тэмцэлдэхгүй байгаасай гэж Чингис хаан туйлаас их хүсчээ. Үүнийг тэр өөрийн их нэр сүр, зарлиг хуулинд захируулан засаж болно гэж итгэж байв. Ингэж бодсоны учир алс Каспийн тэнгисийн эрэгт байх Батын хүрээрүү урьд явж зам мэдэх болсон Гэрэгийг илгээхээр шийдээд Боорчийг дууджээ. Тэр өглөө Чингис хааны бие илт сайжирч дууу орж өнгө засаад өндийн сууж байжээ. Түүний энэ сэргэлэн байдлыг үзээд Боорчийн ончирсон сэтгэл тайтгаран гийжээ.

-Боорчи.Би чиний хөвүүнийг Батын тийш илгээе гэжээ. Боорчи сурсан зангаар дуугарсангүй.

-Бат Сүбээдэй хоёрыг даруй нааш ирүүлэе.

-Энэ Тангудад тэдэнтэй тэдэнгүй бидний хүч хүрэх биш үү гэж Боорчи хэлжээ.

-Боорчи чи битгий ингэж наана барьж, нимгэн сэтгэ. Надад Батад хэлэх үг байна. Бас Сүбээдэйн нүүрийг харалгүй хичнээн жил болов. Тэр Зэв шиг гэнэт үхэх мэт санагдаад гэсэнд Боорчи дахин тайлбар хэлсэнгүй зарлигийг дагажээ. Үнэхээр Зэв Сүбээдэй хоёр Самаркандын дэргэдээс Орос газар одоноос хойш зургаан жил Чингис хаан тэдэнтэй уулзаагүй бөгөөд Зэв Хивчагийн талд үхэж, Сүбээдэй нутагтаа буцаж ирэлгүй Батын дэргэд Чингис хааны зарлиг ёсоор үлдсэн билээ.

Боорчи, Чингис хааны зарлигийн цаад учрыг ойлгох шиг болжээ.

-Тэгвэл Мухулайг Алтан улсаас дуудъя гэж Боорчи гарахын өмнө зог тусан хэлэхэд Чингис хаан бүр ухасхийн өндийгээд

-Чиний хэлснээр болог. Босож явж чаддаг бол Зэлмийг ч дуудахсан. Бас Чормогон хорчийг Солонгосоос дуудахсан. Даанч хол. Яваад удаагүй тул хэрэггүй гэсэн билээ. Энэ үгэнд Боорчи сэтгэл хөдлөөд тэр өдөржингөө хөл хөөртэй байжээ. Хөвүүнээ сайтар бэлтгүүлж сургав. Хоногийн дараа Чингис хааны өргөөнд Гэрэгийг дагуулан орж бараалхжээ. Гэрэгийг орж ирээд сөхрөн мөргөхийг үзээд Чингис хаан туйлгүй ихэд догдлон уярчээ. Энэ нүдэнд дулаан царайтай, үнэнч сайхан сэтгэлтэй хөвүүнийг харах бүр Чингис хааны сэтгэлд их хайр оволздог бөгөөд чухам яагаад ингэж байгаагаа өөрөө ч тайлбарлаж мэддэггүй билээ. Дээд Тэнгэрээс хувааж өгсөн ганц нөхрийнх нь хөвүүн одоо эцгээ залгамжлан өөрт нь зүтгэж явахыг харах шиг сайхан юм үгүйг Чингис хаан мэдэрчээ.

-Боорчи.Хөвүүн чинь яг чам шиг хүн болох нь дээ гэж Чингис хаан өнөөх үгээ бахархалтай хэлснийг Боорчи Гэрэг хоёр догдлон сонсож суужээ.

-Хүү минь. Чи хичээ. Морио зовоохгүй бас зогсож алмайрахгүй довлогтун. Бат Сүбээдэй хоёрт наашаа мөн чиний адилаар явахыг миний өмнөөс дахин уламжлагтун гэж Чингис хаан Гэрэгт зарлиг буулгав. Боорчийн сэтгэл туйлын хангалуун аз жаргалтай болов. Тэнгэр тэтгэж түүнд ийм сайн хөвүүн илгээжээ гэдэгт одоо тэр итгэжээ. Үнэхээр Гэрэг бол Тэнгэрээс түүнд илгээсэн хөвүүн ажээ. Чингис хаан түүнд өөрийн хөвүүнийг өгсөнд Боорчи баярлахгүй байхын аргагүй билээ. Ийм аз завшаан ер өөр хэнд тохиолдох билээ.

Байдал нэгэнт ингэж тайвшран илааршсан тул Чингис хаан Цагадай Өгөдэй хоёрыг бараалхахыг зөвшөөрсөн байжээ. Гэвч хэргийн учрыг олоогүй тул Цагадай Өгөдэй хоёр сэтгэл түгшиж догдолсоор эцгийнхээ өргөөний босгыг алхжээ. Эцгийгээ мориноос унасныг сонссон ч ингэж дор орж хэвтрийн болсныг тэд гадарласангүй байсан тул хармагц балмагджээ. Чингис хаан өндөр түшлэгт орон дээр хагас суугаа байдлаар тэднийг угтжээ. Тэр эцгийгээ хэвтэрт байхыг анх удаа үзжээ. Хоёул сөхрөн мөргөв. Тэдний айдас түгшүүр хязгааргүй болоод дуудсан даруй ирээгүйдээ гэмшээд барсангүй. Чингис хааны дэргэд Есүй хатнаас өөр хүн үгүй байжээ. Цагадай эцгээс сүрдэж дуугарсангүй.

Харин өршөөл эрсэн үгийг Өгөдэй төлөөлөн хэлэв. Өгөдэйн үгийг Чингис хаан гар занган таслав. Харин түүнийг үг хэлэхээс өмнө Есүй ам нээв.

-Хөвүүд мэдээтэй байгтун.Мориноос унаж бэртсэнээс хойш Хаантны бие их чилүүр боллоо. Гадуур элдэв цуу үг тарахаас сэрэмжлэн Хааны биеийн байдлыг нууцалж байна. Шөнөдөө ихээр халуурч хонох болов. Гэтэл та нар дайтах эзлэхийг урьтал болгон Хаан эцгийнхээ дуудсанд юунд алгуурлан ирсэнгүй вэ. Та нарыг өдий дайтай байлгах гэж Хаан эцгийнхээ зовж зүдэрснийг юунд мартав. Та нарыг үгүй бол Хаан эцэг чинь ганцаар хэрхэх билээ. Юунд та нар ингэж гэнэн балчир хүүхэд шиг аашилцагана вэ.

Тангуд улс тэртэй тэргүй нүүгээд явчихгүй тул юунд тэр Сишоу балгасыг сахиж Хаан эцгийнхээ зарлигийг умартан чилээв гэж Есүй хатан тэднийг ихэд зэмлэн хэлэхэд Цагадай Өгөдэй хоёрын магнайны хөлс ширдэг дээр тов тов дусалж байжээ. Цагадайн дотор хуримтлагдаж, хэлнэ гэж бодсон олон омголон үгс хийсэн одов. Тэр дуугарах бүү хэл гүнзгийхэн амьсгал авч чадахгүй суув. Тулуй чимээгүй орж ирээд зэрэгцэн суухад ч өндийж харж чадсангүй.

-Хөвүүд та нар Есүй хатны үгийг эм хүний үг гэлгүй хүлээн авч сонсогтун. Миний төрүүлж өсгөсөн хөвүүд та нар л Хаан эцгийнхээ зарлигийг эс дагавал өөр хэн дагах билээ. Бүхнийг та нар эхлэн үлгэрлэх ёстой гэж хэлэлцэж тохирсон биш үү. Та нар Зүчи ахыгаа юуны учир Тэнгэрийн гэсгээлд унасныг мартав уу. Тэр хөвүүн буцаж ирэх зарлигийг мэдсээр атал ирсэнгүй суусаар Тэнгэрийн гэсгээлд унав. Үүнээс хойш та нар ч түүн шиг бүү бологтун. Уг нь Цагадай Өгөдэй та хоёрыг зарлиг зөрчсөн тул хүндээр гэсгээвэл зохистой.

Гэвч “Хөвүүдээ залхаавал Монголчууд дотроо эвдрэлцэн самуурав гэж зальхай муу Буур хаанаас өгсүүлээд таны бүх дайснууд баярлах биз” гэж Боорчийн гуйснаар би та хоёрыг өршөөв. Түүнээс биш гэмтнийг гэсгээхэд хойш суух хэрэг юув. Би Цагадай Өгөдэй та хоёрын Боорчид хэлсэн муу үгийг хэзээ ч мартахгүй гэж мэд. Ял чинь хэвээр гэж санаж яв. Ганцхан Боорчи ухаантай сайн хүн тул та хоёрыг өршөөхийг надаас гуйлаа. Би түүний ганц гуйсныг яаж зөвшөөрч эс чадна. Наху баяны ганц хөвүүн Боорчи арван гурван настайдаа миний дэргэд Тэнгэрийн зарлигаар ирж зүтгэснээс хойш өдий жил болж үхэхээс бусдыг үзэхдээ нэг ч удаа ам ангайн өөрийн төлөө юу ч гуйсангүй. Гэтэл өнөөдөр надаас Цагадай Өгөдэй хоёрыг өршөөгөө ч гэж гуйв. Би гайхсан бас та нарын өмнөөс ичсэндээ юу ч дуугарч чадсангүй. Би ийм хөвүүдтэйдээ ичэв.

Чингис хаан ингэж хэлээд хүндээр амьсгаадан суухад тэд чухам нүүрний арьсаа хуулуулж нурууны ясаа хянгардуулсан мэт болжээ.

Ийм хатуу үгийг тэд анх удаа Хаан эцгийнхээ амнаас сонсов. Тэдэнд цай айраг ч амсуулсангүй. Тэднийг бүтэн үдэш ингэж суулган залхаажээ. Харин үдэш болж гэгээ тасарсан хойно Чингис хаан сая ам нээж

-Цагадай Өгөдэй та хоёр Сижоу хавийн балгасыг хураан авч дуусаад надтай нийлэгтүн. Би та хоёрт хоёр сарын хугацаа өгье. Буур хааны баруун хавиргыг хадаж дуусгагтун гэж Чингис хаан тушаажээ. Тэд үг дуугүй гарав. Хагас өдөр сөхөрч суусан тэд мөлхөх шахан гарчээ. Гэвч Хаан эцгийн зарлиг, шийтгэлээс илүү түүний биеийн дорой байдал нь тэднийг ихэд түгшээсэн тул тэр орой Боорчийн өргөөнд бараалхаж өршөөл гуйхын ялдамд чухал хэргийг зөвлөлджээ. Хаан эцэг нь хилэгнээд өөрийн биеийн байдлыг тэдэнд ер дэлгэн тайлбарласангүй тул ингэхээс өөр арга олдсонгүй ажээ. Боорчи ч тэдэнд дорвитой хэлж зөвлөж чадсангүй. Учир нь Чингис хаан биеийн байдлын тухай болоод цаашид хэрхэхээ хэнд ч тэр бүү хэл Боорчид ч нээж хэлэхгүй байгаа нь бүгдийг мухардуулжээ. Харин Каспийн тэнгисийн дэргэдэх “Алтан ордон”-оос Бат Сүбээдэй нарыг, Алтан улсаас Мухулайг дуудаж, Тулуйг буцаахгүй байгаа нь лавтай чухал зөвлөгөөн хийхээр Чингис хаан шийдсэнийг гэрчилнэ.

-Хөвүүд та нар хичээ. Чингис хааны заасан хугацаанд Тангудын баруун хязгаарыг эзлэн аваад даруй ирэгтүн. Бид Чингис хааны зарлигаар удахгүй Түрэмгий балгасыг довтолно гэж Боорчи хэлжээ. Хаан эцгийн үхлийн тухай бодол Цагадай Өгөдэй хоёрыг эзэлжээ. Хаан эцэг нь үхэж үгүй болно гэхэд даан ч итгэмгүй санагдавч цаг хугацаа эргэлт буцалтгүй тул аргагүй хүлээн зөвшөөрч гунигт автан буцжээ. Хэзээ нь энэ олон жил өнгөрч эцэг нь өвгөрч хөгшрөөд одоо босож чадахгүй хэвтрийн болсныг хараад сайхан зүүд зүүдэлж сэрээд гэнэт үхэл үзэх шиг цочиж балмагджээ. Тэд тоймтой хэрэг хэлэлцэж чадсангүй тус тусын цэрэг рүү салж оджээ. Үнэхээр Чингис хааны үхлийн тухай аймшигт түгшүүрт түүний ойр дотнын бүх хүмүүс

автсан байлаа. Чингис хаан ч үүнийг сайн мэдэж байв. Чингис хааны цэрэг довтолсоор Тангудын Таур балгасыг эзлэн авч Буур хааны их үгт жанжин Жаха хамба цааш зугажээ. Хэдий бие нь чилүүр ч довтолгооноо зогсоохыг Чингис хаан хүссэнгүй. Хүний гарт орж хэвтрийн болсондоо өшиж хонзогнох сэтгэл нь Буур хааныг хоггүй хүйс тэмтрэх галзуурсан хүсэлд хөтлөж байлаа. Одоо тэр өөрийн бүх дайсныг тэр дундаа үхлийг хамгийн ихээр үзэн ядаж байв.

### *БАГДАДЫН ХАР СУҮДЭР*

Сэрүүн салхи сэвэлзсэн өдөр Тангудын шавар уулын бэлд хөнгөн цацар бариулаад өдөржин ганцаар бодолд дарагдан суух болсон Чингис хааныг хараад Боорчи чухам хэлэх байхаа олж ядах болжээ. Хэзээ нэгэн цагт ийм гунигт үе ирнэ гэдгийг хэн хэн нь мэдэж байсан ч ийм цочмог гэнэт учирна гэж бодсонгүй нь тэднийг балмагдуулсан байлаа. Чингис хааны ингэж ганцаар суухыг харж тэвчиж чадахгүй болоод Боорчи сэм алхан дэргэд нь очжээ. Боорчийн ийн гэтэн очиход Чингис хаан тэргүүнээ өргөн түүнийг харсан боловч дуугарсангүй.

-Хаантан та юунд ингэж өдөржин газар чилтэл сууна вэ гэж зөөлхөн асуув.

-Намайг суусаар байтал Тангудын энэ тал хотойж үзэгдэнэ үү гэж Чингис хаан инээх аядсан ч царай зүс, дуунаас нь гүнзгий гуниг салсангүй.

-Хаантан минь дэмий суусаар таныг чилэх бий гэж санаа зовох тул хэллээ. Ийм үгийг энд надаас өөр хэн танд хэлэх билээ. Зэлмэ байсан бол лав миний үгийг хэлэх байсан биз. Гэвч урианхайн сайн Зэлмэ хэвтэрт ороод удлаа. Сүбээдэй хол суух тул бидний зовлонг мэдэхгүй. Борохул ч үгүй болов. Зэв ч үгүй болов. Одоо ийм үгийг Боорчи надаас өөр хэн хэлэх билээ дээ. Болчимгүй үг хэлсэн бол та намайг өршөөгтүн гэж хэлэхэд Чингис хаан ус гүйсэн нүдээр түүнийг удаан ширтээд

-Боорчи чи үнэн үг хэллээ. Хар багын анд, халуун сэтгэлт нөхдийг минь дурсаж хамаг цусыг минь чи хөдөлгөлөө гэж арай ядан шивнэв. Чингис хааны энэ байдлыг үзээд Боорчи дэмий тэнэг үг бодлоготой хэлснээ ойлгосон ч оройтжээ. Хэлсэн үгнээсээ болж Боорчи ихэд гэмшин шаналахыг Чингис хаан олж үзээд түүнийг тайвшруулжээ.

-Боорчи чи өөрийгөө бүү зэмлэ. Чи ер дэмий үг хэлсэнгүй. Харин чиний үг олон зүйлийг надад ухааруулав. Би яасан их мартамхай болоо вэ. Би хичнээн олон нөхдөө, ямар их цаг хугацааг ор тас мартаа вэ гэж Чингис хаан шивэгнээд буруу харжээ. Боорчид дахин хэлэх үг олдсонгүй. Чингис хааны сэтгэл дэнслэн догдолсныг ч тайтгаруулах үг олсонгүй.

-Чингис хаан та элдэв эрээн бодолд авгаж эргэж ирэхгүй одсоныг дурсан сэтгэлээ бүү чилээ. Сэтгэл донслох нь таны биед яав ч сайнгүй. Хаантан та болгоож үз. Би дэмий үг хэлж сэтгэлийг тань чилээв. Өршөө гэж Боорчи доор мэхийжээ. Тэр ер ингэж доор мэхийж байсангүй. Харин өнөөдөр яагаад ингэснээ ойлгохгүй болжээ.

-Боорчи чи үүнээс хойш намайг Хаан гэж бүү дуудагтун.

Чингис хааны энэ үгэнд Боорчи малгайгаа унатал цочив. Тэр эхлээд буруу сонсов гэж бодоод

-Хаантан та юу айлдана вэ. Миний чих хатуу болсон тул заримдаа хазгай муруй сонсох болжээ гэж бөхийв.

-Би Боорчи чиний сонссоныг хэлэв. Чи битгий баашил гэж Чингис хаан Боорчийг харгүйгээр зэмлэв.

-Би Чингис хаан таныг хэн гэж дуудна.

-Чи тэгвэл миний нэрийг мартжээ гэж гомдсон мэт шивнэв.

-Би чинь Есүхэй эцгийн өгсөн Тэмүжин нэртэй хүн шүү.

-Тиймээ энэ нэрийг би яаж мартана. Гэтэл ертөнц даяар таныг Чингис хаан гэж дуудах атал би яаж үүнээс өөрөөр таныг хэрхэн дуудах билээ. Тэгвэл ёсонд хазгай хэрэг болох буй заа.

-Харин би Тэмүжин хэвээр үлдмээр байна. Би хорин настай Тэмүжин болмоор байна.

Боорчи гайхан Чингис хааны дэргэд тулж очив. Чингис хаан урагш ширтээд харц нь гүн бодолд автжээ.

-Хаантан минь. Та юу айлдана вэ. Исгэрч одсон салхи эргэж яахан үлээнэ. Би таны хэлснийг ойлгож ядна гэсэн ч Боорчийн сэтгэлд Чингис хааны бодол халдварлан тэр эрт багын амьдралаа гэнэт дурсан санахад элэг зүрх урагдах шиг шимшрээд иржээ.

-Хэрвээ тэгдэгсэн болоосой. Би тэгвэл Онон мөрнийхөө өндөр дэнжинд эргэн очихыг яасан их хүснэ вэ. Наху баян эцгийнхээ агтыг эзгүй сул орхиод найман шарга агтыг чинь эрж одохсон. Эргэн ирэхгүй идэр бага насандаа ганц хором болов очихсон. Тэнд Хасар, Бэлгүтэй, Зэлмэ, Бөртэ бүгд байгаа даа. Бас Гүмүда ч байгаа. Тэмүжин ч тэнд буй гэж Боорчи өөрийн эрхгүй шивнэжээ. Энэ үгийг сонсоод Чингис хаан цочсон мэт давхийн эргэж түүнийг харжээ.

-Тэмүжин. Чи Тэмүжин гэв үү. Энэ нэрийг чамаас ,бас бусдын амнаас сонссонгүй хичнээн жил болов. Өүлэн ижий минь ч ингэж дуудахгүй болсонсон. Энэ газар, хүмүүс, амьдрал юунд ингэж амархан хувирч өөрчлөгдөнө вэ. Би Тэмүжин чигээрээ үлдэж болохгүйн учир юу вэ гэж Чингис хаан гомдолтой шивнэв

-Хаан та үүний учрыг олж ядна уу. Та өөрөө энэ зовлонт амьдралыг өөрчлөн хувиргасан биш үү. Ертөнцийн тал нь одоо таны их сүр хүчний өмнө бөхийж, өвдөг дор чинь сөхөрчээ. Та өөрийнхөө өөрчлөн бүтээсэн ертөнцийн хоймор заларч байна. Хаан танаас өөр агуу хүчтэн үгүй байхад та энд ингэж ганцаар гуниглан суухыг үзээд би гайхаж байна. Энэ дэмий хоосон бодлоо орхигтун. Таныг их үйл хүлээж байна. Энд Тангудын шавар талд жагссан их цэрэг тань хүлээж байна. Нойрноос сэрж үз гэж ам нээсэн дээрээ гэсэн шиг Боорчи хэлэх гэж олон өдөр бодсон үгээ хэлж амрав.

-Би унтаагүй байна. Ухаан минь саруул байна. Ганцхан залуу идэр үе минь санагдах боллоо. Би юу хийх, ямар зарлиг буулгахаа сайн мэдэж байна. Тулуй хөвүүн минь Зүчи ахынхаа

Тэнгэрт хальсан өдрийг мартахгүй санаж миний бодсоныг хэлж сэтгэлийг минь амирлууллаа. Харин Цагадай Өгөдэй хоёр золиг мартсан байжээ. Тэд ч лав санахгүй биз. Боорчи юу гэж бодно.

-Өршөө хаантан. Би хүртэл тэр өдрийг мартсан байхад тэдэн шиг нялх амьтад яаж санах вэ. Тэднийг өршөөсөн тань мэргэн шийдвэр болжээ гэвэл Чингис хаан гэнэт сэргэн зугаатай хөхрөв.

-Боорчи чи битгий нохойт. Цаад хоёрыгоо бүү өмөөр. Тэднийг нялх гэсэн чинь бүр инээд хүргэлээ. Дөч гарч дөрвөн улсыг дайллаа. Одоо тэд мартаха санах нь тэгширч хүн болбол болмоор юм гэжээ.

-Таны их сүр хүчний дор дандаа л ялж дийлж явсан залуус ухаан сууж алсыг бодох нь алгуур ховор байж мэднэ. Ялалт амттай ч ихдэж хэтэрвэл хордох аюултай гэж би санана. Тийм учраас тэдийг нялх гэж хэллээ.

-Би ер нь хөвүүдээ хэн болгож орхив. Зүчи ахынхаа гавьяа, нөлөөг мартаха сэтгэлийг тэд хаанаас олов. Зүчи хөвүүн минь хэн байсныг тэд яагаад мартав. Энд би буруутай биш үү. Боорчи чи дуугүй зогсоно уу. Чи лав намайг буруутгах биз.

-Хаан таны хийсэн, бүтээсэн болгон ганцхан Их Монгол улсын төлөө тул хэн ч таныг буруутгахгүй юм. Та үүнд бүү эргэлзэгтүн.

-Боорчи чамайг үхвэл хэн надад энэ үгсийг надад хэлж манарсан бодлыг сэргээнэ. Чи ер нь хэзээ үхэх хүн бэ гэж Чингис хаан ер тоглож шоглосон шинжгүй тулган асуужээ. Боорчи ч огт бодсонгүй.

-Миний хэзээ үхэхийг Тэнгэр л мэдэх биз гэв.

-Тийм үү. Тэгвэл би чиний хэзээ үхэхийг хэлэмц.

-Зарлигаар больё.

-Гэвч Боорчи чи нэгэн зүйлийг сайн тогтоож ав. Миний чаддаг мэддэг ховор болжээ. Гэвч чи намайг амьд сэрүүн байхад үхэж үл болно.

-Жа.

-Тэгвэл сэтгэл минь онгойж бие минь хөнгөрөв.

-Та биеэ сувиалан асрахаа бүү цалгард.

-Чаддагсан бол Дэлүүн болдогийнхоо энгэрт очоод шүүдэрт өвсөн дээр хэд хөрвөөхсөн. Өглөө эрт Ононгийн эргийн шүүдэрт өвсөн дундуур хөл нүцгэн явахсан. Тэгвэл би тэр дороо илааршин эдгэх болно доо.

-Хоёул Тангудыг буулган авмагц нутагтаа очиж таны хэлснээр явья.

-Тэгье.

Энэ бол тэдний чин сэтгэлийн яриа байсан тул үг бүр нь Чингис хаанд эм мэт шингэж тэр үзтэл сэргэн омогшжээ.

Хорезмоос ирж Тангудад мордох хүртлээ Боорчитой ингэж дотносон ярилгүй удсандаа Чингис хаан гайхсаар байжээ. Зүчийн үхлээс хойш тэдний хооронд үл үзэгдэх хөшиг татсан мэт болоод Боорчитой хоёул үлдэнэ гэхээс тэр ихэд халгах болжээ. Энэ нь Зүчийн тухай түүний бодлыг Боорчи одоо ч шүүмжлэн хэлнэ гэж айсаар байсных билээ. Энэ явдлаас хойш Чингис хаан өөрийгөө Боорчийн өмнө буруутай гэж бодох нь улам гүнзгийрчээ. Урьд Гүмүдэд учирсан явдалд өөрийгөө буруутгах нь их байсан билээ. Энэ сэтгэл Боорчи өөрийн өргөмөл хөвүүнтэй болсноор нэлээд илааршиж байсан ч Зүчи өвчнөөр үхсэн нь сэтгэлийн хуучин шархыг дахин сэдрээжээ. Ер нь Боорчийг Зүчийн тийш илгээсэн нь буруугаар зогсохгүй Боорчийн сэтгэлд ямар гүнзгий цохилт болсныг таамаглах бүрдээ Чингис хаан Боорчийг өрөвдөн өөрийгөө буруутгадаг байжээ. Зүчид өөрийн хөвүүн шиг ханддагыг мэдэх мөртлөө түүнийг ийм бэрх хэрэгт зарсанд нь Боорчи түүнийг үзэн ядах ч энүүхэнд билээ. Зүчийг өвчнөөр үхнэ чинээ хэн санах билээ. Гэтэл Боорчи өнгөрсөн хоёр жил хар цагаан, сайн муу үг ер унагасангүй. Бас Зүчийн яаж үхсэнийг бас Зүчитэй юу ярьснаа ч нарийн тодорхой хэлэлгүй дөлсөөр иржээ. Чингис хаан энэ тухай зүрхлэн асууж чадахгүй байжээ. Харин өнөөдөр нэгэнт нүүр хагарч бага залуу насны явдлаа дурссан сэтгэлээ уудлан үнэн үгээ хэлэх зоригтой болгожээ.

-Боорчи. Чи намайг харааж зүхсэн ч би үл гомдоно. Би чамаар хүчрийг хийлгэж хүндийг үүрүүлжээ. Би чиний хамаг амьдрал, аз жаргалыг булаан авч нүүрээ тахлуулж нүглээ хаалгаж ирлээ. Би одоо чиний төлөө юу хийвэл зохино. Чи хэлээч. Чи хүснэ вэ гэж Чингис хаан босож зогсоод хэлэв. Боорчи дуугарсангүй.

-Боорчи. Би чамайг аз жаргалгүй амьдарч тэгээд бас намайг харааж зүхэж үхээсэй гэж үл хүснэ. Чиний өтөлж өвгөрөхийг харах бүр өвчин шархандаа шаналсан царайг чинь харах бүр би чамайг ийм болгож орхисондоо гэж бодохоор яс минь янгинах шиг болдог болжээ. Би чамайг үхвэл яана гэж өглөө сэрэх бүрдээ бодох боллоо. Бас чамайг харах бүрдээ би яах гэж энэ их улсыг байгууллаа гэж харамсах боллоо. Би ганц чиний биш хичнээн олон сайн нөхрийнхөө амийг золиослов гэж санах бүр чамайг аз жаргалгүй үхэх вий гэж зовох боллоо.

Чингис хаан энэ үгийг харуусал гэмшил дүүрэн хэлэв.

-Тэмүжин. Чи элдвийг бодож биеэ бүү зовоо. Чи биднийг үхэл тийм ч амар дийлэхгүй. Санаа бүү зов. Үхэх гэдэг санааных гэж Тэв Тэнгэрийн хэлснийг санана уу. Миний төлөө бүү сэтгэлээ шаналга. Би аз жаргалтай байна. Миний энэ амьдрал Тэнгэрийн зарлиг учир надад харамсах зүйл нэгээхэн ч үгүй юм. Харин ч ийм хувь заяа хайрласан Тэнгэрт баярлах ёстой юм. Би одоо Тэнгэрээс заяасан хөвүүнтэй болов. Үүнээс илүү аз жаргал надад хэрэггүй. Одоо Чингис хааны зарлигийг биелүүлэхээс өөр аз жаргал надад үлдсэнгүй. Идэр омголон явахыг чинь үзэв. Эзэнт улсаа байгуулж их хаан суухыг үзэв. Энэ болтол зүтгэв. Би өөрөөр яаж амьдарна.

Боорчийн энэ үгэнд Чингис хаан сэтгэл ханаад баяртай инээмсэглэж

-Боорчи. Чи бидэнд ингэж суух хоног цөөхөн үлджээ. Чиний өвчин шаналалаа нуух гэж шүд зууж явааг надаас өөр хэн ч үл мэднэ. Миний өвчин шаналлыг чамаас өөр хүн мэдээсэй гэж би үл хүснэ. Хулангийн авын үед мориноос унаснаас болж цээжээр хатгах нь дуу алдмаар, ухаан балартмаар хүчтэй болсоор байна. Би чам шиг тэвчээртэй байж үл чадах тул энэнээс хойш яах билээ гэж санаа зовох боллоо. Чи намайг яах гэж энд ганцаар өдөржин суугаа гэж санана вэ. Энд ганцаар суухад миний ёолохыг салхинаас өөр хэн ч сонсохгүй юм. Би миний ёолохыг монгол нутгийн минь салхи, Тэнгэр бүү сонсог гэсэндээ энэ Тангудад суусаар байна. Хөвүүд, нөхөд минь миний ёолж арчаагаа алдан доройтохыг бүү үзэг гэсэндээ энд ганцаар хүн чулуу мэт суух боллоо. Миний өвчин илааршин наашлах янзгүй ажээ. Харин ч би эрт үхэх байжээ. Гэтэл Хулан хатан ирж надад бага боловч амьдрал өгөв. Амьдрал, цаг хугацаа гэдэг ямар үнэтэй байдгийг би одоо л ойлгож байна. Би хичнээн их цагийг дэмий сул өнгөрөөгөө вэ. Би өвчнийхөө тухай ганцхан чамд л хэлэв. Чамд хэлсэнд өвчин минь намдах шиг боллоо. Миний өвчинг ганцхан чи л мэдэх боллоо. Миний өвчин чамтай хамт үхэх биз гэжээ.

-Тэмүжин. Би чамд нэг зүйл хэлье Бие чилээрхэж байхад олон долоон юм бүү бод. Тэр тусмаа өнгөрсөн баларсан түүхийг бүр бүү бод. Сэтгэлээ зугаацуул.Өвчнөө март. Наадам цэнгэл зохио. Цэргүүдийнхээ хийморийг сэргээж Тангудын Буур хааныг цочтол наадам хийе. Уйтгарлан суухаа боль. Урьдын Тэмүжинг мартаж угийн Чингис хаан мэт байгтун.

-Боорчи чиний хэлснээр хийе. Чи сая хэлснээ үйлдэгтүн. Харин наадам цэнгэлээ Бат хөвүүнийг ирэхээр больё. Харин түүний өмнө Яргай балгасыг эзлэн авч Буур хааныг явах газаргүй болгогтун. Буур хааныг бүү үхүүл. Түүнийг миний өмнө өөрөө мөлхөж иртэл нь сахиж суугтун гэж Чингис хаан зарлиг болгов.

Түүний Тангуд улсад өөрийн биеэр хэрэг болгон морилон ирсний учрыг Боорчи сая л тод ойлгов. Буур хаанаас өшөөгөө авч бах таваа хангах гэж Чингис хаан энд иржээ. Түүнээс биш Тангудыг мөхөөхөд Буур хааны хотыг л эзлэн авбал болох боловч Чингис хаан ганцхан Буур хааны суугаа хотыг тойрон бусад зах хязгаар хот балгасыг эзлэн цаг алдсаар байгаагийн учир энэ ажээ. Буур хааныг өөрөө ирж амь гуйхыг хүлээж байгаа нь тодорхой болов. Тангудыг мөхөөх дайныг Чингис хаан өөрийн хүслээр сунжруулж байв. Ингэх нь Монголын цэрэгт хохиролтойг Чингис хаан тоосонгүй. Бас Тангуд улсыг эзлэн авч сүрээ үзүүлэх нь дараа

Алтан болоод Сүн улстай дайтахад чухал байв. Тангуд улсыг эзэлснээр одоохондоо найрамдалтай байгаа Сүн улстай эвсэн тэдний нутгаар дамжин Алтан улсын баруун өмнө талаас довтлох боломж нээгдэнэ гэж Чингис хаан бодсон байв. Тийм учраас Сүн улсын хаанд Тангудаас олзолсон их бэлэг илгээж хуучин найрамдалтай байснаа батлан захидал хүргүүлсний хариуг хүлээж байв. Одоо Чингис хааны ухаанд Хималайн их уулсын өмнө хойд талын газар орныг өөрийн улстай нэгтгэх их төлөвлөгөө нэгэнт бэлэн болжээ. Энэ бол Буддаг шүтэгч улс орнууд байв. Тангуд улс бол энэ их дайны үед их цэргийг хүнс хоолоор хангах газар, бэлтгэлээ базаах нутаг болох юм. Тийм учраас Тангудыг дахин сэхэхгүйгээр дарж эзлэн авах нь чухал байв. Тангуд улс дарагдвал баруун зүгээс дайчилсан цэргийн ирэх зам дөт шулуун болох билээ.

Ирээдэйн их дайны давшилтын төлөвлөгөөг зохиож элдвийг нягтлан суух нь Чингис хааны өвчнөө мартаж ганц арга болжээ. Түүний тушааснаар Алтан, Сүн улсад илгээсэн тагнуулууд эргэн ирээд эдгээр улсын нутаг орны байдал, гол мөрөн, уул даваа зам, харгуйн зураг үйлдэж



эхэлжээ. Анх Хорезмыг довтлохдоо бүрэн хэрэглэсэн энэ арга туйлын ашигтай зүйл болох нь нэгэнт батлагдсан юм. Хорезмд довтлохын өмнөх гурван жилд баруун зүгт худалдаачны дүрээр аялсан Чингис хааны тагнуулуудын цуглуулсан мэдээ их довтолгооныг бэлтгэх гол чиглэл баримжаа болсон ажээ. Тагнуулын албыг өргөжүүлж түүнд өргөн эрх мэдэл олгоод олон хэлийн зүг зүгийн улс хотуудаас үнэнч албатуудыг шилэн авч хэрэгтэй нутаг оронд илгээдэг болов. Энэ нууц албыг одоо Зэлмийн хөвүүн Есөнтэй толгойлох болжээ. Есөнтэй бол итгэлтэй үнэнч бас ухаантай хүн гэдгээ нэгэнт Чингис хааны өмнө баталсан билээ. Ингэж Тангудад Монголын их цэрэг дорно зүгт хийх их аян дайндаа алгуур тайван, дайтаж байгаа нэрийн дор нууцаар бэлтгэж байлаа. Гэвч дорно зүгт Алтан улсад довтлох энэ нууцыг одоохондоо ганцхан Чингис хаан л мэдэж байв. Ихэнх цэргүүд, жанжид Тангудыг эзлэн авч талж дээрэмдээд нутаг буцна гэж бодож байлаа. Ерөөс нүүдэлчний дайн ийм байдаг билээ. Гэтэл цаг өөр болж нэг удаа булаан дээрэмдэх биш байнга өөртөө зүтгүүлэх, татвар авах хэмжээг тогтоон нэгдсэн улсын журамд оруулахын тулд дайн хийх хэрэгтэй болсон нь нэгэнт тодорхой байв. Үүний тулд хүчирхэг цэрэгтэй байх ёстой. Их цэрэг дайтаж байлдаж байвал хүчирхэг болно гэж Чингис хаан бодох учир их цэргийг амарч, морио таргалуулахаас бусад цагт аялан дайтаж байх ёстой гэж үзнэ. Бас их цэргийг нэгтгэн өөрийн дор захирч дайн тулаанд байлгах нь шадар, сайдууд өөр хэнд ч гэсэн тусгаар явж бие даах хүсэл зориг төрөх явдлыг хязгаарлах хамгийн сайн арга гэж итгэнэ. Энэ бол арван таван наснаас хийсэн их бага олон дайн тулаанаас олсон ухаан байв. Анх арван таван настайдаа Тэмүжин, Тоорил хааны хүрээнд жил хагас суусан билээ. Энэ хугацаанд Тэмүжин өмнө нь сураагүй, үзээгүй олон зүйлийг үзэж сурчээ. Тоорил хан шинжээд ихэд тоож олны дэргэд ил тод шууд үнэлсэн нь Тэмүжинд өөртөө итгэх их сэтгэлийг анх удаа төрүүлсэн билээ. Тэгэхэд Тэмүжин Тоорилын хөвүүн Сэнгүмийн хамт Түбэгэн аймгийн цөөн бүл иргэдийг дайран дээрэмдсэн нь түүний амьдралдаа үзсэн хамгийн анхны тулаан байсан юм.

Тэд олон адуу, үхэр олзлон авч Тоорил хан тулааны олзыг хуваахдаа нэгэн сайхан саарал морьт Тэмүжинд өгсөн нь түүний анхны олз байв. Бүх төрсөн ах дүү нараа ад үзэн заримыг нь алж, заримыг нь хөөж явуулсан Тоорил ханы эл үйлдлийг Тэмүжин тэр үедээ ер зөвтгөн бодоогүйгээр барахгүй дотроо үргэлж шүүмжилдэг байв. Өөр зуурдаа, халуун ам бүлдээ эвтэй байх нь хүчирхэг байхын гол үндэс гэж Тэмүжин хар багаасаа үзэж өсөж хүмүүжсэн нь Өүлэн эхийн нөлөө байсан ч бас ах дүү гэдэг хамгийн аюултай өширхөг дайсан болдгийн учрыг сайтар ойлгож авсан билээ. Тэгээд Тоорил ханы ах дүү нараа хядсаны учрыг сүүлд ойлгож мэджээ. Харин харь омгийн юм уу өөрийн омгийн жирийн ардын хөвүүдээс аль шударга зоригтойг нь сонгон дэвшүүлж ашиглах замыг сонгосон нь түүний ухааных байв. Нөхөд гэдэг нь эрх мэдэл ил шууд булаалдах нь ховор, бас тэдэнд ингэж өрсөлдөх үндэс шалтгаан бага юм. Нөхдийнхөө гавьяа чадлыг ил тод, шударгаар үнэлэх нь л гол байдаг билээ. Яг ийм нөхдийг Тэмүжин сонгон олж чадсандаа бахдан баясаад ханадаггүй бөгөөд тэр өөрийгөө хүн шинжиж танихдаа гаргууд гэж үнэнээсээ итгэдэг байв. Тэмүжиний хар багын энэ чанар их хаан суухад нь хамгаас ихээр хэрэг тус болжээ. Гэтэл одоо элсүүлж хүмүүжүүлж авсан, ихийг бүтээлцсэн тэр нөхдийн ихэнх дайнд үхэж үрэгдээд эсвэл хөгширч өвгөрсөөр дуусчээ. Дэргэд нь ганц Боорчи л үлдэв. Тийм ч учраас амьд үлдсэн Сүбээдэй Мухулай нарыг дуудуулжээ. Магадгүй сүүлчийн удаа уулзацгаана гэдгээ ч мэдэж байв.

Бие нь муудаж, өвдсөнөөс хойш Чингис хаан ууртай уцаартай болсон ч бас их уяруу зөөлөн болжээ. Тэр сав л гэвэл өнгөрсөн амьдрал, үнэнч нөхдөө дурсан санах болов. Бас хэн нэгнийг

дэмий үхүүлж үр удмыг нь тасалсан байх бий гэж элдвийг хөөн шүүн бодож суух болжээ. Энэ бол үхлээ мэдэрсэн хүний зан юм. Хулангийн авын үеэр түүн рүү дайрсан тэр хар азарга бол үхэл байв. Харин азаар мориноос унаж бас Хулан хатны сүнс тэр азаргыг алснаар Чингис хаан аврагджээ. Гэнэт ирэх үхлийн учир шалтгааныг мэдээд Хулан хатны сүнс салахгүй дагаж явсныг Чингис хаан огт мэдээгүй билээ. Хар азарганы омруунд зоолттой байсан тэр хутга Хулан хатных байсныг Чингис хаан сайн таньсан билээ. Мориноос унасан түүнийг Хулан хатны нь сүнс хамгаалан авч, олон зэрлэг адгуусны хөлд гишгэгдэн үхэхээс аварч бас хар азаргыг хутгалан алжээ. Энэ бол гарцаагүй болсон хэрэг учраас өөрийн бэртсэнд тэрээр хэнийг ч буруутгах ёсгүй гэж шийдсэн билээ. Бүх зүйл Хулан хатны сүнсний ачаар сайнаар төгссөн ч үхэл өөрт нь их ойрхон ирснийг Чингис хаан мэдэрч байлаа. Тийм учраас үхэл авч явахаас өмнө санасан бүгдээ амжуулах гэж яарч байв. Гэтэл амьдрал түүний санаснаар хурдан түргэн хөдөлж урагшилж өгөхгүй ажээ. Харин Хулан хатныхаа сүнсийг дахин хүрээд ирээсэй, үзэгдээсэй гэж хичнээн хүлээсэн ч ирсэнгүй өвөл өнгөрч хавар болжээ. Үхэл гарцаагүй ирэхийг мэдүүлсэн нэгэн учралыг Чингис хаан өөрөөсөө ч нууж байсан билээ. Есүй хатан нь шаардсанаар Чингис хааны сүнсийг дуудуулсанд бие нь илааршиж өвчин намдсан нь түүний сэтгэлээс үхлийн тухай бодлыг түр боловч холдуулж мартуулжээ. Чингис хаан дахиад л мориндоо мордож урьдын адил итгэл зориг төгс дүрдээ орлоо. Энэ бол Батад хэл хүргээд Гэрэгийн буцаж ирсний дараа болжээ.

Бүх юм Чингис хааны бодсоноор болж сарын дараа Тангудын их уст Хөх нуурын эрэг дээр байрлаж асан хээрийн хүрээнд Алтан улсаас Мухулай түүний дараа Каспийн тэнгисийн дэргэдээс Бат Сүбээдэй хоёр иржээ. Үүний өмнө Тангудын баруун болоод баруун өмнө зүгийн хот балгасыг буулган авсан Цагадай Өгөдэй хоёр ирээд байжээ. Өргөн дэнжид задгай алтан асрын дор идээ будаа засаад тэдний ирснийг тэмдэглэн их найр хийжээ. Чингис хааны зүүн талд Цагадай, Өгөдэй, Толуй хөвүүд, Есөнмөнх, Гүюг, Мөнх, Бат, Бүри, Годан, Хубилай зэрэг ач хөвүүд, баруун талд Боорчи, Мухулай, Сүбээдэй дараалан бусад шадар жанжид суужээ. Харин Есүй хатан түүнтэй зэрэгцэн сууж байв. Ингэж нэг бүгдээр цуглан энгүүн сайхан хөөрөлдөн сууя гэсэн нь Чингис хааны их хүсэл байжээ. Тэр хүслээ биелүүлсэндээ сэтгэл ханажээ. Ач нар нь нас бие гүйцэж ахмад нь нэгэнт хорин хоёр гурав хүрснийг үзээд тэр өөрийгөө хичнээн удаан амьдарсныг ойлгов. Чингис хааны зүүн талд түүний их үйлсийг залгамжлагч хөвүүд ач нар нь суухыг харахад тэднээс их гэрэл цацарч байх шиг санагдана. Ач нар нь нүдээ гялалзуулж сэтгэл нь хөдөлсөн янзтай ч ихэд хичээн төлөв дуугүй сууцгаана. Харин түүний баруун талд түүнтэй хамт өсөж тэмцэж ихийг бүтээсэн хөгшид өвгөчүүл суусан нь Чингис хааны өнгөрсөн бөгөөд одоо цаг нь байв.

Боорчийн бодол болсон эгэл дүр, Мухулайн ухаалаг нүд, дулаан царай, Сүбээдэйн цочиж сүрдмээр догшин төрх, Шихихутагийн болгоомжтой, зальжин харц гээд аль хүүхэд цагийнх нь шинж ер өөрчлөгдөөгүй мэт үзэгдэнэ. Ийм нөхөдтэй байхад ертөнцийн талыг хураан авахад юухан байх вэ гэж омогшин бодмоор санагдах ажээ. Одоо Боорчи, Мухулай, Сүбээдэй нарын цаг хүссэн хүсээгүй өнгөрч байгааг мэдэрч суухад аймшигт гуниг төрөх ажээ. Харин идэр хойч үе, ач хөвүүдээ харахад энэ гуниг харамсал эрхгүй мартагдана. Чингис хаан энэ найрын үед олон үг ярьсангүй, иймэрхүү санаа бодолд эзлэгдэн нэг инээж нэг гуниглан суужээ. Нөхөд нь тус тусын явдал түүхээ хөгжилтэй чөлөөтэй сайхан хөөрөлдөж, бага идэр насаа дурсан суухыг сонсоогүй ихэд уджээ. Нөхөд нь цугласан нь Чингис хааныг Тэмүжин болгон буцаан хувиргаж сэтгэл санаа нь өөрчлөгдөхийг тэр мэдэрч байв. Тэр одоо багын

үнэнч нөхдөө Тэмүжиний нүд сэтгэлээр харжсуув. Алтан улсад самуун гарч түүнийг дарах гэж хуруугаа мулталж, хумсаа эмтэлж байснаа Мухулай ярих ажээ. Жалайрын Цагаангуа гэгч өөрийн хөвүүн Мухулайг дагуулан ирж Тэмүжинд бэлэглэсэн нь Мухулайн амьдралын эргэлтийн үе болжээ.

Мухулай бол далдын юмыг тааж мэддэг зөн совинтой цөөхөн хүний нэг байлаа. Тэмүжинг хамгийн хаан болохыг урьдчилан хэлсэн гурван хүний нэг нь Мухулай юм. Тайчу Сачабэх хоёроор толгойлуулсан Жүрхэн аймаг Тэмүжинг эсэргүүцэн эв эвдрэн тэмцээд дарагдахад Мухулай, эцгээ даган иржээ. Жалайр овгийн Цагаангуа уг нь Боржигон аймгийн боол байсан боловч сүүлд нь Жүрхэнд худалдагдаж сул иргэн болсон байжээ. Жүрхэний дагаж ирсэн иргэдээс залуу эрсийг дайчлан түмэн цэрэг болгоход хэнээр толгойлуулах тухай асуудал Тэмүжиний өмнө тулгарчээ. Уг нь Жүрхэн овгийнхныг Хасарт өгье гэж Тэмүжин дотроо шийдэж байжээ. Учир нь Жүрхэн овгийнхон угийн хэрүүлч заргач, омогтой зоримог эрс олонтой тул тэднийг өөртөө ойр байлгах нь хожим осол аюул ихтэй гэж болгоомжлоход хүргэжээ. Бас ингэхийг Тэв Тэнгэр бөө зөвлөсөн байв. Толгойлогчид нь алагдаж омог нь дарагдсан жүрхэнийхнийг Хасарт өгөх нь гарцаагүй зөв зам байсан бөгөөд хэрүүл тэмцэл болбол Хасарт л төвөг чирэгдэл учрах болохоос Тэмүжинд хор хөнөөл ирэхгүй бүлгээ. Ингэж бодсон учраас Тэв Тэнгэрийн үгийг дагажээ. Харин Цагаангуа Зэвгээ, Мухулай хоёр хөвүүнээ дагуулж ирэхэд арван долоон настай Мухулай Тэмүжинд ихэд таалагдаж удтал бодсоны эцэст урьдын шийдвэрээс ухрахад хүрчээ. Мухулай гэгч тэр хөвүүн тун онцгой содон цаанаа нэг хүн татах увидастай мэт санагдаад болсонгүй. Бат чийрэг биетэй ч, ухаан заль нуугдсан тод хурц харцтай нүд нь тэгэж онцгой санагдсаныг хожим тэр ойлгосон билээ. Тэр шөнө Цагаангуагийн хөвүүн Мухулайн дүр төрх зүүдэнд нь солонго мэт үзэгдсэн нь Тэмүжиний сэтгэлийг эргэлзээг арилгаж маргааш нь түүнийг эцгийн нь хамт өргөөндөө дуудан ирүүлэв. Шөнө зүүдэнд үзэгдсэн солонго бол Мухулайг Тэмүжинд илгээсэн Тэнгэрийн дохио байжээ.

Омог зориг ихт Жүрхэн овгийн түмэн цэргийг дөнгөж арван долоон настай Мухулайд захируулахаар өгсөн нь бүгдийн нүдийг бүлтийлгэсэн хачирхалтай шийдвэр байв. Тэр дундаа Тэмүжинд сайн дураар дагаж ирсэн жүрхэний баатар эрс, ноёд ихсийн дургүйцэл эсэргүүцэлтэй тулгарсан билээ. Гэвч Тэмүжинг шүүх, эсэргүүцэх зоригтон ялагдсан жүрхэнийхний дотроос гарсангүй. Учир нь тэдний сүр сүлд, сүнс хийморь нь болсон баатар Бүрибөхийг Тэмүжин заль зохион Бэлгүтэйтэй барилдуулж нурууг нь хугалан үхүүлсэн учир Жүрхэн овгийнхны омог зориг, эсэргүүцэх сэтгэл нь нэгэнт дарагдаад байжээ. Эхлээд Бүрибөхийг үхүүлэхийг Тэв Тэнгэр нэгэнт Тэмүжинд хэлжээ. Ингэж нэгэнт сүлд хийморь нь дарагдсан тул Жүрхэн овог аюулгүй болжээ. Арван долоон настай, боолын хөвүүн Мухулайд итгэхгүй хүн олон байсан ч түүний нууц далд чадлыг Тэмүжин урьдаар тааж мэдсэн нь одоо нэгэнт тодорхой болжээ. Мухулай Жүрхэн овгийн цэргийг итгэлтэйгээр засаад зогссонгүй удалгүй Тэмүжиний гарамгай жанжнуудын нэг болов.

Түүний байгуулсан гавьяаг дурдаж баршгүй гэж одоо Тэмүжин нөхдөө хараад бодож суув. Анх Далан нөмрөгт татаарын цэрэгтэй байлдахад чухам Мухулай дэргэд нь байгаагүй бол Тэмүжин гарцаагүй үхэх байв. Морио шархдуулж татаарын цэрэгт бүслэгдээд юу юугүй цавчуулан үхдэгийн даваан дээр гэнэт тэнгэр дуугарах шиг нижэгнэсэн нь Мухулай хашгиран дайрч ирсэн хэрэг байв. Мухулай татаарын цэргийг хага зүсэн өвс шиг ханаруулан цавчиж зам гаргаад Тэмүжиний дэргэд ирж мориндоо сундлаад мөн л тэр янзаар дайран гарч аварчээ.

Тэгэхэд Мухулай өөрийн харцаар хүн үхүүлж чаддагийг Тэмүжин анх үзэж мэлрэн гайхсан билээ. Ийм чадалтай ид шидтэй хүн байна гэдэгт Тэмүжин итгэхээс өөр аргагүй болжээ. Тэмүжиний шүтэн биширдэг Тэв Тэнгэр бөө ч хүнийг харцаараа үхүүлж чадахгүйг тэр мэдэх билээ. Тэр шөнө Мухулайг илгээсэнд талархан Тэнгэрт мөргөжээ. Хожим тайчуудтай тулалдахад Сорхоншарын охин Хадааныг булаан амьд мэнд аварч гарсан хүн нь мөн Мухулай юм. Хадаан болоод Тэмүжиний сэтгэлийн далд холбоог өөрийн зөн совингоор ойлгон мэдэрсэн Мухулай, эр нь алагдаж үхлийн аюулд учирсан Хадааныг олж аварчээ. Хадаантай уулзсан нь Тэмүжины хувьд хэзээ ч мартагдахгүй азтай хувьтай тохиол гэж тэр үзэх учир Мухулайд талархах нь улам их болжээ.

Тайчуудын олзноос Сорхоншар гэгч боолын ачаар аврагдаад гэрийн зүг явж байхдаа түүний охин, хонгор зөөлөн ааштай Хадааныг эхнэрээ болгон авна гэж тангарагласан билээ. Үүнийгээ ч хагацахын өмнө Хадаанд хэлжээ. Учир нь Хадаан бол бие сэтгэлээ хамгийн анх Тэмүжинд өгсөн охин байлаа. Таргудайн явуулсан эрлийнхэн Тэмүжинг ололгүй давхин одсоны дараа хураалттай ноосонд нуугдаж хэвтсэн Тэмүжин Хадаан хоёр өөрсдийн огт мэдэхгүй тийм гайхалтай сэтгэлд автжээ. Зуны бүгчим халуунд ноос онгичихоос төвөгшөөсөн цэргүүд жадаар сийчсэнд Тэмүжин өртөөд шанааруу нь цус урсаж байжээ. Харин Хадаан түүний цусыг хэлээрээ долоож түүнээс болоод хоюул биесээ хүсэх солиорсон дурлалд автжээ. Халуун ноосон дунд нүцгэн хөлбөрч хүний ёсоор эр эмийн үйлийг анх хийжээ. Хорвоод ийм аз жаргал шаналгаат дурлал байдгийг тэд мэдэхгүй байлаа. Тэдний дурлал аз жаргал ердөө л хоногийн настай байв. Тэмүжинд дурлах биш амьд үлдэх нь чухал байлаа. Гэнэт ирсэн анхны хайраа, амраг хонгор Хадааныг орхин явахаас өөр арга түүнд байсангүй. Тэмүжинг хайгсад Сорхоншарын гэрт хэзээ л бол хэзээ дахин ирж мэдэх байв. Тайчуудын хүрээнээс мултарч Бөртийг эхнэрээ болгож Боржигон аймгаа нэгтгэтлээ Тэмүжин нэг ч өдөр хайртай Хадааныг мартсангүй санасаар байжээ. Эм хүнд ганц хормын дотор ингэтлээ сэтгэл алдарч болохыг Тэмүжин дахиад хэзээ ч үзээгүй билээ. Тайчуудтай тулалдахын өмнө Хадааныг заавал олж авна гэж Тэмүжин бат шийдээд байсан ч амь мэнд уулзах эсэхгээ эргэлзсээр байв. Бас Хадааны тухай бодлоо хэнд ч хэлэлгүй байсан билээ. Гэвч Тэмүжиний сэтгэлийн далд нууцыг Мухулай яаж мэдсэнийг тэр анзаарсангүй. Хадаан бол Тэмүжиний хувьд онцгой учиртай хүн билээ. Тийм учраас энэ тохиолдлыг Тэмүжин одоо ч гайхан биширсээр явдаг юм. Анх арван долоотой Мухулайг Жүрхэн овгийн цэргийг толгойлуулахаар томилоход түүний харцанд дүрэлзсэн тэр гал одоо ч Мухулайн нүднээс тод гэрэлтсээр байхыг Чингис хаан олж үзжээ. Мухулай одоо нэгэнт хөгширч түүний хөвүүн Бор идэр насны жанжин болсон нь өнөө эцгийнхээ дор сууж байлаа. Борын дэргэд Зэлмийн хөвүүн Есөнтэй түүний дээр Боорчийн хөвүүн Гэрэг тэдний хамгийн сүүлд Сүбээдэйн хөвүүн Урианхайдай суух ажээ. Чингис хаан тэднийг хараад бахдах сэтгэлээ барьж дийлэмгүй санагдав. Түүний их хэргийг удирдан үргэлжлүүлэх ухаан зориг дүүрэн гурван үеийн эрс одоо өмнө нь сууж байв. Харин Есөнтэй болоод Урианхайдайн хөвүүд энэ найранд орсонгүй. Учир нь тэд одоо балчир гэлгүй эцэг өвгөдөө орлон гэрийн гаднах хэргийг зохицуулж байжээ. Шинэ залуу үе, шинэ жанжин баатрууд өвс ногоо адилаар ар араасаа урган төлжиж тэдэнтэй хамт шинэ зорилго ундарч шинэ дайн хийх хүсэл цуг урган гарч буйг Чингис хаан ойлгож байв.

Харин түүний нөхдийн дундаас хамгийн ихээр шархдаж гэмтсэн нь Сүбээдэй байжээ. Зүүн нүдээ хар илгээр таглаж боосон угийн догшин сүрлэг Сүбээдэй хөгширч нүүр царай нь

түмэн үрчлээ болоод хүүхэд хараад айж уйлмаар, хөгшид эмс цочиж хашгирмаар үзэгдэнэ. Бас болоогүй инээх нь яг л саа өвчин туссан хүн мэт харагдах тул Чингис хаан сахлын дор инээмсэглэн харж суув. Зэлмэ Сүбээдэй гэгч төрсөн ах дүү хоёр ингэж хэдэн үеэрээ Тэмүжинд амь биеэ зориулах учиртай байжээ. Харин саа өвчинд нэрвэгдсэн ах Зэлмэ нь ирж чадахгүй болжээ. "Би Зэлмэтэй уулзахгүй биз" гэж Чингис хаан гуниглан бодож суув. Киевийн ван хэрхэн бууж өгсөн, түүнийг хоёр хүүгийнх нь хамт цаазалснаа бахархалтайгаар ярьж суугаа Сүбээдэйг хараад Чингис хаан нэгэн зүйлийг тод ойлгож авав. Энэ бол нөхдөө бахдаж тэдний хүч үгүй бол их хаан сууж чадахгүй байснаа ойлгосон явдал юм. Өрөөсөн нүдэт бас хазгар энэ Сүбээдэй бол бага хүчээр дайсны олон цэрэгтэй байлдахдаа гаргууд ёстой нэг чөтгөр шиг арга мэхтэй хүн билээ. Тийм ч учраас Сүбээдэйг хамгийн холын аян дайнд илгээдэг билээ. Найманы Хүчүлүгийг Сүбээдэй бүр Инд мөрний хөндий хүртэл элдэн хөөж сөнөөгөөд ирснийг бахархахгүй, тоохгүй байхын аргагүй юм. Таван улсын нутаг орноор хөндлөн гулд явж хоёр жил хөөсөөр Хүчүлүгийг сөнөөсөн нь ганц Сүбээдэйн хийж чадах хэрэг байлаа. Ийм хэрэгт Сүбээдэйг ямар ч эргэлзээгүйгээр томилсон бөгөөд дараа нь Хорезмыг эзлэн аваад Орост цөмрөн тагнуул туршуулын дайнд илгээсэн нь түүний гайхамшигтай чадварыг үнэлсэнтэй холбоотой юм. Орост цөмрөн орсон нь бас л ганц Сүбээдэйн чадах хэрэг байв. Сүбээдэй ингэж таньж мэдэхгүй газар оронд цөмрөн орж хүч илүү дайсантай аймшиггүй тулж, ялан дийлдэг нь чухам түүний Тэнгэрийн ивээлд багтсаныг биз гэж итгэх билээ. Ерөөс түүний нөхөд өөр өөрийн чаддаг мэддэгээрээ түүнийг их хаан суухад харамгүй зүтгэжээ. Мухулай Алтан улсад арван хэдэн жил сууж эсэргүүцэл бослого бүрийг өөрийн цөөн цэргээр дараад одоо нэгэнт Алтан улсын эрлэг гэгдэх болжээ. Хасарыг үхүүлсний хойно түүнийг Алтан улсыг ерөнхийлөн захирах сайдаар томилж улсын Гоо ван цол олгон суулгасан нь Алтан улсад толгойгоо өндийлгөх боломж олгохгүй хэрэг болсон билээ. Мухулай ингэж чаджээ. Мухулайн ач гавьяагаар Чингис хаан баруун зүгт ар талдаа сэтгэл санаа зовох зүйлгүй байлдаж их ялалт олсон юм. Өнөөдөр, өөрийн амьд үлдсэн гарамгай нөхдөө цуглуулаад Чингис хаан ийн найрлаж суугаа нь Тэнгэрийн ивээлээр олдсон ховор алтан хором байв. Үүнийг хэн хэн нь сайтар ойлгож байлаа.

Их найрын дундуур Чингис хааны их сүр хүчийг баталсан нэгэн хэрэг болов. Энэ нь Чингис хаанд бараалхахаар Багдадын Халифийн элч ирсэн хэрэг байв. Гэрэгийн байцаан мэдэж уламжилснаар тэр элч Туулын хөндийдөх их ордонд очиж Бөртэ хатанд бараалахаад нааш зам заалган хүрч иржээ. Багдадаас гараад жил шахам явсан тэр элч Чингис хаанд лал мөргөлтний тэргүүн халифынхаа захидлыг гардуулах хүсэлтэй гэжээ. Чингис хааны сэтгэлд Хорезмын Перваны хөндийд байхад ирж бараалхсан Римийн ламын элч өнөөх өрөөсөн хөмсөгт, өл халзан Авраам Даяан гэгч санагджээ. Бас Боорчи ч тэр явдлыг санасан бололтой

-Тэр элчийг хэн гэнэ гэж асуужээ.

-Ирсэн элчийн нэрийг Ал Каийд гэнэ. Идэр насны хүн байна гэж Гэрэг хэлжээ. Багдадын халифын элч энд ирснийг сонсоод Цагадай хамгийн ихээр гайхсан ч дуугарсангүй суужээ. Бүгд Чингис хааныг зарлигийг хүлээв.

-Боорчи.Чи Цагадайн хамт Багдадын элчийг сайхан угтан уулзаж үгийг сонсогтун. Биднийг гэж энэ хол ирж байгаа бүхнийг бид нөхрөө гэж угтан авах нь чухал гэж Чингис хаан урамтай хэлжээ.

-Бид одоо уулзах уу гэж Цагадай яаран өндөлзөж асуув.

-Бүү яар. Уулзах гэсэн бол хүлээнэ биз. Маргааш бологтун. Эсвэл хэд хоног хүлээг гэж Чингис хаан зарлиг буулгасан тул Боорчи

-Элчийг тухтай амраа гэж Гэрэгт хэлэв. Гэрэг үүргээ биелүүлэхээр даруй гарч оджээ. Харин Чингис хаан өнөө бэлэн үгт Даяаны тухай бодож суужээ. Маргааш нь Боорчи Цагадай хоёр Багдадын халифын элчтэй уулзаад Чингис хаанд бараалхаж учрыг мэдүүлж Халифын захидлыг орчуулсныг уншин сонгов. Тэр захидалд “Аллах тэнгэрийн ивээл дор оршин байсан Хорезм улс мөхөж султан Желаладдин сураггүй болжээ. Гэвч улс нь мөхөж хаан нь зугатсан ч лалын мөргөлт олон түмэн нутаг газартаа суусаар байх биз. Лалын мөргөлт сүсэгтэн олныг авран гийгүүлэх ариун үүргийг Аллах тэнгэрээс Багдадын халиф надад өгсөн билээ.

Энэ зарлигаар Аллах тэнгэрийн ариун орон Багдадаас лалын мөргөлт Хорезм улсын султаныг сонгон баталж түүнд Аллахын тэнгэрийн авралын баталгаа болсон тамгыг олгож түүгээр дамжуулан лалын мөргөлт сүсэгтэн олноо жолоодон суух эрхтэй болдог жамыг дагасаар даруй мянган оныг үзжээ. Одоо Хорезм улс нэгэнт Чингис хаан таны Их Монгол улсын баруун хаяа болжээ. Багдадын халиф надад Чингис хаан тантай эвдрэлцэн дайсагнах бодол өчүүхэн ч үгүй юм. Ийм сэтгэлийн үүднээс таны жанжин Чормогон хорчийг хэдэн жилийн өмнө Багдадын ойр морилон ирэхэд найрсаг сайнаар угтан авч хаан танд өчүүхэн бэлгийг өргөн найрамдалтай явахаа баталсан билээ. Одоо ч энэ санаа хувираагүйг батална. Гэвч бид Аллах тэнгэрийн ариун зарлигийг эвдэх өөрчлөх эрхгүй юм. Одоо Хорезмын өмнөд нутгийг захиран суугаа таны хөвүүн Цагадайг бид хуучин султаны адил үзэн гүн хүндэтгэлтэй хандаж байна. Үүнийг Цагадай хаан бэлхэнээ батлах буйзаа.

Бид Цагадай хаанд лалын шашны ариун тамгыг шийтгэн олгож түүнийг султан мэт хүндлэн үзэж дээд эрхийг бариулахад татгалзан гэдийх зүйл өчүүхэн ч үгүй. Гэтэл Цагадай хаан нэгэнт манай лалын шашинд дагаж орох эсэх нь мэдэгдэхгүй удаж байгаа нь биднийг хүчир байдалд орууллаа. Цагадай хаанд цэрэг хүч их байвч тэр нэгэнт лалын мөргөлтөн биш нь бид түүнд ариун тамгаа шийтгэн олгох аргагүй болгож байна.

Ард нийтээр шүтэн биширч ивээлд нь багтсан Аллах тэнгэрийн мөргөлтөн болж Халифын тамгыг гардан авахгүйгээр лалын олон мөргөлтнийг зүй ёсоор захиран суухад бэрх болох нь гарцаагүй. Бид таны хөвүүн Цагадай хааныг лалын мөргөлтөн болбол өчүүхэн ч эргэлзгүйгээр ариун тамгаа олгох билээ. Чингэвэл Цагадай хааныг Хорезм даяар шүтэн дагаад зогсохгүй лалын мөргөлтний бусад улсуудад ч нэр алдар нь сайнаар дуурсагдан их хүчийг олох нь гарцаагүй билээ. Цагадай хаан лалыг мөргөлтөн болж султан алдрыг хүртэх аваас нийт лал мөргөлтний улсууд амарлин жаргах эх үндэс болох билээ. Чингис хаан та эл учрыг болгоож мэргэн шийдвэрээ талибах бизээ гэж элчийг илгээв” хэмээжээ. Бичгийг сонсмогц Чингис хаан бодолд оров. Энэ бол зөөлөн алгуур аястай ч шашин мөргөлийн нэр барьсан тулган шаардсан бичиг байв.

-Цагадай чи юу гэж гэж санана гэж Чингис хаан удаан суусангүй асуув. Хаан эцэг нь ингэж асууна гэж Цагадай шөнөжин бодож хоносон билээ. Халифын захидалд түүнийг Хаан хэмээн өргөмжлөн дурдсан нь Цагадайд ихэд сонсголонтой дуулдсан бөгөөд бас энэ захидалд түүний

цаашид хэрхэхийг тов тодорхой өгүүлсэн мэт санагдаад сэтгэл хөдлөн нойргүй шахам хоносон билээ. Үнэхээр Цагадайд өөрийн улсыг байгуулж Хаан эцгийнхээ адил Их хаан суух цаг нэгэнт ирсэн гэж итгэж байжээ. Гэвч Хаан эцэг нь юу гэж үзэхийг таах аргагүй тул хий хөөрөн догдлохоо тэвчих ёстойгоо ойлгожээ. Энэ бол тун осолтой тоглоом байв. Илэрхий тусгаар бие даасан бодлого барихыг Чингис хаан хэзээ ч үл тэвчдэгийг мэдэх тул түрүүлж хамаагүй дэл сул үг унагаж өөрийгөө илчлэхгүй байх нь хамгийн чухал гэж тэр үзжээ.

-Миний үзвэл энэ лалын шашинтан мөргөлчдийн амьдрах байдал сэтгэн бодох нь биднээс эрс өөр. Тэд Аллах тэнгэртээ даанч хатуу итгэдэг юм. Тэдэнд Аллах тэнгэрээс өөр хүчтэн, авралтан байхгүй гэж Цагадайн хэлэхэд

-Одоо ч тэгэж санасаар гэж үү гэж Чингис хаан асуусан нь Цагадайн үгэнд бухимдсаныг байв. Өөрийн эзлэн авсан нутгийн албат иргэд түүнийг биш харин өнөөх Аллах тэнгэр гэгчийг шүтсээр байгаа нь Чингис хаанд огтхон ч таалагдсангүй.

-Лалын мөргөлтнүүд газраар нэг таржээ. Энэ Тангуд улсын баруун талын хотуудын иргэдийн ихэнх нь лалын мөргөлтэй юм гэж Цагадай булзах маягтай өгүүлэв. Чингис хаан бодолд автжээ.

-Тэр элч бас заавал надад бараалхах хүсэлтэй гэв үү гэж Чингис хаан асуув.

-Тийм ээ. Гэвч надтай уулзсан нь түүнд болох биз гэж Цагадай санаагаа шууд хэлжээ. Учир нь Цагадай лалын мөргөлтнийг өөрийн албат боол гэж үзэж байв. Багдадын халифын элчийг Чингис хаанд бараалхуулах нь өөрийг нь дорд үзсэн хэрэг болно гэж тэр боджээ. Цагадайн энэ туйлын болгоомжгүй үг Чингис хааны хилэнг хөдөлгөж мэдэх байсан тул Боорчи болгоомжлон Цагадайд харцаар сануулсан боловч оройтжээ.

-Багдадын халиф нэгэнт лал мөргөлтний тэргүүн байгаад бас Чингис хаан надад захидал бариулан элч илгээжээ гэж Чингис хаан шивнэв. Цагадай буруу үг хэлж хаан эцгийгээ хилэгнүүлсэндээ айж цочоод тоош тонгойв. Гэвч Чингис хаан тэр дороо тайвшраад

-Халифын элчийг надад бараалхуул гэж зарлиг болжээ. Харин бараалхуулахын өмнө Гэрэгийг дуудан өнөөх элчийн ямархуу ааш аягтай хүн болохыг асууж сонсжээ. Учир нь Гэрэг тэр элчийг ирснээс хойш нүд салгахгүй ажиглан мөрдөж байжээ. Ирсэн элч буюу Чингис хааны хүрээнд гаднаас ирэгсдийг ингэж тагнаж мөрдөх нь эртнээс тогтсон хатуу ёс, торгон цэргүүдийн нэг үүрэг байлаа. Энэ дагуу Гэрэг ажиглаж мэдсэнээ өчжээ. Ал Каийд гэгч тэр элч өглөө үдэш бүр хавтгай модонд хутга зоох сургууль тогтмол хийдгийг сэм харж мэдсэн нь хамгийн хачирхалтай хэрэг шиг Гэрэгт санагджээ

-Тэр элч сүсэгтэн гэхээсээ алуурчин мэт санагдав гэж Гэрэг санаснаа нуулгүй хэлжээ.

-Түүнийг надад бараалхуулахдаа хутгыг авч сайтар нэгжигтүн. Миний дэргэд Мухулайг бай гэж хэл гэж Чингис хаан хэлэв. Гэрэгийн болгоомжлуулсныг үл хайхран тэрээр Багдадын элчийг хүлээн авчээ. Эгмээ хүрсэн өтгөн хар сахалтай цагаан алчуураар толгойгоо ороосон тэр элч үнэхээр зоригтой дайчин эрийн шинжтэй үзэгдэнэ. Угтан авах хүндэтгэх ёслол дуустал Чингис хаан үг дуугарсангүй.

-Ал Каийд гэж чиний эцгийн өгсөн нэр үү гэж Чингис хаан гэнэт асуужээ. Чингис хааны энэ санаандгүй энгийн асуулт Ал Каийдийг бяцхан сандраажээ. Ийм асуултаар яриа эхлэнэ гэж тэр даанч санасангүй. Түүний ингэж цочиж сандрахыг Чингис хаан ажиглав. Үнэхээр түүний ямар нэртэйг Чингис хаан мэдлээ гэж үү гэсэн бодол төрсөн тул элч тэрхэн зуур бодоод ийм өчүүхэн зүйлийг нуух нь утгагүй гэж үзэв.

-Тийм ээ. Чингис хаантан. Намайг уг нь Махмуд Аббас гэдэг юм. Би Мисир хүн л дээ. Багдадын халифын ордонд шадарлах болсноос хойш Ал Каийд гэж нэртэй болсон юм. Ал Каийд гэж эртний араб хэлээр Аллахын аврагч гэсэн үг гэж тэр дахин ийм гэнэтийн асуулт гарахаас сэргийлэн бүгдийг урьдчилан хэлжээ. Энэ нь зөв болж Чингис хаан түүнээс дахин элдэв зүйл асуусангүй ч Ал Каийд их л сэжигтэй болжээ. Чингис хаан түүнээс зүгээр нэг ингэж асуугаагүй гэж бодож суув

-Эрхэм элч ээ. Би танай Халифын сайхан сэтгэлээр илгээсэн захидлыг уншлаа. Та нарын шүтэн биширдэг тэр гэгээн Мухамед гэгч одоо хаана сууна. Чи түүнтэй уулзаж байсан байлгүй гэж Чингис хаан ярианы дундуур асуусан нь Ал Каийдийг хүнд байдалд орууллаа. Чингис хаан ингэж асуух нь аргагүй байлаа. Хорезмыг эзлэн аваад лал мөргөлтнүүдийн хөөрхий номхон байдлыг, шашин шүтлэгтээ хэт ихээр мунхарсныг үзээд тэднийг ингэж бишрүүлсэн Мухамед гэгч хэн болохыг мэдэх гэж олон нэртэй имамтай уулзаж ярьсан бөгөөд эцэст нь энэ бол хэн нэгний санаанаасаа зохиосон үлгэр болохыг олж мэджээ. Барыгжан уулын оройд гарч Аллах тэнгэр гэгчтэй уулзах гэсэн боловч тэр нь байгаагүй тул ийн асуужээ. Чингис хаантай уулзсан лалын мөргөлтөн бүр түүний энэ асуултанд хариулж чадаагүй бөгөөд өнөөдөр энэ Ал Каийд ч үгээ олж хэлж чадсангүй. Шашин гэгч ийм хоосон зүйл болохыг Чингис хаан мэдсээр авч харин хүмүүс бүгдээр түүнийг шүтэн биширсээр, түүний төлөө амиа өгсөөр байгааг л ойлгохгүй байжээ. Мухамед бол мянган жилийн өмнө амьдарч байсан Христос болоод Буддагийн адил хүн.

Харин үзэл сургаал нь олон түмнийг авран гийгүүлсээр байгааг Чингис хаанд тайлбарлахаас өөр арга Ал Каийдад олдсонгүй. Бас Чингис хаан гэгч тэнэг монгол энийг хэзээ ч ойлгохгүй гэж бодож байв. Гэвч Чингис хааны энэ ил шулуун үг сэтгэлд нь хачин дотно дулаан санагдахыг мэдэрчээ. Лалын мөргөлтнүүдийн гэгээн шүтээн Мухамед гэгч байгаагүй гэж ингэж хэлэх зоригтон Чингис хаанаас өөр хаана ч байхгүй гэдэгт Ал Каийд итгэж байв. Өөрийнх нь санааны мухрын орь ганц нууц хүслийг Чингис хаан ийн таах мэт хэлсэн нь түүнийг баярлуулж бас ихээр айлгав. Учир нь Ал Каийд хаад, эздийг нь алах замаар ямар ч улс гүрэн, үзэл бодлыг устгаж бас эзлэн дагуулж болно гэж төрөлхөөсөө итгэсэн нэгэн байв. Гэвч ганц хар биений нь хүчин чадал мөхөс тул санаа нэгтнээ цуглуулан хүчирхэг төмөр цэрэг байгуулахыг хийрхэн мөрөөдөгч байжээ. Тэр өөрийн дор ямарч аймшигтай аллага хийхээс буцахгүй үнэнч нөхөдтэй болж хамгийн их хаадыг устган ертөнцийг өөрийн өмнө сөхрүүлэн мөнхрөхийг хүсэж төлөвлөж байгаа ажээ. Ертөнцийг захирахын тулд хаадаас нь эхлэн алах нь хамгийн богино бөгөөд зөв зам гэж үздэг ажээ. Энэ нууц хүслээ биелүүлэхийн тулд Багдадын халифын дэргэд түүний итгэлийг олж шадарлажээ. Хорезмын хаан Желаладдин болон Багдадын халифын хооронд үүссэн зөрчил түүнд нэр нүүр олох сайхан боломж олгожээ. Хорезмын Желаладдин хааны талын нэр нөлөө бүхий хэд хэдэн хүнийг алж тусалсан нь түүнийг халифын нууц алуурчны зиндаанд хүргэжээ. Харин түүний дараагийн зорилго нь Хорезмыг захиран үлдсэн монголчуудын хаан Цагадайг алах хэрэг байв. Хэрэв



Хорезмд байгаа монголчуудын хаан Цагадайг алчихвал сүйрч доройтсон Хорезм Багдадын мэдэлд орох нь гарцаагүй бөгөөд ингэж чадвал монголчуудын хүчээр лал мөргөлтнүүдийг нэгтгэх үүд нээгдэх юм. Цагадайг алахыг Багдадын халиф зөвшөөрч байснаа эцсийн мөчид ухарч эхлээд хүчирхэг Монголчуудыг лалын мөргөлд дагуулан оруулах замыг сонгож Ал Каийдийг нааш илгээжээ. Юуны өмнө Чингис хааны ойр дэргэд шадарлаж түүнд зүтгэж байгаа олон лал мөргөлтнүүдийг талдаа татах нь хамгийн чухал гэж Халиф үзжээ. Халифын бодол зөв байв. Хэрвээ ингэж чадвал Монголчуудын хүчээр өөрийн нэрийн дор дорно болоод өрнө дахиныг нэгтгэн захирч бүгд Аллах тэнгэрийн дор нэгдэх билээ. Энэ бол Багдадын халифын хүсэл юм. Гэтэл Чингис хаан хэзээ ч лалын мөргөлийг тоож үзэхгүй нь тодорхой болжээ. Ал Каийд Чингис хаанд туйлгүй ихээр атаархаж байв. Түүнд Чингис хаан шиг их цэрэг байсан бол тэр муу Багдадын халифыг хамгаас түрүүнд үхүүлж эмс хатдыг нь эзэмдэх байв. Ийм нэг этгээд гаж донтон түүний өмнө лалын мөргөлтний дүрээр сууж байгааг Чингис хаан гадарласангүй билээ.

-Багдадын халифын захидлын хариуг Цагадай нутагтаа очоод өгнө гэж Чингис хаан хэлснээр тэдний уулзалт өндөрлөв. Харин Ал Каийд Чингис хааныг алахаар шийджээ. Түүний хамгийн өст дайсан нь Чингис хаан гэдгийг Ал Каийд ойлгожээ. Энэ ертөнцийн хамгийн хүчирхэг хааныг алснаар Ал Каийдийн нэр үүрд мөнхрөнө гэж санав. Ийм боломж ганцхан удаа олдох бизээ. Тэгмэгц Ал Каийд баяртай болж Чингис хаан гэгч агуу хаантай учруулж түүний мөнхрөх замыг нээсэн Аллах тэнгэртээ хашгиран мөргөжээ. Ал Каийд энд Чингис хаантай хамт үхэхээр шийдэв. Түүний агуу их нэр төрийн мандах цаг, мөнхрөх хором энд иржээ. Ал Каийд ганцхан үүний төлөө зорьж тэмүүлж амьдарсан билээ. Тэр Ал Каийд нэрнийхээ учрыг тайлж Аллах тэнгэрээ аврахаар эргэлтгүй шийджээ.

Өргөөнд Боорчи Цагадай хоёрыг орж ирсний дараа түрүүнээс хойш ганц үг дуугараагүй Мухулайгаас

-Чи юу гэж санана гэж Чингис хаан асуужээ. Чухам түүний үгийг сонсох гэж л энд суулгасан билээ. Мухулай гэрэлт нүдээрээ хаан эзнээ харж суугаад бодсон ч үгүй

-Ийм хүнийг үтэр түргэн тонилговол зохино. Тэр хаан таныг алахыг хүсч байна гэж шууд хэлэв. Хэн ч юу ч хэлсэнгүй. Мухулай өөрийн далдыг таадаг зөн совингоороо эзэн хаанаа аварсан нь энэ юм.

-Лалын мөргөлтний дунд ийм хүн олон болж мэднэ. Цагадай дүү чи болгоомжтой байгтүн гэж Мухулай дахин хэлэхэд ч дуугарцгаасангүй. Чингис хаан юу гэхийг хүлээж байв.

-Цагадай. Би Мухулайн адил санана. Энэ Ал Каийд гэгч яг алуурчны нүдтэй юм. Тэр нэгэнт тусгаар улсын элч тул энгийн нэг алуурчны адил үзэж үл болно. Элчийг даруй хүндтэйгээр үдэн мордуул. Харин итгэлтэй хүмүүсээ дэргэд нь дагалдуулж яг Багдадын хэрмийн гадна хүргээд түүнийг хороогтүн. Харин Багдадын халифад ямар хариу өгөхийг би Цагадайг буцахаас өмнө хэлнэ гэжээ.

Маргааш өглөө сэрэхэд Ал Каийдийг үдэх гэж торгон цэрэг жагсаж бас Багдад хүртэл дагалдан явах баг цэрэг бэлэн болсон байсан нь хэн нэгэн Ал Каийдийн нууц бодлыг таасан мэт болжээ. Аллага хийх замаар ертөнцийг захирах донтон Ал Каийд гэгч ингэж Багдадын

хэрмийн гадна үхдэл болон аймшигт мөрөөдөлтэйгөө хамт булагджээ. Тэр амьсгал хураатлаа Чингис хааныг алах их хүсэлдээ шатсаар, өөрийн үхэж байгаад огт итгэхгүй байсаар гол нь тасрахыг Цагадайн хөвүүн Есөнмөнх гайхан харж байжээ. Ингэж удаан амь тавьдаг, долоон голтой хүнийг огт үзсэнгүй байжээ. Толгой нь биенээс тасарсан мөрт нүд нь анивчин ам нь ангалзаж ямар нэг зүйлийг хашгирсаар байжээ.

Энэ бол гарцаагүй зөв шийдвэр байсан гэдэгт Боорчи итгэлтэй байлаа. Учир нь Мухулай ер хоосонгүй, ойр зуурын юм мэдэж, таадаг тул ингэжээ. Элч бүр янз янзын санаа өвөрлөж ирэх юмдаа гэж Боорчи боджээ. Загалмайн мөргөлтний тэргүүн Римийн их ламын элч Авраам Даяан гэгч тэр сэтгэлийн хөөрөлтэй эрийг заль зохиож сайхан бэлэн үг хэлээд бултан алга болов гэж Боорчи боддог ажээ. Уг нь Боорчид Даяаны ирсэн Римд очих хүсэл их байсан билээ. Сүбээдэйг Калка голын хөндийд Киевийн их вангийн цэрэгтэй тулалдаж Орос, Хивчагийн нэгдсэн цэргийг хиар цохин сөнөөгөөд байхад Боорчи Гэрэгийн хамт очжээ. Голын хөндий дагаад морьтой явж болохын аргагүйгээр орос, хивчаг цэргийн хүүр овоорсныг тэд зайчлан явсаар арайхийн хүрчээ.

Тэр үдэш Сүбээдэй орос, хивчагийн олзлогдон бууж өгсөн цэргийн ван, ноён сурвалжит зуун хүнийг газарт хэвгүүлээд дээр нь шал тавьж, ширээ идээ засаад Боорчийг хүндэтгэн найр хийжээ. Нутгийн шар үст бүсгүйчүүдийг авчирч өмнөө бүжиглүүлж, дараа нь тэднийг өөрийн цэргүүдэд шагнаан тарааж өгчээ. Орос бүсгүйчүүдийн орилолдох тэр шөнөжингөө тэнгэрээр нэг хадсаар байжээ. Тэд үүр цайтал найрлаж харин шалны доороос “Помогите” гэж хашгирах дуу тод сонсогдсоор байснаа сүүлдээ шивнэх төдий болж эцэст өнөө орос ноёд бүгд дарагдан үхжээ.

Ийнхүү Калка голын хөвөөнд орос ноёдоор амьд ширээ засаж найрлан суухдаа Римд очих хүсэлтэйгээ Боорчи Сүбээдэйд хэлжээ. Сүбээдэй энэ үед амьд могой авчруулаад зүрхийг нь сугалан авч архинд хийгээд түүнийг дайлах гэж байжээ.

-Биеийн чалханд гайхалтай эм гэдэг юм даа гэж Сүбээдэй бахархан хэлээд аягатай улаан архиа цустай гараар барьжээ. Боорчи эргэлзсэнгүй залгиж орхив. Могойн зүрх хэлэн дээр нь тогтоод булхалзан цохилж байх нь мэдрэгдээд хоолой давав. Ходоодонд орсон хойно нь ч могойн зүрх цохилоор байв.

- Чи миний хэлснийг сонссонгүй юу гэж Боорчи хэлэв. Сүбээдэй могойн зүрх сугалахдаа амтшин сатаарсан тул Боорчийн үгийг анзаараагүй байжээ.

-Чи юу гэнэ гэж Сүбээдэй өрөөсөн нүдээрээ цоо ширтэв.

-Рим гэгч улсыг би үзэхийг хүснэ гэж Боорчи шууд хэлэв.

-Чи тэнд очиж яана.

-Өнөө Римийн ламын элч Даяан гэгч намайг урьсан юм. Биднийг очвол хэрмийнхээ үүдийг нээж угтана гэсэн билээ. Хэрэв тэр Римийн их лам тийм их нөлөө эрхтэй нь үнэн бол юуны түрүүнд түүнийг эзлэн авбал зохино гэж Боорчи хэлэв.

-Чиний ингэж бодох чинь яг зөв байна. Би ч бас тэгэж бодож байна. Уг нь одоо эндээс ухасхийвэл ч юу байх вэ дээ. Чи бид Чингис хааныхаа зарлигийг дагахгүй бол яаж болно. Ер нь очсон хойноо энэ бүгдийг Чингис хаанд айлтган нааш дахин ирвэл зохино гэж Сүбээдэйн хэлснээр тэдний Римийн тухай яриа төгссөн билээ. Үнэхээр Чингис хааны нутаг буцах зарлигийг зөрчих эрх тэдэнд байсангүй. Ингэж Даяаны үнэн хэлсэн эсэхийг мэдэх боломж Боорчид олдсонгүй.

Гэвч Даяан гэгч тэр өрөөсөн хөмсөгт эр одоо нэгэнт үгүй болсныг Боорчи мэдсэнгүй. Ертөнцийн эзэн аврагч Ийсүсийн элчтэй уулзаж гэгээрсэндээ солио туссан Даяан өөрийн үзэл бишрэлдээ хөтлөгдсөн чигээр Римд очиж их ламдаа бараалхан Перваны хөндийд Ийсүсийн элч Чингис хаан морилон ирж лалын шашинтнуудыг гэсгээн дараад байгааг үзсэнээ бахархал дүүрэн өчжээ. Чингис хаан бол Ийсүс Христосын авралд багтсан Тэнгэрийн элч болохыг батлан хэлсэн түүний үг Римийн хамба ламын өргөөг эвдэн бусниулах шиг болжээ. Талын зэрлэг нүүдэлчид Ийсүс тэнгэрийн элч байх нь загалмайн мөргөлтний ихэс дээдэст үзээгүй доромжлол байсан тул бүгд нэгэн дуугаар хөөрхий Даяаныг талын зэрлэг нүүдэлчдийн мэхэнд унаж тэдний тагнуул болов гэж үзжээ. Энэ солиорсон мэдээ олонд тархвал түймэр мэт аюултай гэж хамбын зөвлөл хуралдан шийдээд шөнө нь түүнийг баривчлан хорьж маргаашнаас нь тэрслүү үзэлт, буруу номтон болсныг зарлав.

Даяаныг Римийн төв талбайд их түүдгийн дээр шатаан алав. Ертөнцийн эзний элч улаан сорвит монгол эр Боорчи Тэнгэрээс буун ирж аврана гэж итгэн залбирсаар загалмайн шашны үнэн сүсэгт Даяан гэгч эр шатаж үхжээ. Түүнийг үхсэний дараа бүх ном сургаалыг нь хаман авч шатаан устгажээ. Даяаны шавь нар, эхнэр хүүхдийг нь ч мөн адил алжээ. Ингэж талын нүүдэлчдийн хаан Тэмүжинг Ертөнцийн эзний элч байсныг мэдэж байсан цорын ганц хүн үгүй болов. Одоо Даяаныг Рим даяар хараан зүхэж байгааг Боорчи мэдсэнгүй билээ. Римд байсан Сүбээдэйн нууц тагнуул Авраам Даяаны тухай энэ гунигт түүхийг хожим нотолжээ. Лалын мөргөлтний ариун төв гэгдэх Багдадын халифын элч, урт хар сахалтай, толгойгоо цагаан даавуугаар ороосон Ал Каийд гэгч эрийг үдэж өгөхдөө энэ элчид ямар хувь заяа тохиох гэж буйг Боорчи харин мэдэж байлаа.

*ҮХЭЛТЭЙ УРАЛДСАН ЗОЧИН*

Багдадын элчийг буцсаны дараа Чингис хаан, Мухулай, Сүбээдэй гурвыг Боорчи өөрийн хээрийн өргөөндөө залж дайлжээ. Энэ бол жирийн нэг дайлж, цайлсан хэрэг биш юм. Ийм дайллага жирийн уулзалтын үеэр Чингис хааны үйл, бодлогын далд учир начир тодрон гарч боловсрогддог билээ. Нэгэнт хийдгээ хийж үеэ өнгөрөөж буй тэдэнд бодох санах, хийж гүйцээх хэрэг тун олон байлаа. Бас ингэж найр наадам үүсгэх нь Чингис хааныг өвчнөө мартан илааршихад тустай гэж үзжээ. Тэр үдэш Боорчи тэднийг өөрийн гараар сорс хийж дайлсан нь бүгдэд таалагдсан бөгөөд Онон, Хэрлэн, Туулын хөндийгөөр өнгөрөөсөн идэр залуу насыг нь эрхгүй санагдуулжээ. Тэд Боорчийн өргөөнд тухтай сайхнаар ярилцаж суув. Найрын дундуур гараад орж ирсэн Боорчи ихэд ёсорхон

-Чингис хаантан. Танд нэг хүн бараалхахаар иржээ гэж мэдэгдэв.

-Өнөө орой хэнтэй ч уулзахгүй хэдүүл дотно сайхан наргия гэж тогтсон биш үү. Маргааш бол гэж Гэрэгт хэл гэж Чингис хаан ундууцжээ.

-Хаантан энэ хүн тантай уулзах гэж тун олон жил явжээ. Бүр жаран найман жил явсан гэнэ гэж Боорчийн огт тоглосон янзгүй хэлэхэд бүгд гайхав.

-Хэн бэ тэр чинь.

-Та үзмэгц таних биз гэнэ.

-Яах вэ уулзах нь зөв үү. Та нар юу гэж бодно.

-Ийм чухал зочныг хүлээлгэж болохгүй гэж санана гэж Боорчи бусдаа төлөөлөн хэлэхэд

-Тэгвэл оруул гэж Чингис хаан зөвшөөрөв. Боорчи гарч, юүдэн нөмөрсөн, таягтай хүнийг дагуулан орж ирэв. Өргөөнд бамбар дүрэлзэвч гэрэл нь үл хүрэлцэх тул тэд өнөө хүнийг үзмэгц таньсангүй. Бас тэр хүний нүүр царай нь юүдэн дороос сайн харагдахгүй байжээ. Өнөө хүн хөлөө арайхийн зөөх нь шархтай бололтой гэж бодогдмоор ажээ.

-Ертөнцийн хаадын хаан Их Чингис хаан таны амар амгаланг эрье. Боол чинь хөл нугарахгүй өвчтэй тул хаан танд сөхөрч үл чадна. Өршөөгтүн гэж өнөө хүн хэлэв. Бүгд үзэхээр өндийжээ. Чингис хаан бүр ухасхийн босоод

-Боол гэнэ ээ гэж хашгирчээ. Тэр андуурсангүй. Энэ бол Зэлмэ байв. Тэмүжиний унаган боол Жарчудай дарханы хөвүүн урианхайн Зэлмэ ирсэн нь үхдэл амилаад босоод ирсэн мэт цочмоор хэрэг болжээ.

-Ах аа гээд Сүбээдэй үсрэн босов. Чингис хаан даруй түүнд дөхөн очив.

-Зэлмэ. Чи юу. Эсвэл би зүүдэлж байна уу гэж Чингис хаан хашгирав. Түүний сэтгэл догдлон хөдөлжээ.

-Тийм ээ. Хаан та зөв таньжээ. Би таны боол Жарчудайн Зэлмэ байна гэж Зэлмэ хөл дээрээ арайхийн тогтож ядан шивнэв. Их хүчилсэндээ түүний хөлс дусаж хөл нь чичирч байв. Тэр

Чингис хаантай босоо уулзахыг хүссэн тул өвчтэй биеэ ингэж зовоож эцсийн хүчээ шавхжээ. Үүнийг мэдэж байсан Боорчи түүнийг хөтлөн Чингис хааны сууж байсан сэнтийд өргөх шахам суулгав.

-Хаантан өршөө. Миний хөл нугарахгүй тул би аргаа барж Хаан таны сэнтийд суув. Уг нь би хэвтгээр санагдана. Гэвч би та нарын дэргэд яаж хэвтэх билээ гэж Зэлмэ шивнэв. Бүгд хэлэх үгээ олохгүй догдолж хөөрчээ. Хамгийн түрүүнд Сүбээдэй ахтайгаа очиж золгов. Сүбээдэй ахтайгаа уулзсангүй найман жил болжээ.

-Би дүү чамтай уулзахгүй гэж санаж явлаа гэж Зэлмэ нулимс унагав. Бүгдийн нүд нулимсаар дүүрчээ.

-Би хаан таны заасан нутаг Хянганы нурууны ар Айраг нуурын дэргэд үхэж эс чадлаа. Та нарыг энд цугларав гэж сонсоод үхлээс зугатааж биеэ зовоож нааш ирлээ. Бусдыг дуудаад намайг хүн гэж тоож хэл өгдөггүй байжээ. Та гэж Зэлмийн гомдон хэлсэн нь аргагүй тул хэн ч тайлбар хийж чадахгүй болжээ. Чингис хаан Мухулай Сүбээдэй нарыг дуудсаныг Есөнтэй хөвүүн нь хэл хүргүүлж, яаж ийгээд ирэхийг хүсчээ. Есөнтэй, эцгийнхээ сэтгэлийг сайн мэдэх сүрхий ухаантай хүн тул олон жил ганцаар хэвтсэн эцгийгээ өрөвдсөн учир ингэжээ. Тэгээд Зэлмэ замдаа үхэхийг үл тоон нааш гарсан нь энэ байв. ”Би замд үхвэл миний хүүрийг Чингис хаанд үзүүлж хаана оршуулахыг түүгээр заалга” гэж албатууддаа тушаагаад ухаантай, ухаангүй хоёрын хооронд Тангудад арайхийн иржээ. Зэлмийн өвчин нэн хүнд тул тэр олон үг ярисандаа ядраад амьсгаадаж зөвхөн шаналгаатай, чимээгүй инээмсэглэхээс цаашгүй ажээ.

-Зэлмэ чамайг хараад миний сэтгэл ханав. Чамайг дуудаагүй нь зөвхөн чиний биеийг бодсоных юм. Би ер нь сар бүр чамд хишиг хүртээхээ мартаагүй шүү. Чамайг үзмэгц би нутагтаа харихыг яасан их хүснэ. Зэлмэ чамайг хараад бадмалсан зул шиг бага нас минь санагдав. Есүхэй эцгийгээ хорлуулаад орилж хэвтсэн Тэмүжинг би одоо харж байна. Тэр гашуун нулимс аманд амтагдаж хоолой хорсгож байна. Би энэ нулимсны амтыг яаж мартана. Би энэ газрын бүх амтаг дарсыг уув. Тэр дарс болгоноос миний нулимс амтагдах шиг болдог юм. Тэр нулимс миний цусанд нэвчсэн бололтой. Зэлмэ чи тэр гашуун нулимсыг амтлуулав. Зэлмэ чи миний дэргэд суугаад нулимсыг минь арчиж байж билээ гэж Чингис хаан өнгөрснийг дурсан санаад нулимс урсган хэлжээ.

-Би танд хамгийн гашуун дурсамжийг санагдуулжээ. Есүхэй эцэг чинь үхэхэд “Одоо өнчин бид яана. Ингээд бүгд үхнэ дээ” гэж бодсонсон. Гэтэл үхсэнгүй өдий хүрлээ. Би уг нь хаан танд Сүн улсыг хурааж өгье гэж их хүссэнсэн. Гэвч Тэнгэр миний хүслийг таалсангүй. Одоо хөвүүд, ач нар минь дутууг гүйцээж дундуурыг дүүргэнэ биз. Ер нь ертөнцийн хагасыг тэдэнд үлдээх нь зөв. Есөнтэй хөвүүн намайг орлон морийг чинь хөтөлж өргөөг чинь сахиж явна. Үүнээс илүү би юу хүснэ. Хөвүүнээ үзэв, дүү Сүбээдэй чамайг үзэв. Өвгөн болсон Боорчи, Мухулай нөхрөө үзэв. Хаан таны дэргэд ирж гэгээн дүрийг чинь харлаа. Одоо би үхэхэд харамсах зүйлгүй болов. Амьд явах цөөн хэдэн хоногийг минь Хаан эзэн та авагтүн. Би одоо амьдарч ханав гэсэн нь Зэлмийн сүүлчийн үг байжээ. Түүний энэ үгэнд сэтгэл хөдөлсөн тэд удтал дуугүй суув. Зэлмийг гэнэт амьсгаагүй болсныг Боорчи түрүүлэн мэдэв. Зэлмэ нэгэнт амьсгал хураажээ. Гурван настай Зэлмэ хөвүүнээ Жарчудай дархан Тэмүжинг төрөхөд боол болгон бэлэглэснээс хойш тэд хагацсангүй билээ. Зэлмэ ингэж жаран найм наслав. Тэмүжин эзэндээ хиргүй үнэнч сэтгэлээр зүтгээд өнөөдөр дэргэд нь ирж үхэв.

-Хэлээ залгиж үхжээ гэж Боорчийг шивнэхэд бүгд түүний дэргэд сөхрөн суужээ. Чингис хааны харамсал гэмшил хичнээн их байгааг түүний сул асгарах нулимс илчилж байв.

-Урианхайн сайн Зэлмэ чи элгийг минь эмтэлж яагаад үхэв. Чи үхлийг өөрийн дэргэж дуудан ирүүлэгч шидтэн байсныг би мэдсэнгүй явжээ. Хэн чам шиг ингэж чадна. Чи залуу насаа дурсаж ганц шөнө хуучилж суухгүй юунд ингэж яаран одов. Чи амалсандаа хүрэлгүй юунд намайг орхив. Чи миний хойно үхэх ёстой бишүү. Чи яаж үхэхийг надад заалгүй юунд үхэв. Чи үхлээс айлгүй түүнийг өөрийн эрхэнд оруулж чаддаг байжээ. Та нар харцгаа. Энэ хүн миний их улсыг байгуулаад амиа өргөв. Үүнийг бүү март. Та нарын өмнө Урианхайн Жарчудайн хөвүүн Зэлмэ хэвтэж байна. Бүх цэргийг жагсаагтун. Би Зэлмийн үхлийг өөрийн биеэр зарлана гэж Чингис хаан хашгираад бахардан унажээ. Зэлмийн үхэл ганц Чингис хааныг биш бүгдийг ихэд цочоожээ. Зэлмийг яг үхсэн газарт нь гэртэй нь онголох зарлигийг Чингис хаан буулгаж ёсоор болгов.

Зэлмийн үхэлд цочирдсон Чингис хааны бие дахин чилээрхэж хэвтэрт орсон нь бүгдийг түгшээв. Гэвч Чингис хааны бие чилээрхсэнийг нууцалж байв. Зэлмийн үхэл Чингис хааны үхлийн хоёрдох дохио байсныг тэр ойлгожээ. Мориноос унаж бэртсэн нь эргэн илаарших янзтай байсан ч Зэлмийн энэ гэнэтийн үхэл сэтгэл санааны тэнцвэрийг алдагдуулжээ. Чингис хаан одоо өөрийн үхлийг хүлээж байв. Зэлмийн энэ сайн дурын зоримог үхэл Чингис хааны үзэл бодлыг гүнзгий ихээр өөрчилжээ. Үхэхэд бас учир байжээ. Үүнийг Чингис хаан бодсонгүй ажээ. Одоо Чингис хаан хэрхэн үхэх тухай бодох болов. Жамуха яах гэж хэрцгий догшноор цаазлахыг шаардаж байсан учрыг ойлгов. Яаж үхсэнээр нь хүнийг хэмжиж, үнэлж болох мэт санагдаад байлаа. Зэлмэ шиг хэлээ залгиж үхэхэд зүрх зориг, тэвчээрээс гадна олон жилийн дасгал сургууль хэрэгтэйг ойлгов. Олон жил хэвтэрт байхдаа сургуулилсаар Зэлмэ хэлээ залгиж чадах болсныг ч ойлгов. Бас Жамухын хүслийг биелүүлж хэлснээр нь далан агтны сүүлнээс зүүж алаагүйдээ ч харамсав. Жамухын үхэхийн өмнө хэлсэн үг санагджээ. "Хүссэнээрээ үхэж болохгүй тийм цаг чамд ч ирнэ. Тэр цагт намайг ойлгох болно" гэж Жамуха хэлсэн билээ. Чингис хаанд яг Зэлмийн адил өөрийн дураар шийдсэн үедээ үхэх хязгааргүй их хүсэл төрж байв. Гэсэн ч бас үхэхгүй мөнх амьдрах хүслийг түүний их сүр, нэр төр оргилуулах тул тэрээр үхэл, мөнх амьдрах хүсэл хоёрын дунд сэтгэл хоёрдсоор байлаа. Тэнгэрээс ирүүлж буй үхлийн дохио дэндүү тод ойлгомжтой байгаа нь түүнийг үхэлдээ бэлдэхийг өөрийн эрхгүй шаардсаар байв. Харин нэгэн зүйлийн учрыг тод ойлгож авчээ. Зэлмэ зүтгэн ирж дэргэд үхсэн нь өөртөө үлдсэн цөөн боловч хоног хугацаагаа түүнд үлдээснийг мэджээ. Хэрэв Зэлмэ ирж түүний орноос амиа өргөөгүй бол тэр үдэш Чингис хааныг үхэл авч одох байжээ. Ийм нэг учрыг мэдсэн нь Чингис хааныг яарахад хүргэв. Зэлмэ унаган боолын тангараг ёсоор эзэн Тэмүжинийхээ төлөө үлдсэн амьдралынхаа цөөн хоногоо зориулжээ. Нөхөд нь түүнийг үхүүлэхийг хүсэхгүй байгаад Чингис хаан туйлын ихээр уяран догдолж байв. Гэвч түүнд үхлийг ялах хүсэл оргилсон хэвээр ажээ. Өнөөг хүртэл зүдэрч байгуулсан хүчирхэг улс, их эрх мэдэл нь үхлийг ч болов дийлэх хүслийг оргилуулж тэр үхэхгүй юм шиг санахад хүргэжээ. Чингис хаан болоод түүний шадрууд мөнх амьдрах арга замыг уйгагүй эрэн сүвэгчилж байлаа. Тийм ч уचाас Перс, Орос, Хятад газрын нэртэй зартай эмч домч, төлөгчдийг цуглуулан авчрав. Тангудын нийслэл Жинсинфу балгасыг бүслэж суух ахуйд Чингис хааны өргөөний дэргэд газар газрын зуу гаруй оточ мэргэд, ид шидэтнүүд цуглараад байв. Тэдний хэн нь ч мөнх насыг амлаж чадахгүй байлаа.

Тангудын бараг бүх хот балгас эзлэгдэн ганц Жинсинфу л үлджээ. Тангудын нутагт Монголын цэрэг багтах шингэх газаргүй болсон тул Чингис хаан дараагийн төлөвлөснөө гүйцэлдүүлж эхлэв. Өгөдэйн цэрэг, Мухулайн цэрэгтэй хүч хавсран Алтан улсын Жишижоу, Линьтафу, Тажоу, Хэжоу, Сининь, Дэшюнь хотуудыг эзлэн авсанд Чингис хаан хөдөлж Алтан улсын Люнаньшань ууланд гарч зусав. Энд арай сэрүүн тул биеэ сувиалан тэнхрүүлэхэд дөхөмтэй ажээ. Чингис хаан хүссэндээ хүрч Люнаньшань ууланд байхад нь бүтэн сар бүслэгдэн сууж хамаг цэргээ алдсан Тангудын Буур хаан хөвүүд, хатад эмсээ дагуулан хотоосоо гарч ирж буун өгөв. Энэ мэдээг тэр даруй Чингис хаанд хүргэжээ. Буур хааны эцсийн бэхлэлт Жинсинфу балгасыг Цагадай бүсэлж суусаар байжээ. "Буур хааныг өртөө газраас явган явуулж өдрийн газраас өвдгөөр мөлхүүлж үзэгдэх газраас элгээр хэвтүүлж надад бараалхуул. Тэр Чингис хаан намайг хэр удаан хүлээлгэснээ өөрийн зовлогоор үзэг" гэсэн Чингис хааны зарлигийг Гэрэг Цагадайд хүргэж иржээ. Ингээд улсаа алдсан Буур хаан зуны аагим халуунд хатад хөвүүдээ дагуулан өртөө газраас явган алхаж өдрийн газрыг дөрвөн хөллөн туулж өндөр бэлийг элэглэн мөлхөж бараад гуйвж, дайвсан амьтад гурван өдрийн хойно арайхийн Чингис хааны хүрээний захад очив. Чингис хаан түүнийг шадар, хөвүүдийн хамт их өргөөндөө хүндэтгэлтэйгээр хүлээж байв. Өмссөн хувцас нь урагдаж өмнө бие нь нүцгэрсэн тэднийг тэр чигээр бараалхуулав. Харин замд Буур хааны хатад хөвүүд охидоос үлдсэн хоцорсон бүгдийг Гэрэг өөрийн гараар цавчин алжээ. Монгол болоод Тангуд улсын хооронд үргэлжилсэн хорин жилийн дайн ингэж Тангуд улсын бүрэн мөхлөөр дуусах өдөр ирж Буур хаан их үгнийхээ золиос болж явган нүцгэн мөлхсөөр Чингис хаанд мөргөв. Буур хаанд үхэх хүсэл байсангүй. Уг нь Монголын цэргийг дайран ирэхэд урьд хэдэнтээ аргалсан ёсоороо бэлэг сэлт өргөн бууж өгсөн бол Тангуд улс мөхөхгүй бас хэдэн жил болох байлаа. Гэвч Буур хаан хөөрүү, нэрэлхүү зандаа хөтлөгдөж бас цэргийн тоо олондоо эрдэн шадар түшмэлийнхээ ойворгон занд автан дэмий эсэргүүцсэн нь Тангуд улсыг мөхөөхөд хүргэж Алтан улс гол холбоотноо алдан баруун тал нь нүцгэрэн гар мухар болжээ. Буур хаан өртөө газраас мөлхөн ирж улсынхаа тамгыг тушаасан нь Алтан улсад үхлийн дохио боллоо. Буур хаан алтан тамгаа Чингис хаанд өргөн барив. Тангуд улсын төрийн тамгыг Тулуй хураан авчээ.

-Тангуд улсын Буур хаан би хаадын хаан Их Чингис хаанд Гэйхүү хатныхаа хамт мөргөж байна. Тангуд улсын эзэн дээдсээс өвлөн ирсэн шүтээн алтан тамгыг Танд өргөн ивээлд тань багтахаар ирлээ. Миний улс нэгэнт хүчинд автан Чингис хаан таны их улсын дээвэр доор бүтнээр орлоо. Хэрхэхийг Чингис хаан таны зарлиг мэдэг гэж Буур хаан Гэйхүү хатны хамт мөргөжээ. Чухам ингэхийг Чингис хаан хүсэж Тангудын халуун нутагт бүтэн жил хагас тэвчин суусан билээ.

-Буур хаанд хэл. Энэ мөчөөс хойш Тангуд гэж улс үгүй болсон тул Тангуд гэж дахин бүү хэлэхтүн. Улс чинь нэгэнт үгүй болсон тул Буур хаан нэрийг чинь өөрчилж чамайг Шударга гэж нэрлэе. Одоо чи нэгэнт миний албат болсон тул тэр баруун талд миний ач нарын дор суугтүн гэж Чингис хаан зарлиг болгов. Балчир ач нарын зүгээс хэн нэг нь жиг жиг хөхрөх сонсдоод чимээгүй болжээ. Навсарч цоорсон хувцастай Буур хаан үнэхээр гутамшиг, инээдтэй үзэгджээ. Уг нь тэр ингэж доромжлогдож байхаар үхэх байжээ. Гэвч тэр амьд явахыг хүсчээ. Амьд явах хүсэл нь лав Тангуд улстай тэнцэж байлаа. Тэр өөрийн амийг бүтэн улсаараа арилжив. Удалгүй Монгол хуурч дуучид орж ирээд ая дуу өргөжээ. Энэ нь Тангуд улсын мөхлийн дуулал болон сонсдов. Шударга нэртэй болсон Буур хааны хатан Гэйхүү

тэсэлгүй уйлжээ. Алтан хааны гүнж энэ бүсгүй цэвэр үзэсгэлэнтэй нас залуу ажээ. Урт ёслол дуусав. Ийм урт ёслолыг зохиосон нь Тангудын Буур хааныг залхаан тавлах нэг арга байлаа. Ёслолын дараа Шударга хаан хүний ёсоор босож ингэж хүндэтгэл үзүүлсэнд талархан бөхийв.

-Шударга чи газар нутаг, тэмээ малаар арвин, шавар оромжинд шавалдан суугч тангуд иргэнийг надад дагаар оруулан амирлуулсанд би чамайг сайшаан шагнах ёстой юм. Би чамайг өөрийн үнэнч шадрын ёсоор үзэж өөрийн охин Тэнүүнбилэгийг чамд хатан болгон шагнан өгье гэж Чингис хаан хэлэв.

Чингис хааны энэ үгэнд бүгд цочиж, Есүй хатан бараг муужран унах дөхжээ. Дөнгөж арван тав хүрч буй хамгийн хайртай, энхрий охиноо ингэж эсэргүүцэн тэмцээд эцэст нь ичгүүр гутамшигтайгаар бууж өгч буй дайсандаа шагнан өгсөн нь байж боломгүй доромжлол мэт ойлгомжгүй санагдсан ч хэн ч дуугарч түвдсэнгүй.

-Чиний үр удмыг миний шадрын үр удам гэж миний Алтан ургийн үр сад үеийн үед асарч явах болно. Чиний үр удам үеийн үед миний охин Тэнүүнбилэгийн боол болж босгоны дэргэд сууж зүтгэгтүн гэж Чингис хаан үргэлжлүүлэн зарлиг болгожээ. Тэнүүнбилэг охиныг уйлуулан авчирч Шударгын дэргэд суулгав. Есүй хатан арай л уйлсангүй. Чингис хааны энэ зарлиг олны дургуйцлийг төрүүлж байгаа нь илт байсан ч тэр огт анзаарч тоосонгүй. Учир нь бүх хэргийг тэр нэгэнт дотроо аль эрт шийдэн тооцсон байжээ.

-Тэнүүнбилэг охин минь бүү уйл. Чи бол миний охидын дотроос ухаан эрдэм, уран гоолигоороо онцгой нь билээ. Би энэ Шударгын гавьяаг үнэлж чамайг шиллээ. Би чамд хайртайн учир бас Есүй хатан эхийн чинь ухаан саруулыг, улсдаа зүтгэснийг үнэлсний учир би чамайг энэ Шударгад өгч байна. Чи энэ өдрөөс эхлэн Тангудын хааны хатны эдэлж байсныг эдэлж, өмчилж байсныг авагтун. Жинсинфү балгасыг эзэмшин суугтун. Тангуд иргэдийг захиран халамжлагтун. Энэ өдрөөс эхлэн Тэнүүнбилэг чиний зөвшөөрөл зарлиггүйгээр тангуд иргэнийг хувааж зөөхийг би цаазлаж байна. Чи дайнд нэрвэгдсэн тангуд иргэдийг асарч тэднийг их улсдаа зүтгүүл.

Чингис хааны далд бодлыг сая л нэг ойлгож сонссон бүгд инээмсэглэн царай тэнийлгээд Есүй хатан амьсгаа авч нулимсаа арчжээ. Шударга бүр ч сэтгэл ханав. Чингис хаан гэнэт өөрийн хайртай охиноо өгсөн нь Тэнгэрийн аврал болж сохорсон биш завшив гэдэг болжээ. Тийм учраас Шударга үсрэн босож Чингис хааны хөлд мөргөөд

-Чингис хаан таны ивээлд би сэтгэл ханав. Алтан урагт чинь багтаж авралд чинь шүтэж явахаа тангараглая гэж хашгирчээ. Гэвч тэр дэндүү яарчээ. Харин Шударгын ийм хачин авирласанд Гэйхүү хатан нь тэвчиж эс чадаад өөрийн хэлээр нэг зүйлийг тэчъяадан зандарсан ч тэр эмийн бухимдлыг хэн ч тоосонгүй өнгөрчээ. Чингис хаан тааламжтайгаар инээмсэглэж байв. Сэтгэл нь үнэхээр тэнүүн сайхан болжээ.

-Шударга чи сонсож бай. Хэн боловч зүтгэлийн хирээр харамж хүртэж, нүглийн хирээр гэгсгээл амсахыг би Тэнгэрийн зарлиг гэж санана. Тийм учраас Шударга чиний гавьяаг үнэлэв. Харин би чиний өдүүлсэн ялыг тоочъё гэвэл нэгэнт өөртөө итгэлтэй болж хууртсан Шударга



-Би таны чин шударга үзлийг бахдаж байна гэж бөхийв. Чингис хааны сэтгэлд олон жил хадгалагдан эссэн аймшигт хорслын төгсгөл ойртож байгааг Боорчи гадарлаж байв. Чухам үүний учир Тангудад алгуурлан суусныг ч ойлгов. Хорсол заналаа тайлж өшөө авах үедээ Чингис хаан хэрхэн аз жаргал дүүрэн болохыг тэр харж байлаа.

-Чи намайг олон жилийн өмнө Хорезмд морилохдоо нэг замын цэрэг гарга гэхэд “Хүч хүрэхгүй бол дайнд мордох хэрэг юун” гэж их үг хэлээд тоомсорлосонгүй ял хийжээ. Бас өнгөрсөн намар цэргээ татаж бууж өг гэхэд үл тоон Аша хамбыг илгээн үлэмж цэргийн амийг сүйтгэв. Энэ хоёр гэмд чинь ямар ял олгохыг чи хэл гэж Чингис хаан зандрав. Хэлмэрч даруй орчуулан хэлэхэд Шударгын царай зэвхийрчээ.

-Чингис хаан та болгоо. Таныг Хорезмд морилоход би хаан оронд нэгэнт суугаагүй байсан билээ. Тэр их үгийг Аша хамба жанжин хэлснийг би сонссон. Харин өнгөрсөн хавар Аша хамба л цэрэг хөдөлгөн эсэргүүцэхийг шаардсанд би түүнийг ятгаж дийлээгүй билээ. Энд миний хамаарах хэрэг гэж юу байх билээ гэж өөрийгөө өмөөрөв.

-Би чамтай танай улсын үйлдсэн ялыг хэлэлцэж байна. Танай улс надтай эртнээс дайсан болов. Бүр эртнээс та нар миний дайсан Сэнгүмийг ивээн орогнуулж ирсэн. Бас дагаж ороод найрамдсан мөртөө Алтан улстай эвсэн тэдний самууныг дэмжиж Мухулайтай дайтаж байсныг сануулья. Чи хаан хүн тул улсынхаа ялыг үүрэх ёстой. Үүний тулд хаан суудаг юм. Хаан сууна гэдэг ямба эдлэхийг биш ял үүрэхийг хэлдэг гэдгийг чи мэдэж ав.

-Би бүтэн улсын урьд өмнийн хаадын ялыг үүрэх нь шударга бус болно. Би үүнийг хэрхэвч зөвшөөрөхгүй гэж Шударга орилов. Гэвч тэр оройтжээ. Түүний үхэл нэгэнт иржээ.

-Шударга чи бүү балмагд. Энд чиний зөвшөөрөл хэрэг болохгүй. Санаа бүү зов. Нэгэнт танай улсаас миний өмнө үйлдсэн нүгэл их тул би чамайг цаазаар аваачна. Хаан хүн гавьяа ч эдлэх, гай ч үүрэх ёстой юм. Чиний өдөөсөн дайнд үрэгдсэн олон олон тангуд иргэний сүнс баярлах биз. Үүнийг одоо хороо гэж Чингис хаан зарлиг болгомогц Гэрэгийн торгон цэрэг ухасхийн орж ирээд Шударгыг барьж авчээ.

-Наадахаа хаан хүний ёсоор цусгүй үхүүл. Хүндтэй оршуул гэмэгц Шударгад дахин дуугарах сөхөө өгсөнгүй. Айсандаа болоод Шударгын шээс савиран урсахыг бүгд харав. Торгон цэргүүд түүний нурууг даруй хугалж алаад чирч одов. Гэйхүү хатан бархиран уйлж гарч гүйжээ. Чингис хааны энэ гэнэтийн үйлдэл бүгдийг гайхуулж бас Тэнүүнбилэг охиноо Шударгад өгсний цаад учир тодорсон нь олныг бишрүүлжээ.

-Харин тэр Шударгын эмийг бүү хоригтун. Хаа хүртэл гүйх юм бол үзье. Эрээс зугатаад эм хүн хаа холдоно. Их сайндаа Хөх нууранд үйж үхнэ биз гэж Чингис хаан хөхөрчээ. Үнэхээр эр нь нүдний өмнө үхэхийг харсандаа ухаан самуурсан Гэйхүү хатан Хөх нууранд үйж үхжээ. Хайртай Тэнүүнбилэг охиноо Тангудын хааны сууринд суулгасан Чингис хааны ухаанд Есүй хатан биширч талархалтай байгаагаа илэрхийлж инээмсэглэн ёсолжээ. Есүй хатнаа баярлуулья гэж бодсоор яваад сая л нэг санасандаа хүрсэндээ Чингис хаан ч баяртай болжээ. Хэрэв Гэйхүү хатан үхээгүй бол түүнийг Тулуй хөвүүндээ өгье гэж Чингис хаан бодож байжээ. Гэвч бүх юм санаснаар болсонгүй тэр эм үхсэнд ихэд гонсойжээ. Харин Тангуд иргэнээс Есүй хатан болоод Боорчи, Мухулай хоёрт түм түмийг өгөв. Тэнүүнбилэг охин нь

Тангудын хааны ордонг эзлэн сууж суурин тангуд иргэдийг захирах болов.

Чингис хааны энэ зарлигийг хэн ч эсэргүүцсэнгүй ч Тангудын нутгийн ихэнхийг эзлэн авсан Цагадай Өгөдэй хоёрт таашаагдсангүй билээ. Ингэж Тангуд улс мөхөв. Одоо Их Монгол улсын өмнөд хил Хималайн их уулстай нийлжээ. Чингис хаан Тангудыг өөрийн санаснаар мөхөөсөндөө бахдаж хөөрөөд сэтгэл нь олзруугаа үсрэхээр булчин шөрмөсөө хураасан ирвэсийн адил хөвчирчээ. Түүний сэтгэлд ялж дийлэх, эзлэн булаах их хүсэл түймэр мэт дүрэлзэн байлаа. Тангудыг мөхөөсний их ялалтын бахдал хөөрлийн эрчээр тэр Алтан улсыг эзлэн авахыг хүсч байв. Тангуд улс мөхсөн нь Алтан хааныг үхтэл айлгаж тэр нийслэлээ бүр дорно зүг рүү нүүлгэсэн мэдээг тагнуул хүргэж иржээ. Алтан улсын мөхөл нэгэнт иржээ. Одоохондоо Сүн улстай эвдрэлцэх нь ашиггүй тул Тангуд улсыг мөхөөсөн тухай мэдэгдэх элчийг их бэлгийн хамт Сүн улсын хаанд дахин илгээв. Энэ бол Сүн улсын нутгаар дамжин Алтан улсыг санаандгүй байгаа талаас нь цохих бэлтгэл байв. Алтан улс хойт хил дээрээ хамаг цэргээ татсан нь Чингис хааныг өмнө болоод баруун талаас довтлохгүй гэж санасных байв.

Ийм цагийг ашиглан Алтан улсыг гэнэгүй талаас нь довтлохоор Чингис хаан шийджээ. Түүний уураг тархи ийм эрч хүчтэй, цэцэн цэлмэг байгаагүй мэт санагдана. Сүүлийн хэд хоногт урьд өмнө нь ойлгож мэдээгүй байсан олон чухал учрыг тодруулан ойлгожээ. Ингэж оюун ухаан нь хэт сэргэг цэлмэг болсон нь үхлийн гуравдах дохио болохыг тэр ойлгохгүй байв. Харин ч эргээд илааршиж байна гэж хууртан бодож ялах дийлэх их хүсэлд автжээ. Түүнд ялалт амжилт нь тод харагдаж байв. Тэр өөрийгөө үхэхгүй гэдэгт дахин итгэлтэй болжээ.

### *БАТХААНЫ ХАГУУ НЭХЭЛ*

Батын дагуулууд дунд ирсэн нэг хүнийг хэн болохыг таниад Чингис хаан ихэд цочирдон гайхжээ. Тангудыг мөхөөсөн их баярын дунд Батын дэргэдээс алхам холдохгүй сүүдэр мэт даган явсан хүн бол Зүчийн боол Тату байв. Нүүрний нь баруун тал түлэгдэн шатаад аймшигтай таталдан эдгэсэн Тату нэг хажуугаас нь харвал цоо эрүүл хүн шиг нөгөө сорвитой талаас үзвэл чөтгөр шулам мэт ажээ. Ингэж нүүр царай нь өөрчлөгдөж хувирсан Татуг танимагц Чингис хаан Боорчийг дуудав. Нэгэнт үхсэн гэж бодож итгэж явсан Тату амьд төдийгүй Батыг дагаж ирсэн нь Чингис хааныг хилэгнэхэд хүргэв. Тату аль эрт үхэх ёстой байжээ. Чухам Алтан улсад өөрийн хүчээр цэрэглэн орохоор шийдээд үг авалгүй муйхарлан зүтгэсээр нутаг буцсан Хасарыг хэнд ч сэжиг авахуулахгүйгээр алж чадах хүн бол Тату гэж Зүчи үзсэн билээ. Хасар юу сэдэж, тэгээд юуны учир түүнийг хөнөөх хэрэгтэй болсныг Чингис хаан өөрөө Зүчид хэлжээ. Түүний ярихыг Зүчи дуугүй сонсож суусан билээ.

-Ийм хүнд бэрх хэргийг ууган хөвүүн чамд итгэн даатгахаас өөр арга надад үгүй юм. Чамаас өөр итгэлтэй хүнийг би олохгүй биз гэж Чингис хааныг хэлэхэд Зүчийн нүд баяр бахдал, омог зоригоор дүүрэн гэрэлтэхийг Боорчи харж байжээ. Чингис хаан нэг сумаар хоёр туулай буудахаар шийдсэнийг Боорчи сая л ойлгов. Хасарын үхлээр Зүчийн алдагдсан итгэлийг буцаан олохыг тэр хүсчээ. Эзэнт улсынхаа төр, их хааныхаа өөдөөс тэрсэлсэн хэн боловч үхэх үйлтэйг Зүчи ч ойлгон эцгийнхээ үгийг шууд дэмжив. Алтан улсын зүүн хойт нутгийг эзлэн сууж өөрийн улсыг байгуулах гэж Хасар авга нь шийдсэн нь их гэрийн зүүн ханыг буулган зөөсөнтэй утга нэг болох тул Зүчи эцгийнхээ шийдвэрийг зөв гэдэгт огтхон ч эргэлзээгүй

бөгөөд энэ нууц бөгөөд чухал хэргийг түүгээр итгэн гүйцэлдүүлэхээр болсон нь Чингис хаан түүнд бусдаас илүү итгэж байгаа хэрэг гэж үзэн баярлажээ. Харин Хасарыг хэрхэн хэл амгүй үхүүлэхийг Чингис хаан хэлсэнгүй билээ. Зүчи Боорчи хоёр зөвлөлдөөд Зүчийн хэлсэн ёсоор хийхээр болж Чингис хаанд айлтгасанд тэр зөвшөөрчээ. Ингээд Зүчи, Хасарын их хатан Борогчины дүү, өөрийн боол Татуг дуудан ирүүлжээ. Тату, Зүчи эзнийхээ зарлигийг ганц үг ган хийн эсэргүүцсэнгүй. Амийг нь аварсан эзний үг Татуд Тэнгэрийн зарлиг билээ. Тату Хасарыг хадам ах минь ч гэж бодсонгүй. Яагаад түүнийг үхүүлэх болсныг асуух эрх бас сонирхол ч байсангүй. Хасарын өргөө гэрт орж гарахад хэн ч сэжиглэхгүй цөөхөн хүний нэг бол Тату гэдгийг Зүчи сайн мэдэж байв. Хасар Борогчин хоёр Татуд ихэд сайнаар ханддагийг ч тооцжээ. Хэрэв хэрэг илэрч мэдэгдвэл Тату хэргийг задлахгүйгээр үг дуугүй үхнэ гэдгийг ч мэдэж байв. Энэ учрыг ч Зүчи түүнд хатуу хэлжээ. Зүчи эзнийхээ төлөө амиа өгөх нь түүний эрхэм дээд хүсэл, ачийг нь хариулсан хэрэг болно гэж Тату харин ч баяртай болжээ. Гэвч Тату угийн зоригтой гавшгай хүн тул энэ бэрх хэргийг яаж хийхийг өөрөө сайтар бодож төлөвлөжээ. Үнэхээр Татуг очоод буцсаны маргааш шөнө Хасар өргөөндөө үхээд хоносон билээ. Замаас эргэн шөнө буцаж очоод Хасарын өргөөний гадна харуулыг ховсдон унтуулж бүх хэргийг Тату өөрийн хүссэнээр хийж орхисныг хэн ч мэдэж сэжиглэсэнгүй. Тэр бүү хэл зүүн хавирганы завсраар шаасан хулсан зүүний орыг хэн ч үзэлгүй өнгөрчээ. Уулын модонд хүлээж байсан Зүчи, Татуг дагуулан буцжээ. Харин ингэхдээ Татуг үхүүлэх Чингис хааны зарлигийг биелүүлсэнгүй ажээ. Чингис хаан Хасарын үхлийн шалтгааныг хэн нэгэн илрүүлэн дэлгээсэй гэж хүсээгүй тул Татуг үгүй хийх зарлиг буулгасан бөгөөд Зүчи ёсоор болгосон гэж хэлсэн атал өнөө Тату амьд явахыг үзээд ингэж хилэгнэсэн билээ. Гэхдээ хэргийн гол нь Татуг амьд үлдээсэнд биш болохыг Чингис хаан ойлгож байв. Хамгийн гол учир нь тэр нэгэн өдөр Хасарын хэлсэн үгэнд байсан билээ. Татуг үзээд өнгөрсөн тэр явдал санагдсан нь Чингис хааныг аймшигтайгаар хар даран зүүдэлж байх шиг болгожээ. Тэр өдрийн явдлыг яагаад ч мартаж тайвширч болохгүйг Татуг үзмэгц Чингис хаан ойлгожээ.

Хасарыг орж ирмэгц түүний сэтгэлийн хөдлөлийг Чингис хаан тод харжээ. Энэ явдал Хорезмыг дайлахаар шийдсэн Их хуралдайн дараахан болжээ. Хасар Чингис хааны дайллага хүндлэлд тушигдан ам нээж төвдсөнгүй хэсэг зуур болов. Хүнд хэцүү яриа болохыг ах дүү хоёр хоёул мэдэж хэн хэн нь сэтгэл түгшиж байлаа. Хасарын үр удмыг алтан урагт үл тооцон Их Монгол улсын хаан сууринд суух эрхгүй болгосон зарлиг нь энэ байтугай хэцүү бэрхшээл учруулахыг Чингис хаан нэгэнт тооцсон тул Хасарын юун тухай ярихыг таамаглаж байв. Харин энэ удаа тэр түрүүлж дуугарахыг бодсонгүй. Түүний үг Хасарын сэтгэлийн бухимдлыг цочроож мэдэх билээ. Тийм учраас Чингис хаан огт өөр зүйл хүүрнэж ажиггүй суужээ. Бас дээр нь Хорезмд цэрэг оруулахыг Хасар эрс эсэргүүцсэн нь тэднийг хэрэлдүүлэх нэг сэжүүр болжээ. Чингис хаан яаж ч бодоод Хасарын юу гэж хэлж, юун тухай ярихыг таамаглаагүй ч ямартаа ч Хорезмд орох цэргийн нэг замыг Хасараар толгойлуун жаахан буулт хийж түүнийг тайвшруулах хуучин сайн аргаа сэдэж суужээ. Гэтэл яриа огт санаандгүй байдлаар эхэлжээ. Хасар тийм ч удаан тэсвэрлэж чадсангүй. Түүний ингэж хүлээн тэвчсэн нь эрх биш Хаан ахыгаа хүндэтгэн бас болсон хэрэг явдлын талаар түрүүлэн үг хэлж түүнийг тайтгаруулах байх гэж найдаж байсных билээ. Гэтэл Чингис хаан тэр талаар огт үг хэлсэнгүй өөр зүйлийг ярьж булзааруулж байх нь ер өөрийн шийдвэрт эргэлзэж тээнэгэлзсэн шинжгүй Хасарыг хүн гэж тоохгүй байгааг илтгэжээ. Хасар ч юу гэж хэлж ярихаа олон өдөр бодож шийдсэн байв. Харин Хасарын үг Чингис хааныг гайхуулахаасаа илүү айлгаж түгшээсэн билээ.

-Ахаа. Би танд Тэнгэрийн зарлигийг дуулгахаар ирлээ гэж Хасар тод хэлэв. Хасар “Тэнгэрийн зарлиг” гэж хэлж байхыг Чингис хаан хэзээ ч сонсоогүй тул энэ үгэнд цочиж огт таамаглаагүй яриа өрнөхийг мэдэрч яагаад юм бэ айжээ. Гэтэл түүнийг хамгаалах хэн ч үгүй тэд хоёулханаа байсан нь ингэж айх шалтаг болов. Гэвч хариу үг хэлсэнгүй.

-Тэнгэр нэгэнтээ зарлиг буулгаж Хасар намайг улсын эрхийг барина гэлээ. Би Тэнгэрийн зарлигийг дагахгүй байж яахан болох билээ. Харин би ах тантай өрсөлдөн эрх булаалдах гэсэн санаа өвөрлөсөнгүйгээр өнөөг хүрлээ. Өсөхдөө тавьсан тангаргаа би өнөө ч хүртэл санаж бас сахиж байна. Гэвч би Хаан ах таныг сандраахгүй, хамаг их улсаа бусниулахгүйгээр Тэнгэрийн зарлигийг дагахаар шийдлээ. Хаан ах таны буулгасан зарлиг ёсоор Хасар би болоод миний үр удам Их Монгол улсад дурсагдах нэргүй, дээд язгуургүй энгийн дорд сул иргэн мэт үзэгдэх боллоо. Би ах танаас сүүлдэж төрснөөс өөр ялгүй тул зүтгэн байгуулсан гавьяа минь Их Монгол улсад үнэлэгдэх ёстой гэж үзнэ. Би өөрийн үр удмыг нэргүй явж гэргүй үрэгдээсэй гэж үл хүсэх тул энэ үгийг хэлж байна. Та миний оронд байсан бас л ингэх бизээ. Би өнөөдрөөс хойш ах танаас ам асууж зарлиг сонсохгүйгээр явахаар шийдлээ. Надад өөрийн албат иргэд үнэнч цэргүүд бий. Би энэ бүхнийг бүлээн цусаа урсгаж бүтэн биеэ үрэн явж олжээ. Би Хаан ах таны хамаг их улсыг сандраахгүй хаяа нийлэн явахаар шийдлээ. Нэгэн цагт би Хаан ах таны зарлигаар Зүрчидийн Алтан улсын зүүн хойд нутгийг эзлэн хураасан билээ. Одоо би тэр нутгаа эзэмшин сууж өөрийн улсыг байгуулъя. Өргөн их улсын чинь зүүн хилийг сахиж, зэрэгцэн эв найртай явъя. Би эзэлсэн улсаас цэрэг нэмэн дайчилж Алтан улсын үлдсэн нутгийг хураан авч нэгэн цагт бидний өвөг дээдсийг тамлан хороосон Алтан улсаас өшөө авч дуусгая. Есүхэйн хоёр хөвүүний байгуулсан хоёр их улс зэрэгцэн оршиж үр удам минь мөнхөд та биднийг залгамжлан бидний нэрийг дуурсган суувал бид Тэнгэрийн зарлигийг дагасан хэрэг болно. Түмэн үеийн бахархал болох биш үү.

Хасар өөрийн үгэнд хөөрөн догдолж бүр босож зогсчээ. Чингис хаан ч босов. Тэд яг л тулалдах гэж байгаа мэт хэрэн зогсчээ.

-Ах та баруун зүгт уужуу тайван явж их газрыг эзлэн авах хэргээ ардаа санаа зовох зүйлгүй гүйцэлдүүлэгтүн. Харин би өөрийн улсын хүчээр Алтан улс болоод Солонгосыг эзэлж харин дараа нь хоёул хүч хавсран Сүн улсыг зэрэг дайран мөхөөе. Ингэвэл энэ газар бүхлээр та бид хоёрын гарт орох үүд нээгдэнэ. Бид одоо хүчтэй болжээ. Хамаг хүчээ ганц зүгт зарж алгуурлан цаг алдалгүй зэрэг явж ихийг эзэлье. Энэ нарны дор Есүхэйн хөвүүдийн хоёр их улс зэрэгцэн оршихыг үзээд эх эцэг хоёр минь баярлан жаргах бус уу. Би тавь гартлаа Тэмүжин ах танд зүтгэв. Одоо үр хүүхдийнхээ төлөө зүтгэх цаг минь иржээ. Хаан ах та, Тэмүгэ дүүг албат цэргийн нь хамт надад өг. Би Хаан ах танд зүтгэсэн шиг Тэмүгэ надад зүтгэг. Би түүнд өөрийн улсад их эрх олгож өөртөө хавсруулъя. Бас Мухулайг надад өгөгтүн. Тэр Алтан улстай байлдах их туршлагатай тул би түүний хүчийг авахыг хүсч байна. Өөр хүсэх зүйл надад үгүй. Би таны амийг хэдэнтээ аварсан гавьяатай хүн. Хаан ах та зарлиг буулгаж Их хуралдайг зарлаж миний тусгаар улсыг ил тодоор тунхаглаасай гэж би хүснэ. Миний улсыг хаан таны зарлигаар “Хасар их улс” гэж нэрлэе. Хаан ах та энэ бүхнийг өөрийн зарлигаар батлан тунхаглах аваас сая Тэнгэрийн зарлиг болох билээ. Олон жилийн өмнө “Хасар чамайг улсын эрхийг барина гэж Тэнгэр хэллээ” гэж Хөхөчүгийн хэлсэнд би ихэд уурлаж “Тэмүжин ахтай эвдрэлцүүлэн алалдуулах муу арга сэдэв” гэж санасан билээ. Ах та ингэж санасныг би мэдэж байна. Гэтэл Тэнгэрийн зарлигт намайг Хаан ахтайгаа өрсөлдөн

тэмцэхийг бус өөрийн тусгаар улс байгуулахыг хэлжээ. Би үүнийг саяхан л ойлгож мэдэв. Газар орон ийм удам байхад ах та бид хоёр зэрэгцэн сууж зөрөлдөн тэмцэхийн хэрэг юун. Та бид хоёр их улсыг байгуулвал энэ ертөнц бүхэлдээ Есүхэйн хөвүүдийн мэдэлд хураагдах болно. Чухам энэ тухай Алангуа эхийн тухай болоод Буянтай өвгөний тухай домогт дурдсаныг мэдээд Өүлэн эх маань бидэнд өгүүлжээ. Энэ домгийг үнэн болгох цаг одоо нэгэнт ирэв гэж хэлээд Хасар сая л нэг тайвширчээ. Чингис хаан хойморт зогссон чигээр бодолд автжээ. Хасарын хэлсэнд ер эвгүй хорон санаа эвдрэлцлийн шинж илэрсэнгүй. Бас яг Хасарын хэлснээр ингэж хийх нь зүйтэй мэт санагдсан билээ. Хасар өөрийн улсыг байгуулвал болохгүй юмгүй бас тэр ингэх эрхтэй юм. Тэр нэгэнт ингэж шийдсэн бол Хасарт хэн ч саад хийж чадахгүй хэрэг байв. Ийм зорилго, үнэн зөв шаардлагыг биелүүлэхгүй эсэргүүцэх өчүүхэн төдий шалтаг тэр үед Чингис хаанд олдсонгүй тул

-Хасар чи зөв боджээ. Тусгаар их улс байгуулахыг санасан чинь сайн хэрэг болжээ. Чи ч үүнийг чадах билээ. Би Их хуралдайг хуралдуулж зарлиг буулгая. Чи өөрийн улсыг хэлснээрээ нэрлэгтүн. Харин Их хуралдай хуралдаж намайг зарлиг буулгатаг энэ бүхнийг чандлан нууцлах нь зөв. Цагаан хэл ам хүрч болно. Дүү чиний тусгаар улс байгуулах хүслийг хорон санаатан ашиглаж биднийг эвдрэлцэв хэмээн мушгин гуйвуулж мэдэх тул би ингэж бодов гэж хэлсэнд Хасар түүний үгийг сайшаан зөвшөөрч баяр хөөр дүүрэн нутгаа зорьсон билээ. Дээрх үгийг Чингис хаан үнэн сэтгэлээс бүр яг ингэж хийхээр шийдсэн мэт хэлсэн билээ. Гэвч Хасарт хэлсэн үг нь түүний их хүсэл, үйлийг түр хугацаагаар саатуулж цаг хожсон төдий арга болоод өнгөрөх учиртай байжээ. Хасарт яав ч тусгаар улс байгуулах эрх олгож болохгүй байв. Чингэвээс зовж байгуулсан улсаа эвдэн нураасантай үлгэр нэг болох юм. Зөвхөн нэгтгэж нэг гарын дор захируулахыг хүсэж зүтгэсээр ирсэн мөртлөө Хасарын хатуу үг, хар зоригоос айж эцэст нь их зорилгоосоо ухрахыг тэр хүссэнгүй. Хасарт тусгаар эрх өгвөл Тэмүгэ болоод Хачиуны үр удам юу гэх вэ. Энэ газар орныг нэгтгэхгүйгээр амар амгалан оршиж чадахгүй гэж Чингис хаан үзэх тул Хасарын үйлдлийг газар авахуулахгүй зогсоохоос өөр зам олсонгүй. Өөрийн их улсын ирээдүйн энх амар амьдрал, бүрэн бүтэн оршин байх бат үндсийг хамгаалахын тулд салан тусгаарлах гэсэн хэнийг ч болов найр тавин өршөөхгүй байх ёстойг тэр ойлгосон билээ. Үүнээс үүдээд Хасарын тэрхүү зоримог хүсэл зорилгыг үл тэвчин бухимдах болж яарч тэвдэх нь нэмэгджээ. Хасар түүний зарлигийг хүлээлгүйгээр Алтан улсад довтлон орвол юу болох билээ. Эсвэл өөрийн улсыг дур мэдэж тунхаглан зарлавал яана гэж бодохоос байж суухын аргагүй болжээ. Хасар чухамдаа яг Тэв Тэнгэрийн адил түүний сэтгэлийн доторхи дайсан болжээ. Түүнтэй илээр тэмцэлдэн булаалдах нь босгосон улсаа нураасантай адил агаад Их Монгол улсын дотор Чингис хаанаас гадна Хасар шиг эрх мэдэлтэй бөгөөд өөрийн хүчирхэг цэрэгтэй хүн нэг ч үгүй байсан нь Чингис хааныг мухардуулж байв. Бас Хасарыг шууд эсэргүүцэж түүнтэй эвдрэлцэхгүй аятай үг хэлэн аргалан тайвшруулж явуулсан нь зөв болов гэж Тэнгэрт талархан мөргөжээ. Хасарыг нэг удаа улсын эрх барина гэж Тэв Тэнгэр бөө үнэн хэлжээ гэдэгт Чингис хаан дахин итгэв. Иймээс хэлсэн үг, амласан зүйлд нь Хасар итгэж тайвшраад буй чухам энэ цагт л түүнийг нэгмөсөн үгүй хийх нь ганц зөв зам гэж Чингис хаан эргэлтгүй шийджээ. Яг энэ үед Боорчи Алтайн өвөр дэх хүрээнээсээ Чингис хааны хүрээнд ирсэн нь Тэнгэрийн таалснаар болов гэж Чингис хаан баярлажээ.

Хэрэг явдал Чингис хааны санаснаар болж тэр өөрийн улсыг бутрах аюулаас сэргийлж Хасарыг хэл амгүй үхүүлж чадав. Гэвч тусгаар улс байгуулах хүсэл ганц Хасарт байгаагүй нь

лавгайг тэр таамаглажээ. Иймээс салж тусгаарлах гэсэн хэнийг ч болов эзэнт улсын эв нэгдэл, их зорилгынхоо дайсан гэж үзэж өршөөхгүй байхаар Чингис хаан эргэлт буцалтгүйгээр шийдэж хожим хойшид зарлиг болгон хэрэгжүүлэхээр тогтжээ. Энэ бол зөвхөн ганц түүний бодол биш шадрууд нь ч дэмждэг Их Монгол улсын төрийн бодлого болсон байлаа. Гэтэл ийм нууц чухал хэргийн амьд гэрч үлдсэнийг үзээд өнгөрсөн тэр эмзэг явдал эрхгүй санагдан Чингис хаан цочиж хирдхийсэн нь энэ юм. Бас Зүчи түүний зарлигийг биелүүлэхгүй байсан нь ганц Хорезмд болсон хэрэг биш гэдэг нь тодорхой болсон бөгөөд энэ явдал түүнийг гунигт бодолд автуулжээ. Түүний үг, зарлигийг Тэнгэрийн зарлиг адил олон бүгдээр үг дуугүй биелүүлэн дагадаг гэж итгэж явсан нь худал болохыг үзээд цочирдон хилэгнэж Боорчийг дуудсан билээ. Зүчийн буруу үйлдлийг Боорчи үүрэх ёстой гэж Чингис хаан үзжээ.

Чингис хааны ааш авир, аливаа мэдрэмж нэн хурц болсныг ажигласан Боорчи түүний хилэгнэхийг үг дуугүй хүлцэн сонсож байв. Тавин жил тохой салалгүй зүтгэсэн энэ хугацаанд Чингис хаан анх удаагаа Боорчид ийнхүү хилэгнэсэн учрыг ч Боорчи таамаглажээ. Бас Чингис хааны хартай, болгоомжтой занг шүүмжлэн гайхаж суув.

-Чи тэр боолыг дарай үхүүл. Харин Бат, Хасарын үхлийн талаар сэжиг авч мэдэх тул болгоомжтой байгтун гэж Чингис хаан жаахан тайвшраад хэлжээ. Ерөөс Чингис хаан өөрийгөө буруутгахыг үл хүсэх тул аливаа явдлыг нууцлах зантай байсан нь насны эцэс ойртож өвгөрөх тусам гүнзгийрээд бүр сүүлдээ хардаж сэрдэх, хааж нууцлахын дон болон хувирчээ. Үүнийг Боорчи мэдэх тул түүний зарлигийг үг дуугүй хүлээн авав.

Боорчи тэр даруй Баттай уулзжээ. Бат Боорчийг эцгийнхээ адил нэн их хүндэтгэх тул асарт нь өөрийн биеэр морилон ирсэнд нь хөөрч баярласан билээ. Боорчийг очиход асрын үүдэнд өнөө үйлт Тату чөтгөр царайлан зогсож байв.

-Энэ Тату чамд тийм их үнэтэй хүн үү гэж Боорчи үгийн далимд асуув. Учир нь Тату Батад өгсөн учрыг, бас Тату эцэг хүү хоёрт хэрхэн зүтгэж байсныг Боорчи мэдэх тул болгоомжилж байв. Харин Бат, Боорчийн ийн сонирхсоныг огт өөрөөр тааварлаж эхлээд Мухулайн адил Тату худалдан авахыг хүсч байна гэж ойлгожээ.

-Энэ Тату бол Зүчи эцгийн минь зүрх юм гэж хэлсэн Батын сүржин үгийг сонсоод Боорчи туйлын их гайхжээ. Гэвч Чингис хааны зарлигийг зөрчих эрх байсангүй. Бас Тату заавал үхүүлэх учиртайг ч Батад тайлбарлаж ойлгуулах арга олдсонгүй.

-Бат. Чи энэ боолоо нутаг руугаа даруй буцаа гэсэнд Бат их гайхжээ.

-Чингис хаан энэ боолын аймшигт царайг үзээд нүднээс нь далд оруулахыг надад тушаав. Чи одоо түүнийг явуул. Би Чингис хаанд нүднээс далд болгов гэж айлтгая гэж Боорчи шууд тулгав. Тату үхүүлэх гэвэл түүн шиг хялбар зүйл үгүй ч ингэх хүсэл Боорчид огт төрсөнгүй нь гайхалтай. Тату шиг үнэнч боолыг олоход бэрх, бас түүнийг үхүүлэхийг Бат хэзээ ч үл зөвшөөрөхийг сая анзаарч мэдсэн тул түүнд үүнээс өөр арга олдсонгүй билээ. Харин Бат хэргийн учир зөвхөн Татугийн түлэнхий нүүрэнд ч биш, цаана нь огт өөр эмзэг шалтгаан байгааг ойлгожээ. Тийм биш бол Боорчи сайд ингэж өөрийн биеэр заларч ирэхгүй билээ. Боорчи яаж ч дүйвүүлээд түүний ийнхүү хүрч ирсний гол учир нь Тату болохыг Бат мэдэрч

байсан ч асууж төвдсөнгүй. Боорчийн хэлсэн ёсоор тэр даруй Татуг буцаав. Харин Боорчи Чингис хаанд

-Татуг нүднээс далд болгов гэж айлтгажээ. Харин Чингис хаан огт хариу хэлсэнгүй нь түүний хилэн дарагдаагүйг гэрчилнэ. Загасан нүдэт Тату Тэнгэрийн авралд багтсан хүн болохоо дахин баталж гуравдахь удаагаа ингэж үхлээс аврагдав. Ургенчид галд шатан үхдэгийн даваан дээр Батын тушаалаар эвдсэн далангийн ус оволзон ирээд галыг унтраасан ч Тату сувгаар урсан хотын гадна холд хаягдсан билээ. Тал бие нь шатсан Татуг нутгийн гэмгүй түрэг иргэн олж асарч аварчээ. Тэр түрэг хүний оромжинд нэрээ бас хаанахын хэн гэгч болохоо санатлаа Тату жил гаран элий балай хэвтсэн билээ.

Татуг буцсаны дараа Бат Сүбээдэй хоёр явах хүсэлтэй байгаагаа Чингис хаанд айлтгасан нь түүнийг бодолд оруулжээ. Үнэхээр ч тэд гэдрэг буцах хэрэгтэй нь тодорхой байв. Зүчийн улс эзгүй үлдээд даруй хэдэн сар болсон тул ингэхээс өөр аргагүй юм. Харин буцах тухай үгийг Сүбээдэй биш Бат хэлжээ.

Чингис хаан Сүбээдэйг дуудан зөвлөлдөв. Зүчийн улсыг хөвүүн Батад нь өвлүүлэн үлдээхийг Сүбээдэй зөвлөөд Батын тухай сайхан үг хэлж түүнийг улсаа авч явж чадахыг баталжээ. Бат тэгэхэд дөнгөж арван найман нас өнгөрч байсан билээ. Сүбээдэйтэй ийнхүү зөвлөлдсөний хойно Чингис хаан эргэлзэх зүйлгүй болжээ. Бат ч үнэхээр яарч байв. Учир нь Чингис хааны зарлигийг дагаж Алтан ордноос мордох үед хайртай Герта хатан нь бие тулгар байсан бөгөөд одоо төрөх нь хэзээ мөдгүй болсон тул хөвүүн төрүүлээд байгаасай гэж ихэд хүсч байлаа. Чингис хаан Батыг буцахаар шийдсэнийг сайшаасан агаад харин энэ тохиолдлыг ашиглан сүүлийн сард бодож тогтсон нэгэн хэргийг гүйцэлдүүлэхээр шийдэв. Энэ бол өнөө хэр эзлэн нэгтгэсэн их улсаа хөвүүддээ хуваан эзэмшүүлэх явдал байв. Тэдний эзэмшин суух нутаг орныг өөрийн зарлигаар шийдэн бататгаж, хуваан өгөх нь хожим хойшид өөр хоорондоо харгалдан хэрүүл зарга үүсгэх, эвдрэн булаалдах муу үйлийн үндсийг нэг мөр үгүй болгоно гэж тэр итгэх болжээ. Нэгэнт болох үйлээс тойрч гарах аргагүй гэдгийг ч ойлгожээ. Биеийн байдлаа бодвол ерөөс хөвүүдтэйгээ, тэр дундаа Баттай дахин уулзаж учиртай үгийг хэлэлцэх боломжгүй болохыг гэрчилж байсан нь бас ингэж шийдэхэд нөлөөлжээ. Чингис хаан ийн шийдэхийн өмнө олон талаас нь шигшин бодож шинжин үзээд өөрийн шийдвэрийн зөв бурууг нягталсан билээ. Шадар нөхөд нь бүгд нэгэн дуугаар сайшаав. Өөрөө мэрэглэн үзвэл таатай сайхан төлөг буужээ. Бас урьд шөнө зүүдээ манаж хоновол Өүлэн эх нь залуу үзэсгэлэнтэй дүрээрээ Есүхэй эцгийг нь их аянаас ирэхэд уян дээрээ угтан тосож байна гэж зүүдлээд бүр ч баясан итгэжээ. Тэр эцэг эх хоёроо хамт байгаагаар огт зүүдлэж байгаагүй бөгөөд ингэж зүүдэлснээ түүний шийдвэрийг Өүлэн эх, Есүхэй эцэг нь талархан дэмжиж байгаа хэрэг гэж боджээ.

Өглөө нь Люньаньшань ууланд үүл хуралдаж солонго татсан байлаа. Энэ бол Тэнгэр түүний шийдвэрийг сайшааж буйгийн дохио байсан тул нэгэнт эргэлзэх зүйлгүй болоод Цагадай, Өгөдэй, Тулуй хөвүүдээ Зүчийн хөвүүн Батын хамт дуудан ирүүлжээ. Тэднийг өргөөнд хүлээж байтал Чингис хаан орж ирэв. Түүний хамт Боорчи, Мухулай, Сүбээдэй, Шихихутуг бас нас балчир гэлгүй Тулуйн бага хөвүүн таван настай Аригбөх хүртэл алтан ургийн бүх ач хөвүүд орж ирсэн нь гайхалтай хэрэг болов. Тэдний араас өөр хэн ч орж ирсэнгүй.

-Сууцгаа гэж Чингис хаан тушаав. Гэвч хөвүүд нь хэрхэн суух учраа олж цөхжээ.

-Бат чи эцгийнхээ сууринд суу гэж Чингис хааны хэлсэн нь хэргийн учрыг тайлав. Батыг зүүн талд Өгөдэй авгынхаа дор суу хэмээн Шихихутаг урихад өнөөдөр ямар нэгэн чухал яриа болохыг энэ содон явдал батлав. Учир нь Батаас ахмад Цагадайн Есөнмөнх, Өгөдэйн Гүюг нас чацуу Тулуйн Мөнх, Өгөдэйн Годун гээд бусад ач хөвүүд зогсож хоцорчээ. Чингис хаан хоймрын сэнтийд залрахад түүний баруун талд Цагадай, Тулуй, зүүн талд Өгөдэй Бат хоёрыг суулгасан байлаа. Бүгдийг суусны хойно Чингис хаан үгээ хэлэв.Тэр олон үг нуршсангүй шууд л гол зүйлээ хэлнэ гэж шийджээ.

-Бөртэ эх чинь байсан бол ингээд бид халуун бүлээрээ цуглав. Миний одоо хэлэх үгийн гэрч болгон та нарыг хожим хойно мартаж цалгардах аваас сануулж яваг гэж би энд Боорчи, Мухулай, Сүбээдэй, Шихихутаг нарыг зориуд байлгаж байна. Энэ дөрөв бол миний хэлснийг хэзээ ч мартаж, бас осолдож зөрчихгүй итгэлтэй нөхөд минь юм. Би эдгээр нөхдийнхөө өмнө та нарт зарлигаа буулгая. Бат хөвүүн нас бие гүйцэж,эр зориг, эрдэм чадал жигдрэн их цэргийг засаж, улсыг удирдах чадлаа харуулсан тул өнөөдрөөс эхлэн би түүнийг Зүчи эцгийнхээ сууринд сууж байхыг зарлиг болгож байна. Энэ өдрөөс эхлэн Бат, Зүчийн эзэлсэн нутгийг үрийн үрд захиран суух болно. Үүнийг та нар сайтар мэдтүгэй. Хаан миний нэр сүр, цэргийн хүч их ч хүмүүний бие мөнх бус. Би энэ ертөнцийн таван өнгө, дөрвөн хэлийн дөчин улсыг нэгтгэн хураав. Зүүн зүгт Гуулин улс, баруун зүгт Энэтхэг, Инд мөрөн, Багдад, Кавказын уул, Каспийн тэнгис өнгөртөл умард зүгт Байгаль далай, Саяны уулыг өнгөртөл өмнө зүг Шар мөрнийг өнгөрч Хималайн уулсыг хүртэл өргөн их газар нутаг, үй олон улс иргэнийг нэгтгэх гэж халуун цусаа хөртөл хатан биеэ харьгал зүтгэсний учир юу вэ. Та нар юу гэж санана гэж Чингис хаан бахтай сайхан хэлээд дуугүй болов. Хөвүүд, ач нарын хэн ч дуугарсангүй. Бүгд жижиг томгүй даруу төлөв сууж Чингис хааны үгийг шимтэн сонсч байлаа. Чингис хаан ч ямар нэгэн хариу хүлээгээгүй тул үгээ цааш үргэлжлүүлэв. Харин ганц Шихихутаг л Чингис хааны үг бүрийг хөх дэвтэртээ бичиж авах ажээ.

-Тиймээ.Та нар өөр өөрийнхөөрөө бодох биз. Гэвч та нар нарийн учрыг олохгүй. Энэ бол алтан ургийн хөвүүд та нарын төлөө юм. Миний хөвүүд, ач нар цашид Чингис хааны алтан ургийн үр сад хэмээгдэн бүхэнд хүндлэгдэж нэртэй төртэй баян цатгалан амьдрахын тулд юм. Тэнгэрийн ивээлд орших газар орныг миний их нэрийн дор нэгтгэн амирлуулахын тулд юм. Үүнийг та нар мартаж үл болно. Үр ачдаа захиж нэгэнт миний зарлиг сургаалаар хураасан улсын хил хязгаарыг өргөтгөн тэнгэрийн хаяа хүртэл дайлан явцгааж эзлэн нэгтгэгттүн. Үүний тулд би та нарыг цуглуулав. Миний хойно Өгөдэй хаан сууринд сууж бусад нь түүнд нэгэн үзүүрт сэтгэлээр хүчин зүтгэлээ өгөгтүн. Цагадай, Алтайгаас Аму дарья мөрөн хүртэлх нутгийг авагтун. Өгөдэй Уйгар газар Ил мөрөн, Тарвагатайн уулсын хавийн нутгийг эзлэн суу. Тулуй чи отгон хөвүүний ёсоор гурван голын Монгол нутгаа мэд. Харин Бат чи эцгийн оронд Саяны уулсаас Кавказын уулс хүртэлх газрыг авч тус тусдаа өргөтгөн явсугай. Та нарын эзлэн суусан нутгийг та нарын үр хүүхэд Есөнмөнх, Гүюг, Мөнх гээд ууган ач хөвүүд ахлан ач нар маань уламжлан эзэмшиж суух биз. Миний эзэлсэн нутаг өргөжин тэлж байвал миний сүнс сүлд бахархан баясах болно гэдгийг бүү март. Миний энэ гэрээсийг миний алтан ургийн үр удам үүрд даган мөрдөж байхыг би зарлиг болгож байна. Алтан ургийн хөвүүд дотроос эрх биш ухаантай гавшгай эрдэм төгс нэгийгээ шилж хаан сууринд өргөмжлөгтүн. Өргөмжилсөн бол түүнийхээ үг зарлигийг Тэнгэрийн зарлиг гэж даган биелүүлэгтүн. Ингэж чадвал Чингис хаан миний алтан ураг энэ газрыг мөнхөд захиран суух нь гарцаагүй. Миний энэ зарлигийг хөх дэвтэрт бичиглэн үрийн үрд, үеийн үед хүртэл дагаж



мөрдөгтүн. Бас энэ зарлигийг чихээр сонссон бүгдийн нэрийг бичиж батлагтүн. Хожим үгээ мартаж миний зарлигийг зөрчсөн хүн гарваас энэ дэвтрийг үзүүлж үгийг нь мэдүүлж шударгаар яллагтүн. Энэ зарлигийг хэн хэрхэн дагаж мөрдөж буйг Боорчи болоод Шихихутагийн үр удам хянан явагтүн. Одоо их цэргээ засаж Алтан улс руу хөдөлгөхөд бэлдэгтүн. Их цэргийг Өгөдэй захир. Цагадай баруун замын цэргийг, би Тулуйн хамт зүүн замын цэргийг удирдъя. Хөвүүдээ тус тусын цэрэгт хамт авч явцгаа гэж Чингис хаан зарлиг болов. Чингис хаан Өүлэн эхийнхээ ярьсан Буянтай өвгөний домгийг үнэн болгож энэ газрыг өөрийн хөвүүддээ хуваан өгөв. Өүлэн эх нь хичнээн холыг харж тэр домгийг ярьсныг Чингис хаан гайхан бишрээд барахгүй байлаа. Одоо түүний хөвүүд энэ газрыг өөрсдийн нэрээр нэрлүүлэн мөнхлөөсэй гэж хүсэж байв. Дэмий яарч Зүчи хөвүүнээ хардан үйлийг нь барсандаа ихэд харамсжээ. Хөвүүд нь эцгийнхээ адил их хаан суухыг хүсэх эрхтэйг бас ингэх ёстойг тэр даанч хожуу ухаарчээ. Гэвч Чингис хааны нүүрэн дээр Монголчууд зөвхөн Орхон, Онон, Хэрлэн, Туул, Сэлэнгэ таван голын энгээр биш энэ хавтгай газрыг бүхлээр нь эзлэн суух болгосондоо бахархаж хожим хойно түүний тухай яг өнөө Буянтай өвгөний домог мэт үе дамжуулан хүүрнэнэ гэж итгэж байв.

Ийнхүү бүх зүйл тодорхой болов. Бат алтан ургийн дотор лавтай Тулуйн дараа зиндаалах эрхтэй болж их хааны ач хөвүүдийн манлайд суух нь гарцаагүй болжээ. Ингэж санаагүй байсан Батын сэтгэл ихэд хөдөлсөн ч ахмад хөвүүд биеэ барин дуугүй сууцгаав. Өгөдэй Цагадай хоёр хэн маань үг хэлэх вэ гэж түргэн зуур харц солилцоод нэгэнт ахмад хөвүүн тул Цагадай хариу хэлэхээр хоолой засч амжаагүй байтал энд байсан ач хөвүүдийн хамгийн балчир Аригбөх гэнэт

-Өвөг эцэг тэгээд хэзээ үхэх вэ гэж цангинуулан хашгирч бүгдийг цочоожээ. Дэргэд нь зогсож байсан Хубилай ах нь учрыг мэдэх болсны хувьд бушуухан амыг нь дараад авчээ. Гэсэн ч дураараа эрх танхи өссөн Аригбөх тийм амар бууж өгсөнгүй

-Үхэх гэж байгаа хүн чинь л ингэж ярьдаг биздээ гэж Хубилайн гарыг зайлуулан хашгирч амжжээ. Сандарсан Тулуй гараар дохисонд Хубилай Хүлэгү хоёр эрх дэггүй дүүгээ суганаас нь өргөн гарчээ. Гэсэн ч Аригбөх

-Та нар өвөг эцгийн үхэх гэж байгааг мэдэхгүй байгаа юм уу. Тэгвэл өвөг эцэг үхэх гэж байгаа юм байна. Түүнийгээ та нараас нуугаад байна шүү дээ. Өвөг эцгийг битгий үхүүлээч дээ. Аав аа, та өвөг эцгийг битгий үхүүлээрэй. Би танд хэллээ шүү гэж хашгирсаар гарчээ. Аригбөхийн энэ санаадгүй ааш яг тэнгэр ниргэж аянга буусан мэт бүгдийг цочоож гэрт түгшүүртэй нам гүм боллоо. Аригбөх хүүхдийн зөн совингоор болох гэж буй аймшигт хэргийг мэдсэнээ нуулгүй хэлсэн нь энэ байв. Хэн нь ч юу гэж хэлэх арга учраа тэр дороо олсонгүй. Цагадай хэлэх гэж байсан үгээ мартжээ. Хөвүүд нь яаж сандран барьц алдахыг Чингис хаан харлаа. Тэдний хэн нь ч түүний үхлийг төсөөлөхгүй, ямар ч бэлтгэлгүй байгааг ингэж санаандгүй мэдсэн нь Чингис хааныг хирдхийлгэжээ. Тэднийг хараад надаас хойш энэ хэд маань яана даа гэж бодох бүр зүрх нь шимширч тэдний энэ аргаа барсан байдлыг харсаар суух тэвчээр барагдан

-Хүүхдийн үгээр үг хийгээд яах вэ. Надад санаа зовох явдалгүй. Би үхэх болоод энэ үгийг хэлсэнгүй. Та нарын зорилгыг тод болгохын тулд хэллээ. Одоо явцгаа. Харин Бат чи үлд гэжээ. Бүгд дув дуугүй гарцгаав. Өөрийнхөө үхлийн тухай ингэж гэнэт илэн далангүй

сонсоод Чингис хаан ч тайвширч чадахгүй болжээ.

Бат үлдээд өвөг эцгийнхээ буурал үст тэргүүн, үрчлээт нүүрийг өрөвдөж харамссан харцаар сэм ширтэн дуугүй хүлээн сууж байв. Чингис хаан өвөг нь үхнэ гэж санахад Батад аймшигтай, ямар ч хамгаалалтгүй өнчрөн хоцрох мэт сэтгэгдэж байжээ. Чингис хаан эцэст нь хүчлэн биеэ барив. Түүний өмнө харих гэж яарсан залуу хөвүүн сууж байгааг тэр харж байлаа. Чингис хаан ч бас яарах хэрэгтэй болжээ. Нялх балчир Аригбөхийн хэлсэн үгс Тэнгэр түүнийг яаруулж байгаагийн дохио болжээ.

-Хөвүүн чи улаан бар өдрийн морин цагт Монгол нутгаа зорь. Нутагтаа бүү уд. Даруй өөрийн хүрээ рүү морд. Одоо чамайг хүн бүхэн Батхаан гэж нэрлэх болно. Чи энэ нэрийг батлан авч авах биз. Чамд эцгээс өвлөсөн ухаан чадал бий. Би чамд эргэлзэхгүй байна. Чамд хэлэх, хүсэх зүйл байвал эрээлэлгүй хэлэгтүн гэж Чингис хаан Батыг эгц ширтэж байгаад хэлэв. Бат бол угаас хийморьтой, хар багын нүдэнд унаж бусдаасаа тодорсон хөвүүн билээ. Чингис хаан одоо түүнийг бахархан ширтэж байв. Бат баруун хөлөө өвдөглөн сууж

-Хаан эцгийн зарлигт баясан талархаж байна. Би таны их нэр сүрийг хэзээ ч хугалж унагахгүй авч явна гэдгээ тангараглая. Эцгийн хураасан улсын хилийг баруун зүгт тэлж гадаад их далайд хүргэхээ би Танд амлаж байна. Би хэнээс ч тус дэм авахыг үл хүснэ. Би өөрийн чадал ухаанд л итгэнэ гэж нүдээ гялалзуулан хэлэхдээ гэнэт Зүчи эцэгтэйгээ хачин адил харагдсанд Чингис хааны зүрх хөндүүрлэж дуу алдан ёолоод нам суужээ. Гэвч ухаан нь саруул байлаа. Бат сандран дэргэд нь ойртов.

-Хөвүүн чи бүү сандар. Би зүгээр. Харин чиний үг намайг баярлуулж сэтгэл минь ханав. Хүн хамгийн түрүүнд өөртөө л итгэж найдах хэрэгтэй юм. Чамд өөрөөс чинь илүү үнэнч нөхөр, итгэлтэй туслагч хаанаас ч үл олдоно. Чиний эцэг, миний ууган хөвүүн Зүчи арван хоёрхон настайдаа миний зарлигаар дайсны цэргийн хүрээнд амиараа дэнчин тавиад аймшиггүй очиж байлаа. Тэгэхэд эцэг чинь тэнд хэд хонохдоо ганц ч удаа дугхийж сэрэмж алдалгүй оргох мөчийг хүлээж байгаад дайсны хүрээнээс балчир дүүгээ аваад зайлан гарч чадсан юм. Миний хөвүүн Зүчи үнэхээр гайхалтай гарамгай баатар байлаа. Хөвүүн чи эцгээсээ илүү баатар болоорой гэж шивнэв. Энэ үгэнд Бат урамшин

-Та надад итгэж болно. Би эцэг шигээ баатар болно. Харин эцэг шигээ эрт үхэхийг үл хүснэ гэж хэлжээ. Уг нь Бат ингэж хэлнэ гэж огт санаагүй тул санамсаргүй унагасан энэ үгэндээ өөрөө ч цочиж харамсжээ. Гэвч хэлсэн үгээ буцаан залгиж болдоггүйгээс хойш эцгийнхээ үхлийн нууцыг тээж цээжээ өвтгөн явснаа бүгдийг хэлье гэж гэнэт шийджээ. Чингис хаан Батын үгэнд айхтар сүрхий эмзэглэж цочоогүй ч хар багадаа эцгээс өнчирсэн түүнийг ихэд өрөвджээ.

-Эцэг чинь идэр сайхан насандаа хүнд өвчинд нэрвэгдсэн дээ. Өвчинг юу ч үл дийлнэ гэж тэрээр аргадангүй хэлэв.

-Би эцгийгээ өвчнөөр үхсэнд хэзээ ч үл итгэнэ гэж Бат биеэ барьж дийлсэнгүй хоолой зангируулан шивнэв. Тэр дахин үг дуугарвал асгартал уйлахад бэлэн байлаа.

-Чи юуны учир ингэж хэлнэ вэ. Чи яаж ингэж хэлж зүрхэлнэ вэ гэж хэлэх зуураа Чингис хаан,

Батын энэ үгэнд цочин жадаар сүлбүүлсэн мэт болжээ. Бас эцгийнхээ үхэлд Бат түүнийг шууд буруутгаж байх шиг санагдаад гэнэт хилэн бадарчээ. Гэвч Батыг загнаж зандарч зүрхэлсэнгүй. Эцгээс хагацахын зовлонг өөрөө ханатал үзсэн тул Батыг ийм үед загнах нь арай хатуудна гэж бодоод тэвчин биеэ барив. Гэвч зүрх сэтгэл нь түгшин дотор нь түлэгдэх мэт хорсон өвдсөөр байлаа.

-Та надад бүү хилэгнэ. Би төрсөн хөвүүний хувьд эцгийнхээ үхлийн шалтгааныг олох гэж бодож болохгүй гэж үү. Та Есүхэй өвгийг татаарт хорлогдоход над шиг ингэж гуниж шаналаагүй гэж үү. Та яг над шиг эцгээсээ цаг бусаар амь хагацсан бус уу. Та ахмад хөвүүн Зүчээ юунд өөрийн оронд хаан сууринд суулгахаар зарласангүй вэ. Тэгсэн мөрт та түүнийг гайхамшигтай баатар гэж бахдах нь юу вэ. Хаан сууринд суулгахгүйн тулд хорлосон бус уу. Танд тэгэж санагдахгүй байна гэж үү хэмээн Бат нэг л мэдэхэд аймшиггүйгээр хэлж орхижээ. Эцгийгээ гэнэт үхсэнээс хойш дотроо эргэлзэн шаналж зүрхээ шархлуулан бодож, дотроо хадгалж явсан үгээ ийнхүү нэгмөсөн хэлж санаа амрав. Одоо юу ч болбол болог. Үхвэл ч үхье гэж омогшин бодсон ч сэтгэл түгшжээ. Гэвч хэлсэн үгэндээ харамсах нь нэгэнт оройтжээ. Чингис хааны царайг харахад амь нас нь хутганы ирэн дээр ирсэн нь тод байлаа. Одоо Чингис хаан юу гэж хэлэхээс л бүх зүйл шалтгаалах боллоо. Бат даруй сэхээрээд дэмий үгнийхээ төлөө уучлал эрэхэд ч бэлэн байв. Тэр дэндүү түргэджээ. Чингис хааны зан аашийг сайн мэддэг эцэг нь ганц үүнээс л болгоомжлон ирж уулзахгүй байсныг мэдсээр байж ингэж хэлдэг ёроолгүй тэнэг амьтан гэж өөрийгөө хараавч оройтжээ. Хайртай Зүчи эцгийнхээ амиараа дэнчин тавин байж авч өгсөн улсыг алдаж ч мэдэх байдалд орсноо Бат ухаарав. Эцэг нь ямар нууц хадгалж, ямархан учир шалтгааны улмаас гэртээ хэвтсээр эцэс болсныг мэдэх ганц хүн бол Бат юм. Эцэг нь чухамдаа түүний төлөө амиа үрсэн байхад хүү нь хэрэг учрыг чанад ухааран өөртөө хадгалж, хазгай гишгэж илүүг хэлэх ёсгүй атал Бат өчүүхэн зүйлд сэтгэлээ тэвчин барьж чадсангүй алдав. Хэрэв эцгийнхээ өндийн босох ч чадалгүй мэт болж өвдсөн дүр эсгэн баашилсны цаад нууцыг Бат мэдэж байсныг Чингис хаан гэнэт ойлговол түүнийг урвагчийн адил үзнэ гэдгийг тэр гэнэт ухаарчээ. Гэвч энэ нь залуу хөвүүний хожимдсон гэмшлээс өөр юу ч биш байлаа. Батын амьдралдаа үзсэн хамгийн аймшигт мөч эхлээд байгааг тэр зөнгөөрөө мэдэрч байв. Иймээс тэр Чингис хааны царайг харан хэлэх үгээ бодож зогсов. Харин Чингис хаан гэнэт дүрсхийн уурласан ч гэнэт тайвширсан нь завшаан болж Бат жаахан ч гэсэн уужирчээ.

-Бат чи юу ярина. Хаан ширээнд сууна гэдэг санаснаар болдог хэрэг биш. Баатар зориг, бардам зангаар хаан болдоггүй юм. Өгөдэй авга чинь өрөөлд элэгтэй, цэрэгтээ элбэрэлтэй, эрдэм чадал бусдаасаа илүү тул Тэнгэрт тоогджээ. Ганцхан Тэнгэрийн зарлигаар л хаан болдог жамтай. Бат чи мөн ийм байх аваас хожим их хаан болно. Чи зөвхөн өш гомдол өвөрлөсөн балчир сэтгэлийн улмаас л ингэж бодсон байна. Чамд хэцүү байгааг би сайн мэднэ. Эцгээс хагацах шиг эмгэнэл хаа ч үгүй. Та Есүхэй өвгийн өшөөг аваагүй гэж үү гэж чи надаас асуух байх. Тиймээ. Есүхэй эцгийг минь заналтайгаар хорлосон татаар аймаг үгүй болсон. Үүнийг би эцгийгээ алуулсны өш хонзонгоор хийсэн юм биш. Татаарууд Тэнгэрт тэрсэлж бидний өвөг дээдсийг Алтан улсад барьж өгсний учир гэсгээгджээ. Одоо Алтан улс ч үгүй болно. Бат хаан чи сонс. Чи одоо нэгэнт хаан болов. Хаан хүнд хэлэх хэлэхгүй үг, хийх хийхгүй үйл гэж бий. Чи одооноос эхлээд хар толгойгоо бус хамаг улсаа бодох ёстой. Хувийн өчүүхэн хүсэл бодлоо хазаарлаж хамаг олны хүсэл жаргалыг эрхэм болговол хаан алдар чамд өөрөө ирэх болно. Хөвүүн чи үүнийг бүү март. Бат хаан чамайг би энэ өдрөөс эхлэн

эцгийнхээ үхлийн тухай элдвийг бодож эрээгүй ярихыг цаазалж байна. Эцгийнхээ үхлийг март. Бүү харамс. Өс бүү сана. Эцэг чинь өвчнөөр үхсэн. Чи миний зарлигийг дага. Үгүй бол... гэж Чингис хаан зүрхшиж сүрдэм хатуу хэлээд үгээ таслан хүндээр амьсгаадаж Батыг заамдан авч сэгсчив.

-Сонсож байна уу чи. Миний зарлигийг дага. Нэгэнт өнгөрсөн үеийг бүү эргэж дурс. Зөвхөн урагшаа, ирээдүй рүү хар. Мэдэв үү. Март. Мартах ёстойг мартаж эс чадвал чи хэзээ ч их хаан болж чадахгүй. Бат хаан чи миний зарлигийг ойлгов уу гэж Чингис хааны бахардан хашгирсан нь нэн аймшигтай болсонд Бат айсандаа өөрийн эрхгүй өвдөг сөхрөн суужээ.

-Хаантан таны зарлигийг би хичээн дагая.

-Бат хаан. Би хэлсэндээ хүрдэг хүнд дуртай. Чи нэгэнт Тэнгэрт ивээгдсэн тул хаан алдрыг олов. Үүнээс өөр чамд юу хэрэгтэй юм бэ. Сайн эцгийнхээ ясыг бүү өндөлзүүл хэмээн Чингис хааны хашгирах дэндүү заналтай байсан тул Бат

-Өршөө. Хаантан. Таныг ингэж их хилэгнүүлсэнд өршөө. Би эцэгтээ хайртай тул тэсэлгүй ийн хэллээ гэж үнэнээсээ асгаруулан уйлжээ. Өмнө нь сөхрөн суугаад эхэр татан уйлж тонгойсон Батын нулимсыг хараад Чингис хаан сая л ухаан оржээ. Тэгээд Батыг гэнэт өрөвдөн гол нь харлаж тэврэн авав. Бат айсандаа, бас эцгийгээ санаж өнчирснөөс сэтгэлийн тэнхээ нь тасарч явсан тул түүнийг өрөвдөн энхрийлэхэд сэтгэл нь дэнсэлж бүр гомдолтойгоор улам их мэгшин уйлсаар байсанд Чингис хаан түүнийг ер хориглосонгүй толгойг нь элгэндээ тэврээд тайвширтал нь суув.

Батын хэлсэн үг, түүний сэтгэлийн гүний далд бодол нь Чингис хааныг ихэд түгшээжээ. Эцгийнхээ үхэлд хэн нэгнийг, тэр дундаа өөрийг нь буруутган бодож явааг олж мэдсэн нь ингэж цочирдоход хүргэв. Батын энэ өс хонзон эцэстээ юунд хүргэж болохыг ч тэр ойлгожээ. Эцгийнхээ өвчнөөр үхсэнийг нууц аллага байсан гэж бодсоор байгаа Батыг хатуу чангаар буруутгаж чадаагүй ч бас ингэх шалтгаан байсныг, бүр энэ шалтгаан нөхцлийг нь тэр өөрөө үүсгэсэн мэт санагдаад тайвширч чадсангүй тул шөнө дунд өнгөрснийг ч үл тоон Боорчийг дуудуулжээ. Боорчийг яах гэж дуудаж байгаагаа өөрөө сайн мэдээгүй ч сэтгэлд нь хурсан айдсаас тэр л нэг холдуулж хамгаалах юм шиг санажээ. Сэтгэлд нь цэвдэг хүйтэн айдас хүйдэс хэсэг бусгаар хурсаар байгаа нь ойртон буй үхлийн сүүдэр гэдгийг Чингис хаан сайн мэдэрч байв. Үнэнч боол Зэлмийн нь үлдээж өгсөн амьдралын цөөн хоногууд өнгөрч байгааг тэр мэдэхгүй байв. Хэрэв Өүлэн эх нь амь насаа таслан түүнд үлдээгээгүй бол, Хулан хатны нь сүнс ирж авраагүй бол, бас Зэлмэ өөрийнхөө амьдралын үлдсэн цөөн хоногийг түүнд өгөөд хорвоогоос сайн дураараа яваагүй бол Чингис хаан аль эрт үхэх байв. Түүний амьд байсаар буй нь хайртай Өүлэн эх, үнэнч нөхдийн нь сэтгэлийн хүч, бас Тэнгэрийн хүсэл байлаа. Чингис хаан өөрийн үхлийн энэ мэт нарийн нууцыг мэдэрч ойлгох аргагүй ч үхнэ гэдгээ бат мэдэж байсан тул өчүүхэн төдий зүйлийг ч орхигдуулахгүйгээр өөрийн санаснаар хийж шийдэх гэж яарч байлаа.

Тийм ч учраас өглөө болтол хүлээх цаг түүнд байсангүй. Чингис хаан гадаа гарч хэсэг зогсов. Ийм амгалан нам гүм, агуу гайхамшигт газар дэлхийгээс хагацна гэхэд даанч харамсалтай санагджээ. Тэнгэрт саргүй тул нүхэн харанхуй орчлонг нөмөрчээ. Гагцхүү түг түмэн одод тэртээ дээр анивчин гялалзах нь алс холоос түүнийг дуудах мэт санагдана. Гэтэл газрын

гүнээс бөөгийн дуудлага, хэнгэргийн чимээ урсан гарах шиг болсноо удалгүй чоно улих нь бүр тов тод сонсдож эхлэв.

Энэ бол Тэв Тэнгэр бөө болохыг Чингис хаан дор нь танижээ. Харц Мэнлигийн хөвүүн ид шидэт Хөхөчү л ганцаар чонын хэлээр ярьж чаддагийг Чингис хаан яахан мартаж билээ. Тэв Тэнгэрийн улихыг сонсмогц зүрх нь оволзон булгилж цээжээ дэлбэлэх гэж буй мэт дэлсэж байхыг мэдэрсэн ч энэ нь баярлах, айхын алинаас үүдэлтэй болохыг таасангүй. Чонын дүрд хувилсан Хөхөчү их хүрээний арын уулын оройд зогсоод хушуугаа тэнгэрт сунган салхи татуулан улиж байсныг Чингис хаан олж харсангүй.

### *ГАЛТ ЧОНО*

Боорчи харанхуйн дундаас гэнэт урган гарч ирэв. Тэрээр Чингис хааныг харанхуй шөнө ганцаар гадаа зогсож байхыг үзээд ихэд гайхаж

-Хаантан. Юу болов. Шөнө дунд гэнэт дуудахаар тань бүр сэтгэл түгшиж муу совин татаад. Сүүлийн үед би ер ингэж цочин сандарч үзсэнгүй. Бүр айх ч шиг хэмээн дуу алджээ. Нээрээ ч Боорчийг энэ удаагийнх шиг ингэж түрүүлэн дуу алдаж олон үг хэлэхийг Чингис хаан үзээгүй тул бас гайхжээ. Харин хачирхалтай нь өнөө Тэв Тэнгэрийн чоно мэт улих нь Боорчийг ирмэгц огт сонсогдохгүй болов.

-Боорчи чи ер нь айдаг гэж үү гэж Чингис хаан инээмсэглэн асуугаад өргөөндөө оржээ. Боорчи ч хойноос нь орж тэд сууцгаав. Чингис хаан дахин дуугарахгүй байхаар Боорчи

-Та миний зүрх зоригийг асуух гэж энэ шөнө дунд дуудав уу. Би таны ямар ч зарлигийг гүйцэлдүүлэхдээ айж сандарч явсангүйг Та мэднэ. Юуны учир ингэж шөнө дунд дуудсанаа хэлээч хэмээн болгоомжтойхон асуужээ. Учир нь Боорчид нэг л ёозгүй муу совин татаад байлаа.

Огт санаандгүй байтал Чингис хаан эцсийн гэрээс мэт үгийг хөвүүд, ач нартаа хэлсэний дээр балчир Аригбөхийн хашгирсан нь бүгдийг сандралд оруулжээ. Чингис хааны өргөөнөөс гараад тэд бүгд цуглан хэрхэхээ ярилцсан ч олигтой шийдвэр гаргаж чадсангүй. Юутай ч Чингис хаан өөрийн үхлийг нэгэнт мэдэж буйг бүгдээр хүлээн зөвшөөрсөн билээ. Тэгээд Чингис хаан Тэнгэрт халих аваас яах, юу хийх ёстойг урьдчилан бэлтгэхийг Өгөдэй Шихихутаг хоёрт даалгажээ. Ингэж хөвүүд, шадрууд нь түүний үхэлд бэлдэж эхлэснийг Чингис хаан гадарласангүй.

-Боорчи. Би чамайг нутагтаа буцахыг тушааж байна. Бүр Бурхан халдун ууланд оч гэж Чингис хаан ямар ч оршил тайлбаргүй шууд хэлсэнд Боорчи эхлээд буруу сонсов гэж бодсоноо сүүлд нь Чингис хааны ухаан самуурав гэж санажээ. Гэтэл Чингис хаан өмнөхөө дахин давтаад элдэв тайлбар хэлсэнгүй тул

-Нутагтаа буц гэв үү Та. Яах гэж тэр билээ. Их цэрэг хэдхэн хоногийн дараа Алтан улсын Түрэмгий балгасыг дайлна. Ийм хэргээс намайг зайлуулж гэрт минь буцаах ямар хэрэг болов. Би ямар гэм ялд унав. Хаан та намайг хөгшин гэж, хоёр гар минь илдээ өргөж даахгүй боллоо гэж бодон голов уу. Эсвэл Зэлмийн адил санаснаараа үхэж чадахгүй гэж сонжив уу. Би

хаан таны хишигтэн цэргийн ноён. Шадар сайд. Их эзэн Чингис хааны амь насыг даасан хүн. Гэтэл ийм үед таныг орхиж одно гэдэг юу гэсэн үг вэ. Арван хэдтэй, ангир зүстэй алтан үеэсээ хаан таныг дагав. Таны биеийг орхиж цалгардсан нэг ч хоног надад үгүй. Гагцхүү таны зарлигаар Киевийн дэргэд байсан Сүбээдэй, Хивчагийн тал дахь Зүчийн өргөөг зорихдоо л хэдэн сар хол байжээ. Би таныг ийн зарлиг буулгасанд гайхаад учраа ч олохгүй байна. Ар гэр, Аураг ордонд муу үйл болов уу. Бөртэ хатнаас муу хэл ирэв үү гэж Боорчи нэг л мэдэхэд өөрийн эрхгүй олон үг урсгав. Боорчийг гэнэт ийнхүү догдлон хөөрч залуу хөвүүн шиг оволзон омогтой шартай үг хэлсэнд Чингис хаан гайхаад

-Тайвшир Боорчи. Чи чинь юу болоод үгийн зөрөөгүй хашгичаад эхлэв. Би чамайг ийм ёс журамгүй мэт байхыг ер үзсэнгүй. Эсвэл би зүүдлэж байна уу гэсэнд Боорчи сая л Чингис хааны өмнө бүр босоод зогсчихсоноо анзаарч ихэд гайхан өвдөг сөхрөн буцаж суужээ.

-Та нар чинь юу болов. Намайг үг хэлэхээр л эвэртэй туулай үзсэн мэт байцгаах болж. Эсвэл миний улаан нүүрэн дээр үхэл нь ирэв гэж бичээстэй байна уу. Эргэн тойрны юмс өөр болоод ч байх шиг. Хажуугаар нь Боорчи чи юу ч вэ дээ. Залуу хөвүүн шиг дүрсхийх чинь хэмээн Чингис хаан түүнийг зэмлэжээ. Боорчи ч өөрөө чухам яагаад ингэж битүү хатуу үг хэлснийхээ учрыг олохгүй гайхжээ.

-Боорчи чи аан гэж бай. Ер чиний хэлсэн шиг зүйлийг би бодсон нь үгүй. Чи надад нүүр алдаж гэм ялд унах нь бүү хэл, миний амь нас, алдар нэрийг минь сахиж хар нүдээ анивхийлгүй хатан биеэ амсхийлгүй явааг чинь би яаж мартана. Хэрлэнгийн хөдөө арлын ордон хийгээд Туулын хөвөөн дэх Бөртийн ордонд муу юм огт болсонгүй. Харин... гээд Чингис хаан үгээ тасалсанд Боорчи дахиад л тэссэнгүй өндөлзөж

-Хаан та шууд хэлэгтүн. Миний зүрх хатуу үгэнд хад чулуу шиг дассан. Бүү түвдэгтүн гэжээ.

-Боорчи. Чи битгий хашгичаад байгаач. Тайван сууж сонс. Би Хэрлэнгийн хөдөө арал, Дэлүүн болдогтоо буцсугай гэж шийдлээ гээд Чингис хаан тооно өөд харжээ. Тоононоос цааш харанхуйн дунд тас хар, урт гонзгой дүрс харлан байсан нь түүний үхэл болохыг одоо Чингис хаан мэдэж байв. Гэвч тэр үхэл түүнээс бас ч хэдэн алхам зайтай байлаа. Чингис хаан үхлээс ер айхгүй болжээ. Учир нь одоо түүний дэргэд үнэнч нөхөр Боорчи нь сууж байлаа.

-Хаан та их цэргээ орхиод уу. Би ойлгож ядаж байна. Таныг нутагтаа буцвал их цэргийн... гэтэл Чингис хаан түүний үгийг таслав.

-Монголын их цэргийг одоо хэн ч зогсоож үл чадна. Чингис хаан би ч зогсоохоос өнгөрсөн. Чи бидний өсгөж хүмүүжүүлсэн залуу идэр жанжид, тэдний эрэлхэг цэргүүд яг л уулын голын хүчит урсгал шиг түрхэрч байна. Тэр их хүчит урсгалын өмнө тэсч үлдэх нэгээхэн ч боомт, бэхлэлт цайз, улс орон үгүй болжээ. Харин би л тэр их эрчит урсгалд саад тушаа болох болов. Миний бие Тэнгэрээр тэтгүүлж нөхдөөр дэмжүүлж Их Монгол улсыг байгуулав. Одоо би өөр юуг хүснэ гэжээ. Боорчи Чингис хааны энэ үгийн цаад санааг сайтар ухан ойлгосонгүй.

-Хаан таныг их цэргээ орхиод нутаг буцахад хүрвэл Алтан улс юу гэж үзэхэв. Айж хулчийн дайлах зориг мохов гэх бус уу. Эсвэл бие чилээрхэж... гээд Боорчи хоолойдоо тулж ирсэн

дараагийн үгийг зориглон хэлэлгүй буцаан залгисан мэт дуугүй болов. Гэвч Чингис хаан түүний хэлж чадаагүй үгийг зөнгөөрөө тааж мэдээд

-Үхэв гэнэ гэж үү. Чиний хэлэх гэсэн үг чинь үнэн. Гэвч миний буцсаныг хээрийн салхи, хэлгий шаазгай ч мэдэх учиргүй. Би ийм зарлиг буулгая. Тэгвэл чи яахав.

-Нэгэнт Та ингэж зарлиг буулгавал би юу хэлэхсэн билээ. Тэгвэл бид хэзээ хөдлөх вэ. Ядаж Түрэмгий балгасыг эвдэхийг үзэхсэн.

-Боорчи чи юун өчүүхэн зүйл хүснэ. Чи улаан гал дүрэлзэж утаа униар манаран, манай цэргийн өмнө шавар хэрэм нурж унахыг үзээгүй гэж үү.

-Би дахиад чингэхийг үзэхгүй мэт санагдсан тул хэлэв. Та хэзээ мордохыг зарлиг болгоно. Би бэлдье.

-Чи морь өдрийн морин цагт хөдлөгтүн. Харин би чамайг Бурхан халдунд хүрч намайг угтан авахад бэлэн болмогц эндээс довтолгоё.

-Урьд нь хэзээ ч ингэж байсангүй тул нэн хачирхалтай байна. Бөртэ хатан, Отчигон авга чинь биднийг их аянаас утсаар нэгэнт ёс дэглэм хатуу тогтсон бус уу. Та намайг юунд ийнхүү өөрийн дэргэдээс холдуулах мэт түрүүлж одохыг тушаана гэж Боорчи сэтгэл дундуур байгаагаа нууж үл чадан өгүүлэв. Морь өдөр гэдэг нь ердөө гурав хоногийн дараа болох тул Боорчи ийнхүү гомдолтой байжээ. Уг нь тэр их цэргийн хамт Алтан улсыг дайлан сөнөөнө гэж балчир хүүхэд шиг баярлан догдолж байсан билээ.

-Боорчи. Чи байлдаж дайтахаас өөрийг бодохгүй байсаар наад тархи толгой чинь тараг айргийн сав мэт болов уу. Чингис хаан би хамгийн сүүлчийнхээ аян дайнаас нутагтаа харьж явна. Энэ Тангуд улсад ирсээр жил хагас болов. Одоо би Дэлүүн болдогоосоо дахиж явахгүй. Тиймийн учир би чамайг урьдчилан илгээж байна. Хаана буух, хаана угтах хийгээд хаана, хэрхэн суух энэ бүгдийг Наху баяны ганц хүү хөлөг баатар Боорчи чи шийдтүгэй. Үүнийг би хүсч байна. Чиний засч заасан бууринд би мөнх суухаар шийдэв. Үүнийг чамаас өөр хэн хийнэ. Би ч чамаас өөр хэнээр хийлгэнэ. Миний өсгөсөн, өргөсөн нөхөд чамаас бусад нь бараг бүгд үгүй болов. Тэдэнгүйгээр би одоо юу хийж чадна. Бат хөвүүний хэлсэн үгнээс хойш би ихийг бодох болов. Тэр хөвүүн хорин настай Тэмүжинг, бас Зүчийг санагдуулав. Миний удамд энэ зовлон юунд үл тасарна. Надаас хойш миний үр удам өс хонзон санахгүй амьдраасай гэж би хүснэ. Хорвоог би нэгэнт элээв. Харин одоо энэ хорвоо намайг идэж, эвдэж дуусгахыг харж байна. Би чадах бүхнээ хийв. Хожим намайг үр сад минь лав хараахгүй биз. Харааж нулимах тэнэгүүд гарлаа ч тэд цөөн байх биз гэж найдна. Би хамаг Монголын хөх гүрнийг хан хорвоогоос хэзээ ч арилахгүйгээр бат байгуулав. Үүнээс өөр би юу хийж чадна. Ганц биеийн чадлаар биш гавшгай нөхдийн хүчээр үүнийг гүйцэлдүүлэв. Одоо хөвүүдийн минь цаг болжээ. Морины явдал даахгүй өтөл би хүүхэд нохойн доог, хөнгөн тэрэгний ачаа болохоосоо өмнө нутагтаа харьж үүрд суусугай. Тэнгэрийн зарлигийг зөрчин байж Тангудад ирсэн минь миний алдаа болов. Гэвч хийвэл бүү ай. Айвал бүү хий гэдэг биз. Иймийн тулд би чамайг түргэвчлэн мордохыг тушаав. Би их яарч байна. Намайг хэн нэгэн элдэн хөөж би түүнээс зугатааж байх шиг санагдах болов. Одоо надад Тэнгэрт гарч энэ ертөнцийг бүтнээр нь харахсан гэсэн хар багынхаа тэр орь хүслийг биелүүлэх л үлдлээ.

Чингис хаан чухам юуны тухай ярьж байгааг Боорчи ойлгох тул түүнийг өрөвдөн тэсгэлгүй бэрхээр шаналжээ. Гэвч түүнд яах ч арга байсангүй. Зөвхөн дэмий тайтгаруулах л үлджээ.

-Хаантан Та юунд ингэтлээ яарнав. Нутагтаа буцах даанч сайхан. Гэтэл зорьсон хэргийн эцэст хүрэлгүй замаас буцах гэж яарах чинь юув. Үүнийг чинь л би гайхаж байна. Боорчийн энэ дэмий хоосон, аргаа барсан үгийг Чингис хаан тоож хариу хэлсэнгүй нь түүнийг улам ч арчаагүй дорой байдалд хүргэж тэр өөрийгөө үзэн яджээ.

-Тэгвэл нутагт хүрээд миний юу хийхийг хэлэгтүн гэж Боорчи өөрөө ч мэдэлгүй омогтой хэлэв.

-Чиний юу хийхийг би яаж мэднэ. Би өөртөө биш зөвхөн өргөн олны сэтгэлд л хаан байхыг хүснэ. Би ингэж чадсан бол арван дөрвөн наснаас цэрэг засаж төрийн төлөө биеэ золиосолсны хэрэг тэр. Чи яг ингэж үйлдэгтүн. Өөр би юу хэлнэ. Боорчи чи бид хэд Бөртийг буцааж аваад Бурхан халдун ууланд нэг сайхан ойн цоорхойд сууж юу хэлэлцэж байснаа санана уу. Өнөө Зэлмийн буга алдаг өдөр.

-Би санаж байна. Яаж мартаж билээ. Тэмүжин чиний юу хэлснийг ч санаж байна. Миний бие хэзээ ч үгүй болж мэднэ. Тэр үед энэ ойн цоорхойд бунхлагтун. Сүнс амармаар сайхан хангай гэснийг чинь ч санаж байна.

-Тэгвэл сэтгэл минь ханав. Одоо надад үхлээс айж, нүглээс ичих юм үгүй боллоо. Харин Бөртэд өгсөн тангаргаа эвдсэн нэг явдал бий. Гэвч тэрийг Бөртэ ойлгох биз. Дэргэд байсан бол хэдэн дулаан үг хэлэхсэн. Би түүнийгээ хаяж явсаар энэ насыг дуусгах учиртай байжээ. Би өөрийнхөө буулгасан зарлигийн төлөө харамсаж явсангүй. Харин Зүчи хөвүүнээ хөнөөх зарлиг буулгасандаа л их харамсаж байна. Би ухаан суухгүй, хүнд итгэхгүй хэвээрээ үлдэж. Хүнд өвчинд нэрвэгдээд ирж чадахгүй болов гэсээр байхад нь үл итгэж чамайг илгээсэндээ одоо харамсаж байна. Гэтэл хөөрхий тэр хөвүүн өвчинд шаналсаар үхэв. Харин Бат хөвүүн нь надаас эцгийнхээ амийг нэхэж байдаг. Би ийм болчимгүй хэрэг үйлджээ. Зүчийг өвчнөөр үхсэнийг мэдсээр атал Батын өмнө би буруутан мэт санагдаад хэлэх үг ч олдсонгүй. Надаас хойш Бат бас хэнийг эцгийнхээ үхэлд буруутгаж юу хийх бол гэхээс сэтгэл шимширч зүрх өвдөөд үхэхэд ч хэцүү боллоо гэхийг сонсмогц Боорчийн үс нь босч үхээр үзсэн мэт царай нь зэвхийрчээ.

-Юу гэнэ ээ. Тэр хөвүүн үүний учрыг яаж мэдээ вэ .Мэдэх учиргүй биш үү гэж Боорчи дуу алдахдаа зүрх сэтгэлд нь хүйт дааж айдас дүүрэхийг мэдэрчээ.

-Алдсан хүн арван тамтай гэдэг бил үү. Бат одоо ухаан суужээ. Эцэг Зүчийгээ, миний оронд хаан ширээ залгамжлах ёстой, эцгийнхээ дараа тэр өөрөө бас хаан ор суух ёстой гэж үзэж байна. Уг нь ингэх ёстой ч байсан юм. Гэтэл би Зүчийг өөрийн оронд хаан ширээнд суулгаж яаж чадна. Миний хөвүүд бүгдээрээ л надад хэрэгтэй. Би бүгдэд нь хайртай юм. Зүчи хөвүүн мэргэдийн цусанд төрсөн нь түүний буруу гэж үү. Зүчийг би буруутгаж яаж чадна. Тэр энэ хорвоод амьдрах гэж ирээд өөрийгээ үхлээс булааж төрсөн баатар байв. Би Зүчид өөрийн хөвүүд шиг дастлаа удсан. Гэвч тэр намайг өөрийнхөө хүчээр итгүүлсэн юм. Хорьхон настай залуу Зүчи миний өөдөөс огт цавчихгүй ширтэж байгаад “Эцэг минь би ойн иргэдээс алс явж аймаг улсыг хурааж ирье. Одоо би хорин нас хүрэв. Таны хөвүүн болохоо нэг бол баталсугай,



эсвэл амь өрсөн тулаанд үхье” гэж тов тод хоолойгоор өөртөө итгэлтэй бөгөөд хатуу чанд хэлэхэд нь Зүчийн миний хөвүүн болох хүсэл нь халуу шатах мэт мэдрэгдэж сэтгэл зүрх минь урагдаж байв. Би түүний хүсэлтийг аргагүйдэн зөвшөөрсөн. Зөвшөөрөхгүй байх ч аргагүй байсан юм даг. ”Зүчи чамайг амьд ирвэл өөрийн хөвүүнээ гэж үүрд нэг санаагаар тооцох болно” гэж би тэгэхэд дотроо тангаргаласан юм. Зүчи ч ямаршуу баатар эр болохоо харуулсан. Би бүр заримдаа Зүчид атаархдаг байв. Тэр бол ухаан чадал тэгш төрсөн баатар, Тэнгэрээс надад илгээсэн элч шиг санагддаг. Би Зүчид хайртай, магадгүй бусдаас ч илүү хайртай байв. Гэвч хураасан улсынхаа нэгдмэл байдлын төлөө, алтан ургийнхаа төлөө түүнийг алахаас өөр зам надад байгаагүй юм. Ийм зовлонг надаас өөр хэн гэтэлж чадна. Аз болоход тэр зовлонг хөвүүн өвчнөөр үхэх ёстой байж. Гэтэл Бат намайг эцгийгээ алсан гэж сэжиглэж байгаа нь аймшигтай. Хожим хойно алтан ургийн хөвүүд, ач нар алалцаж ясыг минь өндөлзүүлэх бий гэж би ихэд зовно. Хожим юу болохыг Зүчи ухаан, совин хоёроороо мэдээд газрын холыг зорьж Хивчаг руу одсон. Энэ нь ч зөв гэж би бодсон билээ. Зүчийн судсаар хэний цус булгилж буйг мэдэх болсон цагаасаа Цагадай түүнийг огт үзэж чаддаггүй, арай гэж тэвчдэг байсан юм. Цагадайн ааш зан хэзээнээсээ бэрх. Намайг үгүй бол тэд галзуу ноход шиг хэмлэлдэн хоолой гүрээгээ тас таталцахад ч бэлэн байсан. Хөөрхий Зүчи хөвүүн өөрийн хувь заяаг дагаж эзэндээ зодуулсан нохой шиг гомдолтой гасалсаар салж одсонсон. Түүнээс хойш бид уулзалдаагүй. Хамгийн сүүлд уулзсан хүн нь чи. Зүчи лав өөрийн улсыг байгуулахыг хүссэн биз. Одоо Бат хөвүүн нь эцгийнхээ хүслийг гүйцээг. Батын өмнө өргөн уудам нутаг газар бий. Гэвч түүний улс Их Монгол улсын баруун хязгаар л байхаас биш хэзээ ч тусгаар улс болох ёсгүй. Миний их улсыг тасчин хувааж булаалдан салгахыг би тэвчихгүй. Тийм хүсэлтэн буй аваас хэн ч бай Тэнгэрийн цаазанд унах болно. Хасар ч, Зүчи ч ялгаагүй гэж Чингис хаан гэнэт бухимдан хилэгнэж бахардах шахан өгүүлжээ. Чингис хааныг тайтгаруулах хэрэгтэй байлаа.

-Тиймээ. Зүчийг яахин мартаж болох билээ. Мартахын аргагүй хүмүүн гэж байх. Тэр бол Зүчи юм. Би бол түүнийг бүр ч мартаж учиргүй хүн. Анх морины явдал дунд хөнгөрөхдөө Бөртэ тэнхэл нь барагдаж аргаа бараад мориноос унахад нь би Зүчийг үхээ биз гэж бодож билээ. Морьдын тоосон дунд унаад хүй тасраагүй хэвтэж байсан тэр улаан нялзрай амьтныг замаас зайлуулах санаатай алган дээрээ авахад учиргүй бархирч байсансан. Тэгэхэд л Тэмүжин чиний зарлигийг би амьдралдаа цорын ганц удаа зөрчиж хүйг нь тас хазаад өвөртөлсөн билээ. Би тэр үед чиний хэлснээр түүнийг эзгүй хээр газар хөсөр шидэж орхисон бол хорвоо дээр Зүчи гэх хүн байхгүй, хожим нь Хаан та ингэж шаналахгүй байв гэж би гэмшин бодсоор өнөөг хүрлээ. Гэвч энэ хорвоогийн элдэв учрыг хэн урьдчилан тааж мэдэх билээ. Алганд минь арвалзан бархирах тэр нялх амьтныг хажуу тийш нь шидчих зүрх хүрээгүй юм. Уургийг нь дөнгөж амлуулаад бүтэн өдөр давхин Хэрлэнгийн эрэгт буухад огт дажгүй тарвалзан уйлж байсан билээ. Тэгэхэд би “Энэ хөвүүнийг хүн болдог л юм бол хамгаалж явсугай” гэж өөртөө тангарагласан юм. Хаан та тэгэхэд Зүчийг голж хаясан бол би авах байв. Тийм ч учраас Ойн иргэдийг дайлахад би гуйж цуг явсан. Ухаандаа түүнийг хамгаалсан санаатай юм. Яагаад ч юм бэ чи түүнийг юу юугүй хорлох гээд байх шиг санагддагсан. Зүчи ч үүнийг мэддэг байсан даа.

-Чамд тэр өөрөө тэгэж хэлэв гэж үү.

-Зүчи тэгэж хэлэх хүн биш.

-Боорчи. Байз, байз. Ингэхэд чи ер нь Зүчийг үхсэн гэж надад худал хэлсэн хүн биш биз. Гэнэтхэн тэгэж бодогдоод явчих чинь. Түүнийг өвчнөөр үхэв гэж чи надад худал хэлсэн мэт санагдана.

Чингис хааны энэ санаандгүй үгийг сонсоод Боорчи эргэлзэж орхив. Батын тухай түүний хэлсэн болон одоо энэ хэлж байгаагаас үзэхэд Чингис хаан түүнийг ингэж шөнө дөлөөр дуудсаны бас нэг учир тодрох шиг болжээ. Тэдний хамт байх хугацаа нэгэнт дуусч байгаа нь нуух аргагүй үнэн болж байхад сэтгэлдээ зовлон тээж явахын хэрэг юу билээ гэж Боорчи бодов. Бас тэр нууцыг Чингис хаан хэдийн мэдчихээд түүнийг сорьж сонжиж суугааг ч хэн мэдлээ. Ер нь тэрээр хэзээний тэгэж хүнийг сорьж туршиж байдаг, хэнд ч үл итгэгч, сэжигч зантай билээ. Тэгээд ч одоо Боорчид айж ичих хэрэг нэгэнт үгүй болсон нь илт байв.

-Зүчийн үхсэн нь гарцаагүй үнэн. Харин өвчнөөр үхсэн нь худал. Үүнийг би ганцаараа л мэдэх юм гэж Боорчи хэдэн жил өөрөөсөө ч бараг далдлан хадгалж явсан нууцаа шуудхан түс тас хэлэв. Чингис хаан харин Боорчийн төсөөлөн хүлээсэн шиг тэгтлээ цочиж хилэгнэх байдал гаргасангүй, санаснаас ихэд тайван сууж, сонсоод

-Үхсэн. Гэхдээ өвчнөөр үхсэн нь худал гэж чи юу ярина. Энийг чинь би юу гэж ойлговол зохихыг хэлээч гэжээ.

-Хаан та Зүчийг буруу санаа агуулсан ахул өөрийн үзэмжээр хороох ёстой бол хороохыг надад тушаасан бус уу.

-Чи юу ярина. Хивчагаас буцаж ирээд чи надад Зүчи өвчнөөр нас барав гэсэн тул бүхэл улсаараа их гашуудал зарласан бус уу.

-Хаантан Та юу айлдана. Миний зарлигаар Зүчийг хороов гэж Та зарлах байсан гэж үү. Хөвүүнийг чинь хороов гэж хэлэх үг миний аманд яахин багтах билээ гэж Боорчи гашуудалтай шивнэв. Хэсэг зуур нам гүм болжээ. Чингис хааны гар салганан нүд нь аяганаасаа бүлтрэн гарах нь үү гэмээр бүлтийж нэг юм хэлэх гэсэн бололтой ам нь хэд ангалзсанаа юу ч дуугарч чадалгүй ширээ тулан босоод ирэв. Боорчи ч үсрэн босчээ. Чингис хаан чив чимээгүй ойртон ирээд түүнийг заамдан авав. Нүд нь галзуурсан мэт дүрлийж ам нь ангалзах нь аймшигт үгс хашгирч байх мэт. Гэвч түүний дуу гарахгүй бөглөрчээ. Чингис хааныг ингээд үхэх нь үү дээ гэж Боорчи сүнсээ зайлтал айх мөртөө дэмий юм хэлэв гэж харамсах ч сөхөө байсангүй. Чингис хааны царай хөхрөн амьсгаа нь тасалдахад Боорчи аргаа барж өөрийн мэдэлгүй алгадаад авчээ. Чингис хаан сая л нэг цочин цээжний нь бөглөө онгойж арай ядан амьсгаа аваад

-Чи намайг хуурчээ хэмээн байдаг хоолойгоороо хилэнтэйгээр хашгирчээ. Түүний дууг сонсоод Боорчи тайвшрав. Сая түүнийг алгадаагүй бол Чингис хаан амьсгал нь бөглөрөн хормын дотор үхэх байв. Харин Боорчи учрыг тэр дор нь ухааран хэрхэхийг зөв сэтгэж түүнийг үхлээс зайлуулжээ. Үхлийн хар сүүдэр алгуур холдон одов.

-Чи миний зарлигийг зөрчиж аймшиггүйгээр хуурсан байна. Би чиний аль үгэнд итгэнэ. Хэлээч гэж Чингис хаан бухимдан өгүүлээд түүнийг дахин заамдан авав.

-Би чамайг өөрийн гараар багалзуурдан ална. Миний хөвүүнийг алсны чинь төлөө алах болно. Би чамайг Зүчийг авчир гэсэн биш үү. Чи ч түүнийг даруй дагуулан авчирна гэж амласан биш үү гэсээр үгээ ч дуусгалгүй Боорчитой зууралдсан чигээрээ ухаан балартан суужээ. Гэвч тэр дороо сэргэж өндийн суув. Чингис хаан тэрхэн хооронд тайвширсан нь гайхалтай ч Боорчи тайвширч чадахгүй байлаа.

-Намайг алах ч багадна. Гэвч би Хаан таны зарлигийг дагахгүй байж яахин чадна. Энэ муу мойног гар яасан их нүгэл үйлдэв. Нүгэл нүглийн дотроос орчлонд ирэхэд нь тосч авсан гараараа түүнийг хөнөөх гэдэг юутай аймшиг. Тэр өдрөөс хойш би огт өөр хүн болчих шиг л санагдсан даа. Би Хаан таны сэтгэлийг шархлуулахгүй л гэсэндээ “Өвчнөөр үхэв” хэмээсэн билээ. Бас үнэхээр өвчнөөр үхсэн мэт л хороосон. Үүнээс өөрөөр би яах билээ. Би үйлээ л дагасан. Одоо ч дагахад бэлэн. Наху баян эцгийнхээ адууг эзгүй хээр орхиод чамайг дагахдаа л би ингэж шийдсэн буй. Намайг албал алтугай. Одоо надад үхэхэд хайран бус.

-Чи Зүчийн тухай чин үнэнийг хэлэгтүн. Миний сэтгэлийг бүү дурс.

-Таны сэжиглэн бодсон бүгд үнэн байв. Зүчи “Бие өвчлөв” гэж зар тараагаад гэртээ бүгэж, Хаан таныг нутаг буцахыг хүлээхээр шийдсэн байв. Есөнтэй Танд чухам үнэнийг хэлжээ. Зүчи ч надад тэгэхэд бүх үнэнээ хэлж бас намайг дэргэдээ үлдэхийг ч ятгасан. Тэр бүгдийг сайтар төлөвлөсөн байлаа. ”Бие муудав” гэсэн нь хаан эцэгтэйгээ олны нүдэн дээр эвдрэлцэхээс зайлсхийхийн тулд байжээ. Бас намайг хараад л яах гэж ирснийг минь дор нь мэдсэн дээ. ”Хаан эцэг чинь хилэгнэж даруй ирэхийг тушаав” гэхийг минь сонсоод сууж сууж “Боорчи ахай. Би энэ улсыг байгуулах гэж цусаа урсгаж, цулбуураа хумилгүй явлаа. Би өөрийн байгуулсан улсдаа ясаа тавья даа” гэсэн юм. Би юу ч хэлж чадаагүй. Ер нь юу ч хэлэх билээ. Бид хоёр Каспийн тэнгисийн зэгст хөвөөгөөр морьтой зэрэгцэн галигуулж явлаа. Зүчи их цэргээ тал дүүртэл жагсаагаад “За Боорчи ахай. Таны өмнө миний их цэрэг байна. Энэ цэрэг надтай цуг Каспийн тэнгисийн зүүн эрэг, Хивчагийн талын гурван их голын хот балгасыг дайлан авч нэгтгэсэн юм. Надад одоо ямар ч улс аюултай биш. Миний цэрэг зоригтой, хурдан гавшгай, надад үхлээ үнэнч тэмцэнэ. Би ийм цэргүүдээс хагацах даанч хайран. Би Бөртэ эхийнхээ үгийг л дагая. Би эхийнхээ сэтгэлийг зовоож үл чадна. Ээж минь надад “Зүчи хүү минь. Чи бол Тэмүжин эцэг, Бөртэ ээждээ зовлонгоос олдсон үр нь юм. Тэмүжин эцэг чинь чамайг хүн болог гэж эгэмнээс чинь татаж энгэртээ нааж, хөлийг чинь дөрөөнд гарыг чинь ганзганд хүргэж өгсөн юм. Энэ хүний гарт чиний амь нас байгаа гэдгийг бүү март. Чи бол эцгийнхээ дайны сахиус болох ёстой. Тийм болохоор хөвүүн чи эцгийгээ дуудахад ирж, дохиход зогсож бай. Чи үх гэвэл дуугүй л үхэх ёстой” гэж үргэлж сургасан юм. Би Боорчи таныг алах шиг амархан юм алга. Бас цэргээ хөдөлгөж Туулын хөндийг дайлах ч амархан байна. Гэвч тэгэж түмний шившиг болж хаан эцгийн хайран нэрийг үрж, хамаг Монголын хана туургыг эвдээд яана. Би хаан эцгийн өршөөлөөр хүн болсон. Одоо түүний хүслээр үхсүгэй. Хаан эцэг минь намайг сайн хөвүүн байсан даа гэж хайрлаж яваасай гэж хүснэ. Өөр хэлэх зүйл надад үгүй. Би одоо дөнгөж дөч хэвийж байна. Хамаг Монголын их үйлсэд миний амь нас хэрэгтэй бол автугай. Хамаг Монголын төлөө ганцхан Зүчи би ч биш, хэрэгтэй болвол түм түмэн Зүчи харамсах юмгүй амиа өгөх биз гээд инээж байсан даа. Би одоо Бөртэ хатны ухааныг эрхгүй бишрэн гайхна. Халуун амь, бүлээн цусаа таслан байж өгөөд хорвоод төрүүлсэн хонгор үрээ эх хүн яаж ийнхүү хатуу бэрхээр засан хүмүүжүүлж чадав хэмээн Боорчи шивнэн өгүүлжээ. Энэ үед Чингис хааны эмгэнэл

хязгааргүй болоод бүр эхэр татан уйлж байв.

-Миний байгуулсан улсыг Бат хөвүүн минь засна биз. Харин хаан эцэгт хэлэгтүн. Бат бол Зүчи биш тул түүнийг бүү гадуурхагтун. Миний байгуулсан улсыг өөрийн чадлаар өргөтгөн их улсын баруун хаяаг батлан сахиж сууг. Түүнийг бүү хорло гэж гуйгаарай. Намайг төрөхөд үгүй хийж орхиогүй тул би хаан эцэгтээ их өртэй хүн. Тэр намайг соёрхож амьдрал өгсөн. Би эхийн захиснаар түүнд үнэнч зүтгэв. Одоо үх хэмээсэн тул би үхье. Харин би өөрийн амийг егүүтгэж үл чадна гэж тод хэлээд давхиад явсан.

-Дуустал ярь. Би тэвчиж сонсоно.

-Зүчи намайг дэргэдээ үлдэж их улс хамтран байгуулахаар зүтгээч гэсэн. Түүнд үхэх хүсэл огтхон ч байхгүйг би харж байлаа. Зүчээс өөр овилоггүй хүн байсан бол аль эрт хаан танаас туурга тусгаарлан улсаа зарлах байв. Гэтэл тэр хаан таныг хүндэтгэн аядуу зөөлөн хүмүүжилтэй зандаа хөтлөгдөн бүгдийг хаан танд зовлон учруулалгүй бага багаар хийхийг зорьжээ. Тэр надтай хамт нааш ирэхгүй нь тодорхой болсон тул надад өөр арга үлдсэнгүй. Би Зүчийн үгийг сайшааж үлдэхээр болоод түүнийг хуурч алсан билээ. Би түүнийг шөнө унтаж байхад нурууг нь хугалж орхисон гэж Боорчи үгээ зөөн байж арайхийн хэлж дуусгав. Энэ үед харамсаж гашуудсандаа түүний ухаан балартаж байжээ. Чингис хаан ч чимээгүй уйлсаар байлаа. Хүчирхэг түрэмгий агаад омог бардам зантай, хэн нэгэнд нулимсаа үзүүлэх нь байтугай сандарч тэвдэж, айж балмагдаж байгаага ч хүнд харуулахгүй байхыг хар багаасаа сурч, үргэлж сүрдэж бишрэм байж чаддаг Чингис хаан бяцхан хүүхэд мэт енгэнэтэл уйлж халуун нулимсаа хүнээс нуухгүй асгаруулан байхыг харсан хүн гайхаж алмайрахаасаа сэтгэл эмтэрч уяран өрөвдмөөр харагдах ажээ.

-Боорчи чи миний нулимсыг үз. Ус байна уу гэхэд мөлхөн очиж арчин үзэв. Чингис хааны нүднээс үнэхээр ус биш цус урсан гарч байх ажээ. Тэр зүрхээрээ мэлмэрэн цусаар уйлж байлаа. Түүний хийсэн аян дайны хөлд дайрагдаж Монголын эсрэг мөчөөрхөн Мөнх Тэнгэрийн зарлигийг аймшиггүй сөрж хар толгойдоо лай хураагаад Чингис хаанд бууж өгөөгүйн учир түүнийг хилэгнүүлж овог удмаараа хүйс тэмтрүүлсэн түмэн хэлийн хэчнээн хүний зүрхнээс гуниг гаслан, өшөө хорсол нэвт шингэсэн ийм нулимс цусан зам татуулан урсаа бол гэсэн аймшигт бодол толгойд нь өөрийн эрхгүй зурсхийн орж ирсэнд зэвүүцэн хирдхийсэн Боорчи

-Цус байна. Одоо дахин уйлахгүй биз. Сайн уйл. Таны хөвүүдээс хамгийн гайхамшигтай нь Зүчи байсан юм даа. Гэтэл би тэр хөвүүнийг чинь алж амьдын хар нүгэлд унав. Харин одоо үнэн учрыг Танд хэлж миний санаа амарлаа. Энэ аймшигт нууцыг Та бид хоёроос өөр хэн ч үл мэднэ. Намайг хэрхэхээ Та мэд хэмээн мөргөжээ.

-Миний нүднээс гашуун нулимс биш зүрхний минь сүүлчийн цус дусал дуслаар асгарч байна. Надад үлдсэн балга цус ингээд дуусч байна. Өүлэн эхийн минь надад хайрласан амьдралыг тэтгэгч халуун урсгал ийнхүү тасарч байна Боорчи. Би их нүгэлтэй, үйлийн үртэй хүн юм. Юуны учир би хөвүүнээ алав. Яах гэж. Хураан авсан нутаг орон багадсан мэт Зүчээс юугаа харамлав. Би сая улсаа хөвүүддээ хуваан өгөв. Тэр үед би Зүчээс яагаад харамлав. Би юуны учир ингэж өөрчлөгдөнө вэ. Зүчийн амьдад ийн сэтгэхгүй яав. Над шиг мунхаг хүн үгүй биз. Өүлэн ижий минь хичнээн жилийн өмнө миний өнөө хийхийг

урьдчилан сануулжээ. Тэр Буянтай өвгөний тухай домогт миний хийхийг заажээ. Гэтэл би ухаарсангүй.

Чингис хаан шархдаж улангассан араатан мэт гаслан бархирна. Түүний эмгэнэл, харуусал, үзэн ядалтыг харах бүү хэл, үйлж гаслах дууг нь сонсоход бэрх ажээ.

-Би хэзээ, хэнд, ямар нүгэл хийсний лайгаар ийм хүнд ялд унав. Хайртай Бөргийнхөө амин ганц үрийг нь юунд би хөнөөв. Би юуны тулд гүрний хаан болж энэ их улсыг хураав. Гэмгүй хөвүүнээ туурга тусгаарлахыг санаархсаны нь төлөө хөнөөхийн тулд уу. Боорчи чи хэлээч. Би яах ёстой байв.

Боорчид хариу хэлэх чадал нэгэнт үгүй болсон тул чимээгүй болжээ. Чингис хаан гэнэт дахин догширч

-Чи юунд хөвүүнийг минь хөнөөв. Цэргийг нь хөдөлгөж Монгол нутагтаа дагуулан ирэхгүй яав, чи. Би түүнтэй тулалдаж хэн нь амьд үлдэхээ үзсэн бол дээр байж. Тэгсэн бол би Зүчийн гарт үхэхэд харамсах зүйл үгүй байв. Би Зүчи хөвүүнийхээ амиар юу олов. Их улсаа хураахад минь нөхөр болооч гэснийг нь ашиглан мэхэлж, санаандгүй байсан хөвүүнийг минь чи хороожээ. Би энэ үгийг чинь сонссон хойноо хатан Бөргийнхээ царайг яаж харна. Эх хүн зөн совингоороо мэддэг байж. Гэтэл би гэдэг тэнэг толгой иймхэн юмны учир олохгүй өдий олон жил хууртаж явжээ. Боорчи чи намайг гутаан доромжлов. Итгэлт нөхөр Боорчи чи, намайг илжигнээс дор үзэв. Би чамайг нүдэндээ үзэхийг ч үл хүснэ. Чи үтэр түргэн далд ор. Зайл. Тонил.

Боорчи чимээгүй босч явав.

-Амьд дээрээ зайл.

Боорчийг гарахын алдад Чингис хаан

-Боорчи хүлээ. Би үгээ дуусгаагүй байна гэсэн тул тэр эргэж суужээ. Хоюул учраа олохоо байж элий балай болон солиорсон мэт болжээ.

Боорчи бушуухан тэндээс холдохын түүс болж байв. Угаас гансарч гашуудан хилэгнэж галзуурсан Чингис хааныг тэсч харах, тэвчиж сонсохын аргагүй болж байв.

-Би сонсож байна. Хаантаан.

Чингис хаан гэнэт хаанаас ч юм урд нь Боорчийн огт үзэж хараагүй шүр мэт туяарсан жижиг улаан чулуу гаргаж ирээд духандаа хүргэж, зүрхэн тус газраа хэсэг зуур барьж байснаа зүүн гартаа тас атган нүдээ аньж чимээгүй болов. Боорчи ч дахин үг дуугаралгүй Чингис хаан нүдээ нээж түүнийг харах хүртэл тэвчээртэй хүлээж байлаа. Чингис хааны тас атгаастай зүүн гар гэнэт нэвт гэрэлтэн байхыг Боорчи олж үзжээ. Тэрхэн зуур гэнэт дотор нь онгойсон мэт болж бяцхан тайвшраад саяхан л үхдэл адил өгөр зэвхий болчихсон байсан царай зүс нь хүртэл гийж уужирсан Чингис хаан

-Зүчийн үхлийг чи үүрд март. Чи түүнд огт буруугүй. Сэтгэлээ тайван байлга. Харин нутгийн зүг явахаа бүү март. Хэлсэн цагт явж үз. Одоо явж амар гэжээ.

Чингис хааны энэ гэнэтийн гэмээр тайвшруулах үгэнд сэтгэл багахан уужирсан ч дөнгөж саяхан итгэлт нөхөр нь бүү хэл элэг буруутан ч хараад өрөвдөж харуусмаар гаслан гашуудаж, хилэгнэн догширч байсан багын андаасаа нэг л холдомгүй санагдахад

-Үүр цайтал бас ч зай байна. Танд бараа болж хэсэг зуур хүлээзнэе. Хаан таны цухал жаахан ч гэсэн дарагдаг гэв.

-Би одоо чамд Чингис хаан биш болсон. Хоёулаа анх Хэрлэнгийн эрэг дээр уулзсан Тэмүжин, Боорчи хоёроороо л үлдье.

Тэмүжиний энэ элэг дэвтээм ээнэг дотно үгийг сонсоод

-Тийм бол сайнсан гэж Боорчи тайтгаран инээжээ. Хэдий инээж сэтгэл санаа тайвширсан мэт боловч дахин хэзээ ч уулзахгүйгээр салж хагацах гэж байгаагаа хэн хэн нь зөн совин, зүрх сэтгэлээрээ тод мэдрээд үгээр хэлэхэд хэцүү их гунигт автжээ.

Энэхүү хагацлын өгүүлшгүй гунигийн дэргэд амьд яваа насандаа тэдний үзэж эдлэсэн зовлон шаналал харин жаргал шиг санагдана. Тэд нэг их юм яримаар байсан ч нэг насаар салахгүй хамт явсан тул ярих хэлцэх юм нэгэнт үгүй болж дууссан мэт байх ажээ. Зөвхөн хагацахын тулд ингэж олон жил тохой залган зүтгэсэн мэт санагдах нь даан ч харамсалтай. Гэвч тэд цуглуулж хураасан алт эрдэнэс, цуурайтаж мандсан алдар нэрийн алийг ч үл тоон гуйлгахгүй ирж ялгахгүй аваад явдаг аймшигт үхлийн өмнө хүчгүйдэн бууж өгч байгаагаа зөвшөөрч ойлгож чадахгүй байв. Хараалт тэр үхэл ердөө хэдхэн алхамын зайнд ирчихээд аль хэдийн халуун сэтгэл, хатан зүрхэнд нь хар сүүдрээ тусгаад байгааг учир мэдэхгүй балчир хүүхэд ч гуниг хургаагүй нүдээрээ хирдхийн харахаар тод байлаа. Одоо үхлийг буцаах хүч нэгэнт үгүй болсон байв. Үүнийг Чингис хаан мэдэж байсан тул бүх аргаа хэрэглэн үхлээс зугатаахыг хичээж байв.

-Боорчи. Миний сэтгэл тайвширч цэвэршив. Их улсынхаа төлөө хийсэн үйл тул би Хасарын төлөө ч, Зүчийн төлөө ч харамсахгүй байх нь зөв юм. Чи ч өөрийгөө бүү буруутга гэж Чингис хаан тайвшраад хэлэв. Гэвч тэд хоюул Зүчийн үхэлд буруугүй гэдгээ даанч мэдэхгүй байлаа. Чилэгэр бөхийн удам Бичэлдэй хөвүүнийг цавчин алахдаа үхлийн аймшигт дуу хөдлөгөөнийг мэдэрснээс болж Зүчи хачин ихээр айж цочсон бөгөөд сүүлд нь Бичэлдэйн үхэлд харамсан шаналсаар байсан нь Зүчийн сүнс зайлснаас болсон байв. Хийх ёсгүй үйлийг хийсэн нь Зүчийн үйлийн үр болж тэр мөчид түүний сүнс дахин эргэж ирэхгүйгээр зайлсан байжээ. Үүнийг хэн ч мэдэх аргагүй юм. Бат хөвүүнийхээ ирээдүйн сайн сайхан, тусгаар их улсын төлөө Бичэлдэйг үхүүлэв хэмээн итгэж явсан нь Зүчийн үхлийг дахин хоёр жил саатуулжээ. Боорчи яаралгүй дахин нэг хоног тэвчсэн бол Зүчи өөрөө үхэх байв. Гэвч энэ нууцыг зөвхөн Тэнгэр л мэдэх тул Боорчид юуны буруу байх билээ.

-Тэмүжин анд минь. Би чамайг яаж орхиж явна гэж чи санав гэж Боорчи арга барагдан шивнэжээ. "Тэмүжин анд" гэсэн үг сэтгэлд хичнээн ойр, уяралтай сайхан сонсдохыг Чингис хаан сэтгэл дэнслэн анзаарчээ.

-Удахгүй уулзах тул сэтгэлээ бүү зов доо, Боорчи минь.

-Тиймээ. Чи бид хоёр удахгүй уулзах нь гарцаагүй. Би үүнд итгэж байна.

Хаа нэгтэй холоос бөөгийн хэнгэрэг дуугарах сонсогдсонд тэд чимээгүй болжээ. Боорчи ч үүнийг тов тодхон сонсов.

-Ойрноос нэг хэрмэл тэнүүлч ингэж хүссэн газраа, хүссэн цагтаа бөөлж явдаг болсон гэнэ гэж Боорчи хэлжээ. Харин Тэмүжин түүний хэлснийг сонсоогүй мэт

-Чи явахдаа хишигтэн цэргийнхээ хагасыг дагуул. Одоо дахиад уулзахгүйгээр яв. Хоюул Бурхан халдун ууландаа дахин уулзъя гэв. Боорчи удалгүй Чингис хааны өргөөнөөс гарч явахад нэгэнт үүр цайж бас нэгэн өдөр эхэлж байв. Тэд ингэж өнөө салаад маргааш уулзах мэт хагацжээ. Энэ бүхэн Тэнгэрийн зарлиг байсан тул хэн нь ч зөрчсөнгүй билээ. Тавин жил хамт зүтгэсэн тэднийг хагацуулах нь ганцхан үхэл боловч бас дахин уулзуулах нь үхэл юм. Тийм учраас Боорчи нутагруугаа яаран морджээ. Боорчийн ийн гэнэт явсны нарийн нууцыг Өгөдэйгөөс өөр хүн мэдсэнгүй.

Тэв Тэнгэрийн сүнс эргэн ирснийг Чингис хаан мэдэрчээ. Гэвч Тэв Тэнгэр яагаад ч юм бэ, түүнийг тойрон хүрээний гадуур эргэлдэж зөвхөн ирснээ мэдэгдэх төдий байлаа. Тэв Тэнгэр түүнд туслах гэж ирсэн гэдэгт Чингис хаан эргэлзэж тээнэгэлзэхгүй итгэж байв. Үнэхээр үхлийн сүүдэр ойртон ирэхэд хаа холд хэнгэрэгийн дуучоно улих сонсогддог бөгөөд үхэл ч даруй холдон оддог ажээ. Сүүлийн хэдэн өдөр Чингис хаан Өүлэн эхийнхээ өгсөн Тэнгэрийн тэмдгийг гараасаа нэг мөч ч салгахгүй болсон бөгөөд Хулан хатныхаа хутгыг бүсэндээ байнга зүүдэг болжээ. Хулангийн ав хомрогын үеэр түүн рүү дайрсан өнөөх аймшигт хар азарганы зүрхэнд зоолттой байсан хутга бол Хулан хатны нь хутга болохыг Чингис хаан андууралгүй таньсан билээ. Учир нь Хорезмын хаан Мухамедийн эх Туракина хатны зүүж явсан энэ хутгыг Хулан хатан гуйсаар байж авсан юм. Ингэхэд нь Чингис хаан маш их дургүйцэж яг адилхан хутга хийлгэж өгье гэсэн ч зөвшөөрөөгүй тул аргаа барж билээ. Тэгээд эрх дураараа хатан нь чухам юунд нь болоод ингэтлээ шохорхсоныг мэдэх гэж тэр хутгыг ихэд анхааран үзсэн тул тэр хожим хойно ч андуурахгүй танихаар болжээ. Гэтэл Хулан хатан нь ганцхан түүнийг аврах гэж л энэ хутгыг зүтгэн зүтгэн байж авсныг сая л нэг мэджээ. Энэ явдал бол Тэв Тэнгэр бөөгийн хэлснээр Тэмүжин, Тэнгэрт ивээгдсэний баталгаа гэж итгэжээ. Харин үхэл гарцаагүй ирэхийн дохио бол Тэв Тэнгэрийн түүнд өгсөн Тэнгэрийн сахиус алга болсон явдал байлаа. Тэр сахиусны нууцыг ганц Тэмүжин өөрөө л мэдэх тул алга болсныг нь хэнд ч хэлсэнгүй. Хулангийн авын үеэр догшин хулангийн хөлд өртөн тасарч алга болсон байх гэж таахаас өөр арга үгүй байлаа. Чингис хааны бие болоод сэтгэл санаа хямарч эхэлсний үндэс нь Тэнгэрийн сахиусаа гээснээс болсон гэдэгт тэрээр итгэж байлаа. "Нутагтаа суу" гэж Өүлэн эх нь Тэнгэрийн нэрээр Барыгжан уулын оройд гарахад захисан нь чухам энэ явдлыг зөгнөсөн хэрэг байжээ.

Одоо тэрээр харамсавч нэгэнт оройтжээ. Түүнийг Мөнх Тэнгэр ч үхлээс хамгаалахгүй болжээ. Тэнгэрийн сахиусны хүчээр Чингис хаан хичнээн удаа үхлээс аврагдсаныг тооцоолж хэлэхийн аргагүй байлаа. Тангудыг зорилгүй Тэнгэрийн зарлигийг дагаж нутагтаа суусан бол хэзээ үхэх байсныг бас тодорхойлон хэлэх аргагүй ч нэгэнт буруу зүйл хийснээ хүлээн зөвшөөрөхөөс өөр замгүй болжээ. Үхэл хаяанд нь ирчихсэн байгаа нь тодорхой болмогц

хүссэнээрээ үхэх хүсэл тэсгэлгүй оргилдог ажээ. Яг ийн санагдахад Чингис хаан өөрийн эрхгүй Жамухыг дурсан санадаг бөгөөд түүнийг хүссэнээр нь үхүүлээгүйдээ харамсан дэмий зүйл хийжээ хэмээн үе үе гэмших болжээ. Ер нь энэ хэд хоногт Чингис хаан өөрийгөө таних, ойлгохоо нэгэнт больсон байлаа. Эргэн тойрныхон нь ч үүнийг мэдээд түүнтэй маш болгоомжтой харьцаж, бараг зугатаах болжээ.

Хаан эцгийгээ эмчлэн сувилахын тулд Өгөдэй хөвүүн нь тэргүүлэн бүгдээрээ бололцоотой бүхнийг хийж байлаа. Харин Боорчийг Гэрэгийн хамт Монгол нутаг руугаа явсны хойно Алтан улсаас нэгэн өвгөн лам ирж Чингис хаанд бараалхах хүслээ илэрхийлжээ. Есөнтэйн тагнуул туршуулуудын хэлснээр энэ өвгөн лам үхсэнийг ч босгодог шидтэй домч гэж алдаршсан хүн байжээ. Үүнийг шалгаж тогтоомогц Өгөдэй Чингис хаанд айлтгав. Чингис хаан бие тавгүйрхсэнээс хойш энэ тэр отчийн өгсөн эмнээс өөрөө сэжиглэн уухгүй болжээ. Тэрээр хүн бүр өөрийг нь хорлон үхүүлэх бий гэж муу санаж байсан нь эдгэрч тэнхрэхэд нь илэрхий саад болж байлаа. Энэ бол түүний үхлийн эрхэнд орж эхэлсний цаад шалтгаан болохыг Чингис хаан ойлгосонгүй. Халуун ханиад туссан нь ужгирсаар байгааг ч тэр ойшоож үзсэнгүй билээ.

-Өгөдэй чи түрүүлэн уулзаж бай. Би дараа нь орёе гэж Чингис хаан хэлсэн нь ер өмнө нь тохиолдож байгаагүй явдал бөгөөд Өгөдэй ч огт юм бодоогүй ажээ. Хаан эцгийн хэлсэн ёсоор Өгөдэй тэр ламтай уулзав. Олон жил даяанч хийж Буддаг шүтэн гэгээрсэн гэх тэр нанхиад өвгөн нээрээ л хүний сэтгэлийг татмаар ариун дүртэй нь өөрийн эрхгүй шүтэн бишрэх сэтгэл төрүүлэх ажээ. Өгөдэй ёс алдахгүй гэж ламтай ойр зуурыг туршин ярилцжээ. Өнөө ламыг Учан арш гэх агаад тэр арш Өгөдэйн үгийг сонсож суугаад

-Та залуу хүн гэхэд ухаантай хүн юм. Би таныг их хаан эцгийнхээ нэр сүрийн доор бүх юмыг хялбархнаар бүтээсээр өтөлсөн болов уу гэж бодсон юм. Тань шиг хувь зохиолтой хүмүүс ихэвчлэн ухаан санаа нь хөгжөөгүй, бодол сэтгэл нь түгжигдмэл, голдуу өөрийгөө ихэд бодож биеэ тоосон мулгуу амьтад болсон байдаг юм гэвэл Өгөдэй

-Та намайг бодоод арай зөөлрүүлж хэлж байгаа юм биш биз. Би танд яг тийм хүн шиг санагдаж байна уу. Та үнэнээ шууд хэлбэл сайнсан. Би ил үнэн үгэнд дуртай. Чингис хаан эцэг маань биднийг ингэж хүмүүжүүлсэн юм. Та айх явдалгүй. Үнэн санаагаа хэлэгтүн гэжээ.

-Би үхлээс айдаг наснаасаа өнгөрсөн хүн тул ямар ч их хаанаас үл айна. Бас үнэн үг хэлэхээс ч үл айна. Та миний хэлсэнд итгэж болно. Би дөрвөн улсын хэл нэвтэрхий мэднэ. Монголчууд та нарын хэл заншлыг би хамгийн эрт сурсан. Учир нь танай өвөг дээдэс цаг үргэлж л миний удмынхны гэр оронг уулгалан дайрч хүнс, үр тариаг дээрэмддэг байв. Одоо цөлмөн дээрэмдэхээс хэдийн хэтрээд бүр нутаг орныг минь эзлэн суухаар ирж байна. Харин таны эцэг Чингис хаан эрдэм номтой, ухаантай хүмүүсийг үнэлж түшдэг, үг сургаалийг нь хүндлэн дагадаг гэж сонссон тул би өөрийн нүдээр үзэж, биеэр уулзахаар ирлээ. Би дорно дахины бүх газар орноор зорчиж бумбын болоод Буддагийн ном сургаалыг үзсэн хүн хэмээн ярьж байтал Чингис хаан гэнэт орж иржээ. Нанхиад арш босч мэхийв. Чингис хаан огтхон ч ёс төр гүйцэлдүүлэлгүй гайхмаар хүйтэн царай гарган суужээ. Өгөдэй хаан эцгийгээ бүр ойлгохоо больжээ.



-Эрхэм нанхиад хүн таны алдрыг дуулсан тул би уулзахыг зөвшөөрсөн билээ. Би танаас хэдэн зүйл асууя.

-Хаан та намайг шалгаж сорих гэв үү гэсэнд Чингис хаан

-Үгүй. Би нанхиад хүн чиний үнэн үгийг сонсох гэж хүснэ. Би сая чиний ярихыг зах зухаас сонсов. Миний өвөг дээдэс чиний удмыг дээрэмдсээр иржээ гэв үү. Тэгвэл танай нанхиад иргэд малчин монголчууд бидний бэлчээр газрыг сэм сэмээр эзлэн түрж элсний нүүдэл шиг чив чимээгүй өдөр хоногоор ахих тул хичнээн таслаж зулгаавч үндэс яргаж үрээ цацсаар байдаг хогийн ургамал мэт тэднийг бид үтэр хөөн зайлуулах нь зөв буй заа гэж хилэнтэй асуужээ. Чингис хааны хүйтэн царайлсны учир энэ байжээ. Уг нь Чингис хаан аливаа элч хийгээд өргөө ордныг нь өөрөө зорьж ирэгсдэд дандаа сайнаар ханддаг заншилтай мөртөө нанхиад аршийг үзээд ийнхүү хилэгнэсэн нь түүний хэлсэн их үгнээс болжээ. Гэтэл хөгшин арш их хаанаас огт айж сүрдсэнгүйгээр барахгүй

-Нүүдэлчин омгийн байнгын довтолгооноос хамгаалах гэж манай хаад их Цагаан хэрмийг барьсан нь одоо ч таны өмнө давшгүй даваа, дарагдашгүй хүч болон хөндөлдөж буй. Та үүнийг яах гэж барьсан гэх бол. Арай Монголчууд үүнийг барьсан гэхгүй байлгүй дээ гэж ихэд даажигнан асуужээ. Чингис хааны өмнөөс ийн аймшиггүй дуугарах зоригтон байна гэж огт санаагүй Өгөдэй энэ хөгцөн шүдэт хөгшин аршийн хэгжүүн үгнээс болж хаан эцэг нь хилэгнэн догширч биеэ муутгахаас их эмээж байв.

-Та үнэн үгэнд тун ойрхон байна. Үнэндээ бол энэ их Цагаан хэрмийг биднээс айсан нанхиадын хаад барьсан юм биш. Нанхиадуудыг хойд зүг хорхой адил мөлхөж хорт могой шиг гулсаж ирэхээс болгоомжлон та нар өөрсдөө давж ирэхээргүй тэр шавар хэрмийг нүүдэлчин омгийнхон бид та нараар бариулсан юм. Энэ цагаан хэрэм та нарыг биднээс биш харин биднийг та нараас хамгаалж байгаа биш үү.

-Таны хэлж буй бол зоосны нэг тал. Зоосыг газар хаяхад аль ч талаараа унаж мэднэ.

-Одоо бидэнд тэр шавар хэрэм хэрэггүй. Ертөнцийн бүх улс хоорондоо эв найрыг сахиж нэгэн дээвэр доор Чингис хааны Их Монгол улсад нэгдэн дайн дажингүй энх амар амьдрах цаг ирж байна.

-Таны зориг, зорилго хоёр их гэдгийг би гадарлана. Та мөнх бус. Таны энэ их хүч ч мөнх байхгүй. Ертөнцөд мөнх юм гэж үгүй тул Хаан таны сүр хүч, хураасан их улс нэг л өдөр үгүй болно.

-Гэвч газар дэлхий байсаар, хүн зон амьдарсаар, тэмцсээр, улс гүрнээ байгуулсаар байх биз. Тийм болохоор ямар юм мөнхрөх, юу нь ул мөргүй үгүй болох тухай та бид маргаад яах вэ. Мөнхрөхийг хүсэхгүй хэн байна. Та ч мөнхрөхийг хүсч буй.

-Тиймээ. Хүн угаасаа үхэхийг үл хүснэ. Тэгэхдээ үхлийн хажуугаар өнгөрөх хүн нэг ч үгүй. Харин хүний сайн үйл мөнх биш юм гэхэд олон зуун жилээр үлдэж болно. Та одоо цагаан хэрмийг хар. Дахин хэдэн зуун жил болоход байж л байна. Түүний адил Хаан та ч сайн үйл бүтээе гэвэл болох биз. Хэрэв та одоохон их цэргээ гэдрэг татан бидний нанхиад улсыг амар

тайван орхивол тэр таны бүтээх хамгийн их ариун үйлс болохсон. Би үүнийг л таниас хүсэх гэж өдөр шөнийг ялгалгүй зүтгэж өвгөн биеэ чилээн зовоосоор хүрч ирэв. Бид цагаан хэрэмнийхээ хойно урд талд аль аль нь амар жимэр амьдран сууцгааж болно шүү дээ.

-Ийм хэргийг би тантай хэлцэх ёсгүй .Алтан улс бол монголчуудыг хэдэн үеэрээ түйвээн бусниулж түрэмгийлэн хорлосоор ирсний ялыг тантай хэлэлцэх билүү би. Ухаантай зоригтой эрчүүдийг маань алан хядаж, уяхан туяхан бүсгүйчүүдийг нь булаан эдлэж, удам сайт мал сүргийг нь уулгалан дээрэмдсээр ирсэн биш үү, та нар. Би үүнийг тэвчин суухын аргагүй. Ертөнцийг нэгтгэн нэгэн жолоогоор залж хүн зоныг нь амирлуултал миний санаа үл амарна. Энэ хэргийг би эс гэхэд миний хөвүүд гүйцэлдүүлэх биз. Та энэ хэрэгт ухаан зарах хэрэггүй.

-Өвгөн арш би Хаан таны саруул ухаанд найдан энэ үгийг хэлсэн билээ. Нэгэнт тохиосон үйлийг дагахаас өөр замгүй. Магадгүй таны асаасан талын их түймэр их далайн ус хүрч байж унтрах буй. Бас салхи эргэвэл таны өргөөг ч агшин зуур өршөөлгүй түймэрдэж мэднэ.

-Та их мэргэн ухаантай үг хэлэв. Би таныг их тоож байна. Таны сурсан үзсэн их биз.

-Тийм ээ. Би хатангир хүнийг таргалуулж халзан хүнд үс ургуулахаас эхлээд аливаа муу муухайгаас ангижруулах, түүний дотор өвдөх өвчин, өршөөлгүй зовлонгоос гэтэлгэх хүртэл олон эрдэм үзлээ. Сансар огторгуйн явдал, сар нарны хөдөлгөөн гээд надад үзээгүй, судлаагүй зүйлгүй.

-Яах гэж энэ их юмыг сурах гэж бие сэтгэлийг чилээн зүтгэнэ, Та. Хэнд хэрэг болно гэж ийнхүү нэгэн биенд хэтийдэм ихийг хураана. Өвгөн арш танд үр хүүхэд гэж бий юу.

-Эрдмийг энэ биендээ хэрэглэх гэж сурах бага хэрэг.Би бусдад хүртээх гэж, эртний заяатай нанхиад улсаа баян хүчирхэг, бялхам тансаг байгаасай. Алтан улсын савраас мултарч амар тусгаар болоосой гэсэндээ үсээ цайж үеэ мойнийтол суув. Би хүсвэл таны дэргэд шадарлан суухад ч татгалзах зүйлгүй.

-Миний санахад та нанхиад улсынхаа төлөө зүтгэвэл зүйтэй буй заа. Харин та хүнийг өвдөх зовлонгоос хэрхэн салгана вэ.

-Энэ амархан. Би нэгэн шидэт үрэл бүтээсэн юм. Бумбын сургаалийн ид шид шингэсэн энэ үрлийг хүртсэн хүн хормын дотор Тэнгэрийн оронд очдог. Ямар ч зовлон шаналал үгүй. Энэ бол зовж шаналсан, амьдрах итгэлгүй болсон хөөрхий ядуусыг аврах буян болох сайн үйл юм гэсэнд түүний яриа Чингис хаанд таалагдав бололтой магнай нь тэнийгээд

-Би таныг хүндэтгэн зоог барья. Та татгалзахгүй буй заа гэж Өгөдэйг зангахад тэр гарч тэд хоёул үлдэв

-Ухаантай хүнтэй үг солиход үүлтэй тэнгэр цэлмэх мэт оюун санаа онгойно. Та тэр шидэт үрлийнхээ хүч чадлыг надад үзүүлж болох уу гэж Чингис хаан Өгөдэйг гарсан даруй яаран асуужээ.

-Энэ бол би танд л итгэж хэлсэн нууц шүү. Хаан төрийг барина гэдэг хүчир ажил. Магадгүй ийм үрэл танд хэрэг болж мэдэх юм. Би танд тусалж болно. Та шан харамж гэх зүйлгүй. Энэ байна гээд арш уутнаас үрэл гаргаж өгчээ.

-Та энэ үрлийг хүртмэгц ухаан санаа цэлмэн гэгээрээд даруй ариун хутгийг олж аливаа бүх өвчин зовлон мартагдан илаарших болно. Би таныг бие чилээрхэн тавгүй байгааг дуулаад ингэж сайхан сэтгэл өвөрлөн ирлээ. Та наад үрлээ хүртмэгц ямар шидтэйг тэр дороо үзэх болно.

-Тийм үү. Та тэгвэл надад хоёрыг өгнө үү.

-Хоёрыг турших хэрэггүй. Нэг л байхад хангалттай. Та итгэлтэй байж болно.

-Хаан би ч ганцыг хүртэхэд болно гэж үү.

-Та их наргианч хүн юм. Та адилхан л мах цусанд төрсөн хүн. Нэг л болно.

-Би эргэлзэж байна. Би үзээгүй тул итгэмгүй байна.

-Та наад үрлээ амандаа хийгээд үзэгтүн. Тэгвэл та миний хэлсэнд итгэх болно. Гаднаас идээ будаа оруулж ирсэн тул тэдний яриа тасарчээ. Өгөдэйг гар гэсэн тул тэр ч гайхсаар гарчээ. Эцэг нь энэ нанхиад арштай юуг ингэтлээ нууцлан ярьсаар байгааг тэр ойлгож яджээ.

-Нанхиад хүн чи мөнхрөх хүн нэг ч үгүй гэж хэлэв үү.

-Тиймээ энэ ертөнцөд мөнх зүйл гэж нэгээхэн ч үгүй.

-Нанхиад хүн чи буруу л ярьж байна. Их хэргийн төлөө өөрий аз жаргал эд хөрөнгө нэр төрөөсөө таггалзан үхэж чадвал тэр бас мөнх нас болно.

-Ингэж итгэж үхсэн хүн хичнээн олныг тоолж яаж барна. Тэдний хэд нь эдүгээ мөнхөрснийг хэн яаж мэднэ. Хаантан та ийм аргаар мөнхрөх гэвэл алдаа болно. Гэхдээ танд ийм зориг зүрх байгаа гэдгийг би харж байна.

-Хүн хэрэгтэй цагт л үхэж сурах хэрэгтэй. Би ч, та ч, бүгд тэгэх ёстой.

-Санаснаар үхнэ гэдэг өчүүхэн төдий зоригийн хэрэг шүү дээ. Гэхдээ би хаан тантай маргах хүсэл үгүй байна. Би тантай санаа бүрэн нэг байна. Амтат идээ будаагаар дайлсанд талархаж байна.

-Та аль нутгийн хүн бэ.

-Би өмнө зүгийн Шэнлүшаан уулын хүн. Тэнд миний төрсөн нутаг буй. Шэньлюля гэж тосгон буй. Аав минь тэнд илжгэнд хөллөсөн анжсаар газар хагалдаг байлаа. Би аавдаа тусалж, илжгийг нь тууж өгдөгсөн.

-Аав тань тэнгэрт хальсан буй заа.

-Тиймээ. Аав минь олон жилийн өмнө нас элж, шарилыг нь Шэнлүшаан уулын энгэрт оршуулсан. Би ч гэсэн хэзээ нэгэн цагт тэр ууланд эцгийнхээ дэргэд нутаглахсан гэж хүсдэг юм.

-Би таныг хүссэн ёсоор тань Шэнлүшаан ууланд эцгийн тань хажууд оршуулахыг зарлиг болгомц.

-Шэнлүшаан уул хүртэл газар хол, зам зуур олон боомт бэхлэлт нанхиадын шилдэг цэргүүд тосч буй тул таны зарлигийг биелүүлэх боломжгүй л болов уу.

-Та битгий санаа зов. Бүтэхгүй зүйлийг би юу гэж зарлиг болгох вэ. Харин та надаас хүсэх зүйлээ хүссэн тул би танд нэгэн хүсэлт тавья гэж Чингис хаан хэлсэнд арш жаахан гайхсан ч их л дарууханаар

-Би биелүүлж дөнгөх болов уу гэжээ.

-Тэр амархан гээд Чингис хаан хундаганд дарс дүүргээд дотор нь үрлээ хийв.

-Та энэ дарсыг тогтооно уу. Энэ дарс бол хүний хүслийг хангагч Монгол газрын идээ юм. Дотор нь таны шидэт үрлийг хийсэн. Идээ эзнээ таньдаггүй гэдэг юм гээд барьжээ.

-Хаантан та юу хүснэ вэ. Миний өгсөн үрэл хор шүү дээ гэж нанхиад арш балмагдан хашгирч босон харайжээ.

-Би нанхиад хүн чамайг зовлонгоос гэтэлгэхээр шийдлээ. Би ухаантай хүнийг хүндэтгэнэ. Тийм учраас өөр үхлийг бус, таны өөрийн зохион сэдсэн энэ үхлийг танд зориулж байна. Би таны хүсэл ёсоор Шэнлүшаан ууланд эцгийн тань дэргэд оршуул гэж тушаамц.

-Та намайг ингэж алах хэрэггүй. Би таны дайсан биш. Би үхэх болоогүй.

-Та нанхиад улсын төлөө зүтгэнэ гэв. Тэгвэл удахгүй тэр нанхиад улс тань Алтан улстай хамт үүрд үгүй болно. Бас та манай цэргүүдэд тас цавчуулж үхэхгүйгээр эндээ хүндтэйгээр үхэх нь дээр буй. Уугтун. Та нанхиад улсынхаа төлөө тогтоогтун гэж Чингис хаан туйлын таашаалтайгаар хэлээд хундагатайгаа барин аршын дэргэд очив.

-Хаан та үнэн хэлж буй биз. Би үхэхээс үл айна. Нанхиад улсынхаа төлөө би тогтооё. Чи хэзээ ч миний улсыг дийлэхгүй биз гээд өвгөн арш хорыг даруй уужээ. Хормын төдий чимээгүй байснаа дотор нь бачууран цээж хүзүү хоолойгоо урж

-Чи талын зэрлэг махчин. Гэмгүй улс орныг сөнөөн устгагч араатан. Чиний өмнө ганцхан үхэл сүйрэл л бий. Чи ертөнцийн хамаг сайхныг сүйрүүлэн хөнөөгч. Чамайг хараал идэг гэж өөрийн хэлээр галзуурсан мэт орилсон тул Өгөдэй орж иржээ. Чингис хаан инээж гар өргөн Өгөдэйг хүлээ гэж дохижээ.

-Чи үхлийн муугаар үхнэ. Чамайг миний үр удам, чиний сүйтгэсэн улс иргэдийн үр удам үргэлж хараах болно. Чи бол хүн биш, алуурчин гэж хашгираад ширдгэн дээр унаж тэр дороо амьсгал нь тасарчээ. Өгөдэй гайхсан ч юм асууж амжсангүй.

-Би энэ нанхиад хүний үнэн дүрийг үзэв. Чи ч үзэв. Нанхиад хүний үнэн дүр энэ ажээ. Намайг хорлох гэж ирээд өөрөө тэр хорондоо үхэв. Энэ нанхиадын хүүрийг Шэнлүшаан ууланд эцгийн нь дэргэд нутаглуул. Би амласан юм. Би Алтан хааны илгээсэн хорыг түүний элчид уулгаж хөнөөв. Тэр намайг хорлон алах гэж энэ аршийг илгээжээ. Одоо тэр аюул өнгөрөв. Сэтгэл минь ханав хэмээн Чингис хаан ихэд сэтгэл бахтай хэлсэнд Өгөдэй

-Та яаж мэдэв гэж ихэд гэмшин асуужээ.

-Хөвүүн чи бүү сэтгэлээ зовоо. Та нар үүнийг мэдэх аргагүй. Харин надад Тэнгэр хэлжээ гээд Чингис хаан гар сунган Тэнгэрт залбирчээ. Өгөдэй гайхах үл итгэх хослон зогсов.

-Одоо би тэдэнд үнэн дүрээ үзүүлсүгэй. Түрэмгий балгасыг эвдэн сүйтгэ. Хэнийг ч байсан амьд бүү үлдээ. Хэн нь махчин араатан болохыг үзсүгэй. Бушуул. Цэргээ хөдөлгө гэж хашгираад Чингис хаан ухаан алдан унажээ.

Цэв цэнхэр тэгсэн мөртөө гайхалтай тунгалаг манан дунд Тэмүжин хаашаа ч юм бэ давхиж оджээ. Бөртэ өлгийтэй нялх хүүгээ тэврэн зам тосон зогсож байлаа. Энэ замаар Тэмүжин нөхдийн хамт эргэн ирэх ёстой ажээ. Нээрээ ч удалгүй алсад морин төвөргөөн сонсдов. Бөртэ чимээ чагнан сэтгэл догдлоод

-Хөвүүн минь чи сонсож байна уу. Аав чинь чамайг төрлөө гэж мэдээд ийм хурдан эргээд иржээ. Чи хар даа тэр. Аав чинь тайчуудын Таргудайг дараад иржээ. Тэр ачаа хөсөг морь малыг нь хар. Лавгай аав чинь их олзтой, ирмүүн баяртай ирж явна. Чи их азтай хүү юм даа. Чи аавынхаа дайснаа дарсан өдөр мэндэлжээ. Аавдаа бас ялалт авчирчээ. Аав чинь яасан их баярлах бол гэж өлгийтэй хүүхэдтэйгээ ярьж зогсохыг Тэмүжин харж байв. Тэмүжин Хасарын хамт түүний дэргэд давхин очив.

-Чи яагаад энд ганцаараа зогсоно вэ.

-Би чамайг бусдаад түрүүлж тосоё гэж санаад.

-Яасан болгоомжгүй юм бэ. Тайчууд бидний араар явж байвал яана. Үүнээс хойш бүү ингэж хүрээнээс хол яв гэж Хасар түрүүлэн хашгирчээ.

-Тэмүжин чи хар даа. Чи дахиад хүүтэй боллоо.

-Хүү юу гэж Тэмүжин баяртай хэлээд үнсэв.

-Надад баатар эр хэрэгтэй. Миний хүсэл лав биелнэ.

-Тэмүжин хүүдээ нэр өгөөч

-Аав нь чамайг Өгөдэй гэж нэрлэе. Өгөдэй, Өгөдэй гэж хөвүүнийхээ чихэнд хашгирна.

-Тэмүжин би чамайг үхэв гэж зүүдэллээ. Үүнээс хойш гэртээ суу. Би чамайг гуйя гэж Бөртэ уйлсанд

-Тэгвэл би мөнхрөх нь л дээ гэж Тэмүжин хөхөрч байв. Энэ үед Боорчи, Зэлмэ нар ирэв.

-Харцгаа та нар. Энэ Тэмүжин ахын хөвүүн Өгөдэй. Бид Тайчуудтай тулалдаж байх зуур хөвүүн мэндэлжээ. Тэмүжин ах гурван хөвүүнтэй болов. Өгөдэй, Өгөдэй, Өгөдэй гэж Хасар хашгирсаар байтал өнөөх цэнхэр манан хийсэн одоод оронд нь гэрийн унь тооно тодорчээ. "Хасар чи юунд ингэж түрүүлэн дуугарч түрэмгий загнана вэ. Өгөдэй чинь миний хөвүүн биш үү" гэж бодоод Чингис хаан сэргэжээ. Газар доргин хөдөлж байх нь гэр тэрэг явж буйг гэрчилнэ. Ухаан алдаад сэргэж буйгаа Чингис хаан мэдэв. Бас хойд насандаа түр очоод эргэж ирснээ гадарлав. Тэнд Хасар түүнийг хүлээж байгааг сая харжээ. Одоо үхэл яг тоононы ирмэг дээр суугаад далбилзан хөдөлж, бас их доогтойгоор инээж байгаа нь тов тод танигдаж байв. Хасар дүү нь болоод Бөртэ зүүдэнд орсон нь үхлийн эцсийн дохио болохыг Чингис хаан ойлгов. Чингис хаан насан эцэслэж байгааг Бөртэ зөнгөөрөө мэдээд яг энэ мөчид ухаан балартан унасанд Туулын хөндийн хүрээ даяараа түүнийг сэхээх гэж сандарч байцгаажээ. Үхлийн дохио Бөртэд адилхан үзэгджээ. Бөртийн яаж тарчилж байгааг Чингис хаан мэдэрч байв. Түүнийг үхэхэд хамгийн ихээр гашуудан шаналах ганц хүн бол Бөртэ юм. Үхэл алгуур холдоход Өгөдэй дэргэд нь ганцаар сууж байхыг харжээ. Амжих хэрэгтэй гэж Чингис хаан шаналан бодов.

-Өгөдэй. Би чамайг дуудав. Би сая чамайг бас ижийг чинь зүүдлэв. Би Бөртэ хатан эхийг чинь санав. Үхэл одоо намайг нэхэн энд иржээ. Тэр миний сүнсийг авч явахаар хүлээж ядан байна. Хөвүүн чи сайн сонс. Хөвүүн минь надаас хойш эхийгээ сайтар асар. Би их хаан суусан ч эхийг чинь ер жаргаасангүй. Бүтэн биеийг нь дөрөв хувааж зовоов. Тийм бус уу. Би эхтэй чинь уулзаж чадахгүй тул миний ингэж хэлснийг эхдээ дамжуулаарай. Арван настай Бөртэ охиныг би одоо тод харж байна. Тэр намайг лав өршөөх биз.

-Хаан аав та санаа бүү зов. Та нутагтаа очно. Ээж таныг тосч авна гэхдээ Өгөдэйн нүднээс нулимс асгарсаар ажээ.

-Тийм бол сайнсан. Би ээжийн чинь өвдгийг нь дэрлэж хэвтгээд үсээ самнуулах дуртай юм. Ингэж үсээ самнуулж хэвтсэнгүй хичнээн удав. Би ээжид чинь залуу үедээ нэг тангараг тавьсан юм. Тэр тангаргаа няцсан тул би их нүгэлтэй хүн шүү. Хүү чи мэдэж ав.

-Та юу ярина...

-Би Бөртэд боолынхоо охинтой самуурахгүй гэж тангаргаласан юм. Тэр тангаргаа би эвдсэн. Гэвч тэр хүүхэн үхсэн. Бөртэ ээж чинь ямар их тэвчээртэй, ухаантайг чи мэдэхгүй. Ээж чинь миний бие сэтгэлийн тал нь юм. Бөртэ энд байвал би лав ингэж хэвтэхгүй. Хүнд авааль эхнэр шиг хүн хаана олдоно. Ядарсан ч, задарсан ч үрийн минь эх л дэргэд байж баяр гунигийг цуг хуваалцана. Тийм тул би Бөртийг яаж мартана. Хөвүүн чи Тулуй дүүгээрээ ээжийгээ асруул. Отгон хөвүүн голомтоо сахиг. Тэр голомтыг эх чинь нэг насаараа манаж суув. Одоо бүү осолд. Бүү цалгард. Зөвд зөөлөн, бурууд хатуу бай. Цэргээ асар. Цэргийг эс асарвал чи яаж жанжин болно. Ухаантныг түш, уруудсаныг эргүүл. Ард олон идэх хоолтой, элбэг баян бол чиний улс бат бэх байх болно. Цагадай ах чинь түргэн зантай, түрэмгий ааштай ч буулт нь зөөлөн. Түүнийг аяар нь байлга. Тулуй лав чиний үгнээс үл зөрнө. Батыг чи Зүчи ахынхаа адил хүндэтгэж өөрийн хүү Гүюгийн адил захирч яв. Батын сэтгэл тогтворгүй болж мэднэ. Сүбээдэйг Батын дэргэдээс бүү холдуул. Боорчийг аливаад бүү албад. Тэр үхтлээ юу хүссэнээ

хийж яваг. Залуу халуун насны итгэлт олон нөхдөөс минь одоо тэр л ганцаар үлдэв. Би түүний хамаг аз жаргал, хайран сайхан залуу насыг булаан авчээ. Тэр ийм үйлтэй байж. Боорчийг эцгийн адил асар. Чи Гэрэгийг бас сайн асар. Гэрэг бол Боорчид тэнгэрээс заяасан ганц үр нь юм шүү. Түүнийг бүү үхүүл. Чи өөрийн охидоос нас бие гүйцмэгц Гэрэгт өг. Боорчи лав баярлана. Билгүтэй авгынхаа үр удмыг сайтар асар. Билгүтэй надад өргөсөн тангаргаа эвдэлгүй үхлээ үнэнч зүтгэснийг бүү умарт. Хасар авгын чинь үр сад өрсөлдөн тэмцэлдэж магад. Тэднийг Хөлөн буйрын талаас бүү нааш өнгөрөө.

Тэнд нь суулгагтун.

-За.Таны хэлснээр би бүгдийг хийе ...

-Чи өнөөдрөөс хаан мэт явагтун. Хүний тусыг бага гэлгүй амь тавьж хариул. Цэргийн дотор баатар бодлогыг сахь. Төрийн үйлд төв чигийг эрхэмлэ. Энэ дөрвийн нэгийг ядаж эрхэмлэн явбаас эр хүнд нэг насны үйлс болно. Би арван дөрвөн наснаас цэргийг засч, төрийг хүчирхэг түвшин байлгахыг хичээв. Би таван өнгө, дөрвөн хэлийн их бага дөчин улсыг хураан нэгтгэв. Гэвч одоо бодвоос тун бага зүйлийг амжуулжээ. Амарч цэнгэсэн минь хэтэрч алт шиг өдрүүдээ дэмий их үрсэн нь дэнджээ. Харин юуны учир хүн болж хүзүү сээр холбосныхоо учрыг ойлгосон минь гавьяа болно. Би хөвүүд та нарт энэ ертөнцийг эзлэн нэгтгэх их замыг нээж өгөв.

Одоо Цагадайн өмнө лалын мөргөлтний бүх улсыг нэгтгэх зам нээлттэй боллоо. Түүнийг баруун урагш давшуулж юуны түрүүн тэр Багдадын их үгт халифыг дайлан дарж түүнээс султан цол олгодог дархан эрхийг нь даруй хураан ав. Тэгээд цааш Улаан тэнгисийг өнгөрч Мисир орныг эзлэн ав гэж даалга.

Батын өмнө загалмайн мөргөлтний улсууд бүгд сүйрэн унах үүд нээлттэй бий. Тэр хөвүүнийг Сүбээдэйн хамт явж загалмайн мөргөлтний бүх улсыг нэгтгэн их улсад захируулахыг захь. Хамгийн эхлээд дотроо эв түнжингүй байгаа Орос угсаатан аймгуудын талыг эзлэн авч дараа нь оросыг оросоор нь даруулагтун.

Харин хөвүүн чи өөрөө энэ дорно зүгийн улс орон, Буддаг шүтэгч улсуудыг хураан авагтун. Алтан улсын бүх шилдэг цэрэг Дунгуан боомтод бий. Дунгуан бол өмнөө их уултай умартаа их мөрнөөр хашигдсан эзлэхүйеэ бэрх боомт. Харин Сүн улстай найрамдлаа батлаад нутгаар нь дайран гарч Алтан улсын өмнөөс довтолбол тэд Дунгуан боомтоос цэргээ санд мэнд гарган өмнө зүг татна. Тэр үед нь амжиж довтолон дарвал зохино. Тулуй дүүгээ чи өөртөө хавсруул. Харин Тулуй дүү чинь эх Монгол нутагтаа эцэг өвгөдийнхөө шарилыг сахин сууг. Энэ Монгол нутаг чинь ядрахад хоол, явгарахад морь, унтахад гэр, өвдөхөд эм чинь болох юм. Тэгээд хөвүүн чи миний хэлснээр хийж тэр Христос, Будда, Мухамед гурвыг Мөнх Тэнгэрийн хүчин дор нэгтгэн үнэн сүсэгтнүүдийг нь хураан захирч суу. Ер хүмүүний сэтгэл санааг дагуулвал үйл нь аяндаа дагана гэдэг юм. Миний алтан ургийн хөвүүд та нарт бурханы, загалмайн, лалын мөргөлтөн иргэдийг тус тусын нутагт нь нэгтгэн Мөнх Тэнгэрийн хүчин дор захиран суухыг Тэнгэр зарлиг болгожээ. Үүнийг бүү март. Хэзээ ч бүү цалгардаж осолд. Чамд хаана ч, хэнд ч байхгүй хүчирхэг их цэрэг, сэтгэл санаа нэгдсэн албат иргэдтэй, дэлхийд жишиггүй Их улсыг өөрийн биеээр хүлээлгэн өгөв.

Одоо хөвүүн чамайг юуны учир хаан сууринд шилэн өргөмжилсний учрыг хэлье. Энэ учрыг ганц би л мэдэх юм. Чамд бусад ах дүү нараасаа онцгойрч Тэнгэрт тоогдсон хоёр үйл бий. Нэгд, чи намайг Алтан улсад дайтаж явахад “Одоо энэ Алтан улстай дайтах нь цаг болоод цэргийн гарз болно. Харин баруун зүгийн улсууд дотроо эв нэгдэлгүй, хэрүүл тэмцэл ихтэй тул эзлэхэд хялбар “гэж үнэн санааг хэлж үйлс ялалтын үүдийг нээж туслав. Хоёрт, “Хаан эцэг та өөрөө зорин очиж байлдан эзлэх цагаа эцэслэж харин энэ газрын хүмүүс өөрсдөө Таныг зорин хуйлран ирж нэгдэх тийм улсыг байгуулж Орхоны хөндийд Хархорум гэдэг их хотыг цогцлоон ертөнцийн төв болгоё” хэмээн алс ирээдүйн замыг заасан мэргэн үг хэлэв. Үүний тулд би чамайг эргэлзэх зүйлгүйгээр хаан сууринд сонгосон билээ.

Би чиний хэлснийг бүрэн гүйцэлдүүлж чадсангүй. Харин чи өөрийн хэлснийг марталгүй энэ мэт мэргэн санаагаа хэрэгжүүлэн Хархорум төвтэй нэгэн их улсыг газар дээр байгуул. Хархорумыг цогцлоох Орхоны мөндий бол газар дэлхийн их хүч гайхамшигтайгаар хурсан урам зориг сэргээж, ухаан бодол саруулсгах увидис шидтэй, өөдөлж мандахын хишиг буян төгс нутаг шүү. Чухам тэр л газар алтан ургийн аз хийморь төгс бадарч Их улсын нийслэлийг зорьсон газар газрын олон хэл, шүтлэг мөргөлтний хөл тасрахгүй байхыг би одоо тодоос тод харж байна. Тэндээс нийслэлээ бүү хөдөлгөөрэй. Осолдож хөдөлгөх аваас алс хэтдээ Монголын заяа хазайж Их улсын минь сүр хүчин, алдар суу сарних вий. Түрэг болоод Хүннүгийн үеэс тэнд их улсын нийслэл байжээ. Үүнийг үүрд санаж үрийн үрд уламжлан захиж үлдээ. Чингис хаан миний нэрийг хэзээ ч муугаар бүү дуудуул. Миний бие үгүй боловч Чингис хааны их суу алдарТэнгэр мэт олон монголчуудыг үүрд ивээж мөнхрөх болно.

Би Алтан улсын ганц нэг боомтыг өөрийн биеээр авч эс чадсандаа харамсаж байна. Гэвч нэгэн бие дуусавч надаас дутахгүй хөвүүд, ач үрс минь их хэргийг гүйцээн миний хүрээгүйд хүрч, амжаагүйг гүйцэлдүүлнэ биз. Их хаан ор суух хөвүүн чи туйлаас хичээ...

-Хаан эцэг минь.Би хичээнгүйлэн сонсч байна гэж Чингис хааны амьсгаа дарахын хооронд Өгөдэй бишрэн шивнэжээ.

-Бүх цэргийг дээд доод гэлгүй их цаазад захируул. Сайдыг санааны туйлд бүү хүргэ. Түшмэдийг манлайн суудалд бүү суулга. Сайд, түшмэд чинь санааны туйлд хүрч, суудлын дээдэд сууваас санаа нь цадаж чармайн зүтгэх нь багасаад улс төрд хохиролтой, хүмүүжил сурталд муу нөлөөтэй болно. Хөвүүн чи одоо Их хаан болов. Үүнийг бүү март. Өглөө бүр нойрноосоо сэрүүт Их хаанд дүйх агуу үйлсийн тухай бодож бай. Боорчи Мухулай хоёр зөв явдлыг минь зөвшөөрөн тэтгэж, буруу явдлыг буцаан зогсоож энэ их сууринд хүргэв. Хөвүүн чамд чухам ийм үнэнч нөхөр амь мэт чухал. Төр, цэргийг хэрхэн засахыг Боорчийн амьд ахуйд түүнээс асуугтун. Би хийдгээ хийв. Одоо цаг минь болов. Үүнээс илүү удвал би та нарт гай болно.

Намайг босго.

Өгөдэй эцгийгээ өргөн босгов.

-Үгээ хэлж сэтгэл минь амрав. Энэ бол миний төрөхдөө атгаж төрсөн Тэнгэрийн тэмдэг юм. Үүний ачаар би чадал хүчин мөхөсдөхийн цагт баатрын тэнхэл авч, бодол санаа ахардан мухардваас саруул ухааны авшиг хүртэж, амин насны гал бөхөх цаг ирсэн энэ өдрүүдэд ч



үүнээс ухаан, тэнхээ сэлбэн аймшигт үхлийн өөдөөс дальдрахгүй харж, оюун сэтгэл хиргүй цэлмэг байсаар хорвоогоос явах мөч тулав. Одоо би Тэнгэрийн их хүчийг үүнээс цааш авах хүсэлгүй болов. Иймээс би Тэнгэрийн тэмдгийг биенээсээ салгаж байж л энэ хорвоог орхих учиртай. Харин миний захиж хэлсэнчилэн үүрдийн амгаланг олсныхоо дараа би үүнийг орчлонд анх ирсэн шигээ зүүн гартаа атган мөнхрөх ёстой юм шүү. Өүлэн эхийнхээ аминчлан захиж хэлснээр энэ Тэнгэрийн тэмдгийг нүд үзэж, хөл хүрэхгүй газарт би өөрийн хамт авч явъя. Намайг бунхлахдаа Тэнгэрийн тэмдгийг зүүн гарт минь атгуулаарай. Би Өүлэн эхийнхээ ухааныг дөнгөж сая л нэг гүйцэв гэж Чингис хаан хэлээд шүр мэт улаан өнгөтэй Тэнгэрийн тэмдгийг их л нандигнан Өгөдөйд өгчээ.

-Атга. Хүнд бүү үзүүл.

Улайдсан мэт халуун тэр чулуу Чингис хааны гараас шилжингүүтээ өнгө нь бүдгэрч байхыг Өгөдэй ажиж амжив. Гарын алга нь аймшигтайгаар түлэгдэн хорсохыг Өгөдэй тэвчжээ.

-Хаан эцэг минь би бүгдийг таны айлдсанаар гүйцэлдүүлье.

-Одоо чи миний морийг авчруул.

-Хаан эцэг минь Та ийм байж яаж морь унана. Тэргэнд явбал амар бус уу.

-Хөвүүн чи миний хэлснийг хийгтүн. Сүүлчийн хүслийг минь сөрж бүү цааргал.

-Их цэргийг зогсоож таны морийг авч ирье.

-Байз хүлээ. Их цэргийг бүү зогсоо. Миний бие самуурах юу ч биш. Их цэргийг надаас болж бүү зогсоо. Их цэрэг зогсоно гэдэг Монголын их улсад үхэлтэй адил. Хөвүүн чи үүнийг хэзээ ч бүү март. Би толбот бор морьтойгоо их цэргийн манлайд явсугай. Хөвүүн чи хаан сууриндаа суу. Намайг Тэнгэрийн орон хүлээж байна. Би морьтойгоо, цэрэгтэйгээ хамт явсугай. Их цэргийг бүү зогсоо. Намайг Тэнгэрт одоход үдэх хүндэтгэлийн цуваа болог. Надаас хойш ч их цэргийг бүү зогсоо гэсэн нь Чингис хааны хүчээ шавхан хэлсэн эцсийн үг болов. Түүний зүрх хаяа нэгхэн тасалдангуй цохилж байсан ч тэр өөрт шингэн үлдсэн Тэнгэрийн их хүчээр үхэлтэй тэмцэж байв.

Чингис хаан энэ орчлонг орхин одохынхоо өмнө ийнхүү санасан бүгдээ хийж санаа нь амрав. Одоо ганцхан хүсэл л үлдэв. Энэ бол түүний олон хоногийн турш бодсон хэрэг байлаа. Чингис хаан Жамуха шиг хүний зааснаар биш, өөрийн хүссэнээр үхэхээр хатуу шийдсэн билээ. Тэр цаг одоо ирэв. Тэр үхлээс хүчтэй гэдгээ харуулахыг туйлын ихээр хүсч байв. Бие махбодь нь аль эрт түүний ухаанд захирагдахгүй болж бүх хөдөлгөөн нь зогсжээ. Гэвч түүний уураг тархи асар их хүч гарган ажилласаар байлаа. Гадаа морь хангинатал янцгаах нь сонсдов. Чингис хааныг түүний Их цэрэг, эрмэг хөлөг нь дуудаж байгаа нь энэ юм. Оюун ухаан нь эцсийн хүчээ дайчлан өөрийн биенд хуримтлагдан байсан Тэнгэрийн их хүчийг нэгмөр шавхан гаргажээ. Чингис хааны биенээс ялгаран гарсан энэ их хүчинд хуй салхи хормын дотор дэгдэн өргөөний дээвэр туургыг хийсгэн одох мэт болов. Одоо түүний нүдний нь өмнө бүх зүйл ил тод харагдана. Холгүй их цэрэг хөврөн урагшлах нь үзэгдэв. Чингис хаан

огт эрүүл хүн шиг цэгц шулуун алхан очоод мориндоо мордов. Өгөдэйн зарлигаар хэн ч түүнд ойртсонгүй.

Чингис хаан одоо юу ч олж харахгүй болжээ. Түүнд ганцхан нүд сохлом цагаан гэрэл үзэгджээ. ”Би хүслээрээ үхэв. Үхэл цагаан өнгөтэй байдаг аж” гэж бодсон нь түүний эцсийн бодол байв. Олон агт, түм түмэн цэргийн жагсаалын манлайд явж сурсан толбот бор морь нь харахын зуургүй цахилан давхиж цэргийн цувааны түрүүнд гармагцаа тайвширч их цэргийн цувааг манлайлан товор товор алхлав. Яг энэ үес Чингис хааны сүнс биеэс салж Тэнгэрт хөөрчээ.

Цэргийн цувааны эхэнд явж байсан Тулуйн хөвүүн Хубилай жагсаалын эхнээс бөөн гал тэнгэрт хөөрөхийг хараад

-Хараач. Тэр галыг. Тэнгэрт гал хөөрч байна. Яг чоно шиг гал. Галт чоно тэнгэрт хөөрч байна гэж цангинуулан хашгирчээ. Хубилайн дуунаар бүгд дээш харж бүр тэнгэрийг цоортол ширтэцгээсэн боловч юу ч олж үзсэнгүй. Гэвч энэ чонын дүрст гал Хубилайгаас бусад хүмүүсийн нүдэнд харагдаагүй нь Тэнгэрийн хүсэл болохыг хэн ч гадарласангүй бөгөөд бүгдээр Хубилайг хий юм харав гэж бодоцгоожээ. Хубилайг харсаар байтал өнөө галт чоно төдөлгүй тэнгэрт шингэн үзэгдэхээ больжээ. Чингис хааны сүнс биенээс тасран Мэнлигийн хөвүүн Хөхөчүгийн хамт ийнхүү Тэнгэрийн орныг зорин одсон билээ. Хар багад нь ганцхан удаа үзэгдсэн галт чоно бол Чингис хааны өөрийнх нь сэтгэл оюуны харагдах дүр, түүний Мөнх Тэнгэр байжээ. Тэмүжин зүүдэндээ галт чоныг үзсэн нь Хөхөчүгийн ид шидийн хүчээр өөрийн сэтгэлийг үзсэн хэрэг байв. Ийм явдал жирийн хүмүүнд огт тохиолдохгүй ажээ. Чингис хааны сүнс-Галт чоно газарт дахин эргэж буухгүйгээр Тэнгэрт одсон бөгөөд сая өндрөөс харахад энэ газар хавтгай биш бөөрөнхий, бас хүрд мэт эргэлдэж байхыг олж үзээд их гайхжээ.

Галт чонын дүрд хувилсан Чингис хааны сүнс Тэнгэрт үүрд одож, харин сүлд хийморь нь түүний унасан газар шороо, удам угсаа, үр хойчид шингэж үлдсэн тул олон монголчууд Мөнх Тэнгэрт тэтгэгдэх ариун хутагийг газрын дээр эгнэгт олжээ... хэмээн хичээнгүйлэн бичээд олон хоног цомцойн суусаар ядарч, гар нүд нь ихэд чилсэн өвгөн буурал бичээч тэрбээр хөшсөн биеэ хөдөлгөн суниажээ.

Гэвч ингэснээр түүний олон жилийн хүчир хөдөлмөр дуусаагүй тул дэнгээ сэргээж дахин нэг шинэ хуудас цаас авч бийрээ бэхэнд нийлээд “ЧИНГИС ХААНЫ НУУЦ ТҮҮХ” гэж томоор дурайлган бичиж гарчиг болгоод бас нэгэн цаасан дээр “Энэхүү түүхийг зөвхөн Танд зориулан бичиглэв. Та үүнийг уншин болгоогоод магтан сайшаах буюу хилэгнэн хараахаа түр тэвчин азнаж саруул мэргэн ухаандаа сайтар тунгаан бодогтүн. Хүмүүний амьдралын чанад нууцыг хэн ч үл мэднэ. Гагцхүү Мөнх Тэнгэрийн эрхшээлд орших тул Та ухаан сэтгэлийнхээ хязгааргүй орчлонг оюуны зулаар гэгээрүүлэн байж тэрхүү чанад нууцыг няцаж цуцалгүй эрж хайгтүн. Нууцыг тайлмагц Та Мөнх Тэнгэрийн ивээлд багтах буйзаа” гэж хэн нэгэнд зориулсан зурвас бичээд сая л санаа амран нэг насны хэргээ бүтээсэн хүний өөдрөг хангалуун сэтгэлтэйгээр нам унтжээ.

Маргааш нь олны анхаарлыг татахгүй газраар Хааны ордонд нэвтрэн орох, эсвэл Мөнх хаанд уг түүхийг өөр итгэлтэй хүнээр дамжуулан олны нүдэнд үзүүлэлгүйгээр хүргэх аргыг

эрэлхийлэхээр Хархорум хотын их зээл, хааны ордныг зорьжээ. Франц дархан Бушьегийн урласан далавчит охин тэнгэр бүрээ татаж буй дүрстэй, луун толгойт мөнгөн модны дэргэдүүр өнгөрч явтал олон торгон цэрэг дагуулсан үзэсгэлэнт хөвүүн давхин ирэхэд тэнд байсан түмэн хэлийн улс бүгд сөхрөн мөргөжээ. Шүд нь гэрэлтэж, нүд нь гялалзсан тэгш өндөр биетэй хар арьстан цэргүүд хөвүүнийг дагалдсан нь өвгөн бичээчийг алмайруулжээ. Учир нь тэр гэртээ шигдэн суусаар хэдэн жил тойрсон тул Хархорум хотод энэ мэт шинэ зүйл бий болсныг мэдсэнгүй байжээ. Энэ бол Мөнх хааны бага хөвүүн Сэрихин ажгуу. Хан хөвүүн Хархорум хотын их зээлийг чиглэн оджээ. Мөнх хааны бага хөвүүн, сэргэлэн цовоо Сэрихинийг эрээн мяраан бараа таваар сонирхон, хамгаалагч торгон цэргүүдээс сатааран холдсон үеэр нь сэм дуудаж уулзаад түүнд нэгэн алтан зоос үзүүлж

-Үүнийг би Мөнх хаанд заавал өгөх учиртай юм. Сайн хөвүүн чи Хаан эцэгтээ осолдолгүй хүргэж өг. Харин энэ зоосыг чи өөрөө шанд нь аваарай хэмээн бас нэг мөнгөн зоос өгөөд “Энэ баринтигтай судрыг хэнд ч мэдэгдэж үзэгдэлгүй хаан эцэгтээ аваачиж өгөөрэй. Хөвүүн чи үзтэл сэргэлэн, нүдэндээ галтай, нүүрэндээ цогтой, баатар эр болох хүн байна. Чи үүнийг эцэгтээ хүргэж өгөөд хэнд ч хэлэлгүй эргэж ирэгтүн. Ирэхээр чинь би чамд үүнийг өгнө” хэмээн нэгэн гялалзсан гоё алтан шагай үзүүлжээ. “Баатар эр болно” хэмээн зөгнөж хэлсэн тэрхүү нүдэнд дулаахан өвгөний үгэнд урамшин баясч алтан шагай шанд нь авахыг бодсон балчир хөвүүн Сэрихин тэрхүү алтан зоос хийгээд баринтигтай судрыг тансаг бөгөөд элбэг хувцсандаа сайтар нуугаад

-Та надад итгэж болно. Би баатар хүний ёсоор осолдолгүй эргэж ирнэ. Үүнийг би хаан эцэгтээ дор нь хүргээд өгчихнө хэмээн цовоо дуугаар итгэлтэй хэлээд хэвлүүхэн нь аргагүй ордон руугаа давхижээ. Хар арьст цэргүүд ч дагалджээ. Харин өнгөрсөн хойно өвгөн бичээч осолтой зүйл хийснээ гэнэт ухаарч өөрийгөө зэмлээд барсангүй.

“Өөрийн биеэр хүргэж өгвөл чанд нууцыг нэгд нэгэнгүй мэдэхийн учир амь насанд осол болох вий гэсэндээ балчир нялх хөвүүнд их нууцыг даатган өгч хар толгойдоо уучлашгүй ял хураав, би. Тэртэй тэргүй хөгшин хонины насгүй болсон би юундаа ингэтэл хоргодоо вэ. Үхтлээ ухаан суухгүй амьтан юм даа” хэмээн гэмшин гасласаар суув. Сэрихин хөвүүн эргэж ирэхгүйд өвгөн бичээчийн тэвчээр барагдан бүхий энэ үес түүний итгэж илгээсэн балчир элч аль хэдийн хаан эцгийнхээ гарт мөнөөх алтан зоос, баринтигтай судар, болон жич зурвас сэлтийг хүний нүд хариулан байж оруулж өгөөд сайшаал магтаал сонсохын зэрэгцээ бяцхан байцаагдаж зогсов. Сэрихиний авчирсан тэрхүү алтан зоосны нэг талд “Аугаа их эзэн хаан Чингис” хэмээн араб үсгээр бичсэн байх ажээ. Харин Сэрихинд өгсөн мөнгөн зоосон дээр нь “Эрхэм дээд эзэн Чингис хаан” гэсэн үг дурайн байсныг хэн ч мэдсэнгүй өнгөрсөн билээ.

“Энэхүү түүхийг зөвхөн Танд зориулан бичиглэв...” хэмээн эхлэсэн зурвасыг уншиж суусан Мөнх хаан хөвүүн рүүгээ гайхаж сонжсон байдлаар хараад

-Энэ зоос, зурвас, баринтигтай судрыг чамд хэн, хаана өгөв хэмээн асуужээ.

-Нэг өвгөн их зээл дээр явахад намайг сэмхэн дуудаж өгөөд хэнд ч үзүүлэлгүй нууж Хаан эцэгтээ осолдолгүй хүргээрэй гэсэн юм. Алтан зоос өгөхдөө тэр танд өртэй л гэсэн шүү дээ. Бас намайг баатар хүн болно гэсэн.

-Тийм ээ. Тэр надад өртэй байж магадгүй юм. Тэр одоо хаа байна.

-Мэдэхгүй ээ. Надад үүнийг өгчихөөд л яваад өгсөндөг хэмээн Сэрихин хөвүүн анх удаа Хаан эцэгтээ худлаа залж орхиод сандарсандаа нүүр нь улайхыг ажсан Мөнх хаан

-За яахав. Харин энэ явдал чи бид хоёрын нууц болж үлдэг. Хэнд ч бүү хэлээрэй. Ээж, ах нартаа ч гэсэн. Чи одоо ордноос хамаагүй бүү гарч яв хэмээжээ.

“Нууцыг нь хадгална, удахгүй эргээд ирнэ” гэж өнөөх өвгөнд амалчихсан Сэрихин хөвүүн “За” хэмээн доройхон дуугарчээ.

Үүнээс хойш хэд хоногийн дараа нэр үл мэдэх тэрхүү хичээнгүй даруу бичээчийн ирүүлсэн дээрх “Чингис хааны нууц түүх-”ийг энэ үес Их Монгол улсын хаан сууринд залран байсан Мөнх хаан шөнөжин сууж, бие лагшин хийгээд саруул мэлмийгээ чилээн байж ихэд шимтэн уншиж дуусаад босч бие тэнийлгэн “Түмэн амгалант” ордныхоо цонхоор харвал Хархорум хотод аль хэдийнээ өглөөний нар мандан гийгээд баруун этгээдэд байх их хатдын ордны алтан ганжирт дээвэр нүд гялбааж бас харийн иргэдийн суудаг тансаг хүрээний зүгээс загалмайт сүмийн хонхон дуу дүнгэнэх, лалын мөргөлтнийг залбиралд дуудан уянгалах тод содон дуу, худалдаачдын эд бараагаа магтаж ам өрсөлдөн хашгирах далан хэлийн шаагиан шуугиантай холилдон сонсдох авай. Төдөлгүй ордны шадар сайд орж ирээд харийн элч, худалдаачид зэрэг хүмүүс их хаанд бараалхах цагийг хүлээн чилж байгааг сануулахад Мөнх хаан

-Тэд жаахан хүлээг. Их хаанд бараалхах гэдэг санасан зоргоор болдоггүйг ухаарна биз хэмээхдээ Хархорум нийслэл рүү нь харийнхан өөрсдөө тал талаасаа цувж байх цагийг урьдчилан харж асан их Чингис хааны зөн совин, ухаан билгийг биширч түүний гэрээсийг чанд биелүүлэх цаг өөрт нь ирснийг сүслэн бодож зогслоо. Мөнх хаан ордны хишигтнээс хамгийн итгэлтэй хоёр хүнийг сонгож ирүүлэхийг тушаажээ. Удалгүй хамгийн нууц үйлд голдуу зарагддаг найдвартай хоёр цэрэг ирсэнд Мөнх хаан хөвүүн Сэрихинийг эвтэйхэн шалгааж байгаад хэлүүлсэн өнөөх өвгөний төрх байдал, царай зүсийг дурдан хэлж хаана суудаг, хэн болохыг олж тогтоохыг чандлан тушаагаад үүнийгээ хэнд ч мэдэгдэхгүй байхыг хатуу сануулжээ.

Мөнх хаан баринтигтай судрыг уншиж дууссан даруйдаа мөнөөх бичээчийг олж шан хишиг харамгүй хүртээх, нөгөөтэйгүүр Чингис хааны алтан ургаас хаан ор суусан хүн л ганцаар нягтлан унших учиртай тэр нууц түүхийн нарийн ширийнийг чандлан хадгалах учрыг бодолцон хэрхэхийг шийдэхээр хамгийн итгэлтэй хүнээ илгээн ийнхүү эрэл хайгуул болсонд өнөөх үл танигдах өвгөн бичээч нэн зожиг ганцаар хүн байсан агаад харийнхны хүрээнд амьдардаг байсан нь тодорхой болж хэн ч түүний тухай мэдэхгүй байжээ. Гагцхүү мөнөөх өвгөнийг “Үхээд гурав хоножээ” гэсэн баттай боловч бүтэлгүй хэл мэдээг хоёр хишигтэн нь Мөнх хаанд дуулгасан тул тэрээр эрлээ мухарлан санаа амраад бүрлээчийг Орхон мөрний уужим хөндийд хүндтэй нутаглуулж дээр нь ямар ч бичиг тэмдэггүй чулуун хөшөө босгохоор зарлигласныг ёсоор болгосон билээ

“Чингис хааны нууц түүх” нэртэй уг бичмэлд өгүүлснийг уншихад үүнийг бичиглэсэн тэр өвгөн бичээч Чингис хаантай ихэд дотно ойр явсан нэгэн болох нь илт байв. Гэвч Мөнх хаан

хичнээн ч тунгаан бодоод тэр бичээчийн хэн болохыг таасангүй. Бас тэрээр Хархорум хотын харийн иргэд оршин суудаг тансаг хүрээнд даяанч мэт гав ганцаар суудаг байсан хийгээд их эзэн Чингис хааны амьд сэрүүн ахуйд цутгасан араб бичигтэй алтан зоосыг Мөнх хаанд өгүүлсний нарийн учрыг ч тайлах арга байсангүй. Ийнхүү нэгэнт Тэнгэрийн оронд одсон тэрхүү бичээчийн хэн болохыг мэдэх хүн огт гарсангүй. Тэрээр ганц биеэр амар тайван амьдардаг, Хар хорумыг байгуулахаас эхлээд л энд суурин суусан хүмүүн байжээ гэхээс өөрийг олж мэдэж чадсангүй өнгөрөв. ”Чингис хааны нууц түүх”-ийн бүх нууцыг үл таних тэр бичээч ийнхүү өөртөйгөө хамт энэ хорвоогоос авч оджээ. Ийнхүү үл таних бичээчийн илгээсэн товчхон зурваст өгүүлснээр Мөнх хаанд ганцхан өөрийнхөө ухаан сэтгэл хийгээд Мөнх Тэнгэрийн эрхшээлд итгэх л үлджээ.

Мөнх хаан тэр даруйдаа ордны шадар нэгэн бичээчийг дуудан ирүүлж өөрөө хажуугаас нь огт холдолгүй сахин байж уг нууц түүхийг нягт нямбай сийрүүлэн бичүүлж дуусгаад түүний ар гэр, эхнэр хүүхдэд нь элбэг дэлбэг бэлэг сэлт, алт мөнгийг хангалттай хүргүүлээд мөнөөх бичээчийг хол газар хугацаагүй нууц албанд явсан хэмээн хэлүүлснээс хойш түүнийг үзсэн харсан хүн нэгээхэн ч үгүй бүлгээ.

“Нууц түүх”-ийг уншсан нь Мөнх хааныг түмэн бодолд оруулж, Хубилайн “Галт чоно тэнгэрт хөөрч байна” гэж нүдээ дүрлийлгэн хашгирч байсан нь нүдэнд нь харагдаад салахаа байжээ. Тэгэхэд тэд Чингис хааны шарилыг залсан гэр тэргийн ард зэрэгцээд явж байсан тул яахан санахгүй байх билээ. Тэр галт чоныг Мөнх хаан хараагүй бөгөөд огт итгээгүй ажээ. Гэтэл “Нууц түүх”-ийн төгсгөлд Чингис хааны сүнс галт чоно болон тэнгэрт хөөрснийг, бас ганц Хубилайд харагдсан тухай дурдсаныг мэдээд итгэх, гайхах хосолсоор байв. Ингэж бичсэн нь үнэн бол туйлын атаархмаар, бас олон зүйлийг эрэгцүүлэн тунгаамаар хэрэг ажээ. Цаашид “Чингис хааны нууц түүх”-ийг хэрхэхээ Мөнх хаан удаан бодов. Ганц биендээ хадгалан нуух нь даанч байж боломгүй, чухам Тэнгэрийн зарлигийг зөрчсөн хэрэг гэдгийг тэр ойлгож байв. Бас түмэн олонд зарлан тунхаглах нь ч байж боломгүй мэт санагджээ. Тэгээд “Чингис хааны нууц түүх”-ийг “Чингис хааны алтан ургийн бичээс”-тэй хамт Их хааны ямбаны өргөөнд тусгайлан хадгалж зөвхөн Их Монгол улсын хаан сууринд залрагсад л нээн уншиж болохыг Мөнх хаан хатуу чанд зарлиг болгосон нь Чингис хааны тавьдугаар он буюу Христийн тооллын нэг мянга хоёр зуун тавин зургаан он байв.

Энэ үед Хархорум хот “Чингис хааны нууц түүх”-д дурдсанчлан бурхны, загалмайн, лалын шашинтны цорын ганц нэгдсэн мөргөлийн газар, албан харилцаа, арилжаа худалдааны нэгэн чухал зангилаа гэгдэж Чингис хааны захиж гэрээслэн үлдээснээр ертөнцийн төв болоод байлаа.

Энэхүү нэгдсэн нэг ертөнц бол Чингис хааны туйлын хүслэн байв. Өөрийнх нь хүслийг түүний үр удам алгасан цалгардуулалгүй биелүүлж нэр алдрыг нь дуурсган явааг Чингис хааны сүнс-Галт чоно Дээд Тэнгэрээс бахдан харж байгааг Мөнх хаан зөнгөөрөө мэдэж байв.

# Table of Contents

[Өмнөх үг](#)  
[ЗУРГААДУГААР БҮЛЭГ](#)  
[ДОЛООДУГААР БҮЛЭГ](#)  
[НАЙМДУГААР БҮЛЭГ](#)  
[ЕСДҮГЭЭР БҮЛЭГ](#)